2010

Гарын авлага 2

# Сүмийг удирдах нь

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

2010

Гарын авлага 2

# Сүмийг удирдах нь

Хэвлэсэн
Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм
Юта муж, Солт Лейк хот

© 2010 by Intellectual Reserve, Inc.
Бүх эрх хамгаалагдсан
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Англи эхийн зөвшөөрөл: 8/09
Орчуулгын зөвшөөрөл: 8/09
*Handbook 2: Administering the Church*-н орчуулга
Mongolian
08702 363

# Гарчиг


**Оршил . . . . . . . . . . v**

1. **Бурханы төлөвлөгөөн дэх гэр бүлүүд ба Сүм . . . . . . . . . . 1**
2. **Санваарын зарчмууд . . . . . . . . . . 7**
3. **Есүс Христийн Сүмийн удирдлага . . . . . 11**
4. **Тойргийн зөвлөл . . . . . . . . . . 17**
5. **Тойрог, гадсан дахь авралын ажил . . . . 23**
6. **Халамжийн зарчмууд ба удирдлага . . . 35**
7. **Мелкиседек санваартнууд . . . . . . . . . . 41**
8. **Аароны санваартнууд . . . . . . . . . . 51**
9. **Нийгмийн Халамжийн Бүлэг . . . . . . . . . . 65**
10. **Залуу Эмэгтэйчүүд . . . . . . . . . . 79**
11. **Хүүхдийн Хэсэг . . . . . . . . . . 93**
12. **Ням гарагийн анги . . . . . . . . . . 103**
13. **Үйл ажиллагаанууд . . . . . . . . . . 109**
14. **Дуу хөгжим . . . . . . . . . . 123**
15. **Гадасны зохион байгуулалт . . . . . . . . . 131**
16. **Ганц бие гишүүд . . . . . . . . . . 135**
17. **Сүмийн нийтлэг зарчим ба орон нутгийн хэрэгцээнд тохируулах нь . . . 143**
18. **Сүмийн хурал цуглаанууд . . . . . . . . . . 149**
19. **Сүмийн дуудлагууд . . . . . . . . . . 169**
20. **Санваарын ёслол ба адислалууд . . . . 183**
21. **Сүмийн бодлого ба удирдамжууд . . . . 195**

**Хавсралт: Ашигласан материалын жагсаалт . . . . . . . . . . 217**

**Индекс . . . . . . . . . . 219**

# Оршил

"Хүн бүр өөрийн үүргийг мэдэж аваг, тэрээр томилогдсон албан тушаалдаа бүхий л хичээл зүтгэлээр ажиллаг" хэмээн Их Эзэн зөвлөжээ (С ба Г 107:99).

Сүмийн удирдагч нар дуудлагынхаа үүргүүдийг мэдэж, тэдгээрийг биелүүлэхдээ хувийн илчлэлтийг эрэлхийлэх ёстой.

Судрууд болон өнөөгийн бошиглогчдын сургаалуудыг судлах нь удирдагч нарт үүргээ мэдэж, биелүүлэхэд нь тусална. Удирдагч нар Сүнсний нөлөөг хүлээн авдаг байхын тулд Бурханы үгсийг оюун ухаандаа байнга нөөцлөх ёстойг Их Эзэн тэдэнд зөвлөжээ (С ба Г 84:85-г үзнэ үү).

Удирдагч нар мөн Сүмийн гарын авлагууд дахь заавруудыг судалснаар үүргүүдээ мэдэж авдаг. Зарчим, бодлого, дүрэм журмуудыг ойлгохын тулд Сүнсний удирдамжийг эрэлхийлбэл эдгээр заавруud таны илчлэлтэд тус дөхөм үзүүлж чадна.

## Сүмийн удирдагчдад зориулсан гарын авлагууд

Сүмээс удирдагч нарт зориулан хоёр гарын авлага гаргасан юм:

*Гарын авлага 1: Гадасны ерөнхийлөгч ба бишоп.* Энэ гарын авлага нь гадасны ерөнхийлөгч, бишопуудын ерөнхий үүрэг хариуцлагын тухай өгүүлдэг бөгөөд бодлого, дүрэм журмуудын тухай нарийн тодорхой мэдээллийг агуулдаг.

*Гарын авлага 2: Сүмийг удирдах нь.* Энэ гарын авлага бол тойргийн болон гадасны зөвлөлийн гишүүдэд зориулсан удирдамж юм. Эхний хоёр хэсэг нь Сүмийн ажлын сургаалын үндэс суурь болох хувь хүмүүсийн аврал, санваарын хүчээр дамжуулан гэр бүлүүдийг лацдан холбох болон өргөмжлөх тухай өгүүлдэг. Бусад хэсэгт санваартнуудын чуулгууд болон туслах бүлгүүдийг удирдах заавруud байдаг. Уг гарын авлагад мөн тойрог дахь бусад олон туслах бүлгүүдэд хамаарах зарчим болон удирдамжууд агуулагддаг.

Сэдвүүдийг олох болон эш татахад хялбар болгох үүднээс эдгээр гарын авлагууд дахь гарчиг, дэд гарчгуудыг дугаарласан болно. Удирдагчид нэг буюу хэсэг хуудсыг эрж олохын оронд аль нэг сэдвийг дугаараар нь олж болно. Жишээ нь гишүүдийн номлолын ажлын тухай ярилцах үед бишоп *Гарын авлага 2-ын 5.1.2-ыг олохыг тойргийн зөвлөлийн гишүүдээс хүсч болно.* 5-ын тоо нь бүлгийг, 1-ийн тоо нь уг бүлгийн хэсгийг, 2-ын тоо нь дэд хэсгийг зааж байгаа юм.




## Заавруудад оруулсан нэмэлт өөрчлөлт

Тэргүүн Зөвлөл, Арванхоёрын Чуулга, Тэргүүлэх Бишопын Зөвлөлийн захидал, мэдэгдэл, түүнчлэн бусад хэлбэрээр эдгээр гарын авлагад хийсэн шинэчлэлт, нэмэлт өөрчлөлтийн мэдээллүүд үе үе орж байх болно. Ийм өөрчлөлт орох үед эдгээр өөрчлөлтийг удирдагчид гарын авлагадаа оруулан бичиж байх хэрэгтэй. Гарын авлагууд болон эдгээр нэмэлт өөрчлөлтийг удирдагчид хамтад нь хадгалж байх ёстой.

## Заавруудын тухай асуултууд

Эдгээр гарын авлагууд дахь мэдээлэл болон энд дурдагдаагүй асуудлын талаар асуулт байвал удирдагчид тэргүүлэх эрх мэдэлтэндээ хандан тавих хэрэгтэй.

## Салбар, дүүрэг, номлолуудад гарын авлагыг ашиглах нь

Гарын авлагууд дахь *бишоп*, *бишопын зөвлөл* гэдэг нэр томьёо нь салбарын ерөнхийлөгч, салбарын ерөнхийлөгчийн зөвлөлд мөн холбогдоно. *Гадасны ерөнхийлөгч* болон *гадасны ерөнхийлөгчийн зөвлөл* гэдэг нэр томьёо мөн дүүргийн ерөнхийлөгч, дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөлд холбогдоно. Гэвч бишопын болон салбарын ерөнхийлөгчийн алба ба гадасны ерөнхийлөгч болон дүүргийн ерөнхийлөгчийн албууд нь эрх мэдэл, үүрэг хариуцлагын хувьд адил биш юм. Бишоп бол санваарын алба бөгөөд

зөвхөн Тэргүүн Зөвлөлөөр томилогддог. Гадасны ерөнхийлөгчийг Ерөнхий Эрх мэдэлтнүүд болон Бүсийн Далууд дууддаг.

Тойрог, гадаснуудад хамаатай зүйлс нь ихэнхдээ салбар, дүүрэг, номлолуудад мөн хамаарна.

## Сүмийн удирдах газар эсвэл Харьяа үйлчлэлийн төвтэй харилцах нь

Энэ гарын авлагын зарим бүлэгт Сүмийн удирдах газар эсвэл харьяа үйлчлэлийн төвтэй холбоо барих зааврууд орсон болно. Сүмийн удирдах газартай холбоо барих заавар нь АНУ болон Канад дахь санваартны удирдагч нар болон бичиг хэргийн ажилтнуудад хамаарна. Харьяа үйлчлэлийн төвтэй холбоо барих заавар нь АНУ болон Канадаас бусад орнууд дахь санваартны удирдагч нар болон, бичиг хэргийн ажилтнуудад хамаарна.

## Хуваарилалт

*Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* номыг дараах байдлаар хуваарилах ёстой:

- Ерөнхий эрх мэдэлтнүүд, Бүсийн Далууд, ерөнхий туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд, Сүмийн газар хэлтсүүдийн удирдагч нар, ажлын албаны захиралд (тус бүр 1 ш)
- Номлолын ерөнхийлөгчийн зөвлөл (3 ш)
- Гадас, дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөл (3 ш)
- Гадас, дүүргийн бичиг хэргийн ажилтан (1 хувийг өрөөндөө хадгална)
- Гадас, дүүргийн гүйцэтгэх нарийн бичиг (1 ш)
- Дээд зөвлөл (12 ш)
- Гадасны Залуу эрэгтэйчүүд, Нийгмийн Халамжийн бүлэг, Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн Хэсэг, Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөл (тус бүр 3 ш)
- Бишопын зөвлөл, салбарын ерөнхийлөгчийн зөвлөл (3 ш)
- Тойрог, салбарын бичиг хэргийн ажилтан (1 хувийг өрөөндөө хадгална)
- Тойрог, салбарын гүйцэтгэх нарийн бичиг (1 ш)
- Дээд пристүүдийн бүлгийн удирдлага (3 ш)
- Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл (3 ш)
- Тойргийн Залуу Эрэгтэйчүүд, Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн Хэсэг, Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөл (тус бүр 3 ш)
- Тойргийн номлолын удирдагч (1 ш)

Энэхүү гарын авлагыг зөвхөн Сүмийн ерөнхий болон орон нутгийн ажилтнууд Сүмийн ажил хэргийг удирдан зохион байгуулахад ашиглахын тулд бэлтгэсэн болно. Гарын авлагыг хувилан олшруулах буюу өөр хүмүүст өгч болохгүй. Хуваарилах энэхүү жагсаалтаас гадна бичиг хэргийн ажилтан бүр 1 хувийг гадас, тойрог бүрийн өрөөнд найдвартай газарт хадгалах ёстой. Бичиг хэргийн ажилтан санхүү, бүртгэлийн талаарх мэдээлэл, гадасны ерөнхийлөгч, бишопуудын ажилд туслах тухай мэдээллийг үзэхийн тулд энэ хувийг ашиглаж болно.

Энэхүү гарын авлагыг хэрэглэж байсан Сүмийн дуудлагатнууд чөлөөлөгдөхдөө дараагийн хүндээ эсвэл өөрсдийн тэргүүлэх эрх мэдэлтэнд тэр даруйд шилжүүлэн өгөх ёстой.

# 1. Бурханы төлөвлөгөөн дэх гэр бүлүүд ба Сүм


1.1 **Мөнхийн гэр бүлдээ зориулсан Бурхан Эцэгийн төлөвлөгөө . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 2**
1.1.1 Мөнх бус байдлын өмнөх амьдрал дахь Бурханы гэр бүл . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .2
1.1.2 Мөнх бус амьдралын зорилго . . . . . . . . . . . . . .2
1.1.3 Есүс Христийн Цагаатгал . . . . . . . . . . . . . . . . . .2
1.1.4 Бурханы төлөвлөгөөн дэх гэр бүлүүдийн үүрэг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .2
1.1.5 Сүмийн үүрэг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .2

1.2 **Эцэгтээ эргэж очих нь . . . . . . . . . . . . . . . . . . . . 2**
1.2.1 Есүс Христийн сайн мэдээ . . . . . . . . . . . . . . . . .2
1.2.2 Сүмийн удирдагчид болон багш нарын үүрэг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .3

1.3 **Мөнхийн гэр бүлүүдийг бий болгох нь . . . . . . 3**
1.3.1 Нөхөр, эхнэр хоёр . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .3
1.3.2 Эцэг эхчүүд ба хүүхдүүд . . . . . . . . . . . . . . . . . .4
1.3.3 Сүмийн гэрлээгүй гишүүд . . . . . . . . . . . . . . . . .4

1.4 **Гэр бүл ба Сүм . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 4**
1.4.1 Гэр бүлийг бэхжүүлэх нь . . . . . . . . . . . . . . . . . . .5
1.4.2 Гэр бүлийн үдэш . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .5
1.4.3 Хувь хүмүүсийг бэхжүүлэх нь . . . . . . . . . . . . . .6

# 1. Бурханы төлөвлөгөөн дэх гэр бүлүүд ба Сүм

## 1.1 Мөнхийн гэр бүлдээ зориулсан Бурхан Эцэгийн төлөвлөгөө

### 1.1.1 Мөнх бус байдлын өмнөх амьдрал дахь Бурханы гэр бүл

Гэр бүл Бурханаас томилогддог бөгөөд энэ амьдралд болон үүрд мөнхөд хамгийн чухал нэгж байдаг. Бид дэлхий дээр төрөхөөсөө өмнө нэгэн гэр бүлийн гишүүд байсан. Бид "тэнгэрлэг эцэг эхийн хайртай сүнсэн хүү, охин нь бөгөөд тэнгэрлэг шинж чанар, хувь тавилантай юм" ("Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг," *Ensign*, 1995 оны 11-р сар, 102). Бурхан бол бидний Тэнгэрлэг Эцэг бөгөөд бид мөнх бус байдлын өмнөх амьдралд Түүний гэр бүлийн хэсэг байж Түүний дэргэд амьдарч байсан. Тэнд бид анхныхаа хичээлүүдийг заалган, мөнх бус амьдралд бэлтгэгдсэн билээ (С ба Г 138:56-г үзнэ үү).

### 1.1.2 Мөнх бус амьдралын зорилго

Бурхан биднийг хайрладаг учраас өсч хөгжин, Түүнтэй илүү адилхан болохын тулд дэлхийд ирж, бие махбодыг хүлээн авч, соригдох төлөвлөгөөг бидэнд зориулан бэлтгэсэн юм. Энэ төлөвлөгөөг "авралын төлөвлөгөө" (Алма 24:14), "аз жаргалын агуу төлөвлөгөө" (Алма 42:8), "гэтэлгэлийн төлөвлөгөө" (Алма 12:25; мөн шүлэг 26–33-ыг үзнэ үү) хэмээн нэрлэдэг.

Бурханы төлөвлөгөөний зорилго бол биднийг мөнх амьдрал өөд удирдах явдал юм. "Учрыг болгоогтун, үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу бөлгөө" (Мосе 1:39) хэмээн Бурхан тунхагласан билээ. Мөнх амьдрал бол хүүхдүүддээ өгсөн Бурханы хамгийн агуу бэлэг мөн (С ба Г 14:7-г үзнэ үү). Түүнчлэн энэ нь селестиел хаант улсын хамгийн дээд зэрэглэлд өргөмжлөгдөх явдал юм. Бид авралын төлөвлөгөөгөөр дамжуулан Бурханы оршихуйд эргэж очин, бүрэн баяр баясгаланг олох тэрхүү адислалыг хүлээн авч чадна.

### 1.1.3 Есүс Христийн Цагаатгал

Бид Бурханы хаант улсад өргөмжлөгдөхийн тулд мөнх бус амьдралд тохиолддог хоёр саад болох үхэл ба нүглийг даван туулах ёстой. Бид энэ хоёр саадын алиныг нь ч өөрсдөө даван туулж чадахгүй учраас Тэнгэрлэг Эцэг Өөрийн Хүү Есүс Христийг бидний Аврагч, Гэтэлгэгч болгохоор илгээсэн. Аврагчийн цагаатгагч золиослол Бурханы бүх хүүхдэд бие махбодын үхлийг даван туулж, амилуулагдан, үхэшгүй байдлыг олох боломжийг олгосон. Цагаатгал нь бас наманчилж, Түүнийг дагадаг хүмүүст сүнсний үхлийг даван туулж, Бурхантай хамт амьдрахаар Түүний дэргэд эргэн очиж, мөнх амьдралтай болох боломжийг олгосон юм. (С ба Г 45:3–5-ыг үзнэ үү).

### 1.1.4 Бурханы төлөвлөгөөн дэх гэр бүлүүдийн үүрэг

Бид Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний дагуу гэр бүлд төрсөн юм. Бидэнд аз жаргалыг авчирч, хайраар дүүрэн орчинд зөв зарчмуудад суралцаж, мөнх амьдралд бэлтгэгдэхэд туслахын тулд Тэрээр гэр бүлүүдийг бий болгосон билээ.

Тэнгэрлэг Эцэгтээ эргэж очиход бэлтгэхэд нь хүүхдүүддээ туслах чухал үүрэг хариуцлага эцэг эхчүүдэд байдаг. Эцэг эхчүүд Есүс Христийг дагаж, Түүний сайн мэдээгээр амьдрахыг хүүхдүүддээ зааснаар энэ үүргээ биелүүлдэг.

### 1.1.5 Сүмийн үүрэг

Сүм Есүс Христийн сайн мэдээг Бурханы бүх хүүхдэд заах зохион байгуулалт, арга хэрэгслээр хангадаг. Авралын болон өргөмжлөлийн ёслолуудыг хүлээн авах хүсэлтэй бөгөөд зохистой бүх хүмүүсийг адислах санваарын эрх мэдэл Сүмд байдаг.

## 1.2 Эцэгтээ эргэж очих нь

### 1.2.1 Есүс Христийн сайн мэдээ

Авралын төлөвлөгөө бол сайн мэдээний бүрэн байдал юм. Авралын төлөвлөгөөнд Бүтээлт, Уналт, Есүс Христийн Цагаатгал, сайн мэдээний бүх хууль, ёслол, сургаалууд багтдаг. Энэхүү төлөвлөгөө нь биднийг мөнхийн амьдралаар адислаад зогсохгүй, бас мөнх бус амьдралд баяр баясгаланг эдлэх боломжоор хангадаг (2 Нифай 2:25-ыг үзнэ үү).

Бид Есүс Христийн Цагаатгалаар дамжин нүглээс цэвэршин ариусч, Тэнгэрлэг Эцэгийнхээ дэргэд дахин очиход бэлтгэгдэж чадна. Бид энэ адислалыг хүлээн авахын тулд сайн мэдээний зарчмууд болон ёслолуудыг дагах ёстой (Итгэлийн Тунхаг 1:3-ыг үзнэ үү). Бид дараах зүйлсийг хийх хэрэгтэй:

1. Бурханы Төрсөн Ганц Хүү Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлийг хөгжүүлэх.
2. Наманчлалаар дамжуулан Бурхан уруу эргэж, зүрх сэтгэлээ өөрчлөн нүглээ хүлээн, нүглээсээ ангижрах.
3. Нүглээсээ өршөөгдөхийн төлөө баптисмын аврах ёслолыг хүлээн авах.
4. Сүмийн гишүүнээр батлуулж, гар тавилтаар Ариун Сүнсний бэлэг хүлээн авах.
5. Ариун гэрээнүүдийг сахиж, эцсийг хүртэл тэвчих.

Эдгээр зарчмуудыг Адамын үеэс хойш заасаар ирсэн билээ. Бид эдгээр үнэнийг ойлгож, Есүс Христийн тухай бат бөх гэрчлэлтэй болсноор Түүний зарлигуудыг дуулгавартай дагаж, өөрсдийн адислалуудыг гэр бүлийн гишүүдтэйгээ болон бусадтай хуваалцахыг хүсдэг (1 Нифай 8:9–37-г үзнэ үү). Гэрчлэлийн энэхүү бат бөх үндэс суурийг тавьснаар Сүмийн үйл ажиллагааны бусад хэсгүүд аяндаа төлөвшин хөгждөг.

Бид залбирах, судар судлах, тунгаан бодох болон дуулгавартай байх замаар Бурханд ойртсоноор сүнслэг байдлын хувьд өсч хөгждөг билээ. Нифай ийнхүү сургасан байдаг:

“Та нарыг энэ давчуу бөгөөд нарийн замд орсны дараа, бүгд хийгдсэн эсэхийг би асууя? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй; учир нь аврах чадал бүхий түүний гавьяанд та нар бүрэн дүүрнээр даатган, түүнд хэлбэрэлтгүй итгэлтэйгээр Христийн үгсээр бус аваас өдий зэрэгт хүрээгүй болой.

“Иймийн тул, та нар найдварын төгс гэрэлтэйгээр, мөн Бурханыг болон бүх хүмүүнийг хайрлах хайрыг агуулан Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүлэх ёстой. Иймийн тул, хэрэв та нар урагш тэмүүлэн, Христийн үгнээс зооглон, мөн эцсээ хүртэл тэвчих аваас, болгоогтун, Эцэгийн ийн хэлсэнчлэн: Та нарт мөнх амьдрал байх болно (2 Нифай 31:19–20-г үзнэ үү).

Бид бүгд Түүний зарлигуудыг мэдэж, сахин, сайн мэдээгээр амьдрах талаар Бурханы өмнө хариуцлага хүлээдэг билээ. Бид ажил үйлс, зүрх сэтгэлийнхээ хүсэл бодол мөн ямар хүмүүс болсныхоо дагуу шүүгдэх болно. Бид Есүс Христийн жинхэнэ дагалдагчид болсон үед зүрх сэтгэлийн хүчирхэг өөрчлөлтийг мэдэрч, “хилэнцийг үйлдэх хүсэлгүй болдог” (Мозая 5:2; мөн Алма 5:12–15, Моронай 10:32–33-г үзнэ үү). Бид Есүс Христийн сайн мэдээгээр амьдарсан үед шат шатаар өсч хөгжин, бусдыг хайрлаж, тэдэнд үйлчлэх талаараа Аврагчтай улам адилхан болдог.

### 1.2.2 Сүмийн удирдагчид болон багш нарын үүрэг

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид болон багш нар бусдад Есүс Христийн жинхэнэ дагалдагчид болоход нь туслахыг хичээдэг (Мозая 18:18–30-г үзнэ үү). Тэд хувь хүмүүс болон гэр бүлүүдэд ийнхүү туслахын тулд:

1. Есүс Христийн сайн мэдээний сургаалуудыг зааж, гэрчилдэг.
2. Ариун гэрээнүүдээ сахих чармайлтад нь хувь хүмүүс, гэр бүлүүдийг дэмждэг.
3. Зөвлөгөө өгч, дэмжин, үйлчлэх боломжоор хангадаг.

Түүнээс гадна санваарын ёслолуудын гүйцэтгэлд хяналт тавих эрх мэдэл санваартны зарим удирдагч нарт байдаг.

## 1.3 Мөнхийн гэр бүлүүдийг бий болгох нь

Гэр бүл нь Бурханы төлөвлөгөөнд нэн чухал бөгөөд энэ төлөвлөгөө үхлээс цааш үргэлжлэх гэр бүлийн харилцааны арга замыг заадаг. Ариун сүмийн ариун гэрээнүүдийг итгэлтэйгээр сахих нь гэр бүлтэйгээ үүрд нэгдэн Бурханы дэргэд эргэж очиход бидэнд тусалдаг.

### 1.3.1 Нөхөр, эхнэр хоёр

Есүс Христийн сайн мэдээгээр итгэлтэйгээр амьдарч, мөнхийн хань болцгоон лацдан холбуулсан хүмүүс л гагцхүү селестиел хаант улсын хамгийн дээд зэрэглэлд өргөмжлөлийг хүлээн авч чадна.

Санваарын эрх мэдлээр нөхөр, эхнэр хоёрыг энэ амьдралд болон үүрд мөнхөд лацдан холбохыг ариун сүмийн гэрлэлт гэдэг бөгөөд энэ бол хүн бүхэн хүлээн авахын төлөө хичээн чармайвал зохих онцгой боломж ба үүрэг юм. Энэ бол мөнхийн гэр бүлийн үндэс суурь юм.

Эрэгтэй, эмэгтэй хүний сүнсний мөн чанар нь бие туслан амьдрахад оршино. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтдаа өсч хөгжин, өргөмжлөлд хүрэх хувь тавилантай юм.

Эхнэр, нөхрүүдийг бие биетэйгээ нэгдэн нийлэхийг Их Эзэн зарлиг болгосон билээ (Эхлэл 2:24; С ба Г 42:22-ыг үзнэ үү). Энэ зарлигт *нэгдэн* нийлэх гэдэг үг хэн нэгэнд бүхнээ зориулж, итгэл төгс байх гэсэн утгатай юм. Гэрлэсэн хосууд бие биеэ хайрлан, үйлчилж, бие биедээ болон Бурханд чин үнэнч байж, гэрээнүүдээ сахиснаар Бурхантай мөн бие биетэйгээ нэгдэн нийлдэг (С ба Г 25:13-ыг үзнэ үү).

Хосууд гэр бүлээ зөв шударга амьдралын суурь болгон төвхнүүлснээр нэгдмэл болдог. Хожмын Үеийн Гэгээнтэн нөхөр, эхнэрүүд ганц бие амьдралаа ардаа орхиж, гэр бүлээ амьдралын эн тэргүүний эрхэмлэх зүйл болгон авч явдаг. Бурхантай болон бие биетэйгээ хийсэн гэрээнүүдээ сахихаас илүү хэн нэгнийг эсвэл аливаа зүйлийг дээгүүр тавих ашиг сонирхол тэдний амьдралд байх ёсгүй. Хэдий тийм ч гэрлэсэн хосууд гэр бүлдээ анхаарлаа төвлөрүүлэхийн хамт эцэг эх, ах, эгч, дүү нараа хайрлан, тэдэнд тусалдаг байх ёстой. Үүний адил гэр бүлийн үүрэг хариуцлага нь хайр, урам дэмээр насан туршид үргэлжилдгийг ухаалаг эцэг эхчүүд ойлгодог.

Гэрлэлтийн нэгдмэл байдал нь хамтач байхыг шаарддаг. Жишээ нь, Адам, Ева хоёр хамт ажиллаж, залбиран, хамт шүтэн биширч, хамтдаа золиослол хийж, хүүхдүүддээ сайн мэдээг хамт зааж, зөрүүд хүүхдүүдийнхээ төлөө хамтдаа уй гашуу болон шаналж байсан билээ. (Мосе 5:1, 4, 12, 27-г үзнэ үү). Тэр хоёр бие биетэйгээ болон Бурхантай нэгдмэл байлаа.

### 1.3.2 Эцэг эхчүүд ба хүүхдүүд

"Адам, Ева хоёрт Бурханы өгсөн анхны зарлиг нь тэд эхнэр нөхрийн хувьд эцэг эх болох талаар байлаа. . . .Өөрийн хүүхдүүддээ, өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэ гэсэн Бурханы зарлиг хүчин төгөлдөр байсаар байна" ("Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг"). Тэнгэрлэг төлөвлөгөөгөөр эрэгтэй, эмэгтэй хоёр хүн мөнх бус амьдралд хүүхдүүд төрүүлж, тэднийг өсгөн хүмүүжүүлэх хамгийн сайн орчин нөхцлийг бүрдүүлэх нь нэн чухал юм.

Гэрлэхийн өмнө бэлгийн харилцаанд орохоос бүрмөсөн татгалзаж, гэрлэснээс хойш чин үнэнч байх нь энэхүү үүрэг хариуцлагын ариун байдлыг хамгаалдаг. Эцэг эхчүүд, санваартны болон туслах бүлгүүдийн удирдагч нар энэ сургаалыг бэхжүүлэхийн төлөө чадах бүхнээ хийх ёстой.

Сүмийн удирдагчид эцэг эхийн үүргийн талаар заахдаа: "Эцэг нь өрх гэрээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, амьдралын хэрэгцээт зүйлсээр нь хангаж, гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Энэхүү ариун үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой" ("Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг") гэжээ. Хэрэв гэрт эцэг байхгүй бол эх нь гэр бүлийг тэргүүлдэг.

Эцэг эхчүүд "хүүхдүүдээ хайраар болон зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж, бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биенээ хайрлан, үйлчилж, Бурханы зарлигуудыг дагаж, хаана ч амьдарсан хуулийг хүндэтгэн сахидаг иргэд байхыг зааж сургах" ("Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг"; мөн Мозая 4:14–15-ыг үзнэ үү) тэнгэрлэг үүрэгтэй юм.

Ухаалаг эцэг эхчүүд Цагаатгалын эдгээгч, эвлэрүүлэгч, бэхжүүлэгч хүчийг гэр бүлдээ хэрхэн хэрэгжүүлэхийг хүүхдүүддээ заадаг. Мөнх бус хүмүүний сул дорой байдлууд, сэтгэл санааны эмзэглэл, уур уцаар бол нүглийн адил Бурханы хүүхдүүдийг Түүнээс тусгаарладаг юм. Эдгээр нөхцөл байдал гэр бүлийн гишүүдийг ч бие биенээс нь хөндийрүүлэн холдуулдаг. Гэр бүлийн гишүүн бүр гэр бүлийнхээ эв нэгдлийн төлөө хичээн чармайх үүрэгтэй. Гэр орондоо эвтэй байхыг хичээж сурсан хүүхдүүд гэр орноосоо гадуур эв эеийг илүү сайн хичээдэг.

### 1.3.3 Сүмийн гэрлээгүй гишүүд

Сүмийн бүх гишүүд тэр дотроо огт гэрлээгүй эсвэл гэр бүлгүй гишүүд ч мөнхийн гэр бүлд төгс амьдрахын төлөө хичээн чармайх хэрэгтэй. Энэ нь зохистой эхнэр, нөхөр эсвэл хайраар дүүрэн эцэг, эх болохын төлөө бэлтгэх ёстой гэсэн үг юм. Зарим тохиолдолд эдгээр адислалууд дараагийн амьдрал хүртэл биелэгдэхгүй байж болох ч туйлын зорилго нь хүн бүхний хувьд адил юм.

Энэ амьдралын нөхцөл байдлаас шалтгаалан мөнхийн гэрлэлт болон эцэг эх болох адислалуудыг хүлээн авах боломжгүй байгаа итгэлтэй гишүүд Бурхантай хийсэн гэрээнүүдээ сахих юм бол амлагдсан бүх адислалыг мөнх амьдралдаа хүлээн авах болно.

## 1.4 Гэр бүл ба Сүм

Сэргээгдсэн сайн мэдээний сургаал болон үйл ажиллагаагаар дамжуулан гэр бүл ба Сүм бие биенээ харилцан дэмжин, бат бэх болоход нь тусалдаг. Мөнх амьдралын адислалуудад тэнцэхийн тулд гэр бүлүүд сайн мэдээний сургаалуудаас суралцаж, зөвхөн Сүмээр дамжуулан авах боломжтой санваарын ёслолуудыг хүлээн авах хэрэгтэй. Хүчирхэг, оршин тогтнодог байгууллага байхын тулд Сүмд зөв шударга гэр бүлүүд хэрэгтэй.

Гэр бүл дээр төвлөрсөн Сүмийн ёслол, сургаал, хөтөлбөрүүд болон үйл ажиллагаануудаар дамжин хувь хүмүүс, гэр бүлүүд сүнслэг

байдлын хувьд өсч хөгждөг загварыг Бурхан илчилсэн юм. Сүмийн байгууллагууд, хөтөлбөрүүд нь хувь хүмүүс, гэр бүлүүдийг адислахын төлөө оршин тогтнодог. Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид, багш нар эцэг эхчүүдийг орлох биш, харин тэдэнд туслахыг хичээх ёстой.

Сүмийн бүх үйл ажиллагаа нь хувь хүмүүс болон гэр бүлүүдийн амьдралд дэмжлэг үзүүлдэг байхад санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид анхаарч, гэр бүлийн ариун нандин чанарыг улам бэхжүүлэхийг хичээх хэрэгтэй. Гэр бүлүүдийг Сүмийн хэтэрхий олон ажил үүргээр дарахгүй байхад Сүмийн удирдагчид анхаарах хэрэгтэй. Эцэг эхчүүд, Сүмийн удирдагч нар нь хувь хүмүүс болон гэр бүлүүдэд Есүс Христийг дагаснаар Тэнгэр дэх Эцэгтээ эргэж очиход туслахын тулд хамтран ажилладаг.

### 1.4.1 Гэр бүлийг бэхжүүлэх нь

Христийн дагалдагчдыг "цуглаж," "ариун газрууд дээр зогсон," "шилжин нүүлгэгдэхгүй байхыг" урьсан байдаг (С ба Г 45:32; 87:8; 101:22; мөн Шастирын дэд 35:5; Матай 24:15-ыг үзнэ үү). Эдгээр ариун газарт ариун сүм, гэр орон, ариун ёслолын цуглааны танхим орно. Эдгээр барилга байгууламжийн дотор оршдог Сүнс болон хүмүүсийн үйлдэл эдгээрийг "ариун газар" болгодог.

Сүмийн гишүүд хаана ч амьдардаг байлаа гэсэн, Сүнс оршдог гэр орныг бий болгох ёстой. Амьдардаг газраа дэлхийн муу нөлөөнөөс ангид байлгахын төлөө Сүмийн бүх гишүүд хичээж анхаарах хэрэгтэй. Сүмийн гишүүдийн гэр орон нь "залбирлын өргөө, мацгийн өргөө, итгэлийн өргөө, суралцахын өргөө, алдар суугийн өргөө, дэг журмын өргөө, Бурханы өргөө" байх боломжтой (С ба Г 88:119). Сүмийн гишүүд зөв зохистой зугаа цэнгэл, сайн хөгжим, сүнсний нөлөө бүхий урлагийн бүтээл (жишээ нь, Аврагчийн эсвэл ариун сүмийн уран зураг) зэрэг энгийн зүйлсээр дамжуулан Сүнсийг гэр орондоо урьж болно.

Хайраар дүүрэн, чин үнэнч эцэг эхчүүдтэй гэр орон бол хүүхдийн сүнсний болон бие бялдрын хэрэгцээг хамгийн үр өгөөжтэйгөөр бүрдүүлдэг орчин юм. Христ дээр төвлөрсөн гэр орон нь насанд хүрэгчид болон хүүхдүүдийг нүглээс хамгаалах, дэлхийн муу нөлөөнөөс ангид байлгах, сэтгэл санааны болон бусад эмгэгээс эдгээх, жинхэнэ хайр орших газар болж чадна.

Үр хүүхдээ "Эзэний дэг журам болон сургамж дотор" мөн "гэрэл ба үнэнд" өсгөн хүмүүжүүлэхийг эцэг эхчүүдэд үргэлж зарлиг болгосоор ирсэн билээ (Ефес 6:4; Инос 1:1), (С ба Г 93:40). Тэргүүн Зөвлөл тунхагласан нь:

> Үр хүүхдүүдийг тань Сүмд ойр байлгах сайн мэдээний зарчмуудыг тэдэнд зааж, эдгээр зарчмаар хүмүүжүүлэхэд бүх хүч чармайлтаа дайчлан ажиллахыг бид эцэг эхчүүдэд уриалж байна. Гэр орон бол зөв шударга амьдралын үндэс суурь бөгөөд Бурханаас өгсөн энэхүү үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэх амин чухал ажлыг нь өөр ямар ч арга хэрэгслээр биелүүлэх буюу орлуулах боломжгүй юм.
>
> Гэр бүлийн залбирал, гэр бүлийн үдэш, сайн мэдээг судлах болон гэр бүлийн үр өгөөжтэй үйл ажиллагаанд тэргүүн зэргийн ач холбогдол өгч байхыг эцэг эх, хүүхдүүдэд бид зөвлөж байна. Үр өгөөжтэй, тохиромжтой бусад ажил, үйл ажиллагаа байж болох ч, тэдгээр нь гагцхүү эцэг эхчүүд, гэр бүлийн гүйцэтгэж чадах тэнгэрлэг үүргийг орлох ёсгүй" (Тэргүүн Зөвлөлийн захидал, 1999 оны 2-р сарын 11).

Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүү Есүс Христийг мэдэхэд нь үр хүүхэддээ туслах үндсэн үүрэг хариуцлага эцэг эхчүүдэд байдаг (Иохан 17:3-ыг үзнэ үү). Хожмын Үеийн Гэгээнтэн эцэг эхчүүдэд сайн мэдээний сургаал, ёслолууд, гэрээнүүд болон зөв шударгаар амьдрах арга замуудыг үр хүүхэддээ заахыг зарлиг болгосоор ирсэн билээ (С ба Г 68:25–28-ыг үзнэ үү). Эдгээр зүйлсийг заалгаж хүмүүжсэн хүүхдүүд зохих насанд хүрсэн үедээ санваарын ёслолуудыг хүлээн авч, Бурхантай гэрээнүүд хийж тэдгээрийг дагахад бэлтгэгддэг.

Гэр бүлүүдийг бэхжүүлэх нь гэрийн болон айлчлагч багш, гэр бүлийн үдэш зэрэг сүнслэг нөлөө бүхий Сүмийн хөтөлбөрүүдийн анхаарал төвлөрүүлдэг зүйл юм (С баГ 20:47, 51-ийг үзнэ үү). Есүс бүх зүйлд үлгэр дууриал үзүүлдэг байсныхаа адил, гэр орноор орж үйлчлэх, заах, адислахад үлгэр жишээ үзүүлсэн билээ (Матай 8:14–15; 9:10–13; 26:6; Марк 5:35–43; Лук 10:38–42; 19:1–9-ийг үзнэ үү).

### 1.4.2 Гэр бүлийн үдэш

Сайн мэдээг хүүхдүүддээ заах, үүний үнэнийг гэрчлэх, гэр бүлийн эв нэгдлийг бэхжүүлэхийн тулд гэр бүлийн үдшийг долоо хоног бүр явуулж байхыг хожмын үеийн бошиглогчид эцэг эхчүүдэд зөвлөдөг билээ. Гэр бүлийн үдшийг тогтмол хийж байхын тулд гадас, тойргийн удирдагчид даваа гарагийн орой Сүмийн аливаа хурал цуглаан, үйл ажиллагаа явуулахгүй байх ёстой.

Гэр бүлийн үдэшт гэр бүлийн залбирал, сайн мэдээний хичээл, гэрчлэлээ хуваалцах, сүмийн дуулал болон Хүүхдийн Хэсгийн дуунууд, үр өгөөжтэй амралт чөлөөт цагийн үйл ажиллагаанууд орж болно. (Гэр оронд хөгжим ашиглах тухай мэдээллийг 14.8-аас үзнэ үү.) Эцэг эхчүүд зорилго дэвшүүлэх, асуудал шийдвэрлэх, цагийн хуваарийг зохицуулах, гэр бүлийн гишүүдийг хүчирхэгжүүлж, дэмжлэг туслалцаа үзүүлэхийн тулд гэр бүлийн зөвлөгөөнийг гэр бүлийн үдшийн хэсэг болгож эсвэл тусад нь хийж болно.

Гэр бүлийн үдэш бол эцэг эхчүүдийн удирдлага дор зөвхөн халуун ам бүлээрээ цугладаг эрхэм нандин цаг мөч юм. Энэ үеэр гэр бүлүүд юу хийх талаар санваартны удирдагчид удирдамж чиглэл өгөх ёсгүй.

### 1.4.3 Хувь хүмүүсийг бэхжүүлэх нь

Гэр бүлээсээ сүмийн талаар сайн дэмжлэг авч чаддаггүй гишүүдийг Сүмийн удирдагч нар онцгой анхаарах хэрэгтэй. Ийм гишүүдийн тоонд эцэг эх нь Сүмийн гишүүн биш хүүхэд, залуучууд, гэр бүлийн гишүүдийнх нь зарим нь гишүүн бус хүмүүс болон бүх насны ганц бие насанд хүрэгчид орно. Тэд бол Бурханы мөнхийн гэр бүлийн гэрээт гишүүд бөгөөд Тэрээр тэднийг маш их хайрладаг. Сүмд үйлчлэх боломжийг эдгээр хүмүүст олгох хэрэгтэй. Сүмд эдгээр гишүүд өөр хаанаас ч олж чадахааргүй сайхан хамт олон, нөхөрлөлийг олж чадна.

Сүмийн гишүүн бүр үнэ цэнэтэй юм. Бурханы мөнхийн төлөвлөгөө нь Түүний итгэлтэй бүх хүүхдүүдэд мөнх амьдралын адислал болгоныг хүлээн авч, мөнхийн гэр бүлүүдэд өргөмжлөгдөх боломжийг олгодог билээ.

# 2. Санваарын зарчмууд

2.1 **Санваарын эрх мэдэл . . . . . . . . . . . . . . . . . . . . . 8**
2.1.1 Санваарын түлхүүрүүд . . . . . . . . . . . . . . . . . . . . 8
2.1.2 Ёслолууд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 9
2.1.3 Гэрээнүүд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 9
2.2 **Сүмийн зорилго . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 9**
2.3 **Санваар ба гэр бүл . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 10**
2.4 **Санваарын эрх мэдлийг ашиглах нь . . . . . . . . 10**
2.4.1 Эрх мэдлийг хүлээн авах нь . . . . . . . . . . . . . . . 10
2.4.2 Эрх мэдлийг олгох нь . . . . . . . . . . . . . . . . . . . . 10
2.4.3 Санваарын эрх мэдлийг зөв шударгаар хэрэглэх нь . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 10
2.4.4 Хурал цуглааныг тэргүүлэх нь . . . . . . . . . . . . . 10
2.4.5 Санваарын дуудлагаа эрхэмлэн биелүүлэх нь . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 10

# 2. Санваарын зарчмууд

Санваар бол Бурханы хүч ба эрх мэдэл юм. Санваар үргэлж оршиж байсан бөгөөд цаашид эцэс төгсгөлгүй орших болно (Алма 13:7–8; С ба Г 84:17–18-ыг үзнэ үү). Бурхан санвaараар дамжуулан газар, тэнгэр, дэлхийг бүтээсэн бөгөөд тэдгээрийг санваарын хүчээр удирддаг билээ. Тэрээр энэ хүчээр дамжуулан дуулгавартай хүүхдүүдээ өргөмжилж, "үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг" (Мосе 1:39; мөн С ба Г 84:35–38-ыг үзнэ үү) хүмүүнд авчирдаг.

Санваар бол энэ амьдралд Бурханы хүүхдүүдийг аврахад шаардлагатай бүх зүйлийг хийх Бурханаас хүмүүнд өгсөн үйлдэх хүч, эрх мэдэл юм. Сайн мэдээг хүлээн авсан бүх хүмүүс санваарын адислалуудыг хүртэх боломжтой.

Санваарын талаар удирдагчдын судлах ёстой чухал судрын хэсгүүдэд Алма 13; Сургаал ба Гэрээ 13, 20, 84, 107, 121; 124 орно.

## 2.1 Санваарын эрх мэдэл

Санваарыг Аароны болон Мелкизедек санваар гэж хоёр хуваадаг.

Аароны санваар бол доод санваар бөгөөд "Мелкизедек санваарын. . .бэлтгэл хэсэг" юм (С ба Г 107:13–14-ийг үзнэ үү). Энэ санваарыг Мосегийн ах Аарон болон Аароны хөвгүүдэд олгосон учраас Аароны санваар гэж нэрлэдэг.

Аароны санваарт тэнгэр элчүүдийн үйлчлэл, наманчлалын сайн мэдээ, нүглийн уучлалын төлөө усанд умбуулалтаар хийх баптисмын түлхүүрүүд орно (С ба Г 13:1; 84:26–27; 107:20-ийг үзнэ үү). Аароны санваар эзэмшдэг хүмүүс баптисм ба ариун ёслол болох "гаднах ёслолуудыг" гүйцэтгэх эрх мэдэлтэй байдаг (С ба Г 107:14-ийг үзнэ үү). Бишоп бол тойргийнхоо Аароны санваартнуудын ерөнхийлөгч юм. Бишоп энэ үүргийнхээ дагуу тойргийнхоо халамжийн болон санхүүгийн асуудлыг удирддаг (С ба Г 107:68-ыг үзнэ үү).

Мелкизедек санваар бол дээд буюу илүү агуу санваар юм. Есүс Христийн Сүм дэлхий дээр бүрэн байдлаараа байгаа үед энэ санваар оршиж, үйлчилж байдаг. Мелкизедек санваарыг эхний үед "*Бурханы Хүүгийн жаягийн дагуух Ариун санваар" гэж нэрлэдэг байжээ.* Гэвч Агуу Нэгэний нэрийг хүндэтгэх буюу эрхэмлэхээс үүдэн, түүний нэрийг хэтэрхий олон удаа давтахаас зайлсхийж сүмийнхэн эрт дээр үед энэ санваарыг Мелкизедекийн нэрээр буюу Мелкизедек санваар хэмээн нэрлэдэг болжээ" (С ба Г 107:3–4). Мелкизедек бол Абрахамын үед амьдарч байсан "агуу дээд санваартан" (С ба Г 107:2) байлаа.

Сүмийн удирдагчид Мелкизедек санваарын эрх мэдлээр дамжуулан Сүмийг удирдаж, дэлхий даяар сайн мэдээг номлох ажлыг чиглүүлэн, Сүмийн сүнслэг ажлыг удирдан зохион байгуулдаг (С ба Г 84:19–22; 107:18-ыг үзнэ үү). Сүмийн Ерөнхийлөгч бол Мелкизедек санваарын тэргүүлэх дээд прист юм.

Хүн Мелкизедек санваар авснаар итгэлтэй байж, дуудлагаа эрхэмлэн биелүүлж, Бурхан болон Түүний үйлчлэгчдийн үг бүрээр амьдрахаар гэрээнд ордог билээ (С ба Г 84:33–44-ийг үзнэ үү).

### 2.1.1 Санваарын түлхүүрүүд

Санваарын түлхүүрүүд бол санваартны удирдагч нарт Түүний санваарыг дэлхий дээр хэрэглэх, удирдах, хянах, засаглах Бурханаас олгосон эрх мэдэл юм. Санваарын түлхүүрүүдийг эзэмшдэг хүмүүс санваарын эрх мэдлийг удирдан зохион байгуулдаг (С ба Г 65:2; 81:2; 124:123-ыг үзнэ үү). Санваарын түлхүүрүүдийг эзэмшдэг хүмүүс тухайн эрх мэдлийнхээ хүрээнд Сүмийг тэргүүлж, удирддаг.

Есүс Христ Өөрийн Сүмд хамаатай санваарын бүх түлхүүрийг эзэмшдэг. Тэрээр дэлхий дээрх Бурханы хаант улсад хамаатай бүх түлхүүрийг Төлөөлөгч бүрдээ олгосон юм. Хамгийн ахмад, амьд сэрүүн Төлөөлөгч бол Сүмийн Ерөнхийлөгч бөгөөд тэр санваарын бүх түлхүүрийг ашиглах эрх мэдэл бүхий дэлхий дээрх цорын ганц хүн юм (С ба Г 43:1–4; 81:2; 107:64–67, 91–92; 132:7-г үзнэ үү).

Далууд томилолтоор буюу Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгаас эрх мэдэл олгосноор ажил хэргийг явуулдаг. Бүсийн ерөнхийлөгчдийг Тэргүүн Зөвлөл ба Арванхоёроос эрх мэдэл олгосны дагуу бүсүүдийг удирдуулахаар томилдог. Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийг адисалж, Далын Чуулгуудыг тэргүүлэх түлхүүрүүдийг олгодог.

Сүмийн Ерөнхийлөгч нь санваарын түлхүүрүүдийг Санваартны бусад удирдагч нарт хариуцсан бүсүүдийг нь тэргүүлүүлэхээр олгодог. Санваарын түлхүүрүүдийг ариун сүм, номлол, гадас, дүүргийн ерөнхийлөгч, бишоп, салбарын ерөнхийлөгч болон чуулгын ерөнхийлөгч нарт

олгодог. Тэргүүлэх энэхүү эрх мэдэл нь удирдагч бүр зөвхөн харьяаллынхаа нутаг дэвсгэрт дуудагдсан үүргээ биелүүлэхэд хүчин төгөлдөр байдаг. Санваартны удирдагчид дуудлагаасаа чөлөөлөгдөхдөө дуудлагатайгаа холбоотой түлхүүрүүдийг цаашид эзэмшихээ мөн больдог.

Санваартны удирдагчдын зөвлөхүүд түлхүүрүүдийг хүлээн авдаггүй. Тэд онцгойлон адислагдаж, даалгасан болон олгосон эрх мэдлийн дагуу дуудлагат ажлаа гүйцэтгэдэг.

Тойрог, гадасны бүх туслах бүлгүүд тэргүүлэх эрх мэдэл бүхий гадасны ерөнхийлөгч эсвэл бишопын удирдлага дор ажилладаг. Туслах бүлгүүдийн ерөнхийлөгч болон тэдний зөвлөхүүд түлхүүрүүдийг хүлээн авдаггүй. Тэд дуудлагадаа тохирсон эрх мэдлийг хүлээн авдаг.

### 2.1.2 Ёслолууд

Сайн мэдээний ёслолуудыг гүйцэтгэхэд санваарын эрх мэдэл шаардлагатай. Ёслол гэдэг нь баптисм, гишүүний баталгаа, ариун ёслол зэрэг бэлгэдэл бүхий ариун зан үйл юм. Ёслол бүр нь арвин баялаг адислалын үүд хаалгыг нээдэг. Бэлгэдэл нь Эцэгийн хайр, Хүүгийн Цагаатгал, Ариун Сүнсний нөлөөг санахад ёслолыг хүлээн авагчдад тусалдаг.

Ёслолууд нь үргэлж Есүс Христийн сайн мэдээний хэсэг байсаар ирсэн билээ. Жишээ нь баптисмыг Адам, Ева хоёрын үед бий болгосон бөгөөд өнөөдөр Их Эзэний сүмд хэрэглэсээр байна. Аврагчийг үргэлж санаж баптисмын гэрээнүүд болон адислалуудаа шинэчлэхийн тулд хамтдаа ойр ойрхон цуглаж, ариун ёслолоос хүртэхийг Сүмийн гишүүдэд зарлиг болгосон юм (Моронай 6:6; С ба Г 59:8–9-ийг үзнэ үү).

Зарим ёслол нь хариуцлага хүлээх чадвартай бүх хүмүүс селестиел хаант улсад өргөмжлөгдөхөд шаардлагатай байдаг. Эдгээр ёслолд баптисм, гишүүний баталгаа, Мелкиседек санваарын томилолт (эрэгтэйчүүдэд), ариун сүмийн хишиг, ариун сүмийн лацдан холболт ордог. Сүмийн амьд сэрүүн байгаа гишүүд авралын болон өргөмжлөлийн эдгээр ёслолыг өөрсдийнхөө төлөө авдаг. Нас барсан хүмүүс эдгээр ёслолыг төлөөлөн хийлгэх замаар хүлээн авч болно. Төлөөлөн хийдэг эдгээр ёслолыг сүнсний дэлхий дэх нас барсан хүмүүс хүлээн зөвшөөрч, холбогдох гэрээнүүдийг хүндэтгэн сахисан үед хүчин төгөлдөр болдог.

Ёслол гүйцэтгэх болон шаардлагатай эрх мэдлийг хүлээн авах тухай мэдээллийг 20-р бүлгээс үзнэ үү.

### 2.1.3 Гэрээнүүд

Аврал, өргөмжлөлд шаардлагатай бүх ёслолыг Бурхантай хийдэг гэрээнүүд дагалддаг. Гэрээ бол Бурхан болон Түүний хүүхдүүдийн хоорондох мөнхөд үргэлжилдэг, ариун амлалт юм. Бурхан гэрээний нөхцөлүүдийг өгдөг бөгөөд Түүний хүүхдүүд эдгээр нөхцөлийг хүлээн зөвшөөрдөг. Тухайн хүн гэрээг итгэлтэйгээр сахих эсэхээс хамааран Бурхан адислалуудыг амладаг.

Сүмийн гишүүд гэрээнүүдээ хүндэтгэн сахисан үед энэ амьдралд агуу ихээр адислагдаж, өргөмжлөгдөх боломжтой (Египетээс гарсан нь 19:3–5; Шүүгчид 2:1; 3 Нифай 20:25–27; Моронай 10:33; С ба Г 42:78; 97:8-ыг үзнэ үү).

Ёслолуудыг хүлээн авахад хувь хүнийг бэлтгэхийн тулд тухайн хүн хийх гэрээнүүдээ ойлгоход нь эцэг эхчүүд, гэр бүлийн бусад гишүүд, санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид анхаарна (Мозая 18:8–11-ийг үзнэ үү). Ёслолын дараа гэрээнүүдээ сахихад нь түүнд тусална (Мозая 18:23–26-г үзнэ үү).

## 2.2 Сүмийн зорилго

Бурхан хүүхдүүддээ аврал, өргөмжлөлд хүргэх Өөрийн ажилд туслуулахын тулд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг зохион байгуулсан юм. Сүм бүх хүмүүсийг "Христэд иржэ, түүгээр төгөлдөржихөд"(Моронай 10:32; мөн С ба Г 20:59-ийг үзнэ үү) урьдаг. Христэд ирэх урилга нь дэлхий дээр амьдарч байсан, амьдарч байгаа мөн ирээдүйд амьдрах бүх хүмүүст хамаарна.

Хүмүүс баптисм ба гишүүний баталгааны ёслолуудыг хүлээн авснаар Сүмийн гишүүд болдог. Сүм тэднийг болон гэр бүлийг нь дэмжиж дэлхийн нөлөө, ёс бус байдлын "шуурганаас хоргодох газар" болдог (С ба Г 115:6-г үзнэ үү). Мөн үйлчлэл, адислал, хувь хүний өсөлт хөгжилтийн боломжуудаар хангадаг. Сүмийн хөтөлбөр, үйл ажиллагаанууд нь хувь хүмүүс, гэр бүлүүдэд дэмжлэг үзүүлж, бэхжүүлдэг.

Сүм хувь хүмүүс болон гэр бүлүүдийг өргөмжлөлд тэнцэхээр болоход туслах зорилгоо хэрэгжүүлэхийн тулд тэнгэрлэгээр өгөгдсөн үүрэг хариуцлага дээрээ анхаарал төвлөрүүлдэг. Есүс Христийн сайн мэдээгээр амьдрахад гишүүдэд туслах, номлолын ажлаар дамжуулан Израилыг цуглуулах, ядуус, тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах, ариун сүмүүд барьж, төлөөлөх ёслолуудаар дамжуулан нас барагсдын авралыг боломжтой болгох нь эдгээр үүрэг хариуцлагад ордог.

## 2.3 Санваар ба гэр бүл

Сүмийн гишүүн нөхөр, эцэг бүр зохистой Мелкизедек санваартан байхын төлөө хичээх ёстой. Мөн гэр бүлийнхээ сүнслэг тэргүүлэгчийн хувиар үйлчлэн, эхнэртэйгээ эрх тэгш хамтрагч байж, зөв шударга байдал, хайраар өрх гэрээ тэргүүлдэг. Тэд гэр бүлээрээ тогтмол залбирал хийх, судар судлах болон гэр бүлийн үдшийг явуулахад удирддаг. Тэрээр хүүхдүүддээ заах, авралын ёслолуудыг хүлээн авахад бэлтгэхэд нь тэдэнд туслахад эхнэртэйгээ хамтран ажилладаг (С ба Г 68:25–28-ыг үзнэ үү). Тэрээр сүнслэг удирдамж ба эдгээх, тайтгаруулах санваарын адислалуудыг өгдөг.

Олон гишүүдийн гэрт итгэлтэй Мелкизедек санваартан байдаггүй. Иймд сүмийн удирдагч нар сүнслэг анхаарал халамж тавин, гэрийн болон айлчлагч багш нараар дамжуулан эдгээр гишүүдийг хайрлах, тэдэнд дэмжлэг үзүүлэхэд онцгой анхаарах ёстой.

## 2.4 Санваарын эрх мэдлийг ашиглах нь

### 2.4.1 Эрх мэдлийг хүлээн авах нь

Ах нарыг санваарын албуудад томилох тухай мэдээллийг 20.7-гоос үзнэ үү. Сүмийн дуудлагуудад гишүүдийг дуудах, дэмжүүлэн батлуулах, онцгойлон адислах явцын тухай мэдээллийг 19-р бүлгээс үзнэ үү.

### 2.4.2 Эрх мэдлийг олгох нь

Санваартны удирдагчид дуудлагаа биелүүлэхэд нь туслахын тулд бусад хүмүүст эрх мэдлийг олгож болно. Эрх мэдэл олгох тухай мэдээллийг 3.3.4-өөс үзнэ үү.

### 2.4.3 Санваарын эрх мэдлийг зөв шударгаар хэрэглэх нь

Бусдын амьдралыг адислахын тулд санваарыг ашиглах ёстой. Зөв шударга санваартны удирдагч нар хайр, нинжин сэтгэлээр тэргүүлдэг. Тэд өөрсдийн хүсэл бодлыг бусдад тулгахыг хичээх ёсгүй. Ингэхийн оронд тэд бусадтай зөвлөлдөж, илчлэлтээр дамжуулан нэгдмэл санаа бодолд хүрэхийг хичээдэг. Зөв шударгаар бус аваас санваарын хүчийг хэрэглэж чадахгүй гэдгийг Их Эзэн бидэнд хэлсэн билээ (С ба Г 121:36-г үзнэ үү). Иймд санваарын хүчийг сэнхрүүлэл, тэсвэр тэвчээр, нинжин сэтгэл, элдэг дөлгөөн байдал, чин сэтгэлийн хайраар ашиглавал энэ нь зөв болно (С ба Г 121:36, 41–42-ыг үзнэ үү). Хэрэв хүн санваарын хүчийг буруу ашиглахыг хичээвэл "тэнгэр өөрийгөө татан авдаг буюу; Их Эзэний Сүнс гашуудлаг болой; мөн энэ нь буцаан татагдахад, тэр хүний санваарт эсвээс эрх мэдэлд Амен" (С ба Г 121:37).

### 2.4.4 Хурал цуглааныг тэргүүлэх нь

Хурал нь эв нэгдэл, Их Эзэний хүслийг хамтаараа эрж хайх итгэлд хүрэх арга хэрэгслээр удирдагчдыг хангадаг. Хурал нь чуулга, туслах бүлгүүдийн ажлыг уялдуулан зохицуулах боломж олгодог. Орон нутгийн түвшинд хурлыг тэргүүлэх жишээ бол гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, бишопын зөвлөл, санваартны гүйцэтгэх хороод юм. Хурлын тухай мэдээллийг 4.1-ээс үзнэ үү.

### 2.4.5 Санваарын дуудлагаа эрхэмлэн биелүүлэх нь

Санваар атгагчид гэр орондоо болон бусад Гэгээнтнүүдэд үйлчилж, даалгасан ажил үүргийг ухамсартайгаар биелүүлснээрээ дуудлагаа эрхэмлэн биелүүлдэг. "Хүн бүр өөрийн үүргийг мэдэж аваг, тэрээр томилогдсон албан тушаалдаа бүхий л хичээл зүтгэлээр ажиллаг" (С ба Г 107:99) хэмээн Их Эзэн анхааруулсан юм. Санваартны удирдагчид хичээл зүтгэлээр үйлчилж, итгэл, гэрчлэлээр зааж, хариуцсан хүмүүсийнхээ зөв шударга байдлыг урамшуулан дэмжиж, бэхжүүлснээр дуудлагаа эрхэмлэн биелүүлдэг.

# 3. Есүс Христийн Сүмийн удирдлага

3.1 **Аврагчийн удирдах арга барил . . . . . . . . . . . . .12**

3.2 **Сайн мэдээний удирдлагын зарчмууд . . . . . .12**

3.2.1 Сүнслэг байдлын хувьд бэлтгэнэ. . . . . . . . . . .12
3.2.2 Хуралд оролцоно. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .12
3.2.3 Бусдад үйлчил . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .12
3.2.4 Есүс Христийн сайн мэдээг заана . . . . . . . . . .12
3.2.5 Санваартны болон туслах байгууллагуудыг удирдана . . . . . . . . . . . . . . .13

3.3 **Удирдагчдад зориулсан нэмэлт заавруud . . .13**

3.3.1 Их Эзэнийг болон Түүний Сүмийг төлөөлнө . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .13
3.3.2 Эв эе, нэгдмэл байдлыг бий болго. . . . . . . . . .13
3.3.3 Удирдагч болон багш болоход нь бусдыг бэлтгэ . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .13
3.3.4 Ажил үүргийг нь даалгаж, хариуцлагыг төлөвшүүл. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .13
3.3.5 Нүглээс сэрэмжлүүл, гэхдээ нүгэл үйлдэгчийг хайрла. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .14
3.3.6 Бишрэл хүндэтгэлийг дэмж . . . . . . . . . . . . . . .14
3.3.7 Хурал цуглааны хэлэлцэх асуудлуудыг бичгээр бэлтгэ . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .14
3.3.8 Зорилго тавьж төлөвлө. . . . . . . . . . . . . . . . . . . .14
3.3.9 Үүрэгт ажилдаа суралцахдаа Сүмийн эх сурвалжуудыг ашигла . . . . . . . . . . . . . . . . . . . .14

3.4 **Удирдлагын зорилго . . . . . . . . . . . . . . . . . . . . . .15**

# 3. **Есүс Христийн Сүмийн удирдлага**

## 3.1 Аврагчийн удирдах арга барил

Сүмийн бүх удирдагч нар бусдыг "Христийн. . . үнэн дагалдагчид" (Моронай 7:48) болоход нь туслахын тулд дуудагдсан юм. Үүний тулд удирдагч нар юуны өмнө Аврагчийн итгэлтэй шавь нар байхыг цаг үргэлж хичээх ёстой бөгөөд ингэснээр Бурханы оршихуйд эргэж очих болно. Тэгвэл тэд бат бөх гэрчлэлийг хөгжүүлж, Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт улам ойртоход нь бусдад тусалж чадна. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд Сүмийн хөтөлбөр, үйл ажиллагаануудыг ашигладаг.

Удирдагчид хэрхэн "үнэн дагалдагчид" байхыг үлгэр жишээгээрээ бусдад хамгийн сайн зааж чадна. —Итгэлтэй шавь болоход нь бусдад туслахын тулд өөрөө итгэлтэй шавь байх—энэхүү загвар бол Сүм дэх дуудлага бүрийн зорилго юм.

Удирдагчид энэ загварын дагуу үйлчилснээр ариун сүмийн гэрлэлт болон мөнхийн гэр бүлийн адислалд зохистой байх хүсэл эрмэлзэлтэй болоход нь Сүмийн гишүүдэд тусалдаг.

## 3.2 Сайн мэдээний удирдлагын зарчмууд

### 3.2.1 Сүнслэг байдлын хувьд бэлтгэнэ

"Чи [өөрөө хөрвөсний дараа], ах дүүсээ батжуул" (Лук 22:32) хэмээн Аврагч Петрт зарлиг болгосон билээ. Удирдагчид өөрсдөө хөрвөж, сүнслэг байдлын хувьд өсч хөгжсөн үед бусдад хөрвөж, сүнслэг байдлын хувьд өсч хөгжихөд нь тусалж чадна.

Удирдагчид зарлигуудыг сахиж, судрууд болон хожмын үеийн бошиглогчдын сургаалуудыг судалж, залбиран, мацаг барьж, Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусгаснаар өөрсдийгөө сүнслэг байдлын хувьд бэлтгэдэг. Тэд энэхүү бэлтгэлийг хангаснаар хувийн амьдрал, гэр бүлийн үүрэг хариуцлага болон дуудлагадаа өөрсдийгөө удирдах сүнсний удирдамжийг хүлээн авч чадна.

### 3.2.2 Хуралд оролцно

Удирдагчид тэргүүлэх албан тушаалтнуудын удирдлага дор цуглан хувь хүмүүс, гэр бүлүүдэд туслах арга замуудыг хэлэлцэхийн тулд хуралддаг. Тэд Ариун Сүнсээр удирдагдан өөрсдийнхөө байгууллагын гишүүдэд үйлчлэх үр ашигтай арга замуудыг тодорхойлохын тулд хамтран ажилладаг. Сүм дэх хурал цуглааны зарим жишээ бол тойргийн болон гадасны зөвлөл, бишопын зөвлөл, чуулгууд болон туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлууд юм. Хуралд оролцох тухай удирдамжийг 4-р бүлгээс үзнэ үү.

### 3.2.3 Бусдад үйлчил

Удирдагчид Аврагчийн нэгэн адил хувь хүмүүс, гэр бүлүүдэд сүнслэг болон материаллаг байдлын аль алинаар нь үйлчлэхийг эрэлхийлдэг. Тэд зөвхөн байгууллагыг удирдахад хамаг анхаарлаа төвлөрүүлэх бус харин хүн болгонд анхаарал халамж тавих ёстой. Тэд шинэ болон идэвх султай гишүүд, ганцаардаж байгаа, тайтгарал хэрэгтэй хүмүүст хүрч ажиллах хэрэгтэй.

Үйлчлэлийн зорилго бол Христийн үнэн дагалдагчид болоход нь бусдад туслах явдал юм. Бусдад үйлчилнэ гэдэгт дараах зүйлс орно:

- Тэдний нэрсийг тогтоож, тэдэнтэй танилцах (Моронай 6:4-ийг үзнэ үү).
- Тэднийг шүүмжлэлгүйгээр хайрлах (Иохан 13:34–35).
- Аврагч үүнийг хийсэн лүгээ адил, тэднийг харж хандан, итгэлийг нь "нэг нэгээр" (3 Нифай 11:15; 17:21-ийг үзнэ үү) бэхжүүлэх.
- Тэдэнтэй чин сэтгэлээсээ нөхөрлөж, уулзаж ярилцах (С ба Г 20:47-г үзнэ үү).

### 3.2.4 Есүс Христийн сайн мэдээг заана

Бүх удирдагчид бол багш нар юм. Үр ашигтайгаар заах нь Бурхантай харилцах харилцаагаа бэхжүүлж, сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрахад нь хүмүүст сүнслэгээр нөлөөлдөг.

Удирдагчдын хувийн үлгэр жишээ бол заах хамгийн хүчтэй арга юм. Удирдагчид нь удирдлагын хурал, хичээл, үйл ажиллагаанууд дээр гэрчлэлээ хуваалцаж, сургаал дээр тулгуурласан ярилцлага хөтлөн явуулах замаар заадаг. Тэд судруудаас болон хожмын үеийн бошиглогчдын үгсээс заадаг. "Үгийг номлох нь. . . илднээс, эсвээс [өөр] юунаас ч. . .илүү их нөлөө[тэйг]" (Алма 31:5) тэд мэддэг.

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид сайн мэдээг өөрсдөө заахаас гадна бүлгүүдийнхээ сурах, заах ажлын чанарыг хариуцдаг. Ангиудад заагдаж буй хичээл нь үр

өгөөжтэй, сургамжтай мөн сургаалын хувьд зөв байхад тэд анхаарна.

Сайн мэдээг заах болон сурах, багшлах ажлыг сайжруулахад хяналт тавих удирдамжийн тухай нэмэлт мэдээллийг 5.5-аас үзнэ үү.

### 3.2.5 Санваартны болон туслах байгууллагуудыг удирдана

Удирдагчид Сүмээс гаргасан удирдамжуудыг баримталсан үед бусдыг бэхжүүлэх хүч чармайлт нь хамгийн үр дүнтэй байдаг. Санваартны болон туслах байгууллагуудыг удирдах удирдамжууд 7–12-р бүлэгт байгаа.

## 3.3 Удирдагчдад зориулсан нэмэлт зааврууд

### 3.3.1 Их Эзэнийг болон Түүний Сүмийг төлөөлнө

Сүмийн удирдагчдыг Их Эзэн Өөрийн томилогдсон үйлчлэгчдээр дамжуулан дууддаг учраас тэд Түүнийг болон Түүний Сүмийг төлөөлдөг. Удирдагчид Аврагчийн төлөөлөгчид учраас Түүнийг өөрсдийнхөө үлгэр жишээ болгон хардаг. "Та нар ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ? Үнэнээр би та нарт хэлье, бүр миний адил буюу"(3 Нифай 27:27) хэмээн Тэрбээр хэлсэн юм.

### 3.3.2 Эв эе, нэгдмэл байдлыг бий болго

"Нэг байгтун; мөн хэрэв та нар нэг байхгүй аваас та нар минийх биш болой"(С ба Г 38:27) гэж Их эзэн хэлсэн билээ. Тэргүүлэх албан тушаалтнууд өөрсөдтэйгөө хамт үйлчилдэг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс зөвлөгөө хүссэнээрээ эв нэгдлийг хөхүүлэн дэмждэг. Ерөнхийлөгчийн зөвлөлүүдийн гишүүд санаа бодлоо илэн далангүй, тод томруунаар хуваалцаж, бие биеэ анхааралтай сонссоноор эв нэгдлийг бий болгоход тусалдаг.

Сүмийн туслах бүлгийн удирдагчид санваартны удирдагчдаа дагаж, ерөнхийлөгчийн зөвлөлийн болон зөвлөлүүдийн гишүүд эв нэгдэлтэй байвал Ариун Сүнснээс удирдамж хүлээн авч, Их Эзэний таалльн дагуу удирдаж чадна.

### 3.3.3 Удирдагч болон багш болоход нь бусдыг бэлтгэ

Зарим тойргуудад удирдагчид санваартны болон туслах бүлгүүдэд үйлчлэх цөөхөн хэдэн хүнд үргэлж найдлага тавьдаг. Энэ нь итгэлтэй цөөхөн хүнд ачаалал өгч, бусдад сурч, хөгжин дадлага туршлагатай болоход нь саад болж мэднэ. Үр өгөөжтэй ажилладаг удирдагчид үйлчлэх боломжийг бүх гишүүдэд олгодог.

Тэргүүлэх эрх мэдэлтнүүд нь удирдах болон заах дуудлагад үйлчлэх гишүүдийг залбирч судлахдаа Их Эзэн дуудсан хүмүүсээ өсгөж хөгжүүлдэг гэдгийг санах ёстой. Гишүүдийг удирдагч болон багшаар дуудахдаа туршлагатай эсэхийг харгалзах шаардлагагүй. Тэд итгэлээ ашиглан, шаргуу хөдөлмөрлөж, удирдагчдаасаа заавар, дэмжлэг авснаар туршлага сууж, дуудлагат ажилдаа суралцдаг.

Тэргүүлэх албан тушаалтнууд шинэ болон Сүмд дахин идэвхтэй болж байгаа гишүүд, ганц бие залуу насанд хүрэгчдэд үйлчлэх боломж олгох арга замуудыг эрж хайдаг. Шинэ болон Сүмд эргэн ирж байгаа гишүүд сэргээгдсэн сайн мэдээнд баяслыг олсноор бусдад үйлчлэх, Сүмийн тухай улам ихийг мэдэх хүсэлтэй болох нь элбэг тохиолддог. Их Эзэний ажилд хувь нэмэр оруулж, сүнслэг байдлын хувьд өсч хөгжих боломж ганц бие залуу насанд хүрэгчдэд үнэхээр шаардлагатай.

Сүмд үйлчлэх дуудлагуудыг гишүүдэд санал болгох тухай мэдээллийг 19.1.1; 19.1.2-оос үзнэ үү.

### 3.3.4 Ажил үүргийг нь даалгаж, хариуцлагыг төлөвшүүл

Удирдагчид юм бүхнийг ганцаараа хийж чадахгүй, хийх ч ёсгүй. Хэт ихийг хийх гэж оролддог удирдагчид "зайлшгүй зүдэрнэ" (Египетээс гарсан нь 18:18-ыг үзнэ үү) мөн үйлчилдэг хүмүүс нь ч ядарна. Удирдагчид үйлчлэх боломжийг зөвлөхүүд, бичиг хэргийн ажилтнууд, зөвлөл, хороодын гишүүд зэрэг бусад хүмүүст хариуцуулан даалгах хэрэгтэй.

Ажил үүрэг хариуцуулах нь хүнд зүгээр нэг даалгавар өгөхөөс илүү зүйл юм. Үүнд дараах элементүүд ордог:

- Даалгасан ажил үүргийн зорилгыг тайлбарлаж, биелүүлэх арга замыг болон уг ажлыг хэзээ дуусгах ёстойг хэлж өгөх. Ажил хариуцсан хүн уг ажлыг гүйцэтгэж, биелэлтийг эргэж тайлагнах ёстойгоо ойлгосон байна.
- Даалгасан ажлын тухай бичгээр тэмдэглэл хөтөлж, ажилд гарч байгаа ахицыг шалгаж байх.
- Төлөвлөгөө боловсруулж, даалгасан ажил үүргийг биелүүлэх үүрэг хүлээсэн хүний хүч чармайлтыг хүндэтгэх. Удирдагчид нь шаардлагатай үед тусалж, урам дэм хайрлах.
- Даалгасан ажлын тухай эргэж тайлагнаж байхыг ажил хариуцсан хүнээс хүсэх. Удирдагч

тайлан хүлээн авсны дараа уг хүний хүч чармайлтыг үнэлж, түүний хийсэн сайн зүйлүүдийн төлөө талархал илэрхийлдэг.

### 3.3.5 Нүглээс сэрэмжлүүл, гэхдээ нүгэл үйлдэгчийг хайрла

Удирдагчид гэм нүгэлд эвлэршгүй, хатуу, харин нүгэл үйлдэгчид нигүүлсэнгүй, нинжин сэтгэлээр хандах хэрэгтэй. Тэд бусдад Аврагч яаж хандах байсан тийм байдлаар ханддаг. Ингэснээр гишүүд өөрсдийг нь хайрладаг Аврагчийн хайрыг мэдэрч, амьдралд нь Цагаатгал ямар үүрэг гүйцэтгэснийг ойлгох болно.

### 3.3.6 Бишрэл хүндэтгэлийг дэмж

Хүндэтгэл бол Бурханыг амарлингуй тайвнаар бишрэн шүтэж, хүндлэн дээдлэх явдал юм. Энэ нь сайн мэдээнээс суралцах болон хувийн илчлэлт уруу хөтөлдөг. Жинхэнэ хүндэтгэл хүн бүрийн дотоод сэтгэлээс гардаг.

Сүмийн цуглаанууд дээр хүндэтгэлийн уур амьсгалыг бүрдүүлэхэд удирдагчид тусалж чадна. Ариун ёслолын цуглаан, гадасны чуулган, болон бусад хурал цуглаанууд дээр удирдагчид индэр дээр сууж байхдаа хүндэтгэлийн үлгэр жишээг харуулдаг. Удирдагчид сүмийн хөгжим, сүнслэг нөлөө бүхий үг хэлэх ажлыг зохион байгуулснаар хүндэтгэлтэй байдлыг бий болгодог. Багш нар сүнслэг нөлөө бүхий хичээлүүдийг бэлтгэн, тохиромжтой зураг, дуу хөгжим ашиглан, анги танхимыг урьдчилан бэлтгэж, ангийн гишүүдтэй хайраар, элдэг мэндэлснээр анги танхим дахь хүндэтгэлтэй байдлыг дэмждэг. Тойрог даяар хүндэтгэлтэй байх чармайлт гаргаснаар шүтлэг бишрэлийн үйлчлэл, Сүмийн хичээлүүд илүү баялаг агуулгатай болдог.

### 3.3.7 Хурал цуглааны хэлэлцэх асуудлуудыг бичгээр бэлтгэ

Хурал цуглааны хөтөлбөрийг бичгээр гаргах нь үйлчлэх арга замуудыг хэлэлцэх үед удирдагчдад удирдамж болж чадна. Хурлын хөтөлбөрийг хурлаас өмнө тараах эсвэл хурлыг төлөвлөж хийвэл удирдагчид хэлэлцүүлэгт илүү сайн бэлтгэлтэй байж чадна. Янз бүрийн хурал цуглааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө бэлтгэх удирдамж 4-р бүлэг; 7–12-т байгаа.

### 3.3.8 Зорилго тавьж төлөвлө

Удирдагчид тойргийн гишүүдийн амьдралыг адислахын тулд үйл ажиллагаа, хичээл болон бусад ажлуудыг төлөвлөдөг. Тэд эдгээр нь хүмүүст ашиг тус өгөх ёстойг үргэлж санаж зорилго тавин төлөвлөдөг. Удирдагчид үйл ажиллагаануудыг төлөвлөхдөө 13.1; 13.2 дахь зарчмуудыг баримтална. Тэд сургалт болон сайн мэдээг заах тухай төлөвлөхдөө 5.5 дахь зарчмуудыг баримтална.

Удирдагчид өөрсдийн байгууллагын урт хугацааны төлөвлөгөөг боловсруулна. Энэ төлөвлөгөөнд бүтэн жилийн хуанли хөтөлж, зорилго дэвшүүлж, тэдгээрийг хэрэгжүүлэх явцад үнэлэлт дүгнэлт өгөх зэрэг орно.

Удирдагчид нарийн бичиг нарын тусламжтайгаар төлөвлөгөөнүүд болон даалгасан ажлын биелэлтийн явцыг шалгаж, энэ тухайгаа бичгээр тэмдэглэл хөтөлдөг. Удирдагчид төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлсний дараа эдгээр нь зорилгоо хэрхэн амжилттай биелүүлсэн тухайд үнэлэлт өгнө. Ийнхүү үнэлэлт өгөх нь ирээдүйн төлөвлөлтөнд тусалдаг.

### 3.3.9 Үүрэгт ажилдаа суралцахдаа Сүмийн эх сурвалжуудыг ашигла

Удирдагчид ажилдаа суралцаж, үүргээ биелүүлэхэд туслах дараах эх сурвалжуудыг ашигладаг:

- Энэ гарын авлага. Гадасны ерөнхийлөгчийн болон бишопын зөвлөлийн гишүүд энэ гарын авлагыг бүхэлд нь сайн мэддэг болох ёстой. Бусад удирдагчид өөрсдийнх нь байгууллагын тухай өгүүлдэг 1–6-р бүлгийг бас өөрсдийнх нь ажил үүрэгтэй холбоотой бусад мэдээллийг уншиж судлах хэрэгтэй. Энэхүү гарын авлага нь үр ашигтай үйлчлэхэд удирдагчдад туслах зарчмууд болон аргуудыг заадаг.
- Тайлангууд. Бичиг хэргийн ажилтнууд, нарийн бичиг нар хувь хүмүүс болон бүлгүүдийн өсөлт хөгжилтийг харуулсан тайлангуудаар удирдагчдыг хангадаг. Энэ мэдээлэл нь ямар хүмүүс болон туслах бүлгүүдэд онцгой анхаарал хэрэгтэй байгааг мэдэхэд удирдагчдад тусална.
- Орон нутгийн удирдагчдын заавар. Шинэ удирдагч бүр дэмжүүлэн батлагдсаны дараахан сургалт авах ёстой. Сургалт явуулах удирдагчид нь удирдлагын хурал цуглаанууд болон хувийн харилцаагаараа дамжуулан шинэ удирдагчдад заавар өгч, дэмжлэг үзүүлсээр байдаг.
- Сүмийн сургалтын материалууд. Эдгээр материалыг LDS.org-ийн Serving in the Church-с үзэх буюу Сүмийн удирдах газар эсвэл харьяа үйлчлэлийн төвөөсөө авч болно.
- Сүмийн сэтгүүлүүд болон бусад ном, товхимлууд.

## 3.4 Удирдлагын зорилго

Удирдагчид дуудлагаа эрхэмлэн биелүүлэх явцад ямагт санаж явбал зохих дараах зорилгуудыг Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөлөөс гаргасан юм.

Гишүүн бүрийг санваарын бүх чухал ёслолуудыг хүлээн авч, ёслолуудтай холбоотой гэрээнүүдийг сахин, өргөмжлөл, мөнх амьдралд тэнцэхүйц байхад нь удирдагч нар дэмжих ёстой. Сүмийн удирдагчид доорх үр дүнд хүрэхэд туслахын тулд санваартны чуулга, туслах бүлгүүд, гадас болон тойргийн зөвлөлийн тусламцааг илүү сайн ашиглах ёстой:

**Гэр бүлүүд:** Сүмийн зохион байгуулалтын үндсэн нэгж болох гэр бүлд тэргүүн зэргийн ач холбогдол өгч заа. Гишүүд болон гэр бүлүүд өргөмжлөлд тэнцэхүйц байхад нь туслахад дээд санваартнууд онцгой үүрэг гүйцэтгэх ёстой (С ба Г 84:19–22-ыг үзнэ үү). Гэр бүлийн гишүүн бүрийг судруудаас суралцаж, тогтмол залбиран, Аврагчийн сайн мэдээгээр амьдрахад нь дэмж.

**Насанд хүрэгчид:** Насанд хүрэгч бүрийг ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахуйц зохистой байхад нь дэмж. Эцэг өвгөдөө олж тогтоон, тэдний төлөө ариун сүмийн ёслолуудыг хийх хэрэгтэйг насанд хүрэгч бүрд заа.

**Залуучууд:** Мелкизедек санваар болон ариун сүмийн ёслолуудыг хүлээн авч, бүрэн цагийн номлолд үйлчлэхэд бэлтгэх болон зохистой байхад нь залуу эрэгтэй бүрд тусал. Ариун сүмийн гэрээнүүдийг хийж, сахин, ариун нандин ёслолуудыг хүлээн авахуйц зохистой байхад нь залуу эмэгтэй бүрд тусал. Ач холбогдолтой үйл ажиллагаануудад оролцуулах замаар тэднийг бэхжүүл.

**Нийт гишүүд:** Хүмүүсийг аврах, гэр бүлүүд болон Сүмийн нэгжүүдийг бэхжүүлэх, санваартнуудын үйл ажиллагааг сайжруулан, хөрвүүлэх болон гишүүдийг идэвхтэй хэвээр байлгах, идэвхжүүлэх замаар Израилын угсааг цуглуулахын төлөөх санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид, тойргийн зөвлөл, тойргийн болон бүрэн цагийн номлогчид, гишүүдийн хамтын хүч чармайлтыг зохицуулахад тусал. Өөрсдийгөө, гэр бүлээ хэрхэн ханган тэтгэхийг болон ядуус, тусламж хэрэгтэй хүмүүст Их Эзэний арга замаар хэрхэн туслахыг заа.

3. Есүс Христийн Сүмийн удирдлага

# 4. Тойргийн зөвлөл


4.1 **Сүм дэх зөвлөлүүд . . . . . . . . . . 18**

4.2 **Бишопын зөвлөл . . . . . . . . . . 18**

4.3 **Санваартны гүйцэтгэх хороо . . . . . . . . . . 18**

4.4 **Тойргийн зөвлөл . . . . . . . . . . 18**

4.5 **Тойргийн зөвлөлийн ажил . . . . . . . . . . 18**

4.5.1 Хүн болгонд өсч хөгжихөд нь тусал . . . . . . . . 18

4.5.2 Тойргийг хүчирхэгжүүлэхэд тусал . . . . . . . . 19

4.6 **Тойргийн зөвлөлийн хурлууд . . . . . . . . . . 19**

4.6.1 Удирдах зарчмууд . . . . . . . . 19

4.6.2 Хурлын төлөвлөгөөний загвар . . . . . . . . 20

4.6.3 Ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь . . . . . . . . 21

4.6.4 Тойргийн бичиг хэргийн ажилтны үүрэг хариуцлага . . . . . . . . 21

4.6.5 Гүйцэтгэх нарийн бичгийн даргын үүрэг хариуцлага . . . . . . . . 21

# 4. Тойргийн зөвлөл

## 4.1 Сүм дэх зөвлөлүүд

Их Эзэний Сүмийг ерөнхий, бүсийн, гадасны болон тойргийн төвшин дэх зөвлөлүүдээр дамжуулан удирддаг. Эдгээр зөвлөл Сүмийн зохион байгуулалтын үндэс суурь нь болдог.

Удирдагч нар нь төвшин бүр дэх санваарын түлхүүрүүдийн дагуу хувь хүмүүс, гэр бүлүүдийн ашиг тусын төлөө хамтран зөвлөлддөг. Зөвлөлийн гишүүд нь үүрэгт ажилтайгаа холбоотой Сүмийн ажлыг төлөвлөн хэрэгжүүлдэг. Үр ашигтай ажилладаг зөвлөл нь зөвлөлийн гишүүдийг санал бодлоо бүрэн чөлөөтэй илэрхийлэхэд урьж, хувь хүн, гэр бүл, туслах бүлгүүдийн хэрэгцээг хангахад тэдний хичээл зүтгэлийг нэгтгэдэг.

Бишоп тойргийн тэргүүлэх дээд пристийн хувьд хоорондоо холбоотой гурван зөвлөл болох: бишопын зөвлөл, санваартны гүйцэтгэх хороо, тойргийн зөвлөлийг тэргүүлдэг. Энэ бүлэгт эдгээр гурван зөвлөлийн талаар тайлбарлана.

## 4.2 Бишопын зөвлөл

Бишопын зөвлөл нь тойргийн нийт гишүүд, туслах бүлгүүд болон тойргийн үйл ажиллагааг хариуцна. Бишопын зөвлөл доод тал нь долоо хоногт нэг удаа хуралддаг. Уг хуралд тойргийн бичиг хэргийн ажилтан, гүйцэтгэх нарийн бичиг нар оролцоно. Зөвлөмж болгож буй хэлэлцэх асуудлуудын төлөвлөгөөг 18.2.6-гаас үзнэ үү.

Бишоп өөрийн шийдвэрүүдийг зөвлөхүүдтэйгээ, шаардлагатай үед тойргийн зөвлөлтэй хамтран хэлэлцэж байвал шийдвэр илүү өгөөжтэй, сайн хэрэгждэг байна. Бишоп ийм ярилцлагын үеэр задруулах ёсгүй нууц мэдээллийг хуваалцаж болохгүй.

## 4.3 Санваартны гүйцэтгэх хороо

Тойргийн санваартны гүйцэтгэх хороонд (СГХ) бишопын зөвлөл, тойргийн бичиг хэргийн ажилтан, гүйцэтгэх нарийн бичиг, дээд пристүүдийн бүлгийн удирдагч, ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, тойргийн номлолын удирдагч, Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч орно.

СГХ санваарын асуудлуудыг хэлэлцэхийн тулд тогтмол цуглана. Ерөнхийдөө СГХ нь тойргийн зөвлөлийн хэлэлцвэл зохих асуудлуудыг авч хэлэлцдэггүй. Гэвч энэ хороо тойргийн зөвлөлийн хурлын хөтөлбөрт орсон зарим асуудлыг урьдчилан хянах нь тустай байдаг. СГХ тойргийн зөвлөлийн хурлын өмнө хуралдах нь тохиромжтой.

Шаардлагатай бол бишоп тусламжийн асуудлуудыг хэлэлцэх, гэрийн болон айлчлагч багшийн ажлыг зохицуулахын тулд тойргийн СГХ-ны зарим цуглаанд Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийг урьж оролцуулж болно.

## 4.4 Тойргийн зөвлөл

Тойргийн зөвлөлд бишопын зөвлөл, тойргийн бичиг хэргийн ажилтан, гүйцэтгэх нарийн бичиг, дээд пристүүдийн бүлгийн удирдагч, ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, тойргийн номлолын удирдагч, Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн Хэсэг, Ням гарагийн ангийн ерөнхийлөгчид орно.

Тойргийн зөвлөлийн гишүүд гэрчлэлтэй болох, авралын ёслолуудыг хүлээн авах, гэрээнүүдийг сахих, Есүс Христийн ариуссан дагалдагчид болоход нь хүмүүст тусалдаг (Моронай 6:4–5-ыг үзнэ үү). Тойргийн зөвлөлийн нийт гишүүд тойргийн гишүүдийн сайн сайхан байдлын төлөө хариуцлага хүлээдэг. Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид нь өөрсдийн бүлгийн гишүүн бүрийг харж хандах, тэднийг бэхжүүлэх тодорхой үүрэг хүлээдэг.

Тойргийн зөвлөл нийт бүрэлдэхүүнээрээ (1) зөвхөн туслах бүлгүүдийн хамтын ажиллагаагаар тусалж болох зүйлсийг, (2) хамтын ярилцлагаас болон нэгдмэл зүтгэлээс гарч ашиг тусаа өгөх зүйлсийг, (3) тойргийн хэмжээнд бүх нийтэд хамаатай асуудлуудыг ихэвчлэн авч хэлэлцдэг. Санваартны эсвэл аль нэг туслах бүлэгт шууд хамаатай ихэнх асуудлыг тойргийн зөвлөлийн хүрээнд биш харин уг бүлэг дотроо шийдэх ёстой. Түүнээс гадна тойргийн зөвлөлийн гишүүд нууц буюу хувийн чанартай асуудлыг бишопт биечлэн мэдэгдэж болно.

## 4.5 Тойргийн зөвлөлийн ажил

### 4.5.1 Хүн болгонд өсч хөгжихөд нь тусал

Тойргийн зөвлөлийн гишүүд өөрсдийн ихэнх ажлыг тойргийн зөвлөлийн хурлаас гадуур хийдэг. Тэд байгууллагынхаа гишүүд,

тусламж хэрэгтэй хүмүүст хүрч үйлчлэхийн тулд өөрийн зөвлөхүүд, гэрийн болон айлчлагч багш нар, бусад хүмүүстэй хамтран ажиллана.

Тойргийн зөвлөлийн гишүүд өөрсдийн бүлгүүдийн гишүүдийн хэрэгцээ, амьдрал ахуй, сүнслэг байдлын талаар хангалттай мэдээлэл авч байхыг хичээнэ. Тэд бэрхшээлтэй тулгарсан мөн нөхцөл байдал нь хүндэрсэн гишүүдийн талаар мэдээлэлтэй байх хэрэгтэй. Энэ мэдээлэл нь тусламж хамгийн их хэрэгтэй байгаа гишүүдийг олж туслах боломжийг олгодог. Үүний хамт тэд хувь хүний болон гэр бүлийн нууцад хүндэтгэлтэй ханддаг. Хувь хүний зохистой байдлын асуудлыг зөвхөн бишоп шийдвэрлэдэг.

Гишүүд, сонирхогчдын өсөлт хөгжилтийг ажиглаж мэддэг байхад дараах эх сурвалжууд тойргийн зөвлөлийн гишүүдэд тусалж чадна:

1. Тойргийн Улирал тутмын тайлан зэрэг гишүүдийн ирцийн тайлан. Эдгээр тайланг тойргийн бичиг хэргийн ажилтан бэлтгэдэг. Тайлангууд нь Сүмийн үйл ажиллагааны тухай, гишүүдийн ёслол хүлээн авсан байдал, хувь хүмүүс, насны бүлгүүд болон нийт тойрог дахь өсөлт хөгжилтийн тухай мэдээллийг агуулдаг. Сүмийн бүртгэл хөтлөлтийн программ ашигладаг тойргуудад бичиг хэргийн ажилтан нь ашигтай мэдээлэл агуулсан бусад тайлангуудаар хангах боломжтой.
2. Гэрийн болон айлчлагч багш нарын тайлан.
3. New and Returning Member Progress form (Шинэ болон буцаж идэвхтэй болж буй гишүүдийн өсөлтийн маягт). Тойргийн зөвлөлийн гишүүд шинэ гишүүдэд баптисм ба гишүүний баталгааны үеэс нь ариун сүмийн хишгээ хүлээн авах хүртэл нь заах, тэднийг бэхжүүлэх тодорхой арга замуудыг төлөвлөхөд энэ маягтыг ашигладаг. Тойргийн зөвлөлийн гишүүд идэвх султай гишүүдэд ариун сүмийн болон бусад ёслолуудыг хүлээн авахад нь туслах талаар төлөвлөхдөө энэ маягтыг ашиглаж болно.
4. Progress Record (Өсөлтийн тайлан). Бүрэн цагийн номлогч нар сонирхогч бүрийн өсөлт хөгжилтийг тэмдэглэхэд энэ маягтыг ашигладаг. Номлогчид энэ мэдээллийг тойргийн номлолын удирдагчтай, тойргийн номлолын удирдагч тойргийн зөвлөлтэй хуваалцдаг.

### 4.5.2 Тойргийг хүчирхэгжүүлэхэд тусал

Тойргийн зөвлөлийн гишүүд тойргтоо сүнслэг хүч болон эв нэгдлийг бий болгохын төлөө хамтран ажилладаг. Тойргийн зөвлөл нь тойргийнхоо үйл ажиллагаануудыг төлөвлөхөд хяналт тавьдаг. Сайн мэдээн дээр төвлөрсөн зорилгуудыг хэрэгжүүлэхийн тулд үйл ажиллагаануудыг төлөвлөх ёстой. Үйл ажиллагаануудын тухай дэлгэрэнгүй мэдээллийг 13-р бүлгээс үзнэ үү.

## 4.6 Тойргийн зөвлөлийн хурлууд

Тойргийн зөвлөл тогтмол хуралдана (доод тал нь сард нэг удаа). Хурал ихэвчлэн 60-90 минут үргэлжилдэг.

Бишоп хурлыг тэргүүлнэ. Хэрэв тэр эзгүй байгаа бол нэг зөвлөхөө тэргүүлүүлэхээр томилж болно. Гэвч томоохон шийдвэрийг бишопын эзгүйд гаргахгүй.

Бишоп тойргийн номлолын удирдагчийн санал болгосны дагуу бүрэн цагийн номлогчдыг зарим үед тойргийн зөвлөлийн хуралд оролцуулахаар урьж болно.

### 4.6.1 Удирдах зарчмууд

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид тойргийн зөвлөлийн хурлуудад хоёр үүрэг гүйцэтгэдэг. Үүнд:(1) тойргийн зөвлөлийн гишүүний хувьд тойрог дахь хэрэгцээ болон асуудлуудыг тогтоож, шийдлийг олоход бишопт тусална, (2) өөрийн туслах бүлгийг төлөөлнө. Эдгээр удирдагчид үйлчилдэг хүмүүсээ хайрлаж, тэдэнд санаа тавьж, нэгдмэл байж Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийлнэ.

Тойргийн зөвлөлийн хурлууд хувь хүмүүс, гэр бүлүүдийг бэхжүүлэх асуудлууд дээр анхаарал төвлөрүүлэх ёстой. Харин үйл ажиллагаа төлөвлөх, хугацааг товлох болон зохион байгуулалтын бусад ажилд аль болох бага цаг зарцуулна.

Хурлын үеэр бишоп хэлэлцэх асуудал бүрийг тайлбарлах боловч хүмүүсийн ярихыг сонсож дуусах хүртэл уг асуудлыг хэрхэн шийдэхийг хэлдэггүй. Тэрээр өөрөө голлон ярилгүйгээр зөвлөлийн бусад гишүүдийн ярихыг дэмждэг. Тэрээр асуулт асууж, саналаа хэлэхийг зөвлөлийн гишүүдээс хүсч болно. Тэрээр шийдвэр гаргахын өмнө хүмүүсийн яриаг анхааралтай сонсдог. Зөвлөлийн гишүүдийн яриа сүнслэг уур амьсгалд түлхэц үзүүлэх ёстой.

Зөвлөлийн гишүүдийг хувийнхаа туршлагаас бас туслах байгууллагын удирдагчдын байр сууринаас чин сэтгэлээсээ ярихыг дэмждэг. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд аль аль нь өөрсдөө адил тэгш эрхтэй оролцогчийн хувьд санал бодол нь үнэ цэнэтэй гэдгээ мэддэг байх ёстой. Бишоп тойргийн зөвлөлийн хурлаар хэлэлцдэг бүх

асуудлаар Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн Хэсгийн удирдагчдын санал бодлыг асууна. Эмэгтэйчүүдийн санаа бодол зарим үед эрэгтэйчүүдийнхээс өөр байдаг бөгөөд гишүүдийн хэрэгцээг ойлгож, шийдвэрлэх арга хэмжээ авахад нэн чухал байдаг юм.

Чөлөөтэйгөөр ярилцсаны дараа бишоп шийдвэр гаргаж болно. Эсвэл тэрээр уг асуудлыг зөвлөхүүдтэйгөө дахин ярилцахын тулд шийдвэр гаргахаа түр хойшлуулж болно. Түүнийг шийдвэр гаргасны дараа зөвлөлийн гишүүд эвсэг, нэгдмэл байдлаар шийдвэрийг дэмжих хэрэгтэй.

Хэрэв зөвлөлийн гишүүдэд аль нэг чухал шийдвэрийн талаар хүчтэй эргэлзээ төрж байвал бишоп сүнсний баталгаа, эв нэгдлийг эрэлхийлэн, уг асуудлыг зөвлөлийн дараагийн хурлаар авч хэлэлцэхийн тулд хойшлуулж болно.

Зөвлөлийн гишүүд нь сүмийн гишүүд, гэр бүлүүд болон хэлэлцсэн асуудлуудын талаарх хувийн чанартай буюу эмзэг аливаа мэдээллийг нууцлах ёстой.

### 4.6.2 Хурлын төлөвлөгөөний загвар

Гүйцэтгэх нарийн бичиг бишопын удирдлагаар тойргийн зөвлөлийн хурлын хөтөлбөрийг бэлтгэнэ. Уг төлөвлөгөөнд хэлэлцэх асуудлаа оруулахын тулд гүйцэтгэх нарийн бичигтэй холбоо барихыг бишоп зөвлөлийн гишүүдээс хүснэ. Гүйцэтгэх нарийн бичиг хэлэлцэх асуудлуудыг түүний дотор өнгөрсөн хурлуудаар хэлэлцсэн асуудлуудыг дахин хэлэлцэх буюу шалгахыг санал болгож болно. Гүйцэтгэх нарийн бичиг зохиогдох гэж буй тойргийн үйл ажиллагаануудын хуанлийг зөвлөлийн гишүүдэд танилцуулж болно.

Хурлын хөтөлбөрт оруулж болох асуудлуудын жагсаалтыг доор өгөв. Бишоп эдгээр бүх асуудлуудыг хэлэлцэх гэж хичээх хэрэггүй. Ингэхийн оронд хамгийн чухал асуудлуудыг хурлын хөтөлбөрийн эхэнд оруулах хэрэгтэй. Хэтэрхий олон асуудлыг өнгөцхөн хэлэлцэхийн оронд аль болох хувь хүмүүс, гэр бүлүүдийг адислах цөөхөн асуудал дээр анхаарал төвлөрүүлэх нь дээр. Тухайн үед ямар асуудал хамгийн чухал байгааг мэдэхэд бишоп сүнсний нөлөөнд найдвар тавьдаг.

1. Өнгөрсөн хурлаас өгсөн үүрэг даалгаврын товч тайлан.
2. Сүнслэг болон материаллаг тусламж. Сонгож авсан хувь хүмүүс, гэр бүлүүдийн сүнслэг болон материаллаг ахуй амьдралын тухай ярилцах. Тэдний хэрэгцээг, түүний дотор цаашдын хэрэгцээг нь шийдвэрлэхэд туслах төлөвлөгөө гаргах. Гэр бүлүүдийг хэрхэн бэхжүүлэх тухай ярилцах. Дэлгэрэнгүй мэдээллийг 6.2.2-оос үзнэ үү.
3. Номлогч. Тойргийн номлолын төлөвлөгөө боловсруулж, хяналт тавих(5.1.8-ыг үзнэ үү). Өсөлтийн тайланг ашиглан, баптисм хийлгэх гэж байгаа хүмүүс, сонирхогчдын өсөлт хөгжилтийг дүгнэн ярилцах. Бишоп энэ ярилцлагыг удирдан явуулахыг тойргийн номлолын удирдагчаас хүсч болно. Дэлгэрэнгүй мэдээллийг 5.1.2-оос үзнэ үү.
4. Хөрвөгчийг идэвхжүүлэх. New and Returning Member Progress form (Шинэ болон буцаж идэвхтэй болж буй гишүүдийн өсөлтийн маягт) дээрх шинэ гишүүн бүрийн өсөлтийн тухай ярилцаж, цаашид өсч хөгжихөд нь туслах арга замуудыг төлөвлөх (5.2.3-ыг үзнэ үү).
5. Идэвхжүүлэлт. New and Returning Member Progress form (Шинэ болон буцаж идэвхтэй болж буй гишүүдийн өсөлтийн маягт) дээрх идэвх султай гишүүдийн өсөлт, тэдэнтэй нөхөрлөх тухай ярилцаж, цаашид өсч хөгжихөд нь тэдэнд туслах арга замуудыг төлөвлөх (5.3.2-ыг үзнэ үү).
6. Ариун сүм ба гэр бүлийн түүх. Ариун сүмийн ёслолууд хүлээн авахаар бэлтгэж байгаа гишүүдийн өсөлтийг дүгнэн ярилцах. Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд гишүүдийг илүү бүрэн дүүрэн оролцуулах хэрэгтэй гэж үзвэл бишоп гишүүдийг энэ ажилд хэрхэн дэмжих талаар ярилцах. Дэлгэрэнгүй мэдээллийг 5.4.2-оос үзнэ үү.
7. Сайн мэдээнээс суралцаж, заах нь. Сүмийн цуглаанууд дээр болон гэрт сайн мэдээнээс суралцаж, заах чанарыг хэрхэн сайжруулах тухай ярилцах (5.5.2-ыг үзнэ үү).
8. Ахлагч нарын чуулга, дээд приcтүүдийн бүлэг, туслах бүлгүүдийн ажлын тайлан. Хүмүүс дээр гол анхаарлаа төвлөрүүлэхээс зөвлөлийг хөндийрүүлэхгүйн тулд хурлын энэ хэсэг товчхон байх ёстой.
9. Хуанли болон үйл ажиллагааг төлөвлөх нь тойргийн гишүүдийн сүнслэг, материаллаг болон нийгмийн хэрэгцээг шийдвэрлэхэд тусална (13-р бүлгийг үзнэ үү).
10. Боловсролын Тасралтгүй Сан (уг хөтөлбөр батлагдсан газарт хамаарна). Зээлд хамрагдагчдын амжилтыг дүгнэн ярилцах.
11. Бишопын зөвлөлийн дүгнэлтийн үг.

### 4.6.3 Ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь

Тойргийн зөвлөл нь гишүүдийн амьдралыг адислахын тулд ажлын төлөвлөгөө боловсруулахдаа сүнслэг удирдамжийг эрэлхийлнэ. Зөвлөлийн анхаарал нь хөтөлбөрүүдийг зохион байгуулахаасаа илүү хүмүүст туслах ажил дээр төвлөрвөл зохино.

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагч нар тойргийн зөвлөлийн шийдвэрийг хэлэлцэх буюу зөвлөлөөс өгсөн үүрэг даалгавруудыг бусад удирдагчид, багш нарынхаа туслалцаатайгаар биелүүлэхийн тулд тус тусын удирдлагын хурлуудыг хийнэ. Үүнтэй адил, тойргийн номлолын удирдагч нь зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд бүрэн цагийн болон тойргийн номлогчдын хамтарсан хурлыг хийдэг. Туслах бүлгүүд дэх энэ ажил нь тойргийн зөвлөлийн үзэл санаа, зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэдэг.

Зөвлөлийн гишүүд ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ хувь хүмүүс, гэр бүлүүдийг хэт их ажилд дарахгүй байхад анхаарах ёстой (Мозая 4:27; С ба Г 10:4-ийг үзнэ үү). Гишүүн бүрийн нэн тэргүүнд анхаарах зүйл бол гэр бүл нь юм. Тойргийн зөвлөл гишүүдийнх нь гэр бүлийн үүрэг, Сүмийн ажил үүргийн хооронд зохих тэнцвэртэй байдлыг хангахад анхаарах хэрэгтэй.

Тойргийн зөвлөлийн гишүүд ажлын төлөвлөгөөний явцад тогтмол үнэлэлт өгч, ажил үүргийнхээ биелэлтийг эргэж тайлагнадаг байна. Ер нь байнга анхаарал тавьж, өгсөн үүргээ шалгах нь ажлын үр дүн авчирдаг.

### 4.6.4 Тойргийн бичиг хэргийн ажилтны үүрэг хариуцлага

Тойргийн бичиг хэргийн ажилтан тойргийн зөвлөлийн хурлын үеэр өгсөн үүрэг даалгавар, гаргасан шийдвэрийн тухай тэмдэглэл хөтөлнө. Тойргийн зөвлөлийнхөн ашигладаг энэхүү мэдээлэл нь цагаа олсон бөгөөд үнэн зөв байхад тэрээр анхаарна. Тэрээр хамгийн сүүлд шинэчилсэн New and Returning Member Progress form (Шинэ болон буцаж идэвхтэй болж буй гишүүдийн өсөлтийн маягт)-аар хангана. Тэр бас Сүмийн бүртгэл хөтлөлтийн програм хангамжаас статистикийн холбогдох мэдээллээр хангана. Бичиг хэргийн ажилтан бишопын зөвлөлийн болон тойргийн зөвлөлийн гишүүд түүнээс мэдээлэл хүсэхийг хүлээж суулгүй эдгээр эх сурвалжуудаас өөрийн санаачлагаар олсон мэдээллээр тэднийг хангах хэрэгтэй.

Тойргийн бичиг хэргийн ажилтны бусад ажил үүргийн тухай *Гарын авлага 1-ийн* 13.4.2-т өгүүлсэн байгаа.

### 4.6.5 Гүйцэтгэх нарийн бичгийн даргын үүрэг хариуцлага

Гүйцэтгэх нарийн бичиг 4.6.2-т өгүүлсний дагуу тойргийн зөвлөлийн хурлуудын хөтөлбөрийг бэлтгэнэ. Бишоп тойргийн зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн биелэлтэнд хяналт тавихад туслахыг түүнээс хүсч болно. Түүнээс гадна сонирхогчид, шинэ гишүүд, дахин идэвхтэй болж байгаа гишүүдийн талаар тойргийн зөвлөлийн гишүүдээс илтгэл, мэдээлэл авч байхыг бишоп түүнээс хүсч болно.

Гүйцэтгэх нарийн бичиг нь тойргийн зөвлөл болон санваартны гүйцэтгэх хороог холбож өгдөг.

Тойргийн гүйцэтгэх нарийн бичгийн даргын бусад ажил үүргүүдийг *Гарын авлага 1-ийн* 13.4.4-т өгүүлсэн байгаа.

# 5. Тойрог, гадсан дахь авралын ажил


5.1 **Гишүүдийн номлолын ажил .............. 24**

5.1.1 Бишоп ба түүний зөвлөхүүд...............24

5.1.2 Тойргийн зөвлөл.........................24

5.1.3 Тойргийн номлолын удирдагч ............24

5.1.4 Тойргийн номлогчид.....................25

5.1.5 Номлогчдын хамтарсан хурал.............25

5.1.6 Гишүүд, бүрэн цагийн номлогч нартай хамтран ажиллах нь......................25

5.1.7 Баптисмын ёслол ба гишүүний баталгаа....25

5.1.8 Тойргийн номлолын төлөвлөгөө...........26

5.1.9 Гадасны удирдагчид .....................26

5.2 **Хөрвөгчдийг идэвхжүүлэх нь ............. 26**

5.2.1 Шинэ гишүүдийн хэрэгцээ ...............26

5.2.2 Бишоп ба түүний зөвлөхүүд...............27

5.2.3 Тойргийн зөвлөл.........................27

5.2.4 Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид..............................27

5.2.5 Гэрийн болон айлчлагч багш нар ..........28

5.2.6 Тойргийн номлогчид ба бүрэн цагийн номлогчид ..............................28

5.2.7 Тойргийн бусад гишүүдийн нөлөө.........28

5.2.8 Сайн мэдээний зарчмуудын анги..........28

5.2.9 Гадасны удирдагчид .....................28

5.3 **Идэвхжүүлэлт.......................... 29**

5.3.1 Бишоп ба түүний зөвлөхүүд...............29

5.3.2 Тойргийн зөвлөл.........................29

5.3.3 Гэрийн болон айлчлагч багш нар ..........29

5.3.4 Бүрэн цагийн номлогчид ба тойргийн номлогчид ..............................29

5.3.5 Сайн мэдээний зарчмуудын анги..........30

5.3.6 Гадасны удирдагчид .....................30

5.4 **Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажил ........................... 30**

5.4.1 Бишоп ба түүний зөвлөхүүд...............30

5.4.2 Тойргийн зөвлөл.........................31

5.4.3 Дээд пристийн бүлгийн удирдагч .........31

5.4.4 Гэр бүлийн түүхийн зөвлөхүүд............31

5.4.5 Ариун Сүмийн болон гэр бүлийн түүхийн хичээл ба гарын авлага, материалууд.............................31

5.4.6 Гадасны удирдагчид .....................32

5.4.7 Гадсан дахь ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн гарын авлага, материалууд.............................32

5.5 **Сайн мэдээг заах нь..................... 32**

5.5.1 Бишоп ба түүний зөвлөхүүд...............32

5.5.2 Тойргийн зөвлөл.........................33

5.5.3 Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид..............................33

5.5.4 Багш нар ба удирдагчид ..................33

5.5.5 Тойргийн ням гарагийн ангийн ерөнхийлөгч ба түүний зөвлөхүүд.........34

5.5.6 Суралцах, заахад зориулан хэвлэн гаргасан болон онлайн гарын авлага, материалууд.............................34

5.5.7 Сайн мэдээг заах цуврал хичээл ...........34

5.5.8 Гадасны ерөнхийлөгч ба түүний зөвлөхүүд ..............................34

# 5. **Тойрог, гадсан дахь авралын ажил**

Есүс Христийн Сүмийн гишүүд бол “хүмүүний бодгалиудын авралын төлөө түүний талбайд хөдөлмөрлөхийн тулд”(С ба Г 138:56) илгээгдсэн юм. Авралын энэ ажилд гишүүдийн номлолын ажил, хөрвөгчдийг болон идэвхи сул-тай гишүүдийг идэвхжүүлэх, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажил, сайн мэдээг заах зэрэг орно. Бишоп тойргийнхоо хэмжээнд тойргийн зөвлөлийн бусад гишүүдийн туслалцаатайгаар энэ ажлыг удирдан явуулдаг.

Дээрх ажлуудын үндсэн үүрэг хариуцлага бишопт ноогддог ч тойргийн номлолын удирдагч гишүүдийн номлолын ажлыг, дээд пристүүдийн бүлгийн удирдагч ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажлыг зохицуулж, нян гарагийн ангийн ерөнхийлөгч сайн мэдээнээс суралцах, заах чанарыг сайжруулахад тойргийн бусад удирдагчдад тусалдаг. Бишоп нэг зөвлөхдөө хөрвөгчдийг анхаарах харин нөгөө зөвлөхдөө гишүүдийг идэвхжүүлэх ажлыг зохион байгуулуулахаар хариуцуулж болно. Санваартны болон туслах бүлгийн удирдагч бүр өөрийнхөө бүлэг дэх авралын ажилд ахиц дэвшил гаргахад тусалдаг.

## 5.1 Гишүүдийн номлолын ажил

### 5.1.1 Бишоп ба түүний зөвлөхүүд

Бишоп 5.1.8-д өгүүлсний дагуу тойргийн номлолын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхэд тойргийн зөвлөлийг удирдан чиглүүлнэ.

Бишоп нэг Мелкизедек санваартныг тойргийн номлолын удирдагчаар үйлчлүүлэхээр дуудаж, онцгойлон адисална. Бишоп болон түүний зөвлөхүүд бусад гишүүдийг тойргийн номлогчоор үйлчлүүлэхээр дуудаж, онцгойлон адисалж болно.

Бишоп болон түүний зөвлөхүүд гишүүний номлолын ажилд тэргүүн зэргийн ач холбогдол өгөх ёстой. Тэд номлолын ажлын тухай сургаалуудыг тогтмол заадаг. Тэд гишүүдийг бүрэн цагийн номлогчидтой хамтран сонирхогчдыг олж, заах, тэдэнд баптисм хүртээхийг урамшуулан дэмждэг. Номлогчдоор заалгах хувь хүмүүс, гэр бүлүүдийг олж, бэлтгэхэд тэд үлгэр жишээ үзүүлэх ёстой.

Бишоп болон түүний зөвлөхүүд бүрэн цагийн номлогч болох гишүүд, түүний дотор эгч нар болон гэр бүлийн хосуудыг номлолд үйлчлэхээр бэлтгэхэд нь тусална.

### 5.1.2 Тойргийн зөвлөл

Тойргийн зөвлөлийн гишүүд номлолын ажилд бүрэн дүүрэн оролцож байгаа үед гишүүдийн номлолын ажил хамгийн үр өгөөжтэй байдаг. Чуулгууд болон туслах бүлгүүд гишүүдийг номлолын ажилд оролцоход нь дараах арга замуудаар дэмждэг:

1. Заалгах хүмүүсийг олж бэлтгэдэг.
2. Номлогчдыг заах үед тусалдаг (боломжтой бол гишүүдийн гэрт)
3. Сонирхогчидтой нөхөрлөдөг.
4. Өөрсдийгөө болон хүүхдүүдээ бүрэн цагийн номлогчоор үйлчлэхэд бэлтгэдэг.

Тойргийн зөвлөлийн хурлаар зөвлөлийн гишүүд тойргийн номлолын төлөвлөгөөг боловсруулж хэлэлцдэг (5.1.8-ыг үзнэ үү). Тэд баптисм хүртэх гэж байгаа болон бусад сонирхогчдын тухай мөн бүрэн цагийн номлогчдын бэлтгэсэн өсөлтийн тайлан дахь бусад асуудлуудыг хэлэлцдэг. Тэд сонирхогч бүрд өсч хөгжихөд нь туслах төлөвлөгөөг гаргадаг. Баптисм хүртэж, гишүүнээр батлуулахаар бэлтгэж байгаа сонирхогчдод заах боломжтой гэрийн болон айлчлагч багш нарын тухай саналаа хэлдэг.

Бишоп тойргийн номлолын удирдагчийн санал болгосны дагуу бүрэн цагийн номлогчдыг зарим үед тойргийн зөвлөлийн хуралд оролцуулахаар урьж болно.

### 5.1.3 Тойргийн номлолын удирдагч

Тойргийн номлолын удирдагч нь бишопын удирдлага дор дараах үүргүүдийг хүлээдэг:

Тэрээр сонирхогчдыг олж заах, тэдэнд баптисм хүртээх ажлуудыг зохион байгуулж зохицуулна. Тэрээр энэ ажлыг бүрэн цагийн болон тойргийн номлогчидтой хамтран зохицуулна. Бишоп тойргийн зөвлөлийн хурлаар номлолын ажлын тухай хэлэлцүүлгийг удирдан явуулахыг түүнээс хүсч болно.

Тэрээр тойргийн болон бүрэн цагийн номлогчдын хамтарсан хурлыг хөтлөн явуулж, тойргийн номлолын ажлыг удирдан чиглүүлнэ.

Мөн бүрэн цагийн номлогч нарт долоо хоногт аль болох олон хичээл заах боломжийг бий болгоно.

Тэрээр бүрэн цагийн номлогчдын туслалцаатайгаар хөрвөгчдийн баптисмын ёслолыг зохион байгуулна (20.3.4-ийг үзнэ үү).

Тэрээр ариун ёслолын цуглаан дээр шинэ гишүүдийн гишүүний баталгааг хийхэд тусалдаг.

Тойргийн номлолын удирдагч нь бүрэн цагийн номлогчдын хамт сонирхогчдод хичээл заалцаж, тэдэнтэй нөхөрлөнө.

Тэрээр Сайн мэдээний зарчмуудын ангид сууж, бишопын зөвлөл томилсон үед хичээл зааж болно.

Нэг Мелкизедек санваартныг тойргийн номлолын удирдагчийн туслахаар дуудаж болно.

### 5.1.4 Тойргийн номлогчид

Тухайн тойрогт тойргийн хэчнээн номлогч байх хэрэгтэйг бишопын зөвлөл, тойргийн номлолын удирдагч хоёр хамтран шийднэ. Тойргийн номлогчид тэдний удирдлага дор үйлчилнэ. Санваартнууд, эгч нар, гэрлэсэн хосууд тойргийн номлогчоор үйлчилж болно. Тэдэнд хамтрагчдыг томилох шаардлагагүй. Гэвч тэд айлуудаар ганцаараа очих ёсгүй. Нөхөр, эхнэр биш бол эрэгтэй, эмэгтэй хоёр тойргийн номлогчоор хамт явж болохгүй.

Тойргийн номлогчид нь хоёр жил болон заасан хугацаагаар үйлчлэхээр дуудагдана. Тэд ихэвчлэн гэр бүлийн гишүүдийн зарим нь гишүүн эсвэл идэвх султай гэр бүлүүдэд гэрийн болон айлчлагч багшаар ажиллахаас өөр Сүмийн дуудлага авдаггүй. Тэд нэрийн тэмдэг хэрэглэдэггүй.

Тойргийн номлогчид бүрэн цагийн номлогчдын заах хүмүүсийг олж бэлтгэдэг. Тэд сонирхогчидтой нөхөрлөх, тэдэнд заах ажилд тусалдаг.

Тойргийн номлогчид нь гишүүдийн гэрээр очин, зааж болох хүмүүсийг олж бэлтгэх зэргээр номлолын ажлын туршлагатай болоход нь гишүүдийг дэмжинэ.

### 5.1.5 Номлогчдын хамтарсан хурал

Тойргийн номлолын удирдагч бүрэн цагийн болон тойргийн номлогчдын хамтарсан хурлыг хөтлөн явуулна. Энэ хурлыг тогтмол хийнэ. Хэрэв бүрэн цагийн номлогч нар хэд хэдэн тойрогт үйлчилдэг бол ийм хуралд боломжийнхоо хэрээр олон удаа оролцох хэрэгтэй.

Тойргийн номлолын удирдагч энэ хурлаар бүрэн цагийн болон тойргийн номлогчдын ажлыг зохицуулдаг. Тойргийн номлолын удирдагч нь тойргийн номлолын төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар ярилцлага явуулж, номлогчдоор аль болох олон хичээл заалгахаар төлөвлөн, сонирхогчдод заахдаа гишүүдийг аль болох хамт байлцуулах ажлыг зохион байгуулдаг.

### 5.1.6 Гишүүд болон бүрэн цагийн номлогч нар хамтран ажиллах нь

Номлолын ерөнхийлөгч хөрвөгчдөд баптисм хүртээх, тэднийг гишүүнээр батлах түлхүүрүүдийг эзэмшдэг. Бүрэн цагийн номлогчид түүний удирдлага дор сонирхогчдод заах үндсэн үүргийг хүлээдэг. Бүрэн цагийн номлогчид сонирхогч бүртэй баптисм ба гишүүний баталгааны ярилцлага хийж, уг ёслолуудад зөвшөөрөл өгдөг.

Бишоп бүх сонирхогчидтой танилцаж, тэдний өсөлт хөгжилтийг хариуцна. Тэрээр баптисм хүртэх гэж байгаа сонирхогчидтой ярилцлага хийдэггүй ч, баптисм хүртэхээс нь өмнө тэдэнтэй биечлэн уулздаг. Тэрээр бас тэдэнтэй нөхөрлөх тойргийн гишүүдийн хүч чармайлтад анхаарал тавина. Сонирхогчид Сүмийн гишүүдтэй ойр дотно нөхөрлөсөн үед баптисм хүртэж, гишүүнээр батлагдан, Сүмд идэвхтэй хэвээр үлдэх магадлал илүү байдаг.

Ер нь бол бүрэн цагийн номлогчид тойргийн гишүүдтэй хамт ажиллахын тулд хамтрагчаасаа салж явдаггүй. Гэвч олон хүмүүст хичээл заах болсон тохиолдолд тойргийн гишүүдтэй заахаар салж ажиллаж болно. Энэ тохиолдолд бүрэн цагийн номлогчдын хамтрагчаар ажиллах гишүүд номлолын дүрмийг ойлгож, хүлээн зөвшөөрөхөд тойргийн номлолын удирдагч анхаарна. Тэд бүрэн цагийн номлогчийг зөвшөөрөгдсөн хамтрагчгүйгээр хэзээ ч орхиж явах ёсгүйг тэрээр зааварлана.

### 5.1.7 Баптисмын ёслол ба гишүүний баталгаа

Сонирхогч баптисм хийлгэх шийдвэрээ гаргамагц түүний баптисмын ёслолын өдрийг товлох хэрэгтэй. Тухайн хүн бэлтгэгдээгүйгээс өөр шалтгаанаар баптисмын ёслолыг хойшлуулдаггүй. Гэр бүлийн гишүүдийн баптисмыг эцэг нь санваар хүлээн авч баптисмыг өөрөө гүйцэтгэх шалтгаанаар хойшлуулах ёсгүй.

Баптисмын ёслол нь сонирхогчдыг олох болон дэмжих боломж олгодог. Сонирхогчдыг гэр бүлийн гишүүд, төрөл төрөгсөд, найз нараа урихыг дэмжих хэрэгтэй. Сүмийн удирдагчид, номлогчид нь заалгаж байгаа бусад сонирхогч, сонирхогч болохуйц хүмүүс, тэрчлэн шинэ гишүүдтэй ажиллах удирдагчид, гишүүдийг урьж болно. Тойргийн бусад гишүүд оролцож болно.

Сонирхогчдыг оршин суудаг газрынх нь тойргийн ариун ёслолын цуглаан дээр, баптисм хүртсэний дараах ням гарагт гишүүнээр батлах нь тохиромжтой.

Баптисмын ёслол ба гишүүний баталгаа, түүний дотор 8 настай хүүхдүүдийн баптисм

ба гишүүний баталгааны тухай удирдамж 20.3-т байгаа болно.

### 5.1.8 Тойргийн номлолын төлөвлөгөө

Тойргийн зөвлөл нь бишопын удирдлагаар тойргийн номлолын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ. Энэ төлөвлөгөө товчхон бөгөөд энгийн байх ёстой. Төлөвлөгөөнд тойргийн санваартны чуулга болон туслах бүлгүүдийг номлолын ажил, гишүүдийг идэвхтэй байлгах болон идэвхжүүлэх ажилд оролцоход нь туслах зорилго, үйл ажиллагаануудыг оруулдаг. Тойргийн зөвлөл нь тойргийн номлолын төлөвлөгөөг бүрэн цагийн номлогчдын төлөвлөгөөтэй уялдуулан зохицуулна. Төлөвлөлтийн энэхүү үйл явцад дараах алхмууд тустай байж болно:

1. Гишүүдийн номлолын ажил, гишүүдийн идэвх болон идэвхжүүлэх хэрэгцээ ба нөөц боломж, бүрэн цагийн номлогчдын хүрэлцээг авч хэлэлцэх.
2. Ирэх жилд хийх гишүүдийн номлолын ажил, гишүүдийн идэвх болон идэвхжүүлэх ажлын зорилгуудыг тодорхойлох.
3. Эдгээр зорилгыг хэрхэн хэрэгжүүлэхийг шийдэх. Удирдагч нар тойргийн номлолын ажлын зорилго тавих болон гишүүдийг урам зоригтойгоор энэ ажилд оролцуулах арга замуудыг төлөвлөж болно. Тэд улам олон сонирхогчдыг олж, заан, баптисм хүртээхэд бүрэн цагийн номлогчдод туслах санаа, үйл ажиллагаануудыг бодож олж болно. Тэд шинэ гишүүдийг найз нөхөдтэй болгож, тэднийг бэхжүүлэн, идэвх султай гишүүдийг идэвхжүүлэх арга замуудыг төлөвлөх ёстой.

Тойргийн зөвлөл тойргийн номлолын төлөвлөгөөг тогтмол хэлэлцэж, шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулна.

### 5.1.9 Гадасны удирдагчид

#### Гадасны ерөнхийлөгч ба түүний зөвлөхүүд

Гадасны ерөнхийлөгч ба түүний зөвлөхүүд номлолын ажилд тэргүүн зэргийн ач холбогдол өгдөг. Тэд номлолын ажлын зарчмуудыг зааж, гадасны гишүүдийг сонирхогч олох, заах, баптисм хүртээхэд бүрэн цагийн номлогчидтой хамтран ажиллахыг дэмжинэ. Номлогчдоор заалгах хувь хүмүүс, гэр бүлүүдийг олж, бэлтгэж тэд үлгэр жишээ үзүүлдэг.

Гадасны ерөнхийлөгч бишоп бүртэй хийдэг тогтмол ярилцлагадаа тухайн бишопыг тойрог дахь сонирхогчдын өсөлтийн тайлангаа авчрахыг хүсдэг.

Гадасны ерөнхийлөгч гадасныхаа бүрэн цагийн номлогчдын ажлыг зохицуулахын тулд номлолын ерөнхийлөгчтэй тогтмол уулзана. Хэлэлцэх асуудлуудад номлогчдын тоо, байрлал, номлолын ажилд гишүүдийн гүйцэтгэх үүрэг, гишүүдийн идэвх болон идэвхжүүлэх ажилд туслах болон орон нутгийн гишүүдийг сургахад номлогчдын үзүүлэх туслалцаа, номлогчдын амьдрах байр, хоол, унааны тухай асуудлууд орно.

#### Номлолын ажилд томилогдсон дээд зөвлөлийн гишүүн

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл сонирхогчдыг олж, заах, тэдэнд баптисм хүртээх гадасны хүч чармайлтуудад хяналт тавихад туслалцуулахаар, номлолын ажлыг хариуцсан нэг дээд зөвлөлийн гишүүнийг томилно. Энэ дээд зөвлөлийн гишүүн гадасны санваартны гүйцэтгэх хороо, гадасны зөвлөл, гадасны санваартны удирдагчдын болон гадасны бусад хурал цуглаанууд дээр дээрх сэдвүүдээр ярилцлагыг удирдан явуулж болно.

Номлолын ажилд томилогдсон дээд зөвлөлийн гишүүн шинээр дуудагдсан тойргийн номлолын удирдагчдыг сурган дадлагажуулна. Тэрээр тойргийн номлолын нийт удирдагчдад нэг бүрчлэн болон бүлгээр нь тогтмол заавар өгч, дэмжлэг үзүүлнэ. Тэрээр гадасны ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр тойргийн удирдагчид болон тойргийн номлогчдод зориулан сургалт явуулж болно.

---

## 5.2 Хөрвөгчдийг идэвхжүүлэх нь

Сүмийн шинэ гишүүдэд Сүмийн удирдагч, гэрийн болон айлчлагч багш нар болон бусад гишүүдийн дэмжлэг, нөхөрлөл хэрэгтэй байдаг. Энэхүү дэмжлэг "Их Эзэнд [бат бөхөөр] хөрвөгдөхөд"(Алма 23:6) шинэ гишүүдэд тусалдаг.

### 5.2.1 Шинэ гишүүдийн хэрэгцээ

Сүмийн гишүүн болох нь ихэнх хүмүүсийн хувьд сорилт болдог. Энэ нь шашны шинэ сургаал, амьдралын шинэ хэв маягийг хүлээн зөвшөөрөхийг хэлдэг. Сүмийн бүх гишүүд ялангуяа шинэ гишүүдэд Сүмд идэвхтэй хэвээр байхад нөхөрлөл, Сүмд төлөвших ба үйлчлэх боломж, Бурханы үгээр тэжээгдэх гэсэн гурван зүйл хэрэгтэй байдаг (Моронай 6:4-ийг үзнэ үү). Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид бишопын удирдлага дор шинэ гишүүдэд эдгээр асуудалд нь тусалдаг.

### 5.2.2 Бишоп ба түүний зөвлөхүүд

Хөрвөгчдийг идэвхтэй байлгахад бишоп гол үүрэг хүлээдэг. Бишоп болон түүний зөвлөхүүд шинэ гишүүдийг Сүмд идэвхтэй байхад нь туслах дараах үүргүүдтэй. Энэхүү хүч чармайлтыг зохицуулахын тулд бишоп зөвлөхүүдийнхээ нэгийг энэ ажилд томилж болно.

Шинэ гишүүн бүрийг найз нөхөдтэй болгох ажлыг тэд хариуцна.

Насанд хүрсэн шинэ гишүүн бүрд дуудлага өгөх эсвэл үйлчлэх өөр боломж олгох тал дээр тэд анхаарна.

12 болон түүнээс дээш насны ах нар гишүүнээр батлагдсанаасаа хойш удалгүй, болж өгвөл долоо хоногийн дотор Аароны санваарын холбогдох албанд томилогддог байхыг анхаарна. Эдгээр ах нарт санваараа хэрэглэх боломжийг олгох тал дээр анхаарна. Баптисм хүртэж, гишүүнээр батлагдсан ах нар шууд Аароны санваар авах зохистой байдаг.

Бишоп болон түүний зөвлөхүүд 18 болон түүнээс дээш насны ах нарыг Мелкиседек санваар авахад бэлтгэхэд нь туслах талаар дээд пристүүдийн бүлгийн удирдагч, ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч хоёрын хийж байгаа ажилд хяналт тавина. Саяхан баптисм хүртсэн 18 болон түүнээс дээш настай ах нар пристээр үйлчилж, сайн мэдээний тухай хангалттай ойлголттой болж, зохистой байдлаа харуулсны дараа ахлагчаар томилогддог. Гишүүн байх тодорхой хугацаа шаардагддаггүй.

### 5.2.3 Тойргийн зөвлөл

Тойргийн зөвлөлийн хурлаар зөвлөлийн гишүүд тойргийн номлолын төлөвлөгөөнд өгүүлсний дагуу хөрвөгчдийг идэвхтэй байлгах талаар тавьсан зорилгынхоо биелэлтийг хэлэлцдэг (5.1.8-ыг үзнэ үү). Тэд шинэ гишүүн бүрийн өсөлтийг хэлэлцэж, ямар дэмжлэг хэрэгтэй байгааг тогтооно. Тэд энэхүү ярилцлагынхаа удирдамж болгон New and Returning Member Progress form (Шинэ болон буцаж идэвхтэй болж буй гишүүдийн өсөлтийн маягт)-ыг ашиглаж болно. Тэд шинэ гишүүдэд бусад гишүүдийн хайр хүндэтгэл, Их Эзэний хаант улсад үйлчлэхийн баяр баясгалан, сайн мэдээний зарчмуудаар амьдарснаар ирдэг амар амгаланг мэдрэхэд тусалдаг арга замуудын тухай хэлэлцдэг.

Шинэ хөрвөгчдийг бэхжүүлэх талаар тойргийн номлолын удирдагч санваартны болон туслах бүлгүүдийн бусад удирдагчидтай хамтран ажиллах арга замуудыг тойргийн зөвлөл хэлэлцэж болно. Тойргийн зөвлөлийн гишүүд нь ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажил зэрэг үйлчлэх боломжуудыг шинэ гишүүдэд өгч болно.

### 5.2.4 Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид бишопын удирдлагаар шинэ гишүүдийг сүнслэг байдлын хувьд төлөвших болон Сүмд идэвхтэй байхад нь туслах боломжуудаар хангана. Жишээ нь Нийгмийн Халамжийн бүлгийн ерөнхийлөгч нь насанд хүрсэн эмэгтэй хөрвөгчдөд туслах хариуцлага хүлээдэг. Насанд хүрсэн эрэгтэй хөрвөгч бол ирээдүйд ахлагч болохуйц хүн учраас түүнд өсч хөгжихөд нь бишопын зөвлөлийн тодорхойлсны дагуу ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч эсвэл дээд пристүүдийн бүлгийн удирдагч туслах үүрэгтэй. Сүмд гэр бүлийн нэг буюу түүнээс олон хүн элсэн орсон үед Санваарын болон туслах бүлгийн удирдагчид тойргийн зөвлөлийн хурлаар ажил үйлсээ холбон уялдуулах хэрэгтэй.

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид дараах арга замуудаар шинэ гишүүдэд тусалж болно:

Тэд номлогчдын заасан хичээлүүдээс сургаал болон зарчмуудыг ойлгож, амьдралдаа хэрэгжүүлэхэд нь шинэ гишүүдэд тусална.

Тэд шинэ гишүүдийг гэрчлэл хэрхэн хуваалцах, аравны нэг болон бусад өргөлүүдийг төлөх, мацгийн хуулиар амьдрах, яриа өгөх, санваарын ёслолуудыг гүйцэтгэх, гэр бүлийн түүхийн ажилд оролцох, нас барагсдын өмнөөс баптисм ба гишүүний баталгаа гүйцэтгэх (боломжтой газарт), гэрийн болон айлчлагч багшаар үйлчлэх зэрэг Сүмийн үндсэн үйл ажиллагаануудад суралцахад нь анхаарна.

Шинэ гишүүдийг судрууд, Сүмийн сэтгүүлүүд болон хичээлүүдэд хэрэглэх гарын авлагуудтай болоход анхаарна.

Хэрэв шинэ гишүүд семинар, институтийн насных бол хамрагдахад нь санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид тусална.

Шинэ гишүүд ариун сүмийн ёслолуудыг хүлээн авах болзлыг хангасан үед ариун сүмийн бэлтгэлийн хичээлд суух буюу өөр аль нэг хэлбэрээр бэлтгэхэд нь санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид тэдэнд тусалдаг.

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, дээд пристүүдийн чуулгын удирдагч нар гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн өмнө шууд үүрэг хүлээдэг ч, бишоп ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, дээд пристүүдийн бүлгийн

удирдагчтай тогтмол уулзаж, үүргээ хэрхэн биелүүлж байгааг, түүний дотор чуулга, бүлгийн хэмжээнд гэрийн багшлалт хэрхэн явагдаж байгаа талаар тайлагнахыг хүснэ. Тэрээр тэдэнд зөвлөгөө өгч, дуудлагаа хичээл зүтгэл гарган биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ. Удирдагчид шинэ гишүүдтэй ажиллуулахаар адил сонирхолтой эсвэл тэдэнтэй адил сорилттой тулгарч байгаа гишүүдийг томилж болно.

Санваартан болон туслах бүлгийн удирдагчид (эсвэл тэдний томилсон гишүүд) долоо хоног бүр тэдний чуулга буюу туслах бүлэгт хамрагддаг шинэ гишүүдийг ариун ёслолд ирсэн эсэхийг тэмдэглэдэг. Ариун ёслолын цуглаанд ирээгүй гишүүдтэй очиж уулзан, дараагийн долоо хоногт ирэхийг урих даалгаврыг тэд хэн нэгэнд өгнө.

### 5.2.5 Гэрийн болон айлчлагч багш нар

Гэрийн болон айлчлагч багш нар шинэ гишүүдтэй нөхөрлөлийг бий болгон хөгжүүлэхэд чухал үүрэгтэй юм. Мелкизедек санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид бишоптой зөвлөлдсөний үндсэн дээр, чин сэтгэлээр үйлчилдэг гэрийн болон айлчлагч багш нарыг шинэ гишүүдэд томилон ажиллуулахад тэргүүн зэргийн ач холбогдол өгөх ёстой.

Номлолын ерөнхийлөгч зөвшөөрсөн үед бүрэн цагийн номлогч нар шинэ гишүүдэд заахаар гэрийн болон айлчлагч багшийн ажилд тусалж болно.

### 5.2.6 Тойргийн номлогчид ба бүрэн цагийн номлогчид

Хөрвөгчдийг Сүмд идэвхтэй байлгах нь тойргийн санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчдын үндсэн үүрэг хариуцлага боловч тойргийн болон бүрэн цагийн номлогч нар энэ ажилд мөн тусалдаг. Тойргийн номлогч нар номлогчийн эхний дөрвөн хичээлийг бүх шинэ гишүүдэд дахин заана (*Миний сайн мэдээг номло,* 3-р бүлгийг үзнэ үү). Мөн тэд 5-р хичээлийг заана. Шаардлагатай бол бүрэн цагийн номлогч нар тойргийн номлогчдод тусалж болно.

### 5.2.7 Тойргийн бусад гишүүдийн нөлөө

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагч нар тойргийн гишүүдийг шинэ гишүүдэд хайраа үзүүлж, нөхөрлөхийг дэмжинэ. Хөрвөгчдийг гэр бүлийн үдэш, хичээл, үйл ажиллагаануудад хамт оролцохыг урих, шаардлагатай бол унаагаар үйлчлэхэд удирдагчид тойргийн гишүүдийг уриалан дэмжиж болно.

### 5.2.8 Сайн мэдээний зарчмуудын анги

18 болон түүнээс дээш настай гишүүд ням гарагийн ангийн цагаар Сайн мэдээний зарчмуудын ангид сонирхогчдын хамт суудаг. Шинэ гишүүд Сайн мэдээний зарчмуудын ангид ихэвчлэн эхний хэдэн сар суудаг. Тэд бэлэн болсон үедээ Сайн мэдээний сургаалын ангид суна.

Тойргийн номлолын удирдагч Сайн мэдээний зарчмуудын ангид суудаг. Тэрээр уг ангийг тойрог дахь идэвхжүүлэх бусад ажилтай уялдуулна. Бишопын зөвлөлийн гишүүн энэ ангид заалгахаар түүнийг томилж болно. Тойргийн бусад номлогчид энэ ангид сууж болно.

Гэрийн болон айлчлагч багш нар, бусад гишүүд шинэ хөрвөгчид, сонирхогчидтой нөхөрлөхийн тулд энэ ангид сууж болно. Хичээл зааж байгаа багш тойргийн бусад гишүүдийг энэ ангид сууж, гэрчлэл, туршлагаа хуваалцахыг урьж болно. Жишээ нь багш тойргийн гишүүдээс аравны нэгийн адислал, бэрхшээлийг даван туулсан эсвэл Сүмийн дуудлагуудад үйлчилснээр хүлээн авсан адислалын тухай гэрчлэлээ хуваалцахыг урьж болно.

Энэ ангийн багш нар дараах үүргүүдтэй:

Тэд хичээлээ *Сайн мэдээний зарчмууд гарын авлагаас сонгож, заана.* Тэд заахдаа судрууд, ялангуяа Мормоны Номыг байнга ашиглана. Тэд хичээлээ суралцагсдын хэрэгцээнд тохируулж, бодол санаа, гэрчлэлээ хуваалцахыг тэднээс хүснэ.

Тэд гэрчлэлээ байнга хуваалцан Сүнслэг уур амьсгалыг бий болгодог.

Тэд ангийн гишүүдийг Мормоны Номыг тогтмол уншиж, тэр талаар сэтгэгдлээ хуваалцахыг урамшуулан дэмждэг.

### 5.2.9 Гадасны удирдагчид

#### Гадасны ерөнхийлөгч ба түүний зөвлөхүүд

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд гадасны шинэ гишүүдийг бэхжүүлэх ажилд хяналт тавина. Тэд бусад удирдагчдад энэ талаар заавар өгч, дэмжлэг үзүүлдэг. Тэд тойргууд дээр очих үеэрээ шинэ гишүүдтэй уулздаг. Тэд гадасны чуулгантай холбогдуулан шинэ гишүүдэд зориулсан хурлыг зарим үед хийж болно.

Гадасны ерөнхийлөгч бишоп бүртэй хийдэг тогтмол ярилцлагадаа тухайн бишопын тойрог дахь шинэ гишүүдийн өсөлтийн тайланг авчрахыг түүнээс хүснэ.

Гадасны ерөнхийлөгч номлолын ерөнхийлөгчтэй тогтмол хийдэг ярилцлагадаа гадасны

хэмжээн дэх шинэ гишүүдийн өсөлтийн тайланг гарган өгч болно.

#### Дээд зөвлөлийн гишүүд

Тойргийн Мелкиседек санваартны удирдагчид болон тойргийн номлолын удирдагчидтай ажилладаг дээд зөвлөлийн гишүүдийн аль аль нь шинэ гишүүдэд заах, тэдэнтэй нөхөрлөхөд тусална. Тэд ахлагч болохуйц гишүүдэд Мелкиседек санваар авахад бэлтгэхэд нь тусалж болно.

#### Гадасны туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл

Гадасны туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл шинэ гишүүдэд заах, тэдэнтэй нөхөрлөх ажилд тойргийн туслах бүлгийн удирдагчидтай хамтран ажиллаж болно.

## 5.3 Идэвхжүүлэлт

Тойргийн санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид идэвх султай гишүүдийг Сүмийн үйл ажиллагаанд ирэхэд нь үргэлж туслахыг хичээнэ. "Тийм нэгэнд та нар үргэлжлүүлэн тохинуулах болно, учир нь тэд эргэж ирээд мөн наманчилж мөн зүрх сэтгэлийнхээ бүх тэмүүллээр надад ирж, мөн би тэднийг эдгээх ажгуу; мөн та нар тэдэнд авралын авчрах хэрэгсэл байх эсэхийг та нар мэдэхгүй" (3 Нифай 18:32) хэмээн Аврагч хэлсэн билээ.

Идэвх султай гишүүд сайн мэдээнд итгэсэн хэвээр байх боловч сүмд явахад нь хэцүү санагдуулдаг хүнд сорилт тохиолдсон байж мэднэ. Тэдэнд Сүмд найз нөхөд дутдагаас цуглаанууд дээр ганцаарддаг байж болзошгүй. Сүмдээ идэвхгүй болсон хүмүүсийн хувьд амьдралаас нь ямар нэг зүйл байхгүй болсон мэт санагддаг учраас сүмдээ эргэн ирдэг ажээ. Тэд амьдралынхаа хэв маягт өөрчлөлт гаргах хэрэгтэй байгааг ойлгодог. Ийм үед тэдэнд хайраар, нөхөр ёсны санаа тавьж, нөхцөл байдлыг нь ойлгон хүлээн авах Сүмийн идэвхтэй гишүүд хэрэгтэй байдаг.

### 5.3.1 Бишоп ба түүний зөвлөхүүд

Бишоп болон түүний зөвлөхүүд гишүүдийг идэвхжүүлэх үүрэг хариуцлагыг хүлээдэг. Идэвх султай гишүүд итгэлээ сэргээх, эргэж ирж байгаа гишүүд нөхөрлөл, дэмжлэгийг хүлээн авахад туслах талаар санваартны чуулгууд, туслах бүлгүүдийн хийж байгаа ажлыг тэд удирдан чиглүүлдэг. Эргэж ирж байгаа ах нарыг санваарын албанд шат ахихад болон ах, эгч нарыг ариун сүмийн ёслолуудыг хүлээн авах буюу ариун сүмд дахин ороход нь тэд тусалдаг.

Бишоп зөвлөхүүдийнхээ нэгийг идэвхжүүлэх ажлыг зохицуулахаар томилж болно.

### 5.3.2 Тойргийн зөвлөл

Тойргийн зөвлөлийн гишүүд тойргийн номлолын төлөвлөгөөнд тусгагдсан идэвхжүүлэх ажлын зорилгыг бишопын зөвлөлийн удирдлага дор хэлэлцэнэ (5.1.8-ыг үзнэ үү). Тэд бүлгийнхээ идэвх султай гишүүдэд үйлчлэх талаар санал бодлоо хуваалцана. Тойргийн зөвлөлийн гишүүд идэвх султай гишүүдийн хэрэгцээ, нөхцөл байдлын талаар байнга мэдээлэлтэй байснаар уг гэр бүлүүд болон хувь хүмүүс Сүмээс айлчлан очих гишүүдийг хүлээн авах тохиромжтой цаг болон Сүмийн үйл ажиллагаанд оролцох эсвэл ариун сүмийн бэлтгэлийн хичээл авахад бэлэн болсныг мэдэж чадна.

Сүмийн үйл ажиллагаанд эргэж ирэх магадлалтай, идэвх султай гишүүдийг тойргийн зөвлөл залбирч тогтоодог. Тэд бас ямар удирдагчид, ямар гишүүд идэвх султай гишүүдийг хамгийн их бэхжүүлж, тэдэнтэй хувийн харилцаа тогтоон өргөжүүлж чадахыг шийддэг. Гэр бүлийн нэгээс олон гишүүн идэвх султай байгаа бол удирдагчид тойргийн зөвлөлийн хурлаар хамтран ажилладаг.

Тойргийн зөвлөлийн хурлаар эдгээр гишүүдийн өсөлтийг тогтмол хэлэлцэнэ. Зарим гишүүд эргэж ирсний дараа эсвэл эргэж ирэхээс татгалзсан тохиолдолд тойргийн зөвлөл урилгыг хүлээж авах боломжтой өөр гишүүдийг олж тогтооно. Удирдагчид энэ ажилд хяналт тавихын тулд New and Returning Member Progress form (Шинэ болон буцаж идэвхтэй болж буй гишүүдийн өсөлтийн маягт)-ыг ашиглаж болно.

### 5.3.3 Гэрийн болон айлчлагч багш нар

Мелкиседек Санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид бишоптой зөвлөлдсөний үндсэн дээр чин сэтгэлээсээ үйлчилдэг гэрийн болон айлчлагч багш нарыг идэвх султай гишүүдтэй ажиллахад томилоно. Эдгээр удирдагчид эргэж ирэх урилгыг хүлээн авах магадлалтай идэвх султай гишүүд дээр хүч чармайлтаа төвлөрүүлдэг.

### 5.3.4 Бүрэн цагийн номлогчид ба тойргийн номлогчид

Тойргийн номлолын удирдагч, бүрэн цагийн болон тойргийн номлогч нар тохиромжтой үед гишүүдийг идэвхжүүлэхэд тусалж болох ба ялангуяа идэвх султай гишүүдийг идэвхжүүлэх үеэр тэдний гишүүн бус найз эсвэл төрөл

төрөгсдөд номлогч нар хичээл заах боломжтой байвал хамтарч ажиллана.

### 5.3.5 Сайн мэдээний зарчмуудын анги

18 болон түүнээс дээш настай идэвх султай гишүүд ням гарагийн ангийн хичээлийн үеэр Сайн мэдээний зарчмуудын хичээлд сууж болно (5.2.8-ыг үзнэ үү).

### 5.3.6 Гадасны удирдагчид

#### Гадасны ерөнхийлөгч ба түүний зөвлөхүүд

Гадасны ерөнхийлөгч бишоп бүртэй хийдэг тогтмол ярилцлагадаа тухайн бишопын тойрог дахь идэвх султай гишүүдийн өсөлтийн тайланг авчрахыг хүсдэг. Гадасны ерөнхийлөгч, бишоп хоёр эдгээр гишүүдтэй ажиллах талаар тойргийн зөвлөлөөс гаргасан төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилгуудыг хэлэлцдэг.

Гадас болон номлолын ерөнхийлөгч нар номлолын ажлыг ярилцахаар уулзсан үедээ идэвх султай гишүүдтэй ажиллахад бүрэн цагийн номлогчид хэрхэн тусалж чадах тухай ярилцдаг.

#### Дээд зөвлөлийн гишүүд

Тойргийн Мелкизедек санваартны удирдагчидтай ажилладаг дээд зөвлөлийн гишүүд идэвх султай гишүүдэд зааж, тэдэнтэй нөхөрлөж, тусалж болно. Тэд ахлагч болохуйц зохистой гишүүдэд Мелкизедек санваар авахад нь туслах ажилд оролцож болно.

#### Гадасны туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл

Гадасны туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл идэвх султай гишүүдэд заах, тэдэнтэй нөхөрлөх ажилд тойргийн туслах бүлгүүдийн удирдагчидтай хамтран ажиллаж болно.

## 5.4 Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажил

Ариун сүмүүдэд Сүмийн гишүүд өргөмжлөлд шаардлагатай ёслолууд хүлээн авч, ариун гэрээнүүдийг хийдэг. Сүмийн гишүүд ёслол хүлээн авалгүй нас барсан хүмүүсийн өмнөөс ёслолуудыг гүйцэтгэхийн тулд ариун сүмд явдаг.

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид дараах хэсэгт өгүүлсний дагуу ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажлын талаарх үндсэн үүргүүдийн тухай тойргийн гишүүдэд заана:

Гишүүдийг болон тэдний гэр бүлийнхнийг ариун сүмийн ёслолуудаа хүлээн авахад дэмжиж тусална. Удирдагчид Ариун сүмийн хишиг хүртэхийн зорилго нь зөвхөн гэрлэх эсвэл номлолд бэлтгэх биш харин өргөмжлөлд бэлтгэх явдал гэдгийг гишүүдэд заадаг.

Ариун сүмийн хишиг хүртсэн гишүүн бүр ариун сүмийн хүчинтэй эрхийн бичигтэй байж, ариун сүмд аль болох олон удаа явж байхыг удирдагчид хөхүүлэн дэмжих хэрэгтэй. Удирдагчид ариун сүмийн хишиг хүртээгүй насанд хүрэгчид, 12 болон түүнээс дээш насны залуучууд түүний дотор шинэ гишүүдийг хязгаартай ашиглах ариун сүмийн бичигтэй болж, нас барагсдын өмнөөс баптисм хүртэж, гишүүнээр батлуулахын тулд ариун сүмд тогтмол орохыг урамшуулан дэмждэг. Удирдагчид ариун сүмд явах талаар дүрэм журам тогтоох ёсгүй. Ариун сүмийн ажилд хэр зэрэг их оролцохоо гишүүн бүр өөрөө тогтооно.

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид гишүүдэд өвөг дээдсийнхээ нэрсийг олж тогтоон шаардлагатай бол тэдний төлөө ариун сүмийн ёслолууд хийлгэхийг хүсэх буюу боломжтой бол уг ёслолуудыг ариун сүмд өөрсдөө хийлгэх замаар гэр бүлийн түүхийн ажилд оролцохыг заана.

Удирдагчид гишүүдэд садан төрлийн холбоогүй хүний төлөө ариун сүмийн ёслолуудыг ойрын төрөл төрөгсдийнх нь зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэх ёсгүйг ойлгоход нь туслах ёстой. Мөн гишүүдэд өөрийн садан төрөл биш алдартай хүмүүсийн төлөө эсвэл мэдээллийг нь зөвшөөрөлгүй ашиглан бусдын төлөө аврах ёслол хийлгэх хүсэлт тавих ёсгүйг ойлгоход туслах хэрэгтэй.

### 5.4.1 Бишоп ба түүний зөвлөхүүд

Бишоп ба түүний зөвлөхүүд тойргийнхоо хэмжээн дэх ариун сүмийн болон гэр бүлийн ажилд хяналт тавина. Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажлын сургаалууд болон адислалуудыг гадас, тойргийн цуглаанууд дээр тогтмол заахад тэд анхаарна.

Бишоп гишүүдтэй уулзахдаа ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахад бэлтгэх, цаашид боломж олдох бүрд ариун сүмд явахад нь зохистой байхад нь тэдэнд тусална.

Гишүүдийг өвөг дээдсийнхээ нэрсийг олж тогтоон тэдний төлөө ариун сүмийн ёслолууд хийлгэхийг бишоп болон түүний зөвлөхүүд дэмждэг.

Ариун сүмтэй холбоотой бишопын зөвлөлийн бусад үүргүүд *Гарын авлага 1-ийн* 3-р бүлэг-т байгаа.

### 5.4.2 Тойргийн зөвлөл

Улиралд нэг удаа удирдагчид тойргийн зөвлөлийн хурал дээр ариун сүм болон гэр бүлийн түүхтэй холбоотой асуудлуудыг дараах байдлаар авч хэлэлцдэг байх хэрэгтэй:

Хувь хүмүүс болон гэр бүлүүд ариун сүмийн ёслолуудыг хүлээн авч, ариун сүмд аль болох олон удаа ороход нь туслах арга замуудыг тэд хэлэлцэнэ.

Ариун сүмийн бэлтгэлийн эсвэл гэр бүлийн түүхийн хичээлд суух гишүүдийг тэд залбирлаар олж тогтооно.

Гэр бүлийн түүхийн ажилд оролцоход нь гишүүдэд туслах арга замуудыг тэд хэлэлцэнэ.

Бүрэн цагийн номлогчдын заах хүмүүсийг олох, шинэ болон идэвх султай гишүүдтэй ажиллахад гэр бүлийн түүхийн ажлыг ашиглах арга замуудыг хэлэлцэж болно.

### 5.4.3 Дээд пристүүдийн бүлгийн удирдагч

Дээд пристүүдийн бүлгийн удирдагч нь тойргийн зөвлөлийн ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд тусална.

Тэрээр мөн гэр бүлийн түүхийн зөвлөхүүдийн ажлыг удирдана. Хэрэв гадас гэр бүлийн түүхийн төвтэй бол гэр бүлийн түүхийн төвийн захирлын хүсэлтээр зөвлөхүүдийг томилно. Хэрэв гадас FamilySearch indexing-д оролцдог бол тэрээр хүмүүсийг FamilySearch indexing-ийн ажилтнаар үйлчлүүлэх саналыг тавина.

Хэрэв тойрогт дээд пристүүдийн бүлгийн удирдагч байхгүй бол ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч эсвэл томилогдсон өөр нэг Мелкиседек санваартан энэ үүргийг гүйцэтгэнэ.

### 5.4.4 Гэр бүлийн түүхийн зөвлөхүүд

Гэр бүлийн түүхийн зөвлөхүүд дээд пристүүдийн бүлгийн удирдагчийн удирдлага дор дараах үүргүүдийг гүйцэтгэнэ. Тэд *Ариун сүм ба гэр бүлийн түүхийн ажлын гишүүдийн гарын авлага*-г удирдамж болгон ашиглана.

Тэд гишүүдэд өвөг дээдсээ олж тогтооход нь тусална. Тэд гишүүдэд өвөг дээдсийнхээ төлөө ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэх мэдээллийг бэлтгэхэд тусална. Тэд компьютергүй эсвэл компьютер ашиглаж чаддаггүй гишүүдэд тусална. Боломжтой бол тэд энэ дэмжлэгийг гишүүдийн гэрт нь очиж үзүүлнэ.

Тэд ажил үүргийнхээ дагуу орон нутгийн гэр бүлийн түүхийн төвд тогтмол үйлчилнэ. Тэднийг тойргийн гэр бүлийн түүхийн хичээл заалгахаар томилж болно.

Гэр бүлийн түүхийн зөвлөхүүдийн ажил үүргийн тухай нэмэлт мэдээллийг LDS.org дахь *Family History Consultant's Guide to Temple and Family History Work*-с үзнэ үү.

### 5.4.5 Ариун сүм ба гэр бүлийн түүхийн анги ба гарын авлага, материалууд

#### Ариун сүмд бэлтгэх хичээл

Ариун сүмд бэлтгэх хичээл нь гишүүдэд ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахад бэлтгэхэд тусалдаг. Энэ хичээлийг бишопын удирдлага дор төлөвлөнө. Хичээлийг шаардлагатай тохиолдол бүрд сүмийн байранд эсвэл гэр оронд нь заана.

Ариун сүмд бэлтгэх хичээл нь ялангуяа шинэ гишүүд, Сүмд эргэж ирж байгаа идэвх султай гишүүд, хувийн хишгээ хүртсэн боловч ариун сүмийн бичгээ удаан хугацаанд шинэчлээгүй гишүүдэд хэрэгтэй юм. Энэ хичээл нь хувийн хишгээ хүлээн авахаар бэлтгэж байгаа идэвхтэй гишүүдэд мөн тустай байж болно.

Тойргийн зөвлөлийн гишүүд бишопын удирдлага дор ариун сүмд бэлтгэх хичээлд гишүүдийг залбирч сонгодог.

Бишопын зөвлөл нэг эсвэл түүнээс олон багшийг дуудна. Нөхөр эхнэр хоёр байж болно. Энэ цуврал хичээлийг зохион байгуулах заавар нь*"Дээрээс хишиг хүртэх нь: Ариун сүмийн бэлтгэлийн хичээлийн багшийн гарын авлага" -д байдаг.* Хичээлд оролцогчдод *Ариун сүмд орохоор бэлтгэх нь* товхимлын нэг хувийг өгөх ёстой.

#### Гэр бүлийн түүхийн хичээл

Гэр бүлийн түүхийн хичээлийг ням гарагийн ангид эсвэл гишүүдэд илүү тохиромжтой өөр үед зааж болно. Энэ хичээлийг ням гарагийн ангийн ерөнхийлөгч биш харин бишопын зөвлөл зохион байгуулах нь зүйтэй. Багш энэхүү цуврал хичээлийг заахдаа *Ариун сүм ба гэр бүлийн түүхийн ажлын багшийн гарын авлага*-г ашиглана. Багш нь ихэвчлэн бишопын зөвлөлийн томилсон гэр бүлийн түүхийн зөвлөх байдаг. Хичээл нь ерөнхийдөө гишүүд гэр бүлийн түүхээ хөтлөх дадлага хэлбэрээр явагддаг.

#### Гэр бүлийн түүхийн онлайн эх сурвалжуудад нэвтрэх нь

Сүмийн гэр бүлийн түүхийн онлайн эх сурвалжууд нь өвөг дээдсээ олж тогтоох, тэдний тухай мэдээллийг цэгцлэх, тэдний төлөө ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэх хүсэлтийг илгээхэд гишүүдэд тусалдаг. Эдгээр эх сурвалжуудын ихэнх нь Сүмийн гэр бүлийн түүхийн FamilySearch.org вэб хуудсанд байдаг.

Гадас, тойргийн байранд интернетэд холбогдсон компьютер эсвэл гадас, тойргийн компьютеруудад гэр бүлийн түүхийн программ байгаа бол гишүүдэд эдгээр компьютерийг боломжтой үед хэрэглүүлдэг байхыг гадасны ерөнхийлөгчийн болон бишопын зөвлөл анхаарна. Гэр бүлийн түүхийн зөвлөхүүд эдгээр компьютерийн хуваарийг гаргахад тусалж, хэрхэн ашиглахыг гишүүдэд зааж болно.

Сүмийн компьютеруудыг гэр бүлийн түүхийн ажилд ашигладаг гишүүд гишүүнчлэлийн болон санхүүгийн мэдээллүүдэд нэвтрэх боломжгүй байх ёстой.

### 5.4.6 Гадасны удирдагчид

#### Гадасны ерөнхийлөгч ба түүний зөвлөхүүд

Гадасны ерөнхийлөгч болон түүний зөвлөхүүд гадсан дахь ариун сүмийн ба гэр бүлийн түүхийн ажилд хяналт тавина. Энэ ажлын сургаал болон адислалуудын талаар гадасны хурал цуглаанууд дээр тогтмол заадаг байхад тэд анхаарна.

Гадасны ерөнхийлөгч гишүүдтэй уулзахдаа ариун сүмийн ёслолууд хүлээн авахад бэлтгэх, цаашид боломж олдох бүрд ариун сүмд ороход зохистой байхад нь тэдэнд тусална.

Гадасны ерөнхийлөгч болон түүний зөвлөхүүд гишүүдийг өвөг дээдсээ олж тогтоон, тэдний төлөө ариун сүмийн ёслолуудыг хийлгэхийг урамшуулан дэмжинэ.

Ариун сүмтэй холбоотой гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн бусад үүргүүдийн тухай *Гарын авлага 1-ийн* 3-р бүлэг-т өгүүлсэн байдаг.

#### Ариун сүмийн ба гэр бүлийн түүхийн ажилд томилогдсон дээд зөвлөлийн гишүүн (гишүүд)

Дээд пристүүдийн бүлэг, ахлагч нарын чуулгын удирдагчдад ариун сүмийн ба гэр бүлийн түүхийн талаарх үүрэг хариуцлагыг нь заах нэг буюу түүнээс олон дээд зөвлөлийн гишүүдийг гадасны ерөнхийлөгчийн зөвлөл томилж болно. Шаардлагатай бол эдгээр дээд зөвлөлийн гишүүд FamilySearch indexing болон гэр бүлийн түүхийн төвүүд дэх гадасны ажлыг зохицуулна.

### 5.4.7 Гадсан дахь ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн гарын авлага, материалууд

#### Гадсан дахь FamilySearch indexing программ

FamilySearch indexing-нд оролцогчид хүн амын тооллогын материал, сүмийн бүртгэлүүд болон бусад чухал бүртгэл тайлан зэрэг баримт бичгүүдэд нэвтрэхэд өөрсдийн компьютеруудыг ашиглана. Тэд эдгээр баримт бичгээс автомат индексүүдийг бий болгоод дараа нь FamilySearch.org-р дамжин нэвтэрч болно.

Хувь хүмүүс түүний дотор Сүмийн гишүүн бус хүмүүс өөрсдийнхөө FamilySearch indexing-ийг хийж болно. Гэвч гадасны гишүүд индексийн хөтөлбөр дээр хамтран ажиллах нь үр дүнтэй эсэхийг гадасны ерөнхийлөгчийн зөвлөл тодорхойлж болно. Энэ ажил нь идэвх султай эсвэл гэрээс гарах боломжгүй гишүүдийг үйлчлэх боломжоор хангаж болно. Энэ ажилд залуучууд оролцож болно.

FamilySearch indexing программ бий болгох тухай мэдээллийг LDS.org дахь *Administrative Guide for Family History*-гоос үзнэ үү.

#### Гэр бүлийн түүхийн төв

Зарим гадас гэр бүлийн түүхийн төвүүдтэй байдаг. Эдгээр төв үндсэндээ өвөг дээдсээ олж тогтоон, тэдний төлөө ариун сүмийн ёслолууд хийлгэхэд Сүмийн гишүүдэд туслах зорилгоор байгуулагдсан юм. Гэр бүлийн төвүүд дэх эх сурвалж, материалуудыг гадны хүмүүс ашиглаж болно.

Эдгээр төвд Сүмийн гэр бүлийн түүхийн бичил хальс, компьютер, FamilySearch зэрэг интернетийн эх сурвалжуудад нэвтрэн үзэж болно. Мөн гэр бүлийн түүхийг хэрхэн бичих талаар сургалт явуулж болно.

Гэр бүлийн түүхийн төвүүдийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг LDS.org дахь *Administrative Guide for Family History*-с үзнэ үү.

## 5.5 Сайн мэдээг заах нь

Сайн мэдээг үр ашигтай заах нь гэрчлэлээ хөгжүүлж, Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт итгэх итгэлээ өсгөн нэмэгдүүлэхэд хүмүүст тусалдаг. Энэ нь гишүүдийн сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрах хүч чармайлтыг хүчирхэгжүүлдэг. Бурханы үгийг сүнсний хүчээр заасан үед энэ нь “хүмүүсийн оюун ухаанд . . . юунаас ч илүү хүчтэйгээр нөлөөлдөг” (Алма 31:5). Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид өөрсдийн бүлгийн сургалтыг үр дүнтэй байлгахын төлөө хичээнэ. Сүмийн гишүүд хурал цуглаанд оролцохдоо Бурханы үгсээс ирдэг хүч чадал, амар амгалан, сүнсний нөлөөг эрэлхийлдгийг тэд санах ёстой.

### 5.5.1 Бишоп ба түүний зөвлөхүүд

Бишоп ба түүний зөвлөхүүд сайн мэдээг Сүнсний хүч болон хувийн үлгэр жишээгээр

заадаг. Тэд тойргийн зөвлөлийн ажлыг удирдан чиглүүлэхдээ тойрогт зааж байгаа сайн мэдээ нь сургамжтай, сургаалын хувьд зөв байхад анхаарна.

### 5.5.2 Тойргийн зөвлөл

Тойргийн зөвлөлийн гишүүд бишопын удирдлага дор тойргийнхоо хэмжээнд сайн мэдээнээс суралцах болон заах чанарыг хэрхэн сайжруулахыг хамтдаа тогтмол хэлэлцэж байна. Эдгээр ярилцлагыг хөтлөн явуулж, заавар өгүүлэхээр бишоп ням гарагийн ангийн ерөнхийлөгчийг урьж болно.

### 5.5.3 Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид сайн мэдээг үр өгөөжтэй заах тал дээр чармайн ажилладаг. Тэд туслах бүлгүүдийнхээ сайн мэдээнээс суралцах болон заах ажлыг хариуцдаг. Тэд энэ талаар тойргийн ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй зөвлөлдөнө.

#### Гишүүдийг багшаар үйлчлүүлэхээр нэр дэвшүүлэх нь

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид өөрсдийн бүлэгт багшаар дуудагдах тойргийн гишүүдийг бишопын зөвлөлд санал болгодог. Сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрахад ангийн гишүүдэд сүнслэгээр нөлөөлөх хичээлийг бэлтгэж заахыг хичээх багш нарыг удирдагчид санал болгох хэрэгтэй. Тэд ингэхдээ 19.1.1 болон 19.1.2 дахь зарчмуудыг баримтална.

#### Шинээр дуудагдсан багш нарыг сургах нь

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид өөрсдийн бүлгийн шинээр дуудагдсан багш бүртэй боломжтой бол анхных нь хичээлээс өмнө биечлэн уулздаг. Энэ уулзалтаар удирдагчид дараах байдлаар багш нарт заавар өгдөг:

Шаардлагатай бол тэд ангийн гишүүдтэй танилцахад нь тусална. Тэд багш нарт ангийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг өгч, суралцагчдын нэрсийг тогтоохыг хүснэ. Тэд багш нарыг ангийн гишүүдэд анхаарал халамж тавьж харилцахыг дэмжинэ.

*Teaching, No Greater Call* номыг хэрхэн ашиглах ёстойг ойлгоход нь тэд багш нарт тусалдаг. Тэд энэ номыг багш бүрд өгч, агуулгыг нь товч хуваалцана.

Шаардлагатай үед тэд хичээл заахад бэлтгэхэд багш нарт тусална. Тэд зөвшөөрөгдсөн сургалтын материалуудыг хичээлд нь зориулан өгч, хэрхэн ашиглахыг тайлбарлана. Тэд бас *Teaching, No Greater Call* номын 98–99-р хуудсан дээрх "Preparing Lessons" өгүүллийг ярилцаж болно. (Зөвшөөрөгдсөн сургалтын материалуудын жагсаалт болон тэдгээрийг ашиглах заавҏыг *Instructions for Curriculum*-аас үзнэ үү.)

#### Багш нарт байнга дэмжлэг үзүүлэх нь

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид багш нартаа анхаарал тавьж, ажилд нь тусалж дэмжиж байх хэрэгтэй. Удирдагчид анх удаа заавар өгч уулзсанаасаа хойш багш нартай тогтмол уулзаж тэдний өөрсдийнх нь болон хичээл заалгадаг хүмүүсийнх нь хэрэгцээний талаар мөн энэ хэсэгт өгүүлсэн зарчмуудын тухай ярилцана. *Teaching, No Greater Call* номын 24–27-р хуудсан дээрх "Making a Plan to Improve Your Teaching" өгүүлэлд дурдсаны дагуу зорилго дэвшүүлж ажиллахад нь багш нарыг дэмжинэ.

#### Хичээл нь сургамжтай, сургаалын хувьд зөв байхад анхаарах нь

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид ням гарагийн болон бусад ангийн хичээлийн үеэр суралцах, заах ажлын байдалд нь хяналт тавина. Ням гарагийн ангийн болон Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд зэрэг хичээлд тогтмол сууж чаддаггүй удирдагчдыг багш нартай ээлжлүүлэн хичээлд суух боломж олгох хэрэгтэй. Удирдагчид ажиглалт дээрээ үндэслэн хичээлийг үр дүнтэй болгох тухай багш нартай зөвлөлдөнө.

Багш нар судар, хожмын үеийн бошиглогчдын сургаалууд, *Instructions for Curriculum*-д өгүүлсэн зөвшөөрөгдсөн сургалтын материалуудыг ашиглах ёстойг удирдагчид анхаарна. Сургалтын материалууд дээр Сүмийн сэтгүүлүүд, ялангуяа *Ensign*, болон *Лиахона*-гийн ерөнхий чуулганы дугааруудыг нэмж хэрхэн ашиглахыг ойлгоход нь тэд багш нарт тусалдаг.

### 5.5.4 Багш нар ба удирдагчид

Багш нар, удирдагчид сайн мэдээг заахдаа дараах зарчмуудыг удирдлага болгодог.

#### Заадаг хүмүүсээ хайрла

Багш нар, удирдагчид заадаг хүмүүсээ хайрлаж, тэдэнд чин сэтгэлээсээ анхаарал тавьдаг. Тэд ангийн гишүүдийг нэрээр нь мэддэг байх хэрэгтэй. Хичээлд тогтмол ирдэггүй ангийн гишүүдийн тухай мэддэг байхын тулд тэд ирцийн мэдээллийг хянан хэлэлцдэг. Тэдний ирцийг сайжруулахын тулд удирдагчид эдгээр гишүүдтэй хичээлийн бус цагаар холбоо барьж болно.

### Ариун Сүнсээр заа

Багш нар, удирдагчид хичээлд бэлтгэж заахдаа Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийлдэг. Тэд энэ удирдамжийг залбирч, Их Эзэнээс хамааралтайгаа даруухнаар хүлээн зөвшөөрөх замаар эрэлхийлдэг. Хичээлийн үед тэд зааж байгаа сургаалынхаа тухай гэрчлэлээ хуваалцсанаар Ариун Сүнсийг урьдаг.

### Сургаалыг заа

Багш нар болон удирдагчид сайн мэдээний сургаалуудыг зааж, гэрчлэхийн тулд судрууд, хожмын үеийн бошиглогчдын сургаалууд, зөвшөөрөгдсөн сургалтын материалуудыг ашиглана. Сургалтанд зориулсан зөвшөөрөгдсөн материалуудын жагсаалт нь *Instructions for Curriculum*-д байдаг. Шаардлагатай үед багш нар, удирдагчид нэмэлт сургалтын материалыг Сүмийн сэтгүүлүүдээс ялангуяа *Ensign* болон *Лиахона*-гийн ерөнхий чуулганы дугааруудаас авч болно.

### Хичээнгүй суралцахад урь

Хувиараа, гэр бүлээрээ, хичээл дээр сайн мэдээнээс суралцах үйл хэргээ хариуцлагатай хандахад нь багш нар, удирдагчид ангийн гишүүдийг урамшуулан дэмждэг. Багш нар нь ангийн гишүүдийг өөрсдийн судраа хичээл дээр авчирч байхыг дэмжинэ. Багш нар, удирдагчид ярилцлагад идэвхтэй оролцох боломжоор ангийн гишүүдийг хангаж, сайн мэдээгээр амьдарч, амлагдсан адислалуудыг авахад тэднийг урьдаг.

## 5.5.5 Тойргийн ням гарагийн ангийн ерөнхийлөгч ба түүний зөвлөхүүд

Тойргийн ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд сайн мэдээнээс суралцах, заах чанарыг сайжруулахад бусад удирдагчдад туслах чухал хүч болдог. Багш нарыг сургаж дадлагажуулах, заавар өгөх, байнгын дэмжлэг туслалцаа үзүүлэхэд удирдагчдад туслахыг тэднээс хүсч болно.

## 5.5.6 Суралцах, заахад зориулан хэвлэн гаргасан болон онлайн гарын авлага, материалууд

Сайн мэдээнээс суралцах болон заахад гишүүдэд туслахын тулд Сүм *Teaching, No Greater Call* ба *Заах удирдамж* гэсэн хоёр ном хэвлэн гаргасан юм. Энэ хоёр ном нь мөн LDS.org-т байдаг. LDS.org-с бусад материалуудыг мөн олж болно.

## 5.5.7 Сайн мэдээг заах цуврал хичээл

Бишопын болон тойргийн зөвлөл тойрогт Сайн Мэдээг заах аргын цуврал хичээлийг зааж болно. Энэ цуврал хичээл зааж байгаа багш нарт ашиг тустайгаас гадна ирээдүйн багш нарыг бэлтгэхэд тусална. Энэ хичээлийг ихэвчлэн ням гарагийн ангид заадаг. Эдгээр хичээл *Teaching, No Greater Call* номын хуудас 186–239-д байдаг. Бишопын зөвлөл энэ цуврал хичээлийг заалгахаар ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийг томилж болно. Эсвэл өөр нэг гишүүнийг дуудаж болно.

## 5.5.8 Гадасны ерөнхийлөгч ба түүний зөвлөхүүд

Гадасны ерөнхийлөгч, түүний зөвлөхүүд сайн мэдээг Сүнсний хүч болон хувийн үлгэр жишээгээр заадаг. Гадасны хэмжээнд сайн мэдээг заах ажил сургамжтай, сургаалын хувьд зөв байхад тэд анхаарч энэ ажлыг удирдан чиглүүлнэ.

# 6. Халамжийн зарчмууд ба удирдлага

6.1 **Сүмийн халамжийн зорилго . . . . . . . . . . . . . . 36**
6.1.1 Бие даах чадвар . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 36
6.1.2 Ядуус болон тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах ба үйлчлэхэд гишүүдийн тавих хүч чармайлт . . . . . . . . . . . 37
6.1.3 Их Эзэний агуулах . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 37

6.2 **Тойрог дахь халамжийн удирдлага . . . . . . . . 37**
6.2.1 Бишоп . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 37
6.2.2 Тойргийн зөвлөл . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 38
6.2.3 Тойргийн санваартны гүйцэтгэх хороо . . . . . 38
6.2.4 Дээд пристүүдийн бүлэг, Ахлагч нарын чуулга ба Нийгмийн Халамжийн Бүлэг . . . . 38
6.2.5 Тойргийн халамжийн зохицуулагчид . . . . . . 39

6.3 **Гадасны халамжийн удирдлага . . . . . . . . . . . 39**
6.3.1 Гадасны ерөнхийлөгч . . . . . . . . . . . . . . . . . . . . 39
6.3.2 Гадасны зөвлөл . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 39
6.3.3 Гадасны халамжийн зохицуулагчид . . . . . . . 40

6.4 **Нууц хадгалалт . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 40**

# 6. **Халамжийн зарчмууд ба удирдлага**

## 6.1 Сүмийн халамжийн зорилго

Сүмийн халамжийн зорилго нь гишүүдийг бие дааж амьдрах чадвартай болох ядуус болон тусламж хэрэгтэй хүмүүст халамж, үйлчлэл үзүүлэхэд нь туслах явдал юм.

1936 онд Тэргүүн Зөвлөл Сүмийн халамжийн төлөвлөгөөг гаргажээ. "Бидний үндсэн зорилго бол . . .залхуурлын хараалыг үгүй болгож, бэлэнчлэлийн зүхлийг устган, бие даах чадвар, хөдөлмөрч чанар, арвич хямгач, өөрийгөө хүндлэх явдлыг манай хүмүүсийн дунд дахин бий болгох явдал юм. Сүмийн зорилго бол хүмүүст бие дааж амьдралаа авч явахад нь туслах явдал юм. Ажил хөдөлмөр нь манай Сүмийн гишүүдийн амьдралын тэргүүлэгч зарчим болж бат бөх суурь нь болог" хэмээн Тэргүүн Зөвлөл хэлжээ. (Conference Report, 1936 оны 10-р сар, 3).

### 6.1.1 Бие даах чадвар

Бие даах чадвар гэдэг нь өөрийнхөө, гэр бүлийнхээ сүнслэг болон материаллаг хэрэгцээг хангах чадвар, төгс шийдвэр, хүч чармайлт юм. Гишүүд бие даах чадвартай байвал бусдад илүү сайн үйлчлэх, анхаарал халамж тавих чадвартай болдог.

Сүмийн гишүүд сүнслэг болон материаллаг байдлаараа сайн байхын төлөө хичээх үүрэгтэй. Сонгох эрх чөлөөгөөр адислагдсан тул тэд амьдралын замаа өөрсдөө сонгох онцгой боломж, үүрэгтэй бөгөөд асуудлуудаа өөрсдөө шийдэн, бие даах чадвартай болохын төлөө хичээн чармайх ёстой. Гишүүд ингэхдээ Их Эзэнээс илчлэлт авч өөрсдөө хөдөлмөрлөдөг.

Сүмийн гишүүн нь чадах бүхнээ хийгээд ч өдөр тутмынхаа хэрэгцээгээ хангаж чадахгүй байвал юуны өмнө гэр бүлийнхэндээ хандан тусламж хүсэх ёстой. Энэ нь боломжгүй эсвэл хангалтгүй байвал Сүм туслахад бэлэн байдаг.

Гишүүд бие даах чадвартай болж чадах зарим арга замуудын талаар дараах хэсэгт өгүүлсэн болно.

#### Эрүүл мэнд

Оюун санаа, бие бялдартаа анхаарал тавьж байхыг Их Эзэн гишүүдэд зарлиг болгосон юм. Тэд Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагаж, тэжээллэг хоол хүнс хэрэглэн, биеийн тамирын дасгал тогтмол хийж, биеийнхээ жинг хянаж, хангалттай цагаар унтаж байх ёстой. Тэд бие махбод, оюун ухаанд нь хортойгоор нөлөөлөх, донтуулах аливаа буруу зуршлаас зайлсхийх ёстой. Ариун цэвэр, эрүүл ахуйг сайн сахиж, шүд болон эрүүл мэнддээ анхаарал тавьж байх ёстой. Гэр бүлийн гишүүд болон бусад хүмүүстэй сайн харилцаатай байхын төлөө хичээн чармайх ёстой.

#### Боловсрол

Боловсрол нь хүмүүст бие даах чадвараа хөгжүүлэх мэдлэг болон ур чадварыг олгодог. Сүмийн гишүүд судрууд болон бусад сайн номнуудыг уншиж судалдаг байх хэрэгтэй. Унших, бичих, математикийн үндсэн үйлдлүүд хийх чадвараа дээшлүүлэх хэрэгтэй. Тэд боломжийнхоо хэрээр сайн боловсрол, түүний дотор ерөнхий болон тусгай мэргэжлийн боловсрол эзэмших хэрэгтэй. Энэ нь ур чадвараа хөгжүүлэх, тохиромжтой ажил олж хийх болон гэр бүл, Сүм, нийгэмд үнэ цэнэтэй хувь нэмэр оруулахад гишүүдэд туслах болно.

#### Ажил эрхлэлт

Ажил хөдөлмөр бол бие даах чадвар, сайн сайхан амьдралын үндэс суурь юм. Гишүүд өөрийнхөө болон гэр бүлийнхээ хэрэгцээг хангах боломжтой ажил мэргэжил эсвэл хувиараа хөдөлмөр эрхлэхэд бэлтгэж сонголтоо хийхдээ сайн бодож тунгаах хэрэгтэй. Тэд ажлын ур чадвараа сайжруулж, ажилч хичээнгүй, итгэл даах хүмүүс болж, цалин, урамшууллынхаа төлөө шударгаар ажиллах ёстой.

#### Гэр бүлийн нөөц

Гишүүд өөртөө болон гэр бүлийнхээ төлөө өдөр тутмын хэрэглэдэг хүнсний зүйлээс гадна гурван сарын хүнсний нөөцийг бий болгох хэрэгтэй. Хэрэв тухайн улс орны хуулиар зөвшөөрдөг бол илүү урт хугацаанд хэрэглэх үндсэн хэрэглээний хүнсний нөөцийг аажмаар бий болгох хэрэгтэй. Ус бохирдсон буюу тасарсан үед хэрэглэх ундны усыг нөөцлөх ёстой. (*Хэрэгцээтэй бүх зүйлсээ бэлтгэ: Гэр бүлийн нөөц*, 3-ыг үзнэ үү.)

#### Санхүү

Гишүүд санхүүгийн хувьд бие даасан байдалтай болохын тулд аравны нэг болон бусад өргөлүүдийг төлж, шаардлагагүй өр зээлээс зайлсхийж, төсөв зохиож ашиглан, төлөвлөгөөтэйгөөр амьдрах хэрэгтэй. Орлогынхоо тодорхой хувийг тогтмол хадгалах замаар аажимдаа нөөц

хадгаламжтай болох хэрэгтэй. (*Хэрэгцээтэй бүх зүйлсээ бэлтгэ: Гэр бүлийн санхүү,* 3-ыг үзнэ үү.)

#### Сүнслэг хүч чадал

Хүний зуурдын болон мөнхийн сайн сайхан байдалд сүнслэг хүч чадал зайлшгүй чухал юм. Сүмийн гишүүд гэрчлэлээ хөгжүүлж, Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд итгэлтэй байж, Бурханы зарлигуудыг сахин, өдөр бүр залбирч, судрууд, хожмын үеийн бошиглогчдын сургаалыг судлан, Сүмийн цуглаануудад оролцож, Сүмийн дуудлагууддаа үйлчлэн, үүрэгт ажлаа сайн хийснээр сүнслэг байдлаараа өсч хөгждөг.

### 6.1.2 Ядуус болон, тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах ба үйлчлэхэд гишүүдийн тавих хүч чармайлт

Их Эзэн Өөрийн Сүмээр дамжуулан ядуус болон тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах арга замыг бий болгосон юм. Сүмийн гишүүдийг Түүнээс хүлээн авсан зүйлийнхээ төлөө өгөөмрөөр өглөгч байхыг Тэрээр хүсдэг билээ. Мөн "ядуус хийгээд гачигдагсдад зочлон мөн тэднийг [зовлонгоос] хөнгөвчлөхийн тулд туслахыг"(С ба Г 44:6) өөрийн хүмүүсээс хүссэн юм. Тусламж хэрэгтэй хүмүүст хувиараа сайн санааны үйлчлэл үзүүлдэг байхад Сүмийн гишүүдийг урамшуулан дэмждэг билээ. Тэд "сайн зарчимд санаа сэтгэлээ бүрэн зориулж," гуйлгалгүйгээр эсвээс үүрэг даалгавар авалгүйгээр үйлчилдэг байх ёстой (С ба Г 58:26–27-г үзнэ үү).

Их Эзэн Өөрийн хүмүүсийг адисалж, тусламж хэрэгтэй хүмүүст үйлчлэх арга замуудаар тэднийг хангахын тулд мацгийн болон мацгийн өргөлийн хуулийг бий болгосон юм (Исаиа 58:6–12; Малахи 3:8–12-ыг үзнэ үү). Гишүүдээс мацаг барьсан үедээ идээгүй хоёр хоолныхоо үнэтэй тэнцэх мөнгийг мацгийн өргөлд хандивлахыг хүсдэг. Боломжтой бол үүнээс илүүг өгөөмрөөр өгөх хэрэгтэй. Мацгийн хуультай холбоотой адислалуудад Их Эзэнд ойртох, сүнслэг хүч чадал, амьдралын сайн сайхан байдал, өрөвч зөөлөн сэтгэл, үйлчлэх чин хүсэл ордог.

Бусдыг халамжлах зарим боломж Сүмийн дуудлагаар дамжин ирдэг. Гишүүдийн гэр орон, хөршүүд болон нийгэмд тусламж мөн хэрэгтэй байдаг. Гишүүд Сүмийн хүмүүнлэгийн үйлсэд хандив өгснөөр дэлхий дахины өөр өөр шашин шүтлэгтэй ядуус болон гачигдагсдад тусалж чадна.

Их Эзэний арга замаар туслах нь баячуудыг даруусгаж, ядуусыг өргөмжлөн аль алиныг нь ариусгадаг (С ба Г 104:15–18-ыг үзнэ үү). Ерөнхийлөгч Бага Ж.Рубен Кларк ийн сургажээ:

"Халамжийн төлөвлөгөөний урт хугацааны үнэнхүү зорилго бол өгдөг, авдаг Сүмийн гишүүдийн аль алинд нь буй далд сайн чанарыг илрүүлснээр тэдгээрт зөв зан төлөвийг бий болгож, бодгалийнх нь илрээгүй байгаа агуу чанарыг цэцэглүүлэн хөгжүүлэх явдал юм. Эцсийн эцэст энэ нь энэ Сүмийн гишүүн байхын зорилго, учир шалтгаан юм" (гадасны ерөнхийлөгчдийн тусгай цуглаан, 1936 оны 10-р сарын 2).

### 6.1.3 Их Эзэний агуулах

Сүм зарим газарт бишопын агуулах гэж нэрлэгддэг барилгуудыг барьсан билээ. Гишүүд бишопоосоо зөвшөөрөл авч хүнс, хувцас авахаар бишопын агуулахад очиж болно. Гэвч Их Эзэний агуулах гэдэг нь зөвхөн ядууст хүнс, хувцас олгоход ашигладаг барилга бус юм. Үүнд Сүмийн гишүүдийн хандивладаг цаг зав, авьяас чадвар, сэтгэл санааны дэмжлэг, эд материал, мөнгө ордог. Эдгээр зүйлсийг тусламж хэрэгтэй хүмүүст туслахын тулд бишопт өгдөг. Ийм учраас Их Эзэний агуулах тойрог бүрд байдаг. Өргөл болгосон эдгээр зүйлсийг "хүн бүхэн хөршдөө анхаарал тавьж туслахыг эрэлхийлэн, мөн бүх зүйлийг Бурханы алдар суугийн төлөө зориулж, . . . Их Эзэний агуулахад хийх"(С ба Г 82:18–19) ёстой. Бишоп бол Их Эзэний агуулахыг хариуцагч хүн юм.

## 6.2 Тойрог дахь халамжийн удирдлага

### 6.2.1 Бишоп

Бишоп тойргийнхоо хэмжээнд халамжийн ажлыг удирдан зохион байгуулна. Тэрээр ядуусыг эрж олон тэднийг халамжлах тэнгэрлэг үүрэгтэй (С ба Г 84:112-ыг үзнэ үү). Түүний зорилго бол гишүүдийг бие даан амьдралаа авч явах чадвартай болоход нь туслах явдал юм.

Бишопын зөвлөхүүд, Нийгмийн Халамжийн бүлгийн ерөнхийлөгч, дээд пристүүдийн бүлгийн удирдагч, ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч тэрчлэн тойргийн зөвлөлийн бусад гишүүд дээрх үүргээ биелүүлэхэд нь бишопт тусалдаг.

Бишоп гишүүдийн авдаг халамжийн тусламжийн тухай мэдээллийн нууцыг хадгална. Тэрээр тусламж авсан гишүүдийн хувийн нууц болон нэр төрийг анхаарч хамгаална. Тэрээр тойргийн бусад удирдагч нараас тусламж хэрэгтэй гишүүдэд тусалж чадна гэж үзвэл 6.4 дэх удирдамжуудын дагуу мэдээллийг тэдэнтэй хуваалцаж болно.

Бишопын халамжийн үүргүүдийн тухай, түүний дотор мацгийн өргөлийн сангаас

тусламж үзүүлэх тухай дэлгэрэнгүй мэдээллийг *Гарын авлага 1-ийн* 5.2-оос үзнэ үү.

### 6.2.2 Тойргийн зөвлөл

Тойргийн зөвлөлийн хурлууд дээр бишоп халамжийн зарчмуудыг зааж, халамжийн үүргийнх нь талаар зөвлөлийн гишүүдэд заавар өгнө. Зөвлөлийн гишүүд сүнслэг болон материаллаг тусламжийн асуудлуудыг дараах байдлаар авч хэлэлцдэг:

Халамжийн зарчмуудыг тойргийн гишүүд ойлгож, тэдгээрийг баримтлахад туслах арга замуудын тухай тэд хамтран зөвлөлддөг.

Тэд хувийн айлчлал, гэрийн болон айлчлагч багш нарын тайлан, мэдээлэл дээр үндэслэн, тойргийн хэмжээн дэх сүнслэг болон материаллаг хэрэгцээний тухай танилцуулдаг. Мэдээллийг тойргийн нийт зөвлөлтэй хуваалцахад нууц гэж үзвэл удирдагч нар бишопт буюу санваартны гүйцэтгэх хорооны хурал дээр хувийн журмаар танилцуулна (6.2.3-ыг үзнэ үү).

Тэд тойргийн зарим гишүүдийн сүнслэг болон материаллаг хэрэгцээг, түүний дотор урт хугацааны хэрэгцээг шийдвэрлэхэд туслах арга замуудыг төлөвлөдөг. Хөгжлийн бэрхшээлтэй буюу бусад тусгай хэрэгцээтэй гишүүдэд хэрхэн туслахыг шийднэ. Тэд эдгээр мэдээллийг нууц байлгана (6.4-ийг үзнэ үү).

Сүмээс тусламж авсан гишүүдэд ажил хийх эсвэл үйлчлэх боломж олгоход анхаарч энэ тал дээр тэд хүч чармайлт гаргана. Мөн ур дүнтэй хийж болох ажлын жагсаалт гаргаж мөрдөнө. Тухайн бүст Сүмийн халамжийн үйл ажиллагаа байдаг бол Сүмээс тусламж хэрэгтэй хүмүүсийг ажил хийх боломжоор хангаж тэдэнд зориулан сургалт явуулж болно.

Урт ба богино хугацааны туслалцаа хэрэгтэй эсвэл байгалийн гамшгийн үед тусалж чадах авьяас чадвартай тойргийн гишүүдийн жагсаалтыг тэд гаргаж ашиглахын зэрэгцээонцгой байдлын үед арга хэмжээ авах тойргийн энгийн төлөвлөгөөг бичгээр гаргаж хэрэгжүүлнэ (*Гарын авлага 1-ийн* 5.2.11-ийг үзнэ үү). Энэ төлөвлөгөөг гадасны болон бусад байгууллагуудын адил төстэй төлөвлөгөөтэй уялдуулна.

### 6.2.3 Тойргийн санваартны гүйцэтгэх хороо

Шаардлагатай үед тойргийн санваартны гүйцэтгэх хороо халамжийн нууц асуудлуудыг хэлэлцэнэ. Бишоп эдгээр ярилцлагуудад Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийг урьж болно.

### 6.2.4 Дээд пристүүдийн бүлэг, Ахлагч нарын чуулга ба Нийгмийн Халамжийн Бүлэг

Халамжийн ажил нь дээд пристүүдийн бүлэг, ахлагч нарын чуулга, Нийгмийн Халамжийн Бүлгийн гол ажил юм. Дээд пристүүдийн бүлгийн удирдлага, ахлагч нарын чуулга болон Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлууд дээр удирдагчид бие даах чадвар, үйлчлэлийн зарчмуудыг заах болон халамжийн хэрэгцээг шийдвэрлэх арга замуудыг төлөвлөдөг. Бишопын удирдлага дор эдгээр удирдагчид гишүүдэд бие даах чадвартай болох мөн халамжийн урт ба богино хугацааны асуудлуудын шийдлийг олоход нь тусалдаг.

#### Богино хугацааны халамжийн хэрэгцээ

Бишоп тусламж үзүүлэхдээ Мелкизедек санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчдад үүрэг даалгавар өгч болно.

Материаллаг тусламж хэрэгтэй гишүүдтэй уулзуулахаар бишоп ихэвчлэн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийг томилдог. Тэрээр тэдний хэрэгцээг тодорхойлоход тусалж, ямар тусламж үзүүлэх тухай саналаа бишопт хэлнэ. Бишоп түүнээс Бараа материал захиалах бишопын маягтыг бөглөж өгөхийг хүсч, уг маягтыг батлан, гарын үсэг зурна.

Эдгээр гэр бүлүүдийн хэрэгцээг тодорхойлоход Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн гүйцэтгэх үүргийн тухай 9.6.1-д илүү дэлгэрэнгүй тайлбарласан байгаа. Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч болон түүний зөвлөхүүдэд хамаатай богино хугацааны халамжийн үүргийн тухай мэдээллийг 9.6.2 болон 9.6.3-с үзнэ үү.

#### Урт хугацааны халамжийн хэрэгцээ

Эрүүл мэнд, ур чадвар, боловсрол, мэргэжил, ажил, хувийн зуршил, сэтгэл зүйн зэрэг урт хугацааны хүндрэл бэрхшээлүүдээс богино хугацааны олон асуудал үүдэлтэй байдаг. Эдгээр асуудлыг шийдвэрлэхэд гишүүдэд туслах онцгой үүрэг Мелкизедек санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчдад байдаг. Тэдний зорилго бол урт хугацааны асуудлуудыг алгуураар өөрчлөх замаар шийдвэрлэх явдал юм.

Мелкизедек санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид нь хувь хүмүүс болон гэр бүлүүдийн урт хугацааны хэрэгцээний талаар мэдэж авсан үедээ тэдэнд нинжин сэтгэлээр хандана. Тэд тойрог дахь өөрсдийн

бүлгийн нөөц боломжийг ашиглаж, хэрхэн тусалж болох талаар мэдэхийн тулд залбирна.

Хэрхэн туслах талаар илүү сайн ойлгохын тулд Мелкизедек санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид тусламж хэрэгтэй гишүүдтэй ихэвчлэн очиж уулздаг. Тэд гишүүдийн халамжийн хэрэгцээнд нь туслах талаар төлөвлөхөдөө Хэрэгцээ ба эх үүсвэрийн шинжилгээний маягтыг бөглөх буюу маягтад дурдсан зарчмуудыг баримталж болно.

Удирдагчид гишүүдийн урт хугацааны хэрэгцээг шийдвэрлэхэд нь туслахдаа бишоптой зөвлөнө. Зарим тохиолдолд Мелкизедек санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид хамтран ажилладаг.

#### Бишопт тайлагнаж мөн байнгын удирдамж авах нь

Дээд пристүүдийн бүлгийн удирдагч, ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч нар тойрог дахь урт ба богино хугацааны хэрэгцээг шийдвэрлэхдээ авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай бишопт тогтмол тайлагнаж, халамжийн асуудлуудаар тогтмол удирдамж авна.

Хувь хүмүүс, гэр бүлүүд богино хугацааны асуудлуудаа өөрсдөө шийдвэрлэж чадахгүй мөн Мелкизедек санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид шийдвэрлэж чадахгүй бол бишопт даруй мэдэгдэнэ.

Мелкизедек санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид тухайн гишүүдийн гэр бүлийн зохисгүй байдал болон ямар нэг эмзэг асуудлын талаар мэдсэн бол тэднийг бишоп уруу явуулна.

#### Гэрийн болон айлчлагч багш нар

Сүнслэг болоод материаллаг тусламж нь ихэнхдээ гэрийн болон айлчлагч багш нараар эхэлдэг. Гэрийн болон айлчлагч багш нар сар тутмын айлчлалаас гадна тусламж хэрэгтэй хувь хүмүүс болон гэр бүлүүдтэй нөхөрлөж, нинжин сэтгэлээр тусалдаг. Тэд үйлчилдэг хүмүүсийнхээ хэрэгцээний талаар санваартны удирдагчид эсвэл Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагч нартаа илтгэнэ.

#### Чуулга, Нийгмийн Халамжийн Бүлэг болон бусад гишүүдээс үйлчлэл хийхийг хүсэх нь

Мелкизедек санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид ур чадвар, туршлагаараа хүмүүст туслах боломжтой гишүүдээс үйлчлэл хийхийг хүсч болно. Гишүүд хоол хүнсээр туслах, хүүхэд харах эсвэл ажлын байрны талаар олж мэдсэн мэдээллээ хуваалцах зэрэг үйлчлэл үзүүлж болно. Мөн гишүүд эрүүл мэнд, эрүүл ахуй, хоол хүнс, ажил төрөл, боловсрол мэргэжилтэй болох, жижиг бизнес эхлэх эсвэл гэр бүлийн санхүүгээ зохицуулж сурах зэрэг урт хугацааны хэрэгцээнүүдэд туслах арга замаар хангаж болно.

Удирдагч нар тусламж хэрэгтэй хүмүүст туслахыг өөр хүмүүст даалгасны дараа уг тусламж хэрэгтэй хувь хүмүүс эсвэл гэр бүлд үргэлжлүүлэн урам дэм өгч, шаардлагатай бусад зүйлсээр нь туслахын тулд тэдэнтэй холбоотой байна.

Мөн бишоп гишүүдийг бишопын агуулах, Сүмийн ажил эрхлэлтийн алба, Deseret Industries, ХҮГ Гэр бүлийн хөтөлбөр зэрэг Сүмийн халамжийн төвүүд рүү явуулсан үед удирдагчид нь бишопуудыг дэмжин тусална. Удирдагч нар мөн гишүүдийг нийгмийн болон төр засгийн байгууллагуудаас тусламж авахад нь тусалж болно.

### 6.2.5 Тойргийн халамжийн зохицуулагчид

Халамжийн зохицуулагчид нь бишопын зөвлөл, Мелкизедек санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчдад халамжийн үүргээ гүйцэтгэхэд нь туслах хүч болж үйлчилнэ.

Бишопын зөвлөл тохиромжтой ажил олж хийхэд нь гишүүдэд туслахын тулд ажил эрхлэлтийн зохицуулагчийг дуудаж болно. Бишопын зөвлөл нь боловсрол, сургалт, хоол хүнс, эрүүл ахуй, гэр бүлийн нөөц, эрүүл мэнд, гэр бүлийн санхүү, Боловсролын Тасралтгүй Сангийн талаар тусламж хэрэгтэй гишүүдэд туслахын тулд халамжийн бусад зохицуулагчдыг дуудаж болно.

## 6.3 Гадасны халамжийн удирдлага

### 6.3.1 Гадасны ерөнхийлөгч

Гадасны ерөнхийлөгч нь гадасныхаа халамжийн ажилд хяналт тавина. Гадасны ерөнхийлөгчийн халамжийн үүргийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл *Гарын авлага 1-ийн* 5.1-д байдаг.

### 6.3.2 Гадасны зөвлөл

Удирдагчид гадасны зөвлөлийн хурлаар сүнслэг болон материаллаг халамжийн асуудлуудыг дараах байдлаар авч хэлэлцэнэ:

Гадасны хэмжээн дэх халамжийн асуудлуудыг тодорхойлж, шийдвэрлэх арга замуудыг эрж хайна. Гэвч тэд тойргийн халамжийн

асуудлуудыг шийдвэрлэх үүргийг өөрсөд дээрээ авах ёсгүй.

Тэд гадас, тойргийн удирдагчдад халамжийн зарчмуудыг заах арга замуудыг төлөвлөж, халамжийн асуудлыг шийдвэрлэхэд тойргийн удирдагч нарыг гадасныхаа нөөц хүч болж үйлчилж чадах хүмүүсийг олж тогтоох арга замуудыг хэлэлцэнэ.

Тэд онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах гадасны энгийн төлөвлөгөөг бичгээр гаргаж, хэрэгжүүлнэ (*Гарын авлага 1-ийн* 5.1.3-ыг үзнэ үү). Энэ төлөвлөгөө нь уг зөвлөлийн бусад гадас болон улсын байгууллагуудын адил төстэй төлөвлөгөөтэй уялдсан байна.

Тэд халамжийн үйл ажиллагаануудыг төлөвлөхдөө тойргийн удирдагчдад дарамт болохгүй байхад анхаарч, гадасны халамжийн ажил үүргийг хэрэгжүүлэх арга замуудыг төлөвлөнө.

Тэд Далын эсвэл Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн томилсон үед халамжийн үйл ажиллагаанд удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлнэ.

Хэрэв бишоп явуулын эсвэл гэр оронгүй хүмүүст туслах үүрэгт томилогдсон бол гадасны зөвлөлийн гишүүд гадасны нөөц боломжуудаас уг бишопт хэрхэн туслах талаар шийдвэрлэнэ.

### 6.3.3 Гадасны халамжийн зохицуулагчид

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн буюу томилогдсон зөвлөх гадасны ажил эрхлэлтийн мэргэжилтэн болон халамжийн бусад зохицуулагчдыг дуудаж болно. Гадасны эдгээр зохицуулагч бишоп, тойргийн бусад удирдагчдад туслах хүч болж үйлчилдэг. Эдгээр зохицуулагч 6.2.5-д жагсаасан халамжийн асуудлуудад тусалж болно.

## 6.4 Нууц хадгалалт

Бишоп болон тойргийн бусад удирдагчид гишүүдийн халамжийн хэрэгцээний тухай мэдэж, тусламж олгосон тохиолдолд энэхүү мэдээллийг нууц байлгаж, тусламж авсан гишүүдийн хувийн нууц болон тэдний нэр төрийг хамгаална. Мөн тусламж хэрэгтэй байгаа гишүүдийг эвгүй байдалд оруулахгүй байхыг анхаарна.

Зарим үед хувь хүн эсвэл аль нэг гэр бүлийн халамжийн хэрэгцээний тухай тойргийн нийт зөвлөл мөн тойргийн зарим гишүүдэд мэдэгдэх нь тэдэнд туслахад хэрэгтэй байж болох юм. Жишээ нь нэг гишүүн ажилгүй байгаа эсвэл илүү сайн ажил хайж байгаа бол бусад хүмүүс ажил түргэн олоход уг гишүүнд тусалж болно. Энэ тохиолдолд бишоп болон бусад удирдагч тусламж хэрэгтэй гишүүдээс тэдний нөхцөл байдлын тухай мэдээллийг бусадтай хуваалцах зөвшөөрлийг хүснэ.

Удирдагчид хүмүүст туслахыг бусдаас хүсэхдээ зөвхөн энэ үүргийг биелүүлэхэд шаардлагатай мэдээллийг л хуваалцана. Бас нууц хадгалалтын тухай тэдэнд хэлж өгнө.

# 7. Мелкизедек санваар

7.1 **Мелкизедек санваарын тодорхойлолт ба зорилго. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 42**
7.1.1 Мелкизедек санваарын албууд ба үүргүүд. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .42
7.1.2 Мелкизедек санваартны чуулга. . . . . . . . . .42

7.2 **Гадасны Мелкизедек санваартны удирдлага . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 42**
7.2.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл. . . . . . . . .42
7.2.2 Дээд зөвлөлийн гишүүд. . . . . . . . . . . . . . . . .43

7.3 **Тойргийн Мелкизедек санваартны удирдлага . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 43**
7.3.1 Бишопын зөвлөл. . . . . . . . . . . . . . . . . . . . . . .43
7.3.2 Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл ба Дээд пристүүдийн бүлгийн удирдлага . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .43
7.3.3 Ахлагч нарын чуулга, Дээд пристүүдийн бүлгийн нарийн бичиг нар ба нарийн бичгийн туслахууд . . . . . . . . . . . . . . . . . . . .44
7.3.4 Ахлагч нарын чуулга ба Дээд пристүүдийн бүлгийн багш нар . . . . . . . . .45

7.4 **Гэрийн багшлалт. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 45**
7.4.1 Гэрийн багш нарын үүрэг . . . . . . . . . . . . . . .45
7.4.2 Гэрийн багшлалтыг зохион байгуулах нь. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .45
7.4.3 Гэрийн багшлалтыг орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх нь. . . . . . .46
7.4.4 Гэрийн багшлалтын тайлан . . . . . . . . . . . . .47

7.5 **Халамж . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 47**

7.6 **Ахлагч болохуйц ах нар . . . . . . . . . . . . . . . . . 47**
7.6.1 Ахлагч болохуйц ах нарын үүрэг . . . . . . . .47
7.6.2 Ахлагч болохуйц ах нарт Мелкизедек санваар авахаар бэлтгэхэд нь туслах. . . . . .47

7.7 **Удирдлагын хурлууд . . . . . . . . . . . . . . . . . . . 48**
7.7.1 Тойргийн санваартны гүйцэтгэх хорооны болон тойргийн зөвлөлийн хурал . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .48
7.7.2 Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл болон Дээд пристүүдийн бүлгийн удирдлагын хурал. . . . . . . . . . . . . . . . . . . . . .48
7.7.3 Гадасны санваартны удирдлагын хурал . .48

7.8 **Чуулга болон бүлгийн хурлууд . . . . . . . . . . . 48**
7.8.1 Санваартнуудын ням гарагийн хурал . . . .48
7.8.2 Гадасны дээд пристүүдийн чуулгын хурал . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .49

7.9 **Ёслолууд ба адислалуудыг хэрхэн гүйцэтгэхийг заах нь . . . . . . . . . . . . . . . . . . . 49**

7.10 **Нэмэлт удирдамж ба журмууд . . . . . . . . . . . 50**
7.10.1 Тусгай хэрэгцээтэй ах нар. . . . . . . . . . . . . . .50
7.10.2 Хүн нас барсан үед тусламж үзүүлэх нь. . .50
7.10.3 Ариун сүмийн хувцас ба гарментийн тухай заавар . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .50
7.10.4 Үйл ажиллагаануудыг санхүүжүүлэх нь . .50

# 7. Мелкизедек санваар

## 7.1 Мелкизедек санваарын тодорхойлолт ба зорилго

Санваар гэдэг нь Бурханы эрх мэдэл ба хүч юм. Санваарыг Сүмийн зохистой эрэгтэй гишүүдэд олгодог. Санваарын түлхүүрүүдийг эзэмшдэг хүмүүс сайн мэдээний ёслолууд, сайн мэдээний номлол болон дэлхий дээрх Бурханы хаант улсын засаглалыг удирдан зохион байгуулдаг.

Мелкизедек санваартнууд "сүмийн бүх сүнсний адислалуудын түлхүүрүүдийг"(С ба Г 107:18) эзэмшдэг.

Санваарын зорилго, санваарын түлхүүрүүдийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг 2-р бүлэг-с үзнэ үү.

### 7.1.1 Мелкизедек санваарын албууд ба үүргүүд

Мелкизедек санваар нь ахлагч, дээд прист, патриарх, Дал ба Төлөөлөгч гэсэн албуудтай. Санваарын алба бүр нь үйлчлэлийн эрх, үүрэг түүний дотор санваарын ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдэлтэй байдаг. Энэ бүлэг ахлагч нар болон дээд пристүүдийн удирдагчдад зориулсан мэдээллийг агуулсан болно. Ахлагч болон дээд пристийн албанд томилох тухай мэдээллийг 20.7-с үзнэ үү.

#### Ахлагч

Зохистой ах нар 18 нас хүрмэгц Мелкизедек санваар авч, ахлагчийн албанд томилогдож болно. Ахлагч нарын эрх, үүргүүдийг Сургаал ба Гэрээ 20:38–45; 42:44; 46:2; 107:11–12-т илчилсэн байдаг. Ахлагч нар дикон, багш болон пристийн эрх мэдлийг давхар эзэмшдэг.

#### Дээд прист

Ах нар гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, дээд зөвлөл, бишопын зөвлөлд дуудагдсан үед эсвэл гадасны ерөнхийлөгч шийдсэн тохиолдолд дээд пристээр томилогддог. Дээд пристүүдийн эрх, үүрэг бол ахлагч нарыг тэргүүлж, тэдний адил эрх мэдлийг эзэмших явдал юм (С ба Г 107:10-ыг үзнэ үү).

Дүүрэгт харъяалагддаг ах нар дээд пристийн албанд томилогддоггүй.

### 7.1.2 Мелкизедек санваартны чуулга

Санваартны чуулга бол санваарын ижил албатай ах нарын бүлэг юм. Чуулгуудын үндсэн зорилго бол бусдад үйлчлэх, ах нарын дунд эв нэгдлийг бий болгох, сургаал, зарчим, үүргийг гишүүдэд заах явдал юм.

Тойрог бүр нэг эсвэл түүнээс олон ахлагч нарын чуулгатай байна. Чуулга бүр 96 хүртэл ахлагчтай байна (С ба Г 107:89-ийг үзнэ үү).

Гадас бүр дээд пристүүдийн нэг чуулгатай байна. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл бол энэ чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл юм. Тойрог бүрд дээд пристүүд бүлэг болж зохион байгуулагддаг.

Патриархууд чуулга болон зохион байгуулагддаггүй. Төлөөлөгчид болон Далууд Сүмийн төвшинд чуулга болж зохион байгуулагддаг.

## 7.2 Гадасны Мелкизедек санваартны удирдлага

### 7.2.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл

Гадасны ерөнхийлөгч бол гадасны тэргүүлэх дээд прист юм. Тэр болон түүний зөвлөхүүд гадасны дээд пристүүдийн чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийг бүрдүүлдэг. Тэд дээд пристүүдийн чуулгын хурлууд дээр заавар өгдөг. Тэд заавар, зөвлөгөө өгөхийн тулд дээд пристүүдийн бүлгийн болон ахлагч нарын чуулгын хурлуудад оролцдог.

Гадасны ерөнхийлөгч нь Мелкизедек санваар олголт, ахлагч, дээд пристийн албуудад томилох томилолтод хяналт тавина (*Гарын авлага 1-ийн* 16.7.1-ийг үзнэ үү).

Гадасны ерөнхийлөгч тойрог бүрд нэг ахлагчийг ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчөөр дууддаг. Дээд пристүүдийн бүлэгтэй гадас бүрд гадасны ерөнхийлөгч буюу гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн томилогдсон зөвлөх нэг дээд пристийг дээд пристүүдийн бүлгийн удирдагчаар дууддаг. Гадасны ерөнхийлөгч ахлагч нарын чуулгын шинэ ерөнхийлөгч эсвэл дээд пристүүдийн бүлгийн удирдагчийг дуудахаас өмнө тойргийнх нь бишоптой зөвлөлдөнө. Бишоп дуудах хүний нэрийг дэвшүүлж болно.

Гадасны ерөнхийлөгч, томилогдсон зөвлөх эсвэл дээд зөвлөлийн гишүүн нь ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөх болон дээд пристүүдийн бүлгийн удирдагчийн туслахыг дуудна. Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч болон дээд пристүүдийн бүлгийн удирдагч нар бишоптой зөвлөлдсөний үндсэн дээр зөвлөх, туслах нараа санал болгоно.

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд болон дээд пристүүдийн бүлгийн удирдлагыг дуудах бүх саналыг гадасны ерөнхийлөгчийн зөвлөл болон дээд зөвлөл батална.

Чуулгын болон бүлгийн шинэ удирдагчид дуудагдахад гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн эсвэл дээд зөвлөлийн гишүүн тэднийг чуулгын болон бүлгийн гишүүдээр дэмжүүлэхээр танилцуулна.

Ахлагч дээд пристүүдийн бүлгийн удирдлагад үйлчлэхээр дуудагдвал түүнийг адислахаас өмнө дээд пристээр томилно.

Гадасны ерөнхийлөгч ахлагч нарын чуулгын шинэ ерөнхийлөгчийг адисалж, дуудлагынх нь түлхүүрүүдийг өгнө. Дээд пристүүдийн бүлгийн удирдагч нь түлхүүр эзэмшдэггүй ба гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнээр адислуулна. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн эсвэл дээд зөвлөлийн гишүүн нь ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөхүүд болон дээд пристүүдийн бүлгийн удирдагчийн туслахуудыг адисална.

Чуулгын болон бүлгийн шинэ удирдагчдыг дэмжүүлэн батлуулсны дараа гадасны ерөнхийлөгчийн эсвэл бишопын зөвлөлийн гишүүн эдгээр дуудлагыг ариун ёслолын цуглаан дээр зарлана. Гэхдээ ариун ёслолын цуглаан дээр гишүүдээр дэмжүүлэх шаардлагагүй.

Салбар, номлол дахь ахлагч нарын чуулгын дуудлагуудын тухай мэдээллийг 19-р бүлгийн Дуудлагуудын жагсаалт-аас үзнэ үү.

### 7.2.2 Дээд зөвлөлийн гишүүд

Дээд зөвлөлийн гишүүд нь гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор гадсан дахь Сүмийн ажилд хяналт тавихад тусалдаг. Ахлагч нарын чуулга, дээд пристүүдийн бүлгийн талаарх тэдний үүргүүдийг 15.3.1-д өгүүлсэн байгаа.

## 7.3 Тойргийн Мелкизедек санваартны удирдлага

Энэ хэсэгт хувь хүмүүс болон гэр бүлүүдийг бэхжүүлэх арга замаар ахлагч нарын чуулга ба дээд пристүүдийн бүлгийн ажлыг удирдах талаар онцлон өгүүлнэ. Мелкизедек санваартны удирдагчид 3-р хэсэгт өгүүлсэн удирдлагын ерөнхий зарчмуудыг байнга уншиж судлах хэрэгтэй. Эдгээр зарчимд сүнслэг байдлын хувьд бэлтгэх, хурал цуглаануудад оролцох, бусдад үйлчлэх, Есүс Христийн сайн мэдээг заах орно.

### 7.3.1 Бишопын зөвлөл

Бишоп бол тойргийн тэргүүлэх дээд прист юм. Бишоп болон түүний зөвлөхүүд нь чуулга, бүлгийн гишүүдэд анхаарал тавих, чуулга, бүлгийг бэхжүүлэх түүнчлэн санваарын ажилд анхаарал тавихын тулд ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, дээд пристүүдийн бүлгийн удирдагчтай нягт холбоотой ажилладаг.

Бишоп нь ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, дээд пристүүдийн бүлгийн удирдагчтай тогтмол уулзаж байна. Тэрээр энэ хоёр удирдагчаас ажил үүргийнх тайлан, түүний дотор чуулга, бүлгийн хэмжээн дэх гэрийн багшлалтын тайланг нь авч байна. Тэрээр бас тэдэнд заавар өгч, дуудлагаа эрхэмлэн биелүүлэхэд нь сүнслэгээр нөлөөлж, зорилго дэвшүүлэн, түүнийгээ хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажиллахад нь тусалдаг.

### 7.3.2 Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл ба Дээд пристүүдийн бүлгийн удирдлага

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл, дээд пристүүдийн бүлгийн удирдлага нь чуулга, бүлгийн гишүүдийг тэргүүлж, тэдэнтэй хамт хурал цуглаанд суун, тэдэнд заадаг (С ба Г 107:89-ийг үзнэ үү). Тэд тойрог дахь авралын ажилд ахиц дэвшил гаргах чуулгын болон бүлгийн гишүүдийн хүч чармайлтыг удирдан чиглүүлнэ (5-р бүлэг-г үзнэ үү). Тэд бишоп, гадасны ерөнхийлөгчийн болон дээд зөвлөлийн томилогдсон гишүүдээс заавар авдаг.

#### Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч ба Дээд пристүүдийн бүлгийн удирдагч

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч ба дээд пристүүдийн бүлгийн удирдагч нар дараах үүргүүдтэй:

Тэд тойргийн санваартны гүйцэтгэх хороо болон тойргийн зөвлөлийн гишүүнээр үйлчилдэг. Тэд энэ хороо буюу зөвлөлийн гишүүний хувиар хувь хүмүүс болон гэр бүлүүдэд итгэлийг хөгжүүлж, тэднийг хүчирхэгжүүлэх ажилд оролцдог (4-р бүлэг-г үзнэ үү). Дээд пристүүдийн бүлгийн удирдагч тойрог дахь ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд тойргийн зөвлөлийн хамт дэмжлэг үзүүлнэ (5.4.3-ыг үзнэ үү). Дээд пристүүдийн бүлгийн удирдагч байхгүй газарт ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч эсвэл томилогдсон нэг Мелкизедек санваартан энэ үүргийг гүйцэтгэнэ.

Тэд энэ гарын авлагыг ашиглан чуулга, бүлгийн бусад удирдагчид болон багш нарт ажил үүргийг нь заана.

Тэд бишоптой зөвлөлдсөний үндсэн дээр ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөхүүд эсвэл дээд пристүүдийн бүлгийн удирдагчийн туслахуудаар дуудагдах ах нарыг нэр дэвшүүлнэ. Тэд нарийн бичиг болон багш нараар дуудагдах ах нарыг бишопт санал болгодог. Тэд эдгээр нэрсийг дэвшүүлэхдээ 19.1.1 болон 19.1.2 дахь удирдамжуудыг баримтална.

Тэд тухайн чуулга, бүлгийн тайлан бүртгэл, төсөв, санхүүд хяналт тавина. Энэ үүргийг биелүүлэхэд чуулгын эсвэл бүлгийн нарийн бичиг тусална.

#### Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч ба зөвлөхүүд, Дээд пристүүдийн удирдагч ба туслахууд

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл болон дээд пристүүдийн бүлгийн удирдлага дараах үүргүүдтэй. Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, дээд пристүүдийн бүлгийн удирдагч нар эдгээр үүрэгт ажлын заримыг хариуцуулахын тулд зөвлөх ба туслахуудыг дууддаг.

Чуулга, бүлгийн гишүүдийг санваартны болон ялангуяа нөхөр ба эцгийн үүргээ биелүүлэхэд нь дэмжинэ. Чуулгын болон бүлгийн удирдагчид энэ үүргийг чуулга, бүлгийн хурлаар мөн гишүүдтэй уулзаж ярилцлага хийх ба гэрээр нь айлчлах замаар гүйцэтгэдэг.

Тэд гэрийн багшлалтыг зохион байгуулж хяналт тавина.

Ахлагч нарын чуулга, дээд пристүүдийн бүлэгт сайн мэдээнээс суралцах болон заах аргыг сайжруулах талаар хийж байгаа ажилд хяналт тавина. Тэд энэ ажилд 5.5.3 болон 5.5.4 дэх зарчмуудыг баримтална.

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн болон дээд пристүүдийн бүлгийн удирдлагын хурлуудыг хийнэ.

Тэд бишопын удирдлага дор чуулга, бүлэг дэх халамжийн хэрэгцээг шийдвэрлэх арга замуудыг төлөвлөнө (7.5 болон бүлэг 6-г үзнэ үү).

Боломжтой бол жилд нэг удаа чуулга, бүлгийн гишүүдтэй уулзаж эсвэл гэрээр нь айлчилж ярилцлага хийнэ.

Чуулга, бүлгийн ажлыг явуулж, тойргийн зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхийн тулд чуулга, бүлгийн дотор хороодыг зохион байгуулж болно.

Мелкизедек санваар авахаар бэлтгэхэд нь тэд ахлагч болохуйц ах нарт тусалдаг (7.6-г үзнэ үү).

Бишопын зөвшөөрлөөр чуулга, бүлгийн гишүүдэд зориулсан зарим үйл ажиллагааг төлөвлөж болно. Эдгээр үйл ажиллагаанд чуулга, бүлгийн гишүүдийн гэр бүл мөн тэдний гэрийн багшаар очиж уулздаг ганц бие эгч нар оролцож болно. Үйл ажиллагаанууд нь 13-р бүлэг дэх удирдамжийн дагуу байх бөгөөд тойргийн зөвлөлтэй зөвшилдсөн байх ёстой.

Бишоп томилсон үед тэд 18 настай залуу эрэгтэйчүүдийг Мелкизедек санваар авахад бэлтгэхэд нь мөн пристийн чуулгаас ахлагч нарын чуулгад амжилттай шилжихэд нь Залуу эрэгтэйчүүдийн удирдагчид болон эцэг эхчүүдтэй хамтран ажиллана.

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч зөвлөхүүдийнхээ нэгийг тойрог дахь ганц бие залуу насанд хүрэгчдийн ажлыг зохицуулахаар томилно. Хэрэв тойрогт ганц бие залуу насанд хүрэгчдийн хороо байдаг бол энэ зөвлөх тус хороонд үйлчилнэ. (16.3.3;16.3.4-ийг үзнэ үү.)

### 7.3.3 Ахлагч нарын чуулга, Дээд пристүүдийн бүлгийн нарийн бичиг нар ба нарийн бичгийн туслахууд

Бишопын зөвшөөрлөөр ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч эсвэл түүний нэг зөвлөхийг чуулгын нарийн бичгээр дуудаж, адисална. Үүнтэй адил дээд пристүүдийн бүлгийн удирдагч эсвэл туслахуудын нэг нь нэг дээд пристийг дээд пристүүдийн бүлгийн нарийн бичгээр дуудаж, адисална.

Чуулга, бүлгийн нарийн бичгүүд дараах үүргүүдтэй:

Тэд ерөнхийлөгчийн зөвлөлийн эсвэл бүлгийн удирдлагын хурлуудын хөтөлбөрийг бэлтгэхэд чуулга, бүлгийн удирдагчидтай зөвлөлдөнө. Тэд дээрх хурал цуглаануудад оролцож, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавина.

Сар бүр тэд ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч болон дээд пристүүдийн бүлгийн удирдагч нарын бишопт өгөх гэрийн багшлалтын тайланг гаргана. Мөн улиралд нэг удаа ирцийн мэдээллийг ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч эсвэл дээд пристүүдийн бүлгийн удирдагчтай хамтран хянаж, тойргийн гүйцэтгэх нарийн бичигт өгнө.

Нарийн бичгүүд чуулга эсвэл бүлэг нь төсөвтэй үйл ажиллагаанууд төлөвлөдөг бол жил тутмын төсөв боловсруулж, зардлын тайлан гаргахад удирдагч нарт тусална.

Ахлагч нарын чуулга эсвэл дээд пристүүдийн бүлгийн удирдагч нар дээрх ажил үүргүүдийг биелүүлэхдээ нарийн бичгийн туслахуудыг бишопын зөвшөөрлөөр дуудаж,

адисалж болно. Ахлагч болохуйц ах нар нарийн бичгийн туслахаар дуудагдаж болно.

### 7.3.4 Ахлагч нарын чуулга ба Дээд пристүүдийн бүлгийн багш нар

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч буюу түүний зөвлөхүүдийн нэг нь нэг буюу түүнээс олон ахлагчийг ахлагч нарын чуулгын багшаар дуудаж, адисалж болно. Үүнтэй адил дээд пристүүдийн бүлгийн удирдагч эсвэл түүний туслахуудын нэг нь нэг буюу түүнээс олон дээд пристийг дээд пристүүдийн багшаар дуудаж, адисалж болно.

Чуулга, бүлгийн удирдагчид санваартны хурлын үеэр хичээл заах багш нарыг томилно. Багш нар 5.5.4-т өгүүлсэн зарчмуудыг баримтална.

## 7.4 Гэрийн багшлалт

Чуулга, бүлгийн удирдагч нар бишопын удирдлага дор гэрийн багшлалтад хяналт тавина. Тэд гэрийн багш нарт үүрэгт ажлынх нь талаар заавар өгч, энэхүү үүргээ биелүүлэхэд нь урам зориг өгдөг.

Гэрийн багшлалт бол багш, прист, Мелкизедек санваартнуудын санваарын үүрэг хариуцлага юм. Иймээс гэрийн багш нарыг санваартны удирдагчид томилдог. Тэднийг дуудаж, дэмжүүлж адисалдаггүй.

### 7.4.1 Гэрийн багш нарын үүрэг

Гэрийн багшлалт бол Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдээ адисалдаг нэг арга зам нь юм. Гэрийн багш нар "гишүүн бүрийн гэрээр айлчлан, мөн чанга дуугаар болон чимээгүй залбирахыг мөн гэр бүлийн бүх үүргээ гүйцэтгэхийг ухуулдаг" (С ба Г 20:51). Тэд гэр бүлүүд болон хувь хүмүүсийг "харж хандах . . .мөн тэдэнтэй хамт байж тэднийг бэхжүүлэхийн" (С ба Г 20:53) тулд томилогддог. Тэд "сануулж, тайлбарлаж, ухуулж мөн заaж Христэд ирэхэд бүхнийг урьдаг" (С ба Г 20:59).

Боломжтой газруудад гэрийн багш нар сард нэг удаа гишүүдийн гэрээр очиж уулздаг байх ёстой. Гэрийн багш нар хариуцсан гэр бүлүүдээ харж хандан, бэхжүүлэх үр өгөөжтэй бусад арга замуудыг олж болно. Жишээ нь хариуцсан гэр бүлүүдэд үйлчлэл үзүүлж, гэр бүлийн гишүүдтэй э-мэйл эсвэл утсаар холбоо барьж болно.

Гэрийн багш нар Их Эзэнийг, бишопыг мөн чуулга болон бүлгийн удирдагчдыг төлөөлдөг. Тэд гишүүдэд туслах чухал хүч болж чадна. Тэд тухайн гэр бүлийн хэрэгцээ болон уг хэрэгцээг шийдвэрлэх хамгийн үр өгөөжтэй арга замуудын талаар өрхийн тэргүүнтэй зөвлөлдөж болно.

Гэрийн багш нар уг гэр бүлийн гишүүдийн сонирхол, хэрэгцээ түүнчлэн тэдний амьдрал дахь онцгой чухал үйл явдлуудыг мэддэг байх хэрэгтэй.

Шаардлагатай үед гэрийн багш нар хүүхдүүдийг нь адислагдаж, баптисм хүртэн, гишүүнээр батлуулахад эцэг эхчүүдэд тусална. Бас хөвгүүдийг нь Aароны болон Мелкизедек санваар авч, зохих насандаа санваарын албанд томилогдоход эцэг эхчүүдэд тусалж болно.

Ажилгүй болох, өвдөх, ганцаардах, нүүх эсвэл бусад хэрэгцээ гишүүдэд тохиолдсон үед гэрийн багш нар тусална.

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт итгэх итгэлээ бэхжүүлэхэд нь гэрийн багш нар гишүүдэд тусалж, ариун гэрээнүүд хийж сахихад тэднийг дэмждэг. Энэхүү үйлчлэл нь шинэ болон идэвх султай гишүүдэд онцгой чухал юм.

Гэрийн багш нар хувь хүмүүс болон гэр бүлүүдийн тохиромжтой үед нь цаг товлон очиж заадаг. Тэд очиж байгаа гишүүдийнхээ зочид нь гэдгээ санах ёстой.

Тийнхүү очих болгондоо төлөвлөсөн зорилго дээрээ анхаарал төвлөрүүлнэ. Хамтрагчид айлд очихоосоо өмнө хамтдаа залбирах хэрэгтэй. Тэд очиж заах хүмүүсээ бэхжүүлэх арга замуудыг ярилцана. Тэд энэ ярилцлага болон Ариун Сүнсний удирдамж дээр тулгуурлан ихэвчлэн судруудаас мөн *Ensign* болон *Лиахона* сэтгүүлүүдэд нийтлэгдсэн Тэргүүн Зөвлөлийн захиасыг хуваалцдаг. Мөн бишоп болон бусад удирдагчдын захиасаас хуваалцаж болно. Өрхийн тэргүүн тусгай захиас авахыг хүсч болно. Гэрийн багш нар зочлох үеэрээ залбирал хийдэг.

Гэрийн багш нар гэрээр нь очиж заадаг гишүүдийн сүнслэг болон материаллаг байдлын тухай чуулгын эсвэл бүлгийн удирдагчдад сар бүр тайлагнадаг. Тухайн гишүүнд тулгамдсан асуудал бий болсон бол гэрийн багш нар удирдагчдад тэр даруй мэдэгдэнэ.

### 7.4.2 Гэрийн багшлалтыг зохион байгуулах нь

Өрхийн тэргүүн нь ахлагч бол гэрийн багш нар нь ихэвчлэн ахлагч нарын чуулгын гишүүд байдаг. Өрхийн тэргүүн нь дээд прист бол гэрийн багш нар нь ихэвчлэн дээд пристийн бүлгийн гишүүд байдаг. Тухайн гэр бүлийг Мелкизедек санваартан тэргүүлдэггүй бол гэрийн багш нар нь ахлагч нарын чуулгаас эсвэл дээд пристийн бүлгээс байх талаар бишопын зөвлөл шийднэ. Бишопын зөвлөл энэ шийдвэрийг

гаргахдаа санваартны гүйцэтгэх хороо болон тойргийн зөвлөлтэй зөвлөлдөж болно.

Чуулга, бүлгийн удирдагчид гэрийн багш нарын ажлыг зохион байгуулахдаа хувь хүмүүс, гэр бүлүүдийн хэрэгцээг залбирч хэлэлцэнэ. Гэрийн багш нар эдгээр гишүүдийг харж хандан, бэхжүүлэх арга замуудыг удирдагчид хэлэлцэхдээ шаардлагатай бол санваартны гүйцэтгэх хороо болон тойргийн зөвлөлтэй зөвлөлдөнө. Бас гишүүдийн гэр хүртэлх зай, ямар унаагаар очих, аюулгүй байдал зэрэг хүчин зүйлсийг авч хэлэлцдэг.

Удирдагчид эдгээр ярилцлага дээр тулгуурлан боломжтой бол өрх гэр бүрд гэрийн багшаар хамтрагчдийг хоёр хоёроор нь томилно. Тэд хамтрагчдыг томилох болон гэрийн багш нарт гэр бүлийг даалгах бүрдээ бишопын зөвшөөрлийг авна.

Чуулга болон бүлгийн удирдагч нар сайн багш нарт гэрийн багш хамгийн их хэрэгтэй байгаа гишүүдийг даалгана. Удирдагч нар гэрийн багш нарыг томилохдоо тэднийг хүлээн авахуйц шинэ болон идэвх султай гишүүд, ганц бие эцэг эхчүүд, бэлэвсэн хүмүүс зэрэг гэрийн багш хамгийн их хэрэгтэй байж болох хүмүүст онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Ямар нэг бэрхшээлтэй тулгарсан залуу эрэгтэй эсвэл залуу эмэгтэй амьдардаг гэр бүлд залуучуудын удирдагчийг томилох нь тустай байдаг. Хөрвөгчдийг баптисм хүртэхээс нь өмнө тэдэнд гэрийн багш томилох ёстой.

Бишопын зөвлөлийн гишүүн эхлээд ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, дээд пристүүдийн бүлгийн удирдагч, Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч нартай зөвлөлдсөний дараа багш нар болон пристүүдэд гэрийн багшаар үйлчлэх үүрэг өгнө. Тэднийг Мелкиседек санваартнуудтай хамтрагч болгон томилно.

Аароны санваартнууд гэрийн багшаар очдог гишүүдээ харж хандах ажилд хамтрагчтайгаа оролцоно. Энэ ажилд заах цаг товлох, захиас хуваалцах, үйлчлэл үзүүлэх зэрэг ордог. Энэ нь тэдэнд санваараа ашиглаж сурах, түүний дотор номлолд бэлтгэхэд нь тусална (С ба Г 84:106–7-г үзнэ үү).

Ганц бие залуу насанд хүрэгчдийн тойргийн ахлагч нарын чуулгын удирдагчид тойргийнхоо гишүүн бүрд гэрийн багш нарыг томилно. Нэг өрөөнд хамт амьдардаг ганц бие гишүүдэд хамтдад нь зааж болно. Гэвч гэрийн багш нар хүн бүрд тусад нь үйлчлэхэд анхаарал төвлөрүүлж, хүн нэг бүрийн талаар тусад нь тайлагнах ёстой.

Мелкиседек санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид онцгой тохиолдолд нөхөр, эхнэр хоёрыг тэдний очих газарт бишопын зөвшөөрлөөр хамтрагч болгон томилж болно. Гэр бүлийн хос иймхүү гэрийн болон айлчлагч багшийн үүргийг нэг зэрэг гүйцэтгэсэн тухайгаа илтгэнэ. Залуу эцэг эхчүүдэд энэ ажил үүргийг ихэвчлэн өгдөггүй. Учир нь энэ нь тэднийг хүүхдүүдтэйгээ ажиллахаас хөндийрүүлдэг.

### 7.4.3 Гэрийн багшлалтыг орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх нь

Зарим газарт айл болгонд сар бүр очиж заах нь идэвхтэй санваартнуудын тоо хангалтгүй эсвэл бусад бэрхшээлийн улмаас боломжгүй байж болох юм. Энэ тохиолдолд удирдагчид шинэ гишүүд болон Сүмд эргэж ирэх урилгыг хүлээж авах хамгийн их магадлалтай гишүүд мөн тулгамдсан чухал хэрэгцээ бүхий гишүүдийг хамгийн түрүүнд анхаарах хэрэгтэй.

Удирдагчид нь байгаа нөөц боломжоо ашиглан гишүүн бүрийг харж хандан, хүчирхэгжүүлэхийн төлөө чадах бүхнээ хийдэг. Гэрийн багшлалтад хийх аливаа өөрчлөлтийг зөвхөн түр зуур хийж болно.

Гэрийн багшлалтад оруулж болох зарим өөрчлөлтийн санаануудыг доор дурдсан болно.

Мелкиседек санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид тодорхой гэр бүлүүдэд зөвхөн гэрийн багш нарыг эсвэл зөвхөн айлчлагч багш нарыг бишопын зөвшөөрлөөр түр хугацаагаар томилж болно. Зарим тохиолдолд удирдагчид тухайн гэр бүлд очиж заах гэрийн багш нарыг нэг сар, дараагийн сард нь уг гэр бүл дэх Нийгмийн Халамжийн Бүлгийн гишүүдэд очиж заах айлчлагч багш нарыг томилж болно.

Удирдагч нар ховор тохиолдолд бүрэн цагийн номлогчдыг Мелкиседек санваартнуудтай хамт гэрийн багшаар явуулах талаар номлолын ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр асууж болно. Номлолын ерөнхийлөгч энэ зөвшөөрлийг гадасны ерөнхийлөгчтэй ярилцаж шийдвэрлээд гадасны ерөнхийлөгч бишопт мэдэгдэнэ. Ийм зөвшөөрөл өгсөн үед бүрэн цагийн номлогчдыг ихэвчлэн шинэ гишүүд, гэр бүлийн гишүүдийн зарим нь сүмийн гишүүн гэр бүлүүд болон идэвх султай гишүүдэд очиж заахаар томилдог.

Чуулга, бүлгийн удирдагчид хэрэгцээ болон эн тэргүүнд анхаарах зүйлс дээр тулгуурлан, чуулга, бүлгийн гэрийн багшийн үүрэгт ажлыг биелүүлэхэд туслахын тулд зарим гишүүдийн гэрээр очиж болно.

### 7.4.4 Гэрийн багшлалтын тайлан

Чуулга, бүлгийн удирдагчид хамтрагч бүрээс гэрийн багшлалтын тайланг сар бүр авна. Түүнээс гадна тэд томилогдсон гишүүдэд сүнслэг болон материаллаг халамж тавих, тусламж хэрэгтэй гишүүдэд туслах төлөвлөгөө гаргаж мөрдөх тухай асуудлыг хэлэлцэхийн тулд гэрийн багш нартай тогтмол уулзаж байна. Хувийн чанартай мэдээллийг зөвхөн ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч эсвэл дээд пристүүдийн бүлгийн удирдагчид мэдэгдэх ёстой бөгөөд тэд үүнийг нь бишопт мэдэгдэнэ.

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, дээд пристүүдийн бүлгийн удирдагч хоёр гэрийн багшийн ажлын сар тутмын тайланг бишопт өгнө. Холбоо тогтоож чадаагүй хүмүүсийн нэрсийн жагсаалтыг тайлан бүрд оруулах ёстой. Шинэ гишүүд, идэвх султай гишүүд ба тусламж чухал хэрэгтэй хүмүүсийг онцгойлон анхаарна. Хэрэв гэр бүл болон хувь хүнд яаралтай хэрэгцээ бий болсон бол ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч эсвэл дээд пристүүдийн бүлгийн удирдагч энэ тухай бишопт тэр даруй мэдэгдэнэ.

## 7.5 Халамж

Халамж бол ахлагч нарын чуулга, дээд пристүүдийн бүлгийн гол ажил юм.

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл, дээд пристүүдийн бүлгийн удирдлага болон тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл бишопын удирдлага дор халамжийн талаар дараах үүрэг хариуцлагуудыг хүлээдэг:

Материаллаг болон сүнслэг байдлын хувьд бие даах чадварын зарчмуудыг заах.

Ядуус болон тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах, үйлчлэл үзүүлэхэд гишүүдийг дэмжих.

Бие даах чадвартай болж, богино болон урт хугацааны халамжийн асуудлуудыг шийдэх арга замыг олоход хувь хүмүүс, гэр бүлүүдэд туслах.

Халамжийн эдгээр үүргийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг 6-р бүлэг-с үзнэ үү.

## 7.6 Ахлагч болохуйц ах нар

Ахлагч болохуйц ах нар бол 19 болон түүнээс дээш настай, Мелкизедек санваргүй, Сүмийн эрэгтэй гишүүд юм. 19-с доош настай, гэрлэсэн, Мелкизедек санваргүй ах нар ч бас ахлагч болохуйц ах нар юм.

### 7.6.1 Ахлагч болохуйц ах нарын үүрэг

Чуулга, бүлгийн удирдагч нар ахлагч болохуйц ах нарт Мелкизедек санваар авахад бэлтгэхэд нь туслах үүрэгтэй. Ахлагч болохуйц ах бүрийн ахлагч нарын чуулга, дээд пристүүдийн бүлэгтэй цуглаж заавар авч, үйл ажиллагаануудад оролцох эсэхийг бишопууд чуулга, бүлгийн удирдагчид болон ахлагч болохуйц ах бүртэй зөвлөлдөнө. Бишоп ахлагч болохуйц ах нарыг тойргийн ахлагч нар болон пристүүдтэй ямар харилцаатай байдаг мөн тэдний нэг бүрийн нас, хэрэгцээг анхаарч үзнэ.

Чуулга, бүлгийн удирдагчид үр өгөөжтэй ажилладаг гэрийн багш нарыг ахлагч болохуйц ах нарт томилон ажиллуулна. Ахлагч болохуйц ах нар багшийн эсвэл пристийн албад томилогдсон бол удирдагчид түүнд гэрийн багшаар үйлчлэх үүргийг өгч болно.

Чуулга, бүлгийн удирдагчид ахлагч болохуйц ах нарыг чуулга, бүлгийн хурал цуглаан, үйл ажиллагаануудад урина.

### 7.6.2 Ахлагч болохуйц ах нарт Мелкизедек санваар авахаар бэлтгэхэд нь туслах

Мелкизедек санваар авахад ахлагч болохуйц ах нарт туслах нь удирдагчдын эн тэргүүнд анхаарах зүйлсийн нэг байх ёстой. Энэ нь гэр бүлүүдийг бэхжүүлж, гэр бүлийн хосыг ариун сүмийн гэрлэлтэд бэлтгэдэг. Ахлагч болохуйц ах нар бэлтгэлээ зохих ёсоор хангасан үед тэднийг аль болох түргэн томилох хэрэгтэй.

Мелкизедек санваар авахад бэлтгэхэд нь ахлагч болохуйц ах нарт дараах зарчмуудыг заах талаар ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, дээд пристүүдийн бүлгийн удирдагч нар анхаарна:

1. Бошиглогч Иосеф Смитээр дамжин ирсэн санваарын сэргээлт ба түлхүүрүүд
2. Санваарын тангараг ба гэрээ (С ба Г 84:33–44-ийг үзнэ үү)
3. Нөхөр болон эцэг хүний үүрэг
4. Ахлагчийн үүрэг ба санваартны чуулгын зорилго
5. Санваарын ёслол, адислалуудын зорилго ба хэрхэн гүйцэтгэх тухай (20-р бүлэг болон *Гэр бүлийн удирдамжийг* үзнэ үү).

Удирдагчид эдгээр зарчмыг ганцаарчилсан маягаар зааж болно. Нэг тойрогт, тойргуудын дунд эсвэл гадасны хэмжээнд ахлагч болохуйц ах нарт зориулан хичээл зохион байгуулж болно. Энэ хичээлийг заах чадварлаг гэрийн багш нарыг томилж болно. Тэд ариун сүмд

бэлтгэх хичээлийн хэсэг болгон энэ зааврыг өгч болно (5.4.5-ыг үзнэ үү). Шаардлагатай бол энэ үүргийг биелүүлэхэд чуулга, бүлгийн удирдагчдад туслах дээд зөвлөлийн нэг гишүүнийг гадасны ерөнхийлөгч томилж болно.

Ахлагч болохуйц ах нарт Мелкизедек санваар авахад бэлтгэхэд нь туслах эх сурвалж материалуудад Сургаал ба Гэрээний 20, 84, 107, 121-р хэсэг; *Гэр бүлийн удирдамж; Пристийн зэргийн үүргүүд ба адислалууд, А Хэсэг,* хичээл 1–4 ба 9; *Пристийн зэргийн үүргүүд ба адислалууд, Б Хэсэг,* хичээл 1–6 орно.

Бишоп энэхүү ахлагч болох бэлтгэлийг хамгийн түрүүнд хийх шаардлагатай ах нарыг олж тогтоохын тулд чуулга, бүлгийн удирдагчид болон тойргийн зөвлөлтэй зөвлөлдөнө. Үүнээс өөр арга замаар бэлтгэгдэх боломжгүй 18 настай Аароны санваартнуудыг энд хамруулж болно.

Ахлагч болохуйц ах нарт Мелкизедек санваар авахад бэлтгэхэд нь туслахын тулд бишоп *Гарын авлага 1-ийн* 16.7.1 дэх заавруудыг баримтална.

## 7.7 Удирдлагын хурлууд

### 7.7.1 Тойргийн санваартны гүйцэтгэх хорооны болон тойргийн зөвлөлийн хурал

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, дээд пристүүдийн бүлгийн удирдагч нар тойргийн санваартны гүйцэтгэх хороо болон тойргийн зөвлөлийн гишүүнээр үйлчилдэг (4-р бүлэг-г үзнэ үү).

### 7.7.2 Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн болон Дээд пристүүдийн бүлгийн удирдлагын хурал

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл нь ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлыг тогтмол хийнэ. Дээд пристүүдийн бүлгийн удирдлага нь удирдлагын хурлыг тогтмол хийнэ. Чуулгын ерөнхийлөгч эсвэл бүлгийн удирдагч хурлыг хөтөлнө. Чуулга, бүлгийн нарийн бичиг нар цуглаанд оролцож, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврын биелэлтийг мэдээлнэ. Тус тойрогт томилогдсон дээд зөвлөлийн гишүүн зарим үед оролцож болно.

Хурлын хөтөлбөрт дараах асуудлууд орж болно:

1. Чуулга, бүлгийн гишүүд, тэдний гэр бүл, түүний дотор ахлагч болохуйц ах нарыг бэхжүүлэх арга замуудыг төлөвлөх.
2. Санваартны удирдагчдад холбогдох үүрэг хариуцлагыг судрын хэсгүүд, Сүмийн удирдагчдын заавруудаас уншиж, ярилцах.
3. Гэрийн багшийн үүрэгт ажил, түүний гүйцэтгэлийн тухай ярилцаж, сайжруулах арга замуудыг төлөвлөх
4. Чуулга, бүлгийн хурал цуглаанууд дээр сайн мэдээг зааж байгаа байдлын тухай ярилцаж, сайжруулах арга замуудыг төлөвлөх.
5. Тойргийн зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгавруудын тайланг танилцуулах.
6. Чуулга, бүлэгт эв нэгдлийг бий болгох арга замууд, түүний дотор үйлчлэл болон үйл ажиллагаануудыг төлөвлөх.

### 7.7.3 Гадасны санваартны удирдлагын хурал

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл гадасны санваартны удирдлагын хурлыг гадасны чуулган хийх бүрд хуралдуулна (18.3.1, зүйл 2-ыг үзнэ үү). Ерөнхийлөгчийн зөвлөл тухайн жилд гадасны санваартны удирдлагын нэг хурлыг чуулганы бус үеэр хийснээр нийтдээ гурван ийм хурлыг жил бүр хийнэ. Чуулга, бүлгийн удирдагчид болон нарийн бичиг нар оролцоно.

## 7.8 Чуулга болон бүлгийн хурлууд

### 7.8.1 Санваартнуудын ням гарагийн хурал

Санваартнуудын ням гарагийн хурлын нээлтийн үйл ажиллагаанд Мелкизедек болон Аароны санваартнууд хамт оролцох бөгөөд бишопын зөвлөлийн гишүүн хөтлөн явуулдаг (18.2.4-ийг үзнэ үү).

Нээлтийн үйл ажиллагааны дараа ах нар өөр өөрсдийн чуулга, бүлгийн цуглаанд оролцоно. Чуулга, бүлгийн цуглааны зорилго бол чуулгын ажил хэргийг явуулах, санваарын үүргүүдээ сурах, гэр бүлүүдийг бэхжүүлэх, Есүс Христийн сайн мэдээг судлах явдал юм. Эдгээр зорилгоо биелүүлэхийн тулд удирдагчид залбиралтайгаар төлөвлөнө.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн эсвэл бишопын зөвлөлийн гишүүн (эсвэл өөр тэргүүлэх эрх мэдэлтэн) оролцоогүй бол ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч ахлагч нарын чуулгын хурлыг, дээд пристүүдийн бүлгийн удирдагч дээд пристүүдийн бүлгийн цуглааныг тэргүүлнэ. Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн эсвэл бүлгийн удирдлагын нэг гишүүн цуглааныг хөтлөн явуулна.

Ахлагч нар ба дээд пристүүд ердийн үед тус тусдаа цугладаг. Гэвч тойрогт санваартны

хуралд оролцох боломжтой цөөхөн ахлагч эсвэл дээд пристүүд байдаг бол хамт цуглаж болно. Тэд хамт цугладаг байсан ч ганцхан Мелкизедек санваартны чуулгыг дангаар нь байгуулах ёсгүй бөгөөд тойрогт ахлагч ба дээд пристүүд байгаа үед ахлагч нарын чуулга болон дээд пристүүдийн бүлгийг зохион байгуулах ёстой.

Дүүргүүдэд дээд пристүүдийн чуулга байдаггүй учраас дүүрэгт харьяалагддаг салбаруудад дээд пристүүдийн бүлэг байдаггүй. Эдгээр салбарт очдог дээд пристүүд ахлагч нарын чуулгатай хамт цуглана.

Ахлагчийг дээд пристүүдийн бүлгийн цуглаанд оролцох нь өөрт нь тустай гэж үзвэл бишоп зөвшөөрөл өгч болно. Бишоп нь 18 настай Аароны санваартныг ахлагч нарын чуулгатай хамт цуглаанд оролцохыг урьж болно.

Чуулга, бүлгийн удирдагчид ням гарагт заах хичээлийг дараах загварын дагуу төлөвлөнө.

#### Эхний ням гараг

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн эсвэл дээд пристүүдийн бүлгийн удирдлагын гишүүн эхний ням гарагт заана. Тэрээр судрууд, хожмын үеийн бошиглогчдын сургаалууд, Сүмийн зөвшөөрөгдсөн материалуудыг ашиглана. Энэ цуглаанаар Мелкизедек санваартны удирдагчид сайн мэдээний сургаалуудыг зааж, санваарын үүрэг хариуцлагаа идэвхтэй хэрэгжүүлэхэд ах нарт туслана.

Чуулга, бүлгийн удирдагчид заах сэдвийг сонгохдоо Сүнсний удирдамжийг эрэлхийлнэ. Сэдвүүдэд гэрийн багшлалт, санваарын ёслолууд ба адислалуудыг хийж гүйцэтгэх, гэрлэлт болон гэр бүлүүдийг бэхжүүлэх, үйлчлэл, номлолын ажил, хөрвөгчдийг идэвхтэй байлгах, идэвхжүүлэх, сүнслэг болон материаллаг халамж, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажил орж болно. Чуулга, бүлгийн удирдагчид бусдад туслах арга замуудыг төлөвлөх, үүрэг даалгавар өгөх, урьд өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнахыг энэ цагаар хүсэж болно.

#### Хоёрдахь, гуравдахь ням гарагууд

Хоёрдахь, гуравдахь ням гарагт хичээлийг чуулга, бүлгийн удирдагч эсвэл багш заана. Тэрээр Мелкизедек санваартны гарын авлагыг ашиглана. Ерөнхийдөө хичээлүүдийг гарын авлага дахь дэс дараалаар мөн тухайн ням гарагт Нийгмийн Халамжийн Бүлгийн цуглаанд заасан хичээлтэй адил сэдвээр заадаг.

Тойргийн 18 буюу түүнээс дээш настай бүх эрэгтэйчүүд чуулга, бүлгийн цуглаанд оролцох боломжтой эсэхийг үл харгалзан, хувиараа судлахад зориулсан Мелкизедек санваартны гарын авлага хүлээн авсан байх ёстой. Хичээлд оролцогчид гарын авлагаа, мөн боломжтой бол судруудаа авчрахыг удирдагчид дэмжинэ.

#### Дөрөвдэх ням гараг

Дөрөвдэх ням гарагт хичээлийг чуулга, бүлгийн удирдагч эсвэл багш заана. Тэрээр хамгийн сүүлчийн ерөнхий чуулганы захиасуудыг ашиглана. Гадасны ерөнхийлөгч эсвэл бишоп заах захиасуудыг сонгоно.

#### Тавдахь ням гараг

Тавдахь ням гарагт заах сэдэв болон багшийг сонгох (ихэвчлэн тойргийн эсвэл гадасны гишүүн) мөн Мелкизедек Санваартнууд, Нийгмийн Халамжийн Бүлэгтэй нэгдэж цуглах эсэхийг бишоп шийднэ.

### 7.8.2 Гадасны дээд пристүүдийн чуулгын хурал

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл гадасны бүх дээд пристүүдийн оролцдог гадасны дээд пристүүдийн чуулгыг жилд доод тал нь нэг удаа хуралдуулна. Энэ хурлын үеэр гадасны ерөнхийлөгчийн зөвлөл чуулгын ажил хэргийг хөтлөн явуулж, чуулгын гишүүдэд үүргийнх нь тухай заана.

## 7.9 Ёслолууд ба адислалуудыг хэрхэн гүйцэтгэхийг заах нь

Дараах ном, товхимлууд нь ёслол болон адислалуудыг гүйцэтгэх заавсрыг агуулдаг:

1. Энэ гарын авлагын 20-р бүлэг
2. *Гэр бүлийн удирдамж*, хуудас 18–25
3. *Санваарын адислалууд ба үүргүүд, Б хэсэг*, хуудас 42–47

Санваартны удирдагчид эдгээр ном, товхимлуудыг ашиглан ёслол ба адислалуудыг хэрхэн гүйцэтгэхийг ах нарт заадаг. Санваар эзэмшигч бүр *Гэр бүлийн удирдамж*, *Санваарын үүргүүд ба адислалууд, Б хэсэг* номтой байх, ба тэдгээрийг хичээл дээр өөрсдийн номыг ашигладаг байхыг удирдагчид анхаарна.

Санваартны удирдагчид Тэргүүн Зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр ёслол, адислал болон залбирлын зааврууд агуулсан ном товхимлуудыг хэвлэн гаргах буюу ашиглаж болохгүй.

## 7.10 Нэмэлт удирдамж ба журмууд

### 7.10.1 Тусгай хэрэгцээтэй ах нар

Тусгай хэрэгцээтэй ах нарт өвчтэй, өндөр настай, бэлэвсэн, гэр бүл салсан, гэрээс гарах боломжгүй, хагацал үзсэн эсвэл хүнд өвчтэй хүмүүсийг асардаг ах нар ордог. Тэдэнд чуулга, бүлгийн гишүүд нь туслах ёстой.

Дээр дурдсан болон бусад тусгай хэрэгцээтэй ах нар өөрсдийнхөө асуудлуудын талаар ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, дээд пристүүдийн бүлгийн удирдагчтай уулзаж болно. Эдгээр удирдагчид анхааралтай сонсож, хайраа харуулан, урам дэм өгөхийн хамт зохих журмын дагуу нууцыг хадгалах ёстой. Хэрэв тэд тухайн гэр бүлийн зохистой байдал болон бусад эмзэг асуудлын талаар байж болзошгүй ямар-ваа асуудлыг мэдсэн бол уг ах нарыг бишоптой уулзуулахаар явуулна.

Хөгжлийн бэрхшээлтэй ах нарт туслах тухай мэдээллийг 21.1.26 болон disabilities.lds.org-аас үзнэ үү.

### 7.10.2 Хүн нас барсан үед тусламж үзүүлэх нь

Тойрогт гишүүн нас барахад гэр бүлтэй нь холбоо барьж, тайтгаруулан, юу хэрэгтэй байгааг мэдэж, тусламж үзүүлэхийг санал болгохыг бишоп дээд пристүүдийн бүлгийн удирдагч эсвэл ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчөөс хүсч болно. Тэрээр ийм туслалцааг Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчөөс хүсч болно. Энэ ажлыг Мелкизедек санваартнуудын болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид хамтран зохицуулдаг.

Оршуулгын бэлтгэлийг хангахад туслахыг бишоп бас Мелкизедек санваартны удирдагчдаас хүсч болно. Оршуулгын тухай нэмэлт мэдээллийг 18.6-гаас үзнэ үү.

Боломжтой бол хувийн хишгээ хүртсэн нас барсан гишүүдийг ариун сүмийн хувцсаар хувцаслан оршуулах ёстой. Зарим тохиолдолд нас барсан эрэгтэй хүнийг зохих журмын дагуу хувцаслах эсвэл байлцах хувийн хишгээ хүртсэн эрэгтэй хүн томилохыг бишоп дээд пристүүдийн удирдагч эсвэл ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчөөс хүсч болно. Энэ үүргийг дургүйцэхгүй хүлээн авах хүн сонгох тал дээр эдгээр удирдагчид анхаарах ёстой. Нас барсан гишүүдийг хувцаслах удирдамж *Instructions for Clothing the Dead Who Have Received Their Endowments (Хишиг хүртсэн бөгөөд нас барсан хүмүүсийг хувцаслах заавруud)*-д байдаг. Удирдагчид эдгээр заавар бүхий гарын авлагыг Сүмийн хангамжийн төвөөс авч болно.

Нас барсан гишүүдийг ариун сүмийн хувцсаар хувцаслах тухай зааврыг бишоп *Гарын авлага 1-ийн* 3.4.9-өөс үзэж болно.

Ойр дотных нь хүн нас барсны дараахан хэцүү үед байгаа гэр бүлд ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, дээд пристүүдийн бүлгийн удирдагч, гэрийн багш нар болон бусад ах нар дэмжлэг, тайтгарал, тусламж үзүүлэхээ үргэлжлүүлсээр байдаг.

### 7.10.3 Ариун сүмийн хувцас ба гарментийн тухай заавар

21.1.42-ыг үзнэ үү.

### 7.10.4 Үйл ажиллагаануудыг санхүүжүүлэх нь

13.2.8-ыг үзнэ үү.

# 8. Аароны санваар


8.1 **Аароны санваарын тодорхойлолт ба зорилго. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 52**
- 8.1.1 Аароны санваарын албууд ба үүргүүд. . . . 52
- 8.1.2 Аароны санваартны чуулгууд . . . . . . . . . . . 53
- 8.1.3 Аароны санваарын зорилго. . . . . . . . . . . . . 53

8.2 **Эцэг эхчүүд ба Сүмийн удирдагчдын үүргүүд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 53**

8.3 **Тойргийн Аароны санваартны удирдлага. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 53**
- 8.3.1 Бишопын зөвлөл. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 53
- 8.3.2 Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлүүд ба пристийн чуулга дахь бишопын туслахууд. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 55
- 8.3.3 Чуулгын нарийн бичиг нар . . . . . . . . . . . . 55
- 8.3.4 Тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл (Аароны санваартны чуулгын зөвлөгч нар) . . . . . . . . 56
- 8.3.5 Тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн нарийн бичиг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 56
- 8.3.6 Аароны санваартны чуулгын туслах зөвлөгч нар. . . . . . . . . . . . . . . . . . . . . . 57
- 8.3.7 Спортын дасгалжуулагч нар . . . . . . . . . . . 57

8.4 **Гэрийн багшлалт. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 57**

8.5 **Мацгийн өргөлийг цуглуулах нь . . . . . . . . . . 57**

8.6 **10, 11 настай хөвгүүдэд санваар авахаар бэлтгэхэд нь туслах . . . . . . . . . . . . . 57**
- 8.6.1 Эцэг эхчүүд ба гэрийн багш нар . . . . . . . . . 57
- 8.6.2 Хүүхдийн Хэсгийн удирдагчид ба багш нар . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 57

8.7 **Бүрэн цагийн номлолд бэлтгэхэд нь чуулгын гишүүдэд туслах нь . . . . . . . . . . 57**

8.8 **Мелкиседек санваарыг 18 настай залуу эрэгтэйчүүдэд олгох нь. . . . . . . . . . . . 58**

8.9 **Удирдлагын хурал . . . . . . . . . . . . . . . . . . . . . 58**
- 8.9.1 Тойргийн санваартны гүйцэтгэх хорооны болон тойргийн зөвлөлийн хурал . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 58
- 8.9.2 Бишопын зөвлөлийн Залуучуудын хорооны хурал . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 59
- 8.9.3 Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 59
- 8.9.4 Тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал . . . . . . . 59
- 8.9.5 Гадасны санваартны удирдлагын хурал . . 60

8.10 **Жишгүүд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 60**

8.11 **Чуулгуудын ням гарагийн хурлууд . . . . . . . 60**

8.12 **Бурханы өмнө хүлээх үүрэг хөтөлбөр. . . . . 61**

8.13 **Үйл ажиллагаанууд . . . . . . . . . . . . . . . . . . . . 61**
- 8.13.1 Мючел . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 61
- 8.13.2 Залуучуудтай хийх Бишопын зөвлөлийн зөвлөлдөөн . . . . . . . . . . . . . . . . . . 61
- 8.13.3 Жишгийн үйл ажиллагаа . . . . . . . . . . . . . . . 62
- 8.13.4 Скаутын үйл ажиллагаа . . . . . . . . . . . . . . . . 62
- 8.13.5 Гадасны болон гадас дундын үйл ажиллагаанууд. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 62
- 8.13.6 Залуучуудын чуулган . . . . . . . . . . . . . . . . . . 62
- 8.13.7 Үйл ажиллагаануудыг санхүүжүүлэх нь. . . 62

8.14 **Удирдах ур чадварыг заах нь . . . . . . . . . . . 63**

8.15 **Гадасны Аароны санваартны удирдлага . . 63**
- 8.15.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл. . . . . . . . . 63
- 8.15.2 Гадасны Залуу Эрэгтэйчүүдэд томилогдсон дээд зөвлөлийн гишүүн . . . . . 63
- 8.15.3 Гадасны Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл. . . . . . . . . . . . . . . . . 63
- 8.15.4 Гадасны Залуу Эрэгтэйчүүдийн нарийн бичиг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 63
- 8.15.5 Гадасны Аароны санваартнууд–Залуу Эмэгтэйчүүдийн хороо . . . . . . . . . . . . . . . . . 63

8.16 **Залуу Эрэгтэйчүүдийн бүлгийг орон нутгийн онцлогт тохируулан өөрчлөх нь . . 64**

8.17 **Нэмэлт удирдамж ба журмууд . . . . . . . . . . . 64**
- 8.17.1 14-өөс доош насны залуучууд залуучуудын чуулган ба бүжигт оролцох нь. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 64
- 8.17.2 *Итгэлдээ үнэнч байх нь: Сайн мэдээний заалт* (36863). . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 64
- 8.17.3 Өөр шашинтай залуу эрэгтэйчүүд . . . . . . . 64
- 8.17.4 Хөгжлийн бэрхшээлтэй залуу эрэгтэйчүүд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 64

# 8. Аароны санваар

## 8.1 Аароны санваарын тодорхойлолт ба зорилго

Санваар бол Бурханы хүч ба эрх мэдэл юм. Санваарыг Сүмийн зохистой эрэгтэй гишүүдэд олгодог. Санваарын түлхүүрүүдийг эзэмшдэг хүмүүс сайн мэдээний ёслолууд болон дэлхий дээрх Бурханы хаант улсыг удирдан зохион байгуулдаг.

Аароны санваар "тэнгэр элчүүдийн тохинуулал хийгээд бэлтгэл сайн мэдээний түлхүүрийг атгадаг" ба "үг сайн мэдээ нь наманчлалын хийгээд баптисмын мөн нүглүүдийн ангижралын сайн мэдээ бөлгөө." (С ба Г 84:26–27; мөн С ба Г 13:1; 107:20-ийг үзнэ үү) Аароны санваар бас "гаднах ёслолуудыг гүйцэтгэх хүчтэй байдаг" (С ба Г 107:14).

Санваарын зорилго болон түлхүүрүүдийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг 2-р бүлэг-с үзнэ үү.

### 8.1.1 Аароны санваарын албууд ба үүргүүд

Аароны санваар нь дикон, багш, прист, бишоп гэсэн албуудтай. Санваарын алба бүр нь үйлчлэлийн эрх, үүргүүд түүний дотор санваарын ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдэлтэй байдаг. Дикон, багш, пристийн албанд томилох тухай мэдээллийг 20.7-гоос үзнэ үү.

#### Дикон

Зохистой ах нар 12 настайдаа Аароны санваар хүлээн авч, диконоор томилогдож болно. Дикон дараах үүрэг хариуцлагатай:

Тэр зөв шударгаар амьдарч санваарыг ашиглахуйц зохистой байна. Тэрээр чуулгын нөхөддөө болон Сүмийн бусад гишүүдэд сайн үлгэр жишээ үзүүлнэ.

Мөн ариун ёслолыг түгээнэ (20.4.3-ыг үзнэ үү).

Тэрээр "сүмийг харж хандахын тулд томилогдсон," идэвхтэй үйлчлэгчийн хувиар үйлчилдэг (С ба Г 84:111). Тэр "сануулж, тайлбарлаж, ухуулж мөн зааж, мөн Христэд ирэхэд бүхнийг урьдаг байх ёстой." (С ба Г 20:59) Энэхүү үүрэг хариуцлагад чуулгын гишүүд, бусад залуу эрэгтэйчүүдтэй нөхөрлөх, Сүмийн цуглаануудыг гишүүдэд зарлах, хурал цуглаан дээр үг хэлэх, сайн мэдээ болон гэрчлэлээ хуваалцах зэрэг

Тэр "цаг зуурын зүйлсийг . . .адислахад [гүйцэтгэхэд]" (С ба Г 107:68) бишопт тусалдаг. Энэхүү үүрэг хариуцлагад мацгийн өргөл цуглуулах, ядуус ба тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах, сүмийн байр болон газрыг тордох, Сүмийн цуглаанууд дээр бишопын зарлага болж үйлчлэх зэрэг орж болно.

Тэрээр сайн мэдээнээс идэвхтэй суралцагч байж, чуулгын хичээлд оролцоно.

Дикон албынхаа дагуу бусад хэлбэрээр бишопын зөвлөлд тусалдаг. Тэр "хэрэв нөхцөл байдал шаардах аваас . . . сүм дэх [багш нарын] бүх үүргүүдэд" (С ба Г 20:57) тусалдаг.

#### Багш

Зохистой ах нар 14 настайдаа багшаар томилогдож болно. Диконы бүх үүрэг багшид байдаг. Тэр дараах үүргүүдтэй:

Тэрээр ариун ёслолыг бэлтгэнэ (20.4.2-ыг үзнэ үү).

Тэр "Сүмийг ямагт харж хандах, тэдэнтэй хамт байж мөн бэхжүүлэх" (С ба Г 20:53) ёстой. Энэ үүргээ биелүүлэх нэг арга зам бол гэрийн багшаар үйлчлэх явдал юм.

Тэр "сүмд алдас байхгүй, мөн бие биендээ хахир хатуу хандахгүй, мөн худал хэлэхгүй, хов жив хөөцөлдөхгүй, шүүмжлэхгүй байхад анхаарах" (С ба Г 20:54) ёстой. Энэхүү үүрэгт энхийг тогтоогч байж, ёс суртахууны зарчимч, шударга байдлын үлгэр жишээ үзүүлэгч байх нь орно.

Тэрээр "сүм хамтдаа олонтаа цуглахыг анхаарч, мөн тэрчлэн бүх гишүүд үүргээ биелүүлж байгааг анхаарах" (С ба Г 20:55)" ёстой.

Тэрээр багшийн албад нийцсэн бусад арга замуудаар бишопын зөвлөлд тусална.

#### Прист

Зохистой ах нар 16 настайдаа пристээр томилогдож болно. Дикон болон багшийн бүх үүрэг хариуцлага пристэд байдаг. Тэр дараах үүргүүдтэй:

Тэрээр "номлох, заах, тайлбарлах, ухуулах . . . мөн гишүүн бүрийн гэрээр айлчлан, мөн чангаар болон чимээгүй залбирахыг, гэр бүлийн бүх үүргээ гүйцэтгэхийг тэдэнд ухуулах" (С ба Г 20:46–47) ёстой.

Бишоп зөвшөөрөл олгосон үед тэр баптисм гүйцэтгэж, Аароны санваар олгон, дикон, багш,

пристүүдийг томилж болно (С ба Г 20:46, 48-ыг үзнэ үү).

Тэрээр зөвшөөрөл олгосон үед ариун ёслолын ширээний дэргэд үйлчлэн ариун ёслолыг адисалж, ариун ёслолын залбирал хэлнэ (С ба Г 20:46, 77, 79; мөн энэ гарын авлагын 20.4.3-ыг үзнэ үү).

Тэрээр пристийн албаны дагуу бусад тохиромжтой арга замуудаар бишопын зөвлөлд тусална.

#### Бишоп

Ааронын санваарт хамаарах бишопын үүрэг хариуцлагыг 8.3.1-д өгүүлсэн байгаа.

### 8.1.2 Ааронын санваартны чуулгууд

Санваартны чуулга бол санваарын адил алба бүхий ах нарын зохион байгуулалттай бүлэг юм. Чуулгуудын үндсэн зорилго бол бусдад үйлчлэх, эв нэгдэл ба ах дүү ёсны харилцааг бий болгох, мөн сургаал, зарчим, үүргүүдийг гишүүдэд заах явдал юм.

Бишоп диконуудыг 12 хүртэл гишүүнтэй чуулга, багш нарыг 24 хүртэл гишүүнтэй чуулга, пристүүдийг 48 хүртэл гишүүнтэй чуулга болгон зохион байгуулдаг (С ба Г 107:85–87-г үзнэ үү). Чуулгын гишүүнчлэл дээрх тоонуудаас давсан тохиолдолд бишоп чуулгыг хувааж болно. Тэрээр чуулгыг хуваахын өмнө уг чуулгын гишүүдийн тоо, удирдлагын боломж, чуулгыг хуваах нь гишүүдэд хэрхэн нөлөөлөхийг харгалзаж үзнэ.

Цөөхөн залуу эрэгтэйчүүдтэй тойрог, салбарт Ааронын санваартнуудын чуулгууд хичээл, үйл ажиллагаанд хамтдаа цуглаж болно.

### 8.1.3 Ааронын санваарын зорилго

Ааронын санваартай залуу эрэгтэйчүүд бэлтгэлийн болон сүнсний өсөлт хөгжилтийнхөө үед байдаг. Ийм учраас эцэг эхчүүд, бишопын зөвлөл, бусад Ааронын санваартнууд залуу эрэгтэй бүрд:

1. Есүс Христийн сайн мэдээнд хөрвөж, сургаалуудаар нь амьдрахад
2. Санваарын дуудлагадаа итгэлтэйгээр үйлчилж, санваарынхаа албаны үүрэг хариуцлагыг биелүүлэхэд
3. Үр өгөөжтэй үйлчлэл үзүүлэхэд
4. Мелкизедек санваар болон ариун сүмийн ёслолуудыг авахад бэлтгэж, уг санваар болон ёслолуудыг хүлээн авахуйц зохистой амьдрахад
5. Бүрэн цагийн номлолд хүндэтгэлтэйгээр үйлчлэхэд бэлтгэхэд
6. Боломжийнхоо хэрээр сайн боловсролтой болоход
7. Зохистой нөхөр, эцэг болоход бэлтгэхэд
8. Эмэгтэйчүүд, охид, хүүхдүүдэд хүндэтгэлтэй хандахад нь тусалдаг.

Эцэг эхчүүд, удирдагчид гэр бүлийн үдэш, гэр бүлээрээ судар судлах, цуглаан, үйл ажиллагаануудаар дамжуулан эдгээр үүрэг хариуцлагаа биелүүлэхэд залуу эрэгтэйчүүдэд тусалж, Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд тэдэнд дэмжлэг үзүүлдэг (8.12-ыг үзнэ үү).

Залуу эрэгтэйчүүд эдгээр зорилгыг хурал цуглаан, үйл ажиллагаан дээр цээжээр унших албагүй.

## 8.2 Эцэг эхчүүд болон Сүмийн удирдагчдын үүрэг

Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ бие бялдар, сүнслэг байдлын төлөө үндсэн үүрэг хариуцлагыг хүлээдэг (С ба Г 68:25–28-ыг үзнэ үү). Бишопын зөвлөл, Ааронын санваартны бусад удирдагчид дээрх үүргээ биелүүлэхийг нь дэмжих болохоос, эцэг эхчүүдийг орлох ёсгүй. Удирдагчид дараах арга замуудаар дэмжлэг үзүүлнэ:

Эцэг эхчүүдийг хөвгүүдээ Ааронын санваарын ёслол болон ариун сүмийн хишиг хүлээн авахад, бүрэн цагийн номлолд үйлчлэхэд болон ариун сүмд гэрлэхэд мөн ирээдүйн эцэг болоход бэлтгэхэд нь тусалж, залуу эрэгтэйчүүд болон эцэг эхчүүдийн хоорондын харилцааг дэмжинэ.

Чуулгын болон залуучуудын бусад үйл ажиллагаа нь гэр бүлүүдэд эсвэл гэр бүлийн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд дарамт болохгүй байх ёстойг анхаарна.

Удирдагчид сайн мэдээгээр амьдрахад нь гэр бүлийнхнийх нь дэмжлэг үгүйлэгддэг залуу эрэгтэйчүүдийг онцгой анхаарах хэрэгтэй.

## 8.3 Тойргийн Ааронын санваартны удирдлага

Энэ хэсэгт залуу эрэгтэйчүүд болон тэдний гэр бүлийг бэхжүүлэх арга замаар Ааронын санваартнуудын чуулгыг удирдах талаар онцлон өгүүлнэ. Удирдлагын ерөнхий зарчмуудын талаар өгүүлсэн 3-р бүлэг-г Ааронын санваартны удирдагчид байнга уншиж судална. Эдгээр зарчимд сүнслэг байдлын хувьд бэлтгэх, хурал

цуглаануудад оролцох, бусдад үйлчлэх, Есүс Христийн сайн мэдээг заах ордог.

Энэ бүлэгт *чуулгын удирдагчид* гэдэг нэр томьёо нь диконы чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл, багш нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл, бишоп ба пристүүдийн чуулга дахь түүний туслахуудад холбогдоно. Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд бол чуулгын удирдагчид биш, зөвлөгч нар юм.

### 8.3.1 Бишопын зөвлөл

Бишоп тойргийнхоо Аароны санваартны чуулгуудад хяналт тавина. Тэрээр зөвлөхүүдийнхээ хамт бишопын зөвлөл болон тойргийн Аароны санваартнуудын ерөнхийлөгчийн зөвлөлийг бүрдүүлдэг (С ба Г 107:13–15-ыг үзнэ үү). Тэд залуу эрэгтэйчүүдийг нэг бүрчлэн харж хандаж, эцэг эхчүүд, бусад удирдагчидтай нягт хамтран ажилладаг.

#### Бишоп

Бишоп бол тойргийн тэргүүлэх дээд прист юм. Тэрээр мөн пристүүдийн чуулгын ерөнхийлөгч юм (С ба Г 107:87–88). Салбарт салбарын ерөнхийлөгч пристүүдийн чуулгын ерөнхийлөгч байдаг.

Пристүүдийн чуулгын удирдлагад бишоп хоёр туслахтай байх бөгөөд тэд хоёул прист байна. Бишоп олон үүрэг хариуцлагыг туслахуудаа хариуцуулан даалгадаг ч, чуулгын ерөнхийлөгчийн хувьд өөрөө идэвхтэйгээр үйлчилдэг. Тэрээр чуулгад хайр, эв нэгдлийн уур амьсгалыг бүрдүүлнэ. Тэрээр чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн болон чуулгын ням гарагийн хичээлүүдэд оролцож, тэргүүлэхийн хамт чуулгын үйлчлэл, үйл ажиллагаануудад оролцоно. Эзгүй үедээ тэрээр чуулгын удирдлагын үүрэг хариуцлагыг туслахуудынхаа нэгэнд хариуцуулна. Бишоп чөлөөлөгдөхөд туслахууд нь бас чөлөөлөгддөг.

Пристийн албанд томилогдохоор бэлтгэж байгаа залуу эрэгтэйчүүдтэй бишоп ярилцлага хийнэ.

#### Бишоп ба түүний зөвлөхүүд

Бишоп зөвлөхүүдийнхээ нэгийг диконы чуулга, нөгөөг багш нарын чуулгыг хариуцуулахаар томилно. Зөвлөхүүд чуулгуудад хайр, эв нэгдлийн уур амьсгалыг бүрдүүлнэ. Тэд чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлууд, чуулгын ням гарагийн хичээлүүдэд аль болох олон удаа оролцож байна. Мөн чуулгын үйлчлэл, үйл ажиллагаануудад оролцоно.

Бишоп болон түүний зөвлөхүүд чуулгын зөвлөгч нарын тусламжтайгаар чуулгын удирдагчдад удирдлагын ур чадварыг зааж, үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь тусална.

Бишоп зөвлөхүүдийнхээ нэгийг өөрийн удирдлага дор тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн бүлгийг хариуцуулахаар томилно. Уг зөвлөх Залуу Эрэгтэйчүүдийн асуудлуудыг тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй хамт хэлэлцдэг. Тэр эдгээр хэлэлцүүлгийн тухай бишопын зөвлөлийн хурал дээр мэдээлнэ.

Бишоп залуу эрэгтэй бүртэй жилд нэг удаа ярилцлага хийнэ. Боломжтой бол тэрээр 16, 17 настай залуу эрэгтэйчүүдтэй жилд хоёр удаа ярилцлага хийнэ. Хэрэв боломжгүй бол тэрээр нэг зөвлөхдөө зарим ярилцлагыг хувиарлана. 12-15 настай залуу эрэгтэй бүр бишоптой жил бүрийн ярилцлага хийснээс хойш 6 сарын дараа уг чуулгыг хариуцсан бишопын зөвлөхтэй ярилцлагад орно. Бишопууд болон тэдний зөвлөхүүд залуучуудтай ярилцлага хийх удирдамжийг *Гарын авлага 1-ийн* 7.1.7-гоос үзэж болно.

Бишоп эсвэл томилогдсон зөвлөх нь дикон, багшийн албанд томилогдохоор бэлтгэж байгаа залуу эрэгтэйчүүдтэй ярилцлага хийнэ.

Бишоп болон түүний зөвлөхүүд гэрийн багшаар үйлчлэх багш, пристүүдийг томилно.

Бишоп эсвэл томилогдсон зөвлөх нь дикон болон багшын чуулгын ерөнхийлөгч, пристүүдийн чуулгын туслахуудтай тогтмол ярилцлага хийнэ. Бишопын зөвлөлийн гишүүн чуулгын удирдагчидтай чуулгын гишүүн бүрийн болон нийт чуулгын өсөлт хөгжилтийн тухай дээрх ярилцлагуудаар хэлэлцдэг.

Залуу эрэгтэй бүрийг Хүүхдийн Хэсгээс Аароны санваартны чуулгад дэвшин шилжих, санваарын албанд томилогдох, Бурханы өмнө хүлээх үүрэг хөтөлбөрийг биелүүлэхэд бишоп болон зөвлөхүүд түүнийг ариун ёслолын цуглаан дээр танилцуулна.

Бишоп болон түүний зөвлөхүүд Сүмээс зөвшөөрөл өгсөн бол Скаутын үйл ажиллагааг дэмжинэ (8.13.4-ийг үзнэ үү).

Бишоп Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийг дуудаж, онцгойлон адисална. Тэрээр Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөхүүд, нарийн бичиг, чуулгын туслах зөвлөгч, залуу эрэгтэйчүүдийн бүлэгт үйлчилдэг бусад хүмүүсийг дуудаж, адислах үүргийг зөвлөхүүддээ өгч болно.

Бишоп пристүүдийн чуулга дахь зөвлөхүүдээ дууддаг. Тэр эсвэл томилогдсон зөвлөх нь

диконы болон багш нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл, нарийн бичиг нарыг дууддаг. Бишопын зөвлөлийн гишүүд эдгээр албуудад хэнийг дуудахыг шийдэхийн тулд хамтран залбирна. Тэд чуулгад дуудагдах удирдагчдыг зөвхөн насны байдлаар эсвэл чуулгад хэр их удсаныг нь харгалзан дуудах ёсгүй. Бишоп болон түүний зөвлөхүүд хэнийг дуудах талаар сүнсний удирдамжийг эрэлхийлэхийн хамт тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй зөвлөлдөнө.

Бишопын зөвлөлийн гишүүн диконы болон багш нарын чуулгын ерөнхийлөгчөөр үйлчлэх залуу эрэгтэйг дуудахдаа, түүний зөвлөхүүд болон нарийн бичгээр хэнийг дуудах саналтай байгааг нь асууна. Энэхүү үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэхдээ, хэнийг санал болгох талаар Их Эзэнээс удирдамж эрэлхийлж, залбирахыг бишопын зөвлөлийн гишүүн чуулгын ерөнхийлөгчид зөвлөнө. Гэвч хэнийг дуудах талаар сүнсний удирдамж хүлээж авах эцсийн үүрэг хариуцлага бишопын зөвлөлд байдгийг чуулгын ерөнхийлөгч ойлгоход нь бишопын зөвлөлийн гишүүн туслах ёстой.

Бишопын зөвлөлийн гишүүн залуу эрэгтэйгээс дээрх дуудлагуудын аль нэгэнд үйлчлэхийг хүсэхийн өмнө эцэг эхээс нь зөвшөөрөл авна.

Дээрх дуудлагуудыг өгсний дараа бишопын зөвлөлийн гишүүн чуулгын удирдагчдыг дэмжүүлэн батлуулахын тулд чуулгынх нь цуглаан дээр танилцуулна. Дараа нь бишоп эсвэл томилогдсон зөвлөх залуу эрэгтэйчүүдийг онцгойлон адисална. Бишоп пристүүдийн чуулга дахь өөрийн зөвлөхүүдийг онцгойлон адисална. Тэр диконы болон багш нарын чуулгын ерөнхийлөгчийг онцгойлон адисалдаг. Учир нь зөвхөн бишоп тэдний дуудлагын санваарын түлхүүрүүдийг өгч чадна. Тэрээр диконы болон багш нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөхүүд, нарийн бичиг нарыг онцгойлон адислах үүргийг зөвлөхүүддээ өгч болно.

Бишопын зөвлөлийн гишүүн дээрх дуудлагуудыг ариун ёслолын цуглаан дээр зарлах боловч дэмжүүлэхгүй.

### 8.3.2 Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл ба пристийн чуулга дахь бишопын туслахууд

Аароны санваартны чуулгын удирдагчид чуулгын гишүүдтэй "зөвлөлд сууж, тэдэнд үүргийг нь заадаг" (С ба Г 107:85–86-г үзнэ үү). Тэд үүрэг хариуцлагаа биелүүлэхдээ сүнсний удирдамжийг эрэлхийлэхийн хамт бишопын зөвлөл болон чуулгын зөвлөгч нараас удирдамж, заавар авдаг. Аароны санваартны чуулгуудын ерөнхийлөгч чуулгынхаа ажлыг удирдан чиглүүлэх санваарын түлхүүрүүдийг эзэмшдэг. Диконы болон багш нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөхүүд, пристүүдийн чуулга дахь бишопын туслахууд санваарын түлхүүрүүдийг эзэмшдэггүй.

Аароны санваартны чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл, пристийн чуулга дахь бишопын туслахууд чуулгын гишүүд болон тухайн насны бусад залуу эрэгтэйчүүдэд анхаарал тавьж, тэдэнтэй нөхөрлөнө. Шинэ болон идэвх султай гишүүд, хөгжлийн бэрхшээлтэй буюу тусгай хэрэгцээтэй хүмүүст тэд онцгой анхаарал тавьдаг. Чуулгын удирдагчид чуулгын гишүүдийн дунд хайр, ах дүүсэг харилцааг хөгжүүлэхийг хичээдэг.

Аароны санваартны чуулгын удирдагчид чуулгын гишүүдээ санваартны үүрэгт ажлаа биелүүлэх, удирдах туршлага суух, сүнслэгээр өсөх боломжуудаар хангана.

Тэд чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлыг тогтмол хийнэ.

Чуулгын ням гарагийн хичээлийг хөтлөн явуулна.

Тэд чуулгын үйл ажиллагаанууд, түүний дотор Мючелийг төлөвлөхөд тусалдаг.

Бурханы өмнө хүлээх үүрэг хөтөлбөртөө зорилго дэвшүүлж, хэрэгжүүлэхэд чуулгын гишүүдэд тусалдаг.

Заримдаа тэд чуулгын зөвлөгчийн тусламжтайгаар чуулгын ням гарагийн хичээл дээр сайн мэдээний зарчмуудаас зааж болно.

Диконы чуулгын ерөнхийлөгч, багш нарын чуулгын ерөнхийлөгч, пристүүдийн чуулгын туслахуудын нэг нь бишопын залуучуудын хороонд үйлчилдэг (18.2.9-ийг үзнэ үү).

### 8.3.3 Чуулгын нарийн бичиг нар

Чуулгын нарийн бичиг нар дараах үүрэг хариуцлагатай:

Тэд ирцийн тухай мэдээлэл боловсруулж, хянан Залуу Эрэгтэйчүүдийн нарийн бичигт өгнө.

Ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлын хөтөлбөр гаргахдаа чуулгын удирдагчидтай зөвлөлдөнө. Дээрх хурал цуглаанн уудад оролцож, тэмдэглэл хөтлөн, үүрэг дааалгаврын биелэлтэд хяналт тавина.

Үйл ажиллагаануудыг төлөвлөхөд чуулгын удирдагчид болон зөвлөгчдөд тусалж болно.

8. Аароны санваар

### 8.3.4 Тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл (Аароны санваартны чуулгын зөвлөгч нар)

Тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл нь ерөнхийлөгч, хоёр зөвлөхөөс бүрддэг. Тэд Аароны санваартны чуулгад зөвлөгчөөр үйлчилдэг. Тэд бишопын зөвлөлийн заавраар ажиллана. Тэд мөн гадасны Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлөөс сургалт, байнгын дэмжлэг туслалцаа авна.

#### Тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч

Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч дараах үүрэг хариуцлагатай:

Тэрээр тойргийн санваартны гүйцэтгэх хороо болон тойргийн зөвлөлийн гишүүнээр үйлчилнэ. Тэрээр энэ хороо болон зөвлөлийн гишүүний хувьд хувь хүмүүс, гэр бүлүүдийг бэхжүүлж итгэлийг нь хөгжүүлэх ажилд оролцоно (4-р бүлэг-ийг үзнэ үү). Тэр мөн бишопын залуучуудын хорооны гишүүн (18.2.9-ийг үзнэ үү).

Тэрээр энэ гарын авлагыг ашиглан Залуу Эрэгтэйчүүдийн бусад удирдагчдад үүргийг нь заадаг.

Тэр тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн бүлгийн бүртгэл, тайлан, төсөв, санхүүд хяналт тавина. Залуу Эрэгтэйчүүдийн нарийн бичиг энэ үүргийг биелүүлэхэд тусалдаг.

#### Тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч ба түүний зөвлөхүүд

Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч болон түүний зөвлөхүүд Аароны санваартны чуулгын зөвлөгчөөр үйлчилдэг. Ерөнхийлөгч нь пристүүдийн чуулгын зөвлөгч, нэгдүгээр зөвлөх нь багш нарын чуулгын, хоёрдугаар зөвлөх нь диконы чуулгын зөвлөгч байна. Тэд дараах үүрэг хариуцлагатай:

Тэд Аароны санваартнуудыг үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь туслах үүднээс чуулгуудыг удирддаг.

Залуу эрэгтэй бүрийг таньж мэдэн, тэдний авьяас чадвар, сонирхдог зүйлс, бэрхшээлийн талаар ойлголттой болно. Залуу эрэгтэй бүрийг бэхжүүлэх, гэрчлэлээ хөгжүүлэх болон чуулгынхаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг нь урамшуулан дэмждэг. Тэд шинэ гишүүн болон идэвх султай залуу эрэгтэйчүүдэд онцгой анхаарал тавьж,

залуу эрэгтэй бүрийг гэр бүлээсээ сургаалийг сурдаг байхад нь дэмждэг.

Тэд 8.1.3-т жагсаасан зорилгуудыг хэрэгжүүлэхэд залуу эрэгтэйчүүдэд тусална. Үүнд Бурханы өмнө хүлээх үүрэг хөтөлбөрийн хүрээнд зорилго дэвшүүлж, хэрэгжүүлэхэд туслах ажил орно.

Санваартны гүйцэтгэх хороо болон тойргийн зөвлөлийн хурлуудаас өгсөн үүрэг даалгаврын мөрөөр тэд үйлчлэлийн хороодыг зохион байгуулахад чуулгуудын ерөнхийлөгчийн зөвлөлтэй хамтран ажиллаж болно.

Тэд залуу эрэгтэйчүүдийн хэрэгцээний талаар эцэг эхчүүд болон санваартны удирдагчидтай зөвлөлдөж болно.

Чуулгуудын ням гарагийн цуглаан дээр хичээл байнга заах боловч энэ үүргээ туслах зөвлөгч нартайгаа хуваан хийж болно. Чуулгууд дахь сайн мэдээнээс суралцах байдал болон сургалтын чанарт анхаарал тавина. Тэд энэ ажилдаа 5.5.3 болон 5.5.4 дэх зарчмуудыг баримтална.

Тэд Аароны санваартны чуулгуудын хурал цуглаануудад оролцож, шаардлагатай удирдамж зөвлөгөө өгнө. Тэд бишопын зөвлөлд удирдах ур чадварыг чуулгуудын ерөнхийлөгчийн зөвлөл болон пристүүдийн чуулгын туслахуудад заахад нь тусална (8.14-ийг үзнэ үү).

Чуулгын үйл ажиллагаанууд, түүний дотор Мючелийн үйл ажиллагаануудыг төлөвлөж, хэрэгжүүлэхэд тэд чуулгын удирдагчидтай хамтран ажиллана.

Мөн бишопын зөвлөл болон чуулгын удирдагчдад тэд чуулгын эв нэгдлийг бий болгоход тусална.

Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлыг хийнэ. Тэд бас Залуу Эрэгтэйчүүдийн бүлгийг хариуцсан бишопын зөвлөхтэй тогтмол уулзаж байна.

Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд Скаутын үйл ажиллагааг Сүмээс зөвшөөрсөн газарт ерөнхийдөө Скаутын удирдагчдаар дуудагддаг ч, Скаутын туслах удирдагчаар дуудагдаж болно (8.13.4-ийг үзнэ үү).

### 8.3.5 Тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн нарийн бичиг

Залуу Эрэгтэйчүүдийн нарийн бичиг дараах үүрэг хариуцлагатай:

Ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлуудын хөтөлбөр бэлтгэхэд Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй зөвлөлдөнө. Дээрх хурлуудад оролцож, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих.

Чуулгын нарийн бичиг нарт заавар өгч, чуулгын ирцийн бүртгэл хөтлөх талаарх тэдний ажилд хяналт тавих. Улирал тутам ирцийн

тухай мэдээллийг бэлтгэж, Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчтэй хянан хэлэлцэж, тойргийн бичиг хэргийн ажилтанд өгөх.

Тэрээр Бишопын болон Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүдэд цуглаанд тогтмол оролцохгүй байгаа болон санваарын аль нэг албанд томилогдох болсон залуу эрэгтэйчүүдийн талаар мэдээлдэг байна.

Бурханы өмнө хүлээх үүрэг хөтөлбөрт оролцож байгаа залуу эрэгтэй бүрийн өсөлтийг тэмдэглэх үүрэгт түүнийг томилж болно.

Тэрээр жил тутмын төсөв боловсруулж, зардлын тайлан гаргахад Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлд тусална.

### 8.3.6 Аароны санваартны чуулгын туслах зөвлөгч нар

Үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлд туслуулахаар чуулгын туслах зөвлөгчдийг бишопын зөвлөл дуудаж болно. Чуулгын туслах зөвлөгч нар чуулгын ням гарагийн зарим хичээлийг зааж болно. Тэд бас үйл ажиллагаануудыг, түүний дотор Мючелийг зохион байгуулахад тусалж болно.

Чуулгын туслахын зөвлөгч нар Скаутын үйл ажиллагааг Сүмээс зөвшөөрсөн газарт ерөнхийдөө туслах удирдагчаар дуудагддаг ч, Скаутын удирдагчаар бас дуудагдаж болно (8.13.4-ийг үзнэ үү).

### 8.3.7 Спортын дасгалжуулагч нар

Бишопын зөвлөл Залуу Эрэгтэйчүүдийн спортын багуудад эрэгтэй хүмүүсийг дасгалжуулагчаар дуудаж болно. Дасгалжуулагчид Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн удирдлага дор үйлчилнэ. Спортын хөтөлбөрүүдийн тухай мэдээллийг 13.6.21-ээс үзнэ үү.

## 8.4 Гэрийн багшлалт

Гэрийн багшлалтыг хийх нь багш, прист, Мелкизедек санваартнуудын санваарын үүрэг юм. Гэрийн багшлалт түүний дотор Аароны санваартнуудад гэрийн багшийн ажил үүргийг хуваарилах тухай нарийн тодорхой мэдээллийг 7.4-өөс үзнэ үү.

## 8.5 Мацгийн өргөлийг цуглуулах нь

Тойргийн нөхцөл байдлаас шалтгаалан мацгийн өргөлөө сар бүр хандивлахад туслахын тулд бишоп Аароны санваартнуудыг, ялангуяа диконуудыг айлуудаар явуулж болно.

Санваартнууд мацгийн өргөлийг цуглуулахдаа хоёр хоёроороо явах ёстой. Шаардлагатай бол Мелкизедек санваартнууд Аароны санваартнуудтай явж болно.

Гишүүд аравны нэг зэрэг бусад өргөлүүдийг мацгийн өргөл цуглуулж буй хүмүүст өгч болохгүй.

Мацгийн өргөл цуглуулдаг хүмүүс өргөлийг бишопын зөвлөлийн аль нэг гишүүнд даруй өгөх хэрэгтэй.

## 8.6 10, 11 настай хөвгүүдэд санваар авахад бэлтгэхэд нь туслах

### 8.6.1 Эцэг эхчүүд ба гэрийн багш нар

10, 11 настай хөвгүүдийн Аароны санваар авахаар бэлтгэхэд туслах үндсэн үүрэг хариуцлагыг эцэг эхчүүд нь хүлээдэг. Гэр бүлийн бусад гишүүд болон гэрийн багш нар мөн үүнд тусална. Аав нь идэвхгүй гишүүн эсвэл эзгүй байгаа гэр бүлүүдэд гэрийн багш нарын дэмжлэг онцгой чухал юм.

### 8.6.2 Хүүхдийн Хэсгийн удирдагчид ба багш нар

10, 11 настай хөвгүүдийг Аароны санваар авахад бэлтгэхэд Хүүхдийн Хэсгийн удирдагчид болон багш нар гэр бүлүүдэд дэмжлэг үзүүлдэг.

Хүүхдийн Хэсгийн удирдагчид бишопын зөвлөлийн удирдлаган доор Санваарыг танилцуулах уулзалтыг жил бүр бэлтгэнэ (11.5.5-ыг үзнэ үү). Диконы чуулгын болон Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлүүдийг оролцохыг урьж болно.

## 8.7 Бүрэн цагийн номлолд бэлтгэхэд нь чуулгын гишүүдэд туслах

Бүрэн цагийн номлолд үйлчлэх боломжтой залуу эрэгтэй бүрийг сүнслэг байдал, бие бялдар, оюун бодол, сэтгэл санаа, санхүүгийн хувьд бүрэн цагийн номлолд бэлтгэхийг Их Эзэн хүсэн хүлээдэг. Номлолд үйлчлэхийг хэдий чинээ эрт шийднэ, төдий чинээ үйлчлэх магадлал нь их байдаг.

Залуу эрэгтэй бүр хувийн гэрчлэлээ болон Их Эзэнтэй харилцах харилцаагаа хөгжүүлэн бэлтгэх хэрэгтэй. Тэрээр судруудыг, ялангуяа Мормоны Номыг судалж бэлтгэх ёстой. Бурханы өмнө хүлээх үүрэг хөтөлбөрт зөвлөмж болгосон зорилго болон үйл ажиллагаануудын ихэнх нь номлолд бэлтгэхэд залуу эрэгтэйчүүдэд тусалж чадна.

Бүрэн цагийн номлолд үйлчлэхэд бэлтгэхэд нь хөвгүүддээ туслах үндсэн үүргийг эцэг эхчүүд хүлээдэг. Гэр бүлийн гишүүд, бишопын зөвлөлийн гишүүд, Аароны санваартны чуулгуудын ерөнхийлөгчийн зөвлөл ба бусад зөвлөгч нар, гэрийн багш нар болон бусад хүмүүс энэхүү хүч чармайлтад нь эцэг эхчүүдэд дэмжлэг үзүүлдэг.

Номлолын үйлчлэлд бэлтгэхэд чуулгын гишүүдэд туслах нь бишопын зөвлөл, чуулгын зөвлөгч нарын нэн тэргүүнд анхаарах зүйл юм. Энэ бэлтгэл нь диконы чуулгаас эхэлдэг. Номлолын бэлтгэлийг чуулгуудын болон ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал цуглаан ба бусад үйл ажиллагааны үеэр заахыг удирдагчид хичээнэ.

Залуу эрэгтэйчүүдэд бүрэн цагийн номлолд бэлтгэхэд бишопын зөвлөлийн гишүүд, чуулгуудын зөвлөгч нар дараах арга замуудаар тусалдаг:

Тэд чуулгуудын хурал цуглаан, чуулгын гишүүдэд зориулсан үйл ажиллагаанууд дээр Ариун Сүнсний нөлөөг танин мэдэх болон мэдрэх боломжоор хангадаг.

Есүс Христийн Цагаатгал, Бошиглогч Иосеф Смитээр дамжсан сайн мэдээний сэргээлт, авралын төлөвлөгөө, баптисм, Ариун Сүнсний бэлэг зэрэг номлогчдын заадаг үндсэн сургаалуудыг тэд залуу эрэгтэйчүүдэд заадаг. Тэд *Миний сайн мэдээг номло* удирдамжийг дээрх сургаалуудыг заах гарын авлага болгон ашиглаж болно.

Залуу эрэгтэйчүүдийг судруудаас ялангуяа Мормоны Номыг өдөр бүр хувиараа судлахыг тэд дэмжинэ. Тэд бас залуу эрэгтэйчүүдийг *Миний сайн мэдээг номло* удирдамжийг судлахыг урамшуулан дэмжинэ.

Тэд бүрэн цагийн номлогчдод тавигддаг шаардлагуудын талаар залуу эрэгтэйчүүд болон тэдний эцэг эхчүүдэд заадаг. Эдгээр шаардлагт сайн мэдээний мэдлэг ба гэрчлэл, хувийн зохистой байдал, эрүүл бие бялдар, нийгмийн болон сэтгэл санааны төлөвшилт, санхүүгийн бэлтгэл орно. Эдгээр шаардлагыг хангахын тулд зорилго тавьж ажиллахад нь тэд залуу эрэгтэйчүүдийг удирдана.

Залуу эрэгтэйчүүдийг семинарт явахыг дэмжинэ.

Багш, пристүүдийг үйлчлэх, түүний дотор гэрийн багшаар ажиллах боломжоор хангана.

Чуулгын хурал цуглаан, бусад үйл ажиллагаагаан дээр сайн мэдээг заах боломжоор залуу эрэгтэйчүүдийг хангана.

Сайн мэдээг найз нөхөд, гэр бүлийн гишүүдтэйгээ хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг дэмжих хэрэгтэй.

Тэд албан болон албан бус үйл ажиллагаанууд дээр буцаж ирсэн номлогчдын үлгэр жишээнээс суралцаж, хамтран ажиллах боломжийг залуу эрэгтэйчүүдэд олгоно.

Энэ бэлтгэлийн нэг хэсэг болгон бишопын зөвлөл болон чуулгын зөвлөгч нар пристийн насны залуу эрэгтэйчүүдийг номлогчийн бэлтгэлийн хичээлд суухыг дэмждэг. Энэ насны залуу эрэгтэйчүүдийн тоог харгалзан бишопын зөвлөл энэ хичээлийг тойргийн төвшинд эсвэл гадасны ерөнхийлөгчийн зөвлөл нь гадасны төвшинд зохион байгуулж болно. Энэ хичээлд ашиглах гол материалуудад судрууд, *Номлогчийн гарын авлага*, *Миний сайн мэдээг номло* гурав ордог.

Бишопуудад зориулсан нэмэлт зааврууд *Гарын авлага 1-ийн* 4.2-т байдаг.

## 8.8 Мелкиседек санваарыг 18 настай залуу эрэгтэйчүүдэд олгох нь

18 буюу түүнээс дээш настай зохистой ах нар Мелкиседек санваар авч, ахлагчийн албанд томилогдож болно. Залуу эрэгтэйн гэрчлэл ба төлөвшсөн байдал, сургууль төгсөлт болон үеийнхэнтэйгээ цаашид үргэлжлүүлэн найзлах хүсэл, дээд сургуульд орсон эсэх зэрэг тухайн хүний нөхцөл байдал дээр тулгуурлан залуу эрэгтэйг 18 нас хүрснийх нь дараахан томилох эсвэл пристийн чуулгадаа хэсэг хугацаагаар үлдэх эсэхийг бишоп шийднэ. Бишоп энэ шийдвэрийг гаргахдаа юуны өмнө залуу эрэгтэй болон эцэг эхтэй нь зөвлөлдөнө. 19 нас хүрмэгц эсвэл сургуульд суралцах, цэргт явах зэргээр гэрээсээ хол газар явах, бүрэн цагийн ажилд орсон тохиолдолд зохистой бүх ах нар ахлагчаар томилогдох ёстой.

Залуу эрэгтэй бүрийг ахлагч нарын чуулгад амжилттай шилжихийн төлөө Залуу Эрэгтэйчүүдийн болон чуулгын удирдагчид хамтран ажиллана.

## 8.9 Удирдлагын хурал

### 8.9.1 Тойргийн санваартны гүйцэтгэх хорооны болон тойргийн зөвлөлийн хурал

Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч тойргийн санваартны гүйцэтгэх хороо, тойргийн зөвлөлийн гишүүнээр үйлчилдэг (4-р бүлэг-г үзнэ үү).

### 8.9.2 Бишопын зөвлөлийн Залуучуудын хорооны хурал

Бишоп бишопын зөвлөлийн залуучуудын хороог тэргүүлдэг. Энэ хороог бишопын зөвлөл, пристийн чуулга дахь бишопын нэг туслах, диконы болон багш нарын чуулгын ерөнхийлөгчид, Залуу Эмэгтэйчүүдийн ангийн ерөнхийлөгчид, Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч нар бүрдүүлдэг. Дэлгэрэнгүй мэдээллийг 18.2.9-өөс үзнэ үү.

### 8.9.3 Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал

Чуулга бүрийн ерөнхийлөгчийн зөвлөл ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлыг тогтмол хийдэг. Бишоп пристийн чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн хуралд байнга оролцож тэргүүлэх бөгөөд туслахуудынх нь нэг хурлыг хөтлөн явуулна. Диконы болон багш нарын чуулгын ерөнхийлөгч өөрсдийнхөө ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлуудыг хөтлөн явуулах бөгөөд хэрэв бишопын зөвлөлийн гишүүн оролцоогүй бол тэд өөрсдөө тэргүүлнэ. Чуулгын зөвлөгч нар болон нарийн бичиг оролцоно. Нарийн бичиг тэмдэглэл хөтөлж, үүрэг даалгаврын биелэлтийг танилцуулна.

Хурлын хөтөлбөрт дараах зүйлс орж болно:

1. Чуулгын гишүүдийг, түүний дотор шинэ болон идэвх султай гишүүдийг бэхжүүлэх арга замуудыг төлөвлөх. Түүнчлэн өөр шашинтай залуу эрэгтэйчүүдтэй нөхөрлөх арга замуудыг төлөвлөх.
2. Санваартны үүрэг хариуцлагатай холбоотой судрын хэсгүүд болон Сүмийн удирдагчдын зааврууд уншиж, ярилцах.
3. Шаардлагатай бол чуулгын гишүүдтэй гэрээр нь очиж уулзах ажлыг төлөвлөх.
4. Бурханы өмнө хүлээх үүрэг хөтөлбөрт амжилт олоход нь залуу эрэгтэй бүрд туслах арга замуудыг ярилцах.
5. Чуулгын хурал цуглаан, үйл ажиллагаануудыг төлөвлөх.
6. Бишопын зөвлөлийн залуучуудын хорооны хурлаар хэлэлцэх асуудлуудыг сонгох (18.2.9-ийг үзнэ үү).
7. Бишопын зөвлөлийн гишүүд эсвэл чуулгын зөвлөгч нараас удирдлагын сургалт авах.

Дээрх асуудлуудыг ярилцсаны дараа мөн чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлаар Скаутын үйл ажиллагааг Сүмээс зөвшөөрсөн бол чуулгын Скаутын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж болно. Скаутын залуу болон насанд хүрсэн удирдагчид хуралд оролцоогүй бол тэднийг энэ асуудлыг хэлэлцэх үеэр урьж болно. Скаутын удирдах албан тушаалтай, өөр шашинтай залуу эрэгтэйчүүдийг оролцуулж болно. Чуулгын ерөнхийлөгч хурлын энэ хэсгийг тэргүүлсэн хэвээр байна. Тэрээр хурлыг хөтлөн явуулахыг Скаутын залуу удирдагчаас хүсч болно. Скаутын үйл ажиллагаа нь 8.1.3-т жагсаасан зорилгуудыг хангаж байгаа эсэхийг чуулгын зөвлөгч нар анхаарна.

### 8.9.4 Тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал

Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл нь ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлыг тогтмол хийнэ. Ерөнхийлөгч цуглаан дээр тэргүүлж, хурлыг хөтлөн явуулна. Нарийн бичиг оролцож, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврын биелэлтийг мэдээлнэ.

Хурлын хөтөлбөрт дараах зүйлс орж болно:

1. Чуулга бүрийн залуу эрэгтэйчүүд 8.1.3-т жагсаасан зорилгуудыг хэрхэн биелүүлж байгаад үнэлэлт өгөх. Эдгээр зорилгыг илүү бүрэн дүүрэн биелүүлэхэд залуу эрэгтэй бүрд туслах арга замуудыг төлөвлөх.
2. Санваартны удирдагчдад холбогдох үүрэг хариуцлагыг судрын хэсгүүдээс болон Сүмийн удирдагчдын зааврууд аас уншиж, ярилцах.
3. Чуулгын удирдагчдад үүрэг хариуцлагынх нь талаар заавар өгөх төлөвлөгөө гаргах.
4. Чуулгын үйл ажиллагаануудын үр дүнгийн талаар ярилцах. Үр өгөөжтэй үйл ажиллагаа төлөвлөхөд залуу эрэгтэйчүүдийг оролцуулах арга замуудыг ярилцах.
5. Чуулгын ням гарагийн хурал дээр сайн мэдээг заах тухай ярилцаж, сайжруулах арга замуудыг төлөвлөх.
6. Ирцийн бүртгэлд дүгнэлт өгч ярилцах. Шинэ болон идэвх султай гишүүдийн ирцийг сайжруулах туслах арга замуудыг төлөвлөх.
7. Залуу Эрэгтэйчүүдийн бүлгийн төсөв, зардлыг хянан хэлэлцэх.

Залуу Эрэгтэйчүүдийн бүлэгт хяналт тавьдаг бишопын зөвлөх Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хуралд оролцож, тайланг нь авч, зөвлөгөө өгнө. Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл нь шаардлагатай бол чуулгын удирдагчид болон туслах зөвлөгч нарыг хуралдаа урьж болно.

### 8.9.5 Гадасны санваартны удирдлагын хурал

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл нь гадасны санваартны удирдлагын хурлыг гадасны чуулган хийх бүрд хуралдуулна (18.3.1, зүйл 2-ыг үзнэ үү). Ерөнхийлөгчийн зөвлөл тухайн жилд гадасны санваартны удирдлагын нэг хурлыг чуулганы бус үеэр хийснээр нийтдээ гурван ийм хурлыг жил бүр хийнэ.

Тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл, нарийн бичиг нар эдгээр хуралд оролцоно. Хурлын хэлэлцэх асуудал нь дикон болон багшын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл, пристийн чуулгын туслахуудад чухал ач холбогдолтой байвал зарим үед тэднийг урьж болно.

## 8.10 Жишгүүд

Жишгүүд нь Сүмийн гишүүдийг хүчирхэгжүүлэх болон удирдах тусалдаг. Залуу эрэгтэйчүүд сайн мэдээний жишгүүдийг сахисан үед Сүмд болон дэлхийд агуу тус үзүүлэх болно. Бас ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахуйц зохистой байх болно.

*Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд Тэргүүн Зөвлөл сайн мэдээний жишгүүдийг тодорхойлж, хэрхэн хэрэгжүүлэхийг залуучуудад заасан байдаг. Залуу эрэгтэй бүр *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолтой байх ёстой. Тэд жишгүүдийг байнга уншиж, эдгээр жишгээр амьдрах нь хэчнээн ашиг тустайг ойлгосон байх хэрэгтэй.

Чуулгын зөвлөгч нар болон тэдний туслахууд товхимол дахь жишгүүдийг судалж, эдгээр жишгийг сахих талаар үлгэр жишээ үзүүлэх ёстой. Тэд эдгээр жишгийг хичээл, Мючелийн үйл ажиллагаа, аялал зуслан, залуучуудын чуулган болон бусад үйл ажиллагаанууд дээр тогтмол зааж, тэдгээрийг сахиулах арга замуудыг олох ёстой.

Сайн мэдээний жишгүүдийг судалж, эдгээрийг сахих талаар хөвгүүддээ үлгэр жишээ үзүүлэн, жишгүүдийг хөвгүүдтэйгээ ярилцаж байх талаар бишопын зөвлөлийн гишүүд болон чуулгын зөвлөгч нар эцэг эхчүүдийг дэмжинэ. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлыг гэр бүлийн үдшийн хичээл, ярианд эх сурвалж болгон ашигладаг байхад залуу эрэгтэйчүүдийг дэмжиж болно.

## 8.11 Чуулгуудын ням гарагийн хурлууд

Санваартны ням гарагийн хурлыг Мелкизедек болон Аароны санваартнуудын хамтарсан нээлтийн ажиллагаагаар эхэлж, бишопын зөвлөлийн гишүүн хөтлөн явуулна (18.2.4-ийг үзнэ үү).

Нээлтийн ажиллагааны дараа санваартнууд өөрсдийн чуулгын хурлуудад оролцоно. Аароны санваартны чуулгууд ихэвчлэн тусдаа цугладаг. Гэвч цөөхөн залуу эрэгтэйчүүдтэй тойрог, салбарт чуулгууд хичээлд хамт сууж болно. Чуулгууд хамт цуглалаа ч гэсэн чуулгуудыг тусад нь зохион байгуулж, чуулга бүрд удирдагчдыг дуудаж, дэмжүүлэн батлуулах ёстой. Боломжтой бол чуулга бүр тусдаа цугладаг, бүрэн бүрэлдэхүүнтэй ерөнхийлөгчийн зөвлөл, болон нарийн бичигтэй байх ёстой.

Чуулгын хурлын зорилго бол чуулгын ажил хэргийг явуулах, санваарын үүргүүддээ суралцах, Есүс Христийн сайн мэдээнээс суралцах явдал юм. Чуулгын удирдагчид болон зөвлөгч нар хурал цуглаануудаар зорилгоо биелүүлдэг байхын тулд залбирч төлөвлөнө. Тэд чуулгын гишүүдийг судруудаа авчирч байхыг дэмжинэ. Удирдагчид хичээлд шаардлагатай Сүмийн баталсан бусад эх сурвалжуудыг авчирч байхыг залуу эрэгтэйчүүдээс хүсч болно.

Өөрөөс нь дээгүүр тэргүүлэх эрх мэдэлтэн байхгүй бол чуулгын ерөнхийлөгчид чуулгын хурал цуглаанууд дээр тэргүүлнэ. Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн эсвэл пристийн чуулгын туслах хөтлөн явуулна. Чуулгууд хамт цугладаг бол пристийн чуулгын туслахууд, багш нарын чуулгын ерөнхийлөгч, диконы чуулгын ерөнхийлөгч нар ээлжээр хөтлөн явуулна.

Чуулгын хурлууд дээр хичээлийг ихэвчлэн чуулгын зөвлөгч нар эсвэл туслах зөвлөгч нар заадаг. Шаардлагатай бол эдгээр ах нар энэ үүрэг хариуцлагыг хуваан хэрэгжүүлж болно. Бишопын зөвлөлийн гишүүд, чуулгын удирдагчид болон чуулгын бусад гишүүд заахад нь заримдаа тусалж болно. Чуулгын удирдагчид эсвэл гишүүд хичээл заахаар бол хичээлдээ бэлтгэхэд нь зөвлөгч тусална. Хичээл заадаг хүмүүс 5.5.4 дэх зарчмуудыг баримтлах ёстой.

Аароны санваартай насанд хүрэгчид энэ чуулгын гишүүд юм. Гэвч тэд ням гарагийн хичээлд ахлагчид болон дээд пристүүдтэй хамт цугладаг. Бишоп нь 18 настай Аароны санваартнуудыг ахлагч нарын чуулгатай хамт цуглахыг урьж болно.

Бишопын зөвшөөрлөөр чуулгын хурлын цагаар залуу эрэгтэйчүүд болон залуу эмэгтэйчүүд зарим үед хамт цуглаж болно.

## 8.12 Бурханы өмнө хүлээх үүрэг хөтөлбөр

Бүх Аароны санваартнууд Бурханы өмнө хүлээх үүрэг хөтөлбөрт идэвхтэй оролцох хэрэгтэй. Энэ хөтөлбөр нь Аароны санваартнуудад сүнслэг хүч чадлаа хөгжүүлэх, санваарын үүргүүдээ сурч, хэрэгжүүлэх, Мелкизедек санваар авахад бэлтгэх, бүрэн цагийн номлолд үйлчлэх, эрүүл мэндээ сахин хамгаалах, бусад хүмүүстэй харилцах харилцаагаа сайжруулах боломжийг олгодог.

Залуу эрэгтэйчүүдийг санваарын албанд анх томилогдсоноос нь хойш аль болох хурдан энэ хөтөлбөрт оролцохыг эцэг эхчүүд болон удирдагчид дэмжинэ. Залуу эрэгтэйчүүд Аароны санваартай байх хугацаандаа зорилго тавьж хэрэгжүүлэхээ үргэлжлүүлсээр байдаг.

## 8.13 Үйл ажиллагаанууд

Чуулгын удирдагчид болон зөвлөгч нар чуулгын гишүүдийн хэрэгцээ, сонирхол дээр тулгуурласан үйл ажиллагаануудыг төлөвлөнө. Бүх залуу эрэгтэйчүүдэд, түүний дотор Сүмд саяхан нэгдсэн болон идэвх султай гишүүдэд хүрч ажиллахад тэд онцгой анхаарна. Үйл ажиллагаанууд нь залуу эрэгтэйчүүдэд Бурханы өмнө хүлээх үүрэг хөтөлбөрийнхөө зорилгуудыг хэрэгжүүлэхэд нь тусалж болох юм. Чуулгын удирдагчид үйл ажиллагаануудыг төлөвлөх болон явуулахад аль болох түлхүү оролцох хэрэгтэй.

Чуулгын үйл ажиллагааны төлөвлөгөөг бишопын зөвлөлийн гишүүн баталж, 13-р бүлэг -дэх удирдамжийг баримтлах ёстой.

### 8.13.1 Мючел

Чуулгын ихэнх үйл ажиллагаанууд Мючелийн үеэр болдог. *Мючел* гэдэг үг нь бие биеэ хүндэлж, дэмжиж, хамтран суралцах гэсэн утгыг илэрхийлдэг. Мючелийн үйл ажиллагаа нь бусдад үйлчлэх олон төрлийн боломж, сүнслэг байдал, оюун ухаан, нийгмийн болон бие бялдрын хөгжлийн боломжуудаар залуучуудыг хангах ёстой.

Мючелийг ерөнхийдөө долоо хоног тутам явуулдаг. Ирэх буцах болон бусад бэрхшээлүүдийн улмаас Мючелийг долоо хоног тутам явуулах боломжгүй бол арай урт хугацаанд 1 удаа явуулж болно. Гэвч сард нэг удаа заавал явуулах ёстой. Мючел нь даваа, ням гарагаас бусад өдөр орой, өдрийн цагаар явагдаж, нэг цагаас цаг хагасын хугацаагаар үргэлжлэх ёстой.

Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл бишопын зөвлөлийн удирдлага дор залуу эрэгтэйчүүдийн мючелийг хариуцна.

Залуу Эрэгтэйчүүд, Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд гадасны болон гадас дундын үйл ажиллагаануудад мючелийн цагаар бэлдэж болно (13.3-ыг үзнэ үү).

#### Мючелийн жил тутмын сэдэв

Тэргүүн Зөвлөл Мючелийн сэдвийг жил бүр зарлана. Удирдагчид Мючелийн нээлтийн ажиллагаа болон залуучуудын бусад үйл ажиллагаанууд дээр энэ сэдвийг онцгойлон дурдана.

#### Нээлтийн ажиллагаа

Мючел нь ихэвчлэн товчхон нээлтийн ажиллагаагаар эхлэх бөгөөд бишопын зөвлөлийн гишүүн тэргүүлнэ. Пристүүдийн чуулга дахь бишопын туслахууд, Лаурел ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд ээлжээр хөтлөн явуулна. Насанд хүрсэн удирдагчид залуу удирдагчдыг энэ үүрэг хариуцлагад нь бэлтгэнэ.

Нээлтийн ажиллагаанд сүмийн дуулал, залбирлаас гадна залуучууд авьяас чадвар, гэрчлэлээ хуваалцах болон дуу дуулж, хөгжим тоглох орж болно.

#### Чуулгын болон ангийн үйл ажиллагаанууд эсвэл хамтарсан үйл ажиллагаанууд

Нээлтийн ажиллагааны дараа Аароны санваартны чуулгууд болон Залуу Эмэгтэйчүүдийн ангиуд ихэвчлэн тусдаа үйл ажиллагаа явуулдаг. Цөөхөн залуу эрэгтэйчүүдтэй тойрог, салбарт бүх залуу эрэгтэйчүүд үйл ажиллагаанд хамт цуглаж болно. Үйл ажиллагаануудыг ч чуулга, ангиуд нийлж хийхээр төлөвлөж болно.

Бүх залуу эрэгтэйчүүд болон залуу эмэгтэйчүүдийн хамтарсан үйл ажиллагааг ихэвчлэн сард нэг удаа зохион байгуулдаг. Бишопын зөвлөлийн залуучуудын хороо хурлаараа эдгээр үйл ажиллагаануудыг хэлэлцэн төлөвлөж, хуваарийг гаргадаг. Эдгээр үйл ажиллагаануудыг бишопын зөвлөлийн удирдлага дор хийнэ.

Тохиромжтой үйл ажиллагааны зарим жишээ бол үйлчлэл, дуу хөгжим, бүжиг, жүжиг, соёлын үйл ажиллагаа, спорт, ажил мэргэжилтэй танилцах болон аялал зугаалга юм.

### 8.13.2 Залуучуудтай хийх Бишопын зөвлөлийн зөвлөлдөөн

Залуучуудтай хийх Бишопын зөвлөлийн зөвлөлдөөнийг бишопын зөвлөл төлөвлөж хийдэг. Үе үе явуулдаг эдгээр хэлэлцүүлэг нь залуучуудын сонирхлыг татдаг, тэдний сүнслэг байдлыг

бэхжүүлдэг сэдвүүдийг хөндөн ярилцах боломжийг бишопын зөвлөлд олгодог. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* болон *Итгэлдээ үнэнч байх нь* товхимлууд дахь сэдвүүдийн талаар ярилцвал онцгой тохиромжтой юм. Бишопын зөвлөл зарим үед энэ хэлэлцүүлэгт зочдыг урьж болно. Зочид нь ихэвчлэн тойргийн болон гадасны гишүүд байдаг.

Залуучуудтай хийх Бишопын зөвлөлийн зөвлөлдөөнийг бүх залуучуудыг оролцуулан эсвэл тодорхой насны бүлгийн залуучуудыг оролцуулан хийж болно. Хэлэлцүүлгийг Мючелийн үеэр, ням гарагт чуулгуудын цуглаан болон Залуу эмэгтэйчүүдийн ангиудын үеэр эсвэл гэр бүлүүдэд илүү хүндрэл учруулахааргүй бусад цагаар явуулж болно. Хэлэлцүүлгийн давтамжийг бишопын зөвлөл тогтоож, бишопын зөвлөлийн залуучуудын хорооны хурлаар хэзээ хийхийг төлөвлөнө.

### 8.13.3 Жишгийн үйл ажиллагаа

Жишгийн үйл ажиллагаа бол ёс суртахууны үнэт зүйлс, мөнхийн зорилгуудад онцгой анхаарал хандуулдаг тусгай хөтөлбөр юм. Энэ үйл ажиллагаа нь залуу эрэгтэйчүүдийг Аврагчид улам ойртуулдаг *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дахь жишгүүдээр амьдрахад тэднийг дэмждэг.

Энэ хөтөлбөрийг жил тутам ихэвчлэн Мючелийн үеэр явуулдаг. Шаардлагатай бол үүнээс олон удаа явуулж болно. Хөтөлбөрийг чуулга, тойрог, гадасны болон гадас дундын төвшинд явуулж болно. Сэдвийг хэрхэн танилцуулснаас хамааран стандарт хөтөлбөрүүдэд Аароны санваартны чуулгууд хамт оролцож болно. Үйл ажиллагаанд аав, ээж нар нь дангаараа болон хамтдаа мөн залуу эмэгтэйчүүд оролцож болно.

### 8.13.4 Скаутын үйл ажиллагаа

Скаутын үйл ажиллагааг Сүмээс зөвшөөрсөн газарт чуулгууд Мючелийн үеэр Скаутын үйл ажиллагаанд оролцож болно. Скаутын үйл ажиллагаа нь ням гарагт сурсан сайн мэдээний зарчмуудаа амьдралд хэрэгжүүлэхэд залуу эрэгтэйчүүдэд туслах ёстой.

Бишопын зөвлөлийн гишүүн бүр өөрийнхөө хариуцдаг Аароны санваартны чуулгуудын Скаутын хөтөлбөрт хяналт тавьдаг. Ер нь бол тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд Скаутын удирдагчдаар үйлчилдэг. Эсвэл бишопын зөвлөл чуулгын туслах зөвлөгчийг Скаутын удирдагчаар дуудаж, Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүдийг Скаутын туслах удирдагчдаар дуудаж болно.

Бишоп ихэвчлэн чуулга бүрд чуулгын ерөнхийлөгч эсвэл пристүүдийн чуулга дахь зөвлөхүүдийнхээ нэгийг Скаутын хөтөлбөр дэх залуучуудын удирдагчаар үйлчлүүлэхээр дууддаг. Гэвч тэр өөр залуу эрэгтэйчүүдийг Скаутын удирдагчдаар томилж болно.

Скаутын үйл ажиллагааг явуулахдаа Сүмээс зөвшөөрсөн газарт 12-15 насны залуу эрэгтэйчүүд бүртгүүлэх ёстой. 16, 17 настай залуу эрэгтэйчүүд скаутын зэрэгэлэлээ ахиулах зорилготой байгаа бол эсвэл гадасны ерөнхийлөгч болон бишоп энэ насны залуучуудад зориулж Скаутын хөтөлбөрийг ивээн тэтгэхээр шийдсэн бол бүртгүүлж болно.

Насанд хүрсэн Скаутын бүх удирдагчид дуудлагадаа үйлчилж эхлэхээсээ өмнө бүртгүүлж, үүрэг хариуцлагынхаа талаар зохих сургалт авсан байх ёстой. АНУ-д бүртгүүлсэн насанд хүрсэн удирдагчид Америкийн Хөвгүүдийн Скаутын байгууллагаас хариуцлагын даатгал хийлгэж авдаг.

Сүм Скаутад бүртгүүлэх залуу эрэгтэйчүүд болон насанд хүрсэн удирдагчдын татварыг бүгдийг нь эсвэл зарим хэсгийг нь төлдөг. Элсэлтийн хураамжийг нь Сүмээс төлдөг. Бүртгэлийн болон элсэлтийн хураамжуудыг гадасны ерөнхий төсвөөс гаргана. Сүм энэ мөнгийг нэгжүүдийн төсөв дээр нэмж олгоно.

Скаутын үйл ажиллагаа нь Аароны санваартны чуулгуудын үйл ажиллагааг зохих ёсоор дэмжиж байгаа эсэхийг бишопын зөвлөл хянахын тулд тойргийн Скаутын хороог зохион байгуулна.

Цөөхөн залуу эрэгтэйчүүдтэй газарт Скаутын бүлгийг олон тойрог, салбар дунд нэг ба зарим тохиолдолд нийт гадас, дүүргийн хэмжээнд нэгийг байгуулж болно.

Скаутын үйл ажиллагааг санхүүжүүлэх тухай мэдээллийг 8.13.7-гоос үзнэ үү. Скаутын тухай нэмэлт мэдээллийг Сүмийн *Scouting Handbook (Скаутын гарын авлага)*-аас үзнэ үү.

### 8.13.5 Гадасны болон гадас дундын үйл ажиллагаанууд

13.3-ыг үзнэ үү.

### 8.13.6 Залуучуудын чуулган

13.4-ийг үзнэ үү.

### 8.13.7 Үйл ажиллагаануудыг санхүүжүүлэх нь

Аароны санваартнуудын үйл ажиллагаа, түүний дотор Сүмээс зөвшөөрсөн газарт

Скаутын үйл ажиллагааг тойргийн төсвөөс санхүүжүүлнэ (13.2.8-ыг үзнэ үү).

#### Жил бүрийн аялал зуслан, түүнтэй адил төстэй үйл ажиллагааг санхүүжүүлэх нь

Хэрэв жил тутмын Скаутын олон хоногийн аялал зуслан буюу түүнтэй төстэй үйл ажиллагааг санхүүжүүлэхэд хүрэлцэх хэмжээний мөнгө тойргийн төсөвт байхгүй бол зардлын зарим хэсгийг эсвэл бүгдийг нь өөрсдөө гаргахыг удирдагчид үйл ажиллагаанд оролцогчдоос хүсч болно. Хэрэв оролцогчдоос гаргасан мөнгө хүрэлцэхгүй бол бишоп 13.6.8-дахь удирдамжийн дагуу хандив цуглуулах аянг жил бүр зохиох зөвшөөрлийг нэг бүлэгт олгож болно.

Жил тутмын аялал зуслан эсвэл адил төстэй үйл ажиллагааны болон унааны зардал хэт их байж болохгүй. Мөн хувиасаа мөнгө өгөх боломжгүй гишүүдийг үйл ажиллагаанаас хасч болохгүй.

#### Тоног төхөөрөмж, материал хэрэгслийн зардал

Боломжтой бол залуучуудын жил тутмын аялал зусланд шаардлагатай тоног төхөөрөмж, материал хэрэгслийг тойргийн төсвөөс худалдаж авах хэрэгтэй. Хэрэв төсөв хүрэлцэхгүй бол 13.6.8 дахь удирдамжийн дагуу хандив цуглуулах аянг жил бүр зохиох зөвшөөрлийг бишоп нэг бүлэгт олгож болно.

Тойргийн төсвөөс эсвэл хандив цуглуулах үйл ажиллагаагаар худалдаж авсан тоног төхөөрөмж, материал хэрэгслийг зөвхөн Сүмийн зорилгоор ашиглана. Эдгээр зүйлсийг хувь хүмүүс, гэр бүлүүд хувийн зорилгоор ашиглаж болохгүй.

Мөн хувь хүмүүсийн өмсөх дүрэмт хувцас худалдаж авахад Сүмийн мөнгийг ашиглаж болохгүй.

## 8.14 Удирдах ур чадварыг заах нь

Чуулгын зөвлөгч нар болон тэдний туслахууд чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл, бишопын зөвлөлийн залуучуудын хороотой ажиллах явцдаа удирдах ур чадварыг зааж, үйл ажиллагаануудыг төлөвлөж, хэрэгжүүлэх, хамтаараа үйлчлэхэд залуу эрэгтэйчүүдэд тусална. Зөвлөгч болон туслах зөвлөгч нар энэхүү ажилдаа энэ гарын авлагын 3-р бүлэг-г ашиглаж болно.

## 8.15 Гадасны Аароны санваартны удирдлага

### 8.15.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд гадасныхаа Аароны санваартнуудыг хариуцна. Тэд энэ үүрэг хариуцлагынхаа дагуу тойргийн Аароны санваартнуудыг тэргүүлэх үүргийнх нь талаар бишопуудад заавар өгнө.

Гадасны ерөнхийлөгч зөвлөхүүдийнхээ нэгийг гадасныхаа Залуу Эрэгтэйчүүдийн бүлэг ба Скаутын үйл ажиллагааг (Скаутын үйл ажиллагааг Сүмээс зөвшөөрөөгүй газарт залуу эрэгтэйчүүдэд зориулсан бусад үйл ажиллагааг) хариуцуулахаар томилно. Скаутын үйл ажиллагааг Сүмээс зөвшөөрсөн газарт уг зөвлөх Скаутын үүрэг хариуцлагын талаар зохих сургалтыг авах ёстой.

Гадасны ерөнхийлөгчийн үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй мэдээллийг 15.1-ээс үзнэ үү. Скаутын үйл ажиллагааны тухай дэлгэрэнгүй мэдээллийг Сүмийн *Scouting Handbook (Скаутын гарын авлага)*-аас үзнэ үү.

### 8.15.2 Гадасны Залуу Эрэгтэйчүүдэд томилогдсон дээд зөвлөлийн гишүүн

Гадасны ерөнхийлөгч дээд зөвлөлийн нэг гишүүнийг гадасны Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй ажиллуулахаар томилдог. Энэ дээд зөвлөлийн гишүүний үүрэг хариуцлагыг 15.3-т өгүүлсэн байдаг.

### 8.15.3 Гадасны Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл

Гадасны Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн үүрэг хариуцлагыг 15.4.1-д өгүүлсэн байдаг.

### 8.15.4 Гадасны Залуу Эрэгтэйчүүдийн нарийн бичиг

Гадасны Залуу Эрэгтэйчүүдийн нарийн бичгийн үүрэг хариуцлагыг 15.4.2-д өгүүлсэн байдаг.

### 8.15.5 Гадасны Аароны санваартнууд–Залуу Эмэгтэйчүүдийн хороо

Гадасны ерөнхийлөгч Гадасны Аароны санваартнууд–Залуу Эмэгтэйчүүдийн хороог тэргүүлүүлэхээр нэг зөвлөхөө томилно. Тус хорооны гишүүдэд гадасны Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүдийн бүлэгт томилогдсон дээд зөвлөлийн гишүүд, гадасны Залуу Эрэгтэйчүүдийн болон Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл ба нарийн бичгүүд орно.

Шаардлагатай үед гадасны ерөнхийлөгчийн зөвлөл залуучуудыг хорооны хуралд оролцуулахаар урьж болно. Залуучуудын чуулган, бүжиг, онцгой цугларалт, гадас дундын үйл ажиллагаануудыг төлөвлөн явуулахдаа залуучуудыг аль болохоор өргөнөөр оролцуулах ёстой. Тэрчлэн гадасны залуучуудад тулгарч байгаа сорилт бэрхшээлүүдийн тухай ярилцахад залуучууд оролцож болно.

## 8.16 Залуу Эрэгтэйчүүдийн бүлгийг орон нутгийн онцлогт тохируулан өөрчлөх нь

Цөөхөн залуу эрэгтэйчүүдтэй тойрог, салбарт Аароны санваартны чуулгууд хичээлд хамт сууж болно (8.11-ийг үзнэ үү). Үйл ажиллагаануудад ч тэд хамтдаа оролцож болно.

Тойрог, салбарт насанд хүрсэн удирдагч дутмаг бол Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл ням гарагийн хичээлийг зааж, зөвлөгчдийн тусламжгүйгээр үйл ажиллагааны хөтөлбөрийг удирдан зохион байгуулна. Маш жижиг нэгжид Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч нь Залуу Эрэгтэйчүүдийн цорын ганц насанд хүрсэн удирдагч байж болно. Энэ тохиолдолд тэр ням гарагийн хичээлийг зааж, нийт залуу эрэгтэйчүүдэд зориулсан үйл ажиллагаануудыг хариуцна. Боломжтой болмогц зөвлөхүүд болон нарийн бичиг дуудна.

Олон хүнтэй үйл ажиллагаа залуучуудад үр ашигтай байдаг учраас хоёр буюу түүнээс дээш жижиг тойрог, салбарын залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүд зарим үед хамтдаа үйл ажиллагаанд оролцож болно. Хил залгаа тойрог, салбарууд цөөхөн залуу эрэгтэйчүүдтэй бол бишоп болон салбарын ерөнхийлөгч нь хоёр долоо хоног тутмын үйл ажиллагаанд залуу эрэгтэйчүүдийг хамтран оролцохыг зөвшөөрч болно. Бишоп болон салбарын ерөнхийлөгч нар энэ хувилбарыг сонгохдоо газрын хол ойр, тээврийн зардал зэрэг хүчин зүйлсийг харгалзаж үзнэ.

Жижигхэн гадас буюу дүүрэгт Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч нь гадасны эсвэл дүүргийн Залуу Эрэгтэйчүүдийн цорын ганц удирдагч байж болно. Боломжтой болмогц зөвлөхүүд болон нарийн бичиг дуудах ёстой.

Орон нутгийн хэрэгцээнд тохируулах тухай ерөнхий мэдээллийг 17-р бүлэг-с үзнэ үү.

## 8.17 Нэмэлт удирдамж ба журмууд

### 8.17.1 14-өөс доош насныхан залуучуудын чуулган ба бүжигт оролцох тухай

14-өөс доош насны залуучууд ер нь тогтмол явагддаг мючелийн үдшээс бусад залуучуудын чуулган болон бүжигт оролцдоггүй (13.6.14-ийг үзнэ үү). Хоногоор явах аялал зуслан болон Скаутын аялалд энэ удирдамжийг баримталдаггүй.

### 8.17.2 *Итгэлдээ үнэнч байх нь: Сайн мэдээний заалт*

Сүм *Итгэлдээ үнэнч байх нь: Сайн мэдээний заалт* товхимлыг судрууд болон хожмын үеийн бошиглогчдын сургаалуудыг судлах гарын авлага болгон нийтэлсэн билээ. Залуу эрэгтэй бүрийг энэ номтой байхад бишопын зөвлөлийн гишүүд, чуулгын зөвлөгч нар анхаарна. Залуу эрэгтэйчүүд сайн мэдээний зарчмуудыг судалж, амьдралд хэрэгжүүлэх, яриа бэлдэх, хичээл заах, Сүмийн тухай асуултуудад хариулахад энэ номыг эх сурвалж болгон ашиглаж болно.

### 8.17.3 Өөр шашинтай залуу эрэгтэйчүүд

Сүмийн жишгүүдийг хүлээн зөвшөөрдөг өөр шашинтай залуу эрэгтэйчүүдэд элгэсэг дотно хандаж, залуучуудын үйл ажиллагаанууддад оролцохыг нь дэмжих хэрэгтэй. Тэдний үйл ажиллагаануудад оролцох зардлыг Сүмийн гишүүн залуу эрэгтэйчүүдийн зардалтай адилаар шийдвэрлэх ёстой. Эдгээр залуу эрэгтэйчүүдийг Скаутын үйл ажиллагаанд оролцоход эцэг эхчүүд нь зардалыг нь гаргаж болно.

### 8.17.4 Хөгжлийн бэрхшээлтэй залуу эрэгтэйчүүд

Хөгжлийн бэрхшээлтэй залуу эрэгтэйчүүд ер нь өөрсдийн чуулгуудад харьяалагддаг. Онцгой тохиолдолд эцэг эхчүүд болон бишоп өөр шийдвэр гаргадаг.

Хөгжлийн бэрхшээлтэй залуу эрэгтэйчүүдийг ойлгож, үйл ажиллагаанд хамруулах, тэдэнд заах тухай мэдээллийг 21.1.26; disabilities.lds.org-оос үзнэ үү.

# 9. Нийгмийн Халамжийн Бүлэг


9.1 **Нийгмийн Халамжийн Бүлгийн тухай ерөнхий мэдээлэл ...................... 66**

- 9.1.1 Зорилго ..............................66
- 9.1.2 Түүх ..................................66
- 9.1.3 Уриа ба бэлэг тэмдэг....................66
- 9.1.4 Гишүүнчлэл ..........................66

9.2 **Тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдлага...................... 67**

- 9.2.1 Бишопын зөвлөл........................67
- 9.2.2 Тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл ........67
- 9.2.3 Тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн нарийн бичиг..................68
- 9.2.4 Нийгмийн Халамжийн Бүлгийн багш нар..............................68
- 9.2.5 Тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн бусад дуудлагууд .............68

9.3 **Удирдлагын хурал ..................... 69**

- Тойргийн Зөвлөлийн хурал .............69
- 9.3.2 Тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал ......................69
- 9.3.3 Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдлагын хурал ............69

9.4 **Тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн цуглаанууд..................... 70**

- 9.4.1 Нийгмийн Халамжийн Бүлгийн ням гарагийн цуглаанууд ...................70
- 9.4.2 Нийгмийн Халамжийн Бүлгийн бусад хурал цуглаанууд.................70

9.5 **Айлчлагч багш.......................... 72**

- 9.5.1 Айлчлагч багш нарын үүрэг хариуцлага ............................72
- 9.5.2 Айлчлагч багш нарыг зохион байгуулах нь..........................72
- 9.5.3 Айлчлагч багшийн ажлыг орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх нь............................73
- 9.5.4 Айлчлагч багшийн тайлан .............73

9.6 **Халамж болон энэрлийн үйлчлэл ........ 73**

- 9.6.1 Гэр бүлийн хэрэгцээг тодорхойлох айлчлал ..............................74
- 9.6.2 Энэрлийн үйлчлэл .....................74
- 9.6.3 Бичиг үсгийн боловсрол ................74

9.7 **Нийгмийн Халамжийн Бүлгийн залуу эгч нарыг хүчирхэгжүүлэх нь................ 75**

- 9.7.1 Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй хамтран ажиллах нь ..........75
- 9.7.2 Ганц бие залуу насанд хүрсэн эгч нарын төлөө хүлээх үүрэг хариуцлага ..........75
- 9.7.3 Ганц бие залуу насанд хүрсэн эгч нарт зориулсан Нийгмийн Халамжийн Бүлгийн тусдаа явагддаг хичээл .........75

9.8 **Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдлага............................... 75**

- 9.8.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл.........75
- 9.8.2 Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл ........76
- 9.8.3 Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн нарийн бичиг..................76

9.9 **Нийгмийн Халамжийн Бүлгийг орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх нь............................ 76**

- 9.9.1 Тойрог дахь нэгээс илүү Нийгмийн Халамжийн Бүлэг ......................76
- 9.9.2 Жижиг нэгжийн Нийгмийн Халамжийн Бүлэг ......................76

9.10 **Нэмэлт удирдамж ба журмууд ........... 77**

- 9.10.1 Тусгай хэрэгцээтэй эгч нар ..............77
- 9.10.2 Хувцаслалтын жишиг...................77
- 9.10.3 Хүн нас барсан үед тусламж үзүүлэх нь...77
- 9.10.4 Гэрлэхээс өмнө жирэмсэлсэн болон хүүхэдтэй болсон залуу эмэгтэйчүүд.....77
- 9.10.5 Ариун сүмийн хувцас ба гарментийн тухай заавар ...........................77
- 9.10.6 Санхүү ................................77

# 9. **Нийгмийн Халамжийн Бүлэг**

Нийгмийн Халамжийн Бүлэг бол санваартнуудад туслах бүлэг юм. Нийт туслах бүлгүүд нь Сүмийн гишүүдийг Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ болон сэргээгдсэн сайн мэдээний тухай гэрчлэлээрээ өсч хөгжихөд нь туслахын тулд оршиж, үйл ажиллагаа явуулдаг. Гишүүд сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрахыг хичээхийн хамт туслах бүлгүүдийн ажлаар дамжуулан заавар, урам, дэмжлэг авдаг.

## 9.1 Нийгмийн Халамжийн Бүлгийн тухай ерөнхий мэдээлэл

### 9.1.1 Зорилго

Нийгмийн Халамжийн Бүлэг нь эмэгтэйчүүдийг итгэл болон хувийн шударга зан чанараа хөгжүүлэхэд нь тусалж, гэр бүлүүдийг бэхжүүлэн, тусламж хэрэгтэй хүмүүст туслах замаар мөнх амьдралын адислалуудад бэлтгэдэг. Ням гарагийн сайн мэдээний хичээл, Нийгмийн Халамжийн Бүлгийн бусад хурал цуглаанууд, айлчлагч багш, халамжийн болон энэрлийн үйлчлэлээр дамжуулан Нийгмийн Халамжийн Бүлэг дээрх зорилгуудаа хэрэгжүүлдэг.

### 9.1.2 Түүх

Бошиглогч Иосеф Смит Нийгмийн Халамжийн Бүлгийг 1842 оны 3-р сарын 17-нд үүсгэн байгуулжээ. "Ядуус, зовж зүдрэгсэд, бэлэвсэн, өнчин хүмүүст туслах болон бүхий л ач буянт зорилгуудыг хэрэгжүүлэхийн төлөө" Нийгмийн Халамжийн Бүлэг зохион байгуулагдсан юм гэж тэрээр заажээ (Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит 2011) Түүнээс гадна Нийгмийн Халамжийн Бүлэг "зөвхөн ядууст туслах төдийгүй бас бодгалиудыг аврахын төлөө" бий болсон юм гэж тэр заасан билээ (*Teachings: Joseph Smith,* 453). Өнөө үед Нийгмийн Халамжийн Бүлгийн ажлын ихээхэн хэсэг нь "Сүмийн бүх эмэгтэй гишүүдийг . . . сүнслэг байдлын хувьд халамжилж, тэдний авралыг эрэлхийлэх явдал мөн" (*Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith* [1998], 185).

Нийгмийн Халамжийн Бүлэг "тэнгэрлэгээр бий болж, тэнгэрлэгээр эрх мэдэл олгогдож, тэнгэрлэгээр үндэслэгдэн, Бурханаас тэнгэрлэгээр томилогдсон юм" (*Teachings: Joseph F. Smith,* 184). Энэ бүлэг нь санваартны удирдагчдын заавраар ажилладаг.

### 9.1.3 Уриа ба бэлэг тэмдэг

Нийгмийн Халамжийн Бүлгийн уриа нь "Энэрэл хэзээ ч дуусдаггүй" (1 Коринт 13:8). Энэ зарчмыг бэлэг тэмдэгт оруулж тусгасан байдаг:

### 9.1.4 Гишүүнчлэл

Сүмийн насанд хүрсэн нийт эмэгтэйчүүд нь Нийгмийн Халамжийн Бүлгийн гишүүд юм.

Залуу эмэгтэй хүн ихэвчлэн 18 настайдаа эсвэл дараа жил нь Нийгмийн Халамжийн Бүлэгт дэвшин ордог. 19 нас хүрсэн залуу эмэгтэй бүр Нийгмийн Халамжийн Бүлэгт бүрэн хамрагдсан байх ёстой. Хувийн гэрчлэл, төлөвшилт, сургууль төгсөлт, үе тэнгийнхэнтэйгээ байх хүсэл, их дээд сургуульд явдаг эсэх зэрэг хувь хүний нөхцөл байдлаас хамааран залуу эмэгтэй хүн 18 хүрэхээсээ өмнө Нийгмийн Халамжийн Бүлэгт дэвшин орж болох ба эсвэл Залуу Эмэгтэйчүүдийн бүлэгтээ хэсэг хугацаагаар үлдэж болно. Залуу эмэгтэй бүр Сүмийн үйл ажиллагаануудад идэвхтэй оролцогч байхын тулд түүнд юу хэрэгтэй талаар эцэг эх болон бишоптойгоо зөвлөлдөнө.

Залуу Эмэгтэйчүүд болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид нь залуу эмэгтэй бүрийг Нийгмийн Халамжийн Бүлэгт амжилттай шилжихийн төлөө хамтран ажиллана.

Хүүхдийн Хэсэг, Залуу Эмэгтэйчүүд эсвэл бусад дуудлагуудад үйлчилдэг насанд хүрсэн эгч нар Нийгмийн Халамжийн Бүлгийн ням гарагийн хурлуудад оролцох боломжгүй байдаг ч Нийгмийн Халамжийн Бүлгийн үйл ажиллагаануудад оролцдог. Тэдэнд айлчлагч багш нар томилогддог ба тэд ч бас айлчлагч багшаар үйлчлэхээр томилогддог. Хэрэв тэдэнд хүндрэл учруулахааргүй бол энэрлийн үйлчлэл, Нийгмийн Халамжийн Бүлгийн цуглаан дээр хичээл заах зэрэг ажил үүргийг өгч болно.

18-аас доош насны гэрлэсэн эмэгтэйчүүд нь Нийгмийн Халамжийн Бүлгийн гишүүд болдог. Зарим онцгой тохиолдлын талаар 10.12.4-с үзнэ үү.

Өөр шашинтай эмэгтэйчүүд Нийгмийн Халамжийн Бүлэгт ирвэл тэднийг халуун дотноор хүлээн авч, дахин ирж байхад нь дэмжинэ.

## 9.2 Тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдлага

Энэ хэсэгт хувь хүмүүс болон гэр бүлүүдийг бэхжүүлэх арга замаар Нийгмийн Халамжийн Бүлгийг удирдах талаар онцлон өгүүлнэ. Удирдлагын ерөнхий зарчмуудын тухай өгүүлсэн 3-р бүлэг-г Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид тогтмол уншиж судалдаг байх хэрэгтэй. Эдгээр зарчмуудад сүнслэг байдлын хувьд бэлтгэх, хурал цуглаануудад оролцох, бусдад үйлчлэх, Есүс Христийн сайн мэдээг заах нь орно.

### 9.2.1 Бишопын зөвлөл

Бишоп болон түүний зөвлөхүүд Нийгмийн Халамжийн Бүлгийг санваартны удирдлагаар хангана.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчөөр үйлчлэх эгчийг бишоп дуудаж, онцгойлон адисална. Бишоп нь тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл, тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн нарийн бичиг, Нийгмийн Халамжийн Бүлгийн дуудлагуудад үйлчлэх бусад эгч нарыг дуудаж, адислах ажлыг хянана. Эдгээр эгчийг дуудаж, адислахад тэрээр зөвлөхүүдээ томилж болно.

Нийгмийн Халамжийн Бүлгийн болон халамжийн асуудлуудыг ярилцахын тулд бишоп Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчтэй тогтмол уулзаж байна.

### 9.2.2 Тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл нь ерөнхийлөгч болон хоёр зөвлөхөөс бүрддэг. Тэд эгч нар болон гэр бүлүүдийг бэхжүүлэхийн төлөө ажилладаг сүнслэг удирдагчид юм. Тэд бишопын зөвлөлийн удирдлага дор ажиллана. Тэд гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлөөс сургалт болон байнгын дэмжлэг авна.

#### Тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч дараах үүрэг хариуцлагатай:

Тэрээр тойргийн зөвлөлийн гишүүнээр үйлчилнэ. Тэрээр энэ зөвлөлийн гишүүний хувьд итгэлийг бий болгох, хувь хүмүүс болон гэр бүлүүдийг бэхжүүлэх ажилд оролцдог (4-р бүлэг-г үзнэ үү).

Тэрээр Нийгмийн Халамжийн Бүлгийн ажлын талаар ярилцах болон ажлаа тайлагнахын тулд бишоптой тогтмол уулздаг.

Тэрээр бишопын хүсэлтээр гишүүдийн гэрээр очиж халамжийн хэрэгцээнд нь үнэлгээ өгч, хариу арга хэмжээ авах арга замуудыг санал болгоно (9.6.1-ийг үзнэ үү). Хэрэв Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч байхгүй байгаа бол түүний зөвлөхүүдийн нэгийг Бишоп яаралтай хэрэгцээг шийдвэрлэх арга хэмжээ авах үүрэгт ажилд томилж болно.

Тэрээр Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид, багш нар болоод бусад дуудлагуудад дуудагдах эгч нарыг бишопын зөвлөлд санал болгоно. Тэрээр ийнхүү санал дэвшүүлэхдээ 19.1.1; 19.1.2 дахь удирдамжийг баримтална.

Онцгой байдлын үед тэрээр Нийгмийн Халамжийн Бүлгийн халамжийн үйл ажиллагааг зохицуулна.

Энэ гарын авлагыг эх сурвалж болгон ашиглаж, Нийгмийн Халамжийн Бүлгийн бусад удирдагчид, багш нарт үүргүүдийг нь заана.

Тэр тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн бүртгэл тайлан, төсөв, санхүүд хяналт тавина. Нийгмийн Халамжийн Бүлгийн нарийн бичиг энэ үүрэг хариуцлагад нь тусалдаг.

#### Тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч ба зөвлөхүүд

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч ба түүний зөвлөхүүд дараах үүрэг хариуцлагыг биелүүлэхийн төлөө хамтран ажиллана. Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч дээрх үүрэг хариуцлагуудын заримд нь хяналт тавиулахын тулд зөвлөхүүдээ томилдог.

Тэд айлчлагч багш нарыг зохион байгуулж, хариуцна.

Тойрог дахь энэрлийн үйлчлэлийг хариуцна.

Тэд Нийгмийн Халамжийн Бүлэг дэх сайн мэдээнээс суралцах, заах чанарыг сайжруулахад хяналт тавьдаг. Тэд энэ ажилд 5.5.3; 5.5.4 дэх зарчмуудыг баримтална.

Бишопын удирдлага дор халамжийн хэрэгцээг шийдвэрлэх арга замуудыг төлөвлөнө (9.6;6-р бүлэг-г үзнэ үү).

Тэд Нийгмийн Халамжийн Бүлгийн хурал цуглаануудыг төлөвлөж, хөтлөн явуулна.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлыг хийнэ.

Шаардлагатай бол Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нарын гэрээр очиж уулзана.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч тойрог дахь ганц бие насанд хүрсэн эгч нарт туслах ажлыг зохицуулахын тулд зөвлөхүүдийнхээ нэгийг томилно. Хэрэв тойрогт ганц бие залуу насанд хүрэгчдийн хороо байдаг бол уг зөвлөх тус хороонд үйлчилнэ. (16.3.3; 16.3.4-ийг үзнэ үү.)

### 9.2.3 Тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн нарийн бичиг

Нийгмийн Халамжийн Бүлгийн нарийн бичиг дараах үүрэг хариуцлагатай:

Тэрээр ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлын хөтөлбөр бэлтгэхдээ Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчтэй зөвлөлдөнө. Тэр эдгээр хуралд оролцож, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврын биелэлтийг мэдээлнэ.

Айлчлагч багш нарын зохицуулагч томилогдоогүй бол бишопт өгөх сар бүрийн айлчлагч багшийн тайланг Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчид зориулан гаргаж өгнө (9.5.4-ийг үзнэ үү). Тэрээр ирцийн тайланг улирал тутам гаргаж, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчтэй хянан хэлэлцсэний дараа тойргийн бичиг хэргийн ажилтанд өгнө.

Нийгмийн Халамжийн Бүлэгт дэвшин орж байгаа залуу эмэгтэйчүүдийг Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл нэг бүрчлэн мэддэг байхад тэрээр анхаарна.

Жил тутмын төсөв, зардлын тооцоо гаргахад тэрээр Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлд тусална.

### 9.2.4 Нийгмийн Халамжийн Бүлгийн багш нар

Нийгмийн Халамжийн Бүлгийн багш нар Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлөөр томилогдсоны дагуу хичээл заана. Ингэхдээ 5.5.4-т өгүүлсэн зарчмуудыг баримтална.

### 9.2.5 Тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн бусад дуудлагууд

Энэ хэсэгт нэмж болох дуудлагуудыг жагсаав. Бишоп ба Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч хоёр дуудлага бүрд хүн дуудах албагүй эсвэл шаардлагатай дуудлагуудыг нэмж гаргаж болно.

#### Айлчлагч багшийн зохицуулагч ба хянагч

Олон эмэгтэйчүүдтэй тойрогт айлчлагч багшийн ажлыг зохицуулж, энэ ажлыг үр өгөөжтэй явуулахад Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчид туслах нэг эгчийг дуудаж болно. Түүнээс гадна айлчлагч багшийн хянагч нь айлчлагч багшийн зохицуулагчид мэдээлэл цуглуулах болон энэ ажлыг зохицуулахад тусалж болно.

Айлчлагч багшийн зохицуулагч нь айлчлагч багш нарын гаргасан айлчлалтын болон бусад холбоо барилтын тайланг сар бүр айлчлагч багш нараас хүлээн авна. Айлчлагч багш нарын сар тутмын тайлан гаргахад туслалцуулахын тулд түүнийг томилж болно (9.5.4-ийг үзнэ үү).

#### Энэрлийн үйлчилгээг зохицуулагч ба туслах

Энэрлийн үйлчлэлийн хэрэгцээг тогтоох болон зохицуулахад Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлд туслахын тулд нэг эгчийг дуудаж болно. Туслахуудыг бас дуудаж болно.

#### Нийгмийн Халамжийн Бүлгийн хурлуудын зохицуулагч ба хороо

Ням гарагаас бусад үед болдог Нийгмийн Халамжийн Бүлгийн хурал цуглаануудыг төлөвлөх, зохицуулахад Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлд туслах нэг эгчийг дуудаж болно. Эдгээр цуглаан нь үйлчлэл, хичээл, төсөл, чуулган, сургалт семинар зэрэг байж болно. Зохицуулагчид туслах хорооны гишүүдийг дуудах хүсэлтийг Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл тавьж болно. Хорооны гишүүдэд тодорхой үүрэг хариуцлагыг даалгаж болно.

#### Нийгмийн Халамжийн Бүлгийн нарийн бичгийн даргын туслах

Нарийн бичигт үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд нь туслах нарийн бичгийн туслахыг дуудаж болно.

#### Ганц бие насанд хүрсэн залуу эгч нарын зөвлөгч

Ганц бие насанд хүрсэн залуу эгч нарын зөвлөгч нар ганц бие насанд хүрсэн залуу эгч нарт томилогдсон Нийгмийн Халамжийн Бүлгийн зөвлөхийн удирдлага дор ажиллана. Тэд насанд хүрсэн ганц бие залуу эгч нарт анхаарал тавьж, хүчирхэгжүүлдэг.

Зөвлөгч нарт дараах үүрэг хариуцлагуудаас алийг нь ч даалган хариуцуулж болно:

Тэрээр насанд хүрсэн ганц бие залуу эгчийн айчлагч багшийн хамтрагчаар үйлчилж болно.

Бас ганц бие залуу насанд хүрэгчдийн үйл ажиллагаануудад тусалж болно.

Тэрээр насанд хүрсэн ганц бие залуу эгч нарыг институтийн ангиуд болон шашны бусад хичээлүүдэд оролцохыг нь дэмжинэ.

Тойрогт ганц бие залуу насанд хүрэгчдийн хороо байдаг бол тэр энэ хороонд үйлчилнэ (16.3.4-ийг үзнэ үү).

Хэрэв тойрогт ганц бие залуу эгч нарт зориулсан Нийгмийн Халамжийн Бүлгийн анги байдаг бол тэр энэ ангид явж болно.

#### Хороод

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл нь хувь хүмүүс, гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэх, насанд хүрсэн ганц бие залуу эгч нарт анхаарал тавих, онцгой байдалд бэлтгэлтэй байх, халамж, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажил, номлолын ажил, хөрвөгчдийг идэвхтэй байлгах, идэвхжүүлэлт зэрэг байнга явагддаг ажлуудыг хариуцсан хороодыг байгуулж болно. Хороодын удирдагчид Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч буюу томилогдсон зөвлөхөд ажлаа тайлагнана. Хорооны гишүүдэд зарим үүрэг хариуцлагыг даалган хариуцуулж болно.

Нийгмийн Халамжийн Бүлгийн зорилгыг хэрэгжүүлэхэд тусалж, үйлчлэх боломжийг олон эгч нарт олгох үүднээс хороодыг нэмж байгуулж болно.

Зарим хороог богино хугацааны хэрэгцээг шийдвэрлэхийн тулд түр хугацаагаар байгуулж болно. Ийм хороодод үйлчилж байгаа эгч нарыг дуудаж, онцгойлон адислах шаардлагагүй. Урт хугацаагаар ажиллах хороодыг удирдах болон уг хороодод үйлчлэх эгч нарыг бишопын зөвлөлийн гишүүн дуудаж, онцгойлон адислах ёстой.

#### Хөгжмийн удирдаач ба төгөлдөр хуурчид

Тохиромжтой хөгжим нь Нийгмийн Халамжийн Бүлгийн хурал цуглаанууд дээр Ариун Сүнсийг урихад тусалдаг. Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл Нийгмийн Халамжийн Бүлгийн хурал цуглаанууд дээр хөгжмийн удирдагч, төгөлдөр хуурчаар үйлчлэх эгч нарыг нэр дэвшүүлж болно.

## 9.3 Удирдлагын хурал

### 9.3.1 Тойргийн Зөвлөлийн хурал

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч тойргийн зөвлөлийн гишүүнээр үйлчилдэг (4-р бүлэг-г үзнэ үү).

Шаардлагатай бол халамжийн нууц асуудлуудыг хэлэлцэх, гэрийн болон айлчлагч багшийн ажил үүргийг зохицуулахын тулд бишоп Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийг тойргийн санваартны гүйцэтгэх хорооны зарим цуглаанд оролцуулахаар урьж болно.

### 9.3.2 Тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл нь ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлыг тогтмол хийнэ. Ерөнхийлөгч цуглаан дээр тэргүүлж, хурлыг хөтлөн явуулна. Нарийн бичиг оролцож, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврын биелэлтийг мэдээлнэ.

Хурлын хөтөлбөрт дараах асуудлууд орж болно:

1. Нийгмийн Халамжийн Бүлгийн ажилд эгч нарыг зохион байгуулах, тэдэнд заах, сүнслэгээр нөлөөлөх арга замуудыг авч хэлэлцэх.
2. Бишопын өгсөн зөвлөгөө, үүрэг даалгаврууд түүний дотор тойргийн зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгавруудын тухай ярилцаж, хэрэгжүүлэх арга замуудыг төлөвлөх.
3. Халамжийн хэрэгцээгээ шийдвэрлэхэд Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нарт болон тэдний гэр бүлүүдэд туслах арга замуудыг хэлэлцэх. Энд энэрлийн үйлчлэлийн тухай ярилцах нь орж болно.
4. Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нарт болон тэдний гэр бүлд анхаарал тавьж, бэхжүүлэх талаарх айлчлагч багш нарын ажлыг хэлэлцэн дүгнэлт өгөх. Нийгмийн Халамжийн Бүлгийн шинэ гишүүд, ганц бие насанд хүрсэн эгч нарын хэрэгцээнд онцгой анхаарал хандуулах.
5. Нийгмийн Халамжийн Бүлгийн ням гарагийн болон бусад хурал цуглаануудын хичээлийн үр дүнгийн тухай ярилцаж, сайжруулах төлөвлөгөө гаргах.
6. Нийгмийн Халамжийн Бүлгийн хурал цуглаануудыг төлөвлөх.
7. Нийгмийн Халамжийн Бүлэгт үйлчлэхээр дуудагдах эгч нарын тухай хэлэлцэж, бишопын зөвлөлд танилцуулах Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн саналыг бэлтгэх. Богино хугацаатай үүрэгт ажлуудад туслахыг эгч нараас хүсэх тухай ярилцана.

### 9.3.3 Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдлагын хурал

Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдлагын хурлыг жилд нэгээс хоёр удаа хийж болно. Тойргуудын Нийгмийн Халамжийн

Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл болон нарийн бичиг нар оролцоно. Нийгмийн Халамжийн Бүлгийн дуудлагатай бусад хүмүүсийг шаардлагатай бол урьж болно. 18.3.11-ийг үзнэ үү.

## 9.4 Тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн цуглаанууд

### 9.4.1 Нийгмийн Халамжийн Бүлгийн ням гарагийн цуглаанууд

Нийгмийн Халамжийн Бүлгийн ням гарагийн цуглаанаар Хожмын Үеийн Гэгээнтэн эмэгтэйчүүд итгэл болон хувийн зохистой байдлаа өсгөн нэмэгдүүлэх, гэр бүлүүдийг бэхжүүлэх, тусламж хэрэгтэй хүмүүст туслахад ашиг тустай сайн мэдээний сургаал, зарчмуудаас суралцдаг.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн ням гарагийн цуглааныг хөтлөн явуулна. Цуглаан бүр ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүний нээлтийн үг, сүмийн дуулал, залбирал мөн үйлчлэх боломжууд, ойртож байгаа үйл явдал, өвчтэй байгаа гишүүд болон шаардлагатай бусад мэдээллийн товч зарлалаар эхэлдэг. Ихэнх цагийг сайн мэдээний хичээлд зориулна. Цуглааныг сүмийн дуулал, залбирлаар төгсгөнө.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл дараах загварын дагуу ням гарагийн цуглааныг сар бүр төлөвлөн явуулна.

#### Эхний ням гараг

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн эхний ням гарагийн хичээлийг заана. Тэрээр судрууд, хожмын үеийн бошиглогчдын сургаал, Сүмийн зөвшөөрөгдсөн материалуудыг ашиглана.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд заах сэдвийг сонгохдоо Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийлнэ. Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч бишопоос эгч нарыг ямар сэдвүүдийн талаар ярилцах хэрэгтэй байгаа талаар асууж болно. Сэдвүүдэд сайн мэдээн дэх эмэгтэйчүүдийн үүрэг хариуцлага, гэрлэлт болон гэр бүлүүдийг бэхжүүлэх, айлчлагч багш, үйлчлэл, номлолын ажил, хөрвөгчдийг идэвхтэй байлгах, идэвхжүүлэлт, сүнслэг ба материаллаг халамж, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажил, Нийгмийн Халамжийн Бүлгийн түүх ба зорилго байж болно. Эгч нарт гэрчлэлээ хуваалцах цагийг гаргаж өгч болно.

#### Хоёр, гуравдахь ням гараг

Хоёр, гуравдахь ням гарагийн хичээлийг Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн эсвэл Нийгмийн Халамжийн Бүлгийн багш заана. Тэрээр Нийгмийн Халамжийн Бүлгийн гарын авлагыг ашиглана. Хичээлүүдийг ерөнхийдөө гарын авлага дахь дэс дараалаар заах бөгөөд мөн тухайн ням гарагт ахлагч нарын чуулга, дээд пристүүдийн бүлгийн цуглаан дээр заадаг хичээлтэй сэдэв нь адилхан байна.

Тойрог дахь 18 болон түүнээс дээш настай бүх эмэгтэйчүүдийг (Нийгмийн Халамжийн Бүлгийн хичээлд оролцдоггүй байсан ч гэсэн) Нийгмийн Халамжийн Бүлгийн хувиараа судлах гарын авлагатай байх талаар уг бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл анхаарна. Хичээлд оролцогчдийг өөрсдийн гарын авлага болон судруудаа авчрахыг удирдагчид хүснэ.

#### Дөрөвдэх ням гараг

Дөрөвдэх ням гарагт хичээлийг Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн эсвэл Нийгмийн Халамжийн Бүлгийн багш заана. Багш хамгийн сүүлчийн ерөнхий чуулганы захиасуудыг ашиглана. Гадасны ерөнхийлөгч эсвэл бишоп заах захиасуудыг сонгоно.

#### Тавдахь ням гараг

Тавдахь ням гарагт заах сэдэв болон багшийг (ихэвчлэн тойргийн эсвэл гадасны гишүүн) бишоп сонгоно. Мөн тэрээр Мелкиседек Санваартнууд Нийгмийн Халамжийн Бүлэгтэй нэгдэх эсвэл тусдаа цуглахыг шийднэ. Шаардлагатай бол бишопын зөвлөл тойргийн Ням гарагийн ангийн нарийн бичгээр нэг ахыг дуудаж болно. Нарийн бичигт дараах ажлуудыг даалгаж болно.

### 9.4.2 Нийгмийн Халамжийн Бүлгийн бусад хурал цуглаанууд

Ням гарагийн цуглааны хичээлээс гадна Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар бусад цуглаануудад оролцож болно. Эдгээр хурал цуглаануудад үйлчлэл, хичээл, төсөл, чуулган, сургалт семинар орж болно. Эдгээр цуглаанаар эгч нар Нийгмийн Халамжийн Бүлгийн энэрэлийн болон бусад үүрэг хариуцлагуудаас суралцаж, тэдгээрийг хэрэгжүүлдэг. Тэд итгэл, хувийн зөв шударга байдлаа өсгөн нэмэгдүүлэх, гэр бүлээ бэхжүүлэх, гэр орондоо сүнслэг байх, тусламж хэрэгтэй хүмүүст туслах ур чадварт суралцаж амьдралдаа хэрэгжүүлдэг. Тэд арвич хямгач амьдрал, сүнслэг болон материаллаг аж

байдлын хувьд бие даах зарчмуудад суралцан, хэрэгжүүлдэг. Тэд мөн бие биедээ зааж, хамтран үйлчилснээр эгч дүүсэг ёсны харилцаа, эв нэгдлийг өсгөн нэмэгдүүлдэг.

Нийгмийн Халамжийн Бүлгийн бүх эгч нарыг түүний дотор Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн Хэсэгт үйлчилдэг хүмүүс болон Сүмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдоггүй эгч нарыг эдгээр цуглаандаа урьдаг. Эгч нар өөр шашинтай найз нараа бас урьж болно.

Гэхдээ эдгээр хурал цуглаанд заавал оролцох ёстой гэж эгч нарт бодогдуулах ёсгүй.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч Нийгмийн Халамжийн Бүлгийн бүх хурал цуглаанд хяналт тавина. Тэрээр энэ үүрэг хариуцлагынхаа дагуу хурал цуглаанууд нь тойрог дахь хувь хүмүүс болон гэр бүлүүдийн хэрэгцээг хангахад хэрхэн тусалж болохыг бишоптой тогтмол зөвлөлдөж байна.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч хурал цуглаануудад хяналт тавьдаг ч бүгдэд нь оролцох шаардлагагүй. Гэвч Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүн цуглаан болгонд заавал оролцох ёстой.

### Хурал цуглаануудын давтамж ба хурал цуглааныг хийх газар

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл Нийгмийн Халамжийн Бүлгийн бусад хурал цуглаануудыг хэр зэрэг олон удаа, хаана хийж байхыг залбирч хэлэлцэнэ. Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч гаргасан шийдвэрээ бишопоор батлуулах хэрэгтэй.

Эдгээр хурал цуглаануудыг ихэвчлэн ням болон даваа гарагийн оройгоос бусад цагт хийдэг. Хурал цуглаануудыг ерөнхийдөө сар бүр хийдэг ч, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл тэдгээрийг үүнээс олон, эсвэл цөөн хийж байхыг санал болгож болно. Гэвч хамгийн цөөндөө улиралд нэг удаа заавал цуглаж байх ёстой.

Бусад хурал цуглаануудын давтамж, хийх газар, үргэлжлэх хугацааг бишоп болон Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч хоёр эгч нарын цагийн боломж, гэр бүлийн нөхцөл байдал, хуралд ирэхэд хэр хол зам туулах, унааны үнэ, тойргоос гарах зардал, аюулгүй байдал болон орон нутгийн бусад нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэнэ.

### Хурлыг төлөвлөх.

Эгч нар болон тэдний гэр бүлийг бэхжүүлэх хичээлийн сэдэв болон хамгийн сайн заах арга замуудын тухай Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид залбирч, хамтран зөвлөлдөнө.

Нийгмийн Халамжийн Бүлгийн бүх хурал цуглааны төлөвлөгөөг бишоп баталсан байхыг Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч анхаарна. Бүх төлөвлөгөө нь 13-р бүлэг дэх удирдамжийн дагуу байх ёстойг тэрээр анхаарна.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч эдгээр бүх цуглаанд хяналт тавих хэдий ч цуглаануудыг төлөвлөх, хариуцан явуулах үүрэг хариуцлагыг нэг эсвэл хоёрдугаар зөвлөхдөө даатгаж болно. Тэр энэ үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэх Нийгмийн Халамжийн Бүлгийн цуглааны зохицуулагчаар өөр нэг эгчийг дуудлагад санал болгож болно (9.2.5-ыг үзнэ үү).

Хурал нь нэг сэдэв дээр төвлөрөх эсвэл хуралд оролцогсдыг нэгээс дээш хэсэгт хувааж болно. Ерөнхийдөө багш нар нь тойргийн буюу гадасны гишүүд байх ёстой. Нийгмийн Халамжийн Бүлэг үндэслэн байгуулагдсаны ойгоор жил бүр нэг хурал зохион байгуулж, бүлгийн түүх, зорилго дээр анхаарал төвлөрүүлэн хийж болно.

Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид эдгээр хурал цуглааныг төлөвлөхдөө орон нутгийн хэрэгцээг шийдвэрлэхэд туслахын тулд бишопын сонгосон сэдвүүдэд онцгойлон анхаарлаа хандуулна. Удирдагчид дараах сэдвүүдэд тэргүүн зэргийн ач холбогдол өгөх ёстой:

*Гэрлэлт ба гэр бүл:* гэрлэлт, гэр бүл болоход бэлтгэх, гэрлэлтийг бэхжүүлэх, эх хүн болох, үр хүүхдэдээ багаас нь боловсрол хүмүүжил олгох, хүүхэд залуучуудыг ирээдүйн үүрэг хариуцлагад нь бэлтгэх, гэр бүлийн үдэшт бэлтгэхийг нь урамшуулан дэмжих, хамаатнуудтайгаа харилцаагаа сайжруулан, бэхжүүлэх.

*Гэр ахуй:* гэр орноо цэвэр, цэмцгэр, гоё сайхан авч явах, хоол унд хийх, хувцас хунар оёх зэргээр гэр орон гэр бүлдээ анхаарал халамж тавих чадварт суралцаж, уг чадвараа дээшлүүлэх.

*Бие даах чадвар ба арвич хямгач амьдрал:* санхүү (төсөв зохиож ашиглах, өр зээлгүй байх, ажилд ороход тавигддаг шаардлагуудыг хангасан байх); боловсрол, бичиг үсгийн чадвар (судруудыг судлах, сайн мэдээнээс суралцах, унших сурахыг бусдад заах, хүүхэд, залуучуудыг халамжлан хүмүүжүүлэх, хүүхдийн ном, зохиолыг сонгож авах, компьютер болон бусад технологийг ашиглах, соёлч ухамсрыг хөгжүүлэх); эрүүл мэнд (бие бялдрын эрүүл мэнд, чийрэгжилт, донтолтоос урьдчилан сэргийлэх болон ангижрах, нийгмийн болон сэтгэл санааны эрүүл мэнд, өвчлөлтөөс урьдчилан

сэргийлэх); хүнсний ногоо, жимс тарих; хүнс нөөцлөх, онцгой байдалд бэлтгэлтэй байх.

*Энэрлийн үйлчлэл:* өвчтэй хүмүүс, өндөр настнууд, гэрээс гарах боломжгүй болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ядуус, тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах, саяхан төрсөн нялх хүүхэдтэй эхчүүдэд туслах, хүмүүнлэгийн болон олон нийтийн тусламжийн үйл хэрэгт оролцох.

*Ариун сүмийн ба гэр бүлийн түүхийн ажил:* гэр бүлийн түүхийн мэдээлэл цуглуулж, хадгалах, гэр бүлийнхээ түүхийг бичих, ариун сүмд орохоор бэлтгэх болон ариун сүмийн ажил хийх.

*Сайн мэдээг хуваалцах:* гишүүдийн номлолын ажил, шинэ болон идэвх султай гишүүдтэй нөхөрлөх, хөршүүддээ хүрч ажиллах, идэвхжүүлэлт, шинэ эгч нарыг Нийгмийн Халамжийн Бүлэгт угтан авах, бүрэн цагийн номлолд бэлтгэх.

#### Хүүхдийн анги

Бага насны хүүхдүүдтэй эхчүүдийг ням гарагаас бусад өдөр болдог цуглаануудад оролцуулахын тулд хүүхдийн ангийг зохион байгуулж болно. Бишопын зөвшөөрлөөр Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл энэ ангид хичээл зааж, хяналт тавихыг Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нараас эсвэл тойргийн бусад гишүүдээс хүсч болно. Эгч нар хүүхдүүдэд хичээл заах бол Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл нь эгч нараар хичээлийг ээлжлэн заалгуулна. Ингэснээр бүх эгч нар цуглаандаа суух боломжтой болно. Хэрэв ангид эрэгтэйчүүд хичээл заах бол Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл 11.8.1 дэх удирдамжийг баримтална.

Хүүхдийн ангийн багш нар нас насанд нь тохирсон үйл ажиллагаануудыг төлөвлөж, Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын тухай хүүхдүүдэд заана. Тэд Хүүхдийн Хэсгийн гарын авлагууд, хүүхдэд заахад зориулсан Хүүхдийн Хэсгийн бусад материалуудыг ашиглаж болно.

Хэрэв хүүхдийн ангид идэх юм өгөх бол удирдагчид юуны өмнө хүүхэд бүрийн эцэг эхтэй зөвлөлдөж, чихрийн өвчин, харшилтай эсэхийг нь магадлана.

## 9.5 Айлчлагч багш

Айлчлагч багш нь бие биедээ анхаарал тавих, заах болон бие биеэ хүчирхэгжүүлэх боломжийг эмэгтэйчүүдэд олгоно. Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч айлчлагч багшаар дамжуулан эгч нарын болон тэдний гэр бүлийн урт, богино хугацааны хэрэгцээг тогтоож, шийдвэрлэхэд бишопт тусалдаг.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд нь айлчлагч багш нарт эгч нарыг бие биедээ анхаарал тавьж, халамжлан, санаа тавьж, бие биеэ хүчирхэгжүүлэх арга замуудын талаар заавар өгдөг. Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд энэ зааврыг сар бүрийн эхний ням гарагийн хичээлээр эсвэл Нийгмийн Халамжийн Бүлгийн бусад цуглаан дээр өгч болно.

Айлчлагч багш нарыг дуудаж, дэмжүүлж мөн адислахгүй.

### 9.5.1 Айлчлагч багш нарын үүрэг хариуцлага

Айлчлагч багш нар нь эгч бүртэй дотно танилцаж тэднийг итгэлээ бэхжүүлэхэд нь тусалж, үйлчлэл үзүүлдэг. Заах эгч бүрийнхээ сүнслэг болон материаллаг хэрэгцээнд хэрхэн туслахаа мэдэхийн тулд тэд сүнсний удирдамжийг эрэлхийлнэ.

Айлчлагч багш нар эгч бүрийн хэрэгцээ, нөхцөл байдлыг харгалзан, томилогдсон эгч нартай тогтмол (боломжтой бол сард нэг удаа) харилцаатай байна. Айлчлагч багш нар биечлэн уулзах боломжгүй бол утсаар ярих, э-мэйл болон захидал явуулах зэргээр эгч нарт анхаарал тавьж, бэхжүүлэх бусад арга замыг ашиглана.

Боломжтой үед айлчлагч багш нар сайн мэдээний захиасыг хуваалцана. Эдгээр захиасыг *Ensign*; *Лиахона* сэтгүүлд нийтлэгддэг айлчлагч багшийн сар тутмын захиасууд болон судруудаас авч болно.

Мөн айлчлагч багш нар нь өвчин зовлон, үхэл хагацал зэрэг бусад онцгой нөхцөл байдлын үед энэрэлийн үйлчлэл үзүүлдэг. Тусламж хэрэгтэй үед урт, богино хугацааны тусламжийг зохицуулахад Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчид тэд тусалдаг.

### 9.5.2 Айлчлагч багш нарыг зохион байгуулах нь

Бишоп болон Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл нь тойргийн айлчлагч багш нарыг зохион байгуулахдаа орон нутгийн хэрэгцээ, нөхцөл байдлыг залбиран авч хэлэлцсэний дараа шийднэ. Боломжтой бол ерөнхийлөгчийн зөвлөл эгч нарыг хоёр хоёроор нь хамтрагч болгон томилно. Айлчлагч багш нь эгч нэг бүрийг анхаардаг учраас Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагч нар айлчлагч

багшийн ажлыг хийлгэхдээ эмэгтэйчүүдийг бүлэг болгон зохион байгуулдаггүй.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийнхөн айлчлагч багшийн ажлыг зохион байгуулахдаа хувь хүн болон гэр бүлүүдийн хэрэгцээг залбиралтайгаар авч хэлэлцэнэ. Тэд Залуу Эмэгтэйчүүдээс Нийгмийн Халамжийн Бүлэгт дэвшиж байгаа болон ганц бие эгч нар, тойргийн шинэ гишүүд, саяхны хөрвөгчид, шинэхэн гэрлэсэн эгч нар, идэвх султай гишүүд ба тусгай хэрэгцээтэй бусад эгч нарт онцгой анхаарал хандуулна. Бас хэр хол амьдардаг, унааны асуудал, аюулгүй байдал зэрэг хүчин зүйлсийг харгалзаж үздэг.

Тэд эдгээр ярилцлага дээрээ тулгуурлан тойрог дахь эгч бүрд айлчлагч багш нарыг томилдог. Томилолт бүрд бишопын зөвшөөрөл авдаг.

Мелкизедек санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид онцгой тохиолдолд нөхөр, эхнэр хоёрыг бишопын зөвшөөрлөөр хамтрагч болгон томилж болно. Гэр бүлийн хос энэхүү айлчлалаа гэрийн болон айлчлагч багшийн үүргийг зэрэг гүйцэтгэсэн гэж илтгэнэ. Залуу эцэг эхчүүдэд энэ ажил үүргийг ихэвчлэн өгдөггүй. Энэ нь тэднийг хүүхдүүдээ харах үүргээс хөндийрүүлдэг.

### 9.5.3 Айлчлагч багшийн ажлыг орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх нь

Цөөн гишүүдтэй тойрогт ч удирдагчид илүү онцгой хэрэгцээтэй эгч нартай сар бүр заавал гэрээр нь очиж уулздаг байхаар айлчлагч багш нарыг зохион байгуулна.

Мелкизедек санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид бишопын зөвшөөрлөөр зарим гэр бүлд зөвхөн гэрийн багш эсвэл зөвхөн айлчлагч багшийг түр хугацаагаар томилж болно. Зарим тохиолдолд удирдагчид тухайн гэр бүлд гэрийн багш нарыг нэг сард нь мөн энэ гэр бүлийн Нийгмийн Халамжийн Бүлгийн эгчид айлчлагч багш нарыг дараагийн сард нь томилж болно.

Удирдагч нар номлолын ерөнхийлөгчөөс бүрэн цагийн номлогч эгч нарыг айлчлагч багшийн ажилд туслалцуулах зөвшөөрлийг зарим тохиолдолд хүсч болно. Номлолын ерөнхийлөгч энэ талаар гадасны ерөнхийлөгчтэй ярилцаж шийдвэрлэсний дараа гадасны ерөнхийлөгч бишопт мэдэгдэнэ. Ийм зөвшөөрөл өгсөн үед бүрэн цагийн номлогчдыг ихэвчлэн шинэ гишүүд, гэр бүлийн гишүүдийн зарим нь сүмийн гишүүн гэр бүлүүд болон идэвх султай гишүүдэд очиж заахаар томилдог.

### 9.5.4 Айлчлагч багшийн тайлан

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл эсвэл тэдэнд туслахаар дуудагдсан хүмүүс айлчлагч багш нараас сар бүр тайлан авахад тусална. Айлчлагч багш нар гэрээр нь очиж заадаг эгч нарынхаа хэрэгцээ, өөрсдийн үзүүлсэн үйлчлэлийн тухай тайлагнана. Түүнээс гадна ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд эгч нарт тавих сүнслэг болон материаллаг хангамжийн тухай, тусламж хэрэгтэй хүмүүст туслах төлөвлөгөө боловсруулах тухай ярилцахын тулд айлчлагч багш нартай тогтмол уулзана. Хувийн чанартай мэдээллийг зөвхөн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчид мэдэгдэх ёстой. Тэрээр үүнийг бишопт илтгэнэ.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч айлчлагч багшийн сар тутмын тайланг бишопт өгнө. Холбоо тогтоож чадаагүй хүмүүсийн нэрсийг тайлан бүрд оруулах ёстой. Хэрэв хэн нэгэн эгч болон түүний гэр бүлд яаралтай хэрэгцээ гарсан бол Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч үүнийг бишопт тэр даруй мэдэгдэнэ.

## 9.6 Халамж болон энэрлийн үйлчлэл

Халамж болон энэрлийн үйлчлэл нь Нийгмийн Халамжийн Бүлгийн гол ажил юм.

Тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл, ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл, дээд пристүүдийн бүлгийн удирдлага бишопын удирдлага дор дараах үүрэг хариуцлагуудыг хүлээнэ:

Тэд материаллаг болон сүнслэг байдлын хувьд бие даах чадварын зарчмуудыг заадаг.

Ядуус болон тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжилж, үйлчлэл үзүүлэхэд гишүүдийг дэмжинэ.

Тэд хувь хүмүүс, гэр бүлүүдэд бие даах чадвартай болох урт, богино хугацааны халамжийн асуудлуудын шийдлийг олоход тусална.

Халамжийн эдгээр үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй мэдээллийг 6-р бүлэг -с үзнэ үү.

Дараах хэсгүүдэд зөвхөн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч, түүний зөвлөхүүдэд холбогдох үүрэг хариуцлагын тухай өгүүлнэ.

### 9.6.1 Гэр бүлийн хэрэгцээг тодорхойлох айлчлал

Тусламж хэрэгцээтэй эгч нартай очиж уулзуулахаар бишоп Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийг ихэвчлэн томилдог.

Тэрээр тэдний хэрэгцээг тодорхойлж, ямар арга хэмжээ авах тухай санал болгож болно. Хэрэв түүний очих айлд эмэгтэй хүн байхгүй бол тэр зөвлөхүүдийнхээ нэгийг эсвэл нарийн бичиг, энэрлийн үйлчлэлийн зохицуулагчийн аль нэгийг дагуулж явна.

Гэр бүлийн хэрэгцээг тодорхойлох айлчлалд бэлтгэхийн тулд Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч бишопын даалгасан тухайн гэр бүлийн тухай мэдээллийг судалж, Их Эзэнээс удирдамж эрэлхийлнэ.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч тухайн гэр бүлийн нөөц боломжинд үнэлэлт өгч тэдний хүнс, хувцасны үндсэн хэрэгцээт зүйлсийн жагсаалт гаргаж бишопт өгнө. Бишопоор маягтыг хянуулж батлуулахын тулд Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч Bishop's Order for Commodities form (Бараа материал захиалах бишопын маягтыг) бэлтгэж өгч болно. Тэрээр тусламж авсан хүмүүст үйлчлэхдээ нэр төрийг нь хамгаалж, чин сэтгэлээсээ ойлгож тусална.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч уг гэр бүлийн байдлын тухай бишопт илтгэнэ. Тэрээр хүнс (хүнсний нөөц биш өдөр тутмын хүнсний хэрэгцээ), хувцас, амьдрал ахуй, эрүүл мэнд, нийгэм-сэтгэлзүйн байдлын бүх хэрэгцээний тухай илтгэнэ. Тэр уг гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэх чадвар, боломжийн талаарх өөрийн дүгнэлтийг хуваалцаж болно.

Уг гэр бүлд бие даах чадвараа хөгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажиллахад нь бишоп тусална. Мөн тусалж болох бусад арга замуудын талаар Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчтэй зөвлөлдөнө. Зарим тохиолдолд хамгийн хэрэгтэй тусламжинд (1) орлого, нөөц боломжоо зохицуулан ашиглахад нь туслах, (2) цэвэрлэгээ хийх, юм оёх, хоолны цэс гаргах, хоол хүнсээ даршилж нөөцлөх, эрүүл мэнддээ анхаарал тавих, эмх цэгцтэй байх зэрэг чадварыг зааж өгөх нь орж болно.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч болон түүнд тусалсан хэн ч гэсэн тусламж хэрэгтэй хүнтэй очиж уулзах үедээ олж авсан эсвэл бишопоос мэдсэн аливаа мэдээллийг чандлан нууцална.

### 9.6.2 Энэрлийн үйлчлэл

Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч бүр бусдын хэрэгцээг ойлгож мэдэрдэг байх үүрэгтэй юм. Тэд бусдад туслахын тулд өөрсдийн цаг зав, ур чадвар, авьяас билэгээ зориулж, сүнслэг болон сэтгэл санааны дэмжлэг үзүүлж, залбирлаар дэмждэг.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл нь айлчлагч багш нар болон тойрог дахь бусад гишүүдийн туслалцаатайгаар өндөр настай болсон, биеийн болон сэтгэцийн эмгэгтэй, тусламж яаралтай хэрэг болсон, хүүхэд төрүүлсэн, хүн нас барсан, хөгжлийн бэрхшээлтэй, ганцаардал болон бусад бэрхшээл сорилтын улмаас анхаарал халамж хэрэгтэй болсон хүмүүсийг олж тогтоодог. Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч мэдсэн зүйлээ бишопт мэдэгдэнэ. Тэрээр бишопын удирдлага дор тусламж үзүүлэх ажлыг зохицуулна. Бусдад туслах боломжтой нэгнийг олж тогтоохын тулд тэрээр бүх эгч нарын ур чадвар, нөхцөл байдлыг судалж тодорхойлно.

Тэрээр үйлчлэлийн эдгээр үйл ажиллагааг зохицуулахад туслахыг зөвлөх, энэрлийн үйлчлэлийн зохицуулагч болон айлчлагч багшаас хүсч болно. Мөн туслах хороог байгуулж болно. Эгч нар хоол хүнс, хүүхэд харах, бичиг үсгийн чадвараа дээшлүүлэхэд зарим эгч нарт туслах, эмчилгээ шаардлагатай болсон үед унаагаар хангах болон бусад хэрэгцээг шийдвэрлэхэд тусалж болно.

### 9.6.3 Бичиг үсгийн боловсрол

Уншиж бичих нь ажил олж хийх болон бие даах чадвараа хөгжүүлэхэд тусалдаг. Мөн сайн мэдээний мэдлэг, сүнслэг байдлын хувьд бие даахад чухал үүрэгтэй. Тойрог бүр хэрэгцээ, эх үүсвэртээ тохируулан бичиг үсгийн чадварыг дээшлүүлэх ажлыг хэрэгжүүлнэ. Гишүүдийн бичиг үсгийн мэдлэг дутмаг байгаа бол Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл бичиг үсгийн чадвараа дээшлүүлэхэд нь гишүүдэд туслах арга замуудыг тодорхойлох талаар бишоп болон тойргийн зөвлөлтэй хамтран ажиллана. Томилогдсон удирдагчид болон багш нар *Ye Shall Have My Words* товхимлыг агуулсан Сүмийн бичиг үсгийн чадварыг дээшлүүлэх суралцагчдын болон багшийн гарын авлагыг түүнчлэн багшийн сургалтанд зориулсан DVD-г ашиглаж болно. Түүнээс гадна Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид зарим цуглааныг бичиг үсгийн сургалтанд зориулж болно.

## 9.7 Нийгмийн Халамжийн Бүлгийн залуу эгч нарыг хүчирхэгжүүлэх нь

### 9.7.1 Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй хамтран ажиллах нь

Бага залуу наснаас насанд хүрсэн эмэгтэй хүн болж шилжих нь залуу эмэгтэйн амьдралд шийдвэрлэх чухал үе байдаг. Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй хамтран Нийгмийн Халамжийн Бүлэгт амжилттай шилжихэд нь залуу эмэгтэйчүүдэд туслах эцэг эхийн хүч чармайлтад дэмжлэг үзүүлэх арга замуудыг тодорхойлно.

Энэхүү хүч чармайлтад дараах зөвлөмжүүд тусалж болно:

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч Залуу Эмэгтэйчүүдийн ангид зочилж, бүлгийнхээ талаар танилцуулж болно.

Залуу эмэгтэйчүүд болон Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар Нийгмийн Халамжийн Бүлгийн хурал цуглаан, үйл ажиллагааг зарим үед хамтран явуулахаар төлөвлөж болно.

Гадасны ерөнхийлөгч зөвшөөрсөн үед мөн анги танхимын багтаамж боломжтой бол Залуу Эмэгтэйчүүд ба Нийгмийн Халамжийн Бүлгийн нэгдсэн нээлтийн ажиллагааг сар бүр нэг ням гарагт хийж болно. Залуу эмэгтэйчүүд болон Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар сайн мэдээнээс суралцах болон заах хангалттай цагтай байхын тулд Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл, Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл нээлтийн ажиллагааг сайн зохион байгуулагдсан, товчхон байхаар бодож төлөвлөнө. Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл, Лаурел ангийн ерөнхийлөгчийн зөвлөл хоёр нээлтийн ажиллагааг ээлжлэн хөтлөн явуулна.

Хувийн Хөгжил дэвшлээ дуусгахад нь дэмжлэг хэрэгтэй зарим залуу эмэгтэйчүүдэд туслахыг Нийгмийн Халамжийн Бүлгийн залуухан эгч нараас хүсч болно.

### 9.7.2 Ганц бие залуу насанд хүрсэн эгч нарын төлөө хүлээх үүрэг хариуцлага

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл нь ганц бие залуу насанд хүрсэн эгч нарт анхаарал тавих үүрэгтэй. Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид тус бүлгийн зорилгыг заах, Нийгмийн Халамжийн Бүлгийн ажилд оролцох боломжийг ганц бие залуу насанд хүрсэн эгч нарт олгодог. Тэд ганц бие залуу насанд хүрсэн эгч нарыг айлчлагч багшаар томилдог. Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид ганц бие залуу насанд хүрсэн эгч нарт үйлчлэх үр өгөөжтэй өөр боломжуудыг олгохын хамт Нийгмийн Халамжийн Бүлэгт үйлчлэх дуудлага хүлээн авахыг тэдэнд санал болгож болно.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл ганц бие залуу насанд хүрсэн эгч бүрд айлчлагч багш нарыг томилно. Ганц бие залуу насанд хүрсэн эгч эцэг эхтэйгээ хамт амьдардаг бол түүнд ганцааранд нь айлчлагч багш нар томилох эсвэл ээжийнх нь айлчлагч багш нар түүнд бас айлчлах уу гэдгийг Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл шийднэ.

### 9.7.3 Ганц бие залуу насанд хүрсэн эгч нарт зориулсан Нийгмийн Халамжийн Бүлгийн тусдаа явагддаг хичээл

Хангалттай тооны ганц бие залуу насанд хүрсэн эгч нар тойрогт хамрагддаг бол Нийгмийн Халамжийн Бүлгийн ням гарагийн хичээл болон зарим үйл ажиллагааг тэдэнд зориулан тусад нь зохион байгуулах зөвшөөрлийг бишоп өгч болно. Хэрэв тойргийн аль нэг эгч ганц бие залуу насанд хүрэгчдийн удирдагчаар үйлчилдэг бол (16.3.3-ыг үзнэ үү) тэрээр ангийн удирдагчаар үйлчилж болно. Хичээлийг ангийн гишүүд заадаг бөгөөд хичээлээ залуу эгч нарын хэрэгцээнд төвлөрүүлнэ. Тэд судрууд, хожмын үеийн бошиглогчдын сургаалууд болон Нийгмийн Халамжийн Бүлгийн зөвшөөрөгдсөн гарын авлагыг ашиглана.

## 9.8 Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдлага

### 9.8.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл

Гадасны ерөнхийлөгч гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийг хариуцна. Тэрээр Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч эсвэл ерөнхийлөгчийн зөвлөлтэй тогтмол (ихэвчлэн сар бүр) уулзаж, Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар болон тэдний гэр бүлүүдэд холбогдолтой асуудлуудын тухай зөвлөлдөж санваарын удирдлагаар хангадаг. Эдгээр асуудалд халамжийн тусламж, гадасны хэмжээнд эгч нарын хэрэгцээ ба өсөлт, Нийгмийн Халамжийн Бүлгийн хурал цуглаан, хичээл, үйл ажиллагаанууд орно.

Гадасны ерөнхийлөгчийн туслах бүлгүүдийн талаар хүлээдэг үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй мэдээллийг 15.1-ээс үзнэ үү.

### 9.8.2 Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл

Гадасны туслах бүлгүүдийн ерөнхийлөгч нарын үүрэг хариуцлагыг 15.4.1-д өгүүлсэн байдаг. Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл нь дараах үүрэг хариуцлагатай:

Тэд гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлагаар гадасны бүх эгч нарт зориулан Нийгмийн Халамжийн Бүлгийн нэг эсвэл хоёр цуглааныг жил бүр төлөвлөн явуулна. Эдгээр хурал цуглаанд үйлчлэл, хичээл, төсөл, чуулган, сургалт семинар орж болно. Эдгээр хурал цуглааны нэгийг Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий хуралтай холбогдуулан хийж болно. Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл шаардлагатай бол туслуулах хороодыг байгуулж болно.

Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд нь тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч нарт халамжийн зарчмуудыг болон халамжийн асуудлуудаар бишопт туслах талаар өөрсдийн үүргийг ойлгоход нь тусална.

Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд гадасныхаа ганц бие залуу насанд хүрсэн эгч нарт тусалдаг. Гадсанд ганц бие залуу насанд хүрэгчдийн хороо байдаг бол ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн уг хороонд үйлчилнэ (16.3.2-ыг үзнэ үү).

Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн халамжийн үйл ажиллагааг хариуцна. Тэрээр мөн онцгой нөхцөл байдлын үед гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн оролцоог зохицуулна.

### 9.8.3 Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн нарийн бичиг

Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн нарийн бичгийн үүрэг хариуцлагыг 15.4.2-д өгүүлсэн байдаг.

## 9.9 Нийгмийн Халамжийн Бүлгийг орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх нь

Дараах удирдамжууд нь Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийг орон нутгийн хэрэгцээнд нийцүүлэхэд тойрог, гадаснуудад тусална. Орон нутгийн хэрэгцээнд тохируулах тухай ерөнхий мэдээллийг 17-р бүлэг-с үзнэ үү.

### 9.9.1 Тойрог дахь нэгээс илүү Нийгмийн Халамжийн Бүлэг

Онцгой нөхцөлд бишоп болон гадасны ерөнхийлөгч нар тойрогт нэгээс илүү Нийгмийн Халамжийн Бүлэг байгуулах зөвшөөрөл өгч болно. Тойргийн нутаг дэвсгэр дээрээ асрамжийн байртай, ганц бие залуу насанд хүрэгчдийн, олон тооны ганц бие эхчүүд ба бэлэвсэн эмэгтэйчүүдтэй, тэрчлэн том нутаг дэвсгэртэй тойргууд онцгой нөхцөлд ордог. Нэгээс илүү Нийгмийн Халамжийн Бүлэг байгуулахын зорилго нь эгч нар болон тэдний гэр бүлд анхаарал халамж тавьж, бэхжүүлэхэд тус дөхөм үзүүлэх явдал юм.

Нэгээс илүү Нийгмийн Халамжийн Бүлэгтэй тойрогт Нийгмийн Халамжийн Бүлэг тус бүрийн удирдагчид гишүүддээ зориулсан Нийгмийн Халамжийн Бүлгийн бүрэн хөтөлбөрийг түүний дотор айлчлагч багшийн болон халамжийн хөтөлбөрийг зохион байгуулан хэрэгжүүлнэ. Нийгмийн Халамжийн Бүлэг бүрийн ерөнхийлөгч нь тойргийн зөвлөлийн хурлууд дээр адил тэгш эрхтэй байх бөгөөд халамжийн асуудлууд, эгч нар болон тэдний гэр бүлийг бэхжүүлэх асуудлаар бишоптой тус бүрдээ ажилладаг.

### 9.9.2 Жижиг нэгжүүдийн Нийгмийн Халамжийн Бүлэг

Жижиг тойрог болон салбарт Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл нь зөвхөн Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид, багш нараас бүрдэж болно. Бүр жижиг нэгжид Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч нь Нийгмийн Халамжийн Бүлгийн цорын ганц удирдагч байж болно. Боломжтой бол энэ бүлэгт дурьдсан дуудлагын жагсаалтан дахь зөвлөхүүд, нарийн бичиг, багш нар, бусад дуудлагуудад гишүүдийг дуудах хэрэгтэй.

Залуу Эмэгтэйчүүдийн болон Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчгүй маш жижиг салбарт Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч нь Залуу Эмэгтэйчүүдийн болон Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч дуудагдтал залуу эмэгтэйчүүд, хүүхдүүдэд хичээл заах ажлыг зохион байгуулахад эцэг эхчүүдэд тусалж болно.

Жижигхэн гадас, дүүрэгт Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч нь гадас буюу дүүргийн цорын ганц Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагч байж болно. Боломжтой бол зөвлөхүүд болон нарийн бичгийг дуудах нь зүйтэй.

## 9.10 Нэмэлт удирдамж ба журмууд

### 9.10.1 Тусгай хэрэгцээтэй эгч нар

Тусгай хэрэгцээтэй эгч нарт өвчтэй, өндөр настай, бэлэвсэрсэн, гэр бүл салсан, гэрээс гарах боломжгүй эсвэл хагацал үзсэн, хүнд өвчтэй гэр бүлийн гишүүнээ асардаг эгч нар орно. Нийгмийн Халамжийн Бүлгийн бусад гишүүд тэдэнд туслах үүрэгтэй.

Дээр дурдсан болон бусад тусгай хэрэгцээтэй эгч нар асуудлаа Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчид хандан тавьж болно. Тэрээр тэднийг анхааралтай сонсож, хайрлан, урам дэм өгч, нууцыг зохих журмын дагуу хадгална. Хэрэв тэрээр тухайн гэр бүлийн зохисгүй байдлын талаар болон өөр бусад эмзэг асуудлыг мэдвэл, тэр эгчийг бишоп уруу явуулна.

Хөгжлийн бэрхшээлтэй эгч нарт туслах тухай мэдээллийг 21.1.26 болон disabilities.lds.org-оос үзнэ үү.

### 9.10.2 Хувцаслалтын жишиг

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл үсээ засуулж, даруу хувцас өмсөж байхыг эгч нарт заана. Сүмийн цуглаанууд дээр эгч нарын гадаад төрх байдал болон хувцаслалт нь Их Эзэнийг хүндэтгэх хүндэтгэлийг харуулдаг гэдгийг эгч нар ойлгоход ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд тусална. Эгч нар ариун сүмд явахдаа Их Эзэний өргөөнд ороход тохиромжтой хувцас өмсөх ёстойг ойлгоход нь Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид тусална. Ийм үед тэд чөлөөт болон спортын хувцас өмсөх, хэт чамин үнэт эдлэл хэрэглэхээс зайлсхийх ёстой.

### 9.10.3 Хүн нас барсан үед тусламж үзүүлэх нь

Тойрогт хүн нас барсан үед уг гэр бүлийг тайтгаруулж, хэрэгцээг нь тогтоон, тусламж үзүүлэхийн тулд холбоо барихыг бишоп Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчөөс хүсч болно. Тэрээр мөн энэ талаар туслалцаа үзүүлэхийг ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч болон дээд пристүүдийн бүлгийн удирдагчаас хүсч болно. Мелкизедек санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид энэ ажлыг зохицуулна.

Оршуулгын ёслолын үед цэцэг авах, хоол бэлтгэх, хүүхэд харах, оршуулгын дараа гэр бүлийн гишүүдэд хоол хийж өгөх зэрэг үйлчлэл үзүүлэхийг бишоп Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчдаас хүсч болно. Оршуулгын тухай нэмэлт мэдээллийг 18.6-гаас үзнэ үү.

Боломжтой бол ариун сүмд хувийн хишгээ хүртсэн нас барсан гишүүдийг ариун сүмийн хувцсаар хувцаслаж оршуулах ёстой. Бишоп зарим тохиолдолд хувийн хишгээ хүртсэн, нас барсан эмэгтэй хүнийг зохих журмын дагуу хувцаслах буюу ийнхүү хувцаслахад хяналт тавихын тулд хувийн хишгээ хүртсэн эмэгтэй хүнийг томилохыг Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчөөс хүсч болно. Энэ үүргийг дургүйцэхгүй хүлээж авах хүнд өгөх талаар бишоп, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч хоёр анхаарах ёстой. Нас барсан гишүүдийг хувцаслах удирдамж *Хишиг хүртсэн бөгөөд нас барсан хүмүүсийг хувцаслах зааврууддад байдаг.* Удирдагчид эдгээр зааврыудыг Сүмийн Хангамжийн Төвөөс олж авч болно.

Нас барсан хүнийг ариун сүмийн хувцсаар хувцаслах тухай нэмэлт зааврыг бишоп *Гарын авлага 1-ийн* 3.4.9-өөс үзэж болно.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч, айлчлагч багш нар болон бусад эгч нар ойр дотныхоо хүнийг алдан гашуудаж байгаа гэр бүлд дэмжлэг, тайтгарал, тусламж үзүүлэхээ үргэлжлүүлсээр байдаг.

### 9.10.4 Гэрлэхээс өмнө жирэмсэлсэн болон хүүхэдтэй болсон залуу эмэгтэйчүүд

10.12.4-ийг үзнэ үү.

### 9.10.5 Ариун сүмийн хувцас ба гарментийн тухай заавар

21.1.42-ыг үзнэ үү.

### 9.10.6 Санхүү

13.2.8-ыг үзнэ үү.

9. Нийгмийн Халамжийн Бүлэг

# 10. Залуу эмэгтэйчүүд


10.1 **Залуу Эмэгтэйчүүдийн бүлгийн тухай ерөнхий мэдээлэл . . . 80**
10.1.1 Залуу Эмэгтэйчүүдийн бүлгийн зорилт ба зорилгууд . . . 80
10.1.2 Залуу Эмэгтэйчүүдийн амлалт . . . 80
10.1.3 Залуу Эмэгтэйчүүдийн уриа ба лого . . . 80
10.1.4 Залуу Эмэгтэйчүүдийн эрхэмлэх чанарууд . . . 81
10.1.5 Залуу Эмэгтэйчүүдийн ангиуд . . . 81

10.2 **Эцэг эхчүүд болон Сүмийн удирдагчдын үүрэг . . . 82**

10.3 **Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн удирдлага . . . 82**
10.3.1 Бишопын зөвлөл . . . 82
10.3.2 Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл . . . 83
10.3.3 Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн нарийн бичиг . . . 84
10.3.4 Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн зөвлөхүүд . . . 84
10.3.5 Залуу Эмэгтэйчүүдийн ангиудын ерөнхийлөгчийн зөвлөл . . . 84
10.3.6 Залуу Эмэгтэйчүүдийн ангиудын нарийн бичиг нар . . . 85
10.3.7 Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн үйл ажиллагааны зохицуулагчид . . . 85
10.3.8 Залуу Эмэгтэйчүүдийн хөгжмийн удирдагч ба төгөлдөр хуурч . . . 85

10.4 **Удирдлагын хурал . . . 85**
10.4.1 Тойргийн Зөвлөлийн хурал . . . 85
10.4.2 Бишопын зөвлөлийн Залуучуудын хорооны хурал . . . 85
10.4.3 Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал . . . 85
10.4.4 Бишопын зөвлөхтэй уулзах нь . . . 86
10.4.5 Ангиудын ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал . . . 86
10.4.6 Гадасны Залуу Эмэгтэйчүүдийн удирдлагын хурал . . . 86

10.5 **Жишгүүд . . . 86**

10.6 **Сайн мэдээний ням гарагийн хичээл . . . 87**
10.6.1 Нээлтийн ажиллагаа . . . 87
10.6.2 Ангиуд . . . 87

10.7 **Хувийн хөгжил дэвшил . . . 87**
10.7.1 Мючел дээр хийх хувийн хөгжил дэвшлийн үйл ажиллагаа . . . 87
10.7.2 Эмблем, гэрчилгээ ба шагнал . . . 88
10.7.3 Хувийн хөгжил дэвшлийн талаар удирдагчдын хүлээх үүрэг хариуцлага . . . 88

10.8 **Үйл ажиллагаа ба үйл явдлууд . . . 88**
10.8.1 Мючел . . . 88
10.8.2 Залуучуудтай хийх Бишопын зөвлөлийн хэлэлцүүлэг . . . 89
10.8.3 “Шинэ эхлэл” үйл ажиллагаа . . . 89
10.8.4 Онцгой амжилт гаргасан залуу эмэгтэйчүүд . . . 90
10.8.5 Жишгийн үйл ажиллагаа . . . 90
10.8.6 Залуу Эмэгтэйчүүдийн аялал зуслан . . . 90
10.8.7 Гадасны болон гадас дундын үйл ажиллагаанууд . . . 90
10.8.8 Залуучуудын чуулган . . . 90
10.8.9 Үйл ажиллагаа ба үйл явдлуудыг санхүүжүүлэх нь . . . 90

10.9 **Удирдах ур чадварыг заах нь . . . 91**

10.10 **Гадасны Залуу Эмэгтэйчүүдийн удирдлага . . . 91**
10.10.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл . . . 91
10.10.2 Гадасны Залуу Эмэгтэйчүүдэд томилогдсон дээд зөвлөлийн гишүүн . . . 91
10.10.3 Гадасны Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл . . . 91
10.10.4 Гадасны Залуу Эмэгтэйчүүдийн нарийн бичиг . . . 91
10.10.5 Гадасны Аароны санваартнууд–Залуу Эмэгтэйчүүдийн хороо . . . 91
10.10.6 Гадасны Залуу Эмэгтэйчүүдийн үйл ажиллагааны зохицуулагчид . . . 91

10.11 **Залуу Эмэгтэйчүүдийн бүлгийг орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх нь . . . 92**

10.12 **Нэмэлт удирдамж ба журмууд . . . 92**
10.12.1 14-өөс доош насны залуучууд Залуучуудын чуулган ба бүжигт оролцох тухай . . . 92
10.12.2 Өөр шашинтай залуу эмэгтэйчүүд . . . 92
10.12.3 Хөгжлийн бэрхшээлтэй залуу эмэгтэйчүүд . . . 92
10.12.4 Гэрлэхээс өмнө жирэмсэлсэн болон хүүхэдтэй болсон залуу эмэгтэйчүүд . . . 92

# 10. Залуу эмэгтэйчүүд

Залуу Эмэгтэйчүүдийн бүлэг бол санваартнуудад туслах бүлэг юм. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ болон сэргээгдсэн сайн мэдээний тухай гэрчлэлээрээ өсч хөгжихөд нь Сүмийн гишүүдэд туслахын тулд нийт туслах бүлгүүд оршиж, үйл ажиллагаа явуулдаг. Гишүүд сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрахыг хичээн чармайхдаа туслах бүлгүүдийн ажлаар дамжуулан заавар, дэмжлэг авдаг.

## 10.1 Залуу Эмэгтэйчүүдийн бүлгийн тухай ерөнхий мэдээлэл

### 10.1.1 Залуу Эмэгтэйчүүдийн бүлгийн зорилт ба зорилгууд

Залуу Эмэгтэйчүүдийн бүлгийн зорилго бол нандин гэрээнүүд байгуулж, ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахуйц зохистой байхад нь залуу эмэгтэй бүрд туслах явдал юм. Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчид энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхэд залуу эмэгтэй бүрийг удирддаг:

1. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт итгэх итгэл болон тэдний тухай гэрчлэлийг нь хүчирхэгжүүлэх.
2. Бурханы охин гэдгээ ойлгодог байх.
3. Зарлигуудыг дуулгавартай дагаж, сайн мэдээний жишгүүдээр амьдарснаар зохистой байх.
4. Ариун Сүнсний өдөөлтийг танин, хүлээн авч, итгэл найдвар тавьдаг байх.
5. Залуу эмэгтэй, эхнэр, эх, удирдагч байх тэнгэрлэг үүрэгтээ бэлтгэх.
6. Баптисмын гэрээнүүдээ ойлгож, сахидаг байх.

### 10.1.2 Залуу Эмэгтэйчүүдийн амлалт

Залуу Эмэгтэйчүүдийн амлалт нь дээр жагсаасан зорилтуудыг хэрэгжүүлэхэд залуу эмэгтэй бүрд туслах үндсэн үүрэгтэй.

Залуу эмэгтэйчүүд болон насанд хүрсэн тэдний удирдагчид ням гарагийн цуглааны эхэнд бас Залуу Эмэгтэйчүүдийн бусад цугларалт бүр дээр энэ амлалтаа давтан хэлдэг. Эцэг эхчүүд, асран хамгаалагчид Parental or Guardian Permission and Medical Release form (Эцэг эх, асран хамгаалагчид болон эмнэлгийн зөвшөөрөл) маягтад гарын үсэг зурснаар зөвшөөрөл өгдөг. Үйл ажиллагааг удирдаж байгаа хүн бичгээр зөвшөөрөл өгөх шаардлагатай үйл ажиллагаа бүрд оролцогч бүрээр энэ маягтад гарын үсэг зуруулна.

Бид Тэнгэрлэг Эцэгийн хайртай охид юм. Бид ч бас Түүнд хайртай. Бид Залуу Эмэгтэйчүүдийн эрхэмлэх чанарыг баримталснаар "ямар ч цагт мөн бүх зүйлд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн Бурханы гэрчлэгч болж зогсоно" (Мозая 18:9). Эдгээр эрхэмлэх чанар бол:

Итгэл

Тэнгэрлэг мөн чанар

Хувь хүний үнэ цэнэ

Мэдлэг

Сонголт ба хариуцлага

Сайн үйлс

Зарчимч байдал болон

Ариун журам юм.

Бид эдгээр эрхэмлэх чанарыг хүлээн зөвшөөрч, үүний дагуу үйлдсэнээр гэр орон болон гэр бүлээ бэхжүүлэх нандин гэрээнүүдийг байгуулж, сахих, ариун сүмийн ёслолуудыг хүлээн авах, өргөмжлөлийн адислалуудыг хүртэхэд бэлтгэгдэнэ гэдэгт итгэдэг.

### 10.1.3 Залуу Эмэгтэйчүүдийн уриа болон лого

Залуу Эмэгтэйчүүдийн уриа бол "Үнэн болон зөв шударгын төлөө зогсох" явдал юм.

Залуу Эмэгтэйчүүдийн лого нь Залуу Эмэгтэйчүүдийн уриагаар хүрээлэгдсэн бамбар юм. Бамбар нь залуу эмэгтэй бүрээр дамжин гэрэлтэх Христийн гэрлийг төлөөлдөг. "[Тэдний] гэрэл үндэстнүүдийн хувьд жишиг байж болохын тулд босч мөн урагш тэмүүлэхэд" (С ба Г 115:5) залуу эмэгтэйчүүдийг урьдаг.

### 10.1.4 Залуу Эмэгтэйчүүдийн эрхэмлэх чанарууд

Залуу Эмэгтэйчүүдийн эрхэмлэх чанарууд бол Христийнхтэй адил зан төлөв юм. Ням гарагийн сайн мэдээний хичээл, Мючел болон бусад үйл ажиллагаанууд эдгээр эрхэмлэх чанарыг амьдралдаа хэрэгжүүлэхэд залуу эмэгтэй бүрд тусална.

Дараах үгс болон судрын эшлэлүүд эрхэмлэх чанар бүрийн утгыг ойлгох түлхүүр болдог. Удирдагчид эдгээр үгсийг хичээлд ашиглах ёстой. Удирдагчид залуу эмэгтэйчүүдэд эдгээр үнэнийг амьдралдаа хэрэгжүүлж, хэлэх үг, заах хичээлдээ эх сурвалж болгон ашиглахыг дэмждэг.

Эрхэмлэх чанаруудтай холбоотой өнгүүд нь эрхэмлэх чанаруудыг санахад залуу эмэгтэйчүүдэд туслах ёстой.

*Итгэл (цагаан):* Би Тэнгэрлэг Эцэгийн хайртай охин. Би Түүний мөнхийн төлөвлөгөөнд итгэдэг. Энэ төлөвлөгөө миний Аврагч Есүс Христ дээр төвлөрдөг (Алма 32:21-ийг үзнэ үү).

*Тэнгэрлэг мөн чанар (цэнхэр):* Би тэнгэрлэг чанаруудыг өвлөн авсан. Энэ чанаруудаа би хөгжүүлэхийг хичээдэг (2 Петр 1:4–7-г үзнэ үү).

*Хувь хүний үнэ цэнэ (улаан):* Би өөрийн хязгааргүй үнэ цэнэтэй тэнгэрлэг ажлаа гүйцэлдүүлэхийг хичээх болно (С ба Г 18:10-ыг үзнэ үү).

*Мэдлэг (ногоон):* Би суралцах болон өсч хөгжих боломжуудыг байнга эрэлхийлнэ (С ба Г 88:118-ыг үзнэ үү).

*Сонголт ба хариуцлага (улбар шар):* Би сайныг хилэнцээс дээгүүр сонгох бөгөөд өөрийн шийдвэрүүдийн төлөө хариуцлага хүлээх болно (Иошуа 24:15 ыг үзнэ үү).

*Сайн үйлс (шар):* Би бусдад тусалж, зөв шударга үйлчлэлээр хаант улсыг байгуулах болно (3 Нифай 12:16-г үзнэ үү).

*Зарчимч байдал (ягаан):* Би зөв ба буруугг ялгах мэдлэгтэйгээр өөрийн үйлдлүүдэд тууштай байх ёс суртахууны зоригтой байна (Иов 27:5-ыг үзнэ үү).

*Ариун журам (алтан шар):* Би цэвэр ариун, зохистой байж, ариун сүмд ороход бэлтгэх болно. Миний санаа бодол, үйл хэрэг ёс суртахууны өндөр жишгүүд дээр суурилах болно (Сургаалт Үгс 31:10-ыг үзнэ үү).

### 10.1.5 Залуу Эмэгтэйчүүдийн ангиуд

Тойргийн залуу эмэгтэйчүүд насныхаа ялгаагаар гурван ангид хуваагддаг: Бийхайв (нас 12–13), Миа Мейдс (нас 14–15), Лаурел (нас 16–17).

Залуу эмэгтэй шинэ бүлэгт дэвшин ороход Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчид, ангийн ерөнхийлөгчийн зөвлөл нь баяр хүргэн угтаж авдаг.

#### Бийхайв, нас 12–13



Залуу эмэгтэйг 12 нас хүрэхэд бишоп түүнтэй ярилцлага хийдэг. Тэр Хүүхдийн Хэсгээс Залуу Эмэгтэйчүүдэд дэвшин орж, Хүүхдийн Хэсгийн хуваалцах цагийн үеэр Залуу Эмэгтэйчүүдийн цуглаануудад оролцож эхэлдэг (11.4.3-ыг үзнэ үү). Тэр Бийхайв ангийн гишүүн юм.

Сүмийн анхдагчдад бийхайв нь эв нэгдэл, хамтын ажиллагаа, ажил хөдөлмөрийн бэлгэдэл болдог байв. Сүмийн залуу эмэгтэйчүүд анх бүлэг болон зохион байгуулагдахад тэднийг Бийхайв (Зөгийн үүр) гэдэг байв.

Залуу эмэгтэйчүүд Бийхайв ангийн гишүүн байснаар Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт итгэх итгэлээ бэхжүүлэн бусадтай эв нэгдэлтэй байж, хамтран ажиллаж сурдаг. Энэ нь түүний хувьд үнэн ба зөв шударгын төлөө зогсож, "босч мөн урагш гэрэлтүүлэх"(С ба Г 115:5) цаг үе юм.

#### Миа Мейд, нас 14–15



Залуу эмэгтэй 14 нас хүрсэн үедээ Миа Мейд ангийн гишүүн болдог.

Миа гэдэг нэр томьёо Mutual Improvement Association (MIA) буюу Харилцан Сайжралтын Нийгэмлэг гэсэн утгатай бөгөөд нэг үе Сүмийн залуучуудын хөтөлбөрийн нэр байжээ. *Мейд* гэдэг үг залуу эмэгтэй гэсэн утгатай. Mutual Improvement Association сарнай цэцгийг байгууллагынхаа эмблем болгон авсан бөгөөд уг эмблем өнөөдөр Миа Мейдийн хайр, итгэл, цэвэр ариун байдлын бэлгэдэл болон үргэлжилж байгаа билээ.

Залуу эмэгтэйчүүд Миа Мейд ангийн гишүүн байснаар Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын тухай гэрчлэлээ бэхжүүлэн, Залуу Эмэгтэйчүүдийн эрхэмлэх чанаруудыг хүлээн зөвшөөрч, эдгээрийн дагуу үйлдэн, хайр, итгэл, цэвэр ариун байдалд суралцдаг.

#### Лаурел, нас 16–17



Залуу эмэгтэй 16 нас хүрсэн үедээ Лаурел ангийн гишүүн болдог.

Лаврын модны навч нь олон зууны туршид, ялангуяа титэм болгон сүлжсэн үед хүндэтгэл, амжилт бүтээлийн бэлгэдэл болсоор иржээ.

Залуу эмэгтэйчүүд Лаурел ангийн гишүүн болсноор ариун гэрээнүүд хийж сахих болон ариун сүмийн ёслолууд хүлээн авахад бэлтгэдэг.

#### 18 настай залуу эмэгтэйчүүд

Залуу эмэгтэй ихэвчлэн 18 нас хүрсэн үедээ эсвэл дараа жил нь Нийгмийн Халамжийн бүлэгт дэвшин ордог. Залуу эмэгтэй бүр 19 настайдаа Нийгмийн Халамжийн бүлэгт бүрэн хамрагдсан байх ёстой. Гэрчлэл, төлөвшилт, сургууль төгсөлт, үе тэнгийнхэнтэйгээ байх хүсэл, их сургуульд явдаг эсэх зэрэг хувь хүний нөхцөл байдлаас хамааран залуу эмэгтэй 18 хүрэхээсээ өмнө Нийгмийн Халамжийн Бүлэгт дэвшин орж болно, эсвэл Залуу Эмэгтэйчүүдийн бүлэгтээ илүү удаан хугацаагаар байж болно. Залуу эмэгтэй бүр Сүмийн үйл ажиллагаануудад идэвхтэй оролцогч байхын тулд түүнд аль анги нь хамгийн их тустай болохыг эцэг эх болон бишоптойгоо хамтран шийднэ.

Залуу Эмэгтэйчүүдийн болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид залуу эмэгтэй бүрийг Нийгмийн Халамжийн Бүлэгт амжилттай дэвшүүлэхийн төлөө хамтран ажиллана.

## 10.2 Эцэг эхчүүд болон Сүмийн удирдагчдын үүрэг

Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ бие бялдар, сүнслэг байдлын төлөө гол үүрэг хариуцлагыг хүлээдэг (С ба Г 68:25–28-ыг үзнэ үү). Бишопын зөвлөлийн гишүүд болон Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчид дээрх үүргээ биелүүлэхэд эцэг эхчүүдийг дэмжих боловч, тэднийг орлон ажиллах ёсгүй. Тэд дараах арга замуудаар дэмжлэг үзүүлнэ:

Охид нь 10.1.1-д жагсаасан удирдамжуудыг баримталснаар ариун сүмийн адислалуудыг авахад бэлтгэхэд эцэг эхчүүдэд туслах.

Залуу эмэгтэйчүүд тэдний эцэг эхийн хоорондын харилцааг урамшуулан дэмжих.

Залуу Эмэгтэйчүүдийн үйл ажиллагаа, залуучуудын бусад арга хэмжээ гэр бүлд нь эсвэл гэр бүлийн үйл ажилллагаанд нь ачаалал бий болгохгүй байхад анхаарах.

Сайн мэдээгээр амьдрахад нь хүчтэй дэмжлэг үгүйлэгддэг гэр бүлийн залуу эмэгтэйчүүдэд удирдагчид мэдрэмтгий хандах хэрэгтэй.

## 10.3 Тойргийн залуу эмэгтэйчүүдийн удирдлага

Энэ хэсэгт залуу эмэгтэйчүүд болон тэдний гэр бүлийг бэхжүүлэх арга замаар Залуу Эмэгтэйчүүдийн бүлгийг удирдах талаар онцлон өгүүлнэ. Удирдлагын ерөнхий зарчмуудын тухай өгүүлсэн 3-р бүлэг-г Залуу Эмэгтэйчүүдийн удирдлага байнга унших судлах хэрэгтэй. Эдгээр зарчимд сүнслэг байдлын хувьд бэлтгэх, хурал цуглаануудад оролцох, бусдад үйлчлэх, Есүс Христийн сайн мэдээг заах зэрэг орно.

### 10.3.1 Бишопын зөвлөл

Бишоп болон түүний зөвлөхүүд Залуу Эмэгтэйчүүдийн байгууллагыг санваарын удирдлагаар хангана. Тэд залуу эмэгтэй бүрд анхаарал тавьж, энэхүү хүч чармайлтдаа тэдний эцэг эх, Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчидтай нягт хамтран ажиллана.

#### Бишоп

Бишоп Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчөөр үйлчлэх эгчийг дуудаж, онцгойлон адисална. Тэрээр бас Залуу Эмэгтэйчүүдийн бусад удирдагчдыг дуудаж, онцгойлон адислахад хяналт тавих бөгөөд эдгээр удирдагчдыг дуудаж, онцгойлон адислахад зөвлөхүүдээ томилж болно.

Хувийн хөгжил дэвшлийн хөтөлбөрөө дуусгасан залуу эмэгтэй бүртэй бишоп ярилцлага хийнэ (10.7.3-ыг үзнэ үү).

#### Бишоп ба түүний зөвлөхүүд

Бишоп болон түүний зөвлөхүүд Залуу Эмэгтэйчүүдийн хурал цуглаан, үйлчлэл, үйл ажиллагаануудад тогтмол оролцоно. Бишоп Лаурел ангитай ажиллана. Тэрээр нэг зөвлөхөө Бийхайв ангитай, нөгөө зөвлөхөө Миа Мейд ангитай тус тус ажиллуулахаар томилно.

Бишоп нэг зөвлөхөө тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн бүлгийг хариуцуулахаар томилно. Энэ зөвлөх Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй тогтмол уулзаж байна. Тэрээр Залуу Эмэгтэйчүүдийн асуудлыг бишопын зөвлөлийн хурал дээр мэдээлж байна.

Бишоп залуу эмэгтэй бүртэй жилд нэг удаа заавал ярилцлага хийнэ. Боломжтой бол тэрээр 16, 17 настай залуу эмэгтэйчүүдтэй жилд хоёр удаа ярилцлага хийнэ. Ингэх боломжгүй бол эдгээр ярилцлагын заримыг хийлгэхээр зөвлөхөө томилно. 12-15 насны хоорондох залуу эмэгтэй бүр бишоптой жил тутмын ярилцлаганд орсноос хойш 6 сарын дараа ангид нь хяналт тавьдаг бишопын зөвлөхтэй ярилцлаганд орно.

Бишоп болон түүний зөвлөхүүд эдгээр ярилцлагыг хийхдээ *Гарын авлага 1-ийн* 7.1.7 дахь удирдамжийг баримтална. Тэд тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн нарийн бичгээс Young Women

Personal Progress Tracking Sheet for Leaders (Залуу эмэгтэйчүүдийн хувийн хөгжил дэвшилтэд хяналт тавих удирдагчдын маягт)-ыг авч үзэж болно.

Залуу эмэгтэй бүр Хүүхдийн Хэсгээс Залуу Эмэгтэйчүүдэд эсвэл насны шинэ бүлэгт дэвшин шилжихэд мөн Young Womanhood Recognition (Залуу эмэгтэйн гэрчилгээг) хүлээн авахад бишоп болон түүний зөвлөхүүд ариун ёслолын цуглаан дээр зарлан, хүлээн зөвшөөрдөг. Залуу эмэгтэй насны шинэ бүлэгт шилжихэд бишопын зөвлөлийн гишүүн түүнд гэрчилгээ өгнө.

Бишопын зөвлөлийн гишүүд ангиудын ерөнхийлөгчдөөр хэнийг дуудахыг шийдэхийн тулд хамт залбирна. Тэд удирдагчдыг дуудахдаа зөвхөн насны байдлаар эсвэл тухайн ангид хэр удсанаар нь сонгох ёсгүй. Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл ангиудын ерөнхийлөгчдөөр үйлчлэх залуу эмэгтэйчүүдийг санал болгож болно (19.1.1; 19.1.2-ыг үзнэ үү).

Бишопын зөвлөлийн гишүүн ангийн ерөнхийлөгчөөр үйлчлэх залуу эмэгтэйг дуудахдаа зөвлөхүүдээр болон нарийн бичгээр хэнийг дуудахаар санал болгохыг нь түүнээс асууна. Хэнийг санал болгох тухайд залбирч, Их Эзэнээс удирдамж эрэлхийлж, энэ үүрэг хариуцлагыг биелүүлэхийг бишопын зөвлөлийн гишүүн түүнд санал болгоно. Гэвч хэнийг дуудах талаар сүнсний удирдамж хүлээж авах эцсийн үүрэг хариуцлага бишопын зөвлөлд байдгийг ангийн ерөнхийлөгч ойлгоход бишопын зөвлөлийн гишүүн туслах ёстой.

Бишопын зөвлөлийн гишүүн дээрх дуудлагуудын алиныг нь ч залуу эмэгтэйд өгөхөөсөө өмнө эцэг эхээс нь зөвшөөрөл авна.

Дуудлагыг өгсний дараа бишопын зөвлөлийн гишүүн залуу эмэгтэйчүүдийг дэмжүүлэх санал авахаар ангид нь танилцуулна. Дараа нь бишоп буюу томилогдсон зөвлөх залуу эмэгтэйчүүдийг онцгойлон адисална. Бишопын зөвлөлийн гишүүн дуудлагыг ариун ёслол дээр зарлах боловч дэмжүүлэх санал авахгүй.

Ангиудын ерөнхийлөгчийн зөвлөлд өөрчлөлт оруулах шаардлага гарвал Залуу Эмэгтэйчүүдийн удирдагч бишопын зөвлөлтэй ярилцах хэрэгтэй.

### 10.3.2 Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл

Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл ерөнхийлөгч, хоёр зөвлөхөөс бүрддэг. Тэд бишопын зөвлөлийн удирдлага дор ажиллана. Тэд Гадасны Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлөөс сургалт болон байнгын дэмжлэг авдаг.

Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн бүр дараах байдлаар Залуу Эмэгтэйчүүдийн ангиудаас нэгийг нь хариуцан ажиллана:

Ерөнхийлөгч: Лаурел

Нэгдүгээр зөвлөх: Миа Мейд

Хоёрдугаар зөвлөх: Бийхайв

#### Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч дараах үүрэг хариуцлагуудтай:

Тойргийн зөвлөлийн гишүүнээр үйлчилнэ. Тэрээр энэ зөвлөлийн гишүүний хувьд итгэлийг төлөвшүүлж, хувь хүмүүс, гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэх ажилд оролцоно (4-р бүлэг-г үзнэ үү). Тэр бишопын зөвлөлийн залуучуудын хорооны гишүүн юм (18.2.9-ийг үзнэ үү).

Тэрээр Залуу Эмэгтэйчүүдийн бүлэгт үйлчлэхээр дуудагдах эгч нарыг бишопын зөвлөлд санал болгоно. Ийнхүү нэр дэвшүүлэхдээ 19.1.1; 19.1.2 дэх удирдамжуудыг баримтална.

Энэ гарын авлагыг эх сурвалж болгон ашиглаж, Залуу Эмэгтэйчүүдийн бусад удирдагчдад үүрэгт ажлыг нь заана.

Тэрээр тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн бүлгийн бүртгэл тайлан, төсөв, санхүүд хяналт тавина. Энэ үүрэг хариуцлагад нь Залуу Эмэгтэйчүүдийн нарийн бичиг тусалдаг.

#### Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч ба түүний зөвлөхүүд

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч болон түүний зөвлөхүүд дараах үүрэг хариуцлагуудтай:

Тэд залуу эмэгтэй бүрийг, тэдний авьяас чадвар, сонирхдог зүйлс, сорилт бэрхшээлийг сайн мэддэг байна. Залуу эмэгтэйчүүд нэг бүрийг хүчирхэгжүүлэх, гэрчлэлээрээ өсч хөгжихөд нь туслах, Залуу Эмэгтэйчүүдийн бүлгийн үйл ажиллагаанд оролцоход тэднийг урамшуулан дэмжинэ. Шинэ гишүүн болон идэвх султай залуу эмэгтэйчүүдийг тэд онцгой анхаарч ажиллахын хамт залуу эмэгтэй бүрийг гэр бүлийнхээ сайн гишүүн байхад дэмжинэ.

Тэд Хувийн хөгжил дэвшил дээрээ ажиллахад нь залуу эмэгтэйчүүдэд тусална. Бас тэд өөрсдөө Хувийн хөгжил дэвшил дээрээ ажиллахад дэмжлэг авдаг.

Залуу эмэгтэйчүүдийн хэрэгцээний талаар эцэг эхчүүд болон санваартны удирдагчидтай зөвлөлдөж болно.

Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн хөтөлбөрийг зохион байгуулж, зохих ёсоор үйл ажиллагааг нь явуулахад тэд анхаарна. Тэд энэ ажлын нэг хэсэг болгон Залуу Эмэгтэйчүүдийн зөвлөхүүд, зохицуулагчдад хяналт тавьж, заавар өгнө.

Тэд ням гарагийн хичээлийг олонтаа заадаг ч энэ үүрэг хариуцлагыг Залуу Эмэгтэйчүүдийн зөвлөхүүдтэй хуваалцаж болно. Залуу Эмэгтэйчүүдийн бүлэг дэх сайн мэдээнээс суралцах, заах чанарыг сайжруулахад хянана. Тэд үүнийг хийхдээ 5.5.3; 5.5.4 дэх удирдамжуудыг баримтална.

Тэд ангиудын ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлуудад сууж, шаардлагатай бол удирдамж чиглэл өгнө.

Үйл ажиллагаануудыг түүний дотор Мючелийн үйл ажиллагаануудыг төлөвлөж, хэрэгжүүлэхэд тэд ангиудын ерөнхийлөгчийн зөвлөлтэй хамтран ажиллана. Тэд залуу эмэгтэйчүүдийн дунд эв нэгдлийг бий болгоход ангиудын ерөнхийлөгчийн зөвлөлд тусална.

Тэд ангиудын ерөнхийлөгчийн зөвлөл болон Залуу Эмэгтэйчүүдийн бүлгийн бусад удирдагчдад удирдах ур чадваруудыг заана (10.9-ийг үзнэ үү).

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлыг хийнэ. Тэд Залуу Эмэгтэйчүүдийн бүлэгт хяналт тавьдаг бишопын зөвлөлийн гишүүнтэй тогтмол уулзаж байна.

### 10.3.3 Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн нарийн бичиг

Залуу Эмэгтэйчүүдийн нарийн бичиг дараах үүрэг хариуцлагуудтай:

Тэрээр ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлын хөтөлбөр бэлтгэхэд Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй зөвлөлдөнө. Тэрээр эдгээр хурлуудад оролцож, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврын биелэлтийг мэдээлнэ.

Ангиудын нарийн бичиг нарт заавар өгч, ирцийн бүртгэл хөтлөх талаар тэдний хийж байгаа ажлыг хариуцна. Улиралд нэг удаа ирцийн тухай мэдээллийг бэлтгэж, Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчтэй хянан хэлэлцэж, тойргийн бичиг хэргийн ажилтанд өгнө.

Бишопын зөвлөл, Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл цуглаануудад тогтмол оролцохгүй байгаа болон удахгүй Залуу Эмэгтэйчүүдийн өөр ангид дэвшин орох залуу эмэгтэйчүүдийг сайн мэддэг байхад тэрээр анхаарна.

Тэрээр Young Women Personal Progress Tracking Sheet for Leaders (Залуу эмэгтэйчүүдийн хувийн хөгжил дэвшилтэд хяналт тавих удирдагчдын маягт)-ыг ашиглан залуу эмэгтэйчүүд нэг бүр Хувийн хөгжил дэвшил болон бусад үйл ажиллагаануудад оролцож, удирдлагын дуудлагаа биелүүлэх явцад хэрхэн өсч хөгжсөнийг бүртгэн тэмдэглэнэ. Залуу эмэгтэйг бишопын зөвлөлийн гишүүнтэй ярилцлагад орохоор хуваарь гарсан үед нарийн бичиг залуу эмэгтэйн хяналтын маягтыг бишопын зөвлөлийн гишүүнд өгч болно.

Нарийн бичиг жил тутмын төсөв, зардлын тооцоо гаргахад Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлд тусална.

### 10.3.4 Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн зөвлөхүүд

Бишопын зөвлөл Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлд үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь туслахын тулд Залуу Эмэгтэйчүүдийн зөвлөхүүдийг дуудаж болно. Зөвлөх бүр залуу эмэгтэйчүүдийн насны аль нэг бүлэгтэй тус бүлэгт томилогдсон ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүний удирдлага дор ажиллана. Зөвлөхүүд дараах үүрэг хариуцлагатай:

Тэд үйл ажиллагаанууд, түүний дотор Мючелийг төлөвлөж, хэрэгжүүлэхэд Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл, ангиудын ерөнхийлөгчдөд туслахын хамтням гарагийн хичээлийг зааж болно. Тэд ангиудын ерөнхийлөгчдөд удирдлагын ур чадварыг зааж,

Хувийн хөгжил дэвшлийн хөтөлбөр дэх залуу эмэгтэйчүүд нэг бүрийн өсөлтийг бүртгэхэд тусалж болно.

Тэд уригдсан үедээ тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хуралд сууна.

### 10.3.5 Залуу Эмэгтэйчүүдийн ангиудын ерөнхийлөгчийн зөвлөл

Ангийн ерөнхийлөгчийн зөвлөл ихэвчлэн Залуу Эмэгтэйчүүдийн анги бүрд дуудагддаг. Цөөхөн залуу эмэгтэйтэй тойрог, салбарт залуу эмэгтэйчүүд тус тусын ангидаа зохион байгуулагдах хүртэл насны бүлгүүдийг нэгтгэн нэг ерөнхийлөгчийн зөвлөл дуудаж болно.

Ангиудын ерөнхийлөгчийн зөвлөл дараах үүрэг хариуцлагатай:

Ангийн гишүүдэд, ялангуяа шинэ гишүүд, идэвх сулгай, хөгжлийн бэрхшээлтэй буюу бусад тусгай хэрэгцээтэй эгч нарт анхаарал тавьж, нөхөрлөх. Тэдний төлөө залбирч, тэдэнтэй цагийг хамт өнгөрүүлэн, жинхэнэ найз нөхөд болох.

Ойр дотно харилцаа бий болгож, удирдлагын ур чадварт суралцан сайн мэдээгээр амьдрахад нь ангийн гишүүдэд туслах.

Ангийнхаа гишүүн болох нь сайхан байдгийг мэдэхэд залуу эмэгтэй бүрд туслах.

Хувийн хөгжил дэвшил хөтөлбөртөө амжилт гаргахад нь ангийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх.

Ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлыг тогтмол хийж байх.

Ангийнхаа ням гарагийн цуглаануудыг хөтлөн явуулах.

Үйл ажиллагаануудыг, түүний дотор Мючелийг төлөвлөхөд туслах.

Ангиудын ерөнхийлөгчид бишопын зөвлөлийн залуучуудын хороонд үйлчилдэг (18.2.9-ийг үзнэ үү).

### 10.3.6 Залуу Эмэгтэйчүүдийн ангиудын нарийн бичиг нар

Ангиудын нарийн бичиг нар дараах үүрэг хариуцлагатай:

Тэд ирцийн мэдээллийг бэлтгэж, хянан Залуу Эмэгтэйчүүдийн нарийн бичигт өгнө.

Ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлын хөтөлбөр бэлтгэхэд ангийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй зөвлөлдөнө. Тэд дээрх хурал цуглаануудад оролцож, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврын биелэлтийг хариуцна.

Үйл ажиллагаануудыг төлөвлөхөд ангиудын ерөнхийлөгчийн зөвлөл болон Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчдад тусална.

### 10.3.7 Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн үйл ажиллагааны зохицуулагчид

Тусгай үйл ажиллагаануудыг төлөвлөж хэрэгжүүлэхэд түр хугацаагаар үйлчлэх зохицуулагчдыг бишопын зөвлөл дуудаж болно. Жишээ нь, Залуу Эмэгтэйчүүдийн аялал зуслан, залуучуудын чуулган, спортын тоглолт зэрэг үйл ажиллагаануудад туслах зохицуулагчдыг дуудаж болно. Эдгээр зохицуулагчид тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор үйлчилдэг.

### 10.3.8 Залуу Эмэгтэйчүүдийн хөгжмийн удирдагч ба төгөлдөр хуурч

Бишопын зөвлөл Залуу Эмэгтэйчүүдийн хөгжмийн удирдагч, төгөлдөр хуурчийг дуудаж болно. Энэ дуудлагыг насанд хүрсэн эмэгтэй буюу залуу эмэгтэйд өгч болно.

Хөгжмийн удирдагч ням гарагийн нээлтийн ажиллагааны дууллуудыг сонгож, удирдана. Тэрээр дуу хөгжим сонгох, хөгжмийн авьяас чадвараа хөгжүүлэхэд залуу эмэгтэйчүүдэд тусална.

Төгөлдөр хуурч оршил, төгсгөл хөгжим тоглож, Залуу Эмэгтэйчүүдийн цуглаанууд дээр дууллуудыг дагаж тоглоно.

---

## 10.4 Удирдлагын хурал

### 10.4.1 Тойргийн Зөвлөлийн хурал

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч тойргийн зөвлөлийн гишүүнээр үйлчилдэг (4-р бүлэг-г үзнэ үү).

### 10.4.2 Бишопын зөвлөлийн Залуучуудын хорооны хурал

Бишопын зөвлөлийн залуучуудын хорооны хурлыг бишоп тэргүүлнэ. Энэ хороо бишопын зөвлөл, дээд пристүүдийн чуулгын бишопын туслахуудын нэг, багш нарын болон диконы чуулгуудын ерөнхийлөгч, Залуу Эмэгтэйчүүдийн ангиудын ерөнхийлөгч, Залуу Эрэгтэйчүүд ба Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчдөөс бүрддэг. Дэлгэрэнгүй мэдээллийг 18.2.9-өөс үзнэ үү.

### 10.4.3 Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлыг тогтмол хийнэ. Ерөнхийлөгч зөвлөлийн хурал дээр тэргүүлж, хурлыг хөтлөн явуулна. Нарийн бичиг цуглаанд оролцож, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврын биелэлтийг мэдээлнэ.

Хурлын хөтөлбөрт дараах асуудлууд орж болно:

1. 10.1.1-д жагсаасан зорилтуудыг залуу эмэгтэйчүүд анги бүрдээ хэрхэн биелүүлж байгаад үнэлэлт өгөх. Эдгээр зорилтыг илүү бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд залуу эмэгтэйчүүд нэг бүрд туслах арга замуудыг төлөвлөх.
2. Дуудлагатайгаа холбогдох судрын хэсгүүд, Сүмийн удирдагчдын зааврууддыг уншиж, ярилцах.

3. Ангиудын ерөнхийлөгчийн зөвлөлүүдэд ажил үүргийнх нь талаар заавар өгөх, төлөвлөгөө боловсруулах.
4. Залуу Эмэгтэйчүүдийн үйл ажиллагаануудын үр өгөөжийг ярилцах. Залуу Эмэгтэйчүүдийн эрхэмлэх чанаруудыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тэдэнд туслах үйл ажиллагаануудыг төлөвлөхөд залуу эмэгтэйчүүдийг оролцуулах арга замын талаар ярилцах.
5. Ням гарагийн хичээл дээр сайн мэдээг заах байдлыг ярилцаж, сайжруулах арга замуудыг төлөвлөх.
6. Ирцийн бүртгэлийг нэгтгэн дүгнэх. Шинэ гишүүд, идэвх султай залуу эмэгтэйчүүдэд сүмийн үйл ажиллагаанд оролцоход нь туслах арга замуудыг төлөвлөх.
7. Залуу Эмэгтэйчүүдийн төсөв, зардалд хяналт тавих.

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл шаардлагатай бол зөвлөхүүд, зохицуулагчдыг эдгээр хуралд урьж болно.

### 10.4.4 Бишопын зөвлөхтэй уулзах нь

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл Залуу Эмэгтэйчүүдийн бүлэгт хяналт тавьдаг бишопын зөвлөхтэй тогтмол уулзаж байна. Тэд эдгээр уулзалтаар залуу эмэгтэй нэг бүрийн өсөлт хөгжилт, хэрэгцээний талаар зөвлөлддөг. Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд тайлан бүртгэлээ өгч, санал тавин, хурал цуглаан, үйл ажиллагаануудын төлөвлөгөөг хянан хэлэлцдэг. Шаардлага гарсан үед бүртгэл тайлан өгөх, заавар авахын тулд Залуу Эмэгтэйчүүдийн зөвлөхүүд, ангиудын ерөнхийлөгчийн зөвлөлийг энэ цуглаанд урьж болно.

### 10.4.5 Ангиудын ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал

Анги бүрийн ерөнхийлөгчийн зөвлөл ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлыг тогтмол хийнэ. Ангийн ерөнхийлөгч хурлыг хөтлөн явуулна. Нарийн бичиг оролцож, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврын биелэлтийг мэдээлнэ. Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн, анги хариуцсан зөвлөх бас оролцоно.

Хурлын хөтөлбөрт дараах зүйлс орж болно:

1. Ангийн гишүүдийг түүний дотор шинэ болон идэвх султай гишүүдийг хүчирхэгжүүлэх арга замуудыг төлөвлөх. Бусад шашны залуу эмэгтэйчүүдтэй нөхөрлөх арга замуудыг төлөвлөх.
2. Үүрэг хариуцлагадаа холбогдох судрын хэсгүүд, Сүмийн удирдагчдын зааврууг уншиж, ярилцах.
3. Шаардлагатай бол ангийн гишүүдтэй гэрээр нь очиж уулзах ажлыг төлөвлөх.
4. Хувийн хөгжил дэвшлийн хөтөлбөртөө амжилт гаргахад залуу эмэгтэй бүрд туслах арга замуудыг ярилцах.
5. Ангийн хурал цуглаан, үйл ажиллагаануудыг төлөвлөх.
6. Бишопын зөвлөлийн залуучуудын хорооны хурлаар хэлэлцэх асуудлуудыг авч үзэх (18.2.9-ийг үзнэ үү).
7. Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчдаас удирдлагын сургалт авах.

### 10.4.6 Гадасны Залуу Эмэгтэйчүүдийн удирдлагын хурал

Гадасны Залуу Эмэгтэйчүүдийн удирдлагын хурлыг жилд нэг юм уу хоёр удаа хийнэ. Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд, нарийн бичиг нар оролцоно. Зөвлөхүүд, зохицуулагчид, Залуу Эмэгтэйчүүдэд томилогдсон бишопын зөвлөлийн гишүүнийг шаардлагатай бол урьж болно. 18.3.11-ийг үзнэ үү.

## 10.5 Жишгүүд

Жишгүүд Сүмийн гишүүдийг бэхжүүлж, удирдах бат найдвартай удирдамжаар хангадаг. Залуу эмэгтэйчүүд сайн мэдээний жишгүүдийг сахиснаар Сүмд болон дэлхийд агуу үйлчлэл үзүүлэх болно. Бас ариун сүмийн адислалуудыг авахуйц зохистой байх болно.

*Залуучуудын бат бөх байдлын* төлөө товхимолд Тэргүүн Зөвлөл сайн мэдээний жишгүүдийг тогтоож, жишгүүдийг амьдралд хэрхэн хэрэгжүүлэхийг залуучуудад заасан юм. Залуу эмэгтэй бүр *Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимолтой байх ёстой.*Тэрээр жишгүүдийг байнга уншиж судлан, эдгээр жишгээр амьдрах нь хэчнээн тустай болохыг ойлгодог байх ёстой.

Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчид томхимол дахь жишгүүдийг судалж, тэдгээрийг дагаж мөрдөх талаар өөрсдөө үлгэр жишээ үзүүлдэг байх ёстой. Тэд эдгээр жишгийг хичээл, Мючелийн үйл ажиллагаа, аялал зуслан, залуучуудын чуулган, бусад үйл ажиллагаанууд дээр заах, бататгах арга замуудыг олох ёстой.

Эцэг эхчүүд сайн мэдээний жишгүүдийг судалж, баримтлах талаар үлгэр жишээ үзүүлж, жишгүүдийн тухай охидтойгоо ярилцаж

байхыг бишопын зөвлөлийн гишүүд, Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчид дэмжих хэрэгтэй. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлыг гэр бүлийн үдшийн хичээл, хэлэх үгэнд эх сурвалж болгон ашиглахад залуу эмэгтэйчүүдийг дэмжих хэрэгтэй.

## 10.6 Сайн мэдээний ням гарагийн хичээл

Залуу эмэгтэйчүүд сайн мэдээний мэдлэгээ дээшлүүлж, сайн мэдээ тэдний өдөр тутмын амьдралын асуудлуудад хэрхэн хариулдгийг мэдэхийн тулд, Ариун Сүнсийг мэдэрч гэрчлэлээ бэхжүүлэн, хуваалцахын төлөө ням гараг бүр цугладаг.

### 10.6.1 Нээлтийн ажиллагаа

Боломжтой бол ням гарагийн хичээлийн өмнө залуу эмэгтэйчүүд бүгдээрээ нийлж нээлтийн ажиллагааг товчхон явуулах хэрэгтэй. Тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл цуглааны энэ хэсэгт хяналт тавьж, ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүн цуглааныг хөтлөн явуулдаг.

Нээлтийн ажиллагаагаар удирдагчид дараа нь үргэлжлэх хичээлд Сүнсийг урих уур амьсгалыг бий болгодог. Нээлтийн ажиллагаанд уттан авалт, сүмийн дуулал, залбирал, Залуу Эмэгтэйчүүдийн амлалтыг цээжээр хэлэх болон зарлал орно.

Гадасны ерөнхийлөгч зөвшөөрсөн үед Залуу Эмэгтэйчүүд, Нийгмийн Халамжийн Бүлэг сард нэг удаа ням гарагт нийлж нээлтийн ажиллагааг хийж болно (9.7.1-ийг үзнэ үү).

### 10.6.2 Ангиуд

Нээлтийн ажиллагааны дараа залуу эмэгтэйчүүд сайн мэдээний хичээлдээ цугладаг. Залуу Эмэгтэйчүүдийн хичээл ихэвчлэн насны бүлгүүдээр тусдаа явагддаг. Гэвч шаардлагатай бол удирдагчид дараах хувилбаруудыг авч үзэж болно:

1. Олон залуу эмэгтэйчүүдтэй тойрогт насны бүлгээр нэгээс олон анги зохион байгуулж, анги бүрд зөвлөх, ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийг дуудаж болно.
2. Цөөхөн залуу эмэгтэйчүүдтэй тойрог буюу салбарт насны бүлгүүд ням гарагийн хичээлийг нийлж хийх бөгөөд зөвлөхүүд шаардлагагүй байж болно.
3. Ямар ч тойрогт бүх залуу эмэгтэйчүүд нэгдсэн хичээлийг сард нэг удаа хамтран хийж болно.

Хичээлийг ихэвчлэн Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд буюу Залуу Эмэгтэйчүүдийн зөвлөхүүд заадаг. Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд, зөвлөхүүд шаардлагатай бол энэ үүрэг хариуцлагыг хуваалцаж болно. Залуу эмэгтэйчүүд хичээл заахад тусалж болно. Залуу эмэгтэй хичээл заасан үед Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл эсвэл зөвлөх хичээлд бэлтгэхэд нь тусална. Санваартны удирдагчид, тойргийн итгэлтэй бусад гишүүдийг хичээл заалгахаар урьж болно. Хичээл заах хүмүүс 5.5.4 дэх зарчмуудыг баримтлах ёстой.

Удирдагчид залуу эмэгтэй бүрийг судруудаа авчрахыг дэмжинэ. Мөн хичээлд шаардлагатай Сүмийн зөвшөөрөгдсөн бусад материалуудыг авчирч байхыг удирдагчид залуу эмэгтэйчүүдээс хүсч байна.

Залуу эмэгтэйчүүд, залуу эрэгтэйчүүд бишопын зөвлөлийн чиглүүлснээр заримдаа хамт цуглаж болно.

## 10.7 Хувийн хөгжил дэвшил

Хувийн хөгжил дэвшил бол Есүс Христийн тухай гэрчлэлээ бэхжүүлж, ирээдүйн үүрэгтээ бэлтгэх, ариун сүмд ариун нандин гэрээнүүд хийхээр зохистой байж, гэрээнүүдээ сахихаар бэлтгэхэд нь залуу эмэгтэйчүүдэд туслах зорилготой өсөлт хөгжлийн хөтөлбөр юм.

Хөтөлбөрийн зорилгуудыг *Young Women Personal Progress*-номонд өгүүлсэн байдаг. Залуу эмэгтэйчүүд Залуу Эмэгтэйчүүдийн эрхэмлэх чанарууд дээр тулгуурласан зорилгууд дэвшүүлж, хэрэгжүүлэхийн төлөө эцэг эхчүүд, Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчидтай хамтран ажилладаг.

Эцэг эхчүүд, удирдагчид анхааралтай хэлэлцсэний дараа тусгай хэрэгцээтэй залуу эмэгтэйчүүдэд туслахын тулд хөтөлбөрийг өөрчилж болно. Жишээ нь, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл боловсрол хязгаарлагдмал залуу эмэгтэйчүүд, 16 нас хүрснээсээ хойш Сүмд элссэн буюу дахин идэвхтэй болсон залуу эмэгтэйчүүд, Сүмийн гишүүн биш залуу эмэгтэйчүүдийн тусгай хэрэгцээг харгалзан үзэж болно. Нэг хүний төлөө хийсэн өөрчлөлт эсвэл тохиргоо нь бусад залуу эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлж болохыг удирдагчид харгалзан үзэх ёстой.

### 10.7.1 Мючел дээр хийх Хувийн хөгжил дэвшлийн үйл ажиллагаа

Залуу эмэгтэйчүүдийн удирдагчид, ангиудын ерөнхийлөгчийн зөвлөл Хувийн хөгжил

дэвшлийн зарим үйл ажиллагааг Мючелд оруулан төлөвлөж болно (10.8.1-ийг үзнэ үү). Жишээ нь, бүх залуу эмэгтэйчүүд хамтдаа нэг залуу эмэгтэйн эрхэмлэх чанарыг хөгжүүлэх төсөлд тусалж болно. Хувийн хөгжил дэвшлийн хөтөлбөр нь хувийн шинж чанартай бөгөөд аливаа бүлгийн үйл ажиллагаанууд нь сүнслэг байдал дээр төлөвлөгдсөн байх ёстой.

### 10.7.2 Эмблем, гэрчилгээ ба шагнал

Тойргийн удирдагчид Хувийн хөгжил дэвшлийн гэрчилгээ, шагналыг Сүмийн хангамжийн төвүүдээс авч болно. Эдгээр зүйлсийг тойргийн төсвөөс худалдаж авна.

### 10.7.3 Хувийн хөгжил дэвшлийн талаар удирдагчдын хүлээх үүрэг хариуцлага

#### Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчид

Залуу эмэгтэйг 12 нас хүрэхэд Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, Бийхайв ангийн зөвлөх хоёр түүнтэй болон эцэг эхтэй нь уулзах ажлыг зохион байгуулна. Бийхайв ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн оролцож болно.

Удирдагчид *Young Women Personal Progress* номыг залуу эмэгтэйд гардуулж, уг хөтөлбөрийг түүнд болон эцэг эхэд нь тайлбарлаж өгнө. Хувийн хөгжил дэвшлийн туршлага, төслүүдийг сонгон авч, биелүүлэхэд эцэг эхчүүд нь залуу эмэгтэйтэй хамтран ажиллахыг удирдагчид дэмжинэ. Охидын ээж нар Хувийн хөгжил дэвшил хөтөлбөр дээр ажиллан, шагнал авч болохыг тэд тайлбарлаж болно. Бусад эмэгтэйчүүд бас хөтөлбөрт туслахын хамт өөрсдөө оролцож болно.

Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчид *Залуучуудын бат бөх байдлын төлөө*, *Итгэлдээ үнэнч байх нь* товхимлуудыг (бишоп өмнө нь өгөөгүй бол) залуу эмэгтэйд өгнө. Тэд Залуу Эмэгтэйчүүдийн логотой хүзүүний зүүлтийг түүнд өгнө. Хүзүүний зүүлтийг Сүмийн хангамжийн төвүүдээр дамжуулан захиалж болно.

12 нас өнгөрснөөс хойш залуу эмэгтэйчүүдийн бүлэгт орж ирсэн залуу эмэгтэйчүүдэд удирдагчид үүнийг тайлбарлаж өгнө.

Эцэг эхчүүд, удирдагчдад зориулсан нэмэлт зааврууд *Young Women Personal Progress* номонд байдаг.

#### Бишоп

Залуу эмэгтэй Хувийн хөгжил дэвшлийн хөтөлбөрийг бүхэлд нь дуусгасан үед бишоп түүнтэй ярилцлага хийнэ. Энэ ярилцлага залуу эмэгтэйтэй хийдэг түүний жил тутмын эсвэл зургаан сар тутмын ярилцлагын хэсэг байж болно. Тэр *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дахь жишгүүдийг удирдамж болгон ашиглаж болно. Тэрээр түүний ариун ёслолын цуглаан, (семинар байдаг газарт) семинарын ирц, Мормоны Номыг уншсан байдлыг шалгаж болно. Залуу эмэгтэй Young Womanhood Recognition (Залуу Эмэгтэйн шагнал)-ыг авахад бэлэн болсон байна гэж бишоп үзвэл Хувийн дэвшил хөгжлийн дэвтэрт нь гарын үсэг зурна. Тэрээр шагналыг ариун ёслолын цуглаан дээр гардуулна.

## 10.8 Үйл ажиллагаа ба үйл явдлууд

Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчид түүний дотор ангиудын ерөнхийлөгчид залуу эмэгтэйчүүдийн хэрэгцээ, сонирхол дээр тулгуурласан үйл ажиллагаануудыг төлөвлөдөг. Тэд залуу эмэгтэйчүүд, түүний дотор Сүмд саяхан нэгдсэн болон идэвх султай хүмүүст хүрч ажиллахад онцгой анхаардаг. Үйл ажиллагаанууд хувийн хөгжил дэвшил хөтөлбөрийн зорилгуудаа хэрэгжүүлэхэд залуу эмэгтэйчүүдэд тусалдаг. Үйл ажиллагаануудыг төлөвлөх болон хэрэгжүүлэхэд ангиудын ерөнхийлөгчийн зөвлөл аль болохоор идэвхтэй оролцох хэрэгтэй.

Залуу Эмэгтэйчүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөг бишопын зөвлөлийн гишүүн батлахдаа 13-р бүлэг дэх удирдамжийг баримтлах ёстой.

### 10.8.1 Мючел

Залуу Эмэгтэйчүүдийн ихэнх үйл ажиллагаа Мючелийн үеэр явагддаг. *Мючел* гэдэг нэр томьёо бие биеэ харилцан хүндэтгэж, дэмжих, хамтран суралцах уур амьсгалд туршлага хуваалцах гэсэн утгыг илэрхийлдэг. Мючелийн үйл ажиллагаанууд нь бие биедээ үйлчлэх, сүнслэг байдал, нийгэм, бие бялдар, оюун санааны хувьд өсч хөгжих олон боломжийг залуучуудад олгодог байх ёстой.

Мючелийг ерөнхийдөө долоо хоног бүр явуулдаг. Гишүүд ирж оролцох боломж болон бусад хязгаарлалтуудын улмаас Мючелийг долоо хоног тутам явуулах боломжгүй бол арай урт хугацаанд явуулж болно. Гэвч сард нэг удаа заавал явуулах ёстой. Мючел нь даваа, ням гарагаас бусад өдөр орой, өдрийн цагаар явагдаж, нэгээс цаг хагасын хооронд үргэлжлэх ёстой.

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл бишопын зөвлөлийн удирдлага дор залуу эмэгтэйчүүдийн Мючелд хяналт тавина.

Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд гадасны болон гадас дундын үйл ажиллагаануудад бэлтгэхэд зарим үед Мючелийг ашиглаж болно (13.3-ыг үзнэ үү).

#### Мючелийн жил тутмын сэдэв

Тэргүүн Зөвлөл Мючелийн сэдвийг жил бүр зарлана. Мючелийн нээлтийн ажиллагаа, залуучуудын бусад үйл ажиллагаануудыг явуулахдаа удирдагчид уг сэдэвт тулгуурладаг.

#### Нээлтийн ажиллагаа

Мючел нь ихэвчлэн товчхон нээлтийн ажиллагаагаар эхлэх бөгөөд бишопын зөвлөлийн гишүүн тэргүүлнэ. Пристүүдийн чуулга дахь бишопын туслахууд, Лаурел ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд ээлжээр хөтлөн явуулна. Насанд хүрсэн удирдагчид залуу удирдагчдыг энэ үүрэг хариуцлагад нь бэлтгэнэ.

Нээлтийн ажиллагаанд сүмийн дуулал, залбирал, залуучууд авьяас чадвар, гэрчлэлээ хуваалцахын тулд сонгож авсан дуу хөгжим орж болно.

#### Чуулгын болон ангийн үйл ажиллагаанууд эсвэл хамтарсан үйл ажиллагаанууд

Нээлтийн ажиллагааны дараа Аароны санваартны чуулгууд, Залуу Эмэгтэйчүүдийн ангиуд ихэвчлэн тусдаа үйл ажиллагаа явуулдаг. Цөөхөн залуу эмэгтэйчүүдтэй тойрог болон салбарт бүх залуу эмэгтэйчүүд үйл ажиллагаанд хамтдаа цуглаж болно. Үйл ажиллагаануудыг ч чуулга, ангиуд нийлж хийхээр төлөвлөж болно.

Залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдийн хамтарсан үйл ажиллагааг ихэвчлэн сард нэг удаа зохион байгуулдаг. Бишопын зөвлөлийн залуучуудын хороо хурлаараа эдгээр үйл ажиллагааг хэлэлцэн төлөвлөж, хуваарийг гаргадаг. Эдгээр үйл ажиллагааг бишопын зөвлөлийн удирдлага дор хэрэгжүүлдэг.

Тохиромжтой үйл ажиллагааны зарим жишээ бол төсөл, дуу хөгжим, бүжиг, жүжиг, соёлын үйл ажиллагаа, спортын тоглолт, ур чадварын үзүүлэлт, анги танхимаас гадуурх бусад үйл ажиллагаа юм.

### 10.8.2 Залуучуудтай хийх бишопын зөвлөлийн хэлэлцүүлэг

Залуучуудтай хийх Бишопын зөвлөлийн хэлэлцүүлгийг бишопын зөвлөл төлөвлөж, хэрэгжүүлнэ. Үе үе явуулдаг эдгээр хэлэлцүүлэг нь залуучуудын сонирхлыг татдаг, тэдний сүнслэг байдлыг хүчирхэгжүүлдэг сэдвийг хөндөн ярилцах боломжийг бишопын зөвлөлд олгодог. *Залуучуудын бат бөх байдлын төлөө*; *Итгэлдээ үнэнч байх нь* товхимлууд дахь сэдвүүд онцгой тохиромжтой юм. Бишопын зөвлөл зарим үед энэ хэлэлцүүлэгт зочдыг урьж болно. Зочид нь ихэвчлэн тойргийн болон гадасны гишүүд байдаг.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл шаардлагатай гэж үзвэл дээд зөвлөлийн гишүүдийг бусад хороодод үйлчлүүлэхээр томилж болно. Жишээ нь ахлагч нарын чуулга, дээд пристүүдийн бүлэгтэй ажиллахаар томилогдсон дээд зөвлөлийн гишүүд Мелкиздек санваартнуудын хороо байгуулан хуралдаж болно. Аароны санваартнуудтай ажиллахаар томилогдсон дээд зөвлөлийн гишүүд Аароны санваартнуудын хороо болон хуралдаж болно. Хэлэлцүүлгийг Мючелийн үеэр, чуулгууд болон Залуу эмэгтэйчүүдийн ангиудын ням гарагийн цуглааны үеэр эсвэл гэр бүлүүдэд илүү хүндрэл учруулахгүй бусад цагаар явуулж болно. Хэлэлцүүлгийн давтамжийг бишопын зөвлөл тогтоож, бишопын зөвлөлийн залуучуудын хорооны хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөгөөнд оруулна.

### 10.8.3 Шинэ эхлэл үйл ажиллагаа

Шинэ эхлэл бол залуу эмэгтэйчүүд, тэдний эцэг эх, санваартны удирдагчид болон Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчдад зориулсан жил бүр болдог үйл ажиллагаа юм. Ирэх жил 12 нас хүрэх залуу эмэгтэйчүүдийг эцэг эхтэйгээ хамт оролцохыг урьж болно. Энэ үйл явдлыг хичээлийн жилийн эхээр эсвэл оны эхээр зохион байгуулж болно. Бас Мючелийн үеэр явуулж болно.

Энэ үйл явдал Залуу Эмэгтэйчүүдийн хөтөлбөрийн талаар мэдэхэд нь залуу эмэгтэйчүүд, тэдний эцэг эхчүүдэд тусалдаг. Үүнд Хувийн хөгжил дэвшлийн хөтөлбөрийг тайлбарлах, Залуу Эмэгтэйчүүдийн амлалт, лого, уриа, насны бүлгүүдийн зорилго, бэлгэдлүүдийг танилцуулах нь ордог (10.1-ийг үзнэ үү). Энэ нь ирэх жилийн үйл явдлуудыг төлөвлөхөд залуу эмэгтэйчүүд, тэдний эцэг эхэд тусална.

Шинэ эхлэл үйл ажиллагаа нь залуу эмэгтэйчүүдийг хайрлах хайраа илэрхийлэх, Хувийн хөгжил дэвшлийн туршлагатай болоход нь охиддоо туслахад эцэг эхчүүдийг дэмжих, ирэх жил 12 нас хүрэх залуу эмэгтэйчүүдийг танилцуулж, Сүмд нэгдсэн болон тойрогт шилжиж ирсэн залуу эмэгтэйчүүдэд баяр хүргэж халуун дотноор угтан хүлээн авах боломжийг удирдагчдад олгодог. Энэ бол залуу эмэгтэйчүүдийн Хувийн хөгжил дэвшилд олсон амжилтыг хүлээн зөвшөөрөх цаг үе юм. Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл хаалтын үг хэлүүлэхээр бишопын зөвлөлийн гишүүнийг урьж болно.

Ангийн ерөнхийлөгчийн зөвлөл Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор хөтөлбөрийг төлөвлөнө. Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл энэ ажилд туслахыг зохицуулагчдаас хүсч болно (жишээ нь, найрал дуу, хөгжимчдийн бүлгийг удирдах, үг хэлэгчдийг давтан сургуулилах, жүжиг давтахад туслах). Лаурел ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн хөтлөн явуулж болно.

### 10.8.4 Онцгой амжилт гаргасан залуу эмэгтэйчүүд

Амжилттай залуу эмэгтэйчүүд гэдэг нь сайн үйлс бүтээж яваа залуу эмэгтэйчүүдийн амжилтыг тэмдэглэх үйл ажиллагаа юм. Энэ бол Хувийн хөгжил дэвшлийг тэмдэглэх явдал юм. Залуу эмэгтэй бүр тухайн жилд онцгой амжилттайгаар дуусгасан эрхэмлэх чанарын туршлага буюу төслөө хуваалцдаг. Түүний үзүүлбэрт Хувийн хөгжил дэвшлийн зорилгуудаар дамжуулан хөгжүүлсэн авьяас, чадварууд орж болно. Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчид эцэг эхийг нь оролцуулахаар урина.

Жилийн эхэнд залуу эмэгтэй бүр энэ үйл явдалд зориулан анхаарал төвлөрүүлэх эрхэмлэх чанаруудын талаар бууръ суурьтайгаар бодож үзэхийг удирдагчид дэмжинэ. Тэрээр гэр бүлийн гишүүн, өөр нэг залуу эмэгтэй эсвэл төсөлд оролцож байгаа бусад хүмүүстэй хамтран ажиллаж болох бөгөөд төслийг дуусгахад хэдэн сар ч болж болно.

Энэ үйл явдлыг ихэвчлэн тойргийн төвшинд зохион байгуулагдаг ч гадасны төвшинд бас явуулж болно. Насанд хүрэгчдийн удирдагчид уг үйл явдлыг төлөвлөхөд залуу эмэгтэйчүүдийг оролцуулдаг. Үйл явдал зохион байгуулах огноо болон төлөвлөгөөг жилийн эхээр зарлах ёстой.

### 10.8.5 Жишгийн үйл ажиллагаа

Жишгийн үйл ажиллагаа бол ёс суртахууны эрхэмлэх чанарууд болон мөнхийн зорилгуудад онцгой анхаарал хандуулдаг тусгай хөтөлбөр юм. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дахь жишгүүдээр амьдрахад тэд залуу эмэгтэйчүүдийг дэмждэг. Энэ товхимол тэднийг Аврагчид улам ойртуулах болно.

Эдгээр үйл явдлыг ихэвчлэн Мючелийн үеэр жилд нэг буюу түүнээс олон удаа явуулж болно. Үйл явдлыг анги, тойрог, тойрог дундын болон гадасны төвшинд явуулж болно. Аль нэг сэдвийг хэрхэн танилцуулахаас хамаарч, эдгээр үйл явдлыг Залуу эмэгтэйчүүдийн өөр өөр насны бүлгүүд хамтран зохион байгуулж болно. Ээжүүдийг эсвэл аав нарыг, аав ээж нарыг хамтад нь, мөн залуу эрэгтэйчүүдийг оролцуулж болно.

### 10.8.6 Залуу Эмэгтэйчүүдийн аялал зуслан

Залуу эмэгтэйчүүдэд зориулан жил тутмын аялал зуслан буюу үүнтэй төстэй үйл ажиллагаа зохион байгуулахыг Сүм дэмждэг. Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчид энэ үйл ажиллагааг төлөвлөхдөө *Young Women Camp Manual*; *Young Women Camp: A Guide for Priesthood and Young Women Leaders* товхимлуудыг ашигладаг.

Аялал-зугаалгыг тойргийн болон гадасны төвшинд зохион байгуулж болно. Тойргийн болон гадасны Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл залуу эмэгтэйчүүдийн аялал-зугаалгын хөтөлбөрийн үргэлжлэх хугацааг санваартны удирдагчдын зааврaар шийднэ.

Санваартны удирдагчид гадасны болон тойргийн Залуу Эмэгтэйчүүдийн аялал-зугаалгын зохицуулагчдыг дуудаж болно. Аялал-зугаалгын удирдагчид Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор уг хөтөлбөрийг зохион байгуулж, хөтлөн явуулна. Тэд тоног төхөөрөмж, тээвэр, бусад дэмжлэг туслалцааг зохион байгуулах талаар тойргийн удирдагчид, гадасны үйл ажиллагааны хороотой хамтран ажиллаж болно.

Аялал-зугаалгыг санхүүжүүлэх тухай мэдээллийг 10.8.9-өөс үзнэ үү. Аялал-зугаалгын үеийн аюулгүй байдлын тухай мэдээллийг 13.6.20 болон *Young Women Camp Manual*-аас үзнэ үү.

### 10.8.7 Гадасны болон гадас дундын үйл ажиллагаанууд

13.3-ыг үзнэ үү.

### 10.8.8 Залуучуудын чуулган

13.4-ийг үзнэ үү.

### 10.8.9 Үйл ажиллагаа ба үйл явдлуудыг санхүүжүүлэх нь

Залуу Эмэгтэйчүүдийн үйл ажиллагаа, үйл явдлуудыг тойргийн төсвөөс санхүүжүүлэх ёстой (13.2.8-ыг үзнэ үү).

#### Жил тутмын аялал зуслан болон үүнтэй төстэй үйл ажиллагаануудыг санхүүжүүлэх нь

Хэрэв Залуу Эмэгтэйчүүдийн жил тутмын аялал зуслан эсвэл үүнтэй төстэй үйл ажиллагааг санхүүжүүлэхэд хүрэлцэх хэмжээний мөнгө тойргийн төсөвт байхгүй бол зардлын зарим хэсгийг өөрсдөө гаргахыг удирдагчид үйл ажиллагаанд оролцогчдоос хүсч болно. Хэрэв оролцогчдоос гаргасан мөнгө хүрэлцэхгүй бол

бишоп 13.6.8 дахь удирдамжийн дагуу хандив цуглуулах үйл ажиллагааг жил бүр зохиож байх зөвшөөрлийг нэг бүлэгт олгож болно.

Жил тутмын аялал зуслан эсвэл адил төстэй үйл ажиллагааны болон унааны зардал хэт өндөр байж болохгүй. Мөн хувиасаа мөнгө өгөх боломжгүй гишүүдийг үйл ажиллагаанаас хасч болохгүй.

#### Тоног төхөөрөмж ба материал хэрэгслийг санхүүжүүлэх нь

Боломжтой бол залуучуудын жил тутмын аялал зусланд шаардлагатай тоног төхөөрөмж, материал хэрэгслийг тойргийн төсвөөс худалдаж авах хэрэгтэй. Хэрэв төсөв хүрэлцэхгүй бол 13.6.8 дахь удирдамжийн дагуу мөнгө цуглуулах үйл ажиллагааг жил бүр зохиож байх зөвшөөрлийг бишоп нэг бүлэгт олгож болно.

Тойргийн төсвөөс эсвэл мөнгө цуглуулах үйл ажиллагаагаар ч байна уу худалдаж авсан тоног төхөөрөмж, материал хэрэгслийг зөвхөн Сүмийн зорилгоор ашиглана. Тэдгээр зүйлсийг хүмүүс, гэр бүлүүд хувийн зорилгоор ашиглаж болохгүй.

## 10.9 Удирдах ур чадварыг заах нь

Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчид удирдах ур чадварыг ангиудын ерөнхийлөгчийн зөвлөл, аялал зуслангийн удирдагчид болон удирдах дуудлагуудад үйлчилж байгаа бусад залуу эмэгтэйчүүдэд заана. Үйл ажиллагаануудыг төлөвлөх болон хэрэгжүүлэхэд туслах, Хувийн хөгжил дэвшлийн үйлчлэлийн хөтөлбөрүүдэд хамтран оролцох замаар удирдагчид залуу эмэгтэйчүүдэд заадаг. Удирдагчид заах ажилдаа энэ гарын авлагын 3-р бүлэг-г ашиглаж болно.

## 10.10 Гадасны Залуу Эмэгтэйчүүдийн удирдлага

### 10.10.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд гадасны Залуу Эмэгтэйчүүдийн бүлгийг хариуцна. Тэд энэхүү үүрэг харицлагынхаа хэсэг болгон залуу эмэгтэйчүүдийн талаарх үүрэг хариуцлагыг нь бишопуудад зааварлана.

Гадасны ерөнхийлөгч зөвлөхүүдийнхээ нэгийг гадасны Залуу Эмэгтэйчүүдийн бүлгийг хариуцуулахаар томилно.

Туслах бүлгүүдийн талаарх гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн үүрэг хариуцлагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 15.1-ээс үзнэ үү.

### 10.10.2 Гадасны Залуу Эмэгтэйчүүдэд томилогдсон дээд зөвлөлийн гишүүн

Гадасны ерөнхийлөгч дээд зөвлөлийн нэг гишүүнийг гадасны Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй ажиллуулахаар томилно. Энэ дээд зөвлөлийн гишүүний үүрэг хариуцлагын тухай 15.3-т өгүүлсэн байдаг.

### 10.10.3 Гадасны Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл

Гадасны Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн үүрэг хариуцлагын тухай 15.4.1.-д өгүүлсэн байдаг.

### 10.10.4 Гадасны Залуу Эмэгтэйчүүдийн нарийн бичиг

Гадасны Залуу Эмэгтэйчүүдийн нарийн бичгийн даргын үүрэг хариуцлагыг 15.4.2-т өгүүлжээ.

### 10.10.5 Гадасны Аароны санваартнууд–Залуу Эмэгтэйчүүдийн хороо

Гадасны ерөнхийлөгч гадасны Аароны санваартнууд–Залуу Эмэгтэйчүүдийн хороог тэргүүлэх нэг дээд зөвлөлийн гишүүнийг томилно. Хорооны бусад гишүүд нь гадасны Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүдийн байгууллагуудад томилогдсон дээд зөвлөлийн гишүүд, Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл ба нарийн бичиг, Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл болон нарийн бичиг нар юм.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл шаардлагатай бол уг хорооны хурлуудад залуучуудыг урьж болно. Залуучуудын чуулган, бүжиг, онцгой цугларалт, гадас дундын үйл ажиллагаануудыг төлөвлөх болон хэрэгжүүлэхэд залуучуудыг аль болохоор өргөн оролцуулах ёстой. Залуучууд гадасны хэмжээнд залуучуудад учирч байгаа сорилт бэрхшээлүүдийн тухай ярилцахад оролцож болно.

### 10.10.6 Гадасны Залуу Эмэгтэйчүүдийн үйл ажиллагааны зохицуулагчид

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл гадасны үйл ажиллагаанууд буюу хөтөлбөрүүдийг төлөвлөж, хэрэгжүүлэхэд туслахын тулд түр хугацаагаар үйлчлэх Залуу Эмэгтэйчүүдийн зохицуулагчдыг гадасны гишүүдийн дундаас томилж болно. Зохицуулагчдыг Залуу Эмэгтэйчүүдийн аялал зуслан, гадасны болон гадас дундын үйл ажиллагаа, спортын үйл явдлуудын үеэр томилж болно. Тэд гадасны Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор үйлчилнэ.

## 10.11 Залуу Эмэгтэйчүүдийн бүлгийг орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх нь

Цөөхөн залуу эмэгтэйчүүдтэй тойрог болон салбарт бүх залуу эмэгтэйчүүд сургалтанд хамтдаа цуглаж болно (10.3.5; 10.6.2-ыг үзнэ үү). Тэд үйл ажиллагаанд хамт цуглаж болно.

Тойрог эсвэл салбарт насанд хүрсэн удирдагч дутмаг бол Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл ням гарагийн хичээлийг заах, туслахуудын тусламжгүйгээр үйл ажиллагааны хөтөлбөрийг удирдан зохион байгуулна. Маш жижиг нэгжид Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч Залуу Эмэгтэйчүүдийн бүлгийн цорын ганц насанд хүрсэн удирдагч байж болно. Энэ тохиолдолд тэрээр ням гарагийн хичээлийг заах, нийт залуу эмэгтэйчүүдийн үйл ажиллагаануудыг хариуцна. Боломжтой бол зөвлөхүүд, нарийн бичгийн даргыг дуудах ёстой.

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчгүй жижиг салбарт Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч нь Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч дуудагдтал залуу эмэгтэйчүүдэд заах хичээлийг зохион байгуулахад эцэг эхчүүдэд тусалж болно.

Олон хүнтэй бүлэг дэх олон нийтийн үйл ажиллагаа залуучуудад ашигтай байдаг учраас хоёр буюу түүнээс дээш жижиг тойрог эсвэл салбарын залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүд зарим үед хамтарсан үйл ажиллагаанд оролцож болно. Хил залгаа тойрог, салбарууд цөөхөн залуу эмэгтэйчүүдтэй бол бишоп, салбарын ерөнхийлөгч хоёр долоо хоног тутмын үйл ажиллагаанд залуу эмэгтэйчүүд хамтран оролцохыг зөвшөөрч болно. Бишоп, салбарын ерөнхийлөгч нар энэ хувилбарыг сонгохдоо газрын хол ойр, тээврийн зардал зэрэг хүчин зүйлсийг харгалзаж үздэг.

Жижигхэн гадас буюу дүүрэгт Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч нь гадасны эсвэл дүүргийн Залуу Эмэгтэйчүүдийн цорын ганц удирдагч байж болно. Боломжтой бол зөвлөхүүд, нарийн бичгийн даргыг дуудах хэрэгтэй.

Орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх тухай мэдээллийг 17-р бүлгээс үзнэ үү.

## 10.12 Нэмэлт удирдамж ба журмууд

### 10.12.1 14-өөс доош насны залуучууд Залуучуудын чуулган ба бүжигт оролцох тухай

14-өөс доош насны залуучууд нь залуучуудын чуулган болон тогтмол төлөвлөдөг Мючелийн үдшээс бусад цагт болдог бүжигт ихэвчлэн оролцдоггүй (13.6.14-ийг үзнэ үү). Залуу Эмэгтэйчүүдийн жил тутмын аялал зусланд энэ удирдамжийг баримтлахгүй.

### 10.12.2 Бусад шашны залуу эмэгтэйчүүд

Сүмийн жишгүүдийг баримталж амьдрахыг зөвшөөрдөг бусад шашны залуу эмэгтэйчүүдэд элэгсэг дотноор хандаж, залуучуудын үйл ажиллагаануудад оролцохыг нь дэмжих хэрэгтэй. Тэд Хувийн хөгжил дэвшил хөтөлбөрт оролцож, шагналыг нь авч болно. Тэдний оролцох зардлыг Сүмийн гишүүн залуу эмэгтэйчүүдийн зардалтай адилаар шийдвэрлэх ёстой.

### 10.12.3 Хөгжлийн бэрхшээлтэй залуу эмэгтэйчүүд

Хөгжлийн бэрхшээлтэй залуу эмэгтэйчүүд тус тусынхаа ангид явдаг нь хэвшин тогтсон зүйл юм. Цөөн онцгой тохиолдолд эцэг эхчүүд болон бишопын зөвлөлийн зөвшөөрлөөр үүнийг дагахгүй байж болно.

Хөгжлийн бэрхшээлтэй залуу эмэгтэйчүүдийг ойлгох, сүмийн үйл ажиллагаанд оролцуулах, тэдэнд заах тухай мэдээллийг 21.1.26 болон disabilities.lds.org-аас үзнэ үү.

### 10.12.4 Гэрлэхээс өмнө жирэмсэлсэн болон хүүхэдтэй болсон залуу эмэгтэйчүүд

Хэрэв залуу эмэгтэй гэрлээгүй байхдаа жирэмсэн болсон бол Залуу Эмэгтэйчүүдийн анги болон үйл ажиллагаануудад оролцох шийдвэрийг уг залуу эмэгтэй, түүний эцэг эх болон бишоп нар залбирч шийднэ.

17 буюу түүнээс дээш настай залуу эмэгтэй гэрлээгүй байхдаа хүүхэд төрүүлж, хүүхдээ өөрөө өсгөхөөр шийдсэн бол түүнийг Нийгмийн Халамжийн бүлэгт уриалагханаар хүлээн авч, түүнд заах, шинэ үүрэг хариуцлагад нь тусална. Тэр Залуу Эмэгтэйчүүдийн үйл ажиллагаанд цаашид оролцохгүй.

17-гоос доош настай залуу эмэгтэй гэрлээгүй байхдаа хүүхэд төрүүлж, хүүхдээ өөрөө өсгөхөөр шийдсэн бол Залуу Эмэгтэйчүүдийн анги болон үйл ажиллагаануудад оролцох шийдвэрийг уг залуу эмэгтэй, түүний эцэг эх болон бишоп нар залбирч шийднэ. Хэрэв залуу эмэгтэй Залуу Эмэгтэйчүүдийн анги болон үйл ажиллагаануудад оролцох бол хүүхэд нь түүнийг дагаж явах ёсгүй.

Ганц бие залуу эмэгтэйчүүд бутач хүүхдийг өсгөн хүмүүжүүлэхийг дэмждэггүй Сүмийн бодлогын тухай мэдээллийг 21.4.12-оос үзнэ үү.

# 11. Хүүхдийн хэсэг


11.1 **Хүүхдийн Хэсгийн амлалт ба зорилго . . . . . 94**

11.2 **Тойргийн Хүүхдийн Хэсгийн удирдлага . . . 94**

11.2.1 Бишопын зөвлөл . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 94
11.2.2 Тойргийн Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл . . . . . . . . . . . . . . . . . 94
11.2.3 Тойргийн Хүүхдийн Хэсгийн нарийн бичиг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 95
11.2.4 Тойргийн Хүүхдийн Хэсгийн хөгжмийн удирдагч(чид) ба төгөлдөр хуурч(ид) . . . . . 95
11.2.5 Хүүхдийн Хэсгийн багш нар ба хүүхэд асрах ангийн удирдагчид . . . . . . . . . . . . . . . 96
11.2.6 Үйл ажиллагааны удирдагчид ба Скаутын удирдагчид . . . . . . . . . . . . . . . . . . . 96

11.3 **Удирдлагын хурал . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 96**

11.3.1 Тойргийн Зөвлөлийн хурал . . . . . . . . . . . . . 96
11.3.2 Тойргийн Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал . . . . . . . 96
11.3.3 Бишопын зөвлөхтэй уулзаж байх нь . . . . . . 96
11.3.4 Гадасны Хүүхдийн Хэсгийн удирдлагын хурал . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 97

11.4 **Хүүхдийн Хэсгийн ням гараг . . . . . . . . . . . . . 97**

11.4.1 Хуваарь . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 97
11.4.2 Хуваалцах цаг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 97
11.4.3 Ангиуд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 98

11.5 **Хүүхдийн Хэсгийн хөтөлбөр болон үйл ажиллагаа . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 98**

11.5.1 Бурханд итгэх итгэл хөтөлбөр . . . . . . . . . . . 98
11.5.2 Үйл ажиллагааны өдөр . . . . . . . . . . . . . . . . . . 98
11.5.3 Скаутын үйл ажиллагаанууд . . . . . . . . . . . . 99
11.5.4 Хүүхдийн Хэсэг ариун ёслолын цуглааныг хариуцан явуулах нь . . . . . . . . . . 99
11.5.5 Санваарын тухай танилцуулах уулзалт . . . 99

11.6 **Гадасны Хүүхдийн Хэсгийн удирдлага . . . . 99**

11.6.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл . . . . . . . . . 99
11.6.2 Гадасны Хүүхдийн Хэсэгт томилогдсон дээд зөвлөлийн гишүүн . . . . . . . . . . . . . . . . . 99
11.6.3 Гадасны Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл . . . . . . . . . . . . . . . . 100
11.6.4 Гадсны Хүүхдийн Хэсгийн нарийн бичиг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 100
11.6.5 Гадасны Хүүхдийн Хэсгийн хөгжмийн удирдагч . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 100

11.7 **Хүүхдийн Хэсгийг орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх нь . . . . . . 100**

11.8 **Нэмэлт удирдамж ба журмууд . . . . . . . . . . 100**

11.8.1 Хүүхдийн Хэсэгт үйлчилдэг эрэгтэйчүүд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 100
11.8.2 Бүртгэлтэй найман настай хүүхдүүдийн баптисмын ёслол . . . . . . . . . 101
11.8.3 Хүүхдийн Хэсэгт гэрчлэлээ хуваалцах нь . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 101
11.8.4 Хүндэтгэлтэй байдлыг хөхүүлэн дэмжих нь . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 101
11.8.5 Жүжигчилсэн тоглолтонд Бурханы дүрд тоглох . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 101
11.8.6 Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд . . . . . . . . . . . 101
11.8.7 Санхүү . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 101

# 11. Хүүхдийн хэсэг

Хүүхдийн Хэсэг бол санваартнуудад туслах бүлэг юм. Бүх туслах бүлгүүд Тэнгэрлэг эцэг, Есүс Христ хоёрын тухай, сэргээгдсэн сайн мэдээний тухай гэрчлэлээрээ өсч хөгжихөд нь Сүмийн гишүүдэд туслахын тулд оршин үйл ажиллагаа явуулдаг. Гишүүд сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрахыг хичээн чармайхдаа туслах бүлгүүдийн ажлаар дамжуулан заавар, урам дэм, дэмжлэг авдаг.

## 11.1 Хүүхдийн Хэсгийн амлалт ба зорилго

Хүүхдийн Хэсгийг 18 сартайгаас 11 хүртэл настай хүүхдүүдэд зориулсан юм. Хүүхдийн Хэсгийн амлалт бол "Бүх хүүхдүүд Их Эзэнээр сургагдах болно; мөн хүүхдүүдийн чинь амар амгалан агуу байх болно"(3 Нифай 22:13) гэсэн үгс юм. Хүүхдийн Хэсгийн зорилго бол хүүхдүүдэд туслах явдал мөн:

1. Хүүхдүүдийг хайрлах Тэнгэрлэг Эцэгийн хайрыг мэдэр.
2. Есүс Христийн сайн мэдээнээс суралцаж, ойлго.
3. Ариун Сүнсний нөлөөг мэдэрч, таньдаг бай.
4. Ариун гэрээнүүд хийж сахихад бэлтгэ.

Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ бие бялдар, сүнслэг байдлын төлөө анхдагч үүрэг хариуцлага хүлээдэг (С ба Г 68:25–28-ыг үзнэ үү). Бишопын зөвлөл, Хүүхдийн Хэсгийн удирдагчид дээрх үүргээ биелүүлэхийг нь дэмжих боловч эцэг эхчүүдийг орлон ажиллах ёсгүй.

## 11.2 Тойргийн Хүүхдийн Хэсгийн удирдлага

Энэ бүлэгт хувь хүмүүс болон гэр бүлүүдийг бэхжүүлэх арга замаар Хүүхдийн Хэсгийг удирдах талаар онцлон өгүүлнэ. Удирдлагын ерөнхий зарчмуудыг авч үздэг 3-р бүлэг-г Хүүхдийн Хэсгийн удирдагчид байнга уншиж судлах хэрэгтэй. Эдгээр зарчимд сүнслэг байдлын хувьд бэлтгэх, хурал цуглаануудад оролцох, бусдад үйлчлэх, Есүс Христийн сайн мэдээг заах зэрэг орно.

### 11.2.1 Бишопын зөвлөл

Бишоп болон түүний зөвлөхүүд Хүүхдийн Хэсгийг санваартны удирдлагаар хангадаг.

#### Бишоп ба түүний зөвлөхүүд

Бишоп Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчөөр үйлчлэх нэг эгчийг дуудаж, онцгойлон адисална. Тэрээр Хүүхдийн Хэсгийн бусад бүх хүмүүсийг дуудаж, адислах талаар анхаарна. Тэднийг дуудаж, онцгойлон адислахад тэрээр зөвлөхүүдээ томилж болно.

Бишоп эсвэл томилогдсон зөвлөх бүртгэлтэй гишүүн, 8 настай хүүхдүүд, бүртгэлтэй гишүүн бус 8 настай хүүхдүүдийн баптисм ба гишүүний баталгааны ярилцлагыг эцэг эх хоёрын аль нэгийг эсвэл асран хамгаалагчийг байлцуулан хийнэ. Эцэг эх нь гишүүн биш 8 настай хүүхдүүд, баптисмын үед 9 буюу түүнээс дээш нас хүрэх хүүхдүүдэд бүрэн цагийн номлогчид зааж, ярилцлага хийнэ.

12 нас хүрч Хүүхдийн Хэсгээс дэвшин шилжихийнх нь өмнө хүүхдүүдтэй бишоп эсвэл томилогдсон зөвлөх ярилцлага хийнэ.

#### Тойргийн Хүүхдийн Хэсэгт хяналт тавихаар томилогдсон зөвлөх

Бишоп тойргийн Хүүхдийн Хэсгийг хариуцуулахаар зөвлөхүүдийнхээ нэгийг томилно. Уг зөвлөх дараах үүрэг хариуцлагатай:

Тойргийн Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй тогтмол уулзаж байх. Хүүхдийн Хэсгийн асуудлуудын тухай бишопын зөвлөлийн хурал дээр мэдээлж байх.

Хүүхдийн ариун ёслолын цуглааны жил тутмын үйл ажиллагааг бэлтгэх ажлыг удирдах.

Санваарыг танилцуулах уулзалт төлөвлөн явуулах ажлыг удирдан чиглүүлэх.

Хуваалцах цагаар бишопын зөвлөлийн гишүүдээр хүүхдүүдэд товч захиас өгүүлэх ажлыг зохицуулах.

Скаутын үйл ажиллагааг Сүмээс зөвшөөрсөн газарт тэрээр 8-11 насны скаутын хөвгүүдийг хариуцна.

### 11.2.2 Тойргийн Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл

Тойргийн Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл нь ерөнхийлөгч, хоёр зөвлөхөөс бүрдэнэ. Тэд бишопын зөвлөлийн удирдлага дор ажиллаж, гадасны Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлөөс сургалт, байнгын дэмжлэг авдаг.

#### Тойргийн Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч

Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч дараах үүрэг хариуцлагатай:

Тэрээр тойргийн зөвлөлийн гишүүнээр үйлчилнэ. Тэрээр энэ зөвлөлийн гишүүний хувьд хувь хүмүүс, гэр бүлүүдийн итгэлийг төлөвшүүлж, бэхжүүлэх ажилд оролцдог (4-р бүлэг-г үзнэ үү).

Хүүхдийн Хэсгийн удирдагчид, багш нараар үйлчлэхээр дуудагдах тойргийн гишүүдийг бишопын зөвлөлд санал болгоно. Ийнхүү санал болгохдоо 19.1.1; 19.1.2 дахь удирдамжуудыг баримтална.

Тэрээр энэ гарын авлагыг эх сурвалж болгон ашиглаж, Хүүхдийн Хэсгийн бусад удирдагчид, багш нарт үүрэгт ажлыг нь заана.

Тэрээр *Бурханд итгэх итгэл* удирдамжийн номыг 11.5.1.-д дүрсэлсний дагуу хэрэглэнэ.

Тэрээр мөн тойргийн Хүүхдийн Хэсгийн бүртгэл тайлан, төсөв санхүүг хариуцна. Түүний энэ үүрэг хариуцлагад нь Хүүхдийн Хэсгийн нарийн бичиг тусална.

#### Тойргийн Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч ба түүний зөвлөхүүд

Тойргийн Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд дараах үүрэг хариуцлагыг биелүүлэхийн тулд хамтран ажиллана. Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч эдгээр үүрэг хариуцлагын заримд нь хяналт тавиулахын тулд зөвлөхүүдээ томилж болно.

Тэд хүүхдүүдийнхээ нэрийг болон тэдний авьяас чадвар, сонирхдог зүйлс, сорилт бэрхшээлийг сайн мэддэг байна. Тэд хүүхэд нэг бүрийг хүчирхэгжүүлэх арга замуудыг эрж хайн, Хүүхдийн Хэсгийн үйл ажиллагаанд оролцоход нь тусална.

Шинээр дуудагдсан багш нарыг сургаж, Хүүхдийн Хэсэг дэх суралцах, заах чанарыг хариуцна. Ингэхдээ 5.5.3 болон 5.5.4 дэх зарчмуудыг баримтална. Тэд (1) Хүүхдийн Хэсгийн багш нар, хүүхэд асрах ангийн удирдагчидтай үе үе уулзаж, тэдний асуултуудад хариу өгч, асуудлуудыг шийдэж, хүүхдүүдэд үйлчлэх арга замуудыг ярилцаж, (2) хуваалцах болон хичээлийн цаг, завсарлагаанаар хүндэтгэлтэй байхад нь туслаж, (3) хичээлд нь суух хуваарийг зохицуулах замаар тэдэнд дэмжлэг үзүүлнэ.

Тэд хуваалцах цагийг төлөвлөж, 11.5-д жагсаасан хөтөлбөр, үйл ажиллагааг хариуцна.

Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлыг тогтмол хийнэ. Тэд бас Хүүхдийн Хэсэгт хяналт тавьдаг бишопын зөвлөлийн гишүүнтэй тогтмол уулзаж байна.

### 11.2.3 Тойргийн Хүүхдийн Хэсгийн нарийн бичиг

Тойргийн Хүүхдийн Хэсгийн нарийн бичиг дараах үүрэг хариуцлагатай:

Тэр ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлын хөтөлбөр бэлтгэхэд ерөнхийлөгчийн зөвлөлтэй зөвлөлдөнө. Тэр эдгээр хуралд оролцож, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврын биелэлтийг мэдээлнэ.

Улирал тутам ирцийн тухай мэдээлэл бэлтгэн, Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчтэй хянан хэлэлцэж, тойргийн бичиг хэргийн ажилтанд өгнө.

Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч, тойргийн гүйцэтгэх нарийн бичиг нар удахгүй баптисм хүртэх болон Хүүхдийн Хэсгээс Аароны санваартан, Залуу Эмэгтэйчүүдэд дэвшин шилжих хүүхдүүдийн талаар мэдэж байгааг тэрээр анхаарна.

Жил тутмын төсөв, зардлын тооцоо гаргахад Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлд тусална.

Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл хүссэн үед хүүхдүүд, багш нар эцэг эхчүүдэд тусална. Жишээ нь, тэрээр хичээлд хяналт тавьж, хуваалцах цагийн үеэр хүндэтгэлтэй байдлыг сахиулахад тусална. Бас дараачийн хуваалцах цагийн үеэр үг хэлэх хүүхдүүдийг томилж, энэ даалгаврын тухай хүүхдүүдийн эцэг эхэд мэдэгдэж болно.

### 11.2.4 Тойргийн Хүүхдийн Хэсгийн хөгжмийн удирдагч(ид) ба төгөлдөр хуурч(ид)

Хүүхдийн Хэсгийн хөгжмийн удирдагчид, төгөлдөр хуурчид Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор дараах үүрэг хариуцлагыг хүлээдэг:

Хуваалцах цагийн дуу хөгжмийг удирдах, түүний дотор хүүхдийн ариун ёслолын үйл ажиллагааны хэсэг болох дуунуудыг төлөвлөх, заах.

Хүсэлт тавьсан үед хүүхэд асрах ангийн болон Хүүхдийн Хэсгийн бусад ангиудад дуу хөгжмөөр туслах.

Хүсэлт тавьсан үед хүүхдийн найрал дуу зохион байгуулж, удирдах.

Хөгжим Хүүхдийн Хэсэгт хэчнээн чухал болохыг Хүүхдийн Хэсгийн хөгжмийн удирдагчид, төгөлдөр хуурчид ойлгоход нь Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд

тусалдаг. Хүүхдийн Хэсгийн дуунуудын ая, үг, захиас нь сайн мэдээний сургаалуудыг хүүхдүүдэд зааж, насан туршид зүрх сэтгэлд нь хоногшин үлддэг билээ.

Хүүхдийн хэсэгт дуу дуулах нь хүндэтгэлтэй намуухан орчинг бий болгож, сайн мэдээг зааж, хүүхдүүдийг Ариун Сүнс болон баяр баяслыг мэдрэхэд нь тусалдаг юм. Хүүхдүүд дуу дуулж байх үед хөгжмийн удирдагчид тэдэнд биеийн хөдөлгөөн хийх, зөвөөр суниах боломжийг олгодог байх хэрэгтэй.

*Children's Songbook* хуваалцах цагийн дуу хөгжим бол Хүүхдийн Хэсгийн дуу хөгжмийн үндсэн эх сурвалж материал юм. Сүмийн дууллын ном, *Найз* болон *Лиахона*-гийн дуунууд бас тохиромжтой. Хүүхдүүд зарим үед эх оронч үзлийн буюу амралтын сэдэвтэй, ням гарагт дуулах болон хүүхдийн насанд тохирсон дуунуудыг дуулж болно. Хүүхдийн Хэсэгт ашиглах бусад дуу хөгжимд бишопын зөвлөлийн зөвшөөрөл шаардлагатай.

Хүүхдүүдэд дуу хөгжим заах тухай мэдээллийг *Children's Songbook*, хуудас 300–304-өөс үзнэ үү. Мөн энэ гарын авлагын 14-р бүлэг; хуваалцах цагийн онлайн LDS.org-ийн Serving in the Church дэх "Music Callings and Resources"-г үзнэ үү.

### 11.2.5 Хүүхдийн Хэсгийн багш нар ба хүүхэд асрах ангийн удирдагчид

Хүүхдийн Хэсгийн багш нар, асрах ангийн удирдагчид янз бүрийн насны хүүхдүүдтэй ажилладаг. Эдгээр багш, удирдагчид 5.5.4.-т өгүүлсэн зарчмуудыг баримтална.

Хүүхдийн Хэсгийн багш нар, асрах ангийн удирдагчид ням гарагт Хүүхдийн Хэсгийн бүх цаг, түүний дотор хуваалцах цаг болон завсарлагаанаар хүүхдүүдтэйгээ хамт байна. Хуваалцах цагийн үеэр тэд томилогдсон ангидаа байж, хүүхдүүдтэйгээ хамт дуу дуулж, хүндэтгэлтэй байхад нь хүүхдүүдэд тусална.

### 11.2.6 Үйл ажиллагааны удирдагчид ба Скаутын удирдагчид

Тойргийн Хүүхдийн Хэсэг 8-11 настай хүүхдүүдэд зориулж, өдрийн болон Скаутын үйл ажиллагаа зохион байгуулдаг бол уг үйл ажиллагааг эдгээр хүүхдийн багш нар мөн энэхүү үүрэгт ажлыг гүйцэтгүүлэхээр бишопын зөвлөлийн бусад удирдагчид төлөвлөн явуулж болно (11.5.2; 11.5.3-г үзнэ үү).

## 11.3 Удирдлагын хурал

### 11.3.1 Тойргийн зөвлөлийн хурал

Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч тойргийн зөвлөлийн гишүүнээр үйлчилдэг (4-р бүлэг-г үзнэ үү).

### 11.3.2 Тойргийн Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал

Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл нь ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлыг тогтмол хийнэ. Ерөнхийлөгч цуглаан дээр тэргүүлж, хурлыг хөтлөн явуулна. Нарийн бичиг оролцож, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврын биелэлтийг мэдээлнэ.

Хурлын хөтөлбөрт дараах зүйлс орж болно:

1. Хүүхдийн Хэсгийн хүүхэд, багш бүрийг хүчирхэгжүүлэх арга замуудыг төлөвлөх.
2. Дуудлагатайгаа холбогдох судрын хэсгүүд, Сүмийн удирдагчдын зааврuудыг уншиж, ярилцах.
3. Хүүхдийн Хэсгийн ням гарагийн үйл ажиллагаа түүний дотор хөгжмийн үр өгөөжийг ярилцах. Үйл ажиллагааны өдрийн үр өгөөжийг ярилцах. Сайжруулах арга замуудыг төлөвлөх.
4. Хүүхдийн Хэсгийн бусад ажилтнуудад үүрэг хариуцлагынх нь талаар заавар өгөх төлөвлөгөө боловсруулах.
5. Ирцийн бүртгэлийг хянаж байх. Хүүхдийн Хэсэгт саяхан орж ирсэн буюу идэвх султай гэр бүлийн хүүхдүүдэд туслах төлөвлөгөө гаргах.
6. Хүүхдийн Хэсгийн төсөв, зардлыг хянан хэлэлцэх.

Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл шаардлагатай бол эдгээр хуралд Хүүхдийн Хэсгийн ажилтнуудыг урьж оролцуулж болно.

### 11.3.3 Бишопын зөвлөхтэй уулзаж байх нь

Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл Хүүхдийн Хэсэгт хяналт тавьдаг бишопын зөвлөлийн гишүүнтэй тогтмол уулзаж байна. Эдгээр уулзалтаар тэд хүүхэд нэг бүрийн өсөлт хөгжилт, хэрэгцээний тухай хамтран зөвлөлддөг. Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд ажлаа тайлагнаж, санал бодлоо хэлж, хурал цуглаан, үйл ажиллагаануудын төлөвлөгөөг хэлэлцэнэ. Шаардлагатай бол Хүүхдийн Хэсгийн ажилтнуудыг ажлаа тайлагнаж,

заавар авахын тулд энэ цуглаанд урин оролцуулж болно.

### 11.3.4 Гадасны Хүүхдийн Хэсгийн удирдлагын хурал

Гадасны Хүүхдийн Хэсгийн удирдлагын хурлыг жилд нэг эсвэл хоёр удаа хийж болно. Гадасны Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд, нарийн бичиг нар оролцоно. Хүүхдийн Хэсгийн бусад удирдагчид, багш нар, Хүүхдийн Хэсэгт томилогдсон бишопын зөвлөлийн гишүүнийг шаардлагатай бол урьж оролцуулж болно. 18.3.11-ийг үзнэ үү.

## 11.4 Хүүхдийн Хэсгийн ням гараг

### 11.4.1 Хуваарь

Хүүхдийн Хэсгийн хичээл нь насанд хүрэгчид болон залуучууд санваартны цуглаан, Нийгмийн Халамжийн Бүлгийн цуглаан, Залуу Эмэгтэйчүүд, Ням гарагийн ангиуд хичээллэж байх үеэр ихэвчлэн 1 цаг 40 минутын хугацаанд үргэлжилдэг.

Асрах ангийн хүүхдүүд энэ бүх цагт асрах ангийн *Behold Your Little Ones гарын авлагад өгүүлсний дагуу ангидаа байна.* Бусад хүүхдүүд хоёр хичээлд оролцоно. Нэг хичээлд нь хүүхдүүд 50 минут үргэлжлэх хуваалцах цагт хамт суна. Нөгөө хичээлд тэд жижиг ангиуд болон хуваагдаж, Хүүхдийн Хэсгийн багш нарын заадаг 40 минутын хичээлд суна.

Хуваалцах цаг болон хичээлд суусан хүүхдүүд, багш нар хоёр хэсгийн хооронд 10 минут завсарлана. Завсарлагын үеэр тэд дараагийн хэсэгт бэлтгэнэ. Хүүхдүүд бие засч, ус ууж болно. Багш нар завсарлагааны турш хүүхдүүдэд анхаарал тавина.

Хүүхдийн Хэсгийн ням гарагийн хуваарийн гурван хувилбарыг доор харуулав. Хүүхдийн Хэсгийн удирдагчид аль хувилбарыг сонгохоо шийдэхдээ Аароны санваартны чуулгын болон Залуу Эмэгтэйчүүдийн ангиудын цуглааны үеэр том хүүхдүүд хуваалцах цагт оролцож байх ёстойг анхаарна. Энэ нь хүүхдүүдийг 12 нас хүрэхэд саадгүй дэвших боломжийг тэдэнд олгоно.

*Хувилбар 1:* Бага насны хүүхдүүд болон том хүүхдүүд хуваалцах цагаар хоёр өөр ангид хуваагдана. Эхний 50 минутанд нэг бүлэг нь хуваалцах цагт оролцож байхад нөгөө бүлэг нь 40 минутын хичээлд сууж,10 минут завсарлана. Дараа нь хоёр бүлэг ангиа сольж, нэг дэх бүлэг хичээлээ эхлэхээс өмнө 10 минутын завсарлага авна.

| | | |
|---|---|---|
| **Хуваалцах цаг** 50 минут | **Завсарлага** 10 минут | **Ангиуд** 40 минут |
| **Ангиуд** 40 минут | **Завсарлага** 10 минут | **Хуваалцах цаг** 50 минут |

*Хувилбар 2:* Бүх хүүхдүүд хуваалцах цагт цуглана. Дараа нь завсарлаж, тус тусын ангид орно.

| | | |
|---|---|---|
| **Хуваалцах цаг** 50 минут | **Завсарлага** 10 минут | **Ангиуд** 40 минут |

*Хувилбар 3:* Бүх хүүхдүүд эхлээд хичээлдээ суна. Дараа нь завсарлаж, хуваалцах цагт хамт суна.

| | | |
|---|---|---|
| **Ангиуд** 40 минут | **Завсарлага** 10 минут | **Хуваалцах цаг** 50 минут |

### 11.4.2 Хуваалцах цаг

Хуваалцах цаг нь Есүс Христийн сайн мэдээнээс суралцаж, Ариун Сүнсийг мэдрэх боломжийг хүүхдүүдэд олгодог. Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл тойрогт жил бүр ирдэг хуваалцах цагийн гарын авлагыг баримтална. Нэмэлт хувиудыг Сүмийн Хангамжийн Төвүүдээс авах буюу LDS.org-ийн Serving in the Church хэсэг дэх "Primary"-гаас үзэж болно.

Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд хуваалцах цагийг ээлжээр хөтлөн явуулна. Хуваалцах цагт ихэвчлэн дараах зүйлс ордог:

1. Оршил хөгжим, хүүхдүүдийн мэдэх хүндэтгэлтэй дуу буюу сүмийн дуулал, хүүхдүүдийн нэг нь нээлтийн залбирал хийх.
2. Дараах зүйлсээс нэгийг нь эсвэл хэд хэдийг хийх: сонгож авсан судрын хэсгийг хүүхдүүдийн нэгээр уншуулах, итгэлийн тунхгуудаас нэгийг цээжээр хэлүүлэх, бишопын зөвлөлийн гишүүний товч захиас, нэг буюу хоёр дуу, тухайн сарын сэдвээр хүүхдүүд үг хэлэх.
3. Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн заадаг сайн мэдээний хичээл. Энэ хэсэг 15 минут орчим үргэлжилнэ. Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд судруудыг ашиглаж, хичээлд бэлтгэх болон заахдаа хуваалцах цагийн гарын авлагыг баримтална.

4. Хөгжмийн удирдагчийн хөтлөн явуулдаг дуулах цаг. Энэ хэсэг 20 минут орчим үргэлжилнэ (хуваалцах цагийн тоймыг үзнэ үү).
5. Төгсгөлийн хөгжим тоглосны дараа хүүхдүүдийн нэг нь хаалтын залбирал хэлнэ.

### 11.4.3 Ангиуд

Дараах удирдамжийн дагуу Хүүхдийн Хэсгийн ангиудад хүүхдүүдийг нас насаар нь бүлэг болгон хуваарилдаг.

Эцэг эхчүүд, удирдагчид, багш нар том болсон хүүхдүүдийг сүм дээр судруудаа авчирдаг байхыг дэмжинэ.

Ангиудыг тухайн нөхцөл байдалд тохируулан өөрчлөх тухай мэдээллийг 11.7-гоос үзнэ үү.

#### Асрах анги

Хүүхдүүд 18 сартай болмогцоо асрах ангид явж болно. Тэд дараагийн гарчиг дахь хүснэгтэд харуулснаар Санбийм (нарны цацраг) ангид явах хүртлээ асрах ангид явж болно.

#### Хүүхдийн Хэсгийн ангиуд

Хүүхдүүд жил бүрийн эхний ням гарагт Хүүхдийн Хэсгийн шинэ ангид дэвшин ордог. Тэд дараах хүснэгтэд харуулсны дагуу ихэвчлэн тухайн оны нэгдүгээр сарын 1-ний өдрийн насны байдлаараа бүлгүүдэд хуваагддаг.

| Нас (нэгдүгээр сарын 1-ний байдлаар) | Анги |
|---|---|
| 3 | Санбийм (Нарны цацраг) |
| 4 | ЗС 4 |
| 5 | ЗС 5 |
| 6 | ЗС 6 |
| 7 | ЗС 7 |
| 8 | Валиент (Баатарчууд) 8 |
| 9 | Валиент 9 |
| 10 | Валиент 10 |
| 11 | Валиент 11 |

#### 12 настай хүүхдүүд

Хүүхдүүд 12 нас хүрээд Хүүхдийн Хэсгээс шат ахин дэвшдэг. Удирдагчид тэдэнд шат ахин дэвшсэн гэрчилгээ өгнө.

Хуваалцах цагийн үеэр 12 настай хүүхдүүд Аароны санваартны чуулга эсвэл Залуу Эмэгтэйчүүдийн ангид суудаг.

Шинээр 12 нас хүрч байгаа хүүхдүүд нь ихэвчлэн жилийн эцэс хүртэл Хүүхдийн Хэсгийн Валиент 11 ангидаа явдаг. Гэхдээ 12 настай хүүхдүүд 12, 13 настай хүүхдүүдэд зориулсан Ням гарагийн хичээлд суух хэрэгтэй эсэхийг бишоп, Хүүхдийн Хэсэг, Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчтэй хамтран зөвлөлдөж шийднэ. Эдгээр удирдагч хамтран зөвлөлдөхдөө хүүхдүүдийн хэрэгцээг болон тухайн жилд хэдэн сард хэчнээн хүүхэд 12 нас хүрэхийг харгалзаж үзнэ. Тэдний гаргах шийдвэр тухайн жилд 12 нас хүрэх бүх залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд хамаарна.

## 11.5 Хүүхдийн Хэсгийн хөтөлбөр болон үйл ажиллагаа

### 11.5.1 Бурханд итгэх итгэл хөтөлбөр

Бурханд итгэх итгэл хөтөлбөр нь 8-11-н насны охид, хөвгүүдэд сайн мэдээний зарчмуудаар амьдрах, гэрчлэлээ хөгжүүлэх, зөв шударга Аароны санваартнууд, зөв шударга залуу эмэгтэйчүүд болоход нь тусалдаг. Энэ хөтөлбөр нь Итгэлийн Тунхгийг цээжлэхэд хүүхдүүдийг урамшуулан дэмждэг.

*Faith in God for Girls (Бурханд итгэх охидын итгэл), Faith in God for Boys (Бурханд итгэх хөвгүүдийн итгэл)* товхимлыг 8 нас хүрч байгаа хүүхэд бүр авсан байх ёстойг тойргийн Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч анхаарна. Эдгээр удирдамжийн номыг хүүхдүүд болон гэр бүлд бүгдэд нь зориулсан үйл ажиллагаануудын эх сурвалж, материал болгон ашиглаж болно гэдгийг ойлгоход тэрээр эцэг эхчүүдэд тусалдаг.

### 11.5.2 Үйл ажиллагааны өдөр

Боломжтой бол Хүүхдийн Хэсэг нь 8-11 насны охид, хөвгүүдэд зориулан үйл ажиллагаа зохион байгуулж болно. Удирдагчид, багш нар *Бурханд итгэх итгэл* удирдамжийг Үйл ажиллагааны эх сурвалж материал болгон ашиглаж, Бурханд итгэх итгэлийн шаардлагуудыг гэр орондоо биелүүлэх талаар хүүхдүүд, эцэг эхчүүдийн хийж байгаа ажилд дэмжлэг үзүүлнэ.

Үйл ажиллагааг сард хоёроос дээш явуулж болохгүй. Үйл ажиллагааг сүмийн байр болон айлд хийж болно. Удирдагчид үйл ажиллагааны давтамж болон хийх газрыг тогтоохдоо хүүхдүүдийн гэр орны цагийн боломж, газрын хол болон очих зардал, хүүхдүүдийн аюулгүй байдал, орон нутгийн бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ. Үйл ажиллагааг явуулахад 11.8.1 дэх удирдамж болон 13-р бүлэг -г баримтлах ёстойг удирдагчид анхаарна.

Бишопын зөвлөл үйл ажиллагааны удирдагчдыг тусад нь дуудаагүй бол Хүүхдийн Хэсгийн багш нар үйл ажиллагааг хөтлөн явуулна.

### 11.5.3 Скаутын үйл ажиллагаанууд

Скаутын үйл ажиллагааг Сүмээс зөвшөөрсөн газарт 8-11 насны хөвгүүдэд зориулан явуулдаг. Скаутын үйл ажиллагаанд сайн мэдээг төвлөрүүлэхийн тулд удирдагчид *Бурханд итгэх хөвгүүдийн итгэл* удирдамжийг эх сурвалжуудын нэг болгож ашиглана. Хөвгүүд дээрх удирдамж дахь шаардлагуудыг биелүүлснээр бас Скаутын шашны шагналын болзлыг хангадаг.

Хүүхдийн Хэсгийн багш нар бас Скаутын удирдагчдаар ажиллаж болно. Эсвэл бишопын зөвлөл Скаутын удирдагчдаар үйлчлэх өөр хүмүүсийг дуудаж болно. Скаутын үйл ажиллагаанд 11.8.1 болон 13-р бүлэг дэх удирдамжуудыг баримтлах ёстойг удирдагчид анхаарах хэрэгтэй.

8-11 насны бүх хөвгүүд Скаутад бүртгүүлэх, түүнчлэн Скаутын бүх удирдагчид бүртгүүлж, холбогдох сургалтанд суусан байхыг Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл анхаарна. Скаутын тухай болон жил тутмын өдрийн аялал-зусланг төлөвлөх тухай дэлгэрэнгүй мэдээллийг *Scouting Handbook* болон *Day Camp Guide for Eleven-Year-Old Scouts* удирдамжуудаас үзнэ үү.

Сүм (АНУ дахь) Tiger Cub хөтөлбөр, (Канадын) Beaver хөтөлбөрийг Хүүхдийн Хэсгийн насны хөвгүүдэд хэрэглэдэггүй.

### 11.5.4 Ариун ёслолын цуглааныг Хүүхдийн Хэсгийнхэн хариуцан явуулах нь

Жил бүр нэг удаа ариун ёслолын цуглааныг хариуцан явуулах нь Хүүхдийн Хэсэгт сурч мэдсэн зүйлээ хуваалцах боломжийг хүүхдүүдэд олгодог. Энэ өдөр нь ихэвчлэн дөрөвдүгээр улиралд болдог.

Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл, хөгжмийн удирдагч нар бишопын зөвлөлийн удирдлага дор яриаг бэлтгэнэ. Тэд тухайн үеийн хуваалцах цагийн гарын авлага дахь удирдамжуудыг баримтлах бөгөөд шаардлагатай бол үүнийг хүүхдүүдийн нөхцөл байдалд тохируулан өөрчилж болно.

Үйл ажиллагааг ариун ёслолын цуглаан дээр ариун ёслолыг гүйцэтгэсний дараа үлдсэн бүх цагт эсвэл зарим хэсэгт нь багтаан явуулна. Хүүхдийн Хэсгийн 3-11 насны бүх хүүхдүүд хуваалцах цагаар сурсан дуунуудаа дуулдаг. Хүүхдүүд бас судрын хэсгээс унших буюу цээжээр хэлэх, яриа өгөх, цөөхүүл хамт дуулах, гэрчлэлээ хуваалцах замаар оролцож болно. Хүүхдийн Хэсгийн насанд хүрсэн удирдагч бас товч гэрчлэлээ хуваалцаж болно.

Ариун ёслолын цуглааны ариун нандин чанарыг хадгалах үүднээс үйл ажиллагаанд дуу, дүрс бичлэг, тусгай хувцас зэрэг зүйлс ашиглах ёсгүй.

### 11.5.5 Санваарын тухай танилцуулах уулзалт

Санваарыг танилцуулах уулзалтыг жил бүр 11 настай хөвгүүд, тэдний эцэг эхэд зориулан явуулдаг. Энэ уулзалтын зорилго бол санваарыг ойлгоход хөвгүүдэд тусалж, мөн санваар авахад бэлтгэхэд нь тэднийг тууштай болгох явдал юм. Цуглааны сэдвүүд нь санваарын зорилго, үүрэг хариуцлага, адислалуудын тухай байж болно (зарим санааг *Бурханд итгэх хөвгүүдийн итгэл,* 12–13-р хуудаснаас үзнэ үү).

Бишопын зөвлөлийн гишүүн Санваарыг танилцуулах уулзалтыг хөтлөн явуулах бөгөөд Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүн оролцоно. Бусад удирдагчид түүний дотор диконы болон Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд бас оролцож болно.

Хэрэв тойрогт 11 настай хөвгүүд цөөхөн байдаг бол уулзалтыг гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор бусад тойргуудтай хамтран эсвэл бүх гадасны хэмжээнд явуулж болно. Орон нутгийн хэрэгцээнд тохируулан уулзалтыг ням гарагийн орой диконы чуулгын ням гарагийн хурлын хэсэг болгон явуулж болно. Эсвэл өөр үед явуулж болно.

## 11.6 Гадасны Хүүхдийн Хэсгийн удирдлага

### 11.6.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл

Гадасны туслах бүлгүүдийн талаарх гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн үүрэг хариуцлагыг 15.1-д өгүүлсэн байгаа.

### 11.6.2 Гадасны Хүүхдийн Хэсэгт томилогдсон дээд зөвлөлийн гишүүн

Гадасны ерөнхийлөгч дээд зөвлөлийн нэг гишүүнийг гадасны Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй ажиллуулахаар томилно. Энэ дээд зөвлөлийн гишүүний үүрэг хариуцлагыг 15.3-т өгүүлсэн байдаг. Эдгээр үүрэг хариуцлагаас гадна тэрээр Сүмээс зөвшөөрөл өгсөн газарт 8-11 насны хөвгүүдэд зориулсан Скаутын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тусална (Church's *Scouting Handbook*-ийг үзнэ үү).

#### 11.6.3 Гадасны Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл

Гадасны Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн үүрэг хариуцлагыг 15.4.1-т өгүүлсэн байдаг.

#### 11.6.4 Гадасны Хүүхдийн Хэсгийн нарийн бичиг

Гадасны Хүүхдийн Хэсгийн нарийн бичгийн даргын үүрэг хариуцлагыг 15.4.2-т өгүүлсэн байдаг.

#### 11.6.5 Гадасны Хүүхдийн Хэсгийн хөгжмийн удирдагч

Гадасны Хүүхдийн Хэсгийн хөгжмийн удирдагч нь ерөнхийлөгчийн зөвлөлийнхөө удирдлага дор гадасны Хүүхдийн Хэсгийн удирдлагын хурлууд дээр заавар өгнө. Тэр бас Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөхүүд, хөгжмийн удирдагчид, төгөлдөр хуурчдад заавар өгнө. Гадасны Хүүхдийн Хэсгийн хөгжмийн удирдагч хүсэлт тавьсан үед гадасны хүүхдийн найрал дууг зохион байгуулж, удирдана.

Хөгжмөөр дамжуулан сайн мэдээг хүүхдүүдэд заах үр өгөөжтэй арга замуудыг заавал оруулах ёстой. *Children's Songbook,* хуудас 300–304-т эх сурвалж материалууд байдаг. Мөн энэ гарын авлагын 14-р бүлэг; хуваалцах цагийн тухайн үеийн гарын авлага, LDS.org-ийн Serving in the Church хэсэг дэх "Music Callings and Resources"-ийг үзнэ үү.

### 11.7 Хүүхдийн Хэсгийг орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх нь

Насны ангилалаар нэг бүлэгт олон хүүхэдтэй тойрогт Хүүхдийн Хэсгийн удирдагчид тухайн ангийг хүүхдүүдийг олон анги болгон зохион байгуулж болно. Ийнхүү тохируулан өөрчлөх нь асрах ангийн насны олон хүүхэдтэй тойргуудад бүр илүү чухал байдаг.

Цөөхөн хүүхэдтэй тойрогт Хүүхдийн Хэсгийн удирдагчид өөр өөр насны хоёр буюу түүнээс дээш бүлгийг нэг анги болгон нэгтгэж болно.

Жижигхэн тойрог эсвэл салбарт Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд нь өөрсдөө Хүүхдийн Хэсгийн удирдагчид, багш нар байж болно. Бүр жижиг нэгжид Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч нь Хүүхдийн Хэсгийн цорын ганц удирдагч бөгөөд багш байж болно. Энэ тохиолдолд тэр хуваалцах цагийг хөтлөн явуулж, бүх хүүхдүүдийг нэгтгэсэн ангид заана. Боломжтой бол дараах дэс дараалаар илүү олон удирдагч, багш нарыг дуудах хэрэгтэй:

1. Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөхүүд
2. Хөгжмийн удирдагчид
3. Хүүхдийн хэсгийн болон асрах ангийн удирдагчид
4. Нарийн бичиг
5. Үйл ажиллагааны удирдагч болон Скаутын удирдагчид (Скаут байдаг бол)

Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчгүй маш жижиг салбарт Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч дуудагдтал хүүхдүүддээ хичээл заахад нь эцэг эхчүүдэд тусалж болно.

Жижиг гадас буюу дүүрэгт Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч нь гадасны эсвэл дүүргийн Хүүхдийн Хэсгийн цорын ганц удирдагч байж болно. Боломжтой бол бусад удирдагчдыг дараах дэс дараалаар дуудах хэрэгтэй:

1. Гадасны эсвэл дүүргийн Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөхүүд
2. Хөгжмийн удирдагч
3. Нарийн бичиг

Орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх тухай ерөнхий мэдээллийг 17-р бүлэг -с үзнэ үү.

### 11.8 Нэмэлт удирдамж ба журмууд

#### 11.8.1 Хүүхдийн Хэсэгт үйлчлэх эрэгтэйчүүд

Бишопын зөвлөл болон Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл Хүүхдийн Хэсэгт үйлчлэх гишүүдийг авч хэлэлцэхдээ тойргийн зохистой эрэгтэйчүүдийг харгалзан үзэх хэрэгтэй. Хүүхдүүд, ялангуяа гэртээ зохистой санваартангүй хүүхдүүд халамжтай санваартнуудын зөв шударга үлгэр жишээг харах нь ашиг тустай юм. Эрэгтэй хүмүүс Хүүхдийн Хэсгийн багш, хөгжмийн удирдагч, төгөлдөр хуурч, үйл ажиллагааны удирдагч, Скаутын удирдагчдаар үйлчилж болно. Тэд бас хүүхэд асрахад тусалж болно.

Эрэгтэйчүүд хүүхдэд заахаар томилогдсон үед заавал хариуцлага хүлээх насанд хүрсэн хоёр хүн байлцах ёстой. Насанд хүрсэн хоёр хүн нь хоёр эрэгтэй хүн, эхнэр нөхөр хоёр эсвэл тухайн гэр бүлийн хоёр гишүүн байж болно. Жижиг салбаруудад ангид хоёр багш байх боломжгүй бол Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүн нь эрэгтэй багш зааж байгаа ангиудаар байн байн орж анхаарал тавина.

### 11.8.2 Сүмд бүртгэлтэй найман настай хүүхдүүдийн баптисмын ёслол

20.3.4-ийг үзнэ үү.

### 11.8.3 Хүүхдийн Хэсэгт гэрчлэлээ хуваалцах нь

Эцэг эхчүүд, Хүүхдийн Хэсгийн удирдагчид, багш нар зааж байгаа үедээ энгийн бөгөөд шууд гэрчлэл хэлж, гэрчлэл гэж юу болохыг мэдэж, гэрчлэлээ хэрхэн илэрхийлэхийг сурахад нь хүүхдүүдэд тусалдаг.

Хүүхдийн Хэсэгт гэрчлэлийн цуглаан хийдэггүй. Гэвч эцэг эхчүүд, Хүүхдийн Хэсгийн удирдагчид, багш нар хүүхдүүдэд гэрчлэлээ хуваалцах өөр боломжууд олгож болно. Жишээ нь хүүхдүүд гэр бүлийн үдшийн хичээлээр болон хуваалцах цагаар яриа өгөхдөө гэрчлэлээ хуваалцаж болно. Эдгээр боломж нь хүүхдүүдийг том болохоороо эцэг эх, ах эгч, бусад хүмүүсийн тусламжгүйгээр мацгийн болон гэрчлэлийн цуглаан дээр гэрчлэлээ хуваалцаж чаддаг болоход нь тусалдаг.

### 11.8.4 Хүндэтгэлтэй байдлыг хөхүүлэн дэмжих нь

Хүндэтгэл бол Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт хайр, хүндэтгэлээ илэрхийлэх явдал юм. Хүүхдийн Хэсгийн удирдагчид болон багш нар хүндэтгэл гэж юу болохыг, хэрхэн хүндэтгэлтэй байхыг ойлгоход нь хүүхдүүдэд тусалдаг. Тэд хувийн үлгэр жишээгээрээ хүндэтгэлтэй байдлыг дэмжинэ. Тэд бас сүмд ирэхдээ судруудаас заахаар бэлтгэж, Ариун Сүнсний нөлөөг урих үзүүлэн, суралцах үйл ажилагаануудыг ашигласнаар хүндэтгэлийг бий болгодог.

### 11.8.5 Жүжигчилсэн тоглолтонд Бурханы дүрд тоглох тухайд

Удирдагчид, багш нар жүжигчилсэн тоглолтонд ялангуяа ариун үйл явдлуудыг хүмүүс жүжигчлэн тоглож байгаа үед хүндэтгэлтэй байдлыг сахихад анхаарах ёстой. Бурхан Эцэг, Ариун Сүнс хоёрыг ямар ч байдлаар дүрслэн үзүүлж болохгүй. Есүсийн төрөлтийн хэсгээс бусад тохиолдолд Аврагчийг хүүхэд дүрслэн үзүүлж болохгүй. Нэмэлт удирдамжуудыг 13.6.15-с үзнэ үү.

### 11.8.6 Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд

Хүүхэд байнгын өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл бусад тусгай хэрэгцээтэй бол тэдэнд туслах арга замыг тодорхойлохын тулд Хүүхдийн Хэсгийн удирдагчид санваартны удирдагчидтай зөвлөлдөнө.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ер нь бол ердийн ангид суулгадаг. Шаардлагатай бөгөөд боломжтой бол тэдний ангид заах тусгай багшийг дуудаж болно эсвэл тэдэнд тусад нь зааж болно. Хэрэв өвчин буюу хөгжлийн бэрхшээлээс болоод хүүхдийг гэрт нь байлгахаас өөр аргагүй бол Хүүхдийн Хэсгийн багш нар уг хүүхдэд хичээл заахад гэр бүлийнх нь гишүүдэд тусална. Тухайн хүүхэд Хүүхдийн Хэсэгт өөрийн насны бүлэгт хуваарилагдсан бол багш хичээл заахдаа түүнийг ирснээр тэмдэглэнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй эсвэл бусад тусгай хэрэгцээтэй хүүхдүүд 12 нас хүрэхээрээ Хүүхдийн Хэсгээс дэвшинэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ойлгож, үйл ажиллагаанд хамруулах, тэдэнд заах тухай мэдээллийг 21.1.26; disabilities.lds.org.-аас үзнэ үү.

### 11.8.7 Санхүү

Хүүхдийн Хэсгийн бүх үйл ажиллагааг үүний дотор асрах анги болон Скаутын үйл ажиллагааг тойргийн төсвөөс санхүүжүүлнэ. Хүүхдийн Хэсгийн үйл ажиллагаа, хичээл цуглаанд зориулан худалдаж авсан зүйлс нь тойргийн өмч юм. Эдгээр зүйлсийг Хүүхдийн Хэсгийн ажилтнууд болон тэдний гэр бүлийн гишүүд хувийн зорилгоор ашиглаж болохгүй.

Хэрэв 8-11 насны хүүхдийн жил тутмын аялал зуслан эсвэл үүнтэй төстэй үйл ажиллагааг санхүүжүүлэхэд хүрэлцэх хэмжээний мөнгө тойргийн төсөвт байхгүй бол зардлын зарим хэсгийг өөрсдөө гаргахыг удирдагчид үйл ажиллагаанд оролцогчдоос хүсч болно. Жил тутмын аялал зуслан эсвэл адил төстэй үйл ажиллагааны болон унааны зардал хэт өндөр байж болохгүй. Мөн хувиасаа мөнгө өгөх боломжгүй гишүүдийг үйл ажиллагаанаас хасч болохгүй.

Хувь хүмүүсийн дүрэмт хувцсыг худалдаж авахад Сүмийн мөнгийг ашиглаж болохгүй.

Үйл ажиллагаануудыг санхүүжүүлэх тухай дэлгэрэнгүй мэдээллийг 13.2.8-с үзнэ үү.

# 12. Нярм гарагийн анги


12.1 **Ням гарагийн ангийн зорилго . . . . . . . . . . . 104**

12.2 **Тойргийн Ням гарагийн ангийн удирдлага . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 104**

12.2.1 Бишопын зөвлөл. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 104
12.2.2 Тойргийн Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөл. . . . . . . . . . . . . . . . 104
12.2.3 Ням гарагийн ангийн багш нар . . . . . . . . . 105
12.2.4 Тойргийн Ням гарагийн ангийн нарийн бичиг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 105
12.2.5 Ням гарагийн ангийн ангийн дарга . . . . . 105

12.3 **Удирдлагын хурал . . . . . . . . . . . . . . . . . . . . . 105**

12.3.1 Тойргийн Зөвлөлийн хурал . . . . . . . . . . . . 105
12.3.2 Тойргийн Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал . . . . . . 105
12.3.3 Бишопын зөвлөхтэй уулзах нь . . . . . . . . . . 105
12.3.4 Гадасны Ням гарагийн ангийн удирдлагын хурал . . . . . . . . . . . . . . . . . . . . . 106

12.4 **Ням гарагийн ангиуд . . . . . . . . . . . . . . . . . . . 106**

12.4.1 Залуучуудын анги . . . . . . . . . . . . . . . . . . . . 106
12.4.2 Ганц бие залуу насанд хүрэгчдийн анги. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 106
12.4.3 Хөгжлийн бэрхшээлтэй гишүүдэд туслах нь . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 106

12.5 **Тойрог дахь суралцах, заах чанарыг сайжруулах нь. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 106**

12.6 **Цуглааны байрны номын сан. . . . . . . . . . . . 106**

12.6.1 Тойргийн номын санч ба номын санчийн туслахууд . . . . . . . . . . . . . . . . . . . . 106
12.6.2 Олон тойрог цуглaдаг сүмийн байрны номын сангийн удирдлага . . . . . . . . . . . . . 107
12.6.3 Сүмийн байрны номын сангийн журам. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 107

12.7 **Гадасны Ням гарагийн ангийн удирдлага . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 107**

12.7.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл. . . . . . . . 107
12.7.2 Гадасны Ням гарагийн ангийг хариуцсан дээд зөвлөлийн гишүүн . . . . . . 107
12.7.3 Гадасны Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөл. . . . . . . . . . . . . . . . 107
12.7.4 Гадасны Ням гарагийн ангийн нарийн бичиг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 107

12.8 **Ням гарагийн ангийг орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх нь . . . . . . 107**

# 12. Ням гарагийн анги

Ням гарагийн анги бол санваартнуудад туслах бүлгүүдийн нэг юм. Бүх туслах бүлгүүд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын тухай болон сэргээгдсэн сайн мэдээний тухай гэрчлэлээрээ өсч хөгжихөд нь Сүмийн гишүүдэд туслахын тулд оршин үйл ажиллагаа явуулдаг. Гишүүд сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрахыг хичээн чармайхдаа туслах бүлгүүдээр дамжуулан заавар, урам дэм, дэмжлэг авдаг.

## 12.1 Ням гарагийн ангийн зорилго

12 болон түүнээс дээш настай Сүмийн бүх гишүүд Ням гарагийн ангид хамрагддаг. Бусад шашны хүмүүс ч Ням гарагийн ангийн хичээлд оролцож болно. Ням гарагийн ангийн зорилго бол:

1. Заах, суралцах, нөхөрлөх үйл явцаар дамжуулан Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт итгэх хувь хүмүүсийн болон гэр бүлүүдийн итгэлийг бэхжүүлэх.
2. Сүм дээр болон гэр орондоо "хаант улсын сургаалыг бие биендээ заахад" (С ба Г 88:77) Сүмийн гишүүдэд туслах.

## 12.2 Тойргийн Ням гарагийн ангийн удирдлага

Энэ хэсэгт хувь хүмүүс болон гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэх арга замаар Ням гарагийн ангийг зохион байгуулах талаар онцлон өгүүлнэ. Удирдлагын ерөнхий зарчмуудын тухай өгүүлдэг 3-р бүлэг-г Ням гарагийн ангийн удирдагчид байнга уншиж судлах хэрэгтэй. Эдгээр зарчимд сүнслэг байдлын хувьд бэлтгэх, хурал цуглаануудад оролцох, бусдад үйлчлэх, Есүс Христийн сайн мэдээг заах нь орно.

### 12.2.1 Бишопын зөвлөл

Бишоп болон түүний зөвлөхүүд Ням гарагийн ангийг санваартны удирдлагаар хангана.

Бишоп Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийг дуудаж, адисална. Мөн Ням гарагийн ангийн бусад дуудлагад гишүүдийг дуудаж, адисална. Тэднийг дуудаж адислахыг тэр зөвлөхүүддээ даалгаж болно.

Бишоп зөвлөхүүдийнхээ нэгийг тойргийн ням гарагийн анги болон цуглааны байрны номын санг хариуцуулахаар томилно. Энэ зөвлөх Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй байнга уулзаж байна. Тэрээр Ням гарагийн ангийн болон цуглааны байрны номын сангийн талаарх асуудлуудыг бишопын зөвлөлийн хурал дээр тайлагнаж байна.

### 12.2.2 Тойргийн Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөл

Тойргийн Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөл нь ерөнхийлөгч, хоёр зөвлөхөөс бүрдэнэ. Тэд бүгдээрээ Аароны эсвэл Мелкиседек санваартнууд байх ёстой. Тэд бишопын зөвлөлийн удирдлага дор ажиллана. Тэд гадасны Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлөөс сургалт, байнгын дэмжлэг авна.

#### Тойргийн Ням гарагийн ангийн ерөнхийлөгч

Ням гарагийн ангийн ерөнхийлөгч дараах үүрэг хариуцлагатай:

Тэрээр тойргийн зөвлөлийн гишүүнээр үйлчилдэг. Тэрээр энэ зөвлөлийн гишүүний хувьд хувь хүмүүс, гэр бүлүүдийн итгэлийг төлөвшүүлж, бэхжүүлэх ажилд оролцдог (4-р бүлэг-г үзнэ үү). Тэрээр гишүүдийн сүм дээр болон гэр орондоо суралцах, заах чадварыг сайжруулж болох арга замуудыг тойргийн зөвлөлийн хурал дээр зөвлөмж болгоно. Бишоп урьсан үед тэрээр тойрог дахь сайн мэдээнээс суралцах, заах чадварыг сайжруулахад туслахын тулд тойргийн зөвлөлийн хурлын үеэр сургалт явуулна.

Мөн ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлд үйлчлэх зөвлөхүүд, Ням гарагийн ангийн багш нар, тойргийн номын санч болон түүнд туслах тойргийн гишүүдийг бишопын зөвлөлд санал болгоно. Шаардлагатай бол Ням гарагийн ангийн нарийн бичгээр үйлчлэх гишүүнийг тэрээр бас санал болгоно. Ийнхүү санал болгохдоо тэрээр 19.1.1 болон 19.1.2 дахь удирдамжуудыг баримтална.

Энэ гарын авлагыг ашиглаж, Ням гарагийн ангийн удирдагчдад үүргийг нь заана.

#### Тойргийн Ням гарагийн ангийн ерөнхийлөгч ба түүний зөвлөхүүд

Тойргийн Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд дараах үүрэг хариуцлагыг биелүүлэхийн тулд хамтран ажиллана:

Тэд Ням гарагийн анги дээр сайн мэдээнээс суралцах болон заах чанарыг сайжруулах ажилд хяналт тавина. Энэ ажилд тэд 5.5.3 болон 5.5.4 дэх зарчмуудыг баримтална. Тэд (1) Ням

гарагийн ангийн багш нартай уулзаж, тэдний асуултуудад хариу өгч, асуудлуудыг шийдэж, ангийн гишүүдэд үйлчлэх арга замуудыг ярилцах мөн (2) хичээлд нь суух замаар тэдэнд дэмжлэг үзүүлнэ.

Тэд сайн мэдээнээс суралцах, заах чанарыг сайжруулах мэргэжилтнүүд болж үйлчилдэг (12.5-г үзнэ үү).

Мөн цуглааны байрны номын санг хариуцна. Үүнд (1) шинээр дуудагдсан номын санчдыг сургах, (2) байнгын сургалт дэмжлэгээр хангах, (3) номын санчтай зөвлөлдөж жил бүрийн номын сангийн төсвийг санал болгох нь орно.

Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлыг хийж байна. Тэд Ням гарагийн ангийг хариуцсан бишопын зөвлөлийн гишүүнтэй хуралдана.

Ням гарагийн ангийн ерөнхийлөгч үүрэг хариуцлагынхаа заримыг хариуцуулахаар зөвлөхүүдээ томилно. Жишээ нь Ням гарагийн ангиудыг насны ангилалаар зохион байгуулах, багш нарыг сургах, цуглааны байрны номын санд хяналт тавих, шаардлагатай бол Ням гарагийн ангийг орлон заах багш нарыг зохион байгуулахад туслах үүрэг хариуцлагыг зөвлөхүүддээ хариуцуулан даалгаж болно. Зөвлөхүүд нь ажлынхаа талаар түүнд байнга тайлагнаж байна.

### 12.2.3 Ням гарагийн ангийн багш нар

Ням гарагийн ангийн багш нар бишопын болон Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн томилсон ангиудад заадаг. Тэд 5.5.4 дэх зарчмуудыг баримтална.

### 12.2.4 Тойргийн Ням гарагийн ангийн нарийн бичиг

Шаардлагатай бол бишопын зөвлөл Ням гарагийн ангийн нарийн бичгийн даргыг дуудаж болно. Нарийн бичиг дараах үүрэгтэй байж болно:

Тэрээр ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлын хөтөлбөрийг бэлтгэхэд нь ерөнхийлөгчийн зөвлөлтэй зөвлөлдөнө. Тэр ерөнхийлөгчийн зөвлөлийн хуралд оролцож, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврын биелэлтийг мэдээлнэ.

Тэрээр ирцийн мэдээлэл бэлтгэж, Ням гарагийн ангийн ерөнхийлөгчтэй хамт хянаж, Ням гарагийн ангийн хичээлд оролцоход нь гишүүдийг дэмжих арга замуудыг тодорхойлоход тусална. Багш нар энэ мэдээллийн нэг хувийг авах ёстой.

### 12.2.5 Ням гарагийн ангийн ангийн дарга

Бишопын зөвлөлийн зөвшөөрлөөр, Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөл ангийн даргаар үйлчлэх гишүүдийг дуудаж болно. Ангийн дарга нь эмэгтэй хүн байж болно. Тэд хичээлийн эхэнд товчхон мэндчилж, ангийн шинэ гишүүд, зочдыг танилцуулж, ангийн гишүүдийг нээлт, хаалтын залбирал хийхийг урина. Ирцэд хяналт тавих, хичээлд тогтмол оролцдоггүй ангийн гишүүдтэй нөхөрлөхийг дэмжихэд туслахыг ангийн даргаас хүсч болно.

---

## 12.3 Удирдлагын хурал

### 12.3.1 Тойргийн Зөвлөлийн хурал

Ням гарагийн ангийн ерөнхийлөгч тойргийн зөвлөлийн гишүүнээр үйлчилнэ (4-р бүлэг)-г үзнэ үү.

### 12.3.2 Тойргийн Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал

Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөл нь ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлыг тогтмол хийнэ. Ерөнхийлөгч цуглаан дээр тэргүүлж, хурлыг хөтлөн явуулна. Нарийн бичиг оролцож, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврын биелэлтийг мэдээлнэ.

Хурлын хөтөлбөрт дараах зүйлс орж болно:

1. Дуудлагатайгаа холбогдох судрын хэсгүүд болон Сүмийн удирдагчдын зааврuudыг уншиж, ярилцах.
2. Ням гарагийн ангийн үр өгөөж, багш нар болон ангийн гишүүдийг хөгжихөд нь туслах арга замуудыг хэлэлцэх.
3. Санваартны болон бусад туслах бүлгүүдийн суралцах болон заах чанарыг сайжруулах талаар хүсэлтүүдэд туслах арга замуудыг төлөвлөх.
4. Ирцийн мэдээллийг хянан хэлэлцэх. Ням гарагийн ангийн ирцийг нэмэгдүүлэхийг дэмжих арга замуудыг төлөвлөх.

### 12.3.3 Бишопын зөвлөхтэй уулзах нь

Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөл Ням гарагийн ангид хяналт тавьдаг бишопын зөвлөлийн гишүүнтэй тогтмол уулзаж байна. Тэд эдгээр уулзалтаар тойрог дахь Ням гарагийн ангийн суралцах болон заах ажлын байдлын талаар хамтран зөвлөлдөнө. Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд ажлаа тайлагнаж, санал зөвлөмж гаргаж, хурлуудын төлөвлөгөөг хянан хэлэлцэнэ.

### 12.3.4 Гадасны Ням гарагийн ангийн удирдлагын хурал

Гадасны Ням гарагийн ангийн удирдлагын хурлыг жилд нэгээс хоёр удаа хийж болно. Уг хуралд тойргийн Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд, нарийн бичиг нар оролцоно. Ням гарагийн ангийн багш нар, Ням гарагийн ангид томилогдсон бишопын зөвлөлийн гишүүнийг шаардлагатай бол урьж болно. 18.3.11-г үзнэ үү.

## 12.4 Ням гарагийн ангиуд

Ням гарагийн анги нь ариун ёслолын цуглааны дараа санваартнууд, Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эмэгтэйчүүдийн цуглааны өмнө болдог. Хичээл 40 минут үргэлжилнэ. Хичээл бүр дээр нээлт, хаалтын залбирал хийнэ. Нээлт, хаалтын дуулал дуулах шаардлагагүй.

Ням гарагийн хичээл нь насанд хүрэгчдийн анги, залуучуудын ангиас бүрдэнэ. Батлагдсан хичээлүүд түүний дотор сонгож заах зарим хичээлүүд нь одоо мөрдөж байгаа *Instructions for Curriculum*-д байдаг.

### 12.4.1 Залуучуудын анги

Ням гарагийн хичээлийн ерөнхийлөгчийн зөвлөл 1-р сарын 1-ний байдлаар 12-18 насны залуучуудыг анги болгон зохион байгуулна. Жишээ нь ерөнхийлөгчийн зөвлөл 1-р сарын 1-ний байдлаар 14 эсвэл 15 нас хүрсэн бүх залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг нэг анги болгон зохион байгуулж болно. Эдгээр залуус дараагийн жил хүртэл энэ ангидаа байна.

12 нас хүрсэн залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн Ням гарагийн ангийн тухай мэдээллийг 11.4.3-аас үзнэ үү.

### 12.4.2 Ганц бие залуу насанд хүрэгчдийн анги

Хангалттай олон ганц бие залуу насанд хүрэгчидтэй тойрог бүр тэдэнд зориулан Ням гарагийн ангийг тусад нь зохион байгуулж болно. Багш нар судрууд, Ням гарагийн ангийн батлагдсан гарын авлагуудыг ашиглаж, ганц бие залуу насанд хүрэгчдийн хэрэгцээг онцгой анхаарч заана.

### 12.4.3 Хөгжлийн бэрхшээлтэй гишүүдэд туслах нь

Хөгжлийн бэрхшээлтэй гишүүдийг ойлгож, оролцуулан, заах тухай мэдээллийг 21.1.26 болон disabilities.lds.org-аас үзнэ үү.

## 12.5 Тойрог дахь суралцах, заах чанарыг сайжруулах нь

Тойрог дахь суралцах, заах чанарыг сайжруулах мэргэжилтнүүдээр тойргийн Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд үйлчилдэг. Тэд бишопын зөвлөл эсвэл санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчдын хүссэн үед зөвлөгөө, сургалт өгч, дэмжлэг үзүүлнэ. Шинээр дуудагдсан багш нарыг сургах, өөрсдийн бүлэг дэх суралцах, заах чанарыг сайжруулахад тэд удирдагчдад тусална.

## 12.6 Цуглааны байрны номын сан

Цуглааны байр бүр сайн мэдээнээс суралцах болон заахад гишүүдэд туслах гарын авлага, бусад материалууд бүхий номын сантай байх ёстой. Тойргийн Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөл сүмийн байрны номын санг хариуцна.

Номын сан нь сүмийн байрны хэмжээнээс шалтгаалаад өөр өөр хэмжээтэй байна. Тэд дараах бүх зүйлийг эсвэл заримыг нь номын сандаа байлгах хэрэгтэй. Үүнд: судрууд, Сүмийн сэтгүүлүүд, Сүмээс хэвлэн гаргасан зураг, дуу, дүрс бичлэгийн материалууд, шохой, арилгагч, харандаа, телевизор, DVD тоглуулагч, хувилагч машин.

Тойргууд, институтийн ангиуд, гэр бүлийн түүхийн төвд сүмийн байрны номын санд байгаа гарын авлага, материалуудыг дундаа ашиглах зөвшөөрлийг гадасны ерөнхийлөгчийн зөвлөл өгч болно.

### 12.6.1 Тойргийн номын санч ба номын санчийн туслахууд

Тойргийн номын санч нь байгаа гарын авлага, материал, сургалтын тоног төхөөрөмжийг авч, ашиглахад нь удирдагчид, багш нар болон бусад гишүүдэд тусална. Тэрээр номын санд ажиллах гишүүдийн цагийн хуваарийг гаргаж мөрдүүлнэ. Энэ цагийн хуваарьт бүх номын санчид ням гараг бүр ариун ёслолын цуглаан, Ням гарагийн анги эсвэл Мелкизедек санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн цуглаанд оролцох боломжтой байхыг анхаарна.

Шаардлагатай бол тойргийн номын санч нь номын сангийн ашиглалтыг зохицуулахын тулд бусад тойрог, бүлгүүдтэй хамтран ажиллана. Тэрээр номын сан дахь сургалтын материал, тоног төхөөрөмжүүдийг зохион байгуулалттай байлгаж, анхаарч тордон, гишүүдэд материалуудыг ашиглах энгийн тогтолцоог бий болгоно.

Номын санчийн туслахууд тойргийн номын санчийн заавраар ажиллаж, түүний олон үүрэг хариуцлагаас хуваалцдаг.

### 12.6.2 Олон тойрог цугладаг сүмийн байрны номын санг удирдах нь

Олон тойрог цугладаг байранд тойргууд нэг номын сантай байдаг. Энэ тохиолдолд хариуцагч бишоп номын санг зохицуулах үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тэрээр номын санг ашиглах болон номын сангийн төсвийг захиран зарцуулах хороог томилж болно. Тус хорооны бүрэлдэхүүнд тойрог бүрийн Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүн, тойрог бүрийн номын санч орох ёстой.

### 12.6.3 Сүмийн байрны номын сангийн журам

Сүмийн байрны номын сантай холбоотой журмууд LDS.org-ийн Serving in the Church хэсэг дэх "Sunday School"-д байдаг.

## 12.7 Гадасны Ням гарагийн ангийн удирдлага

### 12.7.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл

Гадасны туслах бүлгүүдийн талаар гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн хүлээдэг үүрэг хариуцлагыг 15.1.-д өгүүлсэн байдаг.

Ням гарагийн ангид хяналт тавьдаг гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн бас гадас дахь сүмийн байрны номын сангуудад хяналт тавьдаг.

### 12.7.2 Гадасны Ням гарагийн ангийг хариуцсан дээд зөвлөлийн гишүүн

Гадасны ерөнхийлөгч дээд зөвлөлийн нэг гишүүнийг гадасны Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй ажиллуулахаар томилно. Энэ дээд зөвлөлийн гишүүний үүрэг хариуцлагыг 15.3-т өгүүлсэн байгаа.

### 12.7.3 Гадасны Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөл

Гадасны ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд нь санваартнууд байна. Боломжтой бол тэд Мелкизедек санваартай байх ёстой. Тэдний үүрэг хариуцлагыг 15.4.1-д өгүүлсэн байдаг. Түүнээс гадна тэд дараах үүрэг хариуцлагатай:

Тэд сайн мэдээнээс суралцах, заах чанарыг сайжруулах зохицуулагчид болж үйлчилдэг.

Гадсан дахь сүмийн байрны номын сангуудын ашиглалт, үйл ажиллагааг зохицуулна. Үүнд дараах ажлууд орно:

1. Тойргийн Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөл хүссэн үед шинээр дуудагдсан тойргийн номын санчдыг сургахад туслах.
2. Тойргийн номын санчид, гадасны хэмжээн дэх номын санчдын туслахуудад зориулан сургалт, цулаануудыг зохион байгуулах.
3. Сүмийн байрны номын сангууд шаардлагатай гарын авлага, материал, тоног төхөөрөмжөөр хангагдсан байхад анхаарах.
4. Сүмийн байрны номын санд гадасны удирдагчдад шаардлагатай сургалтын материал, тоног төхөөрөмж байгаа эсэхийг анхаарах.

### 12.7.4 Гадасны Ням гарагийн ангийн нарийн бичиг

Гадасны Ням гарагийн ангийн нарийн бичгийн үүрэг хариуцлагыг 15.4.2-т өгүүлсэн байдаг.

## 12.8 Ням гарагийн ангийг орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх нь

Жижиг тойрог эсвэл салбарт Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд багшаар үйлчилж болно. Шаардлагатай бол залуучуудын ангиудыг нийлүүлж болно. Бүр жижиг нэгжид Ням гарагийн ангийн ерөнхийлөгч нь Ням гарагийн ангийн цорын ганц удирдагч бөгөөд багш байж болно. Энэ тохиолдолд тэрээр 12 болон түүнээс дээш насны бүх гишүүдийн ангид Ням гарагийн хичээлийг заана. Боломжтой бол илүү олон удирдагч, багш нарыг дуудах хэрэгтэй.

Жижиг гадас буюу дүүрэгт ням гарагийн ангийн ерөнхийлөгч нь гадасны эсвэл дүүргийн ням гарагийн ангийн цорын ганц удирдагч байж болно. Боломжтой бол зөвлөхүүдийг дуудах ёстой. Гадасны Ням гарагийн ангийн нарийн бичгийг дуудаж болно.

Орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх тухай ерөнхий мэдээллийг 17-р бүлэг -с үзнэ үү.

# 13. Үйл ажиллагаанууд


13.1 **Сүмийн үйл ажиллагааны зорилго .......110**

13.2 **Үйл ажиллагаануудыг төлөвлөх нь .......110**

13.2.1 Үйл ажиллагаануудыг төлөвлөх нь ..... 110
13.2.2 Гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэх нь ..... 110
13.2.3 Оролцоог дэмжих нь.................. 110
13.2.4 Жишгүүд............................ 110
13.2.5 Аюулгүй байдал..................... 111
13.2.6 Үйл ажиллагааны төрлүүд ........... 111
13.2.7 Үйл ажиллагаануудын цагийн хуваарь ............................ 111
13.2.8 Үйл ажиллагаануудын санхүүжилт .... 112
13.2.9 Тоног төхөөрөмж, материал хэрэгслийн санхүүжилт............... 112

13.3 **Гадасны, гадас дундын болон бүсийн үйл ажиллагаа...................112**

13.3.1 Ерөнхий удирдамж................... 112
13.3.2 Гадасны үйл ажиллагааны хороо....... 113

13.4 **Залуучуудын чуулган ...................114**

13.5 **Нэмэлт үйл ажиллагаа ..................114**

13.6 **Бодлого ба удирдамж ...................115**

13.6.1 Ослоос урьдчилан сэргийлэх ба хариу арга хэмжээ авах тухай ......... 115
13.6.2 Насанд хүрэгчдэд тавих хяналт........ 115
13.6.3 Арилжааны болон улс төрийн үйл ажиллагааны тухай................... 115
13.6.4 Зохиогчийн эрх бүхий материалууд.... 115
13.6.5 Хөл хорих хууль...................... 115
13.6.6 Хөгжим бүжиг ....................... 115
13.6.7 Үйл ажиллагаанд оролцогчдод зориулсан онцгой цугларалт........... 115
13.6.8 Хандив цуглуулах үйл ажиллагаа ...... 115
13.6.9 Даатгал.............................. 116
13.6.10 Даваа гарагийн үдэш ................. 116
13.6.11 Шинэ жилийн үдэшлэг ............... 117
13.6.12 Хоногоор явах үйл ажиллагаа.......... 117
13.6.13 Эцэг эхийн зөвшөөрөл ................ 117
13.6.14 14-өөс доош насны залуучуудын оролцоо ............................ 118
13.6.15 Бурханы дүрд тоглох тухайд........... 118
13.6.16 Үйл ажиллагааны залбирал............ 118
13.6.17 Үйл ажиллагаанд зориулж Сүмийн бус барилга байгууламж түрээслэх..... 118
13.6.18 Хүчирхийллийн тухай мэдэгдэх нь..... 118
13.6.19 Хүндэтгэлийн өдрийг сахих тухай ..... 118
13.6.20 Аюулаас урьдчилан сэргийлэх, осол гарсан үед авах арга хэмжээ ба ослын тухай мэдээлэх нь............ 118
13.6.21 Спортын үйл ажиллагаа .............. 119
13.6.22 Татвар ноогддог үйл ажиллагаанууд.... 120
13.6.23 Ариун сүмд орох тухай ............... 120
13.6.24 Аялал .............................. 120
13.6.25 Зөвшөөрөгдөөгүй үйл ажиллагаа....... 121

# 13. Үйл ажиллагаанууд

## 13.1 Сүмийн үйл ажиллагааны зорилго

Тойрог, гадас, гадас дундын үйл ажиллагаанууд нь Сүмийн гишүүдийг "ариун хүмүүсийн адил нутгийн иргэд" (Ефес 2:19) болгон хамтад нь цуглуулдаг билээ. Үйл ажиллагаанууд нь хөгжилтэй, сонирхолтойгоос гадна гэрчлэлтэй болгож, гэр бүлүүдийг бэхжүүлэн, эв нэгдэл, хувийн өсөлт хөгжилтийг дэмждэг билээ.

Үйл ажиллагаанууд нь хамтач үзэл санаа, дэмжин туслах хүслийг бий болгосноор гишүүдийг бэхжүүлдэг. Үйл ажиллагаанууд нь өөрсдийн насны бусад хүмүүс, удирдагчид, гэр бүлийнхэнтэйгээ ойр дотно холбоотой байхад нь гишүүдэд туслах ёстой. Бас сайн мэдээгээр амьдрах нь "гэгээнтнүүдэд баяслыг" (Инос 1:3) хэрхэн авчирч байгааг харахад гишүүдэд туслах ёстой.

Сүмийн үйл ажиллагаануудыг сайн мэдээн дээр төвлөрсөн зорилгуудыг хэрэгжүүлэхийн тулд төлөвлөх ёстой. Дээр дурдсан ерөнхий зорилгуудаас гадна дараах зорилгууд байдаг:

1. Гишүүдийг адисалж, нийгмийн оролцоог идэвхжүүлдэг үйлчлэлүүдэд оролцох.
2. Авьяас болон урлагын мэдрэмжийг хөгжүүлэх.
3. Бие бялдар болон спортын ур чадвараа хөгжүүлэх.
4. Боловсрол эзэмших ба мэргэжлийн сургалтанд хамрагдах.
5. Онцгой үйл явдлууд мөн Сүмийн болон орон нутгийн тэмдэглэлт үйл явдлуудыг зохион байгуулах.
6. Удирдлагын ур чадварыг хөгжүүлэх.
7. Бие даах чадварыг хөгжүүлэх.
8. Номлолын ажил, гишүүдийг идэвхтэй хэвээр байлгах, идэвхжүүлэх, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд оролцох.

## 13.2 Үйл ажиллагаануудыг төлөвлөх нь

### 13.2.1 Үйл ажиллагаануудыг төлөвлөх нь

Удирдагчид үйл ажиллагааг төлөвлөхөөсөө өмнө гишүүдийн сүнслэг болон материаллаг хэрэгцээг харгалзаж үзэх ёстой. Ямар үйл ажиллагаа гишүүдийн хэрэгцээг хангахад тусалж чадах талаар удирдагчид Сүнсний удирдамжийг эрэлхийлнэ. Үйл ажиллагаанууд нь сайн мэдээн дээр төвлөрсөн зорилгыг хэрэгжүүлж, оролцогчдын хэрэгцээг хангадаг байхын тулд нягт нягуур төлөвлөлт шаардлагатай.

Тойргийн зөвлөл бишопын зөвлөлийн удирдлага дор тойргийн үйл ажиллагаануудын төлөвлөлтөнд хяналт тавина. Үйл ажиллагаа нь тойргийн аль нэг туслах бүлэгт зориулагдсан бол уг бүлгийг хариуцсан санваартны эсвэл туслах бүлгийн удирдлага дор төлөвлөгдөнө. Үйл ажиллагаа нь тойрогт зориулагдсан бол бишоп тойргийн зөвлөлийн бүрэлдэхүүн дэх нэг эсвэл хоёр бүлэгт уг ажлыг даалгаж болно. Тэрээр үйл ажиллагаа зохион байгуулах ажлыг тойргийн зөвлөлийн удирдлага дор ажиллах бусад хувь хүмүүс, хороонд даалгаж болно. Ихэнхдээ эдгээр үүрэг даалгаврыг аль нэг үйл ажиллагаанд зориулж, түр хугацаагаар өгдөг.

Гадасны зөвлөл нь гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор гадасны үйл ажиллагаануудын төлөвлөлтөнд хяналт тавина. Гадасны үйл ажиллагаануудын тухай дэлгэрэнгүй мэдээллийг 13.3-аас үзнэ үү.

### 13.2.2 Гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэх нь

Удирдагчид үйл ажиллагаанууд нь гэр бүлийг бэхжүүлэх ёстойг анхаарна. Зарим үйл ажиллагаа нь гэр бүл дээр төвлөрч, хамтдаа оролцох боломжийг гэр бүлүүдэд олгодог байж болно. Үйл ажиллагаа нь эцэг эхчүүдийг хүүхдүүддээ Христийн итгэлтэй дагалдагчид байх талаар заахыг дэмжих ёстой.

Хэтэрхий олон үйл ажиллагаагаар гишүүдэд ачаалал өгөхгүй байхыг удирдагчид анхаарах хэрэгтэй.

### 13.2.3 Оролцоог дэмжих нь

Үйл ажиллагаанд идэвхтэй оролцох нь зүгээр үзэхээс илүү үр өгөөжтэй байдгийг анхаарч үйл ажиллагааг төлөвлөхдөө олныг хамруулахыг анхаарах нь зүйтэй. Оролцоог дэмжих нэг арга зам бол өөрсдийн бэлэг буюу ур чадвар, авьяасыг үйл ажиллагааны үеэр харуулах боломжийг гишүүдэд олгох явдал юм.

Үйл ажиллагааг төлөвлөгчид шинэ болон идэвх султай гишүүд, залуучууд, ганц бие насанд хүрэгчид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, бусад шашны хүмүүст хүрч ажиллахад онцгой хүч чармайлт гаргах ёстой. Бие бялдар хөгжлийн бэрхшээл, гэр бүлийн асуудал, соёл,

хэлний ялгаа зэрэг онцгой нөхцөл байдалд удирдагчид соргог анхааралтай хандах хэрэгтэй.

### 13.2.4 Жишгүүд

Сүмийн үйл ажиллагаанууд Сүмийн жишгүүдийг баримталж мөн заадаг байх ёстой. Үйл ажиллагаа нь оролцогчдод ижил төстэй итгэл үнэмшил болон хүмүүжилтэй бусад хүмүүстэй нөхөрлөх орчныг бүрдүүлдэг байх ёстой. Мөн “ариун журамтай, сайхан, эсвээс сайн гэгддэг буюу сайшаалтай”(Итгэлийн Тунхаг 1:13) зүйлсийг дээдэлж, онцгой ач холбогдол өгдөг байх ёстой. Үйл ажиллагаанд ёс суртахуунгүй, муу зүйлсийг хэвийн зүйл болгон харагдуулах, тийм санаа төрүүлэх аливаа зүйлийг хийх ёсгүй. Аливаа үзвэр нь Аврагчийн сургаалуудын дагуу байгаа эсэхэд удирдагчид анхаарах ёстой.

Хувцаслалт, үс засалт нь энгийн даруу, үзэмжтэй, тухайн үйл ажиллагаанд тохирсон байх ёстой. Үйл ажиллагааны хувцаслалтын жишгийг бишопын буюу гадасны ерөнхийлөгчийн зөвлөл шийднэ. Үйл ажиллагааг төлөвлөсөн удирдагчид сайн мэдээний зарчмуудад нийцсэн хувцаслалтын жишгүүдийг зөвлөмж болгох хэрэгтэй.

Сүмийн үйл ажиллагаануудын үеэр болон Сүмийн байранд Мэргэн Ухааны Үгэнд нийцэхгүй зүйлсийг хэрэглэхийг зөвшөөрдөггүй. Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн нь илт байгаа хүмүүсийг Сүмийн үйл ажиллагаанд оруулах ёсгүй.

Сүмийн жишгүүдийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлоос үзнэ үү.

### 13.2.5 Аюулгүй байдал

13.6.20-ийг үзнэ үү.

### 13.2.6 Үйл ажиллагааны төрлүүд

Удирдагчид олон янзын үйл ажиллагаануудыг төлөвлөж хөтөлбөр гаргах ёстой. Гишүүд сонирхолдоо нийцсэн үйл ажиллагаанудад оролцох боломжтой байх хэрэгтэй. Бусад хүмүүсийг сонирхсон үйл ажиллагаандаа оролцохыг гишүүд дэмжих ёстой. Жил бүр үйл ажиллагааг календарчилан төлөвлөх нь гишүүдээс хэт их цаг шаардахгүй үйлчлэл үзүүлэх, соёл урлагийн болон бие бялдрыг хөгжүүлэх үйл ажиллагаануудыг зохион байгуулахад удирдагчдад тусалдаг.

Зохистой үйл ажиллагаануудын зарим жишээг доор харуулав.

#### Үйлчлэл

Үйлчлэл нь тусламж хэрэгтэй хүмүүст Сүмийн гишүүн эсэхийг нь харгалзалгүйгээр хайраа харуулж, тэдэнд тусалсныхаа баяр баясгаланг мэдрэх боломжийг гишүүдэд олгодог. Эдгээр үйл ажиллагаанд өвчтэй буюу ганцаардсан хүмүүсийг эргэж очих, халамжийн ажил үүргийг биелүүлэх, Сүмийн барилга, газрыг тохижуулах, нийгмийн үйлчлэлийн төслүүдэд оролцох зэрэг багтдаг.

#### Соёл урлаг

Соёл урлагийн үйл ажиллагаа нь авьяас чадвар, сонирхдог зүйлээ хөгжүүлэх боломжийг гишүүдэд олгодог. Мөн бүтээлч чанар, өөртөө итгэх итгэл, бусадтай харьцах, хамтран ажиллах чадварыг хөгжүүлдэг. Эдгээр үйл ажиллагаанд авьяас шоу, бүжиг, дуу хөгжим, жүжигчилсэн тоглолт орж болно. Мөн орон нутгийн болон Сүмийн түүхт үйл явдлыг тэмдэглэх орж болно.

#### Спорт, амралт чөлөөт цаг, эрүүл мэнд, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагаа

Сүмийн спортын үйл ажиллагааны тухай мэдээллийг 13.6.21-ээс үзнэ үү.

Амралт чөлөөт цагийн үйл ажиллагаанууд нь тухайн бүс дэх нөөц боломжоос хамааран өөр өөр байж болно. Эдгээрт түүхэн тэмдэглэлт үйл явдлууд, аялал зуслан, явган аялал, хоббигоо хөгжүүлэх үйл ажиллагаанууд орж болно. Амралт чөлөөт цагийн үйл ажиллагааг ихэвчлэн гэр бүлүүд хамтдаа оролцож болохоор төлөвлөнө.

Гишүүдийг эрүүл мэнд, чийрэгжилтэнд чухал ач холбогдолтой үйл ажиллагаанудад хувиараа, гэр бүлээрээ, Сүмийн бүлгүүдээр оролцохыг нь дэмждэг. Эдгээр үйл ажиллагаанд явган явах, гүйх, аэробикийн болон биеийн тамирын бусад дасгал, эрүүл мэндийн хичээл, чийрэгжилтийн сургалт орж болно (13.6.25, зүйл 2-ыг үзнэ үү).

### 13.2.7 Үйл ажиллагаануудын цагийн хуваарь

Сүмийн үйл ажиллагаануудыг аль болох эртнээс төлөвлөнө. Үйл ажиллагаануудыг гадас, тойргийн календарт оруулдаг байх хэрэгтэй. Хүүхэд залуучуудад зориулсан үйл ажиллагаануудын талаар удирдагчид эцэг эхчүүдэд байнга мэдээлдэг байх хэрэгтэй.

Хэрэв үйл ажиллагаа нь цуглааны эсвэл Сүмийн өөр байранд болох бол төлөвлөгчид өөр үйл ажиллагаа, хурал цуглаан давхцахаас сэргийлж, урьдчилан мэдэгдэж зохицуулсан байна. Сүмийн байр бүрд гадасны ерөнхийлөгчийн

зөвлөлөөс хариуцагч бишоп томилогддог. Тэрээр сүмийн байрны цагийн хуваарийг хийлгэхээр ихэвчлэн өөр хүн томилдог ч цагийн хуваарьт өөрөө хяналт тавьдаг.

Даваа гарагийн оройг зөвхөн гэр бүлийн үдэшт зориулна (13.6.10-ыг үзнэ үү).

### 13.2.8 Үйл ажиллагаануудын санхүүжилт

Үйл ажиллагааны зардал нь тухайн жилийн төсөвт багтаж, Сүмийн санхүүгийн бодлоготой нийцэж байх ёстойг удирдагчид анхаарна. Ингэхдээ дараах зарчмуудыг баримтална.

Ихэнх үйл ажиллагаа нь энгийн бөгөөд бага зардалтай эсвэл бүр зардалгүй байж болно. Зардлыг зарцуулахаас өмнө гадасны буюу бишопын зөвлөл баталсан байх ёстой.

Гадасны болон тойргийн төсвөөс Сүмийн бүх үйл ажиллагаа, хөтөлбөрүүд болон материалын үнийг төлдөг. Гишүүд үйл ажиллагаанд оролцсоныхоо төлөө хураамж төлөх ёсгүй. Тэд мөн материал, эд юмс өгөх, түрээс болон орох эрхийн хураамж, хол газар аялах тээврийн зардлыг төлөх ёсгүй. Гишүүд хоол авчирдаг үйл ажиллагаанууд явуулж болох бөгөөд энэ нь тэдэнд төвөг учруулахаар байх ёсгүй.

Дээр дурдсан үйл ажиллагааны санхүүжилтийн бодлогыг доор жагсаасан онцгой тохиолдолд баримтлахгүй байж болно. Удирдагчид дараах үйл ажиллагаануудын зардлыг төлөхөд тойргийн төсөв хүрэлцэхгүй байвал зардлыг бүгдийг нь буюу зарим хэсгийг нь төлөхийг оролцогчдоос хүсч болно:

1. Олон хоногоор явдаг жил тутмын Скаутын аялал зуслан эсвэл залуу эрэгтэйчүүдийн үүнтэй төстэй үйл ажиллагаа.
2. Залуу эмэгтэйчүүдийн жил тутмын аялал зуслан эсвэл үүнтэй төстэй үйл ажиллагаа.
3. Хүүхдийн Хэсгийн 8-11 настай хүүхдүүдийн жил тутмын аялал зуслан эсвэл үүнтэй төстэй үйл ажиллагаа.
4. Бусад нэмэлт үйл ажиллагаануудыг 13.5.-д өгүүлсэн байдаг.

Хэрэв оролцогчдоос гаргасан мөнгө хүрэлцэхгүй бол бишоп 13.6.8 дахь удирдамжийн дагуу хандив цуглуулах үйл ажиллагааг жил бүр зохиож байх зөвшөөрлийг нэг бүлэгт олгож болно.

Жил тутмын аялал зуслан, үүнтэй адил төстэй үйл ажиллагааны болон унааны зардал хэт өндөр байж болохгүй. Мөн хувиасаа мөнгө өгөх боломжгүй гишүүдийг үйл ажиллагаанаас хасч болохгүй.

Ганц бие залуу насанд хүрэгчдэд зориулсан гадас дундын буюу бүсийн томоохон үйл ажиллагааны санхүүжилтэнд баримталж болох онцгой тохиолдлыг 16.3.7.-гоос үзнэ үү.

Үйл ажиллагаатай холбоотой аяллыг санхүүжүүлэх тухай удирдамжийг 13.6.24-с үзнэ үү.

### 13.2.9 Тоног төхөөрөмж, материал хэрэгслийн санхүүжилт

Боломжтой бол залуучуудын жил тутмын аялал зусланд шаардлагатай тоног төхөөрөмж, материал хэрэгслийг тойргийн төсвөөс худалдаж авах хэрэгтэй. Хэрэв төсөв хүрэлцэхгүй бол 13.6.8 дахь удирдамжийн дагуу хандив цуглуулах үйл ажиллагааг жил бүр зохиож байх зөвшөөрлийг бишоп нэг бүлэгт олгож болно.

Тойргийн төсвөөс эсвэл хандив цуглуулах үйл ажиллагаагаар худалдаж авсан тоног төхөөрөмж, материал хэрэгслийг зөвхөн Сүмийн зорилгоор ашиглана. Тэдгээр зүйлсийг хүмүүс, гэр бүлүүд хувийн зорилгоор ашиглаж болохгүй.

Хувь хүмүүст зориулан дүрэмт хувцас худалдаж авахад Сүмийн мөнгийг ашиглаж болохгүй.

## 13.3 Гадас, гадас дундын болон бүсийн үйл ажиллагаа

### 13.3.1 Ерөнхий удирдамж

Сүмийн ихэнх үйл ажиллагаа тойргийн хэмжээнд явагддаг. Гэвч 13.1-д тайлбарласан зорилгуудыг хэрэгжүүлэхэд илүү үр өгөөжтэй байж болох гадасны болон гадас дундын үйл ажиллагаануудыг зохион байгуулж байхыг орон нутгийн удирдагчдад зөвшөөрдөг.

Гадасны болон гадас дундын үйл ажиллагаанууд нь залуучууд, ганц бие залуу насанд хүрэгчдэд онцгой ашиг тустай. Эдгээр үйл ажиллагаа нь цөөхөн залуу гишүүдтэй нэгж эсвэл олон залуу гишүүдтэй нэгжтэй ховорхон харилцдаг газарт илүү чухал юм. Сайн төлөвлөсөн гадасны болон гадас дундын үйл ажиллагаанууд нь залуу гишүүдэд Сүмийн гишүүнчлэлдээ сэтгэл өөдрөг байх, олон найз нөхөдтэй болох болон ирээдүйд ариун сүмд гэрлэх ханьтайгаа учрах боломжийг олгодог.

Ганц бие залуу насанд хүрэгчид тохиромжтой үед, бага зардал гаргаж цуглах боломжтой бол гадас дундын олон төрлийн энгийн үйл ажиллагааг ойр ойрхон зохион байгуулах хэрэгтэй. Ганц бие залуу насанд хүрэгчдэд зориулсан

томоохон үйл ажиллагааг мөн зохион байгуулж болно.

Гадасны бүх үйл ажиллагааг гадасны ерөнхийлөгчийн зөвлөл баталж, гадасны зөвлөлийн хурлаар зохицуулж байх ёстой. Гадасны удирдагчид гадасны үйл ажиллагааны тухай тойргийн удирдагчдад тодорхой хугацааны өмнө мэдэгдэнэ. Гадасны үйл ажиллагаа нь тойргийн үйл ажиллагаатай өрсөлдөх биш харин тэдгээрт нэмэр болох учиртайг анхаарна.

Гадас дундын үйл ажиллагаа гадасных нь гишүүдэд ашиг тусаа өгнө гэж гадасны ерөнхийлөгчид үзэх юм бол Дальн Ерөнхийлөгчийн зөвлөл эсвэл Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнээс зөвшөөрөл хүсч болно. Баяр ёслол болон орон нутгийн чухал үйл явдлыг тэмдэглэх нь ийм үйл ажиллагаануудыг явуулах боломж олгодог. Залуучуудын чуулган (13.4-ийг үзнэ үү), үйлчлэлийн болон соёл урлагийн, спорт ба амралт чөлөөт цагийн үйл ажиллагаануудыг гадас дундын түвшинд явуулж болно. Ийм үйл ажиллагаануудыг зохицуулах зөвлөлийн хурлаар олонтаа зохицуулдаг.

Гадасны ерөнхийлөгч нар гадас дундын үйл ажиллагааг төлөвлөхөөс өмнө уг үйл ажиллагаа нь гишүүдийн хэрэгцээнд үнэхээр тохирсон эсэхийг тодорхойлно. Мөн тэд үйл ажиллагааны зардал, хугацаа, унаа тээврийг тооцож үзэх ёстой. Түүнээс гадна гадасны ерөнхийлөгч нар аюулгүй байдлын хүчин зүйлс, шаардлагатай нөөц боломжоо тооцож үзэх ёстой.

Дальн эсвэл Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн нь Бүсийн Дальг эсвэл гадасны ерөнхийлөгчдийг гадас дундын болон бүсийн үйл ажиллагаануудыг төлөвлөж хэрэгжүүлэх хороодын тэргүүлэгчдээр томилж болно. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлүүд эдгээр хороодод үйлчлүүлэхээр гадасныхаа гишүүдийг дуудаж болно. Эдгээр гишүүд гадасны ерөнхийлөгчийн зөвлөлд ажлаа тайлагнана.

Гадас дундын ихэнх үйл ажиллагаануудыг оролцогч гадаснуудын төсвөөс санхүүжүүлнэ. Ариун сүмийг онцгойлон адислахад зориулсан соёл урлагийн томоохон үйл ажиллагаа зэргийн төсөв нь батлагдсан бол бүсээс эсвэл Сүмийн удирдах газраас санхүүжүүлж болно.

Гадасны, гадас дундын, бүсийн үйл ажиллагаанууд нь Сүмийн жишгүүд болон Сүмийн ажлаар явах тухай дүрэм, журмуудтай нийцэж байх ёстой (13.2.4 болон 13.6.24-ийг үзнэ үү). Эдгээр үйл ажиллагаа нь чадварлаг удирдлага, нягт нямбай төлөвлөлт, зохих нөөц бололцоог шаарддаг.

## 13.3.2 Гадасны үйл ажиллагааны хороо

Гадасны үйл ажиллагаануудыг 13.2 дахь удирдамжийг баримтлан төлөвлөнө. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл нь гадасны үйл ажиллагаануудыг төлөвлөхөд гадасны зөвлөл, гадасны туслах бүлгүүдэд туслах гадасны үйл ажиллагааны хороог байгуулж болно. Гадасны үйл ажиллагааны хороо нь тэргүүлэгч (дээд зөвлөлийн гишүүн), гадасны үйл ажиллагааны нэг буюу хоёр удирдагч, (шаардлагатай бол) гадасны үйл ажиллагааны мэргэжилтнүүдээс бүрдэнэ.

Гадасны үйл ажиллагааны хорооны гишүүд нь гадасны үйл ажиллагаануудыг төлөвлөхөд туслахаас гадна тойргийн үйл ажиллагаануудыг төлөвлөхөд тойргийн удирдагчдад зөвлөгөө, заавар өгч, дэмжлэг үзүүлдэг.

Тойргийн үйл ажиллагаануудыг төлөвлөдөг түр хугацааны хороодтой адилгүй нь гадасны үйл ажиллагааны хороо нь ихэвчлэн нэгээс илүү олон гадасны үйл ажиллагааг төлөвлөдөг.

### Гадасны үйл ажиллагааны хорооны тэргүүлэгч

Хэрэв гадасны ерөнхийлөгчийн зөвлөл гадасны үйл ажиллагааны хороо байгуулбал, хорооны тэргүүлэгчээр нэг дээд зөвлөлийн гишүүнийг томилно. Гадасны ерөнхийлөгчийн тодорхойлсноор, хорооны тэргүүлэгч дараах үүрэг хариуцлагатай:

Тэрээр гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн баталсан гадасны календарт тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, зохицуулна.

Гадасны үйл ажиллагаануудыг төлөвлөхөд хорооны гишүүд хэрхэн тусалж байгаад хяналт тавина.

Тухайн жил эхлэхээс өмнө жил бүр гадасны үйл ажиллагааны нарийвчилсан төсвийг гадасны ерөнхийлөгчийн зөвлөлд танилцуулна. Энэ төсөвт гадасны туслах бүлгүүдийн төлөвлөсөн үйл ажиллагаанууд ордоггүй.

Гадасны туслах бүлгүүдэд үйл ажиллагаагаа төлөвлөхөд нь тэрээр мэдээллээр туслахын тулд гадасны гишүүдийн авьяас чадвар, сонирхдог зүйлсийн жагсаалт хөтөлнө. Энэ жагсаалтыг гаргахад гадасны тойргуудад томилогдсон дээд зөвлөлийн гишүүд түүнд тусалж болно. Энэ зорилгоор Talent and Interest Survey form (Авьяас чадвар ба сонирхдог зүйлсийн судалгааны маягт)-г ашиглаж болно.

### Гадасны үйл ажиллагааны удирдагчид ба зохицуулагчид

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн эсвэл томилогдсон дээд зөвлөлийн гишүүн

гадасны үйл ажиллагааны удирдагчдыг дуудаж болно. Тэд гадасны үйл ажиллагааны хороонд хорооны тэргүүлэгчийн удирдлага дор үйлчилнэ. Гадасны үйл ажиллагааны удирдагчид үйлчлэлийн болон соёл урлагийн, спортын ба чийрэгжүүлэх үйл ажиллагаа болон бусад олон үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахад тусалж болно.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн эсвэл томилогдсон дээд зөвлөлийн гишүүн нь гадасны үйл ажиллагааны зохицуулагчдыг дуудаж болно. Эдгээр зохицуулагчдыг дэмжүүлэн батлуулж мөн онцгойлон адисалдаггүй. Тэд гадасны үйл ажиллагааны хорооны тэргүүлэгчийн удирдлага дор үйлчилдэг.

## 13.4 Залуучуудын чуулган

14-18 насны залуу эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг залуучуудын чуулган гэж нэрлэгддэг нэг удаагийн эсвэл байнгын үйл ажиллагаанд оролцохыг урьдаг. Залуучуудын чуулганыг тойргийн эсвэл гадасны төвшинд ихэвчлэн жилд нэг удаа зохион байгуулдаг. Чуулганыг гадас дундын болон бүсийн төвшинд зохион байгуулж болно.

Залуучуудын чуулганы зорилго бол Есүс Христэд итгэх итгэлийг бий болгох, гэрчлэлээ бэхжүүлж, авьяас чадвараа хөгжүүлэн, шинэ найз нөхөдтэй болох, адил итгэл бишрэл, жишгүүдтэй залуучуудтай цагийг хөгжилтэй өнгөрөөхөд нь залуучуудад туслах явдал юм. Залуучуудын чуулганыг төлөвлөхөд тусалснаар залуучууд удирдлагын арга барилд суралцдаг.

Бишопын зөвлөлийн залуучуудын хороо нь бишопын зөвлөлийн удирдлага дор залуучуудын чуулганыг төлөвлөн явуулдаг. Бишопын зөвлөл тойргийн залуучуудын чуулганы төлөвлөгөөг гадасны ерөнхийлөгчийн зөвлөлөөр батлуулна.

Гадасны залуучуудын чуулганыг гадасны Аароны санваартнууд–Залуу Эмэгтэйчүүдийн хороо нь гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор төлөвлөж, зохион байгуулдаг. Гадасны залуучуудын чуулганыг төлөвлөхөд залуучуудыг аль болох өргөнөөр оролцуулахаар урих ёстой. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл шаардлагатай үед дээрх хорооны хурлуудад залуучуудыг урьж оролцуулж болно.

Залуучуудын чуулганыг гадасны эсвэл тойргийн төсвөөс санхүүжүүлнэ. Залуучуудын чуулганд зориулж мөнгө төлөхийг гишүүдээс хүсч болохгүй.

Удирдагчид болон залуучууд чуулганыг төлөвлөхдөө энэ бүлэг дэх журам болон дараах удирдамжуудыг баримтлах ёстой.

1. Залуучуудад сүнслэгээр нөлөөлж, чуулганы зорилгыг ойлгоход нь туслах судар зэргээс сайн мэдээний аль нэг сэдвийг сонгож авах. Мючелийн жил тутмын сэдвийг залуучуудын чуулганы сэдэв болгон сонгож болно. Бишопын зөвлөл эсвэл гадасны ерөнхийлөгчийн зөвлөл сэдвийг батлах ёстой.
2. Онцгой цугларалт, бүлгүүдийн хуралдаан, туршлага солилцох, сонгосон сэдэвт тохирох үйлчлэл зэрэг үйл ажиллагаануудыг төлөвлөх.
3. Үг хэлэгчид болон үйл ажиллагаануудыг бишопын зөвлөл эсвэл гадасны ерөнхийлөгчийн зөвлөлөөр батлуулах. Үг хэлэгчид нь Сүнслэгээр заадаг Сүмийн гишүүд байх ёстой. Залуучуудын чуулганыг зугаа цэнгэлийн талаас нь харж, сайн мэдээнд өнгөц ханддаг үг хэлэгчдийг сонгох ёсгүй. Бас үг хэлэхийн тулд хол газраас ирэх гишүүдийг сонгох хэрэггүй. Үг хэлэгчдийн талаарх бусад удирдамжийг 21.1.20-с үзнэ үү.
4. Хүндэтгэлийн өдөрт тохиромжгүй үйл ажиллагаануудыг ням гарагт төлөвлөхөөс зайлсхийх хэрэгтэй. Харин гэрчлэлийн цуглаан, Залуучуудтай хийх Бишопын зөвлөлийн хэлэлцүүлэг эсвэл адил төстэй бусад хурал цуглааныг хийж болно. Гэхдээ санваартны удирдагчид нь өөрийн тэргүүлдэг тойрог, гадасны хилээс гадна ариун ёслолын цуглаан хийж, ариун ёслолыг адисалж болохгүй. Аливаа онцгой тохиолдолд зөвшөөрлийг Далын Ерөнхийлөгчийн эсвэл Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн батлах ёстой. Гишүүд залуучуудын чуулганд оролцохоор эсвэл чуулганаас буцахдаа ням гарагт явах ёсгүй.
5. Бүх зүйлсийг үргэлж насанд хүрэгчдийн хяналтан дор явагдах ёстойг анхаарна. (13.6.2-г үзнэ үү).

Бишопын зөвлөлийн эсвэл гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүдийг чуулганы үйл ажиллагааны ихэнх үйл ажиллагаанд оролцуулахаар урих хэрэгтэй. Мөн Залуу Эрэгтэйчүүд болон Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийг чуулганы бүх үйл ажиллагаанд оролцохыг дэмжинэ.

## 13.5 Нэмэлт үйл ажиллагаа

Сүмтэй холбоотой нэмэлт үйл ажиллагаануудыг нэгжүүд ивээн тэтгэж болно. Ийм үйл

ажиллагаануудад Сүмийн их сургуулийн урлагийн хамтлагууд, залуучуудын тусгай хөтөлбөр, тодорхой хугацаанд болдог соёлын томоохон үйл явдлууд орно. (1) Шинээр санаачилсан нэмэлт үйл ажиллагаа бол, (2) зардал нь их биш бол, (3) уг үйл ажиллагааг хандив олох зорилгоор зохион байгуулаагүй бол Бүсийн Дал эсвэл Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүний зөвшөөрлөөр гишүүд бага зэргийн хураамж төлж болно. Хувиасаа мөнгө төлөх боломжгүй хүмүүст туслахын тулд төсвийн мөнгийг ашиглаж болно.

## 13.6 Бодлого ба удирдамж

Сүмийн бүх үйл ажиллагаанд дараах журам, удирдамжуудыг баримтлах ёстойг удирдагчид анхаарна.

### 13.6.1 Ослоос урьдчилан сэргийлэх ба хариу арга хэмжээ авах тухай

13.6.20-ийг үзнэ үү.

### 13.6.2 Насанд хүрэгчдийн тавих хяналт

Хүүхэд, залуучууд, ганц бие насанд хүрэгчдэд зориулсан үйл ажиллагаа нь насанд хүрсэн, хариуцлагатай, зохих тооны хүмүүсийн хяналтан дор явагдах ёстой. Хяналт тавих насанд хүрэгчдийн тоо нь хүүхэд залуучуудын тоо, (үйл ажиллагаа нь тодорхой ур чадвар шаарддаг) оролцогчдийн чадвар, орчны нөхцөл, тухайн үйл ажиллагааны хүнд хөнгөний хэмжээ зэргээр тодорхойлогдоно. Үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэхэд эцэг эхчүүдийг дэмжих хэрэгтэй.

### 13.6.3 Арилжааны болон улс төрийн үйл ажиллагааны тухай

Сүмийн барилга байгууламжийг арилжааны болон улс төрийн зорилгоор ашиглахыг зөвшөөрдөггүй. Сүмийн барилга, бусад өмчийг ашиглах журмыг 21.2-с үзнэ үү.

### 13.6.4 Зохиогчийн эрх бүхий материалууд

21.1.12-ыг үзнэ үү.

### 13.6.5 Хөл хорих хууль

Үйл ажиллагаа зохиохдоо хөл хорих хуулийг баримтална.

### 13.6.6 Хөгжим ба бүжиг

Бүжиг, хувцаслалт, үс засалт, гэрлэн чимэглэл, бүжгийн хэв маяг, дууны үг, хөгжим нь Их Эзэний Сүнс орших уур амьсгалыг бүрдүүлэх ёстой (*Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлыг үзнэ үү). Бүжигт хяналт тавих хүмүүс доорх журмыг чанд баримтлах ёстой.

Удирдагч нар нь хамтлаг, найрал хөгжимчид, DJ хөлслөхдөө Performance Contract form (Тоглолтын Гэрээний маягт)-ыг ашиглана. Энэ гэрээ нь бүжгийн хөдөлгөөн, хөгжим нь Сүмийн бүжигт тавигддаг шаардлагуудыг хангахад тусалдаг. Хөгжим тоглох хүмүүс тохиромжгүй дууны үг ашиглахгүй байх ёстой бөгөөд хувцаслалт, үг яриа нь даруу төлөв байх ёстой. Удирдагч нар тоглолыг урьдчилан үзэж, хөгжим тоглох хүмүүс Сүмийн үйл ажиллагааны үеэр Сүмийн жишгүүдийг мөрдөх болно гэсэн тодорхой заалттай, чанд амлалт авсан гэрээ байгуулах хэрэгтэй.

Дуу хөгжмийн хэмнэл нь хөгжимнөөсөө чанга байх ёсгүй. Хөгжим нь зэрэгцэн сууж байгаа хоёр хүн хэвийн байдлаар ярилцахад бие биеийнхээ үгийг саадгүй сонсохоор байх ёстой.

Гэрэл нь өрөөний нөгөө талд байгаа юмсыг харж болохоор байх хэрэгтэй. Анивчсан болон лазер зэрэг хөгжмийн хэмнэлээр анивчдаг гэрлийг зөвшөөрдөггүй. Босоо, булангийн, хана таазны болон тайзны гэрэлтүүлгийг зөвшөөрнө.

### 13.6.7 Үйл ажиллагаанд оролцогчдод зориулсан онцгой цугларалт

Үйл ажиллагааны хэсэг болгон онцгой цугларалтын товч хөтөлбөр зохион байгуулж болно. Онцгой цугларалтад залбирал, тухайн сэдэвт тохируулан сонгож авсан сүмийн дуулал эсвэл дуу, удирдагчийн товч үг, сүнслэг бодол хуваалцах, нэг буюу түүнээс олон оролцогч гэрчлэл эсвэл судраас хуваалцах зэрэг орно. Ийм хөтөлбөр нь Сүнсийг урьж, үйл ажиллагааг үр өгөөжтэй болгоход тусална.

### 13.6.8 Хандив цуглуулах үйл ажиллагаа

Хандив цуглуулах үйл ажиллагааг ер нь бол зөвшөөрдөггүй. Учир нь гадас, тойргийн үйл ажиллагаануудад Сүмээс төсөв олгодог. Онцгой тохиолдолд гадасны ерөнхийлөгч эсвэл бишоп жилд нэг удаа нэг бүлэгт үйл ажиллагаанд зориулж хандив цуглуулах зөвшөөрөл олгож болно. Хандив цуглуулах ийм үйл ажиллагааг зөвхөн дараах зорилгоор зохион байгуулж болно:

1. 13.2.8-д өгүүлсний дагуу жил тутмын аялал зуслан, үүнтэй төстэй үйл ажиллагааны зардлыг төлөхөд туслахын тулд.
2. 13.2.9-д өгүүлсний дагуу жил тутмын аялал зусланд тухайн нэгжид шаардлагатай тоног төхөөрөмж худалдаж авахад туслахын тулд.

Хэрэв хандив цуглуулах үйл ажиллагаа явуулах бол уг үйл ажиллагаа нь маш чанартай, хэрэгцээтэй үйлчилгээ үзүүлдэг байх ёстой. Энэ нь гишүүдийн эв нэгдлийг бэхжүүлдэг байх ёстой.

Хандив цуглуулах үйл ажиллагаанд сайн дураараа хандив өргөж болно. Санваартны удирдагч нар гишүүдийг хандив өгөх үүрэгтэй мэт ойлголт төрүүлэхгүй байхад онцгой анхаарна.

Хандив цуглуулах үйл ажиллагаа явуулж байгаа гадас, тойргууд өөрсдийн хил хязгаараас гадуур сурталчлах эсвэл ажиллах ёсгүй. Бас айлаас айл дамжин бараа бүтээгдэхүүн зарж, үйлчилгээ үзүүлж болохгүй.

Хандив цуглуулах үйл ажиллагаануудад дараах хэлбэрүүдийг зөвшөөрдөггүй:

1. Татвар ноогддог үйл ажиллагаанууд
2. Цалин буюу төлбөртэй үйл ажиллагаанууд
3. Хандив цуглуулах үйл ажиллагааны үеэр найрал хөгжим, урлагийн тоглолт эсвэл бусад үзвэр үйлчилгээнд гадас эсвэл тойрог төлбөр төлөхөөр бол.
4. Арилжааны бараа, бүтээгдэхүүн, түүний дотор нөөцөлдөг хүнсний зүйлүүдийг борлуулах.
5. Сугалаа зэрэг хонжворт тоглоомууд.

Дээрх зааврuудыг баримтлахгүй онцгой тохиолдлыг Далын Ерөнхийлөгчийн зөвлөлийн эсвэл Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн батална.

АНУ-д Friends of Scouting (Скаутын найз)-ын хандив цуглуулах үйл ажиллагаа нь Сүмээс тусдаа сайн дурын үндсэн дээр хийгддэг.

### 13.6.9 Даатгал

#### Авто машины даатгал

13.6.24-ийг үзнэ үү.

#### Эрүүл мэндийн ба ослын даатгал

Дэлхийн олон оронд Сүмийн гишүүд ажил олгогч болон засгийн газраас эсвэл хувиараа эрүүл мэндийн болон ослын даатгалд хамрагддаг. Ийм даатгал хийлгэсэн гишүүд Сүмийн үйл ажиллагааны үед гэмтэж бэртсэн бол уг даатгалаа ашиглах үүрэгтэй.

#### Сүмийн үйл ажиллагааны даатгалын хөтөлбөр

АНУ болон Канадад Church Activity Insurance Program (Сүмийн Үйл ажиллагааны даатгалын хөтөлбөр)-р эмчилгээний болон шүд эмчлүүлсний нэмэлт нөхөн төлбөр, нас барсан болон тахир дутуу болсон тохиолдолд нөхөн төлбөр олгодог. Энэ хөтөлбөр нь тухайн хүний өөрийнх нь эрүүл мэндийн болон ослын даатгалыг орлодоггүй, харин нэмэлт тусламж болдог байна.

Дээрх хоёр оронд үйл ажиллагаануудыг төлөвлөн явуулдаг, хяналт тавьдаг гишүүд Сүмийн Үйл ажиллагааны даатгалын хөтөлбөрийн тухай, түүний дотор нөхөн төлбөрийг олгохгүй байх хязгаарлалтуудыг мэддэг байх ёстой. Энэ хөтөлбөрийн тухай *Church Activity Insurance Handbook* гарын авлагад өгүүлсэн байдаг. Гарын авлагыг дараах хаягаар холбоо барин авч болно:

Deseret Mutual Benefit Administrators
P.O. Box 45530
Salt Lake City, UT 84145-0530
Утас: 1-801-578-5650 or 1-800-777-1647
Э-мэйл: churchactivity@dmba.com
Вэб сайт: www.dmba.com/churchactivity

#### Хариуцлагын даатгал

Боломжтой бол үйл ажиллагаануудад хяналт тавьж байгаа хүн хариуцлагын даатгалд зохих хэмжээний мөнгө төлж өөрсдийгөө хамгаалах хэрэгтэй. Ийм даатгалыг орон гэрийн болон бусад даатгалын гэрээгээр дамжуулан хийж болно.

### 13.6.10 Даваа гарагийн үдэш

Даваа гарагийн оройг Сүм даяар гэр бүлийн үдэшт зориулдаг. Даваа гарагийн оройн 6 цагаас хойш Сүмийн аливаа үйл ажиллагаа, хурал цуглаан, баптисмын ёслол, тоглоом, бусад үйл ажиллагааг зохион байгуулах ёсгүй. Гэр бүлийн үдэшт саад учруулж болох бусад үйл ажиллагаанаас зайлсхийх ёстой. Шинэ жилийн 31-ний үдэшлэг даваа гарагт таарвал энд хамаарахгүй байж болно (13.6.11-ийг үзнэ үү).

Удирдагчид сүмийн барилга болон бусад байгууламжуудыг даваа гарагийн орой хаалттай байлгах талаар анхаарна. Хүлээн авалт болон бусад адил төстэй арга хэмжээг даваа гарагийн орой Сүмийн барилга байгууламжид зохион байгуулж болохгүй. Даваа гарагийн орой гишүүдийг мөн хүлээн авалт хийхийг дэмждэггүй.

Боломжтой бол даваа гарагийн орой хүүхдүүдийг эцэг эхтэйгээ хамт байхад нь саад болох үйл ажиллагааг төлөвлөхгүй байхыг олон нийтийн болон сургуулийн удирдагчдаас гишүүд хүсч болно.

### 13.6.11 Шинэ жилийн үдэшлэг

Шинэ жилийг угтах Сүмийн үйл ажиллагаа төлөвлөгдсөн үед 31-ний өдөр бямба, ням, даваа гарагт тохиох юм бол удирдагчид дараах удирдамжуудыг баримтлах ёстой.

*Бямба гараг.* Гадасны ерөнхийлөгч мацгийн өдрийг өөр ням гарагт шилжүүлэн төлөвлөнө. Бүжиг болон адил төстэй үйл ажиллагаануудыг шөнө дундаас хойш үргэлжлүүлж болохгүй. Харин хөнгөн зуушаар үйлчилж болно. Оролцогчид ням гарагийн цуглаануудад оролцохын тулд хэтэрхий их оройтохгүй байх ёстой.

*Ням гараг.* (1) Өмнөх дурдсан удирдамжийг ашиглан бүжиг болон адил төстэй үйл ажиллагааг 12-р сарын 30-ны бямба гарагт төлөвлөж болно. (2) Сүмийн нэгжүүд үйл ажиллагаа төлөвлөхийн оронд гэр бүлүүдийг шинэ жил угтах үдэшлэгийг гэр орондоо тэмдэглэхийг нь илүү дэмждэг. Хүндэтгэлийн өдөр үйл ажиллагаа зохион байгуулах нь тохиромжгүй. (3) Ням гарагийн орой тохиромжтой цагт хурал цуглаан зохион байгуулж болно.

*Даваа гараг.* Нийтээрээ хурал цуглаанд оролцохоос өмнө гэр бүлүүд гэр бүлийн үдшээ хийж дууссан байхыг дэмждэг. Сүмээс зохион байгуулж байгаа шинэ жил угтах үйл ажиллагааг оройн 9 цагаас өмнө төлөвлөх ёсгүй. Энэ тохиолдолд Сүмийн барилгыг даваа гарагийн орой ашиглах бол зөвшөөрлийг гадасны ерөнхийлөгч эсвэл бишоп өгч болно.

### 13.6.12 Хоногоор явах үйл ажиллагаа

Хоногоор явах үйл ажиллагаанд оролцогч бүх залуучууд эцэг эхийнхээ зөвшөөрлийг авах шаардлагатай (13.6.13-ыг үзнэ үү).

Гадасны ерөнхийлөгч болон бишоп зөвшөөрөл өгөөгүй бол хоногоор явах үйл ажиллагаанд залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн бүлгүүд мөн ганц бие залуу насанд хүрэгч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн бүлгүүд хамтдаа хоногоор үйл ажиллагаанд явж болохгүй. Ийм үйл ажиллагааг зөвхөн Залуучуудын чуулган, ариун сүмийн аялал зэрэгт зориулан ховорхон зохион байгуулдаг.

Удирдагчид хоногоор явах үйл ажиллагаанд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг нэг дор байрлахааргүйгээр зохион байгуулах хэрэгтэй. Эрэгтэй болон эмэгтэй удирдагчдын унтах байр тусдаа байх ёстой. Боломжтой бол гэрлэсэн хосууд нэг байранд хамт орж болно.

Хүүхэд насанд хүрэгчидтэй нэг майханд хонох болвол (1) эцэг эх эсвэл насанд хүрсэн асран хамгаалагч нь (2) уг хүүхэдтэй адил хүйсийн насанд хүрсэн хоёроос цөөнгүй хүнтэй хамт хонохыг зөвшөөрнө.

Хэрэв насанд хүрсэн удирдагчид, залуучуудтай нэг байранд хамт хоножбайгаа бол залуучуудтай адил хүйсийн насанд хүрсэн хоёроос цөөнгүй хүн хамт хонох ёстой.

Хоногоор явах бүх үйл ажиллагаанд насанд хүрсэн хоёроос цөөнгүй удирдагч байх ёстой.

Хоногоор явах үйл ажиллагааны туршид дэмжлэг үзүүлж, хамгаалахын тулд хангалттай тооны санваартан удирдагчид байх ёстой. Залуу Эмэгтэйчүүдийн үйл ажиллагааны үед санваартан удирдагчид залуу эмэгтэйчүүдээс тусдаа байранд хонох ёстой.

Удирдагчид хоногоор явах бүх үйл ажиллагаанд Activity Plan form (Үйл ажиллагааг төлөвлөх маягт)-ыг бөглөнө (Маягтыг тойргийн бичиг хэргийн ажилтнаас авч болно).

Хоногоор явах үйл ажиллагааг Сүмийн байр болон сүмийн байрны газар дээр зохион байгуулахыг зөвшөөрдөггүй.

Спортын танхим зэрэг байранд хоногоор явах үйл ажиллагаа зохион байгуулахыг зөвшөөрдөггүй. Үйл ажиллагааг шөнийн 12 цагт дуусгахаар төлөвлөсөн бол түрээслэж буй байрны хаах цаг нь хэтэрсэн ч Санваартны удирдагчдын зөвшөөрлөөр бүжиг болон бусад үйл ажиллагааг 12 цаг хүртэл үргэлжлүүлж болно.

### 13.6.13 Эцэг эхийн зөвшөөрөл

Хүүхэд залуучууд Сүмийн үйл ажиллагаанд оролцож байгаа тохиолдолд эцэг эхчүүд, асран хамгаалагчдад нь мэдэгдэж, зөвшөөрөл авах ёстой. Үйл ажиллагаа нь (орон нутгийн удирдагчдын шийдсэнээр) тэдний оршин суудаг газраас гадагш явах эсвэл хоногоор явж байгаа бол зөвшөөрлийг бичгээр авах шаардлагатай. Удирдагчид шаардлагатай гэж үзсэн үед бусад үйл ажиллагаануудад бичгээр зөвшөөрөл хүсч болно.

Эцэг эхчүүд, асран хамгаалагчид Parental or Guardian Permission and Medical Release form (Эцэг эх, асран хамгаалагчдын болон эмнэлгийн зөвшөөрлийн маягт)-д гарын үсэг зурснаар энэ зөвшөөрлийг өгдөг (энэ маягтыг тойргийн бичиг хэргийн ажилтнаас авч болно). Үйл ажиллагааг удирдаж байгаа хүн үйл ажиллагаанд оролцогч бүрээс бичгээр зөвшөөрөл авах хэрэгтэй гэсэн үед зохих маягтанд гарын үсэг зуруулан авсан байх ёстой.

### 13.6.14 14-өөс доош насны залуучууд

14-өөс доош насны залуучууд ихэвчлэн Мючелийн үдшээс бусад залуучуудын чуулган болон бүжигт оролцдоггүй.

14-өөс доош насны залуучуудыг бусад ямар үйл ажиллагаануудад оролцож болохыг бишопын зөвлөл эсвэл гадасны ерөнхийлөгч шийднэ. Тухайн үйл ажиллагаа хэр зэрэг орой болох, ярилцлагын сэдэв, үйл ажиллагааны байдал, оролцогчдын төлөв байдал зэрэг хүчин зүйлсийг удирдагчид харгалзан үздэг.

### 13.6.15 Бурханы дүрд тоглох тухайд

Бурхан Эцэг, Ариун Сүнс хоёрыг хурал цуглаан, жүжиг, хөгжимт жүжигт ямар ч байдлаар дүрслэн үзүүлж болохгүй.

Хэрэв Аврагчийн дүрд тоглох бол гүн хүндэтгэлтэйгээр үйлдэх ёстой. Энэ дүрд бүх талаараа зөвхөн шилдэг зан төлөвтэй ах нар тоглох ёстой. Аврагчийг дүрслэн харуулах хүн дуулж, бүжиглэх ёсгүй. Тэрээр үг хэлэхдээ зөвхөн Аврагчийн хэлсэн судрын шууд эшлэлүүдийг л хэлэх ёстой.

Тоглолтын төгсгөлд Аврагчийн дүрд тоглосон хүн хүлээх танхимд эсвэл өөр хаа нэгтээ жүжигт тоглосон хувцсаа өмсөж явах ёсгүй. Тэрээр тэр дороо энгийн хувцсаа сольж өмсөх ёстой.

Аврагч төрж буй үйл явдлаас өөрөөр Аврагчийг хүүхдүүд яриан жүжигт дүрсэлж болохгүй.

### 13.6.16 Үйл ажиллагааны залбирал

Бүх үйл ажиллагаа залбирлаар эхэлж, залбирлаар төгсөх ёстой.

### 13.6.17 Үйл ажиллагаанд зориулж Сүмийн биш барилга байгууламжийг түрээслэх нь

Сүмийн барилга байгууламж гадасны эсвэл гадас дундын үйл ажиллагаанд тохиромжгүй байвал бишоп, гадасны ерөнхийлөгч болон Сүмийн барилга байгууламжийн төлөөлөгчдийн зөвшөөрлөөр Сүмийн биш барилга байгууламжийг түрээсэлж болно.

Сүмийн эзэмшдэггүй барилга байгууламжийг түрээсэлж байгаа эсвэл ашиглаж байгаа үед хариуцлагын даатгалаа үзүүлэхийг орон нутгийн нэгжүүдээс хүсч болно. Бишоп, гадасны ерөнхийлөгч хариуцлагын даатгалын гэрчилгээг Сүмийн удирдах газар дахь Risk Management Division (Эрсдэлийн Менежментийн Хэлтэс)-с эсвэл харьяа үйлчлэлийн төвөөс авч болно. Хүсэлтэд хүсэлт гаргагчийн нэр, хаяг (ихэвчлэн барилга байгууламжийг эзэмшигч), барилга байгууламжийн тодорхойлолт ба байршил, шаардагдах хариуцлага, холбогдох бусад мэдээлэл орно. Удирдагчид гэрчилгээнүүдийг бэлтгэж, шуудангаар явуулах хангалттай цагтай байхын тулд эртнээс төлөвлөх хэрэгтэй.

### 13.6.18 Хүчирхийллийн тухай мэдэгдэх нь

Хэрэв хэн нэгэн Сүмийн үйл ажиллагааны үеэр бие махбод, сэтгэл санааны болон бэлгийн хүчирхийлэл үйлдсэнийг удирдагч мэдсэн бол тэр даруй бишоптой холбоо барих ёстой. Бишопуудад зориулсан заавар *Гарын авлага 1-ийн* 17.3.2-т байдаг.

### 13.6.19 Хүндэтгэлийн өдрийг сахих тухай

Сүмээс (тоглолт, дадлага сургуулилт, аялал зэрэг) спортын эсвэл (аялал зуслан, явган аялал гэх мэт) амралт чөлөөт цагийн үйл ажиллагааг ням гарагт төлөвлөх ёсгүй. Залуучуудын болон бусад бүлгүүд ням гарагт залуучуудын чуулган болон аялал зусланд оролцохоор эсвэл чуулганаас буцахаар аялж болохгүй.

Аюулгүй байдал болон аяллын зардлын талаар ноцтой асуудал үүсэж байвал удирдагчид залуучуудын зарим үйл ажиллагааг ням гарагт төлөвлөж болно. Ийм үйл ажиллагаа нь ням гарагт болдог хурал цуглааны хөтөлбөрөөс тусдаа байж, Хүндэтгэлийн өдрийн уур амьсгалыг сахих ёстой.

### 13.6.20 Аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, осол гарсан үед авах арга хэмжээ ба ослын тухай мэдээлэх нь

#### Аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Үйл ажиллагаа нь оролцогчдод бэртэл учруулах, өвчлүүлэх эрсдэлээр хамгийн бага байх ёстой. Бас үйл ажиллагааны өмч хөрөнгөнд эвдрэл учруулах эрсдэл хамгийн бага байх ёстой. Үйл ажиллагааны үед аюулгүй байдлыг хангахын төлөө удирдагчид бүх талын хүч чармайлт тавина. Удирдагчид аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх үр ашигтай арга хэмжээг төлөвлөж, мөрдсөнөөр осол гарах эрсдэлийг дээд зэргээр багасгаж чадна.

Энэхүү арга хэмжээнд холбогдох сургалт, зохих журмын дагуу хяналт тавих нь орно. Эдгээр сургалт, хяналт нь оролцогчдын нас, төлөвшилтийн байдалд тохирсон байх ёстой.

Тохиолдож болзошгүй онцгой байдалд удирдагчид бэлтгэлтэй байх ёстой. Тэд орон нутгийн хууль хүчний болон онцгой байдлын албадтай хэрхэн эртнээс холбоо барихыг мэддэг байх хэрэгтэй.

### Осол гарсан үед хариу арга хэмжээ авах нь

Сүмийн байран дээр эсвэл Сүмийн үйл ажиллагааны үеэр бэртэл гэмтэл гарсан бол удирдагчид дараах журмуудыг баримтална:

1. Анхан шатны тусламж үзүүлнэ. Хэрэв тухайн хүнд эмнэлгийн тусламж хэрэгтэй бол бишоп болон гадасны ерөнхийлөгч нь түргэн тусламж дуудаж эцэг эх, асран хамгаалагч эсвэл хамгийн ойрын төрөл төрөгсөдтэй нь холбоо барина.
2. Хүн алга болсон эсвэл золгүй явдал тохиолдсон бол орон нутгийн хууль сахиулах байгууллагын эрх бүхий хүмүүст даруй мэдэгдэж, тэдэнтэй бүх талаар хамтран ажиллана.
3. Сэтгэл санааны дэмжлэг үзүүлнэ.
4. Сүмийн эсрэг шүүхэд гомдол мэдүүлэхийг дэмжих ба хориглох үйлдэл хийх ёсгүй. Мөн Сүмийн өмнөөс амлалт баталгаа өгөх ёсгүй.
5. Гэрчүүдийн нэрс, мэдээлэл, болсон явдлын тухай баримт материал, зураг сэлтийг цуглуулж, хадгална.

### Ослын тухай мэдэгдэх нь

Ослын тухай бишоп, эсвэл гадасны ерөнхийлөгчид шуурхай мэдэгдэх ёстой. Үүнд:

1. Сүмийн байранд эсвэл Сүмийн үйл ажиллагааны үеэр гарсан осол, гэмтэл бэртэл, өвчний тухай.
2. Сүмийн үйл ажиллагаанд оролцож байгаад алга болсон хүн.
3. Сүмийн үйл ажиллагааны үед хувийн, олон нийтийн эсвэл Сүмийн өмчид учирсан ноцтой эвдрэлийг мэдэгдэх ёстой.

Хэрэв хүн ноцтой бэртсэн буюу алга болсон, өмч хөрөнгө ноцтой эвдэрч гэмтсэн бол эсвэл хуулийн арга хэмжээ авахуулах нь тодорхой болсон бол гадасны ерөнхийлөгч (эсвэл түүний удирдлагаар бишоп) дараах арга хэмжээнүүдийн аль нэгийг шуурхай авна:

1. АНУ, Канадад тэрээр Сүмийн удирдах газрын Risk Management Division-д мэдэгдэнэ (1-801-240-4049 эсвэл 1-800-453-3860, дотуур утас 2-4049; ажлын бус цагаар эсвэл амралтын өдрүүдэд 1-801-240-1000 эсвэл 1-800-453-3860 дугаараар утасд, тэгвэл залгагч таныг холбогдох хүнтэй тэр даруйд холбож өгнө).
2. АНУ, Канадаас бусад газарт тэрээр харьяа үйлчлэлийн төвд мэдэгдэнэ.

Удирдагчид Сүмийн барилга байгууламж, өмч хөрөнгөнд гарсан эвдрэл гэмтлийг барилга байгууламжийн менежерт мэдэгдэнэ.

### Даатгал ба даатгалтай холбоотой асуултууд

Хэрэв Сүмийн үйл ажиллагаа, үйл явдал, ажил үүргийн үед гэмтэл бэртэл гарсан бол удирдагчид Church Activity Insurance Program-ын холбогдох заалтуудыг анхааралтай уншиж судлах хэрэгтэй. Даатгалын тухай мэдээллийг 13.6.9-өөс үзнэ үү.

Гадасны ерөнхийлөгч (эсвэл түүний удирдлагаар бишоп) аюулгүй байдлын асуудлууд болон Сүмд тавьж буй төлбөрийн шаардлагыг Risk Management Division-д хандан тавина.

## 13.6.21 Спортын үйл ажиллагаа

Сүмийн спорт үйл ажиллагаа нь найз нөхөд болох, бие бялдрыг, болон спортын ур чадварыг хөгжүүлэх боломжоор хангадаг. Сүмийн спорт үйл ажиллагааны гол зорилго нь гишүүдийн оролцоог дэмжиж, спортын болон бусад ур чадварыг хөгжүүлэх явдал бөгөөд хоорондоо өрсөлдөх явдал биш юм. Багийн бүх гишүүд тоглох боломжоор тэгш хангагдах ёстой.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл гадасныхаа хэмжээнд зохион байгуулдаг спортын үйл ажиллагааны дүрмийг батлан мөрдүүлнэ. Хэрэв гадас дундын болон бүсийн үйл ажиллагаа зохион байгуулбал, Далын эсвэл Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн оролцогч бүх нэгжүүдэд зориулсан дүрмийг батална. Орон нутгийн сургууль, бусад байгууллагуудын спортын үйл ажиллагаанд хэрэглэгддэг дүрмийг авч хэрэглэхээр хэлэлцэж болно.

Гадас дундын спортын үйл ажиллагаа зохион байгуулбал Далын эсвэл Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүний томилсон хариуцагч гадасны ерөнхийлөгчөөр дуудагдсан спортын зохицуулагчид эдгээр үйл ажиллагааг зохион байгуулна. Бүсийн спортын тэмцээн зохион байгуулахыг зөвшөөрдөггүй.

Сүмийн ивээн тэтгэдэг спортын үйл ажиллагаанудад оролцогчид нь Сүмийн гишүүд байх албагүй. Гэвч тэд тухайн гадасны хилийн дотор амьдардаг ба Сүмийн бодлого, жишгүүдийг зөвшөөрөн, баримталдаг байх ёстой.

Тоглогчдын Сүмийн спорт үйл ажиллагаанд оролцож болох насны ангилалын тухай удирдамжийг гадасны ерөнхийлөгчийн зөвлөл тогтооно. Энэхүү удирдамжид орон нутгийн ёс заншил, газар зүйн онцлог, сургуулийн систем, спортын удирдах байгууллагуудын дүрмийг харгалзан үзнэ. Спортын үйл ажиллагаа эхлэхээс өмнө хүн бүр оролцох нас, тоглолтын дүрмүүдийг ойлгосон байхын тулд ийм шийдвэр гаргах ёстой.

13. Үйл ажиллагаанууд

Сургууль, муж, аймгийн болон үндэсний спортын байгууллагууд спортын тухайн улиралд зориулсан сургуулийн баг болон Сүмийн багийн тоглолтын дүрмүүдийг бий болгон мөрддөг. Сүмийн удирдагчид болон Сүмийн спорт үйл ажиллагаануудад оролцогчид эдгээр дүрмийг баримтална. Эдгээр дүрмийг зөрчсөнөөр сургуулийн багт оролцох буюу хувиараа тоглох эрхээ алдаж болно.

АНУ, Канадад сургуулийн спортын багийн гишүүнийг спортын адил төрлөөр, нэг улиралд Сүмийн спортын хөтөлбөрт давхар оролцохыг ерөнхийдөө зөвшөөрдөггүй. Сургуулийн багуудад бага, дунд, ахлах сургуулийн сурагчид болон их дээд сургуулийн оюутнууд ордог. Энэхүү удирдамж нь сургуулийнхаа спортын үйл ажиллагаанд оролцогчдод хамаарахгүй. Хэрэв хоёр тоглолт зэрэгцсэн эсвэл давхцаж байвал нэг улиралд болж байна гэж үзнэ. Удирдагч нар сургуулийнхаа шигшээ багт тоглодог залуучуудыг Сүмээс зохиож буй спорт хөтөлбөрүүдэд тоглох бус харин зохион байгуулахад туслахыг дэмждэг.

Багийн дүрэмт хувцас нь энгийн даруухан, хэт үнэтэй биш, тухайн үйл ажиллагаанд тохирсон байх ёстой. Энгийн футболка эсвэл бэлтгэлийн хувцас байхад хангалттай. Дүрэмт хувцасны үнийг гадасны эсвэл тойргийн төсвөөс төлнө.

Багт болон хувь хүнд шагнал, цом олгохыг хориглодог.

### 13.6.22 Татвар ноогддог үйл ажиллагаанууд

Удирдагчид үйл ажиллагаа явуулахдаа татвараас чөлөөлөгддөг Сүмийн статуст хохирол учруулахгүй байхыг анхаарна. Удирдамжийг 21.2-оос үзнэ үү.

### 13.6.23 Ариун сүмд орох тухай

Харьяалагддаг ариун сүм рүү хийх аяллыг тойрог, гадасны төвшинд зохион байгуулдаг. Харин харьяа бус ариун сүм рүү гадас, тойргийн аялал хийхийг дэмждэггүй. Ийм аялалд гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн зөвшөөрөл шаардлагатай. Хоногоор явах ариун сүмийн аялалд бас гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн зөвшөөрөл шаардлагатай.

Ариун сүм уруу хийх аялал 13.6.24 дахь аяллын журамтай нийцэж байх ёстой. Хоногоор явах ариун сүмийн аялал бас 13.6.12 дахь журамтай нийцэж байх ёстой.

### 13.6.24 Аялал

Сүмээс зохион байгуулсан аялалд гишүүд бишопын эсвэл гадасны ерөнхийлөгчийн зөвшөөрөл авсан байх ёстой. Үйл ажиллагаанд зориулсан аялал нь гишүүдэд хүндрэл учруулж болохгүй.

Сүмийн үйл ажиллагаа хийхийн тулд дэндүү хол явахыг дэмждэггүй. Гадасны ерөнхийлөгч эсвэл бишоп ийм үйл ажиллагаа хэрэгтэй гэж үзвэл үүнийг батлахаасаа өмнө сүнслэг үр нөлөө, замын зардал, гэр бүлүүдэд хэрхэн нөлөөлөхийг нь залбирч үзэх хэрэгтэй.

Хэрэв замын зардал ихтэй үйл ажиллагаа батлагдсан бол гишүүд хувиасаа мөнгө төлөх ёсгүй. Гадасны эсвэл тойргийн төсвийн ихээхэн хэсгийг дараа жилийн үйл ажиллагааны замын зардлыг төлөхөөр үлдээж болохгүй.

Энэ хэсэг дэх аялан зорчих болон баримтлах удирдамж нь зохицуулах зөвлөлийн хариуцсан нэгжүүдийн хувьд ижил байх ёстой. Гадасны ерөнхийлөгч зохицуулах зөвлөлийн хурлын үеэр аяллын ерөнхий баримтлах журмуудыг хэлэлцэж, зөвшөөрөл өгч болно.

Удирдагчид орон нутгаасаа гадагш аялах үйл ажиллагаануудад зориулж Activity Plan form-ыг бөглөдөг (маягтыг тойргийн бичиг хэргийн ажилтнаас авч болно).

Залуучуудад зориулсан Сүмийн үйл ажиллагаанд хил залгаа нутгаас гадагш, хоногоор явах аялал орж байгаа бол үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхдүүдийн эцэг эхчүүдээс бичгээр зөвшөөрөл авах ёстой (13.6.13-ыг үзнэ үү). Насанд хүрсэн, хариуцлагатай нэг хүн тэднийг ахлан явах ёстой (13.6.2-г үзнэ үү).

Боломжтой бол Сүмийн бүлгүүд тусгай зөвшөөрөлтэй, хариуцлагын даатгалд даатгуулсан байгууллагын тээврийн хэрэгслийг ашиглах ёстой.

Сүмийн бүлгүүд хувийн зорчигч тээврийн хэрэгслээр зорчиж байгаа бол тээврийн хэрэгсэл бүр нь аюулгүй байдлыг хангасан, хүн бүрд суудлын бүс байх ёстой. Жолооч нь хариуцлага хүлээх чадвартай, насанд хүрсэн, жолооны үнэмлэхтэй байх ёстой. Бүх тээврийн хэрэгсэл болон жолооч нар авто машины хариуцлагын даатгалтай байх ёстой.

Сүмийн байгууллагууд бүлгээр хийх аялалд зориулж, автомашин, автобустай байж болохгүй.

Эрэгтэй эмэгтэй хоёр хүн эхнэр нөхөр биш бол эсвэл хоёулаа ганц бие биш бол Сүмийн

үйл ажиллагаа, хурал цуглаанд оролцох, ажил үүрэг гүйцэтгэхийн тулд хоёулхнаа хамт явж болохгүй.

### 13.6.25 Зөвшөөрөгдөөгүй үйл ажиллагаа

Сүмийн нэгжүүд дараах үйл ажиллагаануудыг ивээн тэтгэж болохгүй. Сүмийн үйл ажиллагаануудыг төлөвлөдөг буюу оролцдог удирдагчид, эцэг эхчүүд, бусад хүмүүс доорх тохиолдлуудад үйл ажиллагаанд оролцохыг хориглодгийг мэддэг байх ёстой.

1. Гэмтэж бэртэх буюу өвчин гарах эрсдэл өндөртэй, хэтэрхий их зардалтай, дэндүү хол аялах үйл ажиллагаанууд (13.6.20 болон 13.6.24-ийг үзнэ үү).
2. Дуу хөгжим, шүлэг, хувцаслалт, бусад зүйлс нь Сүмийн жишгүүдэд үл нийцэх дасгал сургуулилтын хөтөлбөрүүд.
3. Жүжигчилсэн тоглолт биш бол баг өмсдөг үйл ажиллагаа.
4. Залуу бүсгүйг насанд хүрсэнийг зарлах үдэшлэг, хаад, хатдыг сонгон шалгаруулдаг үйл ажиллагаанууд.
5. Энэ бүлэг дэх удирдамжуудад харшлах бусад үйл ажиллагаа.

Үйл ажиллагаа тохиромжтой эсэх талаар бишопт асуулт гарвал гадасны ерөнхийлөгчид хандах хэрэгтэй. Гадасны ерөнхийлөгч асуултуудыг Далын эсвэл Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнд хандан тавина.

# 14. Дуу хөгжим


14.1 **Сүмийн хөгжмийн зорилго . . . . . . . . . . . . . 124**

14.2 **Тойргийн хөгжмийн удирдлага . . . . . . . . . 124**

14.2.1 Бишопын зөвлөл. . . . . . . . . . . . . . . . . . . . . . 124
14.2.2 Тойргийн хөгжмийн зөвлөх . . . . . . . . . . . 124
14.2.3 Тойргийн хөгжмийн тэргүүлэгч . . . . . . . 124
14.2.4 Тойргийн хөгжмийн удирдагч. . . . . . . . . 124
14.2.5 Тойргийн бадралт баг бишгүүрч, төгөлдөр хуурч . . . . . . . . . . . . . . . . . . . . . 124
14.2.6 Тойргийн найрал дууны удирдагч болон удирдаач . . . . . . . . . . . . . . . . . . . . . 125
14.2.7 Санваартны хөгжмийн удирдагч, төгөлдөр хуурч, бадралт баг бишгүүрч . . 125

14.3 **Тойргийн хөгжмийг орон нутгийн нөхцөл, нөөц боломжинд тохируулан өөрчлөх нь . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 125**

14.4 **Тойргийн хөгжим. . . . . . . . . . . . . . . . . . . . . . 125**

14.4.1 Сүмийн шүтэн бишрэх үйл ажиллагааны хөгжмийг төлөвлөх нь . . . 125
14.4.2 Сүмийн шүтэн бишрэх үйл ажиллагаанд тохирох дуу хөгжмийг сонгох удирдамж. . . . . . . . . . . . . . . . . . . . 125
14.4.3 Сүмийн шүтлэг бишрэлийн ёслол дээрх жишиг хөгжмүүд . . . . . . . . . 126
14.4.4 Ариун ёслолын цуглаан. . . . . . . . . . . . . . 126
14.4.5 Найрал дуу . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 126
14.4.6 Ангид дуу хөгжмийг ашиглах нь . . . . . . 127

14.5 **Гадасны хөгжмийн удирдлага . . . . . . . . . . 127**

14.5.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл. . . . . . . 127
14.5.2 Гадасны хөгжмийн зөвлөх . . . . . . . . . . . . . 127
14.5.3 Гадасны хөгжмийн тэргүүлэгч. . . . . . . . . 127
14.5.4 Гадасны хөгжмийн зохицуулагчид . . . . . 127

14.6 **Гадасны хөгжим . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 127**

14.6.1 Гадасны чуулган . . . . . . . . . . . . . . . . . . . . . 127
14.6.2 Гадасны болон гадас дундын найрал дуу . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 127

14.7 **Хөгжмийн сургалт. . . . . . . . . . . . . . . . . . . . . 128**

14.8 **Гэр орон дахь хөгжим . . . . . . . . . . . . . . . . . 128**

14.9 **Хөгжмийн талаарх нэмэлт журам ба удирдамж. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 129**

14.9.1 Ариун ёслолын танхим дахь бусад хөгжим . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 129
14.9.2 Хөгжмийн зохиолыг олж авах ба ашиглах нь. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 129
14.9.3 Төгөлдөр хуур, бадралт баг бишгүүр болон даралтат хөгжим . . . . . . . . . . . . . . . 129
14.9.4 Зохиогчийн эрхийн удирдамжууд . . . . . 129
14.9.5 Хуримын хөгжим. . . . . . . . . . . . . . . . . . . . . 129
14.9.6 Оршуулгын хөгжим . . . . . . . . . . . . . . . . . . 129
14.9.7 Баптисмын ёслолын хөгжим. . . . . . . . . . . 129

14.10 **Онлайн хөгжмийн эх сурвалжууд. . . . . . . 129**

# 14. Дуу хөгжим

## 14.1 Сүмийн хөгжмийн зорилго

Их Эзэн Бошиглогч Иосеф Смитэд өгсөн нэг илчлэлтэнд, "Зүрх сэтгэлийн дуунд сүнс минь баярлах авай; тийм ээ, зөв шударгыг үйлдэгчдийн дуу нь надад хандсан залбирал бөлгөө, мөн энэ нь тэдний тэргүүн дээр адислалаар хариулагдах болно" (С ба Г 25:12) гэжээ.

Тэргүүн Зөвлөлөөс ийн хэлсэн байдаг:

"Сүнслэг нөлөө бүхий хөгжим бол манай сүмийн цуглаануудын амин чухал хэсэг юм. Дууллууд нь Их Эзэний Сүнсийг урьж, хүндэтгэлийн мэдрэмжийг төрүүлэн, биднийг гишүүдийн хувьд нэгтгэн, Их Эзэнийг магтан дуулах боломжийг бидэнд өгдөг.

"Зарим агуу номлолыг дууллууд дуулснаар номлодог. Дууллууд биднийг наманчлал, сайн үйлсийн замаар хөтөлж, гэрчлэл, итгэлийг төлөвшүүлэн, ядарч зовогсдыг тайтгаруулж, уй гашууд автагдагсдыг тайвшруулан, эцсээ хүртэл тэвчихэд бидэнд сүнслэгээр нөлөөлдөг билээ" (*Hymns*, ix).

## 14.2 Тойргийн хөгжмийн удирдлага

### 14.2.1 Бишопын зөвлөл

Бишоп зөвлөхүүдийнхээ хамт тойргийн хөгжимд хяналт тавьдаг. Тэд дараах үүрэг хариуцлагуудтай:

Энэ хэсэгт өгүүлсний дагуу хөгжмийн дуудлагуудад үйлчлэх тойргийн гишүүдийг дуудаж, онцгойлон адисална.

Дуу хөгжмийн сонголт, Сүмийн цуглаануудад ашигладаг хөгжмийн зэмсгүүд тохирч байгаа эсэхийг анхаарахын тулд тойргийн хөгжмийн тэргүүлэгчтэй тогтмол зөвлөлдөж байна (14.4.2 дахь удирдамжийг үзнэ үү).

Тойргийн найрал дуунд оролцохыг гишүүдэд дэмжиж, бусад тойргуудын цагтай давхцахгүйгээр сургуулилтын цагийг гаргаж өгнө.

Цугларагсад нийтээрээ дуулж байгаа дууг идэвхтэй дуулахад гишүүдийг дэмжинэ.

Гишүүдийг санаа сэтгэлийг өргөсөн дуу хөжмийг гэртээ сонсдог байхыг дэмжинэ (14.8-ыг үзнэ үү).

### 14.2.2 Тойргийн хөгжмийн зөвлөх

Бишопын зөвлөлийн нэг гишүүн тойргийн хөгжмийн зөвлөхөөр үйлчилнэ. Тэрээр тойргийн хөгжмийн хөтөлбөрт хяналт тавьж, тойргийн хөгжмийн тэргүүлэгчид зөвлөгөө өгөхийн хамт удирдлагын хурлууд дээр хөгжмийн хөтөлбөрийг төлөөлнө.

### 14.2.3 Тойргийн хөгжмийн тэргүүлэгч

Эрэгтэй эсвэл эмэгтэй гишүүдийн аль нь ч тойргийн хөгжмийн тэргүүлэгчээр үйлчилж болно. Тойргийн хөгжмийн тэргүүлэгч нь тойргийн хөгжмийн зөвлөхийн удирдлага дор дараах үүрэг хариуцлагатай:

Хөгжмийн асуудлуудаар бишопын зөвлөлд туслах гол хүн болж үйлчилнэ.

Ариун ёслолын цуглаан болон тойргийн бусад цуглаанууд дээр хамгийн сайн тохирох дуу хөгжмийг сонгож авах ажлыг зохицуулна.

Хөгжмийн сургалт явуулах, шаардлагатай бол бусад төрлийн дуу хөгжмийн хэрэгцээг шийдвэрлэхэд тойргийн туслах бүлгүүдийн удирдагчдад туслах гол хүн болж үйлчилнэ.

Тойрог дахь хөгжмийн сургалтыг санал болгож, хяналт тавих (14.7-г үзнэ үү).

Шаардлагатай бол тойргийн хөгжмийн нэмэлт үйл ажиллагааг санал болгож, хэрэгжүүлнэ.

Тойргийн хөгжмийн зөвлөх хүссэн үед тойргийн хөгжмийн дуудлагуудад үйлчлэх гишүүдийг санал болгох. Тойргийн хөгжмийн дуудлагуудад үйлчилдэг хүмүүсийг хариуцна.

Тойргийн хөгжмийн тэргүүлэгч шаардлагатай бол гадасны хөгжмийн удирдагчаас сургалт, дэмжлэг авна.

### 14.2.4 Тойргийн хөгжмийн удирдагч

Хөгжмийн удирдагч тойргийн хөгжмийн тэргүүлэгчийн удирдлага дор ариун ёслол дээр цугларагсдын дуулах дууллууд, хүсэлт тавьсан үед тойргийн бусад цуглаанууд дээр дуулах дууллуудыг санал болгож, удирдана. Нэг хүн тойргийн хөгжмийн тэргүүлэгч, хөгжмийн удирдагчаар зэрэг үйлчилж болно.

### 14.2.5 Тойргийн бадралт баг бишгүүрч, төгөлдөр хуурч

Тойргийн бадралт баг бишгүүрч эсвэл төгөлдөр хуурч нь оршил, төгсгөл хөгжим тоглохын хамт ариун ёслолын болон тойргийн бусад цуглаанууд дээр дууллуудыг дагаж хөгжимдөнө.

### 14.2.6 Тойргийн найрал дууны удирдагч ба удирдаач

Тойргийн найрал дууны удирдагч найрал дуулаачдын дуулах дууг санал болгож, найрал дууны сургуулилтыг болон найрал дуучдын дууг удирдана (14.4.5-ыг үзнэ үү).

Тойргийн найрал дууны удирдаач найрал дууны давтан сургуулилт болон дуулах дууг удирдана.

### 14.2.7 Санваартны хөгжмийн удирдагч, төгөлдөр хуурч, бадралт баг бишгүүрч

Санваартны хөгжмийн удирдагч санваартны хурал цуглаануудын нээлтийн ажиллагааны дууллыг санал болгож, хөтлөн явуулна.

Төгөлдөр хуурч эсвэл бадралт баг бишгүүрч оршил, төгсгөл хөгжим тоглож, дууллуудыг дагаж хөгжимдөнө.

## 14.3 Тойргийн хөгжмийг орон нутгийн нөхцөл, нөөц боломжинд тохируулан өөрчлөх нь

Энэ бүлэг дэх удирдамжийг орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчилж болно. Жишээ нь жижиг салбарт, тойргийн хөгжмийн тэргүүлэгч нь найрал дуу болон ариун ёслолын цуглаан, санваартны болон туслах бүлгүүдийн хурал цуглаанууд дээр дууг удирдаж болно. Төгөлдөр хуурч ариун ёслолын цуглаан, санваартны болон туслах бүлгүүдийн хурал цуглааны хөгжим мөн найрал дууны хөгжмийг тоглож болно.

Төгөлдөр хуур тоглож чаддаг хүн байхгүй бол дараах эх сурвалжуудыг ашиглаж болно:

1. Дууллууд болон хүүхдийн дууны CD-нүүд *Church Materials Catalog*-т байдаг ба эдгээрийг Сүмийн Хангамжийн Төвүүдээс авч болно.
2. Дууллууд болон хүүхдийн дуунуудыг (music.lds.org) хөгжмийн вэб сайтаас MP 3 форматаар хуулан авч болно.
3. Сүмийн зарим байр дууллуудыг программчилж оруулсан дижитал төгөлдөр хуууртай байдаг.

Хөгжмийн дуудлагуудад одоо үйлчилж байгаа эсвэл ирээдүйд үйлчлэх хүмүүс хөгжмийн сургалтад сууж мөн цахилгаан хөгжмийг авч ашиглаж болно (14.7-г үзнэ үү).

## 14.4 Тойргийн хөгжим

Хөгжим бол Сүмийн цуглаануудын, тэр тусмаа ариун ёслолын цуглааны маш чухал хэсэг юм. Зөв сонгож авсан дуу хөгжим шүтлэг бишрэлийн сүнсийг улам өргөжүүлэн тэлдэг. Дуу хөгжим нь шүтлэг бишрэлийн шинжтэй, хурал цуглааны уур амьсгалд тохирсон байх ёстой. Ямар дуу хөгжим зохимжтойг санваартны удирдагчид шийднэ.

### 14.4.1 Сүмийн шүтэн бишрэх үйл ажиллагааны хөгжмийг төлөвлөх нь

Тойргийн хөгжмийн дуудлагуудад үйлчилдэг гишүүд шүтлэг бишрэлийн ёслолуудад тохирох дуу хөгжмийг сонгоход хамтран ажилладаг. Боломжтой бол бишоп болон түүний зөвлөхүүд хурал цуглааны сэдвийг нэлээд өмнөөс сонгох хэрэгтэй. Энэ нь сүмийн дуулал, дуу хөгжмийг сонгож авах, найрал дуу ямар сүмийн дуулал, дуунуудыг цуглааны сэдэвт улам хүч нэмэн өргөх боломжийг хөгжмийн тэргүүлэгч, хөгжмийн болон найрал дууны удирдагчдад олгодог. Мөн дуу хөгжмийг урьдчилан сонгож, батлах боломжийг бишопын зөвлөлд олгодог.

### 14.4.2 Сүмийн шүтэн бишрэх үйл ажиллагаанд тохирох дуу хөгжмийг сонгох удирдамж

Сүмийн бүх дуу хөгжим дараах удирдамжуудтай нийцэж байх ёстой.

Сүмийн дууллууд бол Сүмийн шүтэн бишрэх үйл ажиллагааны үндсэн дуу бөгөөд бүх нийтээрээ дуулж болох сүмийн жишиг дуунууд юм. Түүнээс гадна оршил болон төгсгөл хөгжим, найрал дууны хөгжим, хөгжмийн тусгай хөтөлбөрүүдэд сонгож авсан тохиромжтой хөгжмийг ашиглаж болно. Хэрэв сүмийн дууллуудаас өөр дуу хөгжмийг сонгон ашиглаж байгаа бол тэдгээр нь сүмийн дууллууд шиг сүнслэг байх ёстой. Үг нь сургаалтай нийцэж байх ёстой. (“Hymns for Congregations,” *Hymns*, 380–81-ийг үзнэ үү.)

Энгийн дуу хөгжим ням гарагийн ариун ариун ёслолын цуглааны ариун хөгжмийг орлох ёсгүй. Олон нийтэд зориулсан шашны чиглэлийн зарим дуу хөгжим ариун ёслолын цуглаанд тохирохгүй. Концерт, хөгжимт жүжгийн ариун хөгжим ч гэсэн ХҮГ-н шүтлэг бишрэлийн ёслолд тохирохгүй.

Сүмийн цуглаанууд дээрх дуу хөгжим нь хөгжимчний ур чадварт хүмүүсийн анхаарлыг татахаар эсвэл үзүүлэх тоглолт хэлбэртэй байх ёсгүй. Сүмийн хөгжим шүтлэг бишрэлийн зориулалттай болохоос, ур чадварыг харуулах явдал биш юм.

Бадралт баг бишгүүр, төгөлдөр хуур, цахилгаан даралтат хөгжим бол Сүмийн цуглаанууд дээр ашигладаг стандарт хөгжмийн зэмсгүүд

юм. Хэрэв хөгжмийн бусад зэмсэг ашиглаж байгаа бол хурал цуглааны сүнсийг сахин хадгалах ёстой. Дуугаралт нь аль нэг хэмжээгээр шүтлэг бишрэлийн мэдрэмж төрүүлдэггүй гуулин болон цохилуур хөгжмийн зэмсгүүд ариун ёслолд тохиромжгүй.

Ариун ёслол болон тойргийн бусад цуглаанууд дээр Сүмийн дууллийг хөгжимчинтэй дуулна. Хэрэв төгөлдөр хуур, бадралт баг бишгүүр, удирдаач байхгүй бол тохиромжтой хөгжмийн бичлэгийг ашиглаж болно (14.3-г үзнэ үү).

Сүмийн цулаанууд дээр сүмийн дуулал буюу дуу нь тухайн гишүүдийн хэл дээр дуулагдах ёстой.

### 14.4.3 Сүмийн шүтлэг бишрэлийн ёслол дээрх жишиг хөгжмүүд

#### Оршил ба төгсгөл хөгжим

Намуухан оршил болон төгсгөл хөгжим нь Сүмийн цуглаануудад Сүнсийг урьж шүтлэг бишрэлийн уур амьсгалыг бий болгодог. Бадралт баг бишгүүрч эсвэл төгөлдөр хуурч нь цуглаан эхлэхээс өмнө мөн цуглаан дууссанаас хойш таваас арван минут сүмийн дуулал эсвэл өөр зохистой хөгжмүүдийг тоглодог. Дууллуудыг тоглох нь сайн мэдээний сургаалуудыг оюун ухаандаа тунгаан бодоход гишүүдэд тусалдаг.

#### Цугларагсад дуулах нь

Сүмийн ихэнх цуглаанууд дууллуудыг дуулснаар илүү баялаг агуулгатай болдог. Дуу хөгжим бол гишүүдийн Сүмийн шүтлэг бишрэлийн үйл ажиллагаанд оролцдог үндсэн арга хэрэгсэл юм. Шүтэн бишрэх явцдаа Сүмийн дууг нийтээрээ дуулах нь гишүүдийн эв нэгдлийг бэхжүүлэх ер бусын хүчийг агуулдаг.

Санваартны удирдагчид цугларагсдаас тохиромжтой үед суудлаасаа босч дундын дуулал эсвэл үндэсний сүлд дууллыг дуулахыг хүсч болно (“Hymns for Congregations,” *Hymns,* 380–81-ийг үзнэ үү).

#### Дуу хөгжмийг сонгох нь

Найрал болон гоцлол дуучид, хөгжимчид мөн хэсэг бүлгээр дуулах хүмүүс дуу хөгжмөө сонгож дуулж, хөгжимдөж болно. Сүмийн дууллууд болон бусад тохиромжтой дуу хөгжмийг сонгоно (14.4.2-ыг үзнэ үү).

### 14.4.4 Ариун ёслолын цуглаан

Ариун ёслолын цуглааны хөгжмийг бишопын зөвлөл батална. Хөгжим ба үг нь цэвэр ариун, гүн хүндэтгэлтэй, өөрөөр хэлбэл ариун ёслолын цуглаанд тохирсон байх ёстой. Ариун ёслолын цуглааны хөгжим нь шүтэн бишрэх зориулалттай болохоос биш, өөртөө анхаарал татах тоглолт биш.

Нээлт, хаалтын дууллыг ихэвчлэн цугларагсад дуулдаг (“Selecting the Right Hymn,” *Hymns,* 380-ыг үзнэ үү). Гишүүдийн мэддэг, дуртай дуунуудыг ашиглахаас гадна шинэ эсвэл тийм ч сайн мэддэггүй дууллуудыг дуулахад нь дэмжих хэрэгтэй. Гишүүдийн сайн мэдэх ба дуртай дууллууд болон сайн мэдэхгүй дууллуудыг тэнцвэртэйгээр сурч дуулдаг байхын төлөө хөгжмийн удирдагчид хичээх хэрэгтэй (“Hymns for Congregations,” *Hymns,* 380–81).

Ариун ёслолын дууллыг үргэлж цугларагсад дуулна. Энэ сүмийн дуулал нь зөвхөн ариун ёслолд эсвээс Аврагчийн золиослолд зориулагдсан байх ёстой. Гоцлон дуулаачдаар дуулуулах эсвэл хөгжмийн зэмсгүүдээр орлуулж болохгүй. Ариун ёслолын залбирал болон ариун ёслолыг түгээх үеэр хөгжим тоглох ёсгүй, эсвэл түгээсний дараа тоглож болохгүй.

Сонгож авсан дуу буюу дууллыг ариун ёслолын дараа үг хэлэгчдийн хооронд оруулж болно (14.4.3 дахь “Special Musical Selections”-г үзнэ үү).

Хэрэв хөгжмийн хөтөлбөр явуулж байгаа бол энэ нь энгийн, хүндэтгэлтэй, үгээр илэрхийлэх захиаст боломж олгохуйц товчхон байх ёстой. Ариун ёслолын цуглаан дуу хөгжмийн тоглолт болон хувирч болохгүй. Тоглолт, концерт, сүржин ёслол хийх ёсгүй.

### 14.4.5 Найрал дуу

Ариун ёслол дээр сард нэг удаа дуулдаг тойргийн найрал дуутай байхын төлөө тойрог бүр хичээх хэрэгтэй. Тойргийн гишүүд найрал дуунд сайн дураараа оролцож болно. Эсвэл бишопын зөвлөл найрал дуунд оролцуулахаар тэднийг урьж болно.

Маш жижигхэн салбарт бүх гишүүд нь найрал дуунд дуулж болно. Боломж ихтэй том тойрогт бишопын зөвлөл нь найрал дууны ерөнхийлөгч, нарийн бичиг, номын санч, хэсгийн удирдагчид зэрэг дуудлагуудыг олгож болно.

Сүмийн найрал дуунд сүмийн дууллын номыг үндсэн эх сурвалж болгон ашиглахыг дэмждэг. Учир нь сүмийн дууллууд нь сэргээгдсэн сайн мэдээний үнэнийг заадаг. Дууллуудыг найруулах болон найрал дууны тохиромжтой бусад бүтээлүүдийг ч ашиглаж болно (14.4.2-г үзнэ үү).

Сүмийн дууллуудыг найрал дуунд зориулан ашиглах тухай мэдээлэл *Hymns*,-н хуудас 381–383-т байдаг. Найрал дууг зохион байгуулж удирдах тухай нэмэлт мэдээлэл *Conducting Course* гарын авлага, хуудас 73–83-т байдаг.

Тойргийн эсвэл гадасны найрал дууг зохион байгуулах үед сонгон шалгаруулалт хийдэггүй. Сургуулилт нь ихэвчлэн нэг цагаас хэтэрдэггүй.

Тойргийн найрал дуунаас гадна Нийгмийн Халамжийн бүлэг, санваартнууд, залуучууд, хүүхдийн, тэрчлэн гэр бүлийн найрал дуу байгуулж, дууллууд болон сонгож авсан бусад тохиромжтой дуунуудыг Сүмийн цуглаан дээр дуулахыг урьж болно.

### 14.4.6 Ангид дуу хөгжмийг ашиглах нь

Сүмийн дуулал дуулах нь хичээл дээр сайн мэдээний зарчмуудыг заах, бататгах үр ашигтай арга зам болж чадна. Хичээлээ баялаг агуулгатай болгон өргөжүүлэхийн тулд сүмийн дууллуудыг ашиглахыг удирдагчид дэмжих хэрэгтэй.

## 14.5 Гадасны хөгжмийн удирдлага

### 14.5.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл

Гадасны ерөнхийлөгч болон түүний зөвлөхүүд гадасны хөгжимд хяналт тавина. Тэд гадасны хөгжмийн дуудлагуудад үйлчлэх гишүүдийг энэ хэсэгт өгүүлсний дагуу дуудаж, онцгойлон адисална.

### 14.5.2 Гадасны хөгжмийн зөвлөх

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл нэг дээд зөвлөлийн гишүүнийг гадасны хөгжмийн зөвлөхөөр томилно. Тэрээр ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор гадасны хөгжмийн тэргүүлэгчид зөвлөгөө өгч хяналт тавихийн сацуу гадасны зөвлөлийн хурал дээр хөгжмийн хороог төлөөлдөг.

Гадасны хөгжмийн зөвлөх нь гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн зөвшөөрлөөр гадасны хөгжим хариуцсан дуудлагад үйлчлэх гишүүдийг дуудаж, адисалж болно.

### 14.5.3 Гадасны хөгжмийн тэргүүлэгч

Гадасны хөгжмийн тэргүүлэгчээр эрэгтэй эмэгтэй хүний аль нь ч үйлчилж болно. Тэрээр гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор дараах үүрэг хариуцлагатай:

Хөгжмийн асуудлуудаар гадасны ерөнхийлөгчийн зөвлөлд туслах гол хүн болж үйлчлэх.

Гадасны чуулганы хуралдаанууд болон хүсэлт тавьсан үед гадасны бусад хурал цуглаанууд, үйл явдлуудын үед тоглох хөгжим болон хөгжимчдийг зохион байгуулах.

Шаардлагатай бол тойргийн хөгжмийн тэргүүлэгчид зориулан сургалт явуулж, гадасны туслах бүлгүүдийн удирдагчдад туслах гол хүн болж үйлчилнэ.

Гадасны хэмжээн дэх хөгжмийн сургалтын хөтөлбөрүүдийг санал болгож, хяналт тавина (14.7-г үзнэ үү).

Шаардлагатай үед гадасны хөгжмийн үйл ажиллагаануудыг санал болгож, хэрэгжүүлнэ.

### 14.5.4 Гадасны хөгжмийн зохицуулагчид

Шаардлагатай бол гадасны хөгжмийн зохицуулагчид, түүний дотор гадасны бадралт баг бишгүүрчийг дуудаж болно. Эдгээр зохицуулагчдаас гадасны аль нэг хурал цуглааны үеэр дуулах сүмийн дуулал болон дууг бэлтгэхийг хүсч болно. Тэднийг бас хөгжмийн сургалт явуулах эсвэл гадасны үйл ажиллагаанд хөгжим тоглуулахаар томилж болно (14.7-г үзнэ үү).

## 14.6 Гадасны хөгжим

### 14.6.1 Гадасны чуулган

Гадасны чуулганы хөгжмийг итгэл, гэрчлэлийг бэхжүүлэх зорилгоор төлөвлөнө. Гадасны чуулганыг тэргүүлэх эрх мэдэлтэн төлөвлөж байгаа бүх дууллуудыг чуулганаас өмнө нь хянана.

Гадасны чуулганы ерөнхий хуралдааны хөгжимд ихэвчлэн дөрвөн дуулал дуулдаг. Цугларагсад нээлтийн болон дундын дууллыг дуулдаг. Найрал дуучид эхний үг хэлэгчийн өмнө, чуулганы төгсгөлд нөгөө хоёр дууллыг нь дуулдаг. Найрал дууны дуулах хоёр дууллын нэг нь Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дуулал эсвэл найруулсан сүмийн дуулал байх ёстой. Найрал дуу нь тойргуудын найрал дуунаас бүрдэх эсвэл хүүхдийн, залуучуудын, санваартнуудын, Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нарын, гэр бүлүүдийн гэх мэт тусгай найрал дуу байж болно.

Тохиромжтой хөгжим сонгох удирдамжийг 14.4.2-с үзнэ үү.

### 14.6.2 Гадасны болон гадас дундын найрал дуу

Санваартны удирдагчдын зөвшөөрлөөр гадасны болон гадас дундын найрал дууг гадасны чуулган, бүс нутгийн чуулган, нийгмийн тэмдэглэлт үйл явдал зэрэг бусад үйл явдлуудаар

зохион байгуулж болно. Тоглолтын дараа найрал дуучдыг дараагийн үйл ажиллагаа болтол завсарлуулна. Дээрх найрал дуу нь тойргийн найрал дуунд оролцоход гишүүдэд саад болох ёсгүй.

Сүмийн гишүүнээр удирдуулсан мөн дийлэнх нь гишүүдээс бүрдсэн бусад найрал дуучдыг Сүм санхүүжүүлдэггүй. Эдгээр найрал дуучид нэрээ сонгохдоо "ХҮГ," "Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн," "Мормоны" гэхчлэн Сүмийг төлөөлсөн нэрийг хэрэглэх ёсгүй. Санваартны удирдагчид зөвшөөрсөн тохиолдолд олон нийтийн найрал дууны давтан сургуулилт болон тоглолтод Сүмийн байрыг ашиглаж болно. Харин тэд үйл ажиллагаа, санхүүтэй холбоотой Сүмийн жишгүүдийг баримтлах ёстой.

## 14.7 Хөгжмийн сургалт

Хөгжмийн үндсэн ур чадварыг эзэмших нь авьяас чадвараа ашиглах, Сүмд үйлчлэх боломжийг гишүүдэд олгодог. Гадас, тойргийн хөгжмийн тэргүүлэгч нь санваартны удирдагчдын зөвшөөрлөөр хөгжмийн сургалт, семинар, дадлага хичээл зохион байгуулж болно. Мөн хөгжмийн дуудлагуудад одоо үйлчилж байгаа болон ирээдүйд үйлчлэх гишүүдэд зориулсан хөгжмийн сургалтын хөтөлбөрүүдийг зохион байгуулж болно. Эдгээр сургалтад оролцогчид нь гадас, тойргийн хөгжмийн удирдагчид, найрал дууны удирдагчид, төгөлдөр хуурч, бадралт баг бишгүүрч байж болно. Сонирхсон бусад насанд хүрэгчид болон залуучууд, түүний дотор номлогч болох гишүүд мөн оролцож болно. Сургалт нь үнэ төлбөргүй байдаг.

Жил тутмын хөгжмийн сургалтад хөгжим болон найрал дууны удирдаачдад зориулсан сургалт, тойргийн төгөлдөр хуурын хичээл, гадас, тойргийн бадралт баг бишгүүр хөгжмийн сургалт орж болно. Хөгжмийн удирдагч нь санваартны удирдагчидтай зөвлөлдсөний үндсэн дээр энэ сургалтыг явуулж чадах мэргэшсэн багш-сургагчдыг санал болгож болно. Хэрэв сургалт явуулах гадасны хөгжмийн зохицуулагч дуудагдаагүй бол тойргийн найрал дууны удирдаачид санаа бодлоо солилцохын тулд хамтран хуралдах эсвэл гадасны ерөнхийлөгчийн зөвлөл гаднаас тусламж хүсч болно.

Conducting Course Kit, Keyboard Course Kit-ийг хөгжмийн анхан шатны сургалтанд ашиглана. *Conducting Course* гарын авлага нь найрал дуу зохион байгуулж, удирдах зааврыг бас агуулдаг. *Church Materials Catalog*-т жагсаасан эх сурвалжуудыг Сүмийн Хангамжийн Төвүүдээс авч болно.

Үнэхээр өөр боломжгүй тохиолдолд сүмийн байрны төгөлдөр хуур болон бадралт баг бишгүүр хөгжмийг тухайн сүмийн байрыг ашигладаг нэгжүүдийн гишүүдэд дадлага хийх, хувийн төлбөртэй сургалт авах, тайлан тоглолт хийх зөвшөөрлийг санваартны удирдагчид өгч болно. Тоглолт хийхдээ төлбөр авах ёсгүй.

Авьяас чадвараа ашиглах боломжийг хөгжимчдөд олгож, ур чадвараа байнга хөгжүүлэхийг тойргийн хөгжмийн тэргүүлэгч дэмждэг.

## 14.8 Гэр орон дахь хөгжим

Санаа сэтгэлийг өргөсөн дуу хөгжмийг гэр орондоо ашиглах, гэртээ сүмийн дууллын болон *Children's Songbook* байж, эдгээр сүмийн дуулал болон дуунуудыг гэр бүлээрээ дуулдаг байхад санваартны улирдагчид Сүмийн гишүүдийг дэмждэг. Энэ талаар Тэргүүн Зөвлөл хэлэхдээ:

"Сүмийн дууллууд гэр бүлүүдэд төгс сайхан, амар амгалангийн уур амьсгалыг авчирч, гэр бүлийн гишүүдийн хайр, эв нэгдэлд сүнслэгээр нөлөөлдөг.

"Сүмийн дууллуудад дуртай болоход нь хүүхэддээ тусал. Сүмийн дууллуудыг Хүндэтгэлийн өдөр, гэр бүлийн үдшээр, судар судлах үеэр, залбирлын цагаар дуул. Ажил хийх, тоглох үедээ, хамт явах үедээ дуулж бай. Үр хүүхэддээ итгэл, гэрчлэлийг бий болгох дууллуудыг бүүвэйн дуу адил дуулж бай" (*Hymns,* x).

Гишүүд дагаж дуулах эсвэл сүмийн дууллууд болон хүүхдийн дуунуудыг сурахын тулд Сүмээс эрхлэн гаргасан дуу бичлэгүүдийг ашиглаж болно. Эдгээр бичлэгийг *Church Materials Catalog*-т жагсаасан байгаа. Гишүүд Сүмийн дуу хөгжмийг сурах, сонсох, хөгжмийн үндсэн ур чадварыг эзэмших, сайн дуу хөгжмийн талаар олж мэдэхийн тулд Сүмийн хөгжмийн вэб сайтад (music.lds.org) нэвтэрч болно.

Хүүхдүүдээ хөгжмийн хичээл заалгахыг эцэг эхчүүд дэмжих ёстой. Энэ нь авьяас чадвараа ашиглах, Сүмд үйлчлэх боломжийг тэдэнд олгох болно.

Бишопын зөвлөл гэр оронд дуу хөгжмийг ашиглах тухай сэдвээр ариун ёслолын цуглаан дээр үг хэлэх даалгаврыг зарим үг хэлэгчдэд өгч болно. Заримдаа нэг гэр бүлийнхэн ариун ёслолын цуглаан дээр сүмийн дуртай дууллаа эсвэл Хүүхдийн Хэсгийн дууг сонгон дуулж болно.

## 14.9 Хөгжмийн талаарх нэмэлт журам ба удирдамж

### 14.9.1 Ариун ёслолын танхим дахь бусад хөгжим

Соёл, амралт чөлөөт цагийн зарим хөгжмийн тоглолтыг ажлын өдрүүдэд ариун ёслолын танхимд явуулж болно. Гэвч ийм үйл ажиллагаанд соёлын танхим илүү тохиромжтой байдаг. Ариун ёслолын танхимд ямар хөгжим тохиромжтойг орон нутгийн санваартны удирдагчид шийднэ. Ариун ёслолын танхимд алга таших нь зохимжгүй.

### 14.9.2 Хөгжмийн зохиолыг олж авах болон ашиглах нь

Сүмийн шинэ байруудыг юуны өмнө сүмийн дууллын номуудаар хангадаг. Нэмэлт сүмийн дууллын номууд, найрал дууны болон бусад зохиолыг гадас, тойргийн төсвөөр худалдан авч болно. Хөгжмийн зохиол авах жил тутмын төсвийг ирүүлэхийг санваартны удирдагчид гадас, тойргийн хөгжмийн тэргүүлэгчдээс хүсч болно. Төсвийн мөнгөөр худалдаж авсан хөгжмийн зохиолыг ихэвчлэн сүмийн байрны номын санд хадгалах бөгөөд номын санг дундаа ашигладаг бүх нэгжүүд хэрэглэнэ. Гадас, тойргийн хөгжмийн тэргүүлэгч нь энэ хөгжмийн зохиолуудыг индексжүүлэхэд номын санчдад тусалж болно.

### 14.9.3 Төгөлдөр хуур, бадралт баг бишгүүр ба даралтат хөгжим

Бадралт баг бишгүүр хөгжим байгаа бол үүнийг ихэвчлэн оршил, төгсгөл хөгжим тоглох, дууллын аяыг тоглоход ашигладаг. Хэрэв байхгүй эсвэл үүнийг тоглох хүн байхгүй тохиолдолд төгөлдөр хуур ашиглаж болно.

Төгөлдөр хуур, бадралт баг бишгүүрийг Сүмийн цуглаануудад нэг зэрэг ашиглахыг нь Сүм дэмждэггүй. Гэвч энэ хоёр хөгжмийн зэмсгийг зарим үед хамтад нь хэрэглэж болно.

Төгөлдөр хуур, бадралт баг бишгүүр байхгүй тохиолдолд зөөврийн цахилгаан даралтат хөгжим ашиглаж болно.

#### Хөгжмийн зэмсгүүдийг олж авах нь

Ихэвчлэн сүмийн барилгуудад бадралт баг бишгүүр, төгөлдөр хуур, цахилгаан даралтат хөгжим байдаг. Хөгжмийн зэмсгүүдийг шинээр олж авах болон хуучныг солиулах тухай мэдээлэл олж авахын тулд санваартны удирдагчид Сүмийн удирдах газрын Purchasing Division (Худалдан авалт хийх хэлтэс) эсвэл харьяа үйлчлэлийн төвтэй зөвлөлдөж болно.

#### Хөгжмийн зэмсгүүдийг арчилж тордон засварлах нь

Сүмийн байр хариуцсан бишоп болон гадасны барилга байгууламжийн төлөөлөгч (дээд зөвлөлийн гишүүн) нар төгөлдөр хуур, бадралт баг бишгүүрийг хөглөж, арчилж тордон шаардлагатай бол засуулж байна.

### 14.9.4 Зохиогчийн эрхийн удирдамжууд

21.1.12-ыг үзнэ үү.

### 14.9.5 Хуримын хөгжим

Гэр оронд эсвэл сүмийн байранд болж байгаа хуримын ёслолд оршил хөгжим, сүмийн дууллууд, тусгайлан сонгож авсан дуу хөгжим, төгсгөлийн хөгжим тоглогддог. Иргэний гэрлэлтийн ёслол нь уламжлалыг баримталсан, энгийн байх ёстой. Сүмийн байранд хуримын ёслол болж байгаа үед хуримын марш тоглох нь зохимжгүй.

### 14.9.6 Оршуулгын хөгжим

18.6.5-ыг үзнэ үү.

### 14.9.7 Баптисмын ёслолын хөгжим

20.3.4 дэх "Баптисмын ёслол"-с өөс үзнэ үү.

## 14.10 Онлайн хөгжмийн эх сурвалжууд

Нэмэлт эх сурвалжуудыг Сүмийн хөгжмийн вэб сайт (music.lds.org) мөн LDS.org-ийн Serving in the Church хэсэг дэх "Music Callings and Resources"-оос үзнэ үү.

# 15. Гадасны зохион байгуулалт

15.1 **Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл . . . . . . . . 132**
15.1.1 Гадасны удирдагчдыг дуудаж, онцгойлон адислах нь . . . . . . . . . . . . . . . . . . 132
15.1.2 Гадасны туслах бүлгүүдийн ажил, хөтөлбөрүүдэд хяналт тавих нь . . . . . . . . . 132
15.1.3 Гадасны зөвлөл, хороодыг тэргүүлэх нь . . 132

15.2 **Гадасны бичиг хэргийн ажилтан, бичиг хэргийн ажилтны туслахууд, гадасны гүйцэтгэх нарийн бичиг . . . . . . . . 132**

15.3 **Дээд зөвлөл . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 132**
15.3.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийг төлөөлөх нь . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 132
15.3.2 Гадасны зөвлөл, хороодод үйлчлэх нь . . . . 133

15.4 **Гадасны туслах бүлгүүд . . . . . . . . . . . . . . . . 133**
15.4.1 Гадасны туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл . . . . . . . . . . . . . . . . 133
15.4.2 Гадасны туслах бүлгүүдийн нарийн бичиг нар . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 134

15.5 **Гадасны зохицуулагчид . . . . . . . . . . . . . . . . 134**

15.6 **Орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх нь . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 134**

# 15. Гадасны зохион байгуулалт

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл болон гадасны бусад удирдагч нар тойргийн удирдагчдад зааж, тэднийг дэмжихийн төлөө хамтран ажиллана. Энэ бүлэгт гадасны ерөнхий зохион байгуулалтын тухай өгүүлж, гадасны туслах бүлгүүд болон тойргийн туслах бүлгүүдийн харилцааг тайлбарладаг. Гадасны ерөнхийлөгчид зориулсан нарийн тодорхой заавар *Гарын авлага 1*-д байдаг.

## 15.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл

### 15.1.1 Гадасны удирдагчдыг дуудаж, онцгойлон адислах нь

Гадасны ерөнхийлөгч болон түүний зөвлөхүүд 19-р бүлэг дэх Дуудлагуудын жагсаалтад өгүүлсний дагуу гадасны удирдагчдыг дуудаж, адисална.

### 15.1.2 Гадасны туслах бүлгүүдийн ажил, хөтөлбөрүүдэд хяналт тавих нь

Гадасны ерөнхийлөгч гадасны Нийгмийн халамжийн бүлгийг хариуцна. Тэрээр гадасны бусад туслах бүлгүүд: Залуу Эрэгтэйчүүд (зөвшөөрөл олгосон газарт Скаутыг оролцуулан), Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн Хэсэг, Ням гарагийн ангиудыг хариуцуулан зөвлөхүүдээ томилно. Гадасны туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлүүдэд үүргийг нь заах ажлыг зөвлөхүүд анхаарна.

Гадасны ерөнхийлөгч бас гадасны үйл ажиллагаанууд, ганц бие залуу насанд хүрэгчид, (шаардлагатай бол) ганц бие насанд хүрэгчид, Сүмийн сэтгүүлүүд, (шаардлагатай бол) олон нийттэй харилцах ажил, хөгжим, семинар, институт, барилга байгууламжид хяналт тавиулахын тулд зөвлөхүүдээ томилдог.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд хариуцсан туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй тогтмол хуралддаг. Эдгээр хурлаар оролцогчид өөрсдийн байгууллагын гишүүдийн өсөлт хөгжилт, хэрэгцээний тухай хамтран зөвлөлддөг.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд нь хариуцсан хороод болон бусад хөтөлбөрүүдийн зохицуулагчидтай тогтмол уулздаг.

### 15.1.3 Гадасны зөвлөл, хороодыг тэргүүлэх нь

Гадасны ерөнхийлөгч нь гадасны санваартны гүйцэтгэх хороо болон гадасны зөвлөлийг тэргүүлдэг. Бас гадасны сахилгын хурлуудыг тэргүүлдэг. Мөн тэрээр Аароны санваартнууд–Залуу Эмэгтэйчүүдийн хороо, гадасны ганц бие залуу насанд хүрэгчдийн хороо, гадасны ганц бие насанд хүрэгчдийн хороог (зохион байгуулагдсан газарт) тэргүүлүүлэхээр зөвлөхүүдээ томилдог.

## 15.2 Гадасны бичиг хэргийн ажилтан, бичиг хэргийн ажилтны туслахууд, гадасны гүйцэтгэх нарийн бичиг

Гадасны бичиг хэргийн ажилтан, түүний туслахууд, гадасны гүйцэтгэх нарийн бичиг нарын үүрэг хариуцлагын тухай *Гарын авлага 1-ийн* 13.3.2-оос 13.3.4-р хэсэгт өгүүлсэн байгаа.

## 15.3 Дээд зөвлөл

Гадасны Дээд зөвлөлийг бүрдүүлэхийн тулд гадасны ерөнхийлөгчийн зөвлөл арванхоёр дээд пристийг дууддаг (С ба Г 102:1-ийг үзнэ үү). Хэрэв ахлагч дээд зөвлөлд үйлчлэхээр дуудагдсан бол онцгойлон адислагдахаасаа өмнө дээд пристээр томилогдох ёстой.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор гадас дахь Сүмийн ажилд хяналт тавихад дээд зөвлөлийн гишүүд тусалдаг. Дараах хэсэгт өгүүлсний дагуу тэд зөвлөх, зохион байгуулах үүрэгтэй байдаг.

### 15.3.1 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийг төлөөлөх нь

Ах нарыг ахлагч, дээд пристийн албанд томилох тухай гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн шийдвэрийн талаар хэлэлцэхэд дээд зөвлөлийн гишүүд оролцож, шийдвэрийг дэмждэг. Эрэгтэйчүүдийг ахлагчийн болон дээд пристийн албанд томилоход өөрийгөө төлөөлөх эрх мэдлийг гадасны ерөнхийлөгч дээд зөвлөлийн гишүүдэд олгож болно.

Гишүүдэд дуудлага өгөх тухай гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн шийдвэрийн талаар хэлэлцэхэд дээд зөвлөлийн гишүүд оролцож, шийдвэрийг дэмждэг. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл 19-р бүлэг-т өгүүлсний дагуу зарим дуудлагыг өгөх, дэмжүүлэх болон адислах эрх мэдлийг дээд зөвлөлийн гишүүдэд олгож болно.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл Мелкизедек санваартнуудад хяналт тавих ажилд

туслуулахын тулд ахлагч нарын чуулга, дээд пристүүдийн бүлэг, гадасны харьяа тойрог, салбар бүрд өөрсдийгөө төлөөлөх нэг нэг дээд зөвлөлийн гишүүнийг томилно. Дээд зөвлөлийн гишүүд энэ үүргийн дагуу шинээр дуудагдсан дээд пристүүдийн бүлгийн удирдлага болон ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлүүдэд сургалт явуулдаг. Тэд бас эдгээр удирдагчдад байнгын урам дэм хайрлаж, заавар зөвлөгөө, түүний дотор энэ Гарын авлагын 1–7-р бүлэг дээр үндэслэгдсэн зааврыг өгдөг. Хэрэгцээг нь мэдэж, үүргийг нь заан, гадасны ерөнхийлөгчийн зөвлөлөөс мэдээлэл хүргэж байхын тулд тэд эдгээр удардагчидтай тогтмол уулздаг. Бас ахлагч нарын чуулга, дээд пристүүдийн бүлгийн хурлууд түүний дотор ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн болон дээд пристүүдийн бүлгийн удирдлагын хурлуудад үе үе оролцдог. Тэд бишопын зөвлөл, санваартны гүйцэтгэх хорооны хурлуудад оролцдог. Мөн уригдсан буюу томилогдсон бол тойргийн зөвлөлийн хурлуудад оролцдог.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл гадасны туслах бүлгүүдтэй болон 15.1.2-т (гадасны нарын бичиг эсвэл өөр хэн нэгэнд Сүмийн сэтгүүлийг хариуцуулсан бол үүнд орохгүй) жагсаасан хөтөлбөрүүд дээр ажиллуулахын тулд дээд зөвлөлийн гишүүдийг томилдог. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн гадасны туслах бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй хамтран хуралдаж байгаа үед томилогдсон дээд зөвлөлийн гишүүн энэ хуралд оролцоно. Дээд зөвлөлийн гишүүд нь өөрсдийн хариуцсан туслах бүлгүүдийн удирдлагын хурлуудад оролцдог.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл гадасны хэмжээн дэх номлолын ажил, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд хяналт тавихад туслуулахын тулд дээд зөвлөлийн гишүүдийг томилдог (5.1.9; 5.4.6-г үзнэ үү).

Мөн ариун ёслолын болон бусад цуглаанууд дээр өөрсдийгөө төлөөлөн үг хэлэх дээд зөвлөлийн гишүүдийг гадасны ерөнхийлөгчийн зөвлөл томилж болно. Үг хэлэх энэхүү хуваарийг гадасны ерөнхийлөгчийн зөвлөл гаргана. Дээд зөвлөлийн гишүүд ариун ёслолын цуглаан дээр сар бүр үг хэлэх шаардлагагүй.

### 15.3.2 Гадасны зөвлөл, хороодод үйлчлэх нь

Бүх дээд зөвлөлийн гишүүд гадасны санваартны гүйцэтгэх хороо, гадасны зөвлөлд үйлчилдэг.

Дээд зөвлөлийн гишүүд гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор гадасны сахилгын хурлуудад оролцоно (*Гарын авлага 1-ийн* бүлэг 6-г үзнэ үү).

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл шаардлагатай бол бусад хороодод үйлчлэх дээд зөвлөлийн гишүүдийг томилж болно. Жишээ нь, ахлагч нарын чуулга болон дээд пристүүдийн бүлгүүдтэй ажиллахаар томилогдсон дээд зөвлөлийн гишүүд дээрх үүргээ хэрхэн биелүүлэх арга замуудыг хэлэлцэхийн тулд хуралдаж болно. Аароны санваартай холбоотой ажил үүрэг бүхий дээд зөвлөлийн гишүүд хамтран хуралдаж болно.

Хэрэв гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн байхгүй бол дээд зөвлөл хуралдахгүй.

## 15.4 Гадасны туслах бүлгүүд

Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн Хэсэг, Ням гарагийн анги бол санваартнуудад туслах бүлгүүд юм. Туслах бүлэг бүр гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор үйлчилдэг ерөнхийлөгчийн зөвлөлтэй байдаг. Гадасны Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд Мелкизедек санваартнууд байна. Гадасны Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд бас санваартнууд байх бөгөөд боломжтой бол Мелкизедек санваартан байна. Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд эмэгтэйчүүд байна.

Энэ хэсэгт туслах бүлгүүдийн удирдагчдын нийтлэг үүрэг хариуцлагын тухай өгүүлдэг. Түүнээс гадна гадасны Нийгмийн Халамжийн бүлэг, Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд зөвхөн өөрсдийнх нь бүлэгт байдаг зарим онцгой үүрэг хариуцлагатай байдаг. Эдгээр үүрэг хариуцлагыг 9.8.2 болон 12.7.3-т тус тус өгүүлсэн байдаг.

### 15.4.1 Гадасны туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл

Гадасны туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн үндсэн үүрэг хариуцлага бол гадасны ерөнхийлөгчийн зөвлөлд тусалж, тойргийн туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлүүдэд заавар өгч, дэмжлэг туслалцаа үзүүлэх явдал юм. Тэд тойргийн эсвэл гэр бүлийн төвшинд хийгдэх ёстой ажил үүргийг биелүүлдэггүй.

Гадасны туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл дараах үүрэг хариуцлагатай:

Шинээр дуудагдсан тойргийн туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлд удирдамж

өгнө. Туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл, багш нарт байнгын дэмжлэг туслалцаа үзүүлж, заавар өгнө. Тэд зарим заавраа энэ гарын авлагын 1–6-р бүлэг болон туслах бүлгийн тухай бүлэг дэх заавар дээр тулгуурлан өгөх ёстой. Эдгээр удирдагчдын болон үйлчилдэг гишүүдийнх нь хэрэгцээг мэдэж, хэлэлцэн, гадасны ерөнхийлөгчийн зөвлөлөөс өгч буй мэдээллийг хүргэхийн тулд тэдэнтэй хуралддаг. Зарим үед тойргийн удирдагчдын зохион байгуулж буй тойргийн хурал цуглаан, хичээлүүдэд сууна.

Ихэвчлэн жилд нэг удаа болдог гадасны туслах бүлгүүдийн удирдлагын хурал дээр тойргийн туслах бүлгүүдийн удирдагчдад заавар өгнө. Хэрэв орон нутгийн нөхцөл байдал болон ирж очиход бэрхшээлгүй бол гадасны ерөнхийлөгчийн зөвлөл удирдлагын хоёр дахь хурлыг жил бүр хийх зөвшөөрөл өгч болно. (18.3.11-ийг үзнэ үү.) Бишоп тойргийн туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлүүдэд нэмэлт заавар өгөхийг хүсч болно.

Туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд тус тусынхаа бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал дээр хамтран зөвлөлддөг. Тэд бас бүлэгт нь хяналт тавьдаг гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн болон мөн томилогдсон дээд зөвлөлийн гишүүнтэй тогтмол хуралддаг.

Туслах бүлгийн ерөнхийлөгч нар гадасны зөвлөлд үйлчилдэг. Тэд энэ зөвлөлийн гишүүдийн хувьд итгэлийг бий болгох, гадсан дахь хувь хүмүүс, гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэх ажилд оролцдог.

Туслах бүлгүүдийн ерөнхийлөгч нар тус тусынхаа бүлэгт дуудлага өгөх гишүүдийг гадасны ерөнхийлөгчийн зөвлөлд санал болгодог. Тэд ийнхүү санал болгохдоо 19.1.1 болон 19.1.2 дахь удирдамжуудыг баримтална.

### 15.4.2 Гадасны туслах бүлгүүдийн нарийн бичиг нар

Гадасны туслах бүлгүүдийн нарийн бичиг нар гадасны туслах бүлгүүдийн ерөнхийлөгчдийн удирдлага дор дараах үүрэг хариуцлагатай:

Тэд ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлуудын хөтөлбөрийг бэлтгэнэ.

Ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлуудад оролцож, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврын биелэлтийг мэдээлнэ.

Бусад бүртгэлүүдийг хөтөлж, ерөнхийлөгчийн зөвлөл хүссэн үед тайлан гаргана.

Тэд өөрсдийн туслах бүлгийн жил тутмын төсвийг зохиож, зардлын тооцоог гаргана.

Тойргийн туслах бүлгүүдийн нарийн бичиг нарт сургалт явуулна. Энэ сургалтаар тэдэнд ирцийг бүртгэж, мэдээлэх тухай заавар өгнө.

## 15.5 Гадасны зохицуулагчид

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл нь гишүүдэд зориулж үйл ажиллагаа(13.3.2-ыг үзнэ үү), хөгжим (14.5.4-ийг үзнэ үү), халамж (6.3.3-ыг үзнэ үү) болон өөр бусад үүрэгт зохицуулагчдыг дуудаж, адисалж болно.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл нь Сүмийн тухай үнэн зөв мэдээллийг дэлгэрүүлэх, нийгэмд нөхөрлөл, харилцан ойлголтын гүүрийг бий болгоход туслах олон нийттэй харилцах зохицуулагчдыг дуудан, адисалж болно. Олон нийттэй харилцах зохицуулагчдад зориулсан мэдээлэл LDS.org-н Serving in the Church хэсэгт байдаг. Эдгээр зохицуулагчид гадасны олон нийттэй харилцах албаны даргын удирдлага дор үйлчилдэг.

## 15.6 Орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх нь

Газрын хол, тээврийн зардал, харилцаа холбооны хэрэгсэл, удирдлагын боломж зэрэг нь гадасны хөтөлбөрүүдийг зохион байгуулахад хүндрэлтэй байвал гадасны ерөнхийлөгчийн зөвлөл энэ бүлэг дэх удирдамжийг өөрчлөн хэрэглэж болно. Ингэхдээ тойргийн удирдагчид шаардлагатай сургалт хүлээн авах ёстойг анхаарах хэрэгтэй.

Сүмийн дуудлагууд болон туслах бүлгүүдийг орон нутгийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх тухай ерөнхий мэдээлэл 17-р бүлэг-т байдаг. Санваартны чуулгууд болон туслах бүлгүүдэд зориулсан заавруўд 8.16, 9.9, 10.11, 11.7 болон 12.8-т байдаг.

# 16. Ганц бие гишүүд


16.1 **(31 ба түүнээс дээш настай) Ганц бие насанд хүрсэн гишүүдэд үйлчлэх нь . . . . . 136**

16.1.1 Гадасны ганц бие насанд хүрэгчдийн удирдлага . . . . . . . . . . . . . . . . 136

16.1.2 Гадасны ганц бие насанд хүрэгчдийн хороо . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 136

16.1.3 Гадас дундын үйл ажиллагаа . . . . . . . . . . 136

16.1.4 Ганц бие насанд хүрэгчдийн үйл ажиллагаануудад оролцох нь . . . . . . . . . . 137

16.1.5 Гэр бүлийн үдшийн бүлгүүд . . . . . . . . . . . 137

16.2 **(18-30 насны) Ганц бие залуу насанд хүрсэн гишүүдэд үйлчлэх нь . . . . . . . . . . . . 137**

16.3 **Ердийн гадас, тойрог дахь ганц бие залуу насанд хүрэгчид . . . . . . . . . . . . . . . . . . 137**

16.3.1 Гадасны удирдлага . . . . . . . . . . . . . . . . . . . 137

16.3.2 Гадасны ганц бие залуу насанд хүрэгчдийн хороо . . . . . . . . . . . . . . . . . . . . 137

16.3.3 Тойргийн удирдлага . . . . . . . . . . . . . . . . . . 138

16.3.4 Тойргийн ганц бие залуу насанд хүрэгчдийн хороо . . . . . . . . . . . . . . . . . . . . 138

16.3.5 Хурал цуглаан, хичээл, үйл ажиллагаа (Гадас болон тойргийн). . . . . . . . . . . . . . . . 139

16.3.6 Гадас дундын болон бүсийн үйл ажиллагаа . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 140

16.3.7 Үйл ажиллагааг санхүүжүүлэх нь . . . . . . 140

16.3.8 Залуу насанд хүрэгчдийн төв. . . . . . . . . . 140

16.4 **Ганц бие залуу насанд хүрэгчдийн тойрог . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .141**

16.5 **Ганц бие залуу насанд хүрэгчдийн гадас. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .141**

16.6 **Ганц бие залуу насанд хүрэгчдийн тойрог, гадсанд баримтлах удирдамж ба бодлого . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .141**

16.6.1 Сүмийн хөтөлбөрүүд . . . . . . . . . . . . . . . . . 141

16.6.2 Ганц бие залуу насанд хүрэгчдийн нэгжүүдэд үйлчлэхээр дуудагдсан гишүүдтэй хамтран ажиллах нь . . . . . . . 141

16.6.3 Гэр бүлийн үдшийн бүлгүүд. . . . . . . . . . . 141

16.6.4 Гэрийн болон айлчлагч багш нар . . . . . . 141

16.6.5 Удирдагчдын гишүүнчлэлийн бүртгэл . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 141

16.6.6 Ганц бие залуу насанд хүрэгчдийн гишүүнчлэлийн бүртгэл . . . . . . . . . . . . . . 142

16.6.7 Номлолд нэр дэвшүүлэх нь . . . . . . . . . . . 142

16.6.8 Санваарын томилолт . . . . . . . . . . . . . . . . . 142

16.6.9 Сургуулийн амралт . . . . . . . . . . . . . . . . . . 142

16.6.10 Ариун сүмийн эрхийн бичиг . . . . . . . . . . 142

16.6.11 Үйлчлэлийн хугацаа . . . . . . . . . . . . . . . . . . 142

16.6.12 Ганц бие залуу эцэг эхчүүд . . . . . . . . . . . 142

# 16. **Ганц бие гишүүд**

Гэрлээгүй, гэр бүл салсан, бэлэвсэн эрэгтэй, эмэгтэйчүүд Сүмийн гишүүнчлэлийн нэлээд хувийг бүрдүүлдэг. Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид эдгээр гишүүдэд хүрч ажиллан, тэднийг Сүмийн дуудлагат ажилд хамруулдаг. Зохистой ганц бие гишүүдэд удирдлагын болон багшлах дуудлагууд, түүний дотор ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл, дээд пристүүдийн бүлгийн удирдлага, туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлд дуудагдан ажиллах боломж олгох хэрэгтэй.

Их Эзэнд ойртоход нь ганц бие гишүүдэд тусалснаар удирдагчид тэдний гэрчлэлийг бэхжүүлэн, сүнслэг байдал, нийгмийн болон хувийн амжилтынхаа төлөө үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлдэг.

Удирдагчид ганц бие гишүүдэд үйлчилснээрээ гэр бүлтэй нь сөргөлдүүлэх, тэднийг гэр бүлээс нь хөндийрүүлэх биш харин гэр бүлийн амьдралыг нь бэхжүүлэхийг эрэлхийлдэг. Мөн гэрлэх болон эцэг эх болохын ач холбогдлыг зааж гэрчилдэг. Ганц бие залуу насанд хүрэгчдийг эцэг эхтэйгээ хамт амьдардаггүй байлаа ч эцэг эхтэйгээ холбоотой байж, тэднийг хүндэтгэдэг байхад нь удирдагчид дэмжиж тусална. Хүүхдүүддээ зааж, тэднийг хүмүүжүүлэхэд удирдагчид нь ганц бие эцэг эхчүүдэд дэмжлэг үзүүлдэг.

Ганц бие гишүүдийг ганц бие насанд хүрэгчид (31 ба түүнээс дээш настай), ганц бие залуу насанд хүрэгчид (18–30 настай) гэсэн хоёр бүлэгт хуваадаг.

## 16.1 (31 ба түүнээс дээш настай) Ганц бие насанд хүрсэн гишүүдэд үйлчлэх нь

31 болон түүнээс дээш настай ганц бие гишүүдийг өөрсдийн гадас, тойргийн үйл ажиллагаануудад тогтмол оролцдог байхыг удирдагчид дэмждэг. Эдгээр гадас, тойргууд Сүмийн бүрэн үйл ажиллагаагаар хангаж, үйлчлэх, заах, удирдах, бүх насны хүмүүстэй харилцаатай байх боломжуудыг санал болгож чадна. Мөн эдгээр нэгжүүд нь сайн мэдээний төлөвлөгөөн дэх гэр бүл болон гэр орны үүргийн ач холбогдлыг заана.

Удирдагчид ганц бие насанд хүрэгчдийг ойлгож, хэрэгцээг нь шийдвэрлэхэд онцгой анхаарах ёстой. Ганц бие насанд хүрэгчдийн нөхцөл байдал, сонирхдог зүйлс өөрчлөгддөгийг удирдагчид мэддэг байх ёстой. Заримдаа ганц бие насанд хүрэгчид гэр бүл дээр тулгуурласан үйл ажиллагаа, хичээлд оролцох төдийлөн сонирхолгүй байдагт нь удирдагчид соргог мэдрэмжээр хандах ёстой.

### 16.1.1 Гадасны ганц бие насанд хүрэгчдийн удирдлага

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ганц бие насанд хүрэгчдийн хэрэгцээг ойлгож, шийдвэрлэхэд нь туслахыг хичээдэг. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл нь гадасны ганц бие насанд хүрэгчдийг хамтдаа үйлчлэлд оролцох, сайн мэдээнээс суралцах болон тойргоос гадуур нэмэлт үйл ажиллагаанд оролцох боломжоор хангаж болно.

Гадасны ерөнхийлөгч зөвлөхүүдийнхээ нэгийг гадасны ганц бие залуу насанд хүрэгчидтэй ажиллах ажилд хяналт тавиулахаар томилж болно. Тэрээр энэ ажилд туслалцуулахаар нэг дээд зөвлөлийн гишүүнийг томилж болно. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн энэ гишүүн нь дээд зөвлөлийн гишүүнийг гадасны ганц бие залуу насанд хүрэгчидтэй ажиллахаар томилж болно.

### 16.1.2 Гадасны ганц бие насанд хүрэгчдийн хороо

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл гадасны ганц бие насанд хүрэгчдийн хороог зохион байгуулж болно. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг зөвлөх энэ хороог тэргүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнд нэг дээд зөвлөлийн гишүүн, гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүн, нэлээд хэдэн ганц бие залуу насанд хүрэгчид орно. Энэ хороо ихэвчлэн гадасны ганц бие залуу насанд хүрэгчдийн хорооноос тусдаа зохион байгуулагддаг.

Тус хороо шаардлага гарсан үед хуралдана. Хорооны гишүүд нь ганц бие насанд хүрэгчдийг хамтдаа үйлчлэлд оролцох, сайн мэдээнээс суралцах болон тойргоос гадуур нэмэлт үйл ажиллагаанд оролцох боломжоор хангах арга замуудыг төлөвлөж болно.

### 16.1.3 Гадас дундын үйл ажиллагаа

Ганц бие гишүүдийн хувьд үйлчлэх, удирдах болон нийгэмтэй харилцах боломжууд гарч байгаа тохиолдолд гадас дундын үйл

ажиллагаануудыг төлөвлөж, зохион байгуулах хороодыг байгуулахын тулд Бүсийн Дал гадасны ерөнхийлөгчийн зөвлөлтэй хамтран ажилладаг.

### 16.1.4 Ганц бие насанд хүрэгчдийн үйл ажиллагаануудад оролцох нь

Ганц бие насанд хүрэгчдийн үйл ажиллагаануудад зөвхөн ганц бие насанд хүрсэн гишүүд, Сүмийн томилогдсон удирдагчид, Сүмийн жишгүүдийг дагах хүсэлтэй ганц бие насанд хүрсэн гишүүн бус хүмүүс оролцдог. Эхнэр эсвэл нөхрөөсөө тусдаа амьдардаг болон гэр бүлээсээ салах гэж байгаа хүн гэр бүл цуцлах нь хуулийн дагуу шийдвэрлэгдэх хүртэл энэ үйл ажиллагаанд оролцож болохгүй.

### 16.1.5 Гэр бүлийн үдшийн бүлгүүд

Хүүхэдгүй эсвэл эцэг эхээсээ тусдаа амьдардаг ганц бие гишүүдэд зориулсан нэг буюу түүнээс олон гэрийн цуглааны бүлгүүдийг бишопын зөвлөл зохион байгуулж болно. Эдгээр бүлгийг гэр бүл гэж үздэггүй.

## 16.2 (18-30 настай) Ганц бие залуу насанд хүрсэн гишүүдэд үйлчлэх нь

Гадас, тойргийн удирдагчид дараах арга замуудаар ганц бие залуу насанд хүрэгчдийг болон тэдний хаягийг тогтоож, тэдэнд байнга анхаарал халамж тавин ажиллана.

Удирдагч нар ганц бие залуу насанд хүрэгчдэд сүмд идэвх султай үе тэнгийнхээ хүмүүстэй танилцаж тэдэнтэй нөхөрлөхөд нь тусалдаг.

Үр өгөөжтэй үйлчлэх, сайн мэдээнээс суралцах болон олон нийтийн үйл ажиллагаанд хамтдаа оролцох боломжийг ганц бие залуу насанд хүрэгчдэд бүрдүүлж өгнө. Эдгээр үйл ажиллагааны үндсэн зорилго бол амьдралынхаа ханийг олж, ариун сүмд гэрлэхээр бэлтгэн, зөв шударга гэр бүлийг бий болгон төвхнүүлэхэд ганц бие залуу насанд хүрэгчдэд туслах явдал юм.

Мөн хувийн зөв зохистой зорилгоо биелүүлэх, гэрлэлт, боловсрол, ажил мэргэжил, санхүүгийн талаар шийдвэр гаргахад нь тэд ганц бие залуу насанд хүрэгчдэд дэмжлэг үзүүлдэг.

Ганц бие залуу насанд хүрэгч бүр *Итгэлдээ үнэнч байх нь: Сайн мэдээний эшлэл товхимолтой байхад удирдагчид анхаарна.* Энэ номыг ганц бие залуу насанд хүрэгчид сайн мэдээний зарчмуудыг судлах, яриа өгөхөөр бэлтгэх, хичээл заах, Сүмийн тухай асуултуудад хариулах эх сурвалж болгон ашиглахыг нь дэмждэг.

## 16.3 Ердийн гадас, тойрог дахь ганц бие залуу насанд хүрэгчид

### 16.3.1 Гадасны удирдлага

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага нь ганц бие залуу насанд хүрэгчдэд үйлчлэх ажилд онцгой чухал юм. Ганц бие залуу насанд хүрэгчид шилжих хөдөлгөөн ихтэй байдаг. Тэд гадасны тойргуудад харилцан адилгүй тоотойгоор амьдардаг бөгөөд нэг хаяг дээр байнга оршин суудаггүй. Эдгээр шалтгааны улмаас олон нийтийн үйл ажиллагаа, сайн мэдээнээс суралцах, үйлчлэл зэргийг гадасны болон гадас дундын төвшинд хийх нь хамгийн үр өгөөжтэй байдаг.

Гадасны ерөнхийлөгч бишоп бүртэй тогтмол хийдэг ярилцлагандаа тухайн бишопын тойрог дахь ганц бие залуу насанд хүрэгчдийн өсөлт хөгжилтийн тухай асуудаг.

Гадасны ерөнхийлөгч зөвлөхүүдийнхээ нэгийг гадасныхаа ганц бие залуу насанд хүрэгчидтэй ажиллах ажилд хяналт тавиулахаар томилдог. Бас нэг дээд зөвлөлийн гишүүнийг энэ ажилд туслалцуулахаар томилдог.

Ямар хөтөлбөр болон үйл ажиллагаа ганц бие залуу насанд хүрэгчдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирохыг гадасны удирдагчид залбирч шийддэг. Олон хувилбарыг 16.3.5-д жагсаасан байгаа.

Ганц бие залуу насанд хүрэгчдийн ихэнх нь (тэдний олонх нь эцэг эхтэйгээ хамт) ердийн тойргуудад амьдарч байгаа тохиолдолд санваартны удирдагчид нөхцөл байдал бүрэлдсэн үед ганц бие залуу насанд хүрэгчдийн тойрог зохион байгуулах санал тавьж болно (16.4-ийг үзнэ үү).

### 16.3.2 Гадасны ганц бие залуу насанд хүрэгчдийн хороо

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн гадасны ганц бие залуу насанд хүрэгчдийн хороог тэргүүлнэ. Энэ хороонд ганц бие залуу насанд хүрэгчдэд томилогдсон дээд зөвлөлийн гишүүн, гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүн, ганц бие залуу насанд хүрэгчдийн зөвлөхөөр үйлчлэхээр дуудагдсан гэр бүлийн хос, тойрог бүрийн ганц бие залуу насанд хүрэгчдийн удирдагчид ордог. Тойргуудад ганц бие залуу насанд хүрэгчдийн удирдагчид байдаггүй бол энэ хороонд үйлчлүүлэхээр зохистой өөр ганц бие залуу насанд хүрэгчдийг дуудах хэрэгтэй. Энэ хороог ихэвчлэн гадасны ганц бие насанд хүрэгчдийн хорооноос тусд нь зохион байгуулдаг.

Шаардлага гарсан үед хороо хуралдана. Хорооны гишүүд нь ганц бие залуу насанд хүрэгчдийг хамтдаа үйлчлэлд оролцох, сайн мэдээнээс суралцах болон тойргоос гадуур нэмэлт үйл ажиллагаанд оролцох боломжоор хангах арга замуудыг төлөвлөж болно. (16.3.5-ыг үзнэ үү). Тэд ганц бие залуу насанд хүрэгчдийн үйл ажиллагаануудыг төлөвлөхдөө зөвхөн олныг хамарсан үйл ажиллагаанд биш харин сүнслэг байдлын өсөлт хөгжилт, үйлчлэлд анхаарал төвлөрүүлнэ.

Энэ хороо тойргуудын ганц бие залуу насанд хүрэгчдийн хороог тойрогтоо сайн ажиллахад нь тусалдаг.

## 16.3.3 Тойргийн удирдлага

### Бишопын зөвлөл

Тойргийнхоо ганц бие залуу насанд хүрэгчдийг ойлгож, тэдний хэрэгцээг шийдвэрлэхийн тулд бишопын зөвлөлийн гишүүн ганц бие залуу насанд хүрэгч бүртэй доод тал нь жилд нэг удаа ярилцлага хийнэ. Бишопын зөвлөл ганц бие залуу насанд хүрэгчдэд бүгдэд нь тохирох дуудлага өгөхийн тулд тойргийн зөвлөлтэй хамтран ажилладаг. Бишопын зөвлөл нь тойргийн ганц бие залуу насанд хүрэгчдийн хороог зохион байгуулж болно.

Бишопын зөвлөлийн нэг гишүүн тойргийн ганц бие залуу насанд хүрэгчдийг хариуцна. Тэрээр тойргийн ганц бие залуу насанд хүрэгчдийг хариуцсан ахлагч нарын чуулга, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөхүүдээс байнга илтгэл хүлээн авдаг. Тэрээр тойргийн зөвлөлийн хурал дээр ганц бие залуу насанд хүрэгч бүрийн талаар илтгэж болно.

### Ганц бие залуу насанд хүрэгчидтэй ажиллахаар томилогдсон ахлагч нарын чуулгын болон Нийгмийн Халамжийн Бүлгийн зөвлөхүүд

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч нар өөрсдийн бүлэг дэх ганц бие залуу насанд хүрэгчдэд анхаарал халамж тавих ажлыг удирдуулахаар нэг зөвлөхөө томилдог. Эдгээр зөвлөхүүд ганц бие залуу насанд хүрэгчдэд урам дэм, дэмжлэг туслалцаа үзүүлэхийн тулд үе үе тэдэнтэй уулздаг. Тэд ганц бие залуу насанд хүрэгчдийн тухай гэрийн ба айлчлагч багшийн тайлан болон өөрсдийн очсон айлын талаар томилогдсон бишопын зөвлөлийн гишүүнд мэдээлэл өгдөг. Тэд ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч нарт ажлаа тайлагнана. Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч хоёр энэ ажлын талаар тойргийн зөвлөлийн хурал дээр мэдээлнэ.

### Ганц бие залуу насанд хүрэгчдийн удирдагчид

Хангалттай тооны ганц бие залуу насанд хүрэгчидтэй тойрогт бишопын зөвлөл ганц бие залуу насанд хүрсэн ах эсвэл эгчийг ганц бие залуу насанд хүрэгчдийн удирдагчаар дуудаж болно. Эдгээр удирдагчид бишопын зөвлөлийн гишүүнд ажлаа тайлагнана. Хэрэв тойрогт ганц бие залуу насанд хүрэгчдийн хороо байгуулагдсан бол тэд энэ хороонд үйлчилнэ. Гэрийн болон айлчлагч багш нарыг ганц бие залуу насанд хүрэгчдийн хэрэгцээг шийдвэрлэхэд туслуулахын тулд тэд ахлагч нарын чуулгын болон Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй тогтмол уулзаж байна. Тэднийг гадасны ганц бие залуу насанд хүрэгчдийн хороонд үйлчлүүлэхээр томилж болно.

### Ганц бие залуу насанд хүрэгчдийн зөвлөгч нар

Бишопын зөвлөл гэр бүлийн зохистой хосыг тойргийн ганц бие залуу насанд хүрэгчдийн зөвлөгчөөр дуудаж болно. Эдгээр зөвлөгч нар бишопын зөвлөлийн гишүүнд ажлаа тайлагнана. Хэрэв тойрогт ганц бие залуу насанд хүрэгчдийн хороо байгуулагдсан бол тэд энэ хороонд үйлчилнэ. Тэд гадасны ганц бие залуу насанд хүрэгчдийн хороонд үйлчлэхээр томилогдож болно. Ганц бие залуу насанд хүрэгчдэд нөхөрлөл, үйлчлэл, сайн мэдээнээс суралцахын тулд хамтдаа цуглах боломжоор тэд тусалдаг.

## 16.3.4 Тойргийн ганц бие залуу насанд хүрэгчдийн хороо

Нэлээд олон тооны ганц бие залуу насанд хүрэгчидтэй тойрогт гадасны ерөнхийлөгч, бишоп хоёр тойргийн ганц бие залуу насанд хүрэгчдийн хороо шаардлагатай гэж үзэж болно. Бишопын зөвлөлийн гишүүн энэ хороог тэргүүлдэг. Хорооны бусад гишүүдэд ганц бие залуу насанд хүрэгчидтэй ажиллахаар томилогдсон ахлагч нарын чуулгын болон Нийгмийн Халамжийн Бүлгийн зөвлөхүүд, ганц бие залуу насанд хүрэгчдийн удирдагчид, ганц бие залуу насанд хүрэгчдийн зөвлөгчөөр үйлчлэхээр дуудагдсан хүмүүс орно.

Шаардлага гарсан үед хороо хуралдана. Үйлчлэл, удирдлага, сайн мэдээнээс суралцах болон олон нийтийн үйл ажиллагаанудад оролцоход нь ганц бие залуу насанд хүрэгчдэд туслах арга замуудыг хорооны гишүүд хэлэлцдэг. Тэд идэвх султай ганц бие насанд хүрэгчидтэй танилцаж, тэдэнтэй нөхөрлөдөг.

### 16.3.5 Хурал цуглаан, хичээл, үйл ажиллагаа (Гадас болон тойргийн)

Тойрог, гадас, гадас дундын төвшинд явагддаг сайн мэдээнээс суралцах, үйлчлэх, соёлын болон олон нийтийн олон төрлийн үйл ажиллагааг ганц бие залуу насанд хүрэгчдэд зориулан зохион байгуулах хэрэгтэй. Ийм үйл ажиллагаануудад ариун сүмд явах, санваар болон ариун сүмд бэлтгэх семинар, номлолын ажил, олон нийтэд үйлчлэл үзүүлэх, найрал дуу, соёлын үйл ажиллагаа, бүжиг, спортын тоглолт орж болно.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл нь гадасны ганц бие залуу насанд хүрэгчдийн хороо болон тойргийн удирдагчдын туслалцаатайгаар ганц бие залуу насанд хүрэгчдийн хэрэгцээнд хамгийн сайн тохирох хурал цуглаан, хичээл, үйл ажиллагаануудыг зохион байгуулна. Тэд бас үйл ажиллагааг тойргийн, гадасны төвшинд эсвэл зарим үед гадас, тойрог хоёр нийлж зохион байгуулах эсэхийг шийддэг.

Ганц бие залуу насанд хүрэгчдэд зориулсан үйл ажиллагаанууд нь 13-р бүлэг дэх журам, удирдамжуудтай нийцэж байх ёстой. Ганц бие насанд хүрэгчдийн үйл ажиллагаануудад зөвхөн ганц бие насанд хүрсэн гишүүд, Сүмийн томилогдсон удирдагчид, Сүмийн жишгүүдийг дагах хүсэлтэй ганц бие насанд хүрсэн гишүүн бус хүмүүс оролцдог. Эхнэр эсвэл нөхрөөсөө тусдаа амьдардаг, гэр бүлээсээ салах гэж байгаа хүн гэр бүл цуцлах нь хуулийн дагуу шийдвэрлэгдэх хүртэл энэ үйл ажиллагаанд оролцож болохгүй.

Тойрог, гадасны удирдагчид ганц бие залуу насанд хүрэгчдэд зориулсан үйл ажиллагаануудыг төлөвлөхдөө дараах хувилбаруудыг авч үзэж болно.

#### Ганц бие залуу насанд хүрэгчдийг олж, урих

Ганц бие залуу насанд хүрэгчид нь оршин суух газраа байнга өөрчилдөг учраас гадсан дахь ганц бие залуу насанд хүрэгчдийн хаягийг тогтоож, тэдэнтэй нөхөрлөх зорилготой үйл ажиллагааг гадас зохиож байх хэрэгтэй. Ийм үйл ажиллагааг зэргэлдээ орших гадаснууд хамтран зохион байгуулж болно. Идэвхтэй ганц бие залуу насанд хүрэгчид нь ийм үйл ажиллагаануудын үед гол туслах хүч болдог бөгөөд тэднийг тойргийн болон гадасны ганц бие залуу насанд хүрэгчдийн хороо удирдан зохион байгуулдаг. Зарим үед институтийн ажилтнууд тусалж болно.

#### Ганц бие залуу насанд хүрэгчдийн үйлчлэлийн хороо

Ганц бие залуу насанд хүрэгчдийг үйлчлэлийн хороонд үйлчлүүлэхээр олонтаа дууддаг. Энэ хороо нь бишопын зөвлөлийн томилсон гадас, тойргийн удирдагчид эсвэл гадас, тойргийн ганц бие залуу насанд хүрэгчдийн хороонд ажлаа тайлагнана. Уг хороо ямар үйлчлэл хийхийг тухайн нэгжийн удирдагчид шийднэ. Үйлчлэл нь халамж, гэр бүлийн түүх, олон нийттэй харилцах, номлолын ажил болон ганц бие залуу насанд хүрэгчдийг идэвхжүүлэх, Сүмийн барилга байгууламж, төслийн ажилд дэмжлэг үзүүлэх зэрэг Сүмийн хөтөлбөрүүд дээр ихэвчлэн төвлөрдөг. Мөн орон нутагтаа болон бусад газар хүмүүнлэгийн тусламжийн үйлчлэл хийж болно. Үйлчлэлийн хороо нь найз нөхөдтэй болж, амьдралын ханьтайгаа учрах боломжийг олгодог. Тэд бас удирдах болон олон нийтийн ажлын ур чадварыг заадаг.

#### Гэр бүлийн үдшийн бүлгүүд

Санваартны удирдагчид нэг буюу түүнээс олон гэр бүлийн үдшийн бүлгүүдийг эцэг эхтэйгээ хамт амьдардаггүй, гэртээ хүүхэдгүй ганц бие залуу насанд хүрэгчдийн дунд зохион байгуулж болно. Боломжтой бол санваартны удирдагч нар бүлэг бүрт ганц бие залуу насанд хүрэгч санваартныг удирдуулахаар томилно. Ганц бие залуу насанд хүрэгчид нь цөөн гадсанд гадасны удирдагчид хэд хэдэн тойргийн дунд гэр бүлийн үдшийн бүлгүүдийг зохион байгуулж болно. Гэр бүлийн үдшийн бүлгийн удирдагчид нь томилогдсон санваартны удирдагчдад ажлаа тайлагнана. Эдгээр бүлгийг гэр бүл гэж үздэггүй.

#### Ням гарагийн ангиуд

Хангалттай тооны ганц бие залуу насанд хүрэгчидтэй тойрог ням гарагийн ангийг ганц бие залуу насанд хүрэгчдэд зориулан тусад нь явуулж болно (12.4.2-ыг үзнэ үү).

#### Ажлын өдрүүдэд сайн мэдээг судлах ангиуд

Ганц бие залуу насанд хүрэгчдийг институтийн ангиудад элсэхийг нь дэмждэг. Санваартны удирдагчид институтийн жишгүүдэд нийцсэн, ганц бие залуу насанд хүрэгчдийн хэрэгцээг хангаж чадах ангиудыг зохион байгуулахад институтийн орон нутгийн ажилтнуудтай хамтран ажилладаг. Сургуульд сурдаггүй ганц бие залуу насанд хүрэгчид институтийн ангиудад эсвэл орон нутгийн сүмийн байруудад санваартны удирдагчдын дуудсан багш нарын заадаг ангиудад аль алинд нь элсэж болно. Ийм ангиудыг

санваартны удирдагчид, институтийн ажилтнууд хамтран зохион байгуулж болно.

Институтийн ангиуд байдаггүй бол орон нутгийн удирдагчид тусламж хүсч Бүсийн Шашны семинар, институтийн албатай холбоо барьж болно. Шаардлагатай бол орон нутгийн удирдагчид ажлын өдөр сайн мэдээг судлах өөр бүлгийг зохион байгуулж болно.

### 16.3.6 Гадас дундын болон бүсийн үйл ажиллагаа

Гадас дундын болон бүсийн үйл ажиллагаанууд нь ганц бие залуу насанд хүрэгчдэд олон нийттэй харилцах удирдах ур чадварт суралцах, үйлчлэх боломжийг олгодог ба бишопын удирдлага дор явагдана.

Бүсийн далууд ийм үйл ажиллагаануудыг зохион байгуулах гадас дундын хороодыг байгуулахын тулд гадасны ерөнхийлөгчидтэй хамтран ажилладаг. Бүсийн далууд Далын эсвэл Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор ажилладаг. Гадас дундын хороодод ганц бие залуу насанд хүрэгчдийн удирдагчдыг оруулах ёстой.

Зардал багатай, энгийн, хоорондоо амархан танилцах боломжийг оролцогчдод олгох үйл ажиллагаануудыг гадас дундын хороод төлөвлөх хэрэгтэй. Эдгээр хороод ганц бие залуу насанд хүрэгчдийн тойргууд болон шашны институттэй холбоотой ажиллаж, үйл ажиллагаа болон цаг давхардахаас зайлсхийх зохицуулалт хийдэг.

Эдгээр үйл ажиллагааг зохион байгуулах тухай нэмэлт удирдамжийг 13.3.1-ээс үзнэ үү.

### 16.3.7 Үйл ажиллагааг санхүүжүүлэх нь

Ганц бие залуу насанд хүрэгчдэд зориулсан үйл ажиллагаануудыг ихэвчлэн гадасны эсвэл тойргийн төсвөөс санхүүжүүлдэг. Гадас дундын болон бүсийн үйл ажиллагаа зохион байгуулж байгаа үед төсвийг гадаснуудын дунд зөв хуваарилах ёстойг үйл ажиллагаа хариуцсан санваартны удирдагч анхаарах хэрэгтэй.

Үйл ажиллагааны санхүүжилт нь 13.2.8 дахь журамтай нийцэж байх ёстой. Онцгой тохиолдолд, гадас дундын эсвэл бүсийн томоохон үйл ажиллагааны үед зардлын зарим хэсгийг өөрсдөө төлөхийг ганц бие залуу насанд хүрэгчдээс хүсч болно. Гэвч ганц бие залуу насанд хүрэгчид хувиасаа хэтэрхий их мөнгө зарлгүйгээр бүгдээрээ үйл ажиллагаанд оролцох боломжтой байхыг удирдагчид анхаарах ёстой.

### 16.3.8 Залуу насанд хүрэгчдийн төв

Сайн мэдээнээс суралцах, олон нийтийн үйл ажиллагаа, номлолын ажил, идэвхжүүлэлтэд хамт олноор оролцох боломжоор хангахын тулд зарим газарт залуу насанд хүрэгчдийн төв байгуулахыг зөвшөөрдөг. Ганц бие залуу насанд хүрэгчдийн төв нь оролцогч гадаснуудын ерөнхийлөгчийн зөвлөл, институтийн ажилтнууд, номлолын ерөнхийлөгч, ерөнхий удирдлагаар хангах хариуцагч гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн хамтын ажиллагааг шаарддаг. Эдгээр удирдагчдад шашны институтийн суралцагчдын зөвлөл, гадасны ганц бие залуу насанд хүрэгчдийн хороо тусалж болно. Бүрэн цагийн номлогчид энэ төв дээр номлолын ажилд оролцож болох боловч ихэвчлэн номлогч эсвэл номлогч биш гэр бүлийн хосоор туслуулна.

Шашны институтийн зөвлөх зөвлөл (*Гарын авлага 1-ийн* 11.1.3-ыг үзнэ үү), шашны институтийн суралцагчдын зөвлөл (*Гарын авлага 1*-ийн 11.2.2-ыг үзнэ үү), тойрог, гадасны ганц бие залуу насанд хүрэгчдийн хороод, ганц бие залуу насанд хүрэгчдийн гадас, тойргууд зэрэг байгууллагууд уг төвийг ашиглах хуваарь гаргахдаа давхцал болон хуваарь зөрчилдөхөөс зайлсхийх хэрэгтэй. Гадасны ерөнхийлөгч нар нь институтийн ажилтнууд болон бусад удирдагчидтай зөвлөлдөж зарим үйл ажиллагаанд дээрх байгууллагуудыг нэгдэн оролцохыг хүсч болно.

Залуу насанд хүрэгчдийн төвийг сүмийн байранд байгуулж болно. Энэ тохиолдолд хариуцагч гадасны ерөнхийлөгч байр ашиглалтын хуваарьт хяналт тавина.

Институтийн барилгатай газарт Далын Ерөнхийлөгчийн эсвэл Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн институтийн барилгыг залуу насанд хүрэгчдийн төв болгон ашиглах хүсэлтийг тавьж болно. Энэ тохиолдолд институтийн захирал барилгын төлөөлөгчөөр үйлчлэхээ үргэлжлүүлнэ. Институтийн анги болон байр ашиглалтыг институтийн захирал гадасны ерөнхийлөгчтэй зөвлөлдөн хариуцна. Бусад үйл ажиллагаанууд институтийн хичээлд саад болох ёсгүй.

Залуу насанд хүрэгчдийн төв байгуулах зөвшөөрөл хүсэхийн тулд санваартны удирдагчид Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн эсвэл Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гишүүнтэй холбоо барина. Залуу насанд хүрэгчдийн төвийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд удирдагчид Шашны семинар, институтийн удирдах албатай холбоо барих хэрэгтэй.

## 16.4 Ганц бие залуу насанд хүрэгчдийн тойрог

Орон нутгийн нөхцөл байдал, ганц бие залуу насанд хүрэгч гишүүдийн тоо нь ганц бие залуу насанд хүрэгчдийн тойрог байгуулах боломжийг бүрдүүлсэн бол ийм тойрог байгуулах саналыг санваартны удирдагчид *Гарын авлага 1*-ийн 9.1.6 дахь удирдамжийн дагуу тавьж болно.

Ганц бие залуу насанд хүрэгч гишүүд эцэг эхтэйгээ зөвлөлдсөний үндсэн дээр залуу насанд хүрэгчдийн тойрогт эсвэл ердийн тойрогт явахаа шийднэ. Гадасны идэвх султай бусад залуу гишүүдийг олж, тойрогтоо авчрахыг ганц бие залуу насанд хүрэгчдийн тойрогт гадасны ерөнхийлөгч зөвшөөрч болно. Идэвхтэй болсон гишүүд ганц бие залуу насанд хүрэгчдийн тойрогт явах эсвэл ердийн тойрогтоо явахаа өөрсдөө шийдэж болно.

Ганц бие залуу насанд хүрэгчдийн тойргийн бишоп гадасны ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр ганц бие залуу насанд хүрэгч эмэгтэйчүүдэд зориулж, Нийгмийн Халамжийн хоёр дахь бүлгийг, ганц бие залуу насанд хүрэгч эрэгтэйчүүдэд зориулж ахлагч нарын хоёр дахь чуулгыг зохион байгуулж болно. Энэ нь үйлчлэх болон бие биетэйгээ харилцаатай байх илүү боломж олгоно.

Ганц бие залуу насанд хүрэгчдийн тойрог дахь гишүүнчлэл түр хугацааных байдаг. Ганц бие залуу насанд хүрэгчдийг гэрлэсэн эсвэл 31 нас хүрсэн үедээ ердийн тойрогтоо буцаж очих ёстойгоо ойлгоход нь удирдагчид тусална. Энэхүү шилжилт нэлээд хугацаа шаардахын хамт шилжин очиж байгаа залуу насанд хүрэгч бүр сэтгэл хангалуун байж мөн уг тойрогт хэрэгтэй гэдгийг нь мэдрүүлэхэд туслахын тулд дуудлага төлөвлөх талаар ердийн тойргийн бишоптой холбоо тогтоох шаардлага гардаг.

## 16.5 Ганц бие залуу насанд хүрэгчдийн гадас

Санваартны удирдагчид *Гарын авлага 1*-ийн 9.1.7 дахь удирдамжийн дагуу ганц бие залуу насанд хүрэгчдийн гадас байгуулах санал тавьж болно. Уг хэсэгт бас ганц бие залуу насанд хүрэгчдийн гадасны гишүүнчлэл, удирдлагын талаарх удирдамжууд байдаг.

## 16.6 Ганц бие залуу насанд хүрэгчдийн тойрог, гадсанд баримтлах удирдамж ба бодлого

### 16.6.1 Сүмийн хөтөлбөрүүд

Ганц бие залуу насанд хүрэгчдийн тойргууд аль болох Сүмийн тогтсон хөтөлбөрийг ашиглана. Ганц бие залуу насанд хүрэгчдийн тойргийн бишоп, гадасны ерөнхийлөгч нар энэ Гарын авлага болон *Гарын авлага 1* дэх зарчим болон зааврууды баримтална. Үүнд халамжийн тусламж, санхүү, төсвийн тухай зааврууд мөн багтана.

### 16.6.2 Ганц бие залуу насанд хүрэгчдийн нэгжүүдэд үйлчлэхээр дуудагдсан гишүүдтэй хамтран ажиллах нь

Ердийн тойрог, гадасны гишүүдийг ганц бие насанд хүрэгчдийн гадас, тойрогт удирдагчаар үйлчлэхийг эрх бүхий санваартны удирдагч хүссэн үед ердийн тойрог, гадасны удирдлагууд тэднийг бүрэн дүүрэн дэмжих ёстой. Гэвч тухайн гишүүний Сүмийн үүрэгт ажил, гэр бүлийн нөхцөл байдал нь уг дуудлагыг өгөхөд тохиромжгүй гэж гадас, тойргийн эдгээр удирдлагууд үзвэл эрх бүхий санваартны удирдагчидтай зөвлөлдөх ёстой.

### 16.6.3 Гэр бүлийн үдшийн бүлгүүд

Ганц бие залуу насанд хүрэгчдийн тойргийн бишоп 16.3.5-д өгүүлсний дагуу гэр бүлийн үдшийн бүлгүүдийг зохион байгуулж болно.

### 16.6.4 Гэрийн болон айлчлагч багш нар

Ганц бие залуу насанд хүрэгчдийн тойрог, гадасны гишүүн бүр нь гэрийн болон айлчлагч багш нарын хувьд гэр бүлийн гишүүн нь гэсэн үг юм.

### 16.6.5 Удирдагчдын гишүүнчлэлийн бүртгэл

Ганц бие залуу насанд хүрэгчдийн тойргийн бишопын зөвлөлийн гишүүд болон тэдний гэрийнхний гишүүнчлэлийн бүртгэл ихэвчлэн харьяалагддаг тойрогтоо үлддэг. Ганц бие залуу насанд хүрэгчдийн гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, дээд зөвлөл, гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлд үйлчилдэг гишүүдийн хувьд ч бас адил. Эдгээр удирдагчид болон тэдний гэр бүлийнхэн аравны нэг болон өргөлөө харьяалагддаг тойрогтоо төлнө. Бас ариун сүмийн бичиг авахын тулд тэд харьяалагддаг тойрог, гадасныхаа удирдагч уруу очно.



16. Ганц бие гишүүд

### 16.6.6 Ганц бие залуу насанд хүрэгчдийн гишүүнчлэлийн бүртгэл

Ганц бие залуу насанд хүрэгчдийн гишүүнчлэлийн бүртгэл нь тэр гишүүний хамрагдан явж буй тойрогт байх ёстой. Удирдагчид болон бичиг хэргийн ажилтнууд гишүүдийн бүртгэлүүдийг байнга шинэчилж байхыг анхаарах ёстой. Бүртгэлийг хойшлуулах эсвэл бүртгэл болон хүмүүс алдагдахаас зайлсхийхийн тулд байнга шилжин явдаг ганц бие залуу насанд хүрэгчдийн албан бус бүртгэлийг бичиг хэргийн ажилтнууд хөтөлж болно.

### 16.6.7 Номлолд нэр дэвшүүлэх нь

Номлолд нэр дэвшүүлэх тухай мэдээллийг гадасны ерөнхийлөгч, бишопууд *Гарын авлага 1-ийн* 4.3, 4.4, 4.5 болон 4.7-гоос үзэж болно.

### 16.6.8 Санваарын томилолт

20.7-г үзнэ үү.

### 16.6.9 Сургуулийн амралт

Боломжтой бол ганц бие залуу насанд хүрэгчдийн тойрог сургуулийн амралтын үеэр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх хэрэгтэй. Цөөхөн гишүүнтэй ганц бие залуу насанд хүрэгчдийн тойрог сургуулийн амралтын үеэр зэргэлдээх ганц бие залуу насанд хүрэгчдийн тойрогтой нэгдэн цуглаж болно. Энэ тохиолдолд хоёр тойрог бүртгэл, ирц, санхүүгээ тус тусдаа хөтөлнө.

### 16.6.10 Ариун сүмийн эрхийн бичиг

Ихэнх тохиолдолд хувийн хишгээ хүлээн авах гэж байгаа болон ариун сүмд гэрлэхээр төлөвлөж байгаа гишүүдтэй гадасны ерөнхийлөгч ярилцлага хийнэ. Онцгой тохиолдолд ганц бие залуу насанд хүрэгчдийн гадсанд хувийн хишгээ хүлээн авах гэж байгаа болон ариун сүмд гэрлэхээр төлөвлөж байгаа гишүүдтэй ярилцлага хийх эрх мэдлийг гадасны ерөнхийлөгч зөвлөхүүддээ олгож болно.

### 16.6.11 Үйлчлэлийн хугацаа

Ганц бие залуу насанд хүрэгчдийн гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, тойргийн бишопын зөвлөл, дээд зөвлөлд буюу харьяалагддаг тойргоосоо гадна үйлчлэх ах нарыг гурваас таван жилийн хугацаагаар дууддаг. Бусад дуудлагуудад ч мөн адил 3-5 жил үйлчилнэ.

### 16.6.12 Ганц бие залуу эцэг эхчүүд

Хүүхэдтэй ганц бие гишүүд хүүхдээ Хүүхдийн Хэсэг эсвэл залуучуудын хөтөлбөрт хамруулж болохын тулд өөрсдийн тойрогт үлддэг. Гэвч тэд ганц бие залуу насанд хүрэгчдийн тойргийн үйл ажиллагаануудад оролцож болно.

# 17. Сүмийн нийтлэг зарчим ба орон нутгийн хэрэгцээнд тохируулах нь


17.1 **Сүмийн нийтлэг зарчмыг баримтлах нь . . 144**

17.1.1 Судрууд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 144
17.1.2 Зарлигууд ба жишгүүд . . . . . . . . . . . . . . . . 144
17.1.3 Сургаалын цэвэр ариун байдал . . . . . . . . 144
17.1.4 Ариун ёслолын цуглаан ба ням гарагийн цуглааны хуваарь . . . . . . . . . . . . 144
17.1.5 Чуулган . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 145
17.1.6 Ариун сүмийн ажил . . . . . . . . . . . . . . . . . . 145
17.1.7 Сахилгын хурал . . . . . . . . . . . . . . . . . . . . . 145
17.1.8 Бүртгэл, тайлангууд . . . . . . . . . . . . . . . . . . 145
17.1.9 Ёслолууд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 145
17.1.10 Сургалтын хөтөлбөр . . . . . . . . . . . . . . . . . . 145

17.2 **Орон нутгийн хэрэгцээнд тохируулж болох нөхцлүүд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 145**

17.2.1 Гэр бүлийн нөхцөл байдал . . . . . . . . . . . . . 146
17.2.2 Тээвэр болон харилцаа холбоо . . . . . . . . . 146
17.2.3 Цөөхөн хүнтэй чуулга буюу анги . . . . . . 146
17.2.4 Удирдлагын гарын авлага, материалууд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 147
17.2.5 Аюулгүй байдал . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 147

# 17. Сүмийн нийтлэг зарчим ба орон нутгийн хэрэгцээнд тохируулах нь

Сүмийн гишүүд улс төр, нийгэм, эдийн засгийн өөр өөр нөхцөл байдалд амьдардаг. Тойрог салбарууд ч хэмжээ болон удирдах хүмүүсийн нөөц боломжоор ялгаатай байдаг. Энэхүү нөхцөл байдал нь Сүмийн зарим хөтөлбөрийг өөрчлөхийг орон нутгийн удирдагчдаас шаардаж болно. Ийм өөрчлөлтүүд нь туслах бүлгүүдийн болон удирдлагын хурлууд, үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд тусгалаа олдог. Энэ бүлэг дэх удирдамжууд нь тухайн байдалд ямар өөрчлөлтүүд тохиромжтой болон тохиромжгүйг тогтооход санваартны удирдагчдад туслах зорилготой юм.

Бүх тойрог, салбар нь хэмжээ, нөхцөл байдлаасаа үл хамааран, Их Эзэний Сүнсээр нэгэн адил дүүрэн байх хэрэгтэй. "Хоёр болон гурван хүн миний нэрээр хаана цуглана, тэнд би тэдний дунд байна" (Матай 18:20) хэмээн Тэрбээр амласан байдаг.

## 17.1 Сүмийн нийтлэг зарчмийг баримтлах нь

Удирдагчид ямар өөрчлөлт тохиромжтойг мэдэхийн тулд судрууд болон хожмын үеийн бошиглогчид, төлөөлөгчдийн үндэслэн бий болгосон сургаал, ёслол, туршлагуудыг хамгийн түрүүнд ойлгодог байх ёстой. Эдгээр зүйлс Сүм даяар жигд байх ёстой.

Гадасны ерөнхийлөгч, бишоп болон орон нутгийн бусад удирдагчид доор дурдсан бүх заавраар Сүмийн нийтлэг зарчим, цэвэр ариун байдлыг сахин мөрдөх ариун үүрэгтэй юм. Нийтлэг зарчмын энэхүү хэрэгцээ "нэг Эзэн, нэг итгэл, нэг баптисм" (Ефес 4:5 мөн Мозая 18:21) гэсэн судрын зарчим дээр үндэслэгддэг.

### 17.1.1 Судрууд

Сүмийн жишиг бүтээлүүд бол Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувд юм. Сүм олон оронд Библийн нэг орчуулгыг Сүмийн цуглаан, хичээлүүд дээр хэрэглүүлэхээр баталдаг. Мөн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн судруудын зөвшөөрөгдсөн хамгийн сүүлчийн хэвлэлийг ашиглах ёстой. Өөр номнуудыг Сүм дээр судар болгон ашиглах ёсгүй.

### 17.1.2 Зарлигууд ба жишгүүд

Их Эзэний зарлигууд болон Сүмийн зохистой байдлын жишгүүд нь судрууд, Тэргүүн Зөвлөлийн захидал ба албан ёсны баримт бичгүүдэд байдаг. Орон нутгийн удирдагчид эдгээр зарлиг болон жишгүүдийг өөрчлөх ёсгүй. Орон нутгийн удирдагчид нь зарлигуудын талаар нэмж өөрсдийн дүрэм тайлбарыг зааж болохгүй.

Ариун сүмд орох зохистой байдлын жишгүүдийг ариун сүмийн бичгийн номон дахь ярилцлагын асуултуудад нарийвчлан өгүүлсэн байдаг. Орон нутгийн удирдагчид эдгээрийг өөрчлөх ёсгүй.

### 17.1.3 Сургаалын цэвэр ариун байдал

Сүмийн сургаал нь судрууд болон хожмын үеийн бошиглогчид, төлөөлөгчдийн сургаалуудад байдаг. "Энэ сүмийн ахлагчид, санваартнууд хийгээд багш нар Библи хийгээд сайн мэдээний бүрэн байдал байгаа Мормоны Номон дахь, миний сайн мэдээний зарчмуудыг заах ёстой" гэж сургажээ (С ба Г 42:12; мөн С ба Г 52:9, 36-г үзнэ үү).

Сүмд зөв сургаал заагддаг байхад бүх удирдагчид анхаарна. Хэрэв хүн хуурамч буюу эргэлзээтэй сургаал зааж эхлэх юм бол удирдагчид тэр даруй эвтэйхнээр залруулах ёстой. Алдааг ихэвчлэн тухайн хүнтэй ганцаарчлан уулзаж засах хэрэгтэй. Гэвч томоохон эсвэл удаа дараа гаргаж байгаа алдааг нийтийн өмнө залруулах хэрэгтэй.

Аль нэг сэдвээрх сургаал, заадаг зүйлс үнэн гэдэгт орон нутгийн удирдагчид эргэлзэж байвал тэргүүлдэг эрх мэдэлтнээс удирдамж хүсч болно.

### 17.1.4 Ариун ёслолын цуглаан болон ням гарагийн цуглааны хуваарь

Ариун ёслолын цуглааныг явуулах нь заавал биелүүлэх судрын заалт юм (С ба Г 59:9-ийг үзнэ үү). Ариун ёслолын цуглааны тухай заавар 18.2.2-т байдаг. Ням гарагийн хурал цуглаануудын хуваарийг 167-р хуудсанд үзүүлсэн байгаа. Энэ хуваарийг Тэргүүн Зөвлөл, Арванхоёрын Чуулга батлан гаргасан юм. Орон нутгийн удирдагчид үүнийг өөрчилж болохгүй.

Маш онцгой тохиолдолд орон нутгийн удирдагчид ням гарагийн цуглааныг цуцалж болно. Гэвч ховор тохиолдолд ийнхүү цуцалдаг. Жишээлбэл, онцгой байдлын үед аюулгүй байдлыг хангах эсвэл цаг уурын онцгой хүнд

байдлын улмаас цуглаануудыг цуцалж болно. Боломжтой бол бишоп цуглаануудыг цуцлахаас өмнө гадасны ерөнхийлөгчтэй зөвлөх ёстой.

Зарим үед орон нутаг дахь ер бусын нөхцөл байдлаас үүдэн ням гарагийн цуглааны хуваарийг удаан хугацаагаар өөрчлөх зайлшгүй шаардлага гарч болно. Жишээ нь, сүмийн байр гал түймэр, үер, шуурганд эвдэрсэн бол цуглааны хуваарийг өөрчлөх шаардлага гарч болно. Ийм нөхцөлд гадасны ерөнхийлөгч, зохицуулах зөвлөлийг нь тэргүүлдэг Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлөөс эсвэл Бүсийн Даргаас удирдамж хүсэх хэрэгтэй.

Жижиг салбарын удирдагчид *Basic Unit Program Guidebook (Анхан шатны нэгжийн хөтөлбөрийн удирдамж)-ийг* ашиглан өөрсдийн удирдагчдаас удирдамж авч ням гарагийн цуглааны хуваарьт өөрчлөлт оруулж болно.

### 17.1.5 Чуулган

Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгчийн төлөвлөснөөр гадас бүр жилд хоёр удаа гадасны чуулган хийдэг (18.3.1-ийг үзнэ үү).

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл гадасныхаа тойрог эсвэл салбар бүрийн чуулганыг жил бүр төлөвлөн, зохион байгуулж, тэргүүлдэг (18.2.5-ыг үзнэ үү). Дүүргийн ерөнхийлөгч бас дүүргийнхээ салбар бүрийн чуулганыг дээрхийн адилаар төлөвлөн, зохион байгуулж, тэргүүлнэ.

### 17.1.6 Ариун сүмийн ажил

Ариун сүмийн эрхэм ариун ажил Сүмийн Ерөнхийлөгчийн шууд эрх мэдэл дор байдаг. Ариун сүмийн ажилтай холбоотой бүх асуудлыг *Гарын авлага 1-ийн* 3-р бүлэг дэх зааврын дагуу шийдвэрлэх ёстой. Ийм асуудлуудын жишээнд ариун сүмийн бичиг, лацдан холболт, лацдан холболтын зөвшөөрөл болон цуцлалт орно. Гадасны ерөнхийлөгч шийдвэрлэж чадахгүй асуудалтай тулгарвал асуудлыг Тэргүүн Зөвлөлийн Албанд хандан тавина.

Ариун сүмийн үг хэллэг, ариун ёслолууд болон гэрээнүүдийг Сүмийн цуглаан дээр ярихгүй байх талаар удирдагчид анхаарах ёстой.

### 17.1.7 Сахилгын хурал

Сахилгын хурлын тухай заавар *Гарын авлага 1-ийн* 6-р бүлэг -т байгаа. Удирдагчид эдгээр зааврыг, түүний дотор тайлан явуулах шаардлагуудыг зөрчиж болохгүй. Гадасны ерөнхийлөгч шийдвэрлэж чадахгүй асуудалтай тулгарвал асуудлыг Тэргүүн Зөвлөлийн Албанд хандан тавина.

### 17.1.8 Бүртгэл, тайлангууд

Сүмийн бүртгэлүүдийг хөтлөх нь заавал биелүүлэх судрын заалт юм (С ба Г 20:81–83-ыг үзнэ үү). Шаардлагатай бүртгэл, тайлангуудын тухай *Гарын авлага 1-ийн* 13-р бүлэг -т өгүүлсэн байдаг. Тэргүүн Зөвлөл бүртгэл тайлангуудад нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Тухайн бүсээс хамааран сүмийн компьютерийн систем эсвэл хэвлэмэл маягтуудыг ашиглан Сүмийн бүртгэл, тайлангуудыг бэлтгэдэг. Бүртгэл, тайлангууд нь үнэн зөв бөгөөд тэдгээрийг хугацаанд нь явуулдаг байх талаар удирдагчид анхаарна.

### 17.1.9 Ёслолууд

Санваарын ёслолуудыг гүйцэтгэх зааврын тухай 20-р бүлэг-т өгүүлсэн байдаг. Эдгээр заавруудыг өөрчлөх ёсгүй. Баптисм хүртэх болон Аароны санваарын албуудад томилох зэрэг ёслолын үед насны доод хязгаарыг аль нэг шалтгааны улмаас өөрчилж болохгүй.

### 17.1.10 Сургалтын хөтөлбөр

Ням гарагийн цуглааны хичээлүүд дээр Сүмийн баталсан сургалтын гарын авлага, материалуудыг ашиглах ёстой. Эдгээр материалд Сүмээс эрхлэн хэвлүүлсэн гарын авлагууд, сэтгүүл, заах бусад эх сурвалж материалууд орно. Шинэ гарын авлага, сургалтын материалуудыг орон нутгийн төвшинд хэвлэн гаргаж болохгүй.

Бишоп, салбарын ерөнхийлөгч нар хэрэгтэй гэж үзвэл өөрсдөө хичээл заах буюу санваартнуудын болон туслах бүлгүүдэд тусгай хичээл орох зөвшөөрөл өгч болно.

## 17.2 Орон нутгийн хэрэгцээнд тохируулж болох нөхцлүүд

Гадасны ерөнхийлөгч, бишоп, салбарын ерөнхийлөгч нар Сүмийн зарим хөтөлбөрт энгийн өөрчлөлтийг хийж болно. Шаардлагатай бол ийм өөрчлөлтүүдийг дараах байдлаар хийж болно:

1. Туслах бүлгүүдэд үйлчлэх гишүүдийг дуудах болон бүлгийн хөтөлбөрүүдэд
2. Удирдлагын хурлуудын хэлбэр, хуваарьт
3. Үйл ажиллагаануудын хэлбэр, хуваарьт

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, бишопын зөвлөл, салбарын ерөнхийлөгчийн зөвлөл ямар өөрчлөлт тохиромжтойг авч үзэхдээ хоорондоо болон гадас, тойрог, салбарын зөвлөлтэй хамтран зөвлөлдөж болно. Нэлээд их өөрчлөлт хийх нөхцөлд тэд өөрсдийн тэргүүлэх эрх

мэдэлтэнтэйгээ зөвлөлдөж болно. Удирдагчид өөрчлөлт хийхдээ ямагт Сүнсний удирдамжийг эрэлхийлэх ёстой.

Удирдагчид ямар өөрчлөлт тохиромжтойг шийдэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзан үзэж болно.

### 17.2.1 Гэр бүлийн нөхцөл байдал

Дуудлага өгөх, удирдлагын хурал, үйл ажиллагаануудыг төлөвлөхдөө удирдагчид гишүүдийн гэр бүлийн нөхцөл байдлыг харгалзаж үздэг. Сүмийн үйлчлэл, үйл ажиллагаанд оролцох нь үргэлж ямар нэг хэмжээгээр золиослол шаарддаг. Гэвч бат бөх итгэлтэй гэр бүлүүд Сүмд амин чухал юм. Иймээс үйлчлэх буюу хөтөлбөр, үйл ажиллагаануудыг дэмжихийн тулд гэр бүлдээ хэтэрхий их золиослол хийхийг гишүүдээс хүсэх ёсгүй.

Харгалзаж үзэх ёстой гэр бүлийн нэг нөхцөл байдал бол тухайн гишүүний нөхөр эсвэл эхнэрийн үйлчилдэг Сүмийн дуудлага(ууд) юм. Гэр бүлүүдийг Сүмийн үүрэгт ажлаар хэт шахаж болохгүй. Харгалзаж үзэх ёстой өөр нэг нөхцөл байдал бол өрх гэрээ авч явах болон хувийн ажил төрөлдөө зориулдаг гишүүдийн цаг хугацааны асуудал юм. Зарим оронд гишүүд хоёр, гурван ажил зэрэг хийх шаардлагатай байдаг. Эдгээр нөхцөл байдал бол дуудлага өгөх, удирдлагын хурал, үйл ажиллагаануудын хуваарийг гаргаж, төлөвлөхөд удирдагчид зүй ёсоор харгалзаж үзэх ёстой хүчин зүйлс юм.

### 17.2.2 Тээвэр болон харилцаа холбоо

Зарим гадас, тойргууд өргөн уудам нутаг дэвсгэртэй байдаг бөгөөд хурал цуглаан, үйл ажиллагаануудад оролцохын тулд холоос ирж, буцах шаардлагатай болдог. Удирдагчид хурал цуглаан, үйл ажиллагаануудыг хэрэгтэй эсэх талаар дүгнэлт хийхдээ гишүүд тэдгээрт ирэх болон буцахад шаардагдах хугацаа, зорчих зардлыг харгалзаж үзэх ёстой.

Олон оронд автомашин нь нийтлэг хэрэгцээ болж чадаагүй байгаагаас хүмүүс явган эсвэл дугуй, автобус, троллейбусаар явдаг. Гэр нь хол тохиолдолд Сүмийн хөтөлбөр, удирдлагын хурлуудад оролцох гишүүдэд чирэгдэл учруулахгүйн тулд Сүмийн хөтөлбөрүүдэд удирдагчид өөрчлөлт оруулж болно.

Автомашин өргөн хэрэглээ болсон газарт ч гэсэн хол газар машинаар явахад гардаг зардалд удирдагчид анхааралтай байх ёстой. Зарим тохиолдолд дээд зөвлөлийн ажил хэрэг явуулахад удирдагчид утсаар ярих, э-мэйл, интернет ашиглах замаар тээврийн зардлыг хэмнэж болно. Удирдагчид эдгээр эх сурвалжийг ашиглахдаа нууц хадгалах талаар онцгой анхаарах хэрэгтэй.

Амьдралын төвшин нь өөр гишүүд өөр өөр тээврийн хэрэгслээр зорчдог. Жишээ нь ганц бие залуу насанд хүрэгчид нь хүүхдүүдтэй гэр бүлээс илүү хол газар явах, боломжтой байдаг. Ганц бие залуу насанд хүрэгчид боломжийн хугацаанд бага зардлаар цугларах газарт тэдэнд зориулан гадас дундын үйл ажиллагааг үе үе зохион байгуулах хэрэгтэй (13.3.1-ийг үзнэ үү).

Дэлхийн зарим оронд телефон утас өндөр үнэтэй бөгөөд олон гишүүн өөрийн гэсэн утасгүй байдаг. Үүний нэг адил, зарим газарт э-мэйл, интернетэд нэвтрэх боломж хомс. Эдгээр нь өндөр үнэтэй, нийтийн хэрэглээ болоогүй бол удирдагчид шаардлагатай өөрчлөлт оруулах хэрэгтэй.

Явахад хүндрэлтэй эсвэл зардал өндөр, холбоо барих боломж хомс газарт гэрийн болон айлчлагч багшийн ажил илүү хүнд байдаг. Энэ тохиолдолд удирдагчид 7.4.3 болон 9.5.3-т өгүүлсний дагуу зохицуулалт хийж болно.

### 17.2.3 Цөөхөн хүнтэй чуулга буюу анги

#### Ахлагч нар ба дээд пристүүд

Ням гарагийн санваартны хуралдаанд оролцох ахлагч нар, дээд пристүүдийн тоо цөөхөн бол хамтдаа хуралдаж болно. Гэвч Мелкизедек санваартан ганцхан байсан ч хамаагүй Мелкизедек санваартны чуулгыг байгуулах ёстой. Тойрогт ахлагч, дээд пристүүд томилогдохын хэрээр ахлагч нарын чуулга, дээд пристүүдийн бүлгийг зохион байгуулах ёстой.

Дүүрэгт дээд пристүүдийн чуулга байдаггүй учраас дүүргийн харьяа салбаруудад дээд пристүүдийн бүлэг байдаггүй. Эдгээр салбар дахь дээд пристүүд ахлагч нарын чуулгатай хамт хурал цуглаанд оролцдог.

#### Залуу Эрэгтэйчүүд ба Залуу Эмэгтэйчүүд

Цөөхөн залуу эрэгтэйчүүдтэй тойрог, салбарт Аароны санваартны чуулгууд хичээл, үйл ажиллагаанд хамтдаа цуглаж болно (8.11 болон 8.13.1-ийг үзнэ үү). Гэхдээ чуулгуудыг тусад нь зохион байгуулж, чуулга бүрийн удирдагчдыг дуудаж, дэмжүүлэн батлуулна.

Цөөхөн залуу эмэгтэйчүүдтэй тойрог, салбарт хичээл, үйл ажиллагаанд тэд хамтдаа цуглаж болно (10.6.2 болон 10.8.1-ийг үзнэ үү). Нас насны бүлэг бүрд ангийн даргын зөвлөл дуудагдаж болно. Эсвэл тэднийг тус тусын ангиуд болон зохион байгуулагдах хүртэл өөр өөр

насны бүлгүүдийг нийлүүлж, нэг ерөнхийлөгчийн зөвлөл дуудаж болно.

Хэрэв насанд хүрсэн удирдагчид хүрэлцэхгүй байвал Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл ням гарагийн хичээлүүд болон үйл ажиллагааг зөвлөгчгүйгээр зохион байгуулж болно. Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийг мөн дээрхийн адилаар зохион байгуулж болно. Жижиг нэгжид Залуу Эрэгтэйчүүд эсвэл Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч хоёр бүлгийнхээ цорын ганц удирдагч байж болно. Энэ тохиолдолд тэд ням гарагийн хичээлийг заахын хамт залуу эрэгтэйчүүд болон залуу эмэгтэйчүүдийн үйл ажиллагааг хариуцна. Боломжтой бол зөвлөхүүд болон нарийн бичгийг бүлэг бүрд дуудах хэрэгтэй.

Олон хүнтэй бүлэг дэх олон нийтийн үйл ажиллагаа залуучуудад ашигтай байдаг учраас хоёр буюу түүнээс дээш жижиг тойрог, салбарын залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд зарим үед хамтын үйл ажиллагаанд оролцож болно. Хил залгаа тойрог, салбарууд цөөхөн залуу эрэгтэйчүүдтэй эсвэл залуу эмэгтэйчүүдтэй бол бишоп, салбарын ерөнхийлөгч хоёр долоо хоног тутмын үйл ажиллагаанд залуучуудыг хамтран оролцохыг зөвшөөрч болно. Бишоп, салбарын ерөнхийлөгч нар энэ хувилбарыг сонгохдоо газрын хол ойр, тээврийн зардал зэрэг хүчин зүйлсийг харгалзаж үзнэ.

Цөөхөн залуучуудтай тойрог, салбарууддад гадасны болон гадас дундын үйл ажиллагааг үе үе зохион байгуулах нь онц чухал юм (13.3 болон 13.4-ийг үзнэ үү).

Жижигхэн гадас буюу дүүрэгт Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч нь гадасны эсвэл дүүргийн Залуу Эрэгтэйчүүдийн цорын ганц удирдагч нь байж болно. Бас гадас, дүүргийн Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч ч тийнхүү бүлгийнхээ цорын ганц удирдагч нь байж болно. Боломжтой бол зөвлөхүүд болон нарийн бичгийг бүлэг бүрд дуудах хэрэгтэй.

#### Хүүхдийн Хэсэг

Цөөхөн хүүхэдтэй тойрог, салбарт Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл өөр өөр насны бүлгүүдийг нэгтгэн цөөхөн анги зохион байгуулж болно.

Жижиг тойрог, салбарт Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл нь өөрсдөө Хүүхдийн Хэсгийн удирдагчид ба багш нар нь байж болно. Бүр жижиг нэгжид Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч нь Хүүхдийн Хэсгийн цорын ганц удирдагч нь байж болно. Энэ тохиолдолд тэр хуваалцах цагийг хөтлөн явуулж, бүх хүүхдүүдийг нэгтгэсэн нэг ангид хичээл заадаг. Боломжтой бол 11.7-д өгүүлсний дагуу илүү олон удирдагч, багш нарыг дуудах хэрэгтэй.

Жижиг гадас, дүүрэгт Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч нь гадас, дүүргийн Хүүхдийн Хэсгийн цорын ганц удирдагч нь байж болно. Боломжтой бол 11.7-д өгүүлсний дагуу бусад удирдагчдыг дуудах хэрэгтэй.

### 17.2.4 Удирдлагын гарын авлага, материалууд

Удирдах дуудлагуудад дуудагдахад тэнцэх хангалттай тооны гишүүд байхгүй бол зөвхөн зайлшгүй шаардлагатай дуудлагуудад гишүүдийг дуудаж болно. Санваартны тэргүүлэгч нар удирдах албанд идэвхтэй, туршлагажсан гишүүдийг дуудахаас гадна шинэ болон туршлагагүй гишүүд, эргэж ирэх магадлалтай идэвхсултай гишүүдийн дундаас удирдагч болж чадах хүнийг сонгохын тулд сүнсний удирдамжийг эрэлхийлэх хэрэгтэй. Сүмийн гишүүд дуудлага хүлээн авахын тулд туршлагатай эсвэл өндөр шаардлага хангасан байх хэрэггүй. Дуудлагатай байна гэдэг нь гишүүдийн хувьд үйлчлэх, сүнслэг байдлаараа өсч хөгжих чухал арга зам юм.

Удирдах албуудад үйлчлэх хангалттай тооны гишүүд байхгүй бол тэргүүлэх албан тушаалтнууд гадас, тойрог, салбарт багасгасан зохион байгуулалт хийж болно. Жишээ нь зарим бүлэгт зөвхөн ерөнхийлөгч, нэг зөвлөхийг дуудаж, зөвлөх нь нарийн бичгээр давхар үйлчилж болно. Зарим хөтөлбөрийг энгийн болгож болно.

Залуу Эмэгтэйчүүдийн эсвэл Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчгүй маш жижиг салбарт Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч Залуу Эмэгтэйчүүдийн болон Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч дуудагдтал залуу эмэгтэйчүүд, хүүхдүүдэд хичээл заахад нь эцэг эхчүүдэд тусалж болно.

Бүр жижиг салбарын удирдагчид *Basic Unit Program Guidebook (Анхан шатны нэгжийн хөтөлбөрийн гарын авлага)* дахь удирдамжийг баримтална.

### 17.2.5 Аюулгүй байдал

Зарим оронд гэмт хэргийн хувь хэмжээ маш өндөр эсвэл улс төрийн үймээн самуунтай байдаг. Эдгээр бүст гишүүд оройн цагаар гадуур явах нь аюултай гэж удирдагчид үзвэл оройн цагаар үйл ажиллагаа явуулахгүй байж болно. Энэ нь Сүмийн үйл ажиллагааны тоог цөөрүүлж, долоо хоногийн амралтын үеэр

зохиодог зарим үйл ажиллагааг хязгаарлана гэсэн үг юм.

Аюулгүй байдлын хувьд ноцтой эсвэл тээврийн зардал нь өндөр тохиолдолд залуучуудын зарим үйл ажиллагааг ням гарагт төлөвлөж болно. Ийм үйл ажиллагаанууд нь ням гарагийн цуглааны хуваарьтай давхцахгүй байхын сацуу Хүндэтгэлийн өдрийн уур амьсгалыг сахих ёстой.

# 18. Сүмийн хурал цуглаанууд


18.1 **Хурал цуглаануудыг төлөвлөх, хөтлөн явуулах удирдамж . . . . . . . . . . . . . . 150**

18.2 **Тойргийн хурал цуглаанууд . . . . . . . . . . . . . 150**

18.2.1 Ням гарагийн цуглааны хуваарь . . . . . . . 150
18.2.2 Ариун ёслолын цуглаан . . . . . . . . . . . . . . . 151
18.2.3 Мацгийн болон гэрчлэлийн цуглаан . . . 153
18.2.4 Санваартны хурал . . . . . . . . . . . . . . . . . . . 153
18.2.5 Тойргийн чуулган . . . . . . . . . . . . . . . . . . . 153
18.2.6 Бишопын зөвлөлийн хурал . . . . . . . . . . . 154
18.2.7 Тойргийн санваартны гүйцэтгэх хорооны хурал . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 154
18.2.8 Тойргийн Зөвлөлийн хурал. . . . . . . . . . . 154
18.2.9 Бишопын зөвлөлийн Залуучуудын хорооны хурал . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 154
18.2.10 Тойргийн ганц бие залуу насанд хүрэгчдийн хорооны хурал. . . . . . . . . . . 155
18.2.11 Номлогчдийн хамтарсан хурал . . . . . . . . 155

18.3 **Гадасны хурлууд. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 155**

18.3.1 Гадасны чуулган. . . . . . . . . . . . . . . . . . . . . 155
18.3.2 Гадасны санваартнуудын ерөнхий хурал. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 156
18.3.3 Гадасны санваартны удирдлагын хурал. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 156
18.3.4 Гадасны дээд пристүүдийн чуулгын хурал. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 157
18.3.5 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 157
18.3.6 Гадасны санваартны гүйцэтгэх хорооны хурал (Дээд зөвлөлийн хурал). . 157
18.3.7 Гадасны Зөвлөлийн хурал . . . . . . . . . . . . 157
18.3.8 Бишопын зөвлөлүүдтэй хийх хурал . . . . 158
18.3.9 Гадасны Ааронып санваартнууд–Залуу эмэгтэйчүүдийн хорооны хурал . . . . . . . 158
18.3.10 Гадасны бишопуудын халамжийн зөвлөлийн хурал . . . . . . . . . . . . . . . . . . . . . 158
18.3.11 Гадасны туслах бүлгүүдийн удирдлагын хурал . . . . . . . . . . . . . . . . . . . . 158
18.3.12 Гадасны ганц бие залуу насанд хүрэгчдийн хорооны хурал. . . . . . . . . . . 159
18.3.13 Гадасны ганц бие насанд хүрэгчдийн хорооны хурал . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 159

18.4 **Сүмийн хурал цуглаанууд дээр үзүүлэн, дуу, дүрс бичлэгийн материалуудыг ашиглах тухай . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 159**

18.5 **Сүмийн цуглаанууд дээрх залбирал . . . . . 159**

18.6 **Оршуулга ба нас баралтын үе дэх бусад ёслолууд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 159**

18.6.1 Нас баралт ба гашуудал . . . . . . . . . . . . . . . 159
18.6.2 Төлөвлөлт ба тусламж үзүүлэх нь . . . . . . 160
18.6.3 Салах ёс гүйцэтгэх нь (Ийм заншилтай газарт) . . . . . . . . . . . . . . . . . . . 160
18.6.4 Оршуулгын ёслол . . . . . . . . . . . . . . . . . . . 160
18.6.5 Дуу хөгжим. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 161
18.6.6 Оршуулга ба цогцос чандарлах тухай . . 161
18.6.7 Санхүүгийн бодлого. . . . . . . . . . . . . . . . . . 161
18.6.8 Гишүүн бус хүмүүст зориулсан оршуулгын ёслол . . . . . . . . . . . . . . . . . . . . 161

**Тойргийн хурал цуглаануудын жагсаалт . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 162**

**Гадасны хурал цуглаануудын жагсаалт . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 164**

**Ням гарагийн хурлуудын хуваарь . . . . . . . 167**

**Өөр хэлээр ярьдаг нэгжүүдийн цуглааныг нэгтгэх нь . . . . . . . . . . . . . . . . . . 168**

# 18. Сүмийн хурал цуглаанууд

Энэ бүлэг Сүмийн хурал цуглаануудын тухай товч мэдээллийг агуулдаг. Чуулга, Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн Хэсэг, Ням гарагийн анги зэрэг туслах бүлгүүдийн хурлыг энэ гарын авлагад тайлбарласан болно.

Гарын авлагуудад өгүүлсэн хурал цуглаануудаас гадна тэргүүлэх эрх мэдэлтнүүд зарим үед бусад хурлыг зарлан, тэдгээрийн бүтэц, зорилгыг тодорхойлдог.

## 18.1 Хурал цуглаануудыг төлөвлөх, хөтлөн явуулах удирдамж

Удирдагчид "Бурханы зарлигууд хийгээд илчлэлтүүдийн дагуу тэд Ариун Сүнсээр удирдагдан" (С ба Г 20:45 мөн С ба Г 46:2 болон Моронай 6:9-ийг үзнэ үү) цуглаануудыг төлөвлөж, хөтлөн явуулдаг.

Удирдагчид хурал бүрийн хөтөлбөрийг бэлтгэх буюу үүнийг өөрсдийнхөө удирдлага дор бэлтгэх хүнийг томилно. Хурлын хөтөлбөр нь хурлын зорилго дээр анхаарал төвлөрүүлж, цагийг үр өгөөжтэйгөөр ашиглахад оролцогчдод тусалдаг. Хамгийн чухал асуудлуудыг эхлээд хэлэлцэхийг чухалчлах ёстой.

Удирдлагын хурлууд хувь хүмүүс, гэр бүлүүдийг бэхжүүлэхэд анхаарал төвлөрүүлэх ёстой. Хуваарь гаргах болон захиргааны бусад ажил хэрэгт цаг бага зарцуулах ёстой.

Хурал цуглаанаар хамтран зөвлөлдөх тухай удирдамжийг 4.6.1-ээс үзнэ үү.

Тэргүүлэх санваартан хурлыг хөтлөн явуулж болно эсвэл өөрийнхөө удирдлага дор хэн нэгнийг хурлыг хөтлөн явуулахыг хүсч болно.

Хурлыг онц шаардлагагүй бол удаан үргэлжлүүлэх ёсгүй.

Ням гарагийн хурлууд нь гишүүдийн гэр бүлээрээ хамт байх цагаас нь дэндүү их авахгүй байхад удирдагчид анхаарах ёстой. Боломжтой бол удирдагчид ням гарагийн гурван цаг үргэлжилдэг тогтсон цуглаан, өглөө эрт хийдэг удирдлагын хурал болон оройн цагаар хийдэг зарим хурал цуглаануудаас өөр хурлыг төлөвлөхгүй байх хэрэгтэй.

## 18.2 Тойргийн хурал цуглаанууд

Бишоп тойргийн хурал цуглаануудад хяналт тавьдаг. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн, Бүсийн Дал эсвэл Ерөнхий эрх мэдэлтэн оролцоогүй бол тэрээр эдгээр хурлууд дээр тэргүүлнэ. Түүнийг эзгүйд зөвлөхүүд нь тойргийн хурал цуглаануудыг хөтлөн явуулж, тэргүүлж болно. Тэргүүлэх эрх мэдэлтнүүд, зочноор оролцож байгаа дээд зөвлөлийн гишүүдийг индэр дээр урьж суулгана. Дээд зөвлөлийн гишүүд тойргийн хурлуудад оролцохдоо тэргүүлэхгүй.

Хэрэв бишоп, түүний зөвлөхүүд бүгдээрээ эзгүй байгаа бол ариун ёслолын цуглаан дээр тэргүүлэх хүнийг гадасны ерөнхийлөгч томилно. Тэрээр ихэвчлэн дээд пристүүдийн бүлгийн удирдагчийг томилдог боловч тэргүүлэх эрх мэдлийг өөр санваартанд өгч болно.

### 18.2.1 Ням гарагийн цуглааны хуваарь

Ням гарагийн цуглаан нь ариун ёслолоос хүртэх, шүтэн бишрэх, сайн мэдээнээс суралцах, үүргүүдээ мэдэж авах, үйлчлэл үзүүлэх маш чухал цаг юм. Сонирхсон гишүүн бус хүмүүс эдгээр цуглаанд оролцож болно.

Тойргууд ням гарагийн дараах цуглаануудыг нийтэд нь гурван цагт багтаан явуулах ёстой (цуглааны цагийн хуваарийн хувилбарыг хуудас 167 дээрх "Ням гарагийн цуглааны хуваарь" жагсаалтаас үзнэ үү):

1. Ариун ёслолын цуглаан
2. Санваартны хурал (бүх санваартнууд, ахлагч болохуйц ах нар, Аароны санваарын насны томилогдоогүй залуу эрэгтэйчүүд, 18.2.4-ийг үзнэ үү)
3. Нийгмийн Халамжийн Бүлгийн цуглаан (18 болон түүнээс дээш насны бүх эмэгтэйчүүд мөн гэрлэсэн залуу эмэгтэйчүүд)
4. Залуу эмэгтэйчүүд (12-18 насны залуу эмэгтэйчүүд)
5. Хүүхдийн хэсэг (3-11 насны хүүхдүүд, хэрэв нялх хүүхэд харах газартай бөгөөд эцэг эхчүүд нь хүүхдүүдээ оролцуулахыг хүсвэл 18 сараас 2 настай хүүхдүүд)
6. Ням гарагийн хичээл (12-оос дээш насныхан; 12 настай залуу эрэгтэй ба залуу эмэгтэйчүүдийн Ням гарагийн ангид оролцох тухай мэдээллийг 11.4.3-аас үзнэ үү)

### 18.2.2 Ариун ёслолын цуглаан

#### Ариун ёслолын цуглааны зорилго

Ариун ёслолын цуглаан нь Сүмийн гишүүд ариун ёслолоос хүртсэнээр баптисмын гэрээнүүдээ шинэчилдэг сүнслэг цуглаан байх ёстой. Ариун ёслолын цуглааны өөр зорилго бол шүтэн бишрэх, сайн мэдээг заах, ёслолууд гүйцэтгэх, тойргийн ажил хэргийг явуулах, итгэл, гэрчлэлийг бэхжүүлэх явдал юм.

#### Ариун ёслолын цуглааныг төлөвлөж, хөтлөх нь

Бишопын зөвлөлийн гишүүд ариун ёслолын цуглааныг төлөвлөж, гүн хүндэтгэлтэйгээр хөтлөн явуулдаг. Мөн ариун ёслолын зохион байгуулалтад хяналт тавьж яриа өгөх сэдвүүд болон дууг сонгож, үг хэлэх, хөгжим тоглох хүмүүсийг сонгон заавар зөвлөгөө өгч мөн нээлт, хаалтын залбирал хийх гишүүдийг урина. Ариун ёслолын цуглааны өмнө залбирлын цуглаан хийх шаардлагагүй.

Ариун ёслолын цуглаан цагтаа эхэлж, цагтаа дуусдаг байхад бишопын зөвлөл анхаарна. Цуглаан төлөвлөсөн цагаасаа илүү сунжран үргэлжлэх ёсгүй. Цуглааны төлөвлөгөө дараах загвартай байна:

1. Оршил хөгжим (Удирдамжийг 14.4.3-аас үзнэ үү)
2. Мэндчилгээ
3. Ариун ёслолын цуглаанд оролцож байгаа тэргүүлэх эрх мэдэлтнүүд эсвэл дээд зөвлөлийн гишүүдийг танилцуулах
4. Зарлалууд (боломжтой бол ихэнх зарлалыг гишүүдэд тараадаг хөтөлбөрт хэвлэсэн байвал эдгээр нь ариун ёслолын цуглааны цагаас авахгүй байх болно. Бишопын зөвлөл чухал зарлалуудыг нээлтийн дуулалаас өмнө товчхон зарлах хэрэгтэй)
5. Нээлтийн дуулал ба залбирал
6. Тойргийн болон гадасны ажил хэрэг:
   - а Дуудлагад гишүүдийг дэмжүүлэх ба чөлөөлөх (19.3 болон 19.5-аас үзнэ үү)
   - б Баптисм хүртэж, гишүүнээр батлагдсан 8 настай хүүхдүүдийг танилцуулах (хуудас 152 дээрх "Шинэ гишүүдийг танилцуулах нь" хэсгийг үзнэ үү)
   - в Аароны санваар авах эсвэл санваарын алба дэвших ах нарын нэрсийг танилцуулах (*Гарын авлага 1-ийн* 16.7.2-ыг үзнэ үү.)
   - г Анги дэвшиж байгаа залуу эмэгтэйчүүдийг танилцуулах
   - д Тойргийн шинэ гишүүдийн нэрсийг танилцуулах (хуудас 152 дээрх "Шинэ гишүүдийг танилцуулах нь" хэсгийг үзнэ үү)
7. Хүүхдүүдэд нэр өгч адислах (ихэвчлэн мацгийн болон гэрчлэлийн цуглаан дээр), шинэ гишүүдийг гишүүнээр баталж, Ариун Сүнсний бэлэг өгөх
8. Ариун ёслолын дуулал ба ариун ёслолыг гүйцэтгэх нь
9. Сайн мэдээний захиасууд, цугларагсад дуулах мөн тусгай дуу хөгжим
10. Хаалтын дуулал ба залбирал
11. Төгсгөлийн хөгжим

Зарим үед тэргүүлэх албан тушаалтны залруулах шаардлагатай ямар нэг санаандгүй зүйл цуглааны үед тохиолдож болно. Энэ тохиолдолд тэр хэн нэгнийг эвгүй байдалд оруулахгүй байхад анхаарч, шаардлагатай залруулгыг хийх ёстой.

#### Ариун ёслолын цуглааны өмнөх цаг

Удирдагчид ариун ёслолын цуглаан эхлэхээс өмнө хүндэтгэлийн үлгэр жишээг үзүүлэх хэрэгтэй. Бишопын зөвлөл болон үг хэлэгчид ариун ёслолын цуглаан эхлэхээс наад тал нь таван минутын өмнө суудлаа эзэлсэн байх ёстой. Энэ бол яриа хөөрөө өрнүүлэх, үг захиас дамжуулах цаг биш. Хүндэтгэлийн үлгэр жишээг үзүүлэх нь шүтэн бишрэх үйл ажиллагаанд сүнслэг байдлын хувьд бэлтгэлтэй байхад цугларагсдад тусалдаг.

Ариун ёслолын цуглааны өмнөх үе бол ариун ёслолд сүнслэг байдлын хувьд бэлтгэхийн тулд залбиралтайгаар бясалган бодох цаг байх ёстойг гишүүдэд заах ёстой.

Гэр бүлүүд цагтаа ирж, хамт суухыг бишопын зөвлөл дэмждэг.

#### Ариун ёслолыг адисалж, түгээх нь

Ариун ёслолыг хүндэтгэлтэйгээр, зохих дүрэм журмын дагуу адисалж, түгээхэд бишопын зөвлөл анхаарна. Цуглаан эхлэхээс өмнө ариун ёслолын ширээг бэлтгэсэн байх ёстой. Ариун ёслолыг бэлтгэх, адислах, түгээх тухай зааврыг 20.4-өөс үзнэ үү.

#### Хэлэх үгийн сэдэв ба дуу хөгжмийг сонгох нь

Ариун ёслолын цуглаан дээр хэлэх үгийн сэдэв, дуу хөгжмийг бишопын зөвлөл сонгоно. Хэлэх үг, дуу хөгжим нь итгэл болон гэрчлэлтэй болоход гишүүдэд туслах сайн мэдээний сэдвүүд дээр төвлөрсөн байх ёстой.

### Гишүүдээс оролцогчдыг сонгож, заавар зөвлөгөө өгөх нь

*Оролцогчдыг сонгох нь.* Ариун ёслолыг зохион байгуулах гишүүдийг бишопын зөвлөл сонгодог. Тойргийн гишүүдэд оролцох боломжийг олгох ёстой. Хэрэв бишопын зөвлөл гаднаас үг хэлүүлэхээр гишүүдийг уривал 21.1.20 дахь удирдамжийг баримтлах хэрэгтэй.

Бишопын зөвлөлийн гишүүд 12–18 насны залуучуудыг ариун ёслолын цуглаан дээр үг хэлүүлэхээр тогтмол урьдаг. Залуучууд сайн мэдээний даалгасан сэдвээр (таван минут орчим) товч үг хэлэх ёстой. Эцэг эхчүүд нь туслахыг бишопын зөвлөл дэмжих боловч залуучууд хэлэх үгээ өөрсдөө бэлтгэх ёстой.

Бишопын зөвлөл номлогчдыг номлолд явахаас өмнө эсвэл буцаж ирэхэд нь ариун ёслолын цуглаан дээр үг хэлүүлэхээр урьдаг (*Гарын авлага 1,* 4.8.1 болон 4.10.3-ыг үзнэ үү). Гэхдээ энэ бол ердийн ариун ёслолын цуглаан болохоос биш номлогчийг үдэх буюу гэртээ ирснийг нь тэмдэглэх цуглаан биш гэдгийг бишопын зөвлөл тодорхой ойлгуулах хэрэгтэй. Эдгээр цуглааныг бишопын зөвлөл төлөвлөж, хөтлөн явуулна. Номлогчийн гэр бүлийн гишүүд, найз нарыг үг хэлүүлэхээр урих ёсгүй. Гэвч номлолд явж байгаа эсвэл буцаж ирсэн өөр номлогчдыг үг хэлэхийг урьж болно.

Бишопын зөвлөл гадасны ерөнхийлөгчийн томилсон дээд зөвлөлийн гишүүдийг үг хэлэхээр хуваарьт оруулж болно. Дээд зөвлөлийн гишүүдийн үг хэлэх хуваарийг гадасны ерөнхийлөгч тогтооно. Дээд зөвлөлийн гишүүд ариун ёслолын цуглаан дээр сар бүр үг хэлэх шаардлагагүй.

Жил бүр нэг ариун ёслолын хөтөлбөрт Хүүхдийн Хэсгийн хүүхдүүд оролцох хуваарийг бишопын зөвлөл гаргана (11.5.4-ийг үзнэ үү).

Зарим үед тухайн бүсэд үйлчилж байгаа бүрэн цагийн номлогчдыг үг хэлэхийг бишопын зөвлөл урьж болно.

Бишопын зөвлөл нь ариун ёслолын цуглааныг туслах бүлгүүд эсвэл бусад хөгжмийн хүмүүсийн мэдэлд өгч болохгүй. Гэвч бишопын зөвлөлийн удирдлага дор туслах бүлгүүд уригдаж болно.

Бишопын зөвлөлийн гишүүд ариун ёслолын цуглаан дээр үг хэлэх урилгыг цуглаанаас нэлээд өмнө өгөх ёстой.

*Оролцогчдод заавар, зөвлөгөө өгөх нь.* Бишопын зөвлөлийн гишүүд ариун ёслолын цуглаанд оролцох хүмүүст заавар, зөвлөгөө өгнө. Тэд ариун ёслолын цуглааны зорилгуудыг дүгнэж, бүх хэлэх үг, дуу хөгжим нь ариун ёслолын ариун нандин мөн чанарт нийцэж байх ёстойг тайлбарлана.

Гишүүдийг үг хэлүүлэхээр урих үед бишопын зөвлөлийн гишүүн сэдэв болон тухайн хүний үг хэлэх хугацааг тодорхой тайлбарлана. Сайн мэдээний сургаалыг заах, итгэлийн тухай ярих, тэнгэрлэгээр илчлэгдсэн үнэнүүдийг гэрчлэх, түүнчлэн судруудыг ашиглахыг тэрээр үг хэлэгчдэд зөвлөдөг (С ба Г 42:12 ба 52:9-ийг үзнэ үү). Үг хэлэгчид залбирч бэлтгэсний дараа хайрын сүнсээр заах ёстой. Тэд таамаглалын шинжтэй, зөрчилтэй эсвэл Сүмийн сургаалд үл нийцэх сэдвээр үг хэлэх ёсгүй.

Гадасны чуулга болон Ариун ёслолын цуглааны хүндэтгэл бишрэлтэй байдлыг хадгалахын тулд яриа өгөгч судраас эш татахдаа цуглаанд оролцогчдыг судраа нээн үзэхийг хүсэх ёсгүй.

Ариун ёслолын цуглаанд яриа өгөх зэргээр оролцсон гишүүд цуглаан дуустал байх ёстой.

### Дуу хөгжим

14.4.3 болон 14.4.4-ийг үзнэ үү.

### Шинэ гишүүдийг танилцуулах нь

Гишүүнчлэлийн бүртгэлийг тойрогт хүлээн авсан үед, түүнчлэн хөрвөгчид баптисм хүртэж, гишүүнээр батлагдсан үед бишопын зөвлөлийн гишүүн дараагийн ариун ёслолын цуглаан дээр шинэ гишүүдийг танилцуулж, тэдэнд баяр хүргэнэ. Тэрээр хүн бүрийн нэрийг дуудаж, босохыг урьж, шинэ гишүүдийг өөрийн тойрогт гишүүнээр хүлээн авч байгааг гараа өргөн харуулахыг гишүүдээс хүснэ. Гэр бүлийн гишүүдийн нэрсийг хамтад нь уншина. Хэрэв тухайн хүний талаар эсрэг саналтай хүн байвал тэрээр бишоптой хувиараа уулзах ёстой.

Сүмд бүртгэлтэй хүүхдүүд баптисм хүртэж, гишүүнээр батлагдсаны дараа бишопын зөвлөлийн гишүүн хүүхэд бүрийн баптисм, гишүүний баталгааг ариун ёслолын цуглаан дээр зарлана. Эдгээр хүүхдүүд бүртгэлтэй байсан учраас тэднийг тойрогт хүлээн авахаар танилцуулахгүй.

### Үзүүлэн, дуу, дүрс бичлэгийн материалууд

18.4 ба 21.1.5.-ыг үзнэ үү.

### Онцгой нөхцөл байдал дахь ариун ёслол

Ариун ёслолыг хүртсэнээр ирдэг сүнсний адислалууд гишүүн бүрд хэрэгтэй. Гишүүд гэрээс гарах боломжгүй, асрах газарт эсвэл эмнэлэгт байгаа бол эдгээр гишүүдэд зориулж ариун

ёслолыг бэлтгэж, адислан, түгээх санваартнуудыг бишоп томилж болно.

Зарим үед сүмийн байр хол учраас гишүүд ариун ёслолын цуглаанд оролцох боломжгүй байж болно. Онцгой нөхцөл байдлуудад ариун ёслолыг цуглааны байрнаас хол газар гүйцэтгэх эрх мэдлийг бишоп олгож болно. Тэрээр энэ зөвшөөрлийг зөвхөн өөрийнхөө тойргийн хэмжээнд өгч болно. Ариун ёслолыг хөтлөн явуулахаар бишопын зөвшөөрөл өгсөн хүн нь зөвхөн Мелкизедек санваартан эсвэл Аароны санваарын прист байх ёстой. Мөн ариун ёслолыг адисалж, түгээхээр зохистой байх ёстой. Ариун ёслолыг удирдсан санваартан дараа нь бишопт илтгэнэ.

Гишүүд хол яваа эсвэл харьяалагддаг тойргоосоо түр хугацаагаар хол оршин сууж байгаа бол тэд Сүмийн өөр тойрог эсвэл салбарын ариун ёслолын цуглаан болон ням гарагийн бусад цуглаануудад оролцохыг чин сэтгэлээсээ хичээх ёстой.

Ариун ёслолыг гэр бүлийнхний уулзалт болон бусад аялал зугаалгатай хамтатган явуулах ёсгүй.

### 18.2.3 Мацгийн болон гэрчлэлийн цуглаан

Ихэвчлэн сар бүрийн эхний ням гарагийн ариун ёслолын цуглаан нь мацгийн болон гэрчлэлийн цуглаан байдаг. Ерөнхий чуулган болон гадасны чуулган хийх тохиолдолд мацгийн болон гэрчлэлийн цуглааныг өөр ням гарагт шилжүүлж болно.

Бишопын удирдлага дор энэ цуглаан дээр ариун ёслолыг гүйцэтгэхээс өмнө хүүхдүүдэд нэр өгч, адислан мөн гишүүдийг баталж болно.

Ариун ёслолоос хүртсэний дараа хөтлөн явуулж байгаа бишопын зөвлөлийн гишүүн гэрчлэлээ товчхон хуваалцана. Дараа нь тэрээр чин сэтгэлийн гэрчлэлүүд болон итгэлийг нь хүчирхэгжүүлсэн туршлагаасаа хуваалцахыг гишүүдээс урьдаг. Бусдад гэрчлэлээ хуваалцах боломж олгохын тулд гэрчлэлээ товчхон хуваалцахыг бишопын зөвлөл гишүүдээс хүснэ.

Бага насны хүүхдүүд эцэг эх, ах эгч, бусад хүмүүсийн тусламжгүйгээр мацгийн болон гэрчлэлийн цуглаан дээр гэрчлэлээ хуваалцаж суртлаа гэр бүлийн үдэш зэрэг үйл ажиллагаан дээр эсвэл Хүүхдийн Хэсэгт үг хэлэх зэргээр гэрчлэлээ хуваалцаж сурах нь хамгийн сайн арга зам юм.

### 18.2.4 Санваартны хурал

Бүх санваартнууд чуулгаараа эсвэл бүлгээрээ тус тусдаа хуралдахаас өмнө нээлтийн ажиллагаанд хамт суудаг. Ахлагч болохуйц ах нар, Аароны санваартны насны санваарт томилогдоогүй залуу эрэгтэйчүүд бас оролцож болно. Бишопын зөвлөлийн гишүүн хөтлөн явуулна.

Нээлтийн үйл ажиллагаанд нээлтийн дуулал, нээлтийн залбирал орох ёстой. Бас санваарын ажил хэрэг, товч заавар, зарлал, ангийн шинэ гишүүд, зочдыг танилцуулах нь орж болно. Нээлтийн ажиллагааг урт сунжруу зарлал зарлах, мэдээлэл хийхэд ашиглах ёсгүй. Чуулгуудын хурал дээр ихэнх цагийг сайн мэдээний хичээлд зориулах ёстой.

Дээд пристүүдийн бүлгийн удирдагч, ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, пристүүдийн чуулгын туслахууд, багш нарын чуулгын ерөнхийлөгч, диконы чуулгын ерөнхийлөгч нарыг нээлтийн ажиллагаанд бишопын зөвлөлтэй хамт суухыг бишоп урьж болно.

Нээлтийн ажиллагааны дараа санваартнууд чуулга, бүлгийн ажил хэргийг явуулах, санваарын үүргээ суралцах, сайн мэдээг судлахын тулд тус тусдаа хуралд ордог. Бишопын зөвлөлийн гишүүд Аароны санваартны чуулгын хурлуудад оролцдог боловч зарим үед Залуу эмэгтэйчүүдийн ангиудад оролцдог. Зарим үед бишопын зөвлөл дээд пристүүдийн бүлэг, ахлагч нарын чуулга, Аароны санваартны чуулгууд эсвэл бүх санваартнуудад заавар өгөхийн тулд энэ цагаар тэднийг нэгтгэж болно.

Санваартны хурлын үеэр өөр хурал цуглааныг төлөвлөх ёсгүй.

Санваартны чуулга, бүлгийн хурлын тухай дэлгэрэнгүй мэдээллийг 7.8 болон 8.11-ээс үзнэ үү.

### 18.2.5 Тойргийн чуулган

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл тойрог бүрд тойргийн чуулганыг жилд нэг удаа төлөвлөн удирддаг. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, дээд зөвлөл, гадасны туслах бүлгүүд нь гадасны ерөнхийлөгчийн удирдлагын дагуу тойргийн чуулганы хуралдаанууддад оролцдог. Тойргийн чуулганы зорилго бол итгэл, гэрчлэлийг бэхжүүлж, сайн мэдээний хичээл заан, ажил хэргийг явуулж, үйл ажиллагаанд үнэлэлт өгөх явдал юм.

Тойргийн чуулганы гол хуралдаан ариун ёслолын цуглааны үед болдог. Хурлын хөтөлбөр нь бусад ариун ёслолын цуглаануудтай ерөнхийдөө адилхан байдаг. Гадасны ерөнхийлөгч тэргүүлэх бөгөөд гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ихэвчлэн цуглааныг төлөвлөдөг. Бишопын зөвлөлийн гишүүн ихэвчлэн хурлыг хөтөлнө. Ариун ёслолын өмнө гадасны ерөнхийлөгчийн эсвэл дээд зөвлөлийн гишүүн нь Ерөнхий эрх

18. Сүмийн хурал цуглаанууд

мэдэлтнүүд, гадас болон тойргийн албанд дэмжүүлэхдээ Албанд дэмжүүлэх маягтыг (тойргийн бичиг хэргийн ажилтны бэлтгэсэн) ашиглан тойргийн гишүүдэд нэрсийг дэмжүүлэхээр танилцуулна. Ариун ёслолыг түгээсний дараа ихэвчлэн бишоп, гадасны ерөнхийлөгч хоёр үг хэлдэг.

Тойрог нь санваартны болон туслах бүлгүүдийн цуглаануудыг ихэвчлэн тойргийн чуулганы нэг хэсэг болгон явуулдаг. Гадасны удирдагчид эдгээр цуглааны үеэр заавар өгч, туслалцаа үзүүлж болно.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл тойргийн чуулгантай холбогдуулан тойрог дахь хувь хүмүүс болон туслах бүлгүүдийн өсөлт дэвшлийн тухай бишопын зөвлөлтэй хуралдана. Энэ хурлыг тойргийн чуулган болсон ням гарагт эсвэл өөр үед хийж болно.

### 18.2.6 Бишопын зөвлөлийн хурал

Бишопын зөвлөл ихэвчлэн хамгийн цөөндөө долоо хоногт нэг удаа заавал хуралддаг. Тойргийн бичиг хэргийн ажилтан, гүйцэтгэх нарийн бичиг нар оролцож, бичиг хэргийн ажилтан нь үүрэг даалгавар, хурлаас гаргасан шийдвэрийн тэмдэглэл хөтөлнө. Шаардлагатай бол бишоп бусад хүмүүсийг урьж болно.

Энэ хурлын үеэр бишопын зөвлөлийн гишүүд тойргийн асуудлуудын тухай хамтран зөвлөлдөнө. Тэд хувь хүмүүс, гэр бүлүүдийг бэхжүүлэх арга замуудыг төлөвлөж, чуулга, туслах бүлгүүд, хөтөлбөр болон үйл ажиллагаануудад дүгнэлт өгдөг. Бас судар, Сүмийн удирдлага болон гарын авлагуудын зааврuudыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргадаг.

Энэ хурлын үеэр бишопын зөвлөлийн гишүүд тойрогт үйлчлэхээр дуудагдах гишүүдийг хэлэлцдэг. Тэд санваарын болон бусад ёслолуудыг хүлээн авах насанд хүрч байгаа гишүүд, мөн ахлагч, дээд пристээр болон номлогчоор дуудагдах гишүүдийн нэрсийг гадасны ерөнхийлөгчид санал болгохоор хэлэлцдэг.

Энэ хурлаар хэлэлцэх бусад асуудалд ажил үүргүүдийн тайлан, хурал цуглаанууд болон үйл ажиллагааны төлөвлөлт түүнчлэн тойргийн төсвийг хянан хэлэлцэх ажлууд орж болно.

### 18.2.7 Тойргийн санваартны гүйцэтгэх хорооны хурал

4.3-ыг үзнэ үү.

### 18.2.8 Тойргийн Зөвлөлийн хурал

4.6-г үзнэ үү.

### 18.2.9 Бишопын зөвлөлийн Залуучуудын хорооны хурал

Бишоп нь бишопын зөвлөлийн залуучуудын хороонд хяналт тавьдаг. Энэ хороо бишопын зөвлөл, пристүүдийн чуулгын нэг туслах, багш нарын болон диконы чуулгуудын ерөнхийлөгчид, Залуу Эмэгтэйчүүдийн ангийн дарга нар, Залуу Эрэгтэйчүүд ба Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчдөөс бүрддэг.

Бишопын зөвлөл шаардлагатай бол тус хорооны хуралд бусад хүмүүсийг урьж болно. Урьж болох эдгээр хүмүүст пристийн чуулгын нөгөө туслах нь, чуулга болон ангийн даргын зөвлөхүүд, Залуу Эрэгтэйчүүд ба Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд, нарийн бичиг нар орж болно.

Хороо ихэвчлэн сар бүр хуралддаг. Бишоп энэ хурлыг хөтлөн явуулж болно эсвэл зөвлөхүүдийнхээ нэгийг, пристүүдийн чуулгын туслахуудын нэгийг, Лаурел ангийн даргыг энэ хурлыг хөтлөн явуулахаар томилж болно. Бишоп хурал бүрийн өмнө хурлыг хөтлөн явуулах хүнтэй хурлын хөтөлбөрийг ярилцаж, батална. Хурлын хөтөлбөрт дараах зүйлс орж болно:

1. Тойрог дахь залуу хүн бүрийн хэрэгцээ, сонирхлыг тогтоох. Тэдний хэрэгцээг шийдвэрлэхэд туслах арга замуудыг төлөвлөх. Сүмийн жишгүүдээр амьдарч, эдгээр жишгийг эрхэмлэн дээдэлдэг байхад нь залуучуудад туслах арга замуудыг төлөвлөх.
2. Залуу хүн бүрийг Сүмийн хурал цуглаан, үйл ажиллагаануудад оролцоход нь урамшуулан дэмжих арга замуудыг төлөвлөх. Идэвх султай, саяхан баптисм хүртсэн болон Сүмийг сонирхож байгаа залуучуудтай нөхөрлөх ажлыг төлөвлөх болон тайлагнах.
3. Залуучуудын хэрэгцээнд тохирсон үйл ажиллагаануудыг төлөвлөж хэрэгжүүлэх. Эдгээр үйл ажиллагаанд Аароны санваартнууд–Залуу эмэгтэйчүүдийн үйл ажиллагаанууд болон тойргийн залуучуудын чуулган орно. Насанд хүрэгчдийн удирдагчид эдгээр үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ залуучуудыг аль болох оролцуулах ёстой.
4. Төлөвлөсөн зорилго амжилттай хэрэгжсэн эсэхийг мэдэхийн тулд өнгөрсөн үйл ажиллагаануудад үнэлэлт өгөх.

Хорооны хурлууд нь залуучуудад удирдаж сурах боломж олгон заавар зөвлөлгөө өгдөг байх ёстой.

### 18.2.10 Тойргийн ганц бие залуу насанд хүрэгчдийн хорооны хурал

16.3.4-ийг үзнэ үү.

### 18.2.11 Номлогчдийн хамтарсан хурал

5.1.5-ыг үзнэ үү.

## 18.3 Гадасны хурлууд

Гадасны ерөнхийлөгч гадасны хурал цуглаануудад хяналт тавьдаг. Бүсийн Дал болон Ерөнхий Эрх мэдэлтэн оролцоогүй бол тэрээр эдгээр хурлыг тэргүүлнэ. Түүнийг эзгүйд зөвлөхүүд нь гадасны хурал цуглаануудыг хөтлөн явуулж, тэргүүлж болно. Гадасны хурлууд тойргийн ням гарагийн хурлуудтай давхцах ёсгүй.

### 18.3.1 Гадасны чуулган

Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгчийн төлөвлөснөөр гадас бүр жилд гадасны хоёр чуулган хийдэг. Ихэнх оронд гадасны ерөнхийлөгч нь нэг чуулган дээрээ тэргүүлж, нөгөө чуулган дээр томилогдсон Ерөнхий Эрх мэдэлтэн эсвэл Бүсийн Дал тэргүүлдэг.

Гадасны зарим чуулган дээр хиймэл дагуулын шууд нэвтрүүлгээр ням гарагийн ерөнхий хуралдааныг явуулдаг. Энэ шууд нэвтрүүлэг Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн зааврыг агуулдаг. Хиймэл дагуулын нэвтрүүлэг ашиглаж байгаа ба уг чуулган нь гадасны чуулганыг орлож байгаа тохиолдолд Бүсийн Дал буюу Ерөнхий Эрх мэдэлтэн уг чуулган дээр тэргүүлнэ.

Тогтмол болдог гадасны чуулганы өмнө гадасны шинэ ерөнхийлөгчийг дуудах шаардлага гарвал гадасны тусгай чуулганыг хуралдуулж болно.

Гадасны чуулганы үндсэн зорилго бол итгэл, гэрчлэлийг бэхжүүлэх явдал юм. Бүх хэлэх үг, хөгжим нь энэ зорилгыг агуулж төлөвлөгдөх ёстой.

Өөр нэг зорилго бол гадасны ажил хэргийг явуулах явдал юм. Жил бүр гадасны чуулган дээр гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн нь ерөнхий эрх мэдэлтэн болон бүсийн, гадасны удирдагчдыг Officers Sustained form (Албанд дэмжүүлэх маягт)-г ашиглан танилцуулна. Мөн гадасны чөлөөлөгдсөн ажилтнуудын үйлчлэлд талархал илэрхийлэхийн тулд цугларгсдад тэдний нэрсийг танилцуулна. Хэрэв хиймэл дагуулын нэвтрүүлэг энэ чуулгантай давхцаагүй бол, жил бүр гадасны эхний чуулган дээр дэмжүүлнэ. Хэрэв хиймэл дагуулын нэвтрүүлэг давхацсан бол дэмжүүлэлт гадасны хоёр дахь чуулган дээр явагдана.

Хэрэв гадасны удирдлагууд гадасны чуулгануудын хооронд дуудагдсан эсвэл чөлөөлөгдсөн бол, тэднийг гадасны санваартны ерөнхий хурал дээр (Дуудлагуудын жагсаалт хүснэгтийн хуудас 159–160 дээрх дуудлагуудыг) дэмжүүлээгүй эсвэл хийсэн ажилд нь талархал илэрхийлээгүй бол мөн (19.3-т өгүүлсний дагуу) тойргийн ариун ёслолын цуглаан дээр дэмжүүлээгүй бол үүнийг гадасны дараагийн чуулган дээр хийж болно.

Ахлагч эсвэл дээд пристийн албанд томилуулахаар санал болгосон ах нарыг ихэвчлэн гадасны чуулган эсвэл гадасны санваартны ерөнхий хурал дээр дэмжүүлдэг. Заавар нь *Гарын авлага 1-ийн* 16.7.1-д байдаг.

Гадасны чуулган бүр ерөнхийдөө дараах хурлуудаас бүрддэг:

1. Бүсийн Далын буюу Ерөнхий Эрх мэдэлтэн (хэрэв томилогдсон бол), гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, гадасны бичиг хэргийн ажилтны болон гадасны гүйцэтгэх нарийн бичиг оролцсон хурал
2. Бүсийн Дал эсвэл Ерөнхий Эрх мэдэлтэн (хэрэв томилогдсон бол), 18.3.3-т жагсаасан ах нар оролцсон санваартны удирдлагын хурал. Энэ хурлыг тэргүүлэх эрх мэдэлтний шийдсэнээр бямба эсвэл ням гарагийн алинд нь ч явуулж болно.
3. 18 ба түүнээс дээш насны, гадасны бүх гишүүдийн бямба гарагийн оройн хуралдаан. Оролцож байгаа ариун сүмийн ерөнхийлөгчид, гадасны патриархууд, бүрэн цагийн номлолын ерөнхийлөгчид эсвэл тэдний төлөөлөгчид индэрт суух ёстой. Орон нутгийн нөхцөл байдлуудаас хамааран хэрэв тэргүүлэх эрх мэдэлтэн зөвшөөрсөн бол энэ цуглаан ням гарагт явагдаж болно.
4. Бүх гишүүд болон сонирхогч нарт зориулсан, ням гарагийн ерөнхий хуралдаан Оролцож байгаа ариун сүмийн ерөнхийлөгчид, гадасны патриархууд, бүрэн цагийн номлолын ерөнхийлөгчид эсвэл тэдний төлөөлөгчид индэрт суух ёстой. Хэрэв байр танхим нь нэг хуралдаанд бүх хүмүүсийг багтаах боломжгүй бол ням гарагийн хуралдааныг дахин явуулж болно. Хүүхдийн Хэсгийн хүүхдүүд эцэг эхтэйгээ хамт энэ хуралдаанд оролцоно.

Гадасны чуулганы бүх хуралдаан дээрх заавар нь тэргүүлэх эрх мэдэлтний удирдлага дор явагдана. Бүсийн Дал эсвэл Ерөнхий Эрх мэдэлтэн тэргүүлж байгаа тохиолдолд сэдвийг санал болгохыг тэрээр гадасны ерөнхийлөгчөөс хүснэ. Гадасны ерөнхийлөгч тэргүүлж байгаа

тохиолдолд тэрээр зөвлөхүүдийнхээ хамт заах сэдвийг сонгоно.

Шаардлагатай бол чуулганы хуралдаануудыг гадасны бусад нутаг руу нэвтрүүлгээр дамжуулж болно.

#### Гадасны чуулганыг төлөвлөж, явуулах нь

Тэргүүлэх албан тушаалтан чуулганы бүх төлөвлөлтийг удирдана. Чуулган болох өдрөөс өмнө тэрээр бүх оролцогсод болон дууны сонголтыг батална.

Гадасны ерөнхийлөгч ням гарагийн ерөнхий хуралдааныг хөтлөн явуулна. Түүний зөвлөхүүд чуулганы бусад хурлуудыг хөтлөн явуулж болно.

Гадасны ерөнхийлөгч чуулганы ням гарагийн ерөнхий хуралдаан дээр үг хэлнэ. Түүний зөвлөхүүд тэргүүлэх эрх мэдэлтний шийдсэнээр чуулганы бусад хуралдаанууд дээр үг хэлдэг.

Хангалттай сандал байрлуулж, угтан авагчид болон машины зогсоолуудыг төлөвлөнө. Эдгээр үйлчлэлийг хийхийн тулд гадасны удирдагч нар санваартны чуулгууд эсвэл бүлгүүд, түүний дотор ахлагч болохуйц ах нарыг томилж болно.

#### Гадасны чуулганы дуу хөгжим

14.6.1-ийг үзнэ үү.

### 18.3.2 Гадасны санваартнуудын ерөнхий хурал

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл жил бүр нэг удаа гадасны санваартны ерөнхий хурлыг хуралдуулдаг. Гадасны бүх Аароны болон Мелкизедек санваартнууд оролцоно.

Санваартнуудыг зааварлаж, тэдэнд сүнслэгээр нөлөөлөхийн тулд гадасны ерөнхийлөгчийн зөвлөл эдгээр хурлыг явуулна. Ерөнхийлөгчийн зөвлөл сэдвийг болон дээрх хурлууд дээр үг хэлэгчдийг залбирч, сонгон авна.

Эдгээр хурал дээр гадасны ерөнхийлөгчийн зөвлөл гадасны санваартны ажил хэргийг явуулдаг. Үүнд:

1. Ахлагчийн болон дээд пристийн албанд томилохоор нэр дэвшүүлсэн ах нарын нэрсийг танилцуулах, мөн дэмжүүлэх (*Гарын авлага 1-ийн* 16.7.1-ийг үзнэ үү).
2. Шинээр дуудагдсан гадасны удирдлагын нэрсийг танилцуулах болон дэмжүүлэх, мөн хэнийг дэмжүүлэх тухай удирдамжийг (19-р бүлэг дэх Дуудлагуудын жагсаалт-аас үзнэ үү).

### 18.3.3 Гадасны санваартны удирдлагын хурал

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл гадасны санваартны удирдлагын хурлыг гадасны чуулган бүртэй холбогдуулан хуралдуулна (18.3.1, зүйл 2-ыг үзнэ үү). Ерөнхийлөгчийн зөвлөл нь тухайн жилд гадасны санваартны удирдлагын өөр нэг хурлыг хийн, нийтдээ жилд гурван ийм хурлыг хуралдуулдаг. Эдгээр хурлын зорилго бол санваартны удирдагчдад үүргийг нь зааж, чадварыг нь дээшлүүлэн, итгэлийг нь хүчирхэгжүүлэх явдал юм.

Энэ хуралд оролцох ах нарт гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, дээд зөвлөл, гадасны бичиг хэргийн ажилтан (шаардлагатай бол түүний туслахууд), гадасны гүйцэтгэх нарийн бичиг, дээд пристүүдийн бүлгийн удирдагчид, туслахууд, нарийн бичиг нар, ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлүүд, нарийн бичиг нар, тойргийн номлолын удирдагчид, тойргуудын Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд (шаардлагатай бол нарийн бичиг нар, туслахууд, зөвлөхүүд) орно. Ажлын шаардлагаар оролцох бусад хүмүүсийг гадасны ерөнхийлөгч урьж болно.

Энэ хурал нь хамгийн үр өгөөжтэй заавар өгөхүйц уян хатан байх ёстой. Хурлын турш бүх ах нар хамтдаа байж болно. Эсвэл гадасны ажил хэргийг явуулж, ерөнхий заавар өгсний дараа хамтдаа зөвлөлдөн, үүрэг хариуцлагатайгаа холбоотой заавар авахын тулд гадасны ерөнхийлөгчийн зөвлөл тэднийг бүлгүүд болгон хувааж болно. Жишээлбэл:

Бишопын зөвлөлүүд болон Аароны санваартны бусад удирдагчид хамтран хуралдаж болно.

Дээд пристүүдийн бүлгийн болон ахлагч нарын чуулгын удирдагчид хамтран хуралдаж болно.

Номлолын ажилд томилогдсон дээд зөвлөлийн гишүүн эсвэл гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн тойргийн номлолын удирдагчидтай хамтран хуралдаж болно.

Гадасны гүйцэтгэх нарийн бичиг ихэвчлэн тойргуудын гүйцэтгэх нарийн бичиг нартай хамтран хуралддаг.

Гадасны бичиг хэргийн ажилтан нь тойргуудын бичиг хэргийн ажилтнуудтай хамт хуралддаг.

Эдгээр бүлгүүдэд гадасны ерөнхийлөгчийн зөвлөл заавар өгдөг бөгөөд өөрсдөдөө туслуулахын тулд дээд зөвлөлийн гишүүд, гадасны Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл, бусад хүмүүсийг урьдаг.

### 18.3.4 Гадасны дээд пристүүдийн чуулгын хурал

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл гадасны бүх дээд пристүүдийн чуулгын хурлыг жилд нэг удаа заавал хуралдуулна. Энэ хурлын үеэр гадасны ерөнхийлөгчийн зөвлөл чуулгын ажил хэргийг хөтлөн явуулж, чуулгын гишүүдэд үүргийг нь заадаг.

### 18.3.5 Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл тогтмол хуралддаг. Гадасны бичиг хэргийн ажилтан, гүйцэтгэх нарийн бичиг нар оролцож, бичиг хэргийн ажилтан үүрэг даалгавар, гаргасан шийдвэрийн тэмдэглэл хөтөлнө. Шаардлагатай бол бусад хүмүүсийг гадасны ерөнхийлөгч урьж оролцуулж болно.

Энэ хурлын үеэр гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд гадасны асуудлуудын талаар хамтран зөвлөлдөж, хувь хүмүүс болон гэр бүлүүдийг бэхжүүлэх арга замуудыг төлөвлөнө. Тойргууд, дээд пристүүдийн бүлгүүд, ахлагч нарын чуулгууд, туслах бүлгүүд, хөтөлбөрүүд болоод үйл ажиллагаануудад тэд үнэлэлт өгдөг. Тэд бас судар, Сүмийн удирдлага болон гарын авлагуудын зааврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргадаг.

Энэ хурлын үед гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд Сүмийн албанд дуудах гишүүдийг хэлэлцдэг. Тэд бас бишопуудын нэр дэвшүүлсэн номлолд үйлчлэх гишүүд болон ахлагч, дээд пристэд томилогдох ах нарын талаар хянан хэлэлцэнэ.

Энэ хурлаар хэлэлцэх бусад асуудлуудад ажил үүргүүдийн тайлан, хурал цуглаануудын төлөвлөлт, гадасны хуанлийг эргэн нягтлах, түүнчлэн гадасны төсвийг хянан хэлэлцэх асуудлууд орж болно.

### 18.3.6 Гадасны санваартны гүйцэтгэх хорооны хурал (Дээд зөвлөлийн хурал)

Гадасны ерөнхийлөгч гадасны санваартны гүйцэтгэх хороог тэргүүлдэг. Энэ хороо гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, дээд зөвлөл, гадасны бичиг хэргийн ажилтан, гадасны гүйцэтгэх нарийн бичгээс бүрдэнэ. Ажлын шаардлагаар оролцох бусад хүмүүсийг гадасны ерөнхийлөгч урьж болно.

Боломжтой бол энэ хороо сард хоёр удаа хуралдана. Хурлын хөтөлбөрт дараах зүйлс орж болно:

1. Сургаал болон санваартны үүргийн талаар гадасны ерөнхийлөгчийн зөвлөлөөс заавар авах.
2. Мелкизедек санваартнууд, Аароны санваартнууд болон тойргуудтай ажиллах үүргийнхээ талаар заавар авах.
3. Тойрог, ахлагч нарын чуулга, дээд пристүүдийн талаарх ажил үүргээ тайлагнах. Шаардлагатай бол гадасны туслах бүлгүүдийн талаар тайлагнах.
4. Ах нарыг ахлагчийн болон дээд пристийн албанд томилох болон дуудлагууд өгөх гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн шийдвэрийг дэмжихийг дээд зөвлөлийн гишүүдээс хүсэх.
5. Хувь хүмүүс болон гэр бүлүүдийг хэрхэн бэхжүүлэх, гадсан дахь асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх болон удирдлага, гэрийн багшлалт, гишүүдийн номлолын ажил, хөрвөгчдийг идэвхтэй байлгах болон идэвхжүүлэх, ариун сүмийн ба гэр бүлийн түүхийн ажил, халамж болон сайн мэдээ заах ажлыг хэрхэн сайжруулах тухай хамтран зөвлөлдөх.
6. Бусад ажил үүргүүдийн талаар тайлагнах.
7. Буцаж ирсэн номлогчдын тайланг сонсох.
8. Гадасны санваартны удирдлагын хурлуудыг төлөвлөх.

### 18.3.7 Гадасны Зөвлөлийн хурал

Гадасны ерөнхийлөгч гадасны зөвлөлийн хурлыг тэргүүлнэ. Энэ зөвлөл нь гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, дээд зөвлөл, гадасны бичиг хэргийн ажилтан, гүйцэтгэх нарийн бичиг, гадасны Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүд, Ням гарагийн ангийн ерөнхийлөгчдөөс бүрддэг. Шаардлагтай бол бусад хүмүүсийг гадасны ерөнхийлөгч урьж оролцуулж болно.

Гадасны зөвлөл шаардлагатай бол жилд хоёроос дөрвөн удаа хуралдана. Хурлын хөтөлбөрт дараах зүйлс орж болно:

1. Сургаал болон үүргийнхээ талаар гадасны ерөнхийлөгчийн зөвлөлөөс заавар авах.
2. Хувь хүмүүс болон гэр бүлүүдийг хэрхэн бэхжүүлэх, гадсан дахь асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх болон удирдлага, хөрвөгчдийг идэвхтэй байлгах болон идэвхжүүлэх, сайн мэдээг заах ажлыг хэрхэн сайжруулах тухай хамтран зөвлөлдөх.
3. Гадсан дахь номлолын ажил, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажлын талаар.

4. Халамжийн асуудлуудаар хамтран зөвлөлдөх. Бие даах чадвартай болоход нь гишүүдийг хэрхэн дэмжихийг төлөвлөх. Гадасны хэмжээн дэх халамжийн эх үүсвэрүүд шаардлагатай үед тойргуудад хүртээмжтэй болгох талаар анхаарах. Онцгой байдалд хариу арга хэмжээ авах гадасны бичгээр үйлдсэн, энгийн төлөвлөгөө боловсруулж, мөрдөх. Нэмэлт мэдээлэл Гарын авлага 1-ийн 5.1.1 дэх *"Гадасны зөвлөлийн халамжийн ажлыг тэргүүлэх нь"* хэсэгт байгаа.
5. Шаардлагатай бол гадасны туслах бүлгүүд, гадасны үйл ажиллагаанууд болон хөтөлбөрүүдийн талаар тайлагнах.
6. Гадасны хөтөлбөр болон үйл ажиллагаануудын төлөвлөлтийг зохицуулах.
7. Боловсролын Тасралтгүй Сангийн хөтөлбөр батлагдсан газарт уг сангийн байдлыг хэлэлцэх

### 18.3.8 Бишопын зөвлөлүүдтэй хийх хурал

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл бишопын зөвлөлүүдэд ажил үүргийнх нь талаар заавар өгч Сүмийн бодлогын тухай хэлэлцэж, хамтран зөвлөлдөхийн тулд бишопын зөвлөлүүдтэй хамтран хуралдана. Эдгээр хурлыг шаардлагатай бол жилд нэгээс дөрвөн удаа хийнэ.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, бүх бишопын зөвлөл, гадасны бичиг хэргийн ажилтан, гадасны гүйцэтгэх нарийн бичиг энэ хуралд оролцдог. Хэрэв хүсвэл хурлыг гадасны ерөнхийлөгч зөвхөн бишопуудтай хийж болно.

### 18.3.9 Гадасны Аароны санваартнууд–Залуу Эмэгтэйчүүдийн хорооны хурал

Гадасны ерөнхийлөгч нэг зөвлөхөө гадасны Аароны санваартнууд–Залуу Эмэгтэйчүүдийн хороог тэргүүлүүлэхээр томилно. Хорооны бусад гишүүд нь гадасны Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүдийн бүлгүүдэд томилогдсон дээд зөвлөлийн гишүүд, гадасны Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл ба нарийн бичиг, гадасны Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл ба нарийн бичиг байдаг. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл шаардлагатай бол хорооны хуралд залуучуудыг урьж болно. Гадасны үйл ажиллагааны хорооны тэргүүлэгчээр үйлчилдэг дээд зөвлөлийн гишүүн болон бусад хүмүүсийг бас урьж болно.

Энэ хороо шаардлагатай бол залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдийн хамтарсан үйл ажиллагааг гадаснаас зохион байгуулж төлөвлөхийн тулд хуралдана. Залуучуудын чуулган, бүжиг, онцгой цуглаан, гадас дундын үйл ажиллагаануудыг төлөвлөх болон хэрэгжүүлэхэд залуучуудыг аль болохоор өргөн оролцуулах ёстой. Түүнчлэн гадасны залуучуудад тохиолдож байгаа сорилт бэрхшээлийн тухай хэлэлцүүлгүүдэд залуучуудыг оролцуулж болно.

Гадасны үйл ажиллагаа нь тойргийн үйл ажиллагаатай өрсөлдөх биш уялдаж байх ёстой. Эдгээр үйл ажиллагааг гадасны зөвлөлийн хурлуудаар зохицуулна. Үйл ажиллагаануудын тухай тойргийн удирдагчдад нэлээд өмнөөс урьдчилан мэдэгдэх хэрэгтэй.

### 18.3.10 Гадасны бишопуудын халамжийн зөвлөлийн хурал

Гадасны бишопуудын халамжийн зөвлөлийн тухай мэдээлэл *Гарын авлага 1-ийн* 5.3-т байдаг.

### 18.3.11 Гадасны туслах бүлгүүдийн удирдлагын хурал

Гадасны Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн Хэсэг, Ням гарагийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд жил бүр тус бүрдээ гадасны туслах бүлгийн удирдлагын хурлыг төлөвлөн, явуулна. Хэрэв орон нутгийн нөхцөл байдал, ирж очих хугацаа нь удирдагчдад ачаалал өгөхөөргүй байвал гадасны ерөнхийлөгчийн зөвлөл жил бүр хоёр хурал хийх зөвшөөрөл өгч болно. Хэрэв бүх хурлыг нэг дор, нэг газар нийлүүлж хийхээр гадасны ерөнхийлөгчийн зөвлөл шийдээгүй бол бүлэг бүр өөрийнхөө хурлыг төлөвлөн хийж болно.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн оролцоогүй бол тухайн бүлэгт томилогдсон дээд зөвлөлийн гишүүн хурлыг тэргүүлнэ. Тойргийн бүх туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд, нарийн бичиг нарыг урьж оролцуулна. Тойргийн туслах бүлгүүдийн бусад удирдагчид, багш нар, туслах бүлэгт томилогдсон бишопын зөвлөлийн гишүүдийг шаардлагатай бол урьж болно.

Эдгээр хурлын зорилго бол туслах бүлгүүдийн удирдагчдад үүргийг нь зааж, заах, удирдах ур чадварыг эзэмшүүлэн, итгэлийг нь бэхжүүлэх явдал юм. Үйл ажиллагаануудыг зохицуулах, ажлаа тайлагнах, санал бодлоо хуваалцахад эдгээр хурлыг ашиглаж болно.

Эдгээр хурлын бүтэц хамгийн үр өгөөжтэй заавар өгөхүйц уян хатан байх ёстой. Туслах бүлгийн удирдагчид заавар өгөх туршлага хуваалцахын тулд бүгдээрээ хамтран хуралдаж болно. Эсвэл тэд бүлгийнхээ чиг үүргийн хүрээн дэх асуудлуудыг цөөн хүнтэй бүлгүүд болон хэлэлцэж болно. Бүх туслах бүлгүүд нэг үед

цугласан бол тэд ерөнхий зааврыг хамтдаа сонсоод дараа нь бүлгүүд болон хуваагдаж, тус тусынхаа бүлгийн удирдагчдаас заавар авч болно.

Гадасны Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл гадасны туслах бүлгийн удирдлагын хурлыг тогтмол хийдэггүй. Үүний оронд гадасны болон тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл гадасны санваартны удирдлагын хуралд суудаг (18.3.3-ыг үзнэ үү).

#### 18.3.12 Гадасны ганц бие залуу насанд хүрэгчдийн хорооны хурал

16.3.2-ыг үзнэ үү.

#### 18.3.13 Гадасны ганц бие насанд хүрэгчдийн хорооны хурал

16.1.2-ыг үзнэ үү.

## 18.4 Сүмийн цуглаанууд дээр үзүүлэн, дуу, дүрс бичлэгийн материалуудыг ашиглах тухай

Гишүүд үзүүлэнгүүдийг ариун ёслолын цуглаан, гадасны чуулган дээр хэрэглэж болохгүй. Судар болон үзүүлэнг хичээл дээр мөн удирдагчидтай хийх уулзалтад ашиглах нь илүү үр дүнтэй байдаг.

Сүмийн цуглаанууд дээр дуу, дүрс бичлэгийн материалуудыг ашиглах тухай удирдамжийг 21.1.5-аас үзнэ үү.

## 18.5 Сүмийн цуглаанууд дээрх залбирал

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд аль аль нь Сүмийн цуглаанууд дээр нээлт, хаалтын залбирал хэлж болно.

Залбиралыг товч, энгийн, Сүнсний удирдамжаар хийдэг байх ёстой. Залбирлын төгсгөлд бүх гишүүд *амен* гэж дуулдахаар хариулах ёстой.

Гишүүд өөрсдийн төрөлх хэлэндээ тохирох залбирлын үг хэллэгийг ашиглан Тэнгэрлэг Эцэгт хүндэтгэл илэрхийлэх ёстой. Залбирлын үг хэллэг хэл болгонд өөр хэлбэртэй байдаг. Зарим хэлэнд зөвхөн гэр бүл, ойр дотнын найз нартаа хандахад хэрэглэгддэг элэгсэг дотно үгс байдаг. Зарим хэлэнд өндөр дээд хүндэтгэлийг илэрхийлдэг үгс байдаг. Гэхдээ үндсэн зарчим нь адил бөгөөд хайр, хүндэтгэл, ойр дотно харилцааг илэрхийлсэн үг хэллэгүүдээр гишүүд залбирах ёстой. Жишээ нь, англи хэлэнд, гишүүд Тэнгэрлэг Эцэгт хандахдаа *Thee (Танд), Thy, Thine (Таны), Thou (Та)* гэдэг төлөөний нэрүүдийг хэрэглэдэг.

Эхнэр нөхөр хоёроор нэг цуглаан дээр залбирал хийлгэхээс бишопын зөвлөл зайлсхийх ёстой. Ингэх нь ганц бие хүмүүсийг гадуурхаж байгаа мэт сэтгэгдлийг төрүүлж мэднэ. Индэр дээр нэг их гардаггүй гишүүдийг залбирал хийлгэхээр урих хэрэгтэй. Шаардлагатай бол залбирч байгаа хүмүүст сургаал ярих, урт нуршуу залбирал хэлэхгүй байхыг бишопын зөвлөлийн гишүүн анхааруулж болно.

Залбирлын өмнө судрын хэсгээс чангаар уншихыг залбирал хэлж байгаа хүнээс хүсэх ёсгүй.

## 18.6 Оршуулга ба нас баралтын үе дэх бусад ёслолууд

Хүн нас барсантай холбоотой ёслолуудад оролцогч бүх хүмүүс гүн хүндэтгэл, нам гүм сүнслэг байдлыг харуулах талаар Сүмийн удирдагч болон гишүүд анхаарах хэрэгтэй. Ийм ёслолуудыг ихэвчлэн бишопын удирдлага дор гүйцэтгэдэг.

Нас барсан хүмүүст зориулсан ёслолууд нь шашин шүтлэг, соёл, ёс заншил, хуулийн шаардлагын дагуу дэлхий даяар асар их ялгаатай байдаг. Мөн Сүмийн гишүүд нас барсан тохиолдолд оршуулга болон ёслолууд нь дэлхийн янз бүрийн оронд өөр өөр байдаг. Энэ хэсэгт ёс заншил, уламжлалаас үл хамааран нас барсан сүмийн гишүүдийг оршуулах болон бусад ёслолуудад баримтлах ерөнхий зарчмуудын тухай өгүүлсэн болно. Энд бас нас баралт, гашуудалтай холбоотой орон нутгийн ямар ёс заншил нь оролцоход тохиромжтой, ямар нь тохиромжгүй болохыг тодорхойлсон удирдамж байдаг.

#### 18.6.1 Нас баралт ба гашуудал

Нас баралт бол Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөний чухал хэсэг юм (2 Нифай 9:6-г үзнэ үү). Хүн бүр амилуулагдсан төгс бие махбод хүлээн авахын тулд үхлийг туулах нь зайлшгүй юм. Авралын төлөвлөгөөний тухай, ялангуяа Аврагчийн Цагаатгал, Дахин Амилалтын тухай зааж, гэрчлэх нь Сүмийн гишүүний нас баралттай холбоотой ёслолуудын нэн чухал зорилго юм.

Хүн нас барсан үед ойр дотныхонд нь тайтгаруулалт хэрэгтэй болдог. Есүс Христийн шавь нар болох Сүмийн удирдагчид, гишүүд "гашуудах тэдний хамт гашуудаж. . . мөн тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулдаг" (Мозая 18:9) билээ.

Олон оронд буяны үйлчилгээ, талийгаачтай салах ёс гүйцэтгэх болон нутаглуулах ёслолууд

нь талийгаачид гүн хүндэтгэл үзүүлж мөн ойр дотны хүмүүсийг нь тайтгарахад тусалдаг юм. Харин тухайн орны ёс заншилд нь нийцэж байвал илүү энгийнээр буюу гэр бүлээрээ цугларч, оршуулгын газар дээрх ёслолыг хийж талийгаачид гүн хүндэтгэл үзүүлж, ойр дотныхонд нь тайтгарахад нь тусалж болно.

Олон оронд нас баралт болон нас барсан хүний төлөө гашуудахтай холбоотой шашин шүтлэг, ёс заншлын олон ёслол, зан үйл байдаг. Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээнд ийм зан үйл ёслолууд байдаггүй. Сүмийн удирдагчид бусад шашин болон бүлгүүдийн зан үйл, ёслолуудыг нас барсан гишүүдийн оршуулгын ёслолд зориулан Сүмд авч хэрэглэж болохгүй.

Сүмийн гишүүд бусад шашны зан үйл, ёслолуудад хүндэтгэлтэй хандах ёстой. Гэхдээ зарлигуудыг сахих болон сэргээгдсэн сайн мэдээний зарчмуудаар амьдрахад нь сөргөөр нөлөөлөх зан үйл, дадал зуршил, ёс заншилд нэгдэхгүй байхыг гишүүдэд зөвлөх ёстой.

Нас барсан хүмүүсийн оршуулах ёслол болон гашуудлын тухайд хэт өндөр зардалтай, сунжран үргэлжилсэн, амьд байгаа хүмүүст болон амьдрал ахуйд нь ачаа дарамт болдог зан үйл, ёс заншлаас зайлсхийхийг гишүүдэд зөвлөдөг билээ. Ийм зан үйлд хол зам туулж аялах, гашуудлын тусгай хувцас өмсөх, гоёж чимсэн мэдээ нийтлүүлэх, гэр бүлд нь мөнгө өгөх, оршуулгын үеэр сунжран үргэлжилсэн будаалга хийх, нас барсан хүний ойг оршуулгаас хойш тэмдэглэх нүсэр арга хэмжээ зохион байгуулах нь ордог.

Ихэнх улс орны төр засаг хүн нас барсан үед юу хийх ёстойг зохицуулдаг хуультай байдаг. Сүмийн удирдагчид болон гишүүд эдгээр хуулийг мэдэж, дагадаг байх ёстой.

### 18.6.2 Төлөвлөлт ба тусламж үзүүлэх нь

Сүмийн гишүүн нас барахад бишоп уг гэр бүлд очиж, тэднийг тайтгаруулан, тойргоос тусламж хэрэгтэй эсэхийг асууна. Тэрээр өөртэйгөө хамт явахыг зөвлөхүүдээсээ хүсч болно. Төрөл төрөгсөд, найз нөхөд, танилуудад нь нас баралтын тухай мэдэгдэх талаар туслалцаа хэрэгтэй эсэхийг бишоп асууна. Тэр оршуулгын ёслолыг төлөвлөх, тохирох эмгэнэлийн үг бэлтгэх, нас баралтын тухай сонинуудад мэдэгдэхэд туслахыг санал болгодог. Оршуулгын ёслолоос өмнө талийгаачтай салах ёс гүйцэтгэх бол эмгэнэл илэрхийлсэн нийтлэлд ёслолын эхлэх, дуусах цагуудыг тодорхой дурдсан байх ёстой.

Түүнээс гадна тэрээр цогцос хадгалах болон оршуулгын газартай холбоотой зохион байгуулах ажлуудыг орон нутгийн хууль, ёс заншлуудын дагуу хийхэд туслалцаа хэрэгтэй эсэхийг асууна. Шаардлагатай бол уг гэр бүлд зориулж тээврийн хэрэгслээр туслахыг санал болгож болно.

Бишоп тухайн гэр бүлийг хариуцдаг Мелкизедек санваартны удирдагч болон бусад ах нарт (түүний дотор гэрийн багш нарт) хагацал үзсэн гэр бүлд туслах талаар мэдэгдэнэ. Оршуулахад зориулж эрэгтэй хүний цогцсыг хувцаслах, оршуулгын үед гэр орныг нь харж хамгаалах, бусад дэмжлэг үзүүлэхийг уг ах нараас хүсч болно (7.10.2-ыг үз).

Бишоп Нийгмийн халамжийн бүлгийн ерөнхийлөгч болон бусад эгч нарт (түүний дотор айлчлагч багш нарт) уг гэр бүлд туслах талаар мэдэгдэнэ. Эмэгтэй хүнийг оршуулахад зориулж хувцаслах, оршуулгын ёслолд зориулсан цэцгүүдийг арчилж тордох, бага насны хүүхдүүдийг асрах, оршуулгын үед гэр орныг нь харж хамгаалах, хоол хийхийг уг эгч нараас хүсч болно (9.10.3-ыг үзнэ үү).

### 18.6.3 Салах ёс гүйцэтгэх нь (Ийм заншилтай газарт)

Хэрэв оршуулгын өмнө талийгаачтай салах ёс гүйцэтгэдэг бол бишоп салах ёс гүйцэтгэхийг оршуулга эхлэхээс 20 минутын өмнө эхлүүлэх хэрэгтэй. Салах ёслол гүйцэтгэсний дараа хэрэв тухайн гэр бүл хүсэх юм бол гэр бүлийн залбирал хэлж болно. Энэ залбирал сүмийн байранд цугларагсдын цагаас авахгүйн тулд оршуулга эхлэхээр товлосон цагаас өмнө дууссан байх ёстой. Оршуулах ёслолд зориулж авсыг сүмийн байранд авчрахын өмнө тагласан байх ёстой.

Удирдагчид сүмийн байрыг салах ёс гүйцэтгэх болон оршуулах ёслолд зориулж төлөвлөсөн цагаас нэг цагийн өмнө оршуулгын ажилчдад нээж өгөх хэрэгтэй.

### 18.6.4 Оршуулгын ёслол

Хэрэв нас барсан гишүүний оршуулга Сүмийн байранд болж байгаа бол бишоп хөтлөн явуулна. Харин оршуулга гэрт, цогцос хадгалах газарт эсвэл булшны дэргэд явагдаж байгаа бол оршуулгыг хөтлөн явуулахыг уг гэр бүл бишопоос хүсч болно. Бишоп оролцох боломжгүй бол бишопын зөвлөх хөтлөн явуулж болно.

Сүмийн байранд эсвэл өөр газарт байсан ч бишопын хөтлөн явуулж байгаа оршуулга бол Сүмийн цуглаан ба шашны ёслол юм. Энэ бол гэр бүлийн цугларалтаас гадна сүнслэг үйл явдал байх ёстой. Оршуулах ёслол болон оршуулгатай холбоотой цугларалтуудын үед

хүндэтгэлтэй байхыг бишоп гишүүдээс хичээнгүйлэн хүсэх ёстой.

Бишоп оршуулгыг хөтлөн явуулж байгаа үед өөрөө эсвэл зөвлөхүүдийнх нь нэг хяналт тавина. Тэрээр гэр бүлийн хүслийг харгалзах боловч оршуулга нь энгийн, хүндэтгэлтэй, дуу хөгжим, сайн мэдээн дээр тулгуурласан сургаалын товч үг, түүний дотор Аврагчийн Цагаатгал, Дахин Амилалтаас үүдэлтэй тайтгарлын үгсээс бүтсэн байх ёстойг анхаарна. Гэр бүлийнх нь гишүүд үг хэлэх буюу өөр аль нэг хэлбэрээр оршуулах ёслолд оролцох ёстой гэж бодох ёсгүй.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн, Бүсийн Дал эсвэл Ерөнхий Эрх мэдэлтэн өөрийн оролцсон оршуулгын ёслол дээр тэргүүлнэ. Оршуулгын ёслолыг хөтлөх хүн түүнтэй урьдчилан зөвлөлдөж, ёслолыг тэрээр тэргүүлнэ гэдгийг мэдээлнэ. Хэрэв тэргүүлэх албан тушаалтан хүсвэл хаалтын үг хэлж болно.

Видео бичлэг, компьютерийн болон бусад танилцуулгыг оршуулах ёслолын хэсэг болгон ашиглаж болохгүй. Оршуулах ёслолын бичлэгийг интернетэд тавих буюу аливаа бусад хэлбэрээр нэвтрүүлэг хийж болохгүй.

Оршуулга яг цагтаа эхлэх ёстой. Оролцогч хүмүүсийг чилээхгүйн тулд оршуулах ёслол хэтэрхий урт сунжруу байж болохгүй. Оршуулах ёслолыг 1-1 цаг 30 минутын хугацаанд хийвэл тохиромжтой.

Оршуулах ёслол бол сайн мэдээг заах, авралын төлөвлөгөөг гэрчлэх чухал боломж юм. Энэ бол нас барагсдад хүндэтгэл илэрхийлэх нэг боломж юм. Гэвч ийм хүндэтгэл оршуулах ёслолыг давамгайлах ёсгүй. Олон хүнээр хүндэтгэлийн болон дурсамж үг хэлүүлэх нь оршуулгыг хэтэрхий сунжирсан, Сүмийн ёслолын хувьд тохиромжгүй болгож болно. Хэрэв гэр бүлийн гишүүд нь дурсамж үг хэлэх хугацааг сунгахыг хүсвэл гэр бүлийн тусгай цугларалт хийх ба үүнийг оршуулах ёслолоос тусад нь хийж болно.

Оршуулах ёслолыг ням гарагт хийдэггүй.

### 18.6.5 Дуу хөгжим

Оршуулгын хөгжимд оршил хөгжим, нээлтийн дуулал, тусгайлан сонгосон дуу хөгжим, хаалтын дуулал, төгсгөлийн хөгжим орж болно. Энгийн сүмийн дуунууд, сайн мэдээний захиас бүхий бусад дуунууд оршуулах ёслолд хамгийн тохиромжтой байдаг. Нээлт, хаалтын дууллуудыг ихэвчлэн цугларагсад дуулдаг.

### 18.6.6 Оршуулга ба цогцос чандарлах тухай

Боломжтой бол ариун сүмд хишиг хүртсэн, нас барсан гишүүдийг ариун сүмийн хувцсаар хувцаслаж оршуулах хэрэгтэй. Ёс уламжлал эсвэл оршуулгын хэвшин тогтсон заншлаас болоод тохиромжгүй эсвэл хүндрэлтэй нөхцөлд хувцсыг эвхэж, авсан дотор цогцосны хажууд тавьж болно. Ариун сүмийн оршуулгын хувцас болон нас барсан хүмүүсийг ариун сүмийн хувцсаар хувцаслах тухай нэмэлт заавруud 7.10.2, 9.10.3 болон *Гарын авлага 1-ийн* 3.4.9-д байдаг.

Боломжтой бол бишопын зөвлөлийн нэг гишүүн оршуулгын газар уруу хөдлөх цуваag дагалдан явж болно. Хэрэв булшийг онцгойлон адислахаар бол тэрээр уг гэр бүлтэй зөвлөлдөж, 20.9 дэх зааврын дагуу нэг Мелкизедек санваартнаас цуваag дагалдан явахыг хүсч болно. Хэрэв тухайн гэр бүл хүсвэл онцгойлон адислах залбирлын оронд булшны дэргэдэх залбирал хийж болно.

Сүм цогцос чандарлахыг ер нь дэмждэггүй. Гэвч ариун сүмд хишиг хүртсэн гишүүний цогцсыг чандарлах бол цогцсыг ариун сүмийн хувцсаар хувцаслах ёстой. Чандарыг хадгалах газрыг онцгойлон адислах тухай мэдээллийг 20.9-өөс үзнэ үү.

### 18.6.7 Санхүүгийн бодлого

Тухайн ёслол нь гишүүн болон гишүүн бус хүний алиных нь ч төлөө хийгдэж байсан оршуулгын ёслолыг хөтлөн явуулж байгаа болон оролцож байгаа Сүмийн гишүүд төлбөр буюу хандив авах ёсгүй.

Зарим тохиолдолд оршуулгын зардлыг Сүмийн мацгийн өргөлийн сангаас төлж байгаа үед бишопууд оршуулгын товчооныхонтой хамтран тохиромжтой үйлчлэл болон үнийг тогтоож болно.

### 18.6.8 Гишүүн бус хүмүүст зориулсан оршуулгын ёслол

Бишопууд Сүмийн байруудыг гишүүн бус хүмүүсийн оршуулгын ёслолд зориулан ашиглахыг санал болгож болно. Уг ёслолуудыг ерөнхийдөө нас барсан хүний сүмийнх нь хэвшин тогтсон арга маягаар явуулж болно. Гэхдээ өөр Сүмийн болон сүмийн бус байгууллагуудын шашны ёслолыг сүмийн байранд гүйцэтгэж болохгүй. Хэрэв гэр бүл нь хүсвэл ёслолыг тухайн хүний харьяалагддаг сүмийн шашны албан тушаалтан хүндэтгэлтэйгээр, зохих ёс журмыг баримтлан хөтлөн явуулж болно.

## Тойргийн хурал цуглаануудын жагсаалт

| Хурал цуглаан | Зорилго | Оролцогчид | Давтамж |
|---|---|---|---|
| Ариун ёслолын цуглаан | Ариун ёслолоос хүртэж, шүтэн биширэх, сайн мэдээний хичээл зааж, ёслолуудыг гүйцэтгэх, тойргийн ажил хэргийг явуулж, итгэл, гэрчлэлийг хүчирхэгжүүлэх. | Тойргийн бүх гишүүд | Ням гараг бүр |
| Мацаг ба гэрчлэлийн цуглаан | Ариун ёслолоос хүртэж, шүтэн биширэх, ёслолуудыг гүйцэтгэх, тойргийн ажил хэргийг явуулж, гэрчлэлээ хэлэх. | Тойргийн бүх гишүүд | Ихэвчлэн сар бүрийн эхний ням гараг |
| Санваартны хурал | Чуулгын ажил хэргийг явуулах, санваартны үүрэгтээ суралцах, хувь хүмүүс, гэр бүлүүдийг бэхжүүлж, сайн мэдээг заах. | Бүх санваартнууд, ахлагч болохуйц ах нар, тойрог дахь Аароны санваарын насны томилогдоогүй залуу эрэгтэйчүүд | Ням гараг бүр |
| Нийгмийн Халамжийн Бүлгийн ням гарагийн цуглаан | Сайн мэдээг заах, итгэл, зөв шударга байдлаа өсгөн нэмэгдүүлэх, хувь хүмүүс гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэх. | Тойрог дахь 18 болон түүнээс дээш насны эмэгтэйчүүд (мөн гэрлэсэн 18-с доош насны эмэгтэйчүүд) | Ням гараг бүр |
| Нийгмийн Халамжийн Бүлгийн бусад хурал цуглаан, үйл ажиллагаанууд | Итгэл, зөв шударга байдлаа өсгөн нэмэгдүүлэхэд нь Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нарт туслах зарчмууд болон ур чадварт суралцаж, амьдралдаа хэрэгжүүлэх, хувь хүмүүс, гэр бүлүүдийг бэхжүүлэх, тусламж хэрэгтэй хүмүүсийг олж, тэдэнд туслах. | Тойрог дахь 18 болон түүнээс дээш насны эмэгтэйчүүд (мөн гэрлэсэн 18-с доош насны эмэгтэйчүүд) | Ихэвчлэн сард нэг удаа ням болон, даваа гарагийн оройгоос бусад үед мөн улирал тутам төлөвлөж болно. |
| Залуу Эмэгтэйчүүд | Сайн мэдээний зарчмуудыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, сургаалыг заах. | 12-18 настай залуу эмэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчид | Ням гараг бүр |
| Хүүхдийн Хэсэг | Сайн мэдээг зааж, өөрсдийг нь хайрладаг Тэнгэрлэг Эцэгийн хайрыг мэдрэхэд нь хүүхдүүдэд туслах. | 18 сартайгаас 11 насны хүүхдүүд, Хүүхдийн Хэсгийн удирдагчид, багш нар | Ням гараг бүр |
| Ням гарагийн хичээл | Итгэлийг хүчирхэгжүүлж, бие биедээ заахад нь Сүмийн гишүүдэд туслах. | 12 болон түүнээс дээш настай тойргийн гишүүд, Ням гарагийн ангийн удирдагчид, багш нар | Ням гараг бүр |
| Тойргийн чуулган | Итгэл, гэрчлэлийг хүчирхэгжүүлэх, сайн мэдээг заах, ажил хэргийг явуулах, үйл ажиллагаанд үнэлэлт өгөх. | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, гадасны туслах бүлгүүдийн удирдагчид, томилогдсон дээд зөвлөлийн гишүүд, бишопын зөвлөл болон тойргийн гишүүд | Жилд нэг удаа |
| Бишопын зөвлөлийн хурал | Тойргийн холбогдох бүх асуудлыг төлөвлөх, дүгнэн хэлэлцэх | Бишопын зөвлөл, тойргийн бичиг хэргийн ажилтан, тойргийн гүйцэтгэх нарийн бичиг, уригдсан бусад хүмүүс | Ихэвчлэн долоо хоног тутам |

### Тойргийн хурал цуглаануудын жагсаалт (үргэлжлэл)

| Хурал цуглаан | Зорилго | Оролцогчид | Давтамж |
|---|---|---|---|
| Тойргийн санваартны гүйцэтгэх хорооны хурал | Санваарын асуудлуудыг авч үзэх. Шаардлагатай бол тойргийн зөвлөлийн хурлын хөтөлбөрт тусгагдсан асуудлуудтай урьдчилан танилцах, тусламжийн асуудлуудыг хэлэлцэх, гэрийн болон айлчлагч багшийн ажил үүргийг зохицуулах. | Тусламжийн асуудлуудыг хэлэлцэх, гэрийн болон айлчлагч багшийн ажил үүргийг зохицуулахын тулд шаардлагатай бол бишопын зөвлөл, тойргийн бичиг хэргийн ажилтан, тойргийн гүйцэтгэх нарийн бичиг, дээд пристүүдийн бүлгийн удирдагч, ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийг урьж болно. | Тогтмол |
| Тойргийн зөвлөлийн хурал | Хувь хүмүүс, гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэх арга замуудыг төлөвлөх. Сүнслэг болон материаллаг тусламж, номлолын ажил, гишүүдийн идэвх, идэвхжүүлэх, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажил, сайн мэдээнээс суралцах болон заахыг зохицуулах. Хөтөлбөр, үйл ажиллагаануудыг хэлэлцэж, зохицуулах. | Бишопын зөвлөл, тойргийн бичиг хэргийн ажилтан, тойргийн гүйцэтгэх нарийн бичиг, дээд пристүүдийн бүлгийн удирдагч, ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн Хэсгийн болон Ням гарагийн ангийн ерөнхийлөгчид ба уригдсан бусад хүмүүс | Тогтмол (доод тал нь сар бүр) |
| Бишопын зөвлөлийн залуучуудын хорооны хурал | Тойрог дахь залуучуудын хэрэгцээг тогтоох. Хэрэгцээг шийдвэрлэх, Сүмийн жишгүүдээр амьдрахад нь залуучуудад туслах, Сүмийн хурал цуглаан, үйл ажиллагаануудад оролцохыг нь дэмжих арга замуудыг төлөвлөх. Залуучуудад зориулсан үйл ажиллагаануудыг төлөвлөх. | Бишопын зөвлөл, бишопын пристийн чуулгын туслахуудын нэг, багш нар болон диконуудын чуулгын ерөнхийлөгчид, Залуу Эмэгтэйчүүдийн ангийн дарга нар, Залуу Эрэгтэйчүүдийн болон Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчид, уригдсан бусад хүмүүс (чуулга болон ангийн даргын зөвлөхүүд гэх мэт) | Ихэвчлэн сард нэг удаа |
| Тойргийн ганц бие залуу насанд хүрэгчдийн хорооны хурал | Үйлчлэл болон удирдах үүрэгт оролцоход нь ганц бие залуу насанд хүрэгчдэд туслах арга замуудыг санал болгох. Идэвх султай ганц бие залуу насанд хүрэгчдийн хаягийг тогтоож, тэдэнтэй нөхөрлөх. | Бишопын зөвлөлийн гишүүн, ганц бие залуу насанд хүрэгчдэд томилогдсон Нийгмийн Халамжийн Бүлгийн болон ахлагч нарын чуулгын зөвлөхүүд, ганц бие залуу насанд хүрэгчдийн удирдагчид, ганц бие залуу насанд хүрэгчдэд зөвлөгчөөр дуудагдсан гэр бүлийн хос | Шаардлагатай бол |
| Номлогчдийн зохицуулах хурал | Бүрэн цагийн номлогч нар болон тойргийн гишүүдийн номлолын ажил, гишүүдийн идэвх болон идэвхжүүлэх ажлыг зохицуулах. | Тойргийн номлолын удирдагч, тойргийн болон бүрэн цагийн номлогчид (байдаг газарт) | Тогтмол |

18. Сүмийн хурал цуглаанууд

## Гадасны хурлуудын жагсаалт

| Хурал | Зорилго | Оролцогчид | Давтамж |
|---|---|---|---|
| Гадасны чуулган | Итгэл, гэрчлэлийг хүчирхэгжүүлэх, сайн мэдээг заах, гадасны ажил хэргийг явуулах. | Ерөнхий Эрх мэдэлтэн эсвэл Бүсийн Дал (хэрэв томилогдсон бол), гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, гадасны бүх гишүүд | Жилд хоёр удаа |
| Гадасны санваартны ерөнхий хурал | Санваартнуудад заавар, сүнслэг урам өгөх, гадасны санваарын ажил хэргийг явуулах | Бүх санваартнууд, ахлагч болохуйц ах нар, тойрог дахь Аароны санваарын насны бөгөөд томилогдоогүй залуу эрэгтэйчүүд | Жилд нэг удаа |
| Гадасны санваартны удирдлагын хурал | Санваартны удирдагчдад тэдний үүргүүдийг заах, чадварыг нь дээшлүүлэх, итгэлийг нь хөгжүүлэх. | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, дээд зөвлөл, гадасны гүйцэтгэх нарийн бичиг, гадасны бичиг хэргийн ажилтан (шаардлагатай бол бичиг хэргийн ажилтнуудын туслах), гадасны Залуу эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл (шаардлагатай бол нарийн бичиг), бишопын зөвлөлүүд, тойргийн гүйцэтгэх нарийн бичиг нар, тойргийн бичиг хэргийн ажилтнууд (шаардлагатай бол бичиг хэргийн ажилтнуудын туслах), дээд пристүүдийн бүлгийн удирдагчид, туслахууд, нарийн бичиг нар, ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлүүд болон нарийн бичиг нар, тойргийн номлолын удирдагчид, тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд (шаардлагатай бол нарийн бичиг нар, зөвлөгч нар), уригдсан бусад хүмүүс | Жилд гурван удаа (үүнээс гадасны чуулгантай холбогдуулан хоёр удаа) |
| Гадасны дээд пристүүдийн чуулгын хурал | Чуулгын ажил хэргийг явуулж, чуулгын гишүүдэд үүргүүдийг нь заах | Гадасны бүх дээд пристүүд (дүүрэгт болдоггүй) | Доод тал нь жилд нэг удаа |
| Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал | Гадсанд болж байгаа бүх асуудлыг дүгнэж, төлөвлөх, авч үзэх | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, гадасны бичиг хэргийн ажилтан, гадасны гүйцэтгэх нарийн бичиг, уригдсан бусад хүмүүс | Тогтмол |
| Гадасны санваартны гүйцэтгэх хорооны хурал (дээд зөвлөлийн хурал) | Заавар авах, ажлаа тайлагнах, ажил хэрэг явуулах, хамтран зөвлөлдөх. | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, дээд зөвлөл, гадасны бичиг хэргийн ажилтан, гадасны гүйцэтгэх нарийн бичиг, уригдсан бусад хүмүүс | Боломжтой бол сард хоёр удаа |

### Гадасны хурлуудын жагсаалт (үргэлжлэл)

| Хурал | Зорилго | Оролцогчид | Давтамж |
|---|---|---|---|
| Гадасны зөвлөлийн хурал | Заавар хүлээн авах, хамтдаа зөвлөлдөх, тайлагнах, гадасны бүх хөтөлбөр, үйл ажиллагаануудын төлөвлөлтийг зохицуулах. | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, дээд зөвлөл, гадасны гүйцэтгэх нарийн бичиг, гадасны Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн хэсэг, Ням гарагийн ангийн ерөнхийлөгчид, уригдсан бусад хүмүүс | Шаардлагатай бол жилд хоёроос дөрвөн удаа |
| Бишопын зөвлөлтэй хийх хурал | Бишопын зөвлөлүүдэд заавар өгч, бодлого, дүрэм журмуудыг хэлэлцэж, хамтран зөвлөлдөх. | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, бишопын зөвлөлүүд, гадасны нарийн бичиг, гадасны гүйцэтгэх нарийн бичиг | Шаардлагатай бол жилд нэгээс дөрвөн удаа |
| Гадасны Аароны санваартан–Залуу эмэгтэйчүүдийн хорооны хурал | Гадаснаас явуулж буй залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдэд зориулсан үйл ажиллагаануудыг төлөвлөх. | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүн, Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүдэд томилогдсон дээд зөвлөлийн гишүүд, гадасны Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл, нарийн бичиг, гадасны Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл, нарийн бичиг мөн залуучууд болон уригдсан бусад хүмүүс. | Шаардлагатай үед |
| Гадасны бишопын халамжийн зөвлөлийн хурал | Халамжийн асуудлуудаар заавар авах. Туршлага, санал бодол солилцох. Мацгийн өргөл, халамжийн хэрэгцээ, халамжийн тусламжийн байдалд үнэлэлт өгч ярилцах. Тусламж авсан хүмүүсийн хийх боломжтой ажлуудыг тогтоох. Нийгэм дэх халамжийн эх сурвалжуудыг тогтоох. Сүмийн халамжийн үйл ажиллагаанд үнэлэлт өгөх Халамжийн ажил үүргүүдийг зохицуулах. | Гадасны бүх бишоп, салбарын ерөнхийлөгчид (гадасны ерөнхийлөгч нэг бишопыг тэргүүлэгчээр томилно), гадасны ерөнхийлөгч (зарим үед), шаардлагатай бол халамжийн зохицуулагчид | Доод тал нь улиралд нэг удаа |
| Гадасны туслах бүлгүүдийн удирдлагын хурал (Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн хэсэг ба Ням гарагийн анги) | Тойргийн туслах бүлгүүдийн удирдагчдад үүргийг нь заах, удирдах, заах ур чадварыг тэдэнд заах, итгэлийг нь хүчирхэгжүүлж, санаа бодлоо хуваалцах. | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (хэрэв хүсвэл), туслах бүлэгт томилогдсон дээд зөвлөлийн гишүүн, гадасны туслах бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл, нарийн бичиг, тойргийн туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд болон нарийн бичиг нар, тойргийн туслах бүлгүүдийн бусад удирдагчид, багш нар, зөвлөхүүд (шаардлагатай бол); туслах бүлэгт томилогдсон бишопын зөвлөлийн гишүүн (шаардлагатай бол) | Туслах бүлэг бүр жилд нэг удаа, эсвэл гадасны ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр хоёр удаа (18.3.11-ийг үзнэ үү) |

## Гадасны хурлуудын жагсаалт (үргэлжлэл)

| Хурал | Зорилго | Оролцогчид | Давтамж |
|---|---|---|---|
| Гадасны ганц бие залуу насанд хүрэгчдийн хорооны хурал | Гадсан дахь ганц бие залуу насанд хүрэгчдийн хэрэгцээг шийдвэрлэх. Хамтдаа үйлчлэл хийх, сайн мэдээнээс суралцах бусад тойргийн гишүүдтэй холбоотой байх боломжоор ганц бие залуу насанд хүрэгчдийг хангах. Тойргийн ганц бие залуу насанд хүрэгчдийн хороо байгуулагдсан тойрогтоо сайн ажиллахад анхаарах. | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөх, ганц бие залуу насанд хүрэгчдэд томилогдсон дээд зөвлөлийн гишүүн, гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл, гадасны ганц бие залуу насанд хүрэгчдийн зөвлөгч нар, тойргийн ганц бие залуу насанд хүрэгчдийн удирдагчид (дуудагдсан бол), гадасны бусад ганц бие залуу насанд хүрэгчид | Шаардлага гарсан үед |
| Гадасны ганц бие насанд хүрэгчдийн хорооны хурал | Гадасныхаа ганц бие насанд хүрэгчдийн хэрэгцээг шийдвэрлэх. Ганц бие насанд хүрэгчдийг шаардлагатай үед хамтдаа үйлчлэл хийх, сайн мэдээнээс суралцах, тойргоосоо гадна бусад хамтын үйл ажиллагаануудад оролцох боломжоор хангах. | Гадасны ерөнхийлөгчийн нэг зөвлөх, дээд зөвлөлийн гишүүн, гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүн, нэлээд хэдэн ганц бие насанд хүрэгч | Шаардлагатай үед |

## Ням гарагийн цуглааны хуваарь

### Загвар 1

<table>
<tr><td>70 минут</td><td colspan="5">Ариун ёслолын цуглаан</td></tr>
<tr><td>10 минут</td><td colspan="5">Завсарлага</td></tr>
<tr><td>40 минут</td><td colspan="4">Ням гарагийн анги</td><td rowspan="4">Хүүхдийн Хэсэг (асрах анги орно) Дэлгэрэнгүй мэдээллийг 11.4.1-с үзнэ үү.</td></tr>
<tr><td>10 минут</td><td colspan="4">Завсарлага</td></tr>
<tr><td rowspan="2">50 минут</td><td colspan="2">Тойргийн санваартны хурлын нээлтийн ажиллагаа</td><td>Нээлтийн ажиллагаа</td><td>Нээлтийн ажиллагаа</td></tr>
<tr><td>Мелкизедек санваартнууд</td><td>Аароны санваартнууд</td><td>Нийгмийн Халамжийн Бүлэг</td><td>Залуу Эмэгтэйчүүд</td></tr>
</table>

3 цаг Цуглаануудын хоорондох завсарлагааны хугацаа нь орон нутгийн хэрэгцээний дагуу уян хатан байна.

### Загвар 2

<table>
<tr><td rowspan="2">50 минут</td><td colspan="2">Тойргийн санваартны хурлын нээлтийн ажиллагаа</td><td>Нээлтийн ажиллагаа</td><td>Нээлтийн ажиллагаа</td><td rowspan="4">Хүүхдийн Хэсэг (мөн асрах анги) Дэлгэрэнгүй мэдээллийг 11.4.1-с үзнэ үү.</td></tr>
<tr><td>Мелкизедек санваартнууд</td><td>Аароны санваартнууд</td><td>Нийгмийн Халамжийн Бүлэг</td><td>Залуу Эмэгтэйчүүд</td></tr>
<tr><td>10 минут</td><td colspan="4">Завсарлага</td></tr>
<tr><td>40 минут</td><td colspan="4">Ням гарагийн анги</td></tr>
<tr><td>10 минут</td><td colspan="5">Завсарлага</td></tr>
<tr><td>70 минут</td><td colspan="5">Ариун ёслолын цуглаан</td></tr>
</table>

3 цаг Цуглаануудын хоорондох завсарлагааны хугацаа нь орон нутгийн хэрэгцээний дагуу уян хатан байна.

## Өөр хэлээр ярьдаг нэгжүүдийн цуглааны хуваарийг нэгтгэх

Гишүүд нь өөр хэлээр ярьдаг хоёр нэгж нэг байранд цугладаг бол хүүхэд, залуучууд нь хичээлдээ хамт суудаг байвал сайн. Жишээ нь, англиар ярьдаг тойрог, испаниар ярьдаг салбар нэг байранд цугладаг бол испаниар ярьдаг салбарын Хүүхдийн Хэсэг англиар ярьдаг тойргийн Хүүхдийн Хэсэг хоёр нэгдэн хичээллэж болно. Испаниар ярьдаг салбарын залуучууд англиар ярьдаг тойргийн Ням гарагийн анги, Аароны санваартнууд, Залуу Эмэгтэйчүүдийн ангиудтай нийлж хичээллэж болно.

Испаниар ярьдаг салбарын залуучууд бас англиар ярьдаг тойргийн Мючелд нэгдэж болно. Хүүхдүүд нь Каб Скаутын болон бусад үйл ажиллагаанд англиар ярьдаг тойрогтой нэгдэж болно.

Энэ загварыг ашиглахад гадасны ерөнхийлөгчийн зөвшөөрөл шаардлагатай. Гадасны ерөнхийлөгчийн зөвшөөрлийг авсны дараа бишопын болон салбарын ерөнхийлөгчийн зөвлөл өөрсдийн нэгжийн санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчидтай уулзаж, тэдний зөвлөгөөг сонссоны үндсэн дээр уг загварыг хэрэгжүүлэхийн төлөө хамтран ажиллана.

Бишопын болон салбарын ерөнхийлөгчийн зөвлөл хамтран нэгж тус бүрээс ямар гишүүдийг дээр дурдсан бүлгүүдэд үйлчлүүлэхээр дуудахыг шийднэ. Удирдагчид бас Аароны санваартны чуулга, Залуу Эмэгтэйчүүдийн ангиудын удирдагчдыг дуудах тухай асуудлыг хэлэлцэнэ. Санваартны удирдагчид энэ төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсний дараа үйл ажиллагаагаа зохицуулах, асуудлуудыг шийдвэрлэхийн тулд тогтмол хуралдана.

Бишопын зөвлөлөөс нэг, салбарын ерөнхийлөгчийн зөвлөлөөс нэг төлөөлөгч бишопын зөвлөлийн залуучуудын хорооны хуралд оролцоно.

Энэ загварыг хэрэгжүүлэхийн тулд дээрх хоёр нэгжийн хурал цуглааны хуваарийг доорх хүснэгтэд харуулсны дагуу нэгтгэх хэрэгтэй. Дараах хүснэгтэд тойрог эхлээд цуглаж байгаа ч салбар бас эхлээд цуглаж болно.

<table>
<tr><th colspan="2">Тойрог</th><th colspan="2">Салбар</th></tr>
<tr><td colspan="2">Ариун ёслолын цуглаан</td><td colspan="2">Салбарын цуглаан тойргийн цуглаанаас 80 минутын дараа эхэлнэ</td></tr>
<tr><td>Ням гарагийн анги</td><td rowspan="2">Хүүхдийн Хэсэг</td><td>Ням гарагийн анги (залуучууд тойргийн ангиудтай нийлнэ)</td><td rowspan="2">Хүүхдийн Хэсэг (тойргийн Хүүхдийн Хэсэгтэй нэгдэнэ)</td></tr>
<tr><td>Санваартнууд<br>Нийгмийн Халамжийн Бүлэг<br>Залуу Эмэгтэйчүүд</td><td>Санваартнууд (залуу эрэгтэйчүүд тойргийн чуулгуудтай нэгдэнэ)<br>Нийгмийн Халамжийн Бүлэг<br>Залуу Эмэгтэйчүүд (тойргийн залуу эмэгтэйчүүдтэй нийлнэ)</td></tr>
<tr><td colspan="2">Тойргийн цуглаан салбарын цуглаан эхлэхээс 80 минутын өмнө дуусна</td><td colspan="2">Ариун ёслолын цуглаан</td></tr>
</table>

# 19. Сүм дэх дуудлагууд

19.1 **Хэнийг дуудахыг шийдэх нь. . . . . . . . . . . . . .170**
19.1.1 Ерөнхий удирдамж. . . . . . . . . . . . . . . . . . . . 170
19.1.2 Дуудлагуудад санал оруулж батлах нь . . 170
19.1.3 Гадасны дуудлагууд . . . . . . . . . . . . . . . . . . . 171
19.1.4 Тойргийн дуудлагууд. . . . . . . . . . . . . . . . . . 171
19.1.5 Ахлагч нарын чуулга ба дээд пристийн бүлгийн дуудлагууд . . . . . . . . . . . . . . . . . . . 171

19.2 **Дуудлага өгөх нь. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .171**

19.3 **Гишүүдийг сүмийн дуудлагад дэмжүүлэх нь. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .171**

19.4 **Дуудлагатнууд болон багш нарыг адислах нь . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .172**

19.5 **Гишүүдийг сүмийн дуудлагаас чөлөөлөх нь . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .172**

19.6 **Бишопуудыг дуудаж, томилж, адислах нь . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .172**

**Дуудлагуудын жагсаалт . . . . . . . . . . . . . . . . .173**
Гадасны дуудлагууд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 173
Мелкиздек санваарын дуудлагууд. . . . . . . . . . . 175
Тойрог дахь Аароны санваарын дуудлагууд . . . 176
Гадасны харьяа салбаруудын Аароны санваарын дуудлагууд. . . . . . . . . . . . . . . . . . . . . 176
Тойргийн дуудлагууд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 177
Гадасны харьяа салбарын дуудлагууд. . . . . . . . . 179
Номлолын дуудлагууд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 179
Дүүргийн дуудлагууд. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 180
Номлолын харьяа салбаруудын ахлагч нарын чуулгын дуудлагууд . . . . . . . . . . . . . . . . 180
Номлолын харьяа салбаруудын Аароны санваарын дуудлагууд. . . . . . . . . . . . . . . . . . . . . 181
Номлолын харьяа салбарын дуудлагууд. . . . . . . 181
Цэргийн албан хаагч гишүүдийн бүлгийн дуудлагууд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 182

# 19. Сүм дэх дуудлагууд

Энэ хэсэг нь Сүмд үйлчлэх гишүүдийг дуудах, чөлөөлөх тухай мэдээллийг агуулдаг. Хуудас 173–182 дээрх Дуудлагуудын жагсаалтан дахь сонгож авсан дуудлагуудад хэн нэр дэвшүүлдэг, хэн баталдаг, хэнээр дэмжүүлдэгийг мөн хэн дуудаж, адисалдгийг харуулсан болно. Жагсаалтан дахь дуудлагуудыг хэрэгцээ болон дуудах гишүүдийн хүрэлцээг харгалзан бөглөнө.

## 19.1 Хэнийг дуудахыг шийдэх нь

### 19.1.1 Ерөнхий удирдамж

Сүмд үйлчлэх хүн Бурханаас дуудагдах ёстой (Итгэлийн Тунхаг 1:5-г үзнэ үү). Удирдагчид хэнийг дуудахыг шийдэхдээ Сүнсний удирдамжийг эрэлхийлдэг. Тэд тухайн дуудлагад шаардагдах зохистой байдлыг харгалзан үзнэ. Бас тухайн гишүүний хувийн болон гэр бүлийн нөхцөл байдлыг харгалзан үздэг. Дуудлага бүр нь хүмүүст, тухайн гишүүнд болон түүний гэр бүлд ашиг тусаа өгдөг байх ёстой.

Сүмийн дуудлагад үйлчлэх нь золиослол шаарддаг ч, энэ нь тухайн гишүүн гэр бүлийнхээ өмнө болон эрхэлсэн ажлынхаа талаар хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд саад бэрхшээл учруулах ёсгүй (17.2.1-ийг үзнэ үү). Цаг хугацаа их шаарддаг дуудлагад гэрлэсэн хүнийг дуудахаас өмнө уг дуудлага тухайн хүний гэрлэлт, гэр бүлд хэрхэн нөлөөлж болохыг Сүмийн удирдагчид харгалзаж үзэх хэрэгтэй.

Хэрэв боломжтой бол гишүүн нь гэрийн багш эсвэл айлчлагч багшийн үүргээс гадна нэг л дуудлагад үйлчлэхээр дуудагдах ёстой.

Төлөвлөж байгаа дуудлагууд болон чөлөөлөлтүүдийн тухай мэдээллийг удирдагчид нууцлах ёстой. Уг хүнд хяналт тавих туслах бүлгүүдийн ерөнхийлөгч зэрэг зөвхөн мэдвэл зохих хүмүүст л уг хүнийг дэмжүүлэхээр танилцуулахын өмнө мэдээлнэ. Дуудлагад нэр дэвшүүлэхээр төлөвлөж байгаа хүнд дуудлагыг өгөх хүртэл мэдэгдэхгүй.

Дуудлагыг гадасны ерөнхийлөгч өөрөө эсвэл түүний удирдлагаар өгөх тохиолдолд тухайн хүний зохистой байдал, гэр бүл, ажил төрөл, Сүмд үйлчлэх нөхцөл боломжийн талаар бишоптой зөвлөлдөх ёстой. Дуудлагуудын жагсаалтад заасан бол тухайн хүнийг дуудах шийдвэрийг дэмжихийг Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл дээд зөвлөлөөс хүснэ.

Залуу эрэгтэй, залуу эмэгтэй хүнийг Сүмийн албан тушаалд дуудахад дуудлагыг өгөхөөс өмнө бишопын зөвлөл эцэг эхээс нь эсвэл асран хамгаалагчаас нь зөвшөөрөл авна.

(1) Тухайн хүний гишүүнчлэлийн бүртгэл тойргийн хавтаст хэрэгт байгаа бөгөөд үүнийг бишоп анхааралтайгаар хянан үзсэний дараа эсвэл (2) тухайн гишүүн зохистой эсэхийг тогтоохын тулд мөн түүний гишүүнчлэлийн бүртгэлд ямар нэгэн тайлбар болон Сүмийн сахилгын шийдвэрлэгдээгүй асуудал байхгүйг магадлан шалгахын тулд уг гишүүний өмнөх бишоптой холбоо тогтоосны дараа л удирдагчид Сүмийн дуудлагыг өгч болно.

Шинэ хөрвөгчдөд ямар нэг тохирох дуудлага эсвэл үйлчлэх өөр ямар нэг үүрэг хариуцлагыг аль болохоор түргэн өгөх хэрэгтэй. Зарим шинэ гишүүд баптисм хүртэж, гишүүнээр батлагдсан даруйдаа дуудлага хүлээн авхад бэлэн байж болно. Зарим нь дуудлага хүлээж авахад бэлтгэгдэхэд нь туслах энгийн ажил үүрэг хүлээн авах хэрэгтэй байж болно. Шинэ гишүүдийг хүүхэд залуучуудад заах ажилд дуудахаас өмнө бишопын зөвлөлийн гишүүн тэдэнтэй ярилцлага хийнэ.

Сүмийн гишүүн биш хүмүүсийг бадралт баг бишгүүрч, хөгжмийн удирдагч, Скаутын удирдагчийн туслах зэрэг зарим үүрэгт дуудаж болно. Гэвч тэднийг Хүүхдийн Хэсгийн хөгжмийн удирдагч зэрэг заах болон удирдан зохион байгуулах дуудлагуудад дуудаж болохгүй. Зарим дуудлагад гишүүн бус хүмүүсийг дуудах боломжтой байдаг ч дуудлага авч болохгүй болсон буюу гишүүнчлэлээс хасуулсан хүмүүст хамаарахгүй.

### 19.1.2 Дуудлагуудад санал оруулж батлах нь

Дуудлагуудын жагсаалтад дуудлага бүрд хэн нэр дэвшүүлж, баталдгийг харуулсан байгаа. Зарим тохиолдолд санваартны болон туслах бүлгүүдийн удирдагч нарыг гадасны ерөнхийлөгчийн зөвлөл болон бишопын зөвлөлд нэр дэвшүүлэх хүнийг санал болгохыг хүсдэг. Тэд хэнийг нэр дэвшүүлэх талаар Их Эзэнээс удирдамж хүлээн авч болно гэдгийг ухамсарлан, энэ үүрэг хариуцлагаа залбиралтайгаар авч үзэх ёстой. Гэвч хэнийг дуудах талаар сүнсний нөлөөлөл хүлээж авах эцсийн хариуцлага нь гадасны ерөнхийлөгчийн зөвлөл болон бишопын зөвлөлд ноогддогийг тэд санах ёстой.

Эдгээрийг залбиралтайгаар авч үзсэний үндсэн дээр санал болгосныг гадасны ерөнхийлөгч, бишопууд анхаарч, санал бүрд тэд анхааралтай дүгнэлт өгөх ёстой. Шаардлагатай бол тэд өөр санал ирүүлэхийг хүсч болно.

### 19.1.3 Гадасны дуудлагууд

Гадасны ерөнхийлөгч Дуудлагуудын жагсаалтын дагуу гадасны ихэнх дуудлагад үйлчилдэг гишүүдэд хяналт тавина.

### 19.1.4 Тойргийн дуудлагууд

Бишопоор дуудагдах эсвэл чөлөөлөгдөх ах нарыг гадасны ерөнхийлөгчийн зөвлөл санал болгодог (19.6-г үзнэ үү). Гадасны ерөнхийлөгч бас бишопын зөвлөхүүд, тойргийн бичиг хэргийн ажилтнууд, тэдний туслахууд, тойргийн гүйцэтгэх нарийн бичиг нарын дуудлагад хяналт тавьдаг. Дуудлагуудын жагсаалтын дагуу тойрог дахь бусад дуудлагуудад бишоп хяналт тавьдаг.

### 19.1.5 Ахлагч нарын чуулга ба дээд пристийн бүлгийн дуудлагууд

Гадасны ерөнхийлөгч Дуудлагуудын жагсаалтын дагуу ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, тэдний зөвлөхүүд, дээд пристүүдийн бүлгийн удирдагч, тэдний туслахуудын дуудлагыг хариуцна.

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч, дээд пристүүдийн бүлгийн удирдагч хоёр чуулгын болон бүлгийн нарийн бичиг болон багшийн дуудлагыг хариуцна. Эдгээр албуудад ах нарыг дуудахаас өмнө бишопын зөвшөөрөл шаардлагатай.

## 19.2 Дуудлага өгөх нь

Дуудлагуудын жагсаалтанд дуудлага бүрийг хэн өгч болох тухай өгүүлсэн байдаг. Шаардагдах зөвшөөрлийг хүлээн авсны дараа гишүүний зохистой байдал, үйлчлэх хүслийг тодорхойлохын тулд эрх мэдэл бүхий удирдагч түүнтэй ярилцлага хийнэ. Хэрэв гишүүн зохистой бөгөөд хүсэлтэй байвал, удирдагч дуудлагыг өгдөг. Гэрлэсэн хүний эхнэр эсвэл нөхрийг байлцахыг урьж, дуудлага өгөх үед дэмжлэг үзүүлж байхыг хүснэ.

Сүмийн дуудлага өгч буй удирдагч дуудлагын зорилго, ач холбогдол, үүрэг хариуцлагуудыг тайлбарлах ёстой. Дуудлагаа биелүүлэхдээ Их Эзэний Сүнсийг эрэлхийлэх талаар гишүүнийг дэмжинэ. Тухайн гишүүнд түүний дээрх шууд удирдах хүний нэрийг хэлж, удирдагчдаа дэмжихийн чухлыг онцлон тэмдэглэнэ. Шаардлагатай бол тэрээр тухайн хүний оролцох ёстой хурал цуглаануудыг нэрлэж, ямар эх сурвалж материалууд байдгийг хэлж өгөх хэрэгтэй. Тухайн дуудлагын талаар анхаарах зүйлс, тохиолдох бэрхшээлүүдийг хэлж, энэ тухай асууж байхыг гишүүнээс хүсч болно.

Удирдагчид дуудлагыг өгөхдөө дуудлагын ариун нандин мөн чанарыг анхаарах ёстой. Дуудлагуудыг чөлөөт хэт энгийн байдалд биш, албан ёсны, хүндэтгэлтэй байдалд өгөх ёстой.

## 19.3 Гишүүдийг сүмийн дуудлагад дэмжүүлэх нь

Сүмийн ихэнх дуудлагуудад дуудагдаж байгаа гишүүд үйлчлэлээ эхлэхээс өмнө дэмжигдэх ёстой. Дуудлагуудын жагсаалтад дэмжүүлэх хэрэгтэй эсэх тэрчлэн ямар хурлаар дэмжүүлэхийг харуулдаг. Уг дуудлагад хяналт тавьдаг удирдагч эсвэл дор дурьдсаны дагуу түүний эрх мэдэл олгосон санваартны албан тушаалтан тухайн хүнийг дэмжүүлэхээр танилцуулдаг.

Дэмжүүлэх гэж буй хүн дуудлагаас чөлөөлөгдөж байгаа хүнийг эхлээд зарлаж, уг хүний үйлчлэлд талархал илэрхийлэхийг гишүүдээс хүсдэг (зөвлөмж болгосон үг хэллэгийг 19.5-аас үзнэ үү).

Дэмжүүлэх хүнийг танилцуулж байгаа үед эрх мэдэл олгогдсон санваарын албан тушаалтан уг гишүүнийг босохыг хүснэ. Уг хүн:

"[Хүний нэр] нь [дуудлага]-д дуудагдсан бөгөөд түүнийг дэмжих саналыг бид оруулж байна. Зөвшөөрч байгаа хүмүүс гараа өргөнө үү. [Түр ажиглана] Татгалзаж байгаа хүн байвал гараа өргөнө үү гэж хэлнэ. [Түр ажиглана]"

Танилцуулагдаж байгаа хүн дэмжүүлэх санал авалтад оролцох ёстой. Хэрэв нэгээс олон хүн дэмжүүлэгдэж байгаа бол тэднийг ихэвчлэн бөөнд нь дэмжүүлдэг.

Хэн нэгнийг дэмжүүлэх үед идэвхтэй гишүүн татгалзах санал өгвөл, тэргүүлэх албаны хүн эсвэл томилогдсон санваартан татгалзах санал өгсөн гишүүнтэй цуглааны дараа ганцаарчлан уулзаж ярилцана. Тухайн санваартан татгалзсан саналыг уг гишүүний тухайн дуудлалгад тэнцэхгүй байх хангалттай шалтгаан мөн эсэхийг тогтооно. Гишүүн бус хүмүүсийн татгалзсан саналыг хэрэгсэх шаардлагагүй.

Гадасны шинэ дуудлагатнууд гадасны дараагийн чуулга эсвэл гадасны санваартнуудын ерөнхий хурал дээр дэмжигдэх боловч дээрх хурлуудаас өмнө үйлчлэлээ эхлэх хэрэгтэй харгалзан, тэднийг гадасны тойргууд болон салбаруудын ариун ёслолын цуглаанууд дээр

дэмжүүлэх ёстой. Гэвч ийм тохиолдлуудыг аль болох цөөхөн байлгах ёстой. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн эсвэл дээд зөвлөлийн гишүүд дэмжүүлэх саналуудыг танилцуулна.

## 19.4 Дуудлагатнууд болон багш нарыг адислах нь

Сүмийн ихэнх албуудад дуудагддаг гишүүд үйлчлэлээ эхлэхээс өмнө адислагдах ёстой. Дуудлагуудын жагсаалтад хэн адислалыг өгөх эрх мэдэлтэйг харуулсан болно. Ерөнхийлөгч нар зөвлөхүүдээсээ өмнө адислагддаг.

Тэргүүлэх эрх мэдэлтний удирдлага дор нэг буюу түүнээс олон Мелкизедек санваартан түүний дотор зохистой эцэг болон нөхөр дуудлагын адислалд оролцож болно (20.1.2-ыг үзнэ үү). Ах нар уг хүний толгой дээр гараа зөөлхөн тавина. Тэгээд ёслол гүйцэтгэх санваартан:

1. Уг хүнийг бүтэн овог нэрээр нь дуудна.
2. Тэрээр Мелкизедек санваарын эрх мэдлээр үйлдэж байгаагаа хэлнэ.
3. Уг хүнд гадас, тойрог, чуулга, дээд пристүүдийн бүлэг эсвэл ангийн холбогдох дуудлагын адислалыг өгнө.
4. Хэрэв тухайн хүн түлхүүрүүдийг хүлээн авах эрхтэй бол түлхүүрүүдийг өгнө. (Гадас, тойргуудад зөвхөн гадасны ерөнхийлөгч, бишоп, чуулгын ерөнхийлөгч л адислагдах үеэрээ ерөнхийлөгчийн зөвлөлийн түлхүүрүүдийг хүлээн авдаг. Зөвлөхүүд, дээд зөвлөлийн гишүүд, дээд пристүүдийн бүлгийн удирдагч, туслах бүлгийн ерөнхийлөгч, бишопын пристийн чуулгын туслахууд болон бүлэг дэх багш нарыг адислахад *түлхүүрүүд* гэдэг үгийг ашиглах ёсгүй.)
5. Сүнсний удирдамжаар адислалын үгсийг нэмж хэлнэ.
6. Есүс Христийн нэрээр төгсгөнө.

Дуудлагын адислал өгөх нь хүн адислах нэг боломж юм. Ер нь бол дуудлагын адислал өгөхөөс өөр үед тухайн хүнд үүргийг нь зааж тодорхой зөвлөгөө өгдөг.

Дуудлагын адислалыг албан ёсны цуглаан дээр өгөх шаардлагагүй. Хүнийг адислах үед залбирал, гэрчлэл хуваалцах мөн заавар өгөх шаардлагагүй.

## 19.5 Гишүүдийг сүмийн дуудлагаас чөлөөлөх нь

Оршин суух газар нь өөрчлөгдөх эсвэл бүрэн цагийн номлолд явах зэрэг тодорхой хугацаатай дуудлагын улмаас тухайн хүнийг чөлөөлөхөөс бусдаар сүмийн дуудлагаас чөлөөлөхийг сүнсний удирдамжаар шийдэх ёстой.

Сүмийн дуудлагуудаас чөлөөлөхдөө дуудлагуудыг өгсөн эрх мэдлийн түвшингийн хүн чөлөөлнө. Чөлөөлөхийн тулд эрх олгогдсон удирдагч уг гишүүнтэй биечлэн уулзаж, чөлөөлөлтийн тухай түүнд мэдэгдэн, үйлчлэлийнх нь төлөө талархал илэрхийлнэ. Удирдагч нь уг хүний тухайн үед ашиглаж байсан материалуудыг түүний оронд дуудагдах хүнд өгөхийн тулд буцааж өгөхийг түүнээс хүснэ. Чөлөөлөлтийг нийтэд зарлахаас өмнө зөвхөн мэдэх шаардлагатай хүмүүст л мэдэгдэх хэрэгтэй.

Тухайн хүн дуудлага авсан тойрогтоо чөлөөлөгдөх ёстой. Эрх мэдэл олгогдсон санваартан:

"[Хүний нэрийг хэлнэ] нь [дуудлагаас] чөлөөлөгдсөн бөгөөд, түүний үйлчлэлд талархал илэрхийлэхийг хүсч байна. Талархаж байгаа гишүүд гараа өргөнө үү" гэж хэлнэ. Татгалзах хүн байна уу гэж асуухгүй.

Ерөнхийлөгч, бишоп эсвэл дээд пристийн бүлгийн удирдагч чөлөөлөгдөхөд зөвлөхүүд хамт чөлөөлөгддөг. Нарийн бичиг нар, багш нар зэрэг бүлэг дэх бусад дуудлагатай хүмүүс хамт чөлөөлөгддөггүй.

## 19.6 Бишопуудыг дуудаж, томилж, адислах нь

Бишопоор дуудах эсвэл чөлөөлөхөд ах нарыг гадасны ерөнхийлөгчийн зөвлөл санал болгодог. Зааврууд нь Recommendation for New Bishop (Шинэ бишопыг нэр дэвшүүлэх) маягт дээр байдаг. Энэ маягт Сүмийн бүртгэл хөтлөлтийн программ хангамж хэрэглэдэг нэгжүүдэд электрон файлаар байдаг. Бусад нэгжүүд үүнийг харьяа үйлчлэлийн төвөөс авч болно.

Бишопоор үйлчлэх хүнийг санал болгоход гадасны ерөнхийлөгчийн зөвлөл 1 Тимот 3:2—7-д байдаг зарчмуудыг нягт нямбай баримтлах ёстой. Бишопоор үйлчилж болох хүнийг тогтоохын тулд гадасны гишүүдийн дунд судалгаа явуулах, хэн нэгнийг нэр дэвшүүлэхийг гуйх замаар санал дэвшүүлэх нь гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн хувьд тохиромжгүй юм.

Шинэ бишоптой ярилцлага хийх, түүнийг дуудах, томилох эсвэл адислахын өмнө түүний нэр Тэргүүн Зөвлөлөөр батлагдах ёстой. Тэргүүн Зөвлөлөөс бичгээр зөвшөөрөл хүлээн авсны дараа гадасны ерөнхийлөгч дуудлагыг өгч болно. Зөвшөөрөл авсаны дараа гадасны ерөнхийлөгч тойргийн гишүүдээр дэмжүүлээд бишопыг томилж, адисалж болно. Гадасны

ерөнхийлөгч бишопыг чөлөөлөхийн өмнө бас Тэргүүн Зөвлөлийн зөвшөөрөл авах шаардлагатай. Гадасны ерөнхийлөгч эдгээр үүргийг зөвлөхөд даалгаж болохгүй.

Хэрэв бишопоор дуудагдах хүн дээд прист биш бол, түүнийг бишопоор томилогдохоос өмнө дээд пристэд томилохыг гадасны ерөнхийлөгч анхаарах ёстой. Хэрэв уг хүн өмнө нь бишопоор томилогдож байсан бол тэрээр зөвхөн тухайн тойргийн бишопоор адислагдана.

Тэргүүн Зөвлөл бишопоор үйлчлэх хүний тухай саналыг хүлээн зөвшөөрсний дараа түүнийг томилж, адислах эрх мэдлийг Ерөнхий эрх мэдэлтэн, Бүсийн дал эсвэл гадасны ерөнхийлөгчид олгодог. Эрх мэдэл олгогдсон санваартан:

1. Уг хүнийг бүтэн овог нэрээр нь дуудна.
2. Тэрээр Мелкиседек санваарын эрх мэдлээр үйлдэж байгаагаа хэлнэ.
3. Уг хүнийг бишопоор томилно (хэрэв тэр өмнө нь томилогдож байгаагүй бол).
4. Тойргийг тэргүүлэхээр, түүнчлэн Аароны санваартнуудын болон пристийн чуулгын ерөнхийлөгчөөр адислахдаа, тойргийн Аароны санваартнууд болон Залуу Эмэгтэйчүүдийн талаарх үүрэг хариуцлагуудыг нь онцлон дурдана.
5. Түүнд түлхүүрүүд, эрх, хүч чадал болон бишопын албаны эрх мэдлийг олгохдоо, Израилын олон нийтийн шүүгч, тойрог дахь тэргүүлэх дээд прист байх бишопын үүрэг хариуцлагуудыг онцлон заадаг.
6. Сүнсний удирдамжаар адислалын үгсийг нэмж хэлнэ.
7. Есүс Христийн нэрээр төгсгөнө.

---

## Дуудлагуудын жагсаалт

### Гадасны дуудлагууд

Дараах хүснэгтэд гадасны дуудлагуудыг жагсаан харуулав. Бусад дуудлагууд болон үйлчлэл хийх боломжуудыг энэ Гарын авлагын бусад бүлгүүдээс үзэж болно. Хэрэгцээ болон дуудах гишүүдийн хүрэлцээг харгалзан дуудлагуудыг өгнө.

| Алба | Нэр дэвшүүлэх хүн | Батлах хүн | Дэмжих хүмүүс [1] | Дуудаж, адислах хүн |
|---|---|---|---|---|
| Гадасны ерөнхийлөгч | Томилогдсон Ерөнхий Эрх мэдэлтэн эсвэл Бүсийн Дал | Томилогдсон Ерөнхий Эрх мэдэлтэн эсвэл Бүсийн Дал | Гадасны чуулган дээрх гишүүд | Томилогдсон Ерөнхий Эрх мэдэлтэн эсвэл Бүсийн Дал |
| Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд | Гадасны ерөнхийлөгч | Томилогдсон Ерөнхий Эрх мэдэлтэн, Бүсийн Дал эсвэл Тэргүүн Зөвлөлөөс бичгээр ирүүлсэн мэдэгдэл | Гадасны чуулга эсвэл гадасны санваартны ерөнхий хурал дээрх гишүүд | Томилогдсон Ерөнхий Эрх мэдэлтэн, Бүсийн Дал эсвэл Тэргүүн Зөвлөлөөс бичгээр ирүүлсэн зөвшөөрөлтэй гадасны ерөнхийлөгч |
| Гадасны бичиг хэргийн ажилтан | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Гадасны чуулга эсвэл гадасны санваартны ерөнхий хурал дээрх гишүүд | Гадасны ерөнхийлөгч |
| Гадасны бичиг хэргийн ажилтнуудын туслах | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Гадасны чуулган эсвэл гадасны санваартны ерөнхий хуралд оролцох гишүүд | Гадасны ерөнхийлөгч эсвэл томилогдсон зөвлөх |
| Гадасны гүйцэтгэх нарийн бичиг | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Гадасны чуулга эсвэл гадасны санваартны ерөнхий хуралд оролцох гишүүд | Гадасны ерөнхийлөгч эсвэл томилогдсон зөвлөх |
| Дээд зөвлөлийн гишүүд | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Гадасны чуулга эсвэл гадасны санваартны ерөнхий хуралд оролцох гишүүд | Гадасны ерөнхийлөгч эсвэл томилогдсон зөвлөх |

### Гадасны дуудлагууд (үргэлжлэл)

| Алба | Нэр дэвшүүлэх хүн | Батлах хүн | Дэмжих хүмүүс [1] | Дуудаж, адислах хүн |
|---|---|---|---|---|
| Гадасны патриарх | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл | Арванхоёрын Чуулга | Гадасны чуулга эсвэл гадасны санваартны ерөнхий хуралд оролцох гишүүд | Тэргүүн Зөвлөлийн, Арванхоёрын гишүүн эсвэл Арванхоёрын Чуулгаас бичгээр ирүүлсэн зөвшөөрөлтэй гадасны ерөнхийлөгч |
| Өмнө нь томилогдсон боловч өөр гадсанд шилжсэн гадасны патриарх | Түүний шилжин очсон гадасны ерөнхийлөгчийн зөвлөл | Арванхоёрын Чуулга | Гадасны чуулга эсвэл гадасны санваартны ерөнхий хурал дээрх гишүүд | Шинэ гадсанд үйлчлэхийн өмнө томилогдохгүй мөн адислуулахгүй |
| Гадасны туслах бүлгүүдийн ерөнхийлөгч нар (Залуу эрэгтэйчүүд, Нийгмийн халамжийн бүлэг, Залуу эмэгтэйчүүд, Хүүхдийн хэсэг, Ням гарагийн анги) | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл (томилогдсон дээд зөвлөлийн гишүүнтэй зөвлөлдсөний үндсэн дээр) | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Гадасны чуулганд оролцох гишүүд | Гадасны ерөнхийлөгч эсвэл томилогдсон зөвлөх |
| Гадасны туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөхүүд, нарийн бичиг нар, туслах бүлгүүдийн бусад удирдагчид | Гадасны туслах бүлгийн ерөнхийлөгч (томилогдсон дээд зөвлөлийн гишүүнтэй зөвлөлдөж) | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Гадасны чуулган дээрх гишүүд | Гадасны ерөнхийлөгч, томилогдсон зөвлөх эсвэл дээд зөвлөлийн гишүүн |
| Гадасны барилга байгууламжийн төлөөлөгч (дээд зөвлөлийн гишүүн) | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлөөс томилогдох боловч дуудаж, дэмжүүлж адислахгүй. | | | |
| Гадасны үйл ажиллагааны хорооны тэргүүлэгч (дээд зөвлөлийн гишүүн) | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлөөс томилогдох боловч дуудаж, дэмжүүлж адислахгүй. | | | |
| Гэр бүлийн түүхийн төвийн удирдагч ба удирдагчийн туслах | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Гадасны чуулганд оролцох гишүүд | Гадасны ерөнхийлөгч, томилогдсон зөвлөх эсвэл дээд зөвлөлийн гишүүн |
| Гадасны индексжүүлэлтийн удирдагч ба удирдагчийн туслах | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Гадасны чуулганд оролцох гишүүд | Гадасны ерөнхийлөгч, томилогдсон зөвлөх эсвэл дээд зөвлөлийн гишүүн |
| Гадасны хөгжмийн удирдагч | Гадасны хөгжмийн зөвлөгч (дээд зөвлөлийн гишүүн) | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Гадасны чуулган дээрх гишүүд | Гадасны ерөнхийлөгч, томилогдсон зөвлөх эсвэл дээд зөвлөлийн гишүүн |
| Гадасны аудиторууд | Гадасны аудитын хорооны дарга (гадасны ерөнхийлөгчийн зөвлөх) | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Дэмжүүлдэггүй | Гадасны ерөнхийлөгч эсвэл томилогдсон зөвлөх[2] |
| Гадасны халамжийн зохицуулагчид (түүний дотор гадасны ажил эрхлэлтийн зохицуулагч) | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Дэмжүүлдэггүй | Гадасны ерөнхийлөгч, томилогдсон зөвлөх эсвэл дээд зөвлөлийн гишүүн[2] |

### Гадасны дуудлагууд (үргэлжлэл)

| Алба | Нэр дэвшүүлэх хүн | Батлах хүн | Дэмжих хүмүүс [1] | Дуудаж, адислах хүн |
|---|---|---|---|---|
| Гадасны семинар, институтийн багш нар | Бишоп (семинар, институтийн ажилтнуудтай зөвлөлдөж болно) | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Гадасны чуулган дээрх гишүүд | Гадасны ерөнхийлөгч, томилогдсон зөвлөх эсвэл дээд зөвлөлийн гишүүн |

[1] Гадасны шинэ дуудлагатнууд өөрсдийн дэмжүүлэх ёстой гадасны дараагийн чуулган эсвэл гадасны санваартны ерөнхий хурлаас өмнө үйлчлэлээ эхлэх шаардлагатай бол тэднийг гадасны тойрог, салбаруудын ариун ёслолын цуглаан дээр дэмжүүлэх ёстой (19.3-ыг үзнэ үү).

[2] Эдгээр дуудлагуудад үйлчлэхээр дуудагдсан гишүүдийг адислах эсэхийг гадасны ерөнхийлөгч шийднэ.

---

## Мелкиседек санваарын дуудлагууд

| Алба | Нэр дэвшүүлэх хүн | Батлах хүн | Дэмжих хүмүүс | Дуудаж, адислах хүн |
|---|---|---|---|---|
| Гадасны дээд пристүүдийн чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл (гадасны ерөнхийлөгчийн зөвлөл) | Хуудас 174 дээрх “Гадасны дуудлагууд”-ыг үзнэ үү. | | | |
| Тойргийн дээд пристүүдийн бүлгийн удирдагч | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл (бишоптой зөвлөлдсөний үндсэн дээр) | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Бүлгийн гишүүд | Гадасны ерөнхийлөгч эсвэл томилогдсон зөвлөх |
| Тойргийн дээд пристүүдийн бүлгийн удирдагчийн туслахууд | Бүлгийн удирдагч (бишоптой зөвлөлдсөний үндсэн дээр) | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Бүлгийн гишүүд | Гадасны ерөнхийлөгч, томилогдсон зөвлөх эсвэл дээд зөвлөлийн гишүүн |
| Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл (бишоптой зөвлөлдсөний үндсэн дээр) | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Чуулгын гишүүд | Гадасны ерөнхийлөгч |
| Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөхүүд | Чуулгын ерөнхийлөгч (бишоптой зөвлөлдсөний үндсэн дээр) | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Чуулгын гишүүд | Гадасны ерөнхийлөгч, томилогдсон зөвлөх эсвэл дээд зөвлөлийн гишүүн |
| Дээд пристүүдийн бүлэг болон ахлагч нарын чуулгын нарийн бичиг ба багш нар | Бүлгийн удирдагч эсвэл чуулгын ерөнхийлөгч (бишоп, дээд пристүүдийн бүлгийн удирдагчийн туслахууд эсвэл ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөхүүдтэй зөвлөлдөж) | Бишоп | Бүлгийн эсвэл чуулгын гишүүд | Бүлгийн удирдагч эсвэл томилогдсон туслах, чуулгын ерөнхийлөгч эсвэл томилогдсон зөвлөх |
| Гэрийн багш нар | Гэрийн багшлалт нь ахлагчид, дээд пристүүдийн санваартны үүрэг хариуцлага юм. Иймээс бишопын удирдлага дор чуулга, бүлгийн удирдагч нар эдгээр ах нарыг гэрийн багшаар *томилдог*. Тэднийг дуудаж, дэмжүүлж адисалдаггүй. | | | |

## Тойрог дахь Аароны санваарын дуудлагууд

| Алба | Нэр дэвшүүлэх хүн | Батлах хүн | Дэмжих хүмүүс | Дуудаж, адислах хүн |
|---|---|---|---|---|
| Пристүүдийн чуулгын ерөнхийлөгч (бишоп) | “Тойргийн дуудлагууд,” хуудас 177-г үзнэ үү. | | | |
| Пристүүдийн чуулгын ерөнхийлөгчийн туслахууд | Бишоп (пристүүдийн чуулгын ерөнхийлөгч) | Бишопын зөвлөл | Чуулгын гишүүд | Бишоп |
| Багш нарын болон диконуудын чуулгын ерөнхийлөгчид | Бишопын зөвлөл | Бишопын зөвлөл | Чуулгын гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх дуудаж бишоп адисална |
| Багш нарын болон диконуудын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөхүүдийн болон чуулгын нарийн бичиг нар | Чуулгын ерөнхийлөгчид | Бишопын зөвлөл | Чуулгын гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх |
| Пристүүдийн чуулгын зөвлөх (тойргийн Залуу эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч) | Бишопын зөвлөл | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп |
| Багш нарын болон диконуудын чуулгын зөвлөгч нар (тойргийн Залуу эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөхүүд), туслах зөвлөгч нар, тойргийн Залуу эрэгтэйчүүдийн нарийн бичиг | Бишопын зөвлөл | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх |
| Гэрийн багш нар | Гэрийн багшлалт нь ахлагчид, дээд пристүүдийн санваарын үүрэг хариуцлага юм. Иймээс эдгээр ах нарыг бишопын зөвлөл гэрийн багшаар *томилдог*. Тэднийг дуудаж, дэмжүүлж мөн адисалдаггүй. | | | |

## Гадасны харьяа салбаруудын Аароны санваарын дуудлагууд

| Алба | Нэр дэвшүүлэх хүн | Батлах хүн | Дэмжих хүмүүс | Дуудаж, адислах хүн |
|---|---|---|---|---|
| Пристийн чуулгын ерөнхийлөгч (салбарын ерөнхийлөгч нь пристийн чуулгын ерөнхийлөгч байна) | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Салбарын гишүүд | Гадасны ерөнхийлөгч |
| Аароны санваарын бусад дуудлагууд | Хуудас 176 дээрх “Тойрог дахь Аароны санваарын дуудлагууд”-д *бишопыг салбарын ерөнхийлөгч*, *тойргийг салбар* гэдэг үгээр орлуулан ойлгоно уу. | | | |

## Тойргийн дуудлагууд

Дараах хүснэгтэд тойргийн дуудлагуудын жагсаалтыг харуулав. Бусад дуудлагууд болон үйлчлэх боломжуудыг энэ Гарын авлагын бүлэг бүрээс үзэж болно. Хэрэгцээ болон дуудах гишүүдийн хүрэлцээг харгалзан дуудлагуудыг өгнө.

| Алба | Нэр дэвшүүлэх хүн | Батлах хүн | Дэмжих хүмүүс | Дуудаж, адислах хүн |
|---|---|---|---|---|
| Бишоп | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл | Тэргүүн Зөвлөл ба Арванхоёрын Чуулга | Тойргийн гишүүд | Ерөнхий Эрх мэдэлтэн, Бүсийн Дал эсвэл Тэргүүн Зөвлөлөөс бичгээр ирүүлсэн зөвшөөрөл бүхий гадасны ерөнхийлөгч |
| Бишопын зөвлөлийн гишүүд | Бишоп | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Тойргийн гишүүд | Гадасны ерөнхийлөгч эсвэл томилогдсон зөвлөх |
| Тойргийн бичиг хэргийн ажилтан | Бишопын зөвлөл | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Тойргийн гишүүд | Гадасны ерөнхийлөгч эсвэл томилогдсон зөвлөх |
| Тойргийн бичиг хэргийн ажилтны туслахууд | Бишопын зөвлөл | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Тойргийн гишүүд | Гадасны ерөнхийлөгч, томилогдсон зөвлөх эсвэл дээд зөвлөлийн гишүүн |
| Тойргийн гүйцэтгэх нарийн бичиг | Бишопын зөвлөл | Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Тойргийн гишүүд | Гадасны ерөнхийлөгч, томилогдсон зөвлөх эсвэл дээд зөвлөлийн гишүүн |
| Тойргийн номлолын удирдагч | Бишопын зөвлөл | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп |
| Тойргийн номлогчид | Бишопын зөвлөл | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх |
| Тойргийн туслах бүлгүүдийн ерөнхийлөгч (Залуу Эрэгтэйчүүд, Нийгмийн халамжийн бүлэг, Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн Хэсэг, Ням гарагийн анги) | Бишопын зөвлөл | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп |
| Тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөхүүд (Багш нарын болон диконы чуулгын зөвлөгч нар), зөвлөгч нарын туслах, тойргийн Залуу Эрэгтэйчүүдийн нарийн бичиг | Бишопын зөвлөл | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх |
| Тойргийн туслах бүлгүүдийн зөвлөхүүд болон нарийн бичиг нар (Залуу Эрэгтэйчүүдээс бусад) | Туслах бүлгийн ерөнхийлөгч | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх |

### Тойргийн дуудлагууд (үргэлжлэл)

| Алба | Нэр дэвшүүлэх хүн | Батлах хүн | Дэмжих хүмүүс | Дуудаж, адислах хүн |
|---|---|---|---|---|
| Зөвлөгч нар, багш нар, хөгжмийн удирдагчид, түүнчлэн тойргийн туслах бүлгүүд дэх бусад дуудлагууд (Залуу Эрэгтэйчүүдээс бусад) | Туслах бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх |
| Нийгмийн халамжийн бүлгийн айлчлагч багш нар | Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нарыг Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл бишопын удирдлага дор айлчлагч багш нараар *томилдог*. Тэднийг дуудаж, дэмжүүлж мөн адисалдаггүй. | | | |
| Ариун сүмд бэлтгэх семинарын багш (нар) | Бишопын зөвлөл | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх |
| Залуу Эмэгтэйчүүдийн ангийн ерөнхийлөгч | Бишопын зөвлөл (Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй зөвлөлдөж) | Бишопын зөвлөл | Ангийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх |
| Залуу Эмэгтэйчүүдийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөхүүд болон ангийн нарийн бичиг нар | Ангийн ерөнхийлөгч | Бишопын зөвлөл | Ангийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх |
| Тойргийн хөгжмийн тэргүүлэгч | Тойргийн хөгжмийн зөвлөгч (бишопын зөвлөлийн гишүүн) | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх |
| Тойргийн хөгжмийн удирдагч, тойргийн бадралт баг бишгүүрч эсвэл төгөлдөр хуурч, тойргийн найрал дууны удирдагч, хөгжимчин, тойргийн найрал дууны ерөнхийлөгч | Тойргийн хөгжмийн удирдагч | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх |
| Санваартны хөгжмийн удирдагч болон төгөлдөр хуурч эсвэл бадралт баг бишгүүрч | Тойргийн хөгжмийн зөвлөгч (бишопын зөвлөлийн гишүүн) | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх |
| Тойргийн номын санч | Ням гарагийн ангийн ерөнхийлөгч | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх |
| Тойргийн номын санчийн туслахууд | Ням гарагийн ангийн ерөнхийлөгч | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх |
| Гэр бүлийн түүхийн зөвлөх | Бишопын зөвлөл (дээд пристүүдийн бүлгийн удирдагчтай зөвлөлдөж) | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх |

### Тойргийн дуудлагууд (үргэлжлэл)

| Алба | Нэр дэвшүүлэх хүн | Батлах хүн | Дэмжих хүмүүс | Дуудаж, адислах хүн |
|---|---|---|---|---|
| Тойргийн ганц бие залуу насанд хүрэгч-дийн удирдагч | Бишопын зөвлөл | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх |
| Тойргийн сэтгүү-лийн захиалгын төлөөлөгч | Бишопын зөвлөл | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх[1] |
| Тойргийн халам-жийн зохицуулагчид (үүнд тойргийн ажил эрхлэлтийн зохицуулагчид ха-маарна) | Бишопын зөвлөл | Бишопын зөвлөл | Тойргийн гишүүд | Бишоп эсвэл томилогдсон зөвлөх[1] |

[1] Эдгээр дуудлагуудад үйлчлэхээр дуудагддаг гишүүдийг адислах эсэхийг бишоп шийднэ.

## Гадасны харьяа салбарын дуудлагууд

| Алба | Нэр дэвшүүлэх хүн | Батлах хүн | Дэмжих хүмүүс | Дуудаж, адислах хүн |
|---|---|---|---|---|
| Салбарын ерөнхий-лөгч | Гадасны ерөнхий-лөгчийн зөвлөл | Гадасны ерөнхий-лөгчийн зөвлөл ба дээд зөвлөл | Салбарын гишүүд | Гадасны ерөнхийлөгч |
| Салбарын бусад дуудлагууд | Хуудас 177-178 дээрх “Тойргийн дуудлагууд”-д *бишопыг салбарын ерөнхийлөгч*, *тойргийг салбар* гэдэг үгээр орлуулан ойлгоно уу. | | | |

## Номлолын дуудлагууд

| Алба | Нэр дэвшүүлэх хүн | Батлах хүн | Дэмжих хүмүүс | Дуудаж, адислах хүн |
|---|---|---|---|---|
| Номлолын ерөнхий-лөгч | Ерөнхий Эрх мэдэлтэн эсвэл Бү-сийн Дал | Тэргүүн Зөвлөл ба Арванхоёрын Чуулга | Дэмжүүлдэггүй | Тэргүүн Зөвлөлийн эсвэл Арванхоёрын Чуулгын гишүүн |
| Номлолын ерөнхий-лөгчийн зөвлөхүүд | Номлолын ерөнхий-лөгч | Бүсийн эсвэл Далын Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн | Бүх дүүргүүдэд дүүргийн чуулган дээр дэмжүүлнэ | Бүсийн болон Далын Ерөнхийлөгчийн зөв-лөлийн гишүүн эсвэл тэдний удирдлагаар ном-лолын ерөнхийлөгч |
| Номлолын бичиг хэргийн ажилтан, номлолын гүйцэтгэх нарийн бичиг | Номлолын ерөнхий-лөгч | Номлолын ерөнхий-лөгчийн зөвлөл | Бүх дүүргүүдэд дүүргийн чуулган дээр дэмжүүлнэ | Номлолын ерөнхийлөгч |
| Номлолын туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл гэж байдаггүй. Салбарын туслах бүлгүүдийн удирдагчдад илүү туршлагатай бусдаар нь сургалт өгүүлэх шаардлагатай гэж номлолын ерөнхийлөгч үзвэл сургах хүмүүсийг томилж болно. | | | | |

19. Сүм дэх дуудлагууд

## Дүүргийн дуудлагууд

| Алба | Нэр дэвшүүлэх хүн | Батлах хүн | Дэмжих хүмүүс | Дуудаж, адислах хүн |
|---|---|---|---|---|
| Дүүргийн ерөнхийлөгч | Номлолын ерөнхийлөгч | Бүсийн эсвэл Далын Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн | Дүүргийн чуулганд оролцох гишүүд | Номлолын ерөнхийлөгч |
| Дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөхүүд | Дүүргийн ерөнхийлөгч | Номлолын ерөнхийлөгчийн зөвлөл | Дүүргийн чуулган эсвэл дүүргийн санваартны ерөнхий хуралд оролцох гишүүд | Номлолын ерөнхийлөгч эсвэл томилогдсон зөвлөх |
| Дүүргийн зөвлөхүүд, дүүргийн бичиг хэргийн ажилтан, бичиг хэргийн ажилтны туслахууд, гүйцэтгэх нарийн бичиг, туслах бүлгүүдийн удирдагчид | Хуудас 173–174 дээрх “Гадасны дуудлагууд”-д *гадасны ерөнхийлөгчийг дүүргийн ерөнхийлөгч, гадсыг дүүрэг* гэдэг үгээр орлуулан ойлгоно уу. | | | |

## Номлолын харьяа салбаруудын ахлагч нарын чуулгын дуудлагууд

| Алба | Нэр дэвшүүлэх хүн | Батлах хүн | Дэмжих хүмүүс | Дуудаж, адислах хүн |
|---|---|---|---|---|
| Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч | Номлолын эсвэл дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөл | Номлолын ерөнхийлөгчийн зөвлөл эсвэл номлолын ерөнхийлөгч эрх мэдэл олгосон тохиолдолд дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөл | Чуулгын гишүүд | Номлолын ерөнхийлөгч эсвэл томилогдсон тохиолдолд дүүргийн ерөнхийлөгч |
| Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөхүүд | Чуулгын ерөнхийлөгч (салбарын ерөнхийлөгчтэй зөвлөлдөнө) | Номлолын ерөнхийлөгчийн зөвлөл эсвэл номлолын ерөнхийлөгч эрх мэдэл олгосон тохиолдолд дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөл | Чуулгын гишүүд | Номлолын ерөнхийлөгч, томилогдсон тохиолдолд дүүргийн ерөнхийлөгч эсвэл санваарын өөр нэг удирдагч |
| Ахлагч нарын чуулгын нарийн бичиг ба багш нар | Чуулгын ерөнхийлөгч (салбарын ерөнхийлөгч болон чуулгын ерөнхийлөгчийн зөвлөхүүдтэй зөвлөлдөнө) | Салбарын ерөнхийлөгч ба чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл | Чуулгын гишүүд | Чуулгын ерөнхийлөгч эсвэл томилогдсон зөвлөх |
| Гэрийн багш нар | Гэрийн багшлалт нь санваартан ахлагч нарын үүрэг хариуцлага юм. Иймээс салбарын ерөнхийлөгчийн удирдлага дор ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл эдгээр ах нарыг гэрийн багшаар *томилдог*. Тэднийг дуудаж, дэмжүүлж мөн адисалдаггүй. | | | |

## Номлолын харьяа салбаруудын Аароны санваарын дуудлагууд

| Алба | Нэр дэвшүүлэх хүн | Батлах хүн | Дэмжих хүмүүс | Дуудаж, адислах хүн |
|---|---|---|---|---|
| Пристүүдийн чуулгын ерөнхийлөгч (салбарын ерөнхийлөгч нь пристүүдийн чуулгын ерөнхийлөгч байна) | Номлолын эсвэл дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөл | Номлолын ерөнхийлөгчийн зөвлөл | Салбарын гишүүд | Номлолын ерөнхийлөгч, томилогдсон тохиолдолд дүүргийн ерөнхийлөгч |
| Аароны санваарын бусад дуудлагууд | Хуудас 176 дээрх "Тойрог дахь Аароны санваарын дуудлагууд"-д *бишопыг салбарын ерөнхийлөгч*, *тойргийг салбар* гэдэг үгээр орлуулан ойлгоно уу. | | | |

## Номлолын харьяа салбарын дуудлагууд

| Алба | Нэр дэвшүүлэх хүн | Батлах хүн | Дэмжих хүмүүс | Дуудаж, адислах хүн |
|---|---|---|---|---|
| Салбарын ерөнхийлөгч | Номлолын эсвэл дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөл | Номлолын ерөнхийлөгчийн зөвлөл | Салбарын гишүүд | Номлолын ерөнхийлөгч, томилогдсон тохиолдолд дүүргийн ерөнхийлөгч |
| Салбарын ерөнхийлөгчийн зөвлөхүүд | Салбарын ерөнхийлөгч | Номлолын ерөнхийлөгчийн зөвлөл эсвэл номлолын ерөнхийлөгч эрх мэдэл олгосон тохиолдолд дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөл | Салбарын гишүүд | Номлолын ерөнхийлөгч, томилогдсон тохиолдолд түүний зөвлөхүүдийн нэг эсвэл дүүргийн ерөнхийлөгч эсвэл дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөхүүдийн нэг. |
| Салбарын бичиг хэргийн ажилтан, бичиг хэргийн ажилтны туслах, гүйцэтгэх нарийн бичиг | Салбарын ерөнхийлөгчийн зөвлөл | Номлолын ерөнхийлөгчийн зөвлөл эсвэл номлолын ерөнхийлөгч эрх мэдэл олгосон тохиолдолд дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөл | Салбарын гишүүд | Дүүргийн ерөнхийлөгч эсвэл түүний томилсон удирдагч |
| Салбарын туслах бүлгүүдийн удирдагчид ба бусад дуудлагууд | Хуудас 177 дахь "Тойргийн дуудлагууд"-д *бишопыг салбарын ерөнхийлөгч*, *тойргийг салбар* гэдэг үгээр орлуулан ойлгоно уу. | | | |

19. Сүм дэх дуудлагууд

## Цэргийн албан хаагч гишүүдийн бүлгийн дуудлагууд

| Алба | Нэр дэвшүүлэх хүн | Батлах хүн | Дэмжих хүмүүс | Дуудаж, адислах хүн |
|---|---|---|---|---|
| Цэргийн албан хаагч гишүүдийн бүлгийн удирдагч | Гадасны ерөнхий-лөгчийн зөвлөл эсвэл номлолын ерөнхий-лөгч | Гадасны ерөнхий-лөгчийн зөвлөл, дээд зөвлөл эсвэл ном-лолын ерөнхийлөг-чийн зөвлөл | Бүлгийн гишүүд | Гадасны ерөнхийлөгч эсвэл боломжтой бол номлолын ерөнхийлөгч, [1] |
| Цэргийн албан хаагч гишүүдийн бүлгийн удирдагчийн тусла-хууд | Бүлгийн удирдагч | Гадасны ерөнхий-лөгчийн зөвлөл, дээд зөвлөл эсвэл ном-лолын ерөнхийлөг-чийн зөвлөл | Бүлгийн гишүүд | Гадасны ерөнхийлөгч, номлолын ерөнхийлөгч эсвэл тэдний аль нэгээр томилогдсон санваартны удирдагч [1] |

[1] Дайн болж байгаа газар эсвэл алслагдсан бүс нутагт гадасны болон номлолын ерөнхийлөгч нь цэргийн албан хаагч гишүүдийн бүлгийн удирдагч болон туслахуудыг дуудаж, адислах боломжгүй. Дээрх нөхцөл байдалд баримтлах зааврууд *Гарын авлага 1-ийн* 10.5-д байдаг.

# 20. Санваарын ёслолууд ба адислалууд


20.1 **Ерөнхий заавруud . . . . . . . . . . . . . . . . . . . . . 184**

- 20.1.1 Ёслолууд ба адислалуудад оролцох нь . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 184
- 20.1.2 Ёслол эсвэл адислалд оролцохуйц зохистой байдал . . . . . . . . . . . . . . . . . . . . . 184
- 20.1.3 Ёслол болон адислалыг өөр тойрогт гүйцэтгэх нь. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 185
- 20.1.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө ёслолуудыг гүйцэтгэх болон тэднээр ёслолуудыг гүйцэтгүүлэх тухай . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 185
- 20.1.5 Ёслол болон адислалуудыг орчуулах тухай . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 185
- 20.1.6 Ёслол болон адислалуудыг гүйцэтгэх заавар. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 185

20.2 **Хүүхдэд нэр өгч, адислах тухай . . . . . . . . .** 185

- 20.2.1 Ерөнхий удирдамж . . . . . . . . . . . . . . . . . . 185
- 20.2.2 Хүүхдэд нэр өгч, адислах заавруud . . . . 185
- 20.2.3 Адислалын бүртгэл ба гэрчилгээ . . . . . . 186

20.3 **Баптисм ба гишүүний баталгаа . . . . . . . . . 186**

- 20.3.1 Гишүүнчлэлийн бүртгэлтэй хүүхдүүд . . 186
- 20.3.2 Хөрвөгчид. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 186
- 20.3.3 Баптисм ба гишүүний баталгааны ярилцлага . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 186
- 20.3.4 Баптисмын ёслол . . . . . . . . . . . . . . . . . . . . 186
- 20.3.5 Баптисмын усан сан. . . . . . . . . . . . . . . . . . 187
- 20.3.6 Баптисмын хувцас . . . . . . . . . . . . . . . . . . . 188
- 20.3.7 Баптисмын гэрчүүд . . . . . . . . . . . . . . . . . . 188
- 20.3.8 Баптисм гүйцэтгэх заавруud . . . . . . . . . . 188
- 20.3.9 Гишүүний баталгаа ба Ариун Сүнсний бэлэг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 188
- 20.3.10 Гишүүний баталгааг гүйцэтгэх заавруud . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 188
- 20.3.11 Баптисм ба гишүүний баталгааны бүртгэл, гэрчилгээ . . . . . . . . . . . . . . . . . . 189

20.4 **Ариун ёслол . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 189**

- 20.4.1 Ерөнхий удирдамж . . . . . . . . . . . . . . . . . . 189
- 20.4.2 Ариун ёслолыг бэлтгэх нь . . . . . . . . . . . . 190
- 20.4.3 Ариун ёслолыг адисалж, түгээх нь. . . . . 190
- 20.4.4 Ариун ёслолд оролцох боломжгүй гишүүдэд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 190

20.5 **Тосыг ариулан адислах нь . . . . . . . . . . . . . 190**

20.6 **Өвчтөнийг адислах нь . . . . . . . . . . . . . . . . . .191**

- 20.6.1 Ерөнхий удирдамж . . . . . . . . . . . . . . . . . . 191
- 20.6.2 Тос түрхэх нь . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 191
- 20.6.3 Тос түрхэлтийг лацдах нь. . . . . . . . . . . . . 191

20.7 **Санваар олгож, санваарын албанд томилох нь . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .191**

- 20.7.1 Ёслол гүйцэтгэх заавруud . . . . . . . . . . . . . 191
- 20.7.2 Томилолтын бүртгэл ба гэрчилгээ . . . . . 192

20.8 **Эцгийн болон тайтгарлын адислал, зөвлөгөө . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 192**

20.9 **Нутаглуулах газрыг адислах нь. . . . . . . . . 192**

20.10 **Дуудлагатнууд болон багш нарыг адислах нь. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 193**

20.11 **Гэр орныг адислах нь. . . . . . . . . . . . . . . . . . 193**

20.12 **Патриархын адислал . . . . . . . . . . . . . . . . . . 193**

- 20.12.1 Ерөнхий удирдамж . . . . . . . . . . . . . . . . . . 193
- 20.12.2 Патриархын адислал авах нь . . . . . . . . . 193
- 20.12.3 Патриархын адислалын хуулбарыг олж авах нь. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 193

# 20. Санваарын ёслолууд ба адислалууд

Энэ бүлэг санваарын ёслолууд болон адислалуудыг гүйцэтгэх тухай зааврuудыг агуулдаг. Гадасны ерөнхийлөгч, бишопууд *Гарын авлага 1-ийн* 16-р бүлэг -т өгүүлсэн ёслолын журмыг сайн мэддэг байх ёстой.

## 20.1 Ерөнхий заавруyд

Ёслол нь баптисмын нэгэн адил санваарын эрх мэдлээр гүйцэтгэгддэг ариун нандин зан үйл юм. Баптисм, гишүүний баталгаа, Мелкизедек санваарын томилолт (эрэгтэйчүүдийн хувьд), ариун сүмийн хишиг болон лацдан холболтын ёслолууд нь хариуцлага хүлээх чадвартай бүх хүмүүсийн өргөмжлөлд шаардлагатай юм. Эдгээрийг аврах ёслолууд гэдэг. Аврах ёслолуудыг хүлээн авахын тулд гэрээнүүдийг Бурхантай хийдэг.

Авралын ёслолуудыг гүйцэтгэхэд зохих түлхүүрүүдийг эзэмшдэг санваартны удирдагч эсвэл эдгээр түлхүүрийг эзэмшдэг хүний удирдлага дор байгаа санваартны удирдагчийн зөвшөөрөл шаардлагатай. Хүүхдэд нэр өгч адислах, нутаглуулах газар адислах, патриархын адислал өгөх, ариун ёслолыг бэлтгэх, адислах, түгээхэд бас ийм зөвшөөрөл шаардлагатай. Мелкизедек санваартнууд санваартны удирдагчаас зөвшөөрөл авалгүйгээр тосыг ариулан адисалж, өвчтэй хүмүүсийг адислан, эцгийн болон тайтгаруулах адислал, зөвлөгөө өгч болно.

Ёслолууд болон адислалуудыг гүйцэтгэдэг ах нар зохистой амьдарч, Ариун Сүнсээр удирдагдахыг хичээж өөрсдийгөө бэлтгэх хэрэгтэй. Ёслол, адислал бүр нь дараах шаардлагуудыг хангах ёстойг анхааран, тэд үүнийг хүндэтгэлтэйгээр гүйцэтгэх ёстой:

1. Үүнийг Есүс Христийн нэрээр гүйцэтгэх ёстой.
2. Санваарын эрх мэдлээр гүйцэтгэх ёстой.
3. Тусгайлан заасан үг хэллэг, ариулан адисалсан тос зэргийг хэрэглэн, зохих дүрэм журмаар гүйцэтгэх ёстой.
4. Энэ бүлгийн зааврuудын дагуу шаардлагатай бол зохих түлхүүрүүдийг эзэмшдэг тэргүүлэх эрх мэдэлтэн (ихэвчлэн бишоп болон гадасны ерөнхийлөгч) ёслол болон адислалд зөвшөөрөл олгох ёстой.

Ёслол, адислалуудыг хянаж буй санваартны удирдагч нар гүйцэтгэж байгаа хүн нь санваарын шаардагдах эрх мэдэлтэй, зохистой, зохих дүрэм журмыг мэдэж, баримталж байгаа байдлыг анхаарна. Ёслол болон адислалыг хүндэтгэлтэйгээр, сүнслэгээр хийхийг удирдагчид эрэлхийлнэ.

Ёслолууд болон адислалуудыг ариун ёслолын цуглаан дээр гүйцэтгэж байгаа үед зохих журмын дагуу гүйцэтгэхэд бишоп анхаарна. Ёслол буюу адислалын аль нэг чухал хэсэг буруу хийгдвэл санваартныг эвгүй байдалд оруулахаас зайлсхийхийн тулд бишоп алдааг чимээгүй залруулна.

Санваарын адислал өгч байгаа хүмүүс ("Би [эсвэл бид] таныг . . .адисалж байна") гэхчлэн залбирлын үгсийг хэлэхээс биш ("Тэнгэрлэг Эцэг минь ээ, энэ хүнийг . . .адислаач" гэхчлэн хэлэхгүй).

### 20.1.1 Ёслолууд ба адислалуудад оролцох нь

Зохих санваартай бөгөөд зохистой ах нар л тойрогт зогсон ёслол болон адислалыг гүйцэтгэж болно. Оролцогчид нь ихэвчлэн санваартны удирдагчид, гэр бүлийн ойр дотно гишүүд, гэрийн багш нар зэрэг ойр дотно холбоотой хүмүүс нь байна. Гэр бүл, найз нөхөд, удирдагчид гээд олон тооны хүмүүсийг ёслол болон адислалд оролцуулахаар урих ёсгүй. Хэт олон хүн оролцох нь төвөгтөй бас ёслолын сүнсийг бууруулж болно. Ёслол гүйцэтгэж байгаа болон тэргүүлж байгаа хүн байхад л хангалттай. Бусад нь ёслол гүйцэтгэж байгаа хүнийг дэмждэг.

Ёслол болон адислалд нилээд хэдэн ах нар оролцож байгаа үед хүн бүр баруун гараа уг хүний толгой дээр зөөлхөн тавьж (эсвэл адислал авч байгаа нялх хүүхдийн доогуур), зүүн гараа зүүн талдаа байгаа ахын мөрөн дээр тавина.

Хүн ёслол болон адислал хүлээн авч байгаа үед тойрогт цөөхөн ах нар зогсдог боловч ихэвчлэн гэр бүлийн гишүүдийг нь байлцуулахаар урьдаг.

Зохих санваартай, зохистой эцгүүдийг гэр бүлийнхээ гишүүдийн ёслолууд болон адислалуудыг гүйцэтгэх, эдгээрт оролцохыг нь удирдагчид дэмжих ёстой.

### 20.1.2 Ёслол болон адислалд оролцохуйц зохистой байдал

Зөвхөн ариун сүмийн бичигтэй байхуйц зохистой, Мелкизедек санваартан ах нар л хүнийг Сүмийн гишүүнээр батлах, Мелкизедек санваар олгох, энэ санваарын албанд томилох, Сүмийн дуудлагын адислал өгч болно.

Бишоп, гадасны ерөнхийлөгч нар Сүнсээр болон дараах заавраар удирдагдан, ариун сүмд орохуйц зохистой биш санваартан ах нарт ёслол болон адислалуудыг гүйцэтгэх эсвэл оролцох зөвшөөрлийг өгч болдог. Гэхдээ шийдвэрлэгдээгүй ноцтой нүгэл үйлдсэн санваартнуудыг тэргүүлэх эрх мэдэлтэн Ёслол болон адислалд оролцуулах ёсгүй.

Бишоп Мелкизедек санваартай эцэг хүнд ариун сүмд орохуйц бүрэн дүүрэн зохистой биш байлаа ч хүүхэддээ нэр өгч адислах зөвшөөрлийг өгч болно. Үүнтэй адил Мелкизедек санваартан эсвэл прист эцэгт хүүхдүүддээ баптисм хүртээх, хөвгүүддээ Аароны санваарын албанд томилох зөвшөөрлийг бишоп олгож болно. Дээрхтэй адил төстэй нөхцөлд Мелкизедек санваартан өөрийн хүүхдийг гишүүнээр батлагдахад, хөвгүүддээ Мелкизедек санваар олгох, эхнэр хүүхдүүдийг нь адислах үед тойрогт зогсож болно. Гэвч тэрээр үг хэлж ёслолыг гүйцэтгэхгүй.

### 20.1.3 Ёслол болон адислалыг өөр тойрогт гүйцэтгэх нь

Өөрийн харьяа бус тойрогт байгаа санваартан нь хүүхдэд нэр өгч адислах, хүнд баптисм хүртээх, гишүүнээр батлах, оршуулгын адислалд оролцохын тулд ариун сүмийн хүчинтэй эрхийн бичгээ эсвэл Бишопын зөвлөлөөс нэгнийх нь гарын үсэг бүхий Ёслол Гүйцэтгэх Зөвшөөрлийн маягтыг тэргүүлэх эрх мэдэлтэнд үзүүлэх ёстой.

### 20.1.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө ёслолуудыг гүйцэтгэх мөн тэднээр ёслол гүйцэтгүүлэх тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө ёслол гүйцэтгэх мөн тэднээр ёслол гүйцэтгүүлэх тухай удирдамж *Гарын авлага 1-ийн* 16.1.8; 16.1.9-д байдаг.

Сонсголын бэрхшээлтэй хүмүүст ёслолыг хөрвүүлж өгөх тухай удирдамжийг энэ Гарын авлагын 21.1.26-гаас үзнэ үү.

### 20.1.5 Ёслол болон адислалуудыг орчуулах тухай

Ёслол болон адислалуудыг орчуулах тухай удирдамж *Гарын авлага 1-ийн* 16.1.2-т байдаг.

### 20.1.6 Ёслол болон адислалуудыг гүйцэтгэх заавар

Ёслол болон адислалуудыг гүйцэтгэх заавар дараах гарын авлага, товхимлуудад байдаг:

1. Гарын авлагын энэ бүлэг
2. *Гэр бүлийн удирдамж*
3. *Санваарын үүрэг ба адислалууд, Б хэсэг*

Санваартны удирдагчид дээрх гарын авлага, товхимлуудыг ашиглан ёслол, адислалуудыг хэрхэн гүйцэтгэхийг ах нарт заадаг. *Гэр бүлийн удирдамж* болон *Санваарын үүрэг ба адислалууд, Б хэсэг* номууд нь санваартан бүрд байх ёстойг удирдагчид анхаарна.

Хэрэв Тэргүүн Зөвлөл зөвшөөрөл олгоогүй бол санваартны удирдагчид ёслол, адислал, залбирлуудын заврыг агуулсан ном товхимол хэвлэн гаргаж ашиглаж болохгүй.

---

## 20.2 Хүүхдэд нэр өгч адислах тухай

### 20.2.1 Ерөнхий удирдамж

“Христийн сүмийн хүүхэдтэй гишүүн бүр тэднийг Сүмийн өмнө ахлагчдад авчрах ёстой, тэд Есүс Христийн нэрээр тэдэн дээр гар тавин, мөн түүний нэрээр тэднийг адислах ёстой” (С ба Г 20:70). Энэ илчлэлийн дагуу, зөвхөн Мелкизедек санваартнууд хүүхдүүдэд нэр өгч адислахад оролцож болно. Хүүхдүүдэд нь нэр өгч адислахаас өмнө энэ заврын тухай санваартны удирдагчид гишүүдэд мэдээлэх ёстой. Адислалын ариун мөн чанарыг хадгалахын хамт, хувь хүмүүс, гэр бүлүүдийг эвгүй байдалд оруулах буюу гомдоохоос зайлсхийхийн тулд удирдагчид боломжтой бүх хүч чармайлтыг гаргах ёстой.

Хүүхдүүдийг эцэг эхчүүдийнх нь бүртгэлтэй тойргийн мацгийн болон гэрчлэлийн цуглаан дээр нэр өгч адислах нь зүйтэй.

### 20.2.2 Хүүхдэд нэр өгч адислах заврууд

Мелкизедек санваартнууд нялх хүүхдийг адислахдаа тойрог болон зогсож, гараа хүүхдийн нуруун доороос нь барина. Том болсон хүүхдийг адислахдаа ах нар хүүхдийн толгой дээр гараа зөөлхөн тавина. Адислал өгч байгаа хүн:

1. Тэнгэрлэг Эцэгт хандана.
2. Мелкизедек санваарын эрх мэдлээр адислалыг гүйцэтгэж байгааг хэлнэ.
3. Хүүхдэд нэр өгнө.
4. Сүнсний удирдамжаар адислалын үгсийг нэмж хэлнэ.
5. Есүс Христийн нэрээр төгсгөнө.

### 20.2.3 Адислалын бүртгэл ба гэрчилгээ

Хүүхдийг адислахаас өмнө Child Blessing Record (Хүүхдийн адислалын бүртгэл)-ийг бэлтгэнэ. Адислалын дараа энэ маягтыг бөглөж, маягтан дээрх заврын дагуу боловсруулан,

хүргүүлнэ. Бичиг хэргийн ажилтан адислалын гэрчилгээг бэлтгэнэ. Бишоп гэрчилгээнд гарын үсэг зурж өөрөө эсвэл бичиг хэргийн ажилтан хүүхдийн эцэг эх эсвэл асран хамгаалагчид өгнө.

Хэрэв бутач хүүхэд байвал гишүүнчлэлийн бүртгэл болон гэрчилгээн дээрх нэр нь төрсний гэрчилгээ эсвэл иргэний бүртгэл мэдээллийн нэртэй тохирч байх ёстой. Хэрэв төрсний гэрчилгээ болон иргэний бүртгэл мэдээлэл байхгүй бол хүүхдэд нэр өгөхдөө тухайн орон нутгийн заншлыг баримтална.

## 20.3 Баптисм ба гишүүний баталгаа

### 20.3.1 Сүмд бүртгэлтэй хүүхдүүд

Тэргүүлэх эрх мэдэлтний удирдлага дор Сүмд бүртгэлтэй хүүхдүүдэд 8 нас хүрэхэд нь эсвэл хүрснээс нь хойш аль болохоор түргэн баптисм хүртээж, гишүүнээр батлах ёстой. Энэ нь Сүмд гишүүний бүртгэлтэй хүүхдүүдэд хамаарна.

Бишоп тойрог дахь долоон настай хүүхдүүдийг тусгайлан анхаарч, тэдний эцэг эхчүүд, Хүүхдийн Хэсгийн удирдагчид болон багш нар, гэрийн багш нар нь баптисмд бэлтгэхэд нь тэдэнд туслан, анхааралдаа авч ажилладаг. Мелкизедек Санваартны болон Нийгмийн халамжийн бүлгийн удирдагчид эцэг эхчүүдийг хүүхдүүддээ заах, уг ёслолд бэлтгэхэд нь дэмждэг. Бишоп хүүхдүүдийг найман нас хүрмэгц тэднийг сайн мэдээг хүлээн авч, баптисм хүртэж гишүүнээр батлуулах боломжтой эсэхэд анхаарал хандуулна.

### 20.3.2 Хөрвөгчид

*Гарын авлага 1-ийн* 16.3.3 дахь "Ярилцлагын заавар"-т өгүүлсэн шаардлагуудыг хангасан үед хөрвөгчид баптисм хүртэж, гишүүнээр батлагдах ёстой.

Хөрвөгчдийн баптисм гэдэг нь (1) урд өмнө нь баптисм хүртэж, гишүүнээр батлуулж байгаагүй ес болон түүнээс дээш настай хүмүүсийн баптисм, (2) эцэг эх нь гишүүн бус найман настай хүүхдүүд эсвэл тэд хүүхэдтэйгээ хамт баптисм хүртэж байгааг хэлнэ.

### 20.3.3 Баптисм ба гишүүний баталгааны ярилцлага

Бишоп эсвэл томилогдсон зөвлөх Сүмд бүртгэлтэй 8 настай хүүхдүүд болон Сүмд бүртгэлгүй боловч эцэг эхийн аль нэг нь эсвэл асран хамгаалагч нь гишүүн 8 настай хүүхдүүдийн баптисм ба гишүүний баталгааны ярилцлагыг хийнэ.

Бүрэн цагийн номлогчид хөрвөгчидтэй баптисм ба гишүүний баталгааны ярилцлага хийдэг (20.3.2-т тодорхойлсноор).

Ярилцлагын заавар *Гарын авлага 1-ийн* 16.3.3-т байдаг.

### 20.3.4 Баптисмын ёслол

Баптисмын ёслол энгийн, товч, сүнслэг байх ёстой. Тойргийн болон гадасны удирдагчид тухайн тойрог, гадас дахь Сүмд бүртгэлтэй найман настай бүх хүүхдийн баптисмын ёслолыг сар бүр хөтлөн явуулдаг. Гишүүд баптисмын ёслолыг дурын өдрөө, санаандаа нийцүүлэн хийхийг хүсэх ёсгүй.

Баптисмын ёслолд гэр бүлийн гишүүд, төрөл төрөгсөд, найз нар, санваартны удирдагчид, гэрийн болон айлчлагч багш нар, туслах бүлгийн удирдагчид, шинэ гишүүнд заах багш нар, хичээл заалгаж байгаа сонирхогчдыг урьж болно. Тойргийн бусад гишүүд оролцож болно.

Баптисмын ёслолыг даваа гарагийн орой төлөвлөх ёсгүй.

#### Нэг тойргийн баптисмын ёслол

*Сүмд бүртгэлтэй найман настай хүүхдүүдэд зориулсан ёслол.* Баптисмын ёслолд зөвхөн нэг тойрог хамрагдсан үед бишопын зөвлөлийн гишүүн Сүмд бүртгэлтэй найман настай хүүхдүүдийн баптисмын ёслолыг тэргүүлнэ.

Бишопын зөвлөлийн гишүүн баптисмын ёслолд хяналт тавина. Тэрээр ёслолыг хөтөлж болно. Эсвэл ёслолыг хөтлүүлэхээр тойргийн номлолын удирдагчийг томилно. Хүүхдийн Хэсгийн удирдагчид бишопын зөвлөлийн удирдлага дор эдгээр ёслолыг төлөвлөхөд тусалж болно.

*Хөрвөгчдөд зориулсан ёслол.* Боломжтой бол бишопын зөвлөлийн гишүүн хөрвөгчдийн баптисмын ёслол бүрд оролцоно. Ёслолд зөвхөн нэг тойрог оролцож байгаа тохиолдолд гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн оролцоогүй бол бишопын зөвлөлийн гишүүн тэргүүлнэ.

Бишопын зөвлөлийн удирдлага дор тойргийн номлолын удирдагч эдгээр баптисмын ёслолыг төлөвлөхөд бүрэн цагийн номлогчидтой хамтран ажилладаг. Бишопын зөвлөлийн гишүүн эсвэл тойргийн номлолын удирдагч ихэвчлэн ёслолыг хөтлөн явуулдаг. Хэрэв тойргийн эдгээр удирдагчдын аль нь ч боломжгүй бол бүрэн цагийн номлолын дүүргийн эсвэл бүсийн удирдагч номлолын ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр ёслолыг төлөвлөн явуулж болно.

#### Нэгээс илүү тойргийг хамарсан баптисмын ёслол

*Сүмд бүртгэлтэй найман настай хүүхдүүдэд зориулсан ёслол.* Ёслолд нэгээс дээш тооны тойрог хамрагдаж байгаа үед Сүмд бүртгэлтэй найман настай хүүхдүүдэд зориулсан баптисмын ёслолыг гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн тэргүүлнэ. Гэвч гадасны ерөнхийлөгчийн зөвлөл нь тэргүүлэх эрх мэдлийг дээд зөвлөлийн гишүүнд олгож болно. Ёслолд тойрог бүрээс бишопын зөвлөлийн гишүүн оролцох ёстой

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл дээд зөвлөлийн гишүүнийг ёслолын хөтөлбөрийг хянаж, хөтлүүлэхээр томилж болно. Хүүхдийн Хэсгийн удирдагчид тэргүүлэх эрх мэдэлтний удирдлага дор эдгээр ёслолыг төлөвлөхөд тусалж болно.

*Хөрвөгчдөд зориулсан ёслол.* Ёслолд нэгээс олон тойрог хамрагдсан үед хөрвөгчдийн баптисмын ёслолыг ихэвчлэн гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн тэргүүлнэ. Гэвч гадасны ерөнхийлөгчийн зөвлөл нь тэргүүлэх үүргийг дээд зөвлөлийн гишүүнд олгож болно. Ёслолд тойрог бүрээс бишопын зөвлөлийн нэг гишүүн оролцох ёстой.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл нь дээд зөвлөлийн гишүүн эсвэл бишопыг баптисмын ёслолын хөтөлбөрийг хянаж хөтлөн явуулахаар томилж болно.

#### Хөрвөгчдийн баптисмын ёслолыг төлөвлөх нь

Сонирхогч баптисм хүртэх амлалт өгснөөс хойш баптисмын ёслолыг аль болохоор хурдан төлөвлөх ёстой. Тухайн хүн бэлэн биш байхаас бусад шалтгаанаар товлосон өдрийг хойшлуулдаггүй. Мөн гэр бүлийн гишүүдийн баптисмыг эцэг нь санваар хүртэж, баптисмыг гүйцэтгэхийг хүлээх шалтгаанаар хойшлуулах ёсгүй.

Хөрвөгчдийн баптисмыг тойргийн номлолын удирдагчаар дамжуулан төлөвлөх ёстой. Хэрэв ёслолыг ням гарагт төлөвлөсөн бол ням гарагт тогтмол болдог цуглаануудтай давхацахгүй тохиромжтой цагт төлөвлөх ёстой.

#### Баптисмын ёслолын бүрэлдэхүүн хэсгүүд

Баптисмын ёслолд дараах зүйлүүд орж болно:

1. Оршил хөгжим.
2. Баптисмын ёслолыг хөтлөн явуулж байгаа санваартны удирдагч товч үг хэлж нээх.
3. Нээлтийн дуулал ба залбирал.
4. Баптисм, Ариун Сүнс зэрэг сайн мэдээний сэдвүүдээр нэгээс хоёр хүн товчхон үг хэлэх.
5. Дуулал дуулах.
6. Баптисмыг гүйцэтгэх (20.3.8-ыг үз).
7. Баптисмд оролцсон хүмүүс хуурай хувцас сольж өмсөх үед цугларагсад хүндэтгэлтэй байна. Энэ үеэр дундын хөгжим тоглож, сайн мэдэх дуулалуудаас болон Хүүхдийн Хэсгийн дуунуудаас дуулж болно. Мөн баптисмын ёслолд оролцсон гишүүн бус хүмүүст зориулж бүрэн цагийн номлогчид сайн мэдээний тухай товч танилцуулга хийж болно.
8. Гишүүнээр батлах. (Сүмд бүртгэлтэй 8 настай хүүхдүүд мацаг ба гэрчлэлийн ням гарагт гишүүнээр батлуулахгүй бол, 20.3.9 болон 20.3.10-г үзнэ үү)
9. Шинэ хөрвөгчид хүсвэл тэдэнд гэрчлэлээ хуваалцах боломжийг олгож болно.
10. Хаалтын дуулал ба залбирал.
11. Төгсгөлийн хөгжим.

### 20.3.5 Баптисмын усан сан

Номлогчид баптисмын усан санг бэлтгэх ажлыг төлөөлөгч бишоп болон гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн томилсон өөр хэн нэгэнтэй хамтран зохион байгуулна. Баптисмын усан санг ашиглах хуваарь нь долоо хоногт нэг эсвэл шаардлагатай бол түүнээс олон удаа баптисм хийх боломжийг номлогчдод олгох ёстой. Гэвч баптисмын усан санг номлогчид тохиромжгүй үеэр ашиглахаар хүсч болохгүй. Баптисмын усан санг ашигласны төлөө төлбөр авч болохгүй.

Баптисмын усан санг усаар дүүргэх үед хариуцлага бүхий насанд хүрсэн хүн дэргэд нь байж, усийг юүлж дуустал нь хариуцна. Баптисмын ёслол бүрийн дараа усан сангаас усыг тэр даруйд юүлж, усан санг цэвэрлэж байх ёстой. Баптисмын сан устай байгаа үед аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах ёстой.

Баптисмын усан санг ашиглаагүй үед нэвтрэх бүх хаалгыг хааж, цоожилсон байх ёстой.

Баптисмын усан сан байхгүй бол баптисм гүйцэтгэх санваартан баптисм хүртэх хүний хамт дотор нь зогсож, түүнийг умбуулахад хангалттай хэмжээний, аюулгүй байдал хангагдсан ямар ч газрыг баптисмд зориулан ашиглаж болно. Баптисмд зориулан усыг адисалдаггүй.

### 20.3.6 Баптисмын хувцас

Баптисм хүртээж байгаа болон хүртэж байгаа хүн норсон үед бие нь нэвт гэрэлтэн харагдахгүй цэвэрхэн, цагаан хувцас өмссөн байна. Ариун сүмийн хишиг хүртсэн хүн баптисм гүйцэтгэх үедээ энэ хувцасны дотуур ариун сүмийн гарментаа өмсөнө.

Орон нутгийн нэгжүүд баптисмын хувцастай байх ёстой бөгөөд үүнийг хэрэглүүлсний төлөө хураамж авах ёсгүй. Хувцсыг төсвийн мөнгөөр худалдаж авна. Хувцсыг цэвэрлэж, засварлахыг бишоп гишүүдээс хүсч болно.

### 20.3.7 Баптисмын гэрчүүд

Баптисм бүрд хоёр прист эсвэл Мелкизедек санваартан ёслол зохих ёсоор гүйцэтгэгдсэнийг гэрчилнэ. Хэрэв үгс нь Сургаал ба Гэрээ 20:73-т өгөгдсөнтэй яг тохироогүй, хүний бие эсвэл хувцас усанд бүрэн дүрэгдээгүй бол баптисмыг дахин үйлдэх ёстой.

### 20.3.8 Баптисм гүйцэтгэх зааврууд

Тэргүүлэх эрх мэдэлтний удирдлага дор зохистой прист эсвэл Мелкизедек санваартан баптисмын ёслолыг гүйцэтгэж болно. Үүний тулд тэрээр:

1. Баптисм хүртэж байгаа хүнтэй хамт усан дотор зогсоно.
2. Уг хүний баруун шууг зүүн гараараа барина (сандрахгүй мөн аюулгүй байдлын тулд), баптисм хүртэж байгаа хүн санваартны зүүн шууг зүүн гараараа барина.
3. Баруун гараа тэгш өнцөг гарган өргөнө.
4. Уг хүний бүтэн нэрийг хэлээд, "Есүс Христийн итгэмжилснээр би танд Эцэг, мөн Хүү, мөн Ариун Сүнсний нэрээр баптисм хүртээж байна. Амен" (С ба Г 20:73) гэж хэлнэ.
5. Уг хүний хамрыг баруун гараар нь чимхүүлнэ (сандрахгүй байхын тулд), тэгээд санваартан баруун гараа уг хүний нурууны дээд хэсэгт байрлуулж, хувцастай нь усанд бүрэн умбуулна.
6. Уснаас гарч ирэхэд нь уг хүнд тусална.

Хөрвөгчийн баптисмыг ихэндээ тухайн тойргийн нэг санваартан эсвэл түүнд заасан номлогчдын нэг нь гүйцэтгэдэг. Хөрвөгч нь баптисм гүйцэтгэх зохистой гишүүнийг өөрөө сонгож болно.

### 20.3.9 Гишүүний баталгаа ба Ариун Сүнсний бэлэг

Хүн баптисм хүртсэнийхээ дараа Сүмийн гишүүнээр батлагдаж, Ариун Сүнсний бэлэг хүлээн авдаг (С ба Г 20:41-ийг үз). Баптисм ба гишүүний баталгаа хийгдсэний дараа тухайн хүн Сүмийн гишүүн болдог (Иохан 3:5, С ба Г 33:11-г үз).

Сүмд бүртгэлтэй 8 настай хүүхдүүдийг гишүүнээр батлах түлхүүрүүдийг бишоп эзэмшдэг. Номлолын ерөнхийлөгч хөрвөгчдийг гишүүнээр батлах түлхүүрүүдийг эзэмшдэг. Гэвч бишоп энэ ёслол нь гишүүний бүртгэлтэй 8 настай хүүхдийнх эсвэл хөрвөгчийнх гэдгээс үл харгалзан уг ёслолын гүйцэтгэлд хяналт тавина. Уг ёслолыг баптимсын дараа удалгүй гүйцэтгэхэд бишоп анхаарна.

Сүмд бүртгэлтэй найман настай гишүүдийг баптисмын ёслол дээр эсвэл тэдний амьдардаг тойргийн ариун ёслолын цуглаан боломжтой бол мацгийн болон гэрчлэлийн цуглаан дээр гишүүнээр батална.

Хөрвөгчид амьдардаг тойргийнхоо аль ч ариун ёслолын цуглаан дээр, боломжтой бол баптимсын дараах ням гарагт гишүүнээр батлагдана. Хөрвөгчид баптисмын ёслол дээр гишүүнээр батлагддаггүй.

Бишопын зөвлөлийн нэг гишүүн энэ ёслолд заавал оролцоно. Номлогч ахлагч нар хөрвөгчид хичээлийг нь заасан бол бишоп тэднийг оролцохыг урина.

Бишоп гишүүний баталгаа өгөхийн тулд ярилцлага хийхгүй.

### 20.3.10 Гишүүний баталгааг гүйцэтгэх заавар

Бишопын зөвлөлийн удирдлага дор нэг болон түүнээс дээш Мелкизедек санваартан энэ ёслолд оролцож болно. Тэд гараа уг хүний толгой дээр зөөлөн тавина. Тэгээд ёслолыг гүйцэтгэж байгаа хүн:

1. Уг хүний бүтэн нэрийг хэлнэ.
2. Мелкизедек санваарын эрх мэдлээр ёслолыг гүйцэтгэж байгааг хэлнэ.
3. Уг хүнийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнээр батална.
4. "Ариун Сүнсийг хүлээн авна уу" гэж хэлнэ ("Ариун Сүнсний бэлгийг хүлээн авна уу" гэхгүй).
5. Сүнсний удирдамжаар адислалын үгсийг нэмж хэлнэ.
6. Есүс Христийн нэрээр төгсгөнө.

#### 20.3.11 Баптисм ба гишүүний баталгааны бүртгэл, гэрчилгээ

Бишоп эсвэл томилогдсон зөвлөх 8 настай хүүхэдтэй ярилцлага хийхдээ Баптисм ба Гишүүний баталгааны бүртгэлийг уг маягтан дээрх зааврын дагуу бөглөнө. Баптисм ба гишүүний баталгааны дараа тойргийн бичиг хэргийн ажилтан уг хүүхдийн гишүүнчлэлийн бүртгэлийг шинэчлэхийн тулд Баптисм ба Гишүүний баталгааны маягтан дээрх мэдээллийг ашиглана.

Бүрэн цагийн номлогч баптисм хийлгэх гэж байгаа хөрвөгчтэй ярилцлага хийж, гишүүний баталгааны тухай хэсгээс бусад Баптисм ба Гишүүний баталгааны маягтын бүх асуултыг бөглөнө. Баптисмын ёслол дээр номлогч энэ маягтыг бишопт эсвэл түүний зөвлөхүүдийн нэгэнд өгнө. Гишүүний баталгааны дараа бишоп эсвэл тойргийн бичиг хэргийн ажилтан гишүүний баталгааны мэдээллийг бөглөнө. Тойргийн бичиг хэргийн ажилтан маягтын хоёр хувийг бүрэн цагийн номлолгчдод эргүүлж өгнө. Номлогчид нэг хувийг нь гишүүнчлэлийн бүртгэл нээхийн тулд номлолын албанд илгээнэ.

Баптисм ба Гишүүний баталгааны бүртгэлийг зохих ёсоор бөглөж, бэлтгэх нь гишүүнчлэлийн бүртгэл нээх, шинэчлэхэд чухал юм.

Гишүүний баталгааны дараа тойргийн бичиг хэргийн ажилтан баптисм ба гишүүний баталгааны гэрчилгээг бэлтгэнэ. Бишоп гэрчилгээнд гарын үсэг зурж, өөрөө эсвэл бичиг хэргийн ажилтнаар гэрчилгээг гишүүнд гардуулж өгнө.

Орон нутгийн хууль, ёс заншлаар тодорхойлогдсон тухайн хүний хууль ёсны нэрийг томилолтын бүртгэл, гэрчилгээн дээр бичих ёстой.

## 20.4 Ариун ёслол

### 20.4.1 Ерөнхий удирдамж

Сүмийн гишүүд Бурханыг шүтэн биширч, ариун ёслолоос хүртэхийн тулд Хүндэтгэлийн өдөр цугладаг (С ба Г 20:75, 59:9-г үз). Энэ эрхэм ариун ёслолын үед тэд баптисмын гэрээнүүдээ шинэчлэхийн тулд Аврагчийн бие, цусыг төлөөлөн дурсаж талх, ус хүртдэг (Матай 26:26-28, Иосеф Смитийн Орчуулга, Марк 14:20-25, Лук 22:15-20, 3 Нифай 18, Моронай 6:6-г үзнэ үү).

Бишопын зөвлөлийн удирдлага дор санваартнууд ариун ёслолын цуглаан бүр дээр ариун ёслолыг адисалж, цугларсан гишүүдэд түгээдэг. Эдгээр үүргийг ихэвчлэн Аароны санваартнууд гүйцэтгэдэг. Бишопын зөвлөлийн удирдлага дор ариун ёслолыг түгээхэд туслахад бусдыг урих онцгой боломж, үүрэг хариуцлага диконы чуулгын ерөнхийлөгчид байдаг. Хангалттай тооны диконууд байхгүй үед өөр тусалж болох хүмүүсийн талаар Бишопын зөвлөлийн гишүүнтэй зөвлөлдөх ёстой.

Ариун ёслолыг түгээхийг Мелкизедек санваартнуудаас хүсэхээс өмнө Аароны санваарын багш, пристүүдийг урих ёстой. Хангалттай тооны Аароны санваартнууд байгаа үед Мелкизедек санваартнуудыг ариун ёслолыг түгээхэд урих шаардлагагүй.

Энэ ёслолд оролцдог санваартан бүр Их Эзэний нэрийн өмнөөс үйлдэж байгаагаа ойлгох хэрэгтэй. Санваартнууд ариун ёслолыг бэлтгэж, адисалж, түгээхдээ Аврагчийн Цагаатгалын тухай тунгаан боддог байхад бишопын зөвлөл тэднийг дэмждэг. Санваартнууд энэ ёслолд оролцохдоо гүн хүндэтгэлтэй байх хэрэгтэйг бишопын зөвлөл анхаарна.

Ариун ёслолыг адисалж, түгээдэг хүмүүс даруу хувцаслаж, үсээ засуулсан, цэвэр цэмцгэр байх ёстой. Хувцаслалт болон зүүлт чимэг нь ариун ёслолын үед гишүүдийн анхаарлыг татахааргүй байх ёстой. Цагаан цамц, зангиа нь ёслолыг хүндэтгэлтэй болгодог тул өмсөхийг зөвлөдөг. Гэвч санваартны хувьд ёслолд оролцоход үүнийг заавал биелүүлэх шаардлагагүй. Хувцас, гадаад байдлаараа бүгд адилхан байх шаардлагагүй. Бишопууд залуу эрэгтэйчүүдэд энэ талын удирдамж өгөхдөө, тэдний санхүүгийн боломж, Сүмд төлөвшиж боловсорсон байдлыг нь харгалзан, болгоомжтой хандах ёстой.

Энэ ёслолын ариун нандин мөн чанар нь дэг жаяг, хүндэтгэлийн үүднээс анхаарал, бэлтгэлийг шаарддаг нь зүй ёсны юм. Ариун ёслолыг адисалж, түгээх үүргийг урьдчилан өгөх ёстой. Оролцогч хүмүүс цуглаан эхлэхээс өмнө хүндэтгэлтэйгээр суудлаа эзэлсэн байх ёстой.

Ариун ёслолыг түгээх нь хатуу чанд эсвэл хэт нүсэр биш, энгийн байх ёстой. Зүүн гараа ар талдаа авах зэрэг аливаа өвөрмөц содон төрх байдал, үйлдлийг ариун ёслол түгээгчдээс шаардах ёсгүй. Ариун ёслолыг түгээх үйл явц нь гишүүдийн анхаарлыг уг ёслолын зорилгоос сарниулахааргүй байх ёстой.

Ариун ёслолыг бэлтгэх, адислах, түгээхийн өмнө санваартнууд гараа савангаар угаах, эсвэл нэг удаагийн чийгтэй алчуур, ариутгагч зэргээр сайн арчих хэрэгтэй.

Ноцтой гэм нүгэл үйлдсэн санваартан наманчилж, уг асуудлыг бишоптойгоо хамтран шийдвэрлэх хүртэл ариун ёслолыг бэлтгэх, адислах, түгээх ёсгүй.

Хэдийгээр ариун ёслол Сүмийн гишүүдэд зориулагдсан ч, үүнийг зөвхөн гишүүдэд түгээх ёстой гэж Бишопын зөвлөл зарлах ёсгүй мөн гишүүн бус хүмүүсийг ариун ёслолоос хүртэхийг хорих ёсгүй.

### 20.4.2 Ариун ёслолыг бэлтгэх нь

Зохистой багш, прист, Мелкизедек санваартнууд ариун ёслолыг бэлтгэж болно. Ариун ёслолыг бэлтгэдэг хүмүүс жижиглээгүй талхтай талхны сав, цэвэр усаар дүүргэсэн аяганууд, тэрчлэн ширээний цэвэрхэн бүтээлгүүд зэргийг цуглаан эхлэхээс өмнө бэлдсэн байх ёстой. Цуглааны дараа эдгээр ах нар талхны сав, ширээний бүтээлгийг цэвэрлэнэ.

Ариун ёслолын ширээний бүтээлгүүд цагаан, нэвт гэрэлтэж харагддаггүй, цэвэрхэн, индүүдсэн байх ёстой. Ариун ёслолын талхны савыг цэвэрхэн байлгах ёстой. Ариун ёслолын талхны сав, аяганparticle удыг Сүмийн Хангамжийн Төвөөс авна.

### 20.4.3 Ариун ёслолыг адисалж, түгээх нь

Зохистой пристүүд болон Мелкизедек санваартнууд ариун ёслолыг адисалж болно. Зохистой дикон, багш, прист, Мелкизедек санваартнууд ариун ёслолыг түгээж болно.

Цугларгсад ариун ёслолын дуулал дуулж байх үед ариун ёслолыг адислах санваартнууд хүндэтгэлтэйгээр зогсон, талхны савнуудыг бүтээсэн бүтээлгийг сөхөж, талхыг жижиг хэсэг болгон хуваана. Тэд талхыг жижиглэн хувааж дууссаны дараа сууж, дуулал дуулахад нэгдэнэ. Энэ дууллыг гоцлон дуулаачдаар дуулуулах буюу хөгжмийн зэмсгүүдээр орлуулж болохгүй.

Дууллын дараа талх адислах хүн өвдөг сөгдөж, ариун ёслолын талхны залбирлыг хэлнэ. Ариун ёслолын залбирлыг Их Эзэн илчилсэн юм (С ба Г 20:77, 79, Моронай 4—5-г үзнэ үү). Залбирлуудыг тод, зөв, хүндэтгэлтэй хэлэхэд бишоп анхаарал тавина. Хэрэв ариун ёслолыг адисалж байгаа хүн үгийг хэлэхэд алдаа гаргаад, үүнийг өөрөө залруулах юм бол дахин залруулах шаардлагагүй. Хэрэв хүн алдааг залруулаагүй бол залбирлыг тэрээр зөв болгон давтаж хэлэхийг бишоп сануулна. Ингэхдээ бишоп уг хүнийг ичээх болон ёслолын ариун нандин мөн чанарыг алдагдуулахаас зайлсхийхийн тулд болгоомжтой байх ёстой.

Залбирлын дараа диконууд эсвэл бусад санваартнууд талхыг цугларгсдад хүндэтгэлтэйгээр, зохих ёсоор тараана. Тэргүүлэх эрх мэдэлтэн ариун ёслолыг эхлээд хүртэнэ. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн, Бүсийн Дал эсвэл Ерөнхий Эрх мэдэлтэн индэр дээр суугаагүй бол бишоп (эсвэл эзгүй үед зөвлөх нь) ариун ёслолын цуглааныг тэргүүлнэ. Дээд зөвлөлийн гишүүн цуглааныг тэргүүлдэггүй мөн ариун ёслолоос эхэлж хүртдэггүй.

Тэргүүлэх эрх мэдэлтэн ариун ёслолоос хүртэхэд, ариун ёслол түгээж байгаа бусад хүмүүс ноогдсон газрууд уруугаа очно.

Санваартан ариун ёслолын савыг гишүүнд өгсний дараа бусад нь савыг тохиромжтой байдлаар нэгээс нөгөөд дамжуулж болно.

Ах нар талхыг түгээж дуусаад, савыг ариун ёслолын ширээн дээр буцааж тавина. Ариун ёслолын ширээний дэргэд ёслол гүйцэтгэж байгаа хүмүүс талхны савыг бүтээлгээр бүтээж, усны аяганы бүтээлгийг сөхнө. Тэгээд ус адислах хүн өвдөг сөгдөж, ариун ёслолын усны залбирлыг хэлэхдээ (С ба Г 20:79-ийг үзнэ үү), *дарс* гэдэг үгийг *ус* гэдэг үгээр орлуулна.

Залбирлын дараа диконууд болон бусад санваартнууд усыг цугларгсдад түгээнэ. Тэд дуусгаад савуудыг ариун ёслолын ширээн дээр буцаан тавьж, ёслол гүйцэтгэгчид савуудыг бүтээхийг хүлээгээд, дараа нь хүндэтгэлтэйгээр суудлаа эзэлнэ.

Цуглаанд оролцож байгаа хүн бүр ариун ёслолыг адислах, түгээх ёслолын үед хүндэтгэлтэй байх ёстой.

Залбирлын үед, ариун ёслолыг түгээж байх үед мөн түгээсний дараа хөгжим тоглох ёсгүй.

### 20.4.4 Ариун ёслолд оролцох боломжгүй гишүүдэд

18.2.2 дахь "Онцгой нөхцөл дэх ариун ёслолын үйлчлэл"-г үзнэ үү.

---

## 20.5 Тосыг ариулан адислах нь

Нэг буюу түүнээс дээш Мелкизедек санваартан өвчтэй буюу зовж шаналсан хүмүүст түрхэж хэрэглэхээс өмнө чидун тосыг ариулан адислах ёстой. Өөр тос ашиглаж болохгүй. Тосыг ариулан адислахын тулд санваартан:

1. Чидун тосны онгойлгосон савыг гартаа барина.
2. Тэнгэрлэг Эцэгт хандана.
3. Тэрээр Мелкизедек санваарын эрх мэдлээр үйлдэж байгаагаа хэлнэ.
4. Тосыг ариулан адисална (савыг биш), тэгээд үүнийг өвчтэй болон зовж шаналсан хүмүүст түрхэж, адислахын тулд адисална.
5. Есүс Христийн нэрээр төгсгөнө.

Ариулан адисалсан тосыг гишүүд уух болон биеийн гэмтэж бэртсэн хэсгүүд дээр түрхэн хэрэглэх ёсгүй.

## 20.6 Өвчтөнийг адислах нь

### 20.6.1 Ерөнхий удирдамж

Зөвхөн Мелкизедек санваартнууд өвчтэй болон зовж шаналсан хүмүүсийг адисалж болно. Хоёр эсвэл түүнээс дээш санваартан өвчтэй хүнийг адисалдаг боловч шаардлага гарвал нэг хүн тос түрхэх, батлах аль алиныг нь ганцаараа гүйцэтгэж болно. Хэрэв ариулан адисалсан тос байхгүй бол тос түрхэлгүйгээр санваарын эрх мэдлээр адислал өгч болно.

Ер нь Мелкизедек санваартай эцэг гэр бүлийнхээ өвчтэй гишүүдийг адислах ёстой.

Өвчтэй хүний хүсэлтээр эсвэл адислал нь тэдний итгэлийн дагуу байх болно гэдэгт ихэд санаа тавиж байгаа хүмүүсийн хүсэлтээр ах нар өвчтэй хүмүүсийг адислана (С ба Г 24:13–14, 42:43–44, 48–52-г үзнэ үү). Эмнэлэгт очиж байгаа Мелкизедек санваартнууд өвчтэй хүмүүсийг адислах боломжуудыг гуйх ёсгүй.

Хэрэв нэг хүн өвдсөн үедээ нэгээс илүү адислал хүсвэл санваартан эхний адислалаас хойш тос түрхэх хэрэггүй. Үүний оронд тэрээр гар тавилтаар, Мелкизедек санваарын эрх мэдлээр адислал өгнө.

Өвчтөнийг адислах нь (1) тос түрхэлт, (2) тос түрхэлтийг батлах гэсэн хоёр хэсгээс бүрддэг.

### 20.6.2 Тос түрхэх нь

Тос түрхэлтийг Мелкизедек санваартан гүйцэтгэнэ. Тэр:

1. Уг хүний толгой дээр ариулан адисалсан тосыг дусаана.
2. Уг хүний толгой дээр гараа зөөлөн тавьж, түүнийг бүтэн овог нэрээр нь дуудна.
3. Тэрээр Мелкизедек санваарын эрх мэдлээр үйлдэж байгаагаа хэлнэ.
4. Өвдсөн болон зовж шаналсан хүмүүст түрхэж, адислахын тулд ариулан адисласан тосыг түрхэж байгаагаа хэлнэ.
5. Есүс Христийн нэрээр төгсгөнө.

### 20.6.3 Тос түрхэлтийг лацдах нь

Хоёр буюу түүнээс олон Мелкизедек санваартан уг хүний толгой дээр гараа зөөлөн тавина. Тослогоог лацдаж байгаа хүн:

1. Уг хүнийг бүтэн овог нэрээр нь дуудна.
2. Мелкизедек Санваарын эрх мэдлээр тосолгоог лацдаж байгаагаа хэлнэ.
3. Сүнсний удирдамжаар адислалын үгсийг нэмж хэлнэ.
4. Есүс Христийн нэрээр төгсгөнө.

## 20.7 Санваар олгож, албанд томилох нь

Гадасны ерөнхийлөгч Мелкизедек санваар олголт болон ахлагч, дээд пристийн албанд томилох томилолтод хяналт тавидаг. Гэвч бишоп ихэвчлэн томилох хүмүүсийг санал дэвшүүлдэг. Эдгээр ах нарыг санваарын томилолт болон санваарын албанд санал дэвшүүлэх, ярилцлага хийх, дэмжүүлэхээр танилцуулах тухай *Гарын авлага 1-ийн* 16.7.1-д өгүүлсэн байдаг.

Аароны санваар олголт болон дикон, багш, пристийн албанд томилоход бишоп хяналт тавина. Зохистой ах нар дараах насны ангилалаар томилогдож болно:

Дикон: 12 настайдаа

Багш: 14 настайдаа

Прист: 16 настайдаа

Эдгээр ах нартай ярилцлага хийх болон дэмжүүлэхээр танилцуулах тухай *Гарын авлага 1-ийн* 16.7.2-т өгүүлсэн байдаг.

### 20.7.1 Ёслол гүйцэтгэх зааврууд

Шаардлагатай ярилцлага болон зөвшөөрлийн дараа:

1. Гадасны ерөнхийлөгч (эсвэл түүний удирдлагаар хэн нэгэн) тухайн хүнийг ахлагчийн албанд томилно. Мөн өөр зохистой Мелкизедек санваартанд үүнийг гүйцэтгэх эрх мэдлийг олгож болно. Зөвхөн Мелкизедек санваартнууд тойрогт зогсож болно.
2. Гадасны ерөнхийлөгч (эсвэл түүний удирдлагаар хэн нэгэн) тухайн хүнийг дээд пристийн албанд томилж болно. Эсвэл өөр нэг зохистой дээд пристэд үүнийг гүйцэтгэх эрх мэдлийг олгож болно. Зөвхөн дээд пристүүд тойрогт зогсож болно.
3. Бишоп (эсвэл түүний удирдлага дор өөр хүн) хүнийг дикон, багш, пристийн албанд томилж болно. Зөвхөн пристүүд болон Мелкизедек санваартнууд тойрогт зогсож, ёслолыг гүйцэтгэж болно.

Хэн нэгэн томилолтонд оролцохын тулд (1) прист эсвэл Мелкизедек санваартан байх ёстой ба (2) томилолт хүлээн авч байгаа хүнтэй адил буюу түүнээс дээд санваарын эрх мэдэлтэй байх ёстой. Жишээ нь дээд пристийг томилоход

эсвэл дээд пристийн гүйцэтгэх албанд хүн адислахад ахлагч тойрогт зогсох ёсгүй.

Санваарын томилолтыг гүйцэтгэхийн тулд эрх олгогдсон нэг эсвэл түүнээс олон санваартан уг хүний толгой дээр гараа зөөлөн тавина. Тэгээд томилолтыг гүйцэтгэж байгаа санваартан:

1. Уг хүнийг бүтэн овог нэрээр нь дуудна.
2. Томилолтыг гүйцэтгэж буй эрх мэдлийг хэлнэ (Аароны эсвэл Мелкизедек санваар).
3. Хэрэв Аароны болон Мелкизедек санваар өмнө нь олгогдоогүй бол үүнийг олгоно.
4. Уг хүнийг Аароны болон Мелкизедек санваартны албанд томилж, уг албаны эрх, хүч, эрх мэдлийг олгоно. (Санваар олгох эсвэл эдгээр албуудын аль нэгэнд томилоход санваарын түлхүүрүүдийг өгдөггүй.)
5. Сүнсний удирдамжаар адислалын үгсийг нэмж хэлнэ.
6. Есүс Христийн нэрээр төгсгөнө.

Томилолт бол адислал өгөх нэг боломж юм. Ер нь томилолтын үед биш өөр үед тухайн хүнд үүргийг нь зааж, зөвлөгөө, заавар өгдөг.

Томилолтыг албан ёсны цуглаан болгох хэрэггүй. Хүн томилогдоход залбирал, гэрчлэл болон заавар шаардлагагүй.

### 20.7.2 Томилолтын бүртгэл ба гэрчилгээ

Мелкизедек санваарын томилолтын дараа Мелкизедек санваарын томилолтын бүртгэлийг гадасны бичиг хэргийн ажилтан маягтан дээрх заврын дагуу бүрэн гүйцэд бөглөж, бэлтгэн хүргүүлнэ. Гадасны ерөнхийлөгч гарын үсэг зурах томилолтын гэрчилгээг гадасны эсвэл тойргийн бичиг хэргийн ажилтан бэлтгэнэ. Дээд зөвлөлийн гишүүн зэрэг гадасны санваартны өөр удирдагч гадасны ерөнхийлөгчийг төлөөлөхөөр томилогдсон бол тэрээр гэрчилгээнд гарын үсэг зурна. Санваартны удирдагч эсвэл бичиг хэргийн ажилтан гарын үсэг зурсан гэрчилгээг гишүүнд өгнө.

Аароны санваарын томилолтын дараа Аароны санваарын томилолтын бүртгэлийг тойргийн бичиг хэргийн ажилтан маягтан дээрх заврын дагуу бүрэн гүйцэд бөглөж, бэлтгэн хүргүүлнэ. Тойргийн бичиг хэргийн ажилтан томилолтын гэрчилгээг бэлтгэнэ. Бишоп гэрчилгээнд гарын үсэг зурж, тэр өөрөө эсвэл бичиг хэргийн ажилтан гэрчилгээг гишүүнд гардуулж өгнө.

Орон нутгийн хууль, ёс заншлаар тодорхойлогдсон тухайн хүний хууль ёсны нэрийг томилолтын бүртгэл, гэрчилгээн дээр бичих ёстой.

## 20.8 Эцгийн болон тайтгарлын адислал ба зөвлөгөө

Эцгийн адислал болон санваарын бусад адислалуудыг Сүнсний удирдамжийн дагуу удирдамж, тайтгарлын төлөө өгдөг.

Мелкизедек санваартай эцэг хүүхдүүддээ эцгийн адислал өгч болно. Энэ адислал хүүхдүүд нь сургуульд орох, номлолд явах, гэрлэх, цэрэгт явах эсвэл ямар нэг сорилт бэрхшээл тулгарах бүрд хэрэгтэй байж болно. Тухайн гэр бүл эцгийн адислалыг гэр бүлийн цэдэгтээ хадгалж болно. Гэвч эцгийн адислалыг Сүмийн бүртгэлд хадгалдаггүй. Хүүхдүүдээ хэрэгтэй үедээ эцгээсээ адислал хүсдэг байхыг эцэг эхчүүд нь дэмжих нь зүйтэй.

Зохистой Мелкизедек санваартнууд бусад гэр бүлүүдийн гишүүд, түүнчлэн хүссэн бусад хүмүүст тайтгарлын адислал, зөвлөгөө өгч болно.

Эцгийн адислал болон тайтгарлын бусад адислал, зөвлөгөө өгөхийн тулд нэг ба түүнээс дээш Мелкизедек санваартнууд уг хүний толгой дээр гараа зөөлхөн тавина. Тэгээд адислал өгч буй санваартан:

1. Уг хүнийг бүтэн овог нэрээр нь дуудна.
2. Мелкизедек санваарын эрх мэдлээр адислалыг гүйцэтгэж байгааг хэлнэ.
3. Сүнсний удирдамжаар адислалын үгсийг нэмж хэлнэ.
4. Есүс Христийн нэрээр төгсгөнө.

## 20.9 Нутаглуулах газрыг адислах нь

Нутаглуулах газрыг адисалж байгаа хүн Мелкизедек санваартай байх ёстой бөгөөд уг ёслолыг хөтлөн явуулж байгаа санваартнаас зөвшөөрөл авсан байна. Нутаглуулах газрыг адислахын тулд тэр:

1. Тэнгэрлэг Эцэгт хандана.
2. Тэрээр Мелкизедек санваарын эрх мэдлээр үйлдэж байгаагаа хэлнэ.
3. Оршуулгын газар нь нас барсан хүний цогцсын хувьд амар амгалангийн газар байхаар адислана.
4. Оршуулгын газар ариусгагдаж, (тохиромжтой газарт) амилуулалт хүртэл хамгаалагдахын төлөө залбирна.
5. Уг гэр бүлийг тайтгаруулахыг Их Эзэнээс гуйж, Сүнсний удирдамжийн дагуу бодол санаагаа илэрхийлнэ.
6. Есүс Христийн нэрээр төгсгөнө.

Хэрэв тухайн гэр бүл хүсвэл газрыг адислахын оронд залбирал хэлж болно.

Хэрэв Сүмийн гишүүний цогцсыг чандарлах бол чандар хадгалах газрыг адислах эсэхийг тэргүүлэх эрх мэдэлтэн шийдэж болно. Гэвч тухайн гэр бүлийн хүсэл, орон нутгийн ёс заншил, хуулийг харгалзан үзэх хэрэгтэй. Хэрэв чандар хадгалах газрыг адислах бол санваартан булш адислах зааврыг ашиглаж болно.

## 20.10 Дуудлагатнууд болон багш нарыг адислах нь

19.4-ийг үзнэ үү.

## 20.11 Гэр орныг адислах нь

Сүмийн гишүүд гэр орноо Ариун Сүнс орших газар, гэр бүлийн гишүүд шүтэн бишрэх, дэлхийгээс аюулгүй байдлыг олж чадах, сүнслэг байдлаар өсч хөгжих, мөнхийн гэр бүлийн харилцаанд бэлтгэх ариун газар болгон адисалж болно. Зээлийн барьцаанд байгаа гэр орныг адисалж болно. Гэр орон нь Их Эзэнд ариулан адислагддаггүйгээрээ Сүмийн барилгуудаас ялгаатай.

Мелкиседек санваартан санваарын хүчээр гэр орныг адисалж болно. Хэрэв тухайн айлд Мелкиседек санваартан байхгүй бол гэр орноо адислахын тулд тэдний ойрын хамаатан, гэрийн багшаа эсвэл өөр Мелкиседек санваартныг урьж болно. Эсвэл уг гэр бүл цуглаж, өмнө дурдсан заавруудаас Ариун Сүнс чиглүүлсний дагуу залбирч болно.

## 20.12 Патриархын адислал

### 20.12.1 Ерөнхий удирдамж

Баптисм хүртсэн, Сүмийн зохистой гишүүн бүр патриархын адислал хүлээж авах эрхтэй буюу хүлээж авах ёстой. Энэ адислал Их Эзэний сүнслэг удирдамжаар хангадаг. Патриархын адислалаа авахад сүнслэг байдлын хувьд бэлтгэхэд нь гишүүдийг Сүмийн удирдагчид болон эцэг эхчүүд дэмжинэ.

Бишоп эсвэл томилогдсон зөвлөх патриархын адислал авахыг хүссэн гишүүдтэй ярилцлага хийнэ. Хэрэв гишүүн зохистой бол Patriarchal Blessing Recommend (Патриархын адислалын зөвшөөрлийн бичиг)-г бишоп олгож, гарын үсэг зурна.

Патриархын адислалын тухай нэмэлт мэдээлэл хэрэгтэй байгаа гадасны ерөнхийлөгч болон бишоп дараах эх сурвалжуудыг үзэж болно:

*Гарын авлага 1,* 16.12

*Information and Suggestions for Patriarchs*

*Дэлхий дахины удирдлагын сургалт хурал: Патриарх*

### 20.12.2 Патриархын адислал авах нь

Гишүүд патриарх уруу очихдоо залбиралтай мөн ням гарагт өмсдөг хувцастайгаа очих ёстой. Тэд мацаг барьж болох боловч заавал барих шаардлагагүй.

Патриархын адислал бүр ариун нандин, нууц буюу хувийн шинжтэй юм. Иймээс үүнийг гэр бүлийн тодорхой тооны гишүүдийг байлцуулж болохоос бусад тохиолдолд ганцаарчлан өгдөг.

Сүмийн гишүүд адислалуудыг хоорондоо харьцуулж үзэх мөн гэр бүлийн ойр дотны гишүүдээс бусад хүмүүстэй хуваалцах ёсгүй. Патриархын адислалуудыг Сүмийн цуглаанууд дээр болон олон хүмүүс цугладаг бусад газарт унших ёсгүй.

Хэрэв патриархын адислалд нь Израилийн овгийг заагаагүй бол патриарх хожим нь овог заасан нэмэлтийг өгч болно.

### 20.12.3 Патриархын адислалын хуулбарыг олж авах нь

Патриархын адислал авсан хүн адислалын хэвлэсэн хувийг нандигнан хадгалж хамгаалах ёстой. Гэвч адислалын хувийг хаясан буюу үрэгдүүлсэн тохиолдолд патриарх өөрийн өгсөн адислалуудын хавтсанд эх хувийг хадгалсан хэвээр байвал хуулбарыг түүнээс олж авч болно. Хэрэв эх хувиудыг Сүмийн удирдах газарт явуулсан бол хуулбарыг дараах хаягаар хандан олж авч болно:

Patriarchal Blessings
15 East North Temple Street
Salt Lake City, UT 84150-1600
Утас: 1-801-240-3581

Патриархын адислалынхаа хувийг хүсч байгаа хүн өөрийн бүтэн нэр, гишүүнчлэлийн бүртгэлийн дугаар (байдаг бол), төрсөн он сар өдрийг бичих хэрэгтэй. Боломжтой бол тухайн хүн патриархын нэр болон адислал өгсөн он, сар, өдрийг ойролцоогоор оруулах хэрэгтэй.

# 21. Сүмийн бодлого ба удирдамжууд


**21.1 Удирдлагын бодлого . . . . . . . . . . 197**

21.1.1 Ослоос урьдчилан сэргийлэх ба хариу арга хэмжээ авах тухай . . . . . 197
21.1.2 Үйл ажиллагааны бодлого . . . . . 197
21.1.3 Өргөмөл хүүхдүүд ба тэдний төрсөн эцэг эх . . . . . 197
21.1.4 Хүүхэд өргөж авах ба өсгөн хүмүүжүүлэх тухай . . . . . 197
21.1.5 Дуу, дүрс бичлэгийн материалууд . . . . . 197
21.1.6 Ерөнхий Эрх мэдэлтнүүд болон Бүсийн Далуудын гарын үсэг ба гэрэл зураг . . . . 197
21.1.7 Библи . . . . . 197
21.1.8 Мормоны Ном . . . . . 198
21.1.9 Сүмийн сэтгүүлүүд . . . . . 198
21.1.10 Сүмийн нэр ба лого . . . . . 198
21.1.11 Компьютер . . . . . 199
21.1.12 Зохиогчийн эрх бүхий материалууд . . . . 199
21.1.13 Сургалтын материалууд . . . . . 200
21.1.14 Ганц бие гишүүд ба зуучлах байгууллага . . . . . 201
21.1.15 Лавлахууд . . . . . 201
21.1.16 Сүмийн гишүүдийн цагаачлал . . . . . 201
21.1.17 Мацгийн өдөр . . . . . 201
21.1.18 Хандив цуглуулах . . . . . 201
21.1.19 Мөрийтэй тоглоом ба хонжворт сугалаа . . . . . 201
21.1.20 Гаднаас ирж үг хэлэх ба хичээл заах тухай . . . . . 201
21.1.21 Орлогын татвар . . . . . 202
21.1.22 Интернет . . . . . 202
21.1.23 Улсын хууль тогтоомж . . . . . 203
21.1.24 Гишүүд Сүмийн удирдах газартай харилцах нь . . . . . 203
21.1.25 Гишүүдийн ажил, мэргэжил болон бусад байгууллагын гишүүнчлэл . . . . . 203
21.1.26 Хөгжлийн бэрхшээлтэй гишүүд . . . . . 203
21.1.27 Бусад шашнууд . . . . . 206
21.1.28 Хоногоор явах үйл ажиллагаа . . . . . 207
21.1.29 Улс төр, олон нийтийн үйл ажиллагаа . . 207
21.1.30 Шуудангийн хууль дүрэм . . . . . 207
21.1.31 Гишүүдийн хувийн мэдээлэл . . . . . 207
21.1.32 Хувийн журмаар хэвлүүлсэн зохиол бүтээлүүд . . . . . 207
21.1.33 Ерөнхий Эрх мэдэлтнүүд болон Бүсийн Далуудын хэлсэн үгийн бичлэг хийх тухайд . . . . . 207
21.1.34 Сүм болон Сүмийн гишүүдийг албан ёсоор нэрлэх тухайд . . . . . 207
21.1.35 Сүм дэх судалгааны ажлууд . . . . . 208
21.1.36 Худалдааны байгууллага . . . . . 208
21.1.37 Хиймэл дагуулын болон видео төхөөрөмж . . . . . 208
21.1.38 Санхүүгийн тусламж хүсэх нь . . . . . 208
21.1.39 Сүмийн удирдагчдын хэлсэн үгсийн тухай . . . . . 208
21.1.40 Симпозиум ба адил төрлийн хурал цуглаан . . . . . 209
21.1.41 Татвар ноогддог үйл ажиллагаанууд . . . . 209
21.1.42 Ариун сүмийн хувцас ба гармент . . . . . 209
21.1.43 Аялах журам . . . . . 209

**21.2 Сүмийн барилга болон бусад өмчийг ашиглах журам . . . . . 210**

21.2.1 Урлагийн бүтээл . . . . . 210
21.2.2 Чимэглэл . . . . . 210
21.2.3 Онцгой байдал . . . . . 211
21.2.4 Галт зэвсэг . . . . . 211
21.2.5 Гал болон лаа . . . . . 211
21.2.6 Төрийн далбаа . . . . . 211
21.2.7 Даваа гарагийн үдэш . . . . . 211
21.2.8 Хоногоор явах аялал зугаалга . . . . . 211
21.2.9 Машины зогсоол . . . . . 211
21.2.10 Ариун ёслолын танхимд гэрэл зураг авах, дүрс бичлэг, нэвтрүүлэг хийх тухайд . . . . . 211
21.2.11 Сүмийн байр талбай . . . . . 211
21.2.12 Цуглааны байранд хадгалж болох зүйлс . . . . . 211

**21.3 Эмчилгээ, эрүүл мэндийн бодлого . . . . . 211**

21.3.1 Цогцост задлан шинжилгээ хийх тухай . . . . . 211
21.3.2 Цогцос чандарлах тухайд . . . . . 211
21.3.3 Зориудаар үхүүлэх тухай . . . . . 211
21.3.4 ХДХВ-ийн халдвар ба ДОХ . . . . . 212
21.3.5 Ховс . . . . . 212
21.3.6 Эмчилгээ болон эрүүл мэндийн асуудлууд . . . . . 212
21.3.7 Эрхтэн, эд эсийн донор ба эрхтэн шилжүүлэн суулгах тухай . . . . . 212
21.3.8 Үхлийг зохиомлоор хойшлуулах тухай . . . . . 212
21.3.9 Бусад бие даасан бүлэг, эвслүүд . . . . . 212
21.3.10 Амьгүй төрсөн хүүхдүүд (төрөхөөсөө өмнө эндсэн хүүхдүүд) . . . . . 213
21.3.11 Мэргэн Ухааны Үг . . . . . 213

**21.4 Бэлгийн ёс суртахууны талаарх бодлого . . . . . 213**

21.4.1 Үр хөндөлт . . . . . 213
21.4.2 Хүчирхийлэл ба хэрцгий авир . . . . . 213
21.4.3 Зохиомлоор үр тогтоох тухай . . . . . 213
21.4.4 Жирэмслэлтээс хамгаалах тухай . . . . . 214
21.4.5 Ариун явдал ба үнэнч чанар . . . . . 214
21.4.6 Ижил хүйстэнтэй бэлгийн харилцаанд орох, ижил хүйстэнд этгэл татагдах тухай . . . . . 214

21.4.7 Зохиомлоор үр хөврөл бий болгох тухай . . . 214
21.4.8 Хар дом . . . 214
21.4.9 Порнограф . . . 214
21.4.10 Ижил хүйстний гэрлэлт . . . 215
21.4.11 Бэлгийн боловсрол . . . 215
21.4.12 Ганц бие жирэмсэн эмэгтэйчүүд . . . 215
21.4.13 Эр эсийн донор . . . 216
21.4.14 Амиа хорлох тухай . . . 216
21.4.15 Мэс заслын аргаар үргүй болох тухайд . . . 216
21.4.16 Үр хөврөлийг өөр эхийн хэвлийд тээх тухайд . . . 216

# 21. Сүмийн бодлого ба удирдамжууд

Дараах бодлогуудын ихэнхийг *Гарын авлага 1-ийн* "Сүмийн бодлого" болон "Барилга байгууламж" бүлгүүдээс авсан болно. Эдгээр болон Сүмийн бусад бодлогын тухай асуултыг бишопт хандан тавих хэрэгтэй.

Энэ бүлэг дөрвөн хэсгээс бүрддэг. Хэсэг бүр нь дэд сэдвүүдийг агуулдаг:

1. Удирдлагын бодлого
2. Сүмийн барилга болон бусад өмчийг ашиглах бодлого
3. Эмчилгээ ба эрүүл мэндийн бодлого
4. Ёс суртахууны талаарх бодлого

## 21.1 Удирдлагын бодлого

### 21.1.1 Ослоос урьдчилан сэргийлэх ба хариу арга хэмжээ авах нь

13.6.20-ийг үзнэ үү.

### 21.1.2 Үйл ажиллагааны бодлого

13.6-г үзнэ үү.

### 21.1.3 Өргөмөл хүүхдүүд ба тэдний төрсөн эцэг эх

Өргөмөл хүүхдүүд болон тэдний төрсөн эцэг эхийн тухай мэдээлэл солилцох, тэдний хооронд холбоо барихтай холбоотой асуудлуудыг анхаарал болгоомжтойгоор шийдвэрлэх хэрэгтэй. Холбогдох бүх талын хууль зүйн эрх, сэтгэл санааны байдлыг харгалзаж үзэх ёстой.

### 21.1.4 Хүүхэд өргөж авах ба өсгөн хүмүүжүүлэх тухай

Хүүхэд өргөж авахыг эсвэл хүүхэд асран хүмүүжүүлэхийг хүсч буй гишүүд тухайн улс орны (мөн тэдний яам, агентлагуудын) хуулийн бүх шаардлагуудыг чанд даган биелүүлэх ёстой. Зөвшөөрөл бүхий эрх мэдэл олгогдсон байгууллагуудаар дамжуулан ажиллахад нь тэднийг дэмжих ёстой.

### 21.1.5 Дуу, дүрс бичлэгийн материалууд

Гишүүд Сүмийн үйл ажиллагаанууд дээр CD, DVD, компьютер дээр боловсруулсан танилцуулга зэрэг дуу, дүрс бичлэгийн материалуудыг дараах хязгаарлалттайгаар хэрэглэж болно:

1. Эдгээрийг ариун ёслолын цуглаан, гадасны чуулганы ерөнхий хуралдаан дээр ашиглаж болохгүй (гэвч төгөлдөр хуур, бадралт баг бишгүүр эсвэл хөгжим тоглох хүн байхгүй бол тохирох хөгжмийн бичлэгийг ашиглаж болно).
2. Зохиогчийн эрхийн зөвшөөрөлгүй бол ашиглаж болохгүй (21.1.12-г үзнэ үү).
3. Эдгээр нь Сүмийн сургаал бодлогод нийцэхгүй зүйлийг агуулж байгаа бол ашиглаж болохгүй.

Дээрх шалгуурыг хангасан дуу, дүрс бичлэгийн материалууд нь уг цуглаанд чухал бол ариун ёслол, гадасны чуулганы ерөнхий хуралдаанаас бусад цуглаануудын үеэр ариун ёслолын танхимд ашиглаж болно.

### 21.1.6 Ерөнхий эрх мэдэлтнүүд болон Бүсийн Далуудын гарын үсэг ба гэрэл зураг

Сүмийн гишүүд Ерөнхий Эрх мэдэлтнүүдээр эсвэл Бүсийн Далын гишүүдээр судар, дууны ном мөн хөтөлбөр зэрэг дээр гарын үсэг зуруулахыг хүсэх ёсгүй. Ингэх нь тэдний ариун дуудлагын болон цуглааны сүнслэг байдлыг алдагдуулдаг. Мөн бусад гишүүдтэй мэндлэх боломжийг багасгадаг.

Гишүүд Сүмийн байранд Ерөнхий Эрх Мэдэлтнүүд эсвэл Бүсийн Далуудын гэрэл зургийг авч болохгүй.

### 21.1.7 Библи

Англиар ярьдаг гишүүд Библийн Хаан Жеймсийн ХҮГ-н сүмийн хэвлэсэн хувилбарыг ашиглана. Энэ хэвлэл нь Сэдэвчилсэн Удирдамж, зүүвэр тайлбар, Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүврүүд, Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувдтай харьцуулсан эшлэлүүд, судлах бусад материалуудыг агуулдаг. Библийн бусад хувилбарууд уншихад хялбар ч, сургаалын хувьд Хаан Жеймсийн Хувилбар англи хэлээрх бусад орчуулгуудаас илүү гэдгийг хожмын үеийн илчлэлт нотолсон юм.

Испаниар ярьдаг гишүүд Библийн Reina-Valera-гийн ХҮГ-н сүмийн хэвлэсэн хувилбарыг ашиглах хэрэгтэй. Энэ хэвлэл англи хэл дээрх ХҮГ-н сүмийн хэвлэсэнтэй адил судлах материалуудыг агуулдаг.

Англиас бусад олон хэлээр Сүмийн цуглаанууд болон хичээлүүд дээр ашиглах ХҮГ-н сүмийн бус Библийн хувилбарыг Сүм зөвшөөрөн

баталсан байдаг. Гишүүд Библийн эдгээр хэвлэлүүдийг ашиглах ёстой.

Библийн аливаа бичээсийн үнэн зөвийг хэмжих хамгийн найдвартай арга зам бол өөр өөр хувилбаруудыг харьцуулах биш, харин Мормоны Ном болон орчин үеийн илчлэлтүүдтэй харьцуулах явдал юм.

Библийн зөвшөөрөн баталсан хувиудыг Сүмийн Хангамжийн Төвүүдээс авч болно. ХҮГ-н сүмийн судруудын электрон хувилбар болон аудио бичлэгүүд бас scriptures.lds.org-д байдаг.

### 21.1.8 Мормоны Ном

Сүм Мормоны Номыг нийтэд дэлгэрсэн буюу орчин үеийн англи хэлээр дахин бичихийг хориглодог. Тэргүүн Зөвлөл хэлэхдээ:

"Ариун бичээсийг өөр хэлээр орчуулах, орчин цагийн хэлээр дахин бичих нь сургаалын алдаа гаргах эсвэл эрт үеийн анхны эх сурвалжийг бүдэгрүүлж мэдэх ноцтой эрсдэлд хүргэж болно. Үүнээс хамгаалахын тулд судруудыг англи хэлнээс бусад хэлнүүдэд орчуулахад биечлэн, нягт няхуур хяналт тавьдаг бөгөөд Тэргүүн Зөвлөл, Арванхоёрын Зөвлөл Мормоны Номны сургаалын агуулгыг орчин цагийн эсвэл орчин үеийн англи хэлээр илэрхийлэх хүч чармайлтыг зөвшөөрдөггүй (Эдгээр нь хүүхдүүдэд зориулсан Сүмийн нийтлэлүүдэд үл хамаарна)" гэжээ. (*Ensign,* 1993 оны 4-р сар, 74).

### 21.1.9 Сүмийн сэтгүүлүүд

Тэргүүн Зөвлөл гишүүдийг сүмийн сэтгүүлүүдийг уншдаг байхыг байнга дэмждэг. Сүмийн орон нутгийн удирдагчид гишүүдийг гэртээ Сүмийн сэтгүүлүүдтэй байхыг нь дэмжих ёстой. Эдгээр сэтгүүл хожмын үеийн бошиглогчдоор дамжуулан өгсөн Их Эзэний удирдамжийг агуулдаг. Сүмийн сэтгүүлүүд Аврагчид итгэх итгэлийг бэхжүүлж, хувь хүнд тохиолддог сорилт бэрхшээлүүдийг даван туулахад сүнслэг нөлөө бүхий удирдамжаар хангадаг.

Гадасны ерөнхийлөгч болон бишоп нар гүйцэтгэх нарийн бичиг нараа Сүмийн сэтгүүлүүдийг захиалах ажлыг зохицуулахаар томилж болно (*Гарын авлага 1-ийн* 13.3.4; 13.4.4-ийг үзнэ үү). Бишопын зөвлөл нь тойргийн сэтгүүлийн төлөөлөгч болон энэ ажилд туслах бусад хүмүүсийг дуудаж болно. Хэрэв тойргийн сэтгүүлийн төлөөлөгч дуудагдсан бол тэрээр Сүмийн сэтгүүлүүдийг захиалахад уриалах ажлыг төлөвлөн зохион байгуулахад болон сэтгүүлүүдийг шинээр захиалах эсвэл захиалгаа сунгахад нь гишүүдэд тусалж, Сүмийн сэтгүүлүүдийг захиалахын ашиг тусыг заадаг.

Гишүүд Сүмийн Хангамжийн Төвүүдээр дамжуулан Сүмийн сэтгүүлүүдийг захиалж болно. Зарим газарт гишүүд Сүмийн вэб хуудсан дээрх захиалгын маягтыг бөглөх замаар захиалж болно.

### 21.1.10 Сүмийн нэр ба лого

Сүмийн нэр болон лого нь Сүмийн гол таних тэмдгүүд юм. Сүмийн нэр болон лого нь албан ёсоор бүртгэгдсэн байдаг бөгөөд дэлхий дахинд хуулиар хамгаалагдсан байдаг. Сүмийн нэр болон логог зөвхөн дараах удирдамжийн дагуу ашиглах ёстой.

Орон нутгийн нэгжүүд дараах бүх нөхцөлийг хангасан үед Сүмийн бичмэл нэрийг (логог биш) хэрэглэж болно:

1. Сүмийн нэрийн доор явагдах нэгжийн үйл ажиллагаа (жишээ нь ариун ёслолын хөтөлбөр).
2. Сүмийн орон нутгийн нэгжийн нэр нь Сүмийн нэртэй хамт хэрэглэгдэнэ (жишээ нь Есүс Христийн Хожмын үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Канион Вью тойрог).
3. Сүмийн нэрийг хэрэглэхдээ албан ёсны логог дууриалгах шаардлагагүй.

Сүмийн албан ёсны логог (энэ гарын авлагын нүүрэн талын хавтсыг үзнэ үү) зөвхөн Сүмийн удирдах газрын Correlation Department (Зохицуулалтын хэлтэс)-ийн зөвшөөрөл олгосон зүйлүүдэд л хэрэглэнэ. Ийм зүйлсийн жишээ гэвэл:

1. Сүмийн албан ёсны ном хэвлэл болон албан бичиг.
2. Номлогчийн нэрийн тэмдэг.
3. Сүмийн байрны гадна талын хаяг.

Логог ямар нэг чимэглэлийн зориулалтаар болон компьютерын дэлгэцэн дээр ашиглах ёсгүй. Логог гэр бүлийн түүхийн ном, цамц, товч, далбаа зэрэг хувийн зорилгоор болон арилжааны зориулалтаар хэрэглэх ёсгүй. Энэ талаар асуулт байвал дараах хаягаар хандаж болно:

Intellectual Property Office
50 East North Temple Street, Room 1888
Salt Lake City, UT 84150-0018
Утас: 1-801-240-3959 эсвэл 1-800-453-3860, дотуур утас 2-3959
Fax: 1-801-240-1187
Э-мэйл:
cor-intellectualproperty@ldschurch.org

### 21.1.11 Компьютер

Сүмийн тэргүүлэх зөвлөл зөвшөөрсөн үед Сүмийн нэгжүүдийг бүртгэл болон гэр бүлийн түүх хөтлөхөд зориулж компьютерээр хангадаг. Гадасны ерөнхийлөгч гадсаны компьютеруудын, ашиглалтанд хяналт тавина. Сүмийн компьютеруудыг олж авах, ашиглах удирдамжийг Сүмийн удирдах газраас эсвэл харьяа үйлчлэлийн төвөөс авч болно. Эдгээр удирдамж компьютерын техник хангамж, программ хангамж, хандивын компьютер, интернет холболт, засвар үйлчилгээ ба актлах, хулгайд алдсан эсвэл эвдэрсэн компьютер, аюулгүй байдал, гишүүд компьютеруудыг хэрхэн ашиглах зэрэг асуудлуудын тухай мэдээллийг агуулдаг.

Шаардлагатай газарт гэр бүлийн түүхийн программ хангамжуудыг гишүүдэд хэрэглүүлэхийн тулд гадасны ерөнхийлөгч нар тойрог, гадасны компьютеруудыг үүнд зориулан зохион байгуулж болно. Тойргийн болон гадасны компьютеруудыг хувийн зорилгоор ашиглахыг зөвшөөрөхгүй.

Компьютер дээрх нууц мэдээллийг хамгаалахын тулд удирдагчид болон бичиг хэргийн ажилтнууд Сүмийн бүртгэл хөтлөлтөд нэвтрэх нууц үгсийг хэрэглэх ёстой. Нууц мэдээллийг хамгаалах тухай нэмэлт зааврууд *Гарын авлага 1-ийн* 13.8 болон 13.9-с үзнэ үү.

Бишопын зөвлөлийн гишүүд болон бичиг хэргийн ажилтнууд гишүүдийн долоо хоног тутмын хандивын ажлыг хийхийн тулд компьютеруудыг өөрсдийн өрөөнд байрлуулах хэрэгтэй.

Компьютеруудын программ хангамжийг хувилах хязгаарлалтуудын талаар 21.1.12-с үзнэ үү.

### 21.1.12 Зохиогчийн эрх бүхий материалууд

Бүтээл болон түүнийг зөвшөөрөл авч ашиглахыг зохицуулдаг хуулиуд улс орон бүрд өөр байдаг. Энэ хэсэгт өгүүлсэн Сүмийн бодлого нь ихэнх орнуудад хэрэглэгддэг олон улсын гэрээнүүдтэй тохирдог. Энгийн ойлгомжтойг нь бодож энэ хэсэгт зохион бүтээгчийн эрхийг "зохиогчийн эрх" хэмээн нэрлэсэн болно. Гэвч эдгээр эрхийг зарим улс оронд өөрөөр нэрлэдэг байж болно.

Зохиогчийн эрх нь эх бүтээлийг түүний эрх болгон бодит хэлбэрээр хуулиар хамгаалсан байдаг, тухайлбал:

1. Ном зохиол, хөгжим, жүжгийн болон бүжгийн бүтээлүүд.
2. Уран зураг, гэрэл зураг ба уран баримал
3. Дуу, дүрс бичлэгийн бүтээлүүд (кино, видео, CD, DVD гэх мэт)
4. Компьютерын программ ба тоглоом
5. Интернет ба мэдээллийн бусад сан.

Сүмийн гишүүд зохиогчийн эрхийн бүх хуулийг чанд мөрдөх ёстой. Зөвхөн зохиогчийн эрхийг эзэмшигчид л өөрсдийн бүтээлийг хувилан олшруулах, тараах, олон нийтэд танилцуулах буюу үзүүлэх, хуулбарлах эрхтэй байдаг. Зохиогчийн эрхийг эзэмшигчээс зөвшөөрөл авалгүйгээр дээрх бүтээлүүдээс ашиглах нь Сүмийн дүрэм журамд нийцэхгүй бөгөөд Сүмийг болон хэрэглэгчийн хуулийн хариуцлага хүлээхэд хүргэх болно.

Бүтээл нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан байдгийг бүтээлийг хэрэглэгч санах ёстой. Хэвлэгдсэн бүтээлүүдэд "© 1959 by John Doe" гэхчлэн зохиогчийн эрхийн тэмдэглэл байдаг. (Дуу хөгжмийн бичлэгүүдэд, уг тэмдэглэл нь ℗ дүрс байдаг.) Гэвч зохиогчийн эрхийн тэмдгийг заавал тавихыг шаарддаггүй. Түүнээс гадна хэвлэгдсэн нийтлэл нь үүний зохиогчийн эрхийг хүчингүй болгож байгаа буюу хувилан олшруулах, тараах, тоглох, дэлгэн үзүүлэх эсвэл зөвшөөрөлгүйгээр хуулбарлаж болно гэсэн хэрэг биш юм.

Сүмийн Intellectual Property Office (IPO) Сүмийн материалууд эсвэл программуудыг, түүний дотор Intellectual Reserve, Inc(IRI)-аар зохиогчийн эрх нь хамгаалагдсан материалуудыг хэрэглэх хүсэлтэнд тусалдаг. IRI бол Сүмийн оюуны өмчийг эзэмшдэг бие даасан, ашгийн бус байгууллага юм. Сүмийн эзэмшдэг материалуудыг ашиглах хүсэлтийн талаарх нэмэлт мэдээллийг LDS.org дахь "Rights and Use Information"-с олж үзэж болно.

Дараах асуулт, хариултууд нь Сүм дээр болон гэр орондоо зохиогчийн эрх бүхий материалуудыг ашиглах үед зохиогчийн эрхийн тухай хуулиудыг ойлгож, хэрэглэхэд нь гишүүдэд тусалж болно. Эдгээр удирдамжинд хариулагдаагүй асуултууд байвал тэд дараах хаягаар холбоо барьж болно:

Intellectual Property Office
50 East North Temple Street, Room 1888
Salt Lake City, UT 84150-0018
Утас: 1-801-240-3959 эсвэл 1-800-453-3860,
дотуур утас 2-3959
Fax: 1-801-240-1187
Э-мэйл:
cor-intellectualproperty@ldschurch.org

*Сүмийн сэтгүүлүүдээс зургуудыг нь хуулбарлаж болох уу?* Сүмийн нийтлэлүүд дэх

зургуудыг Сүм дээр, гэр орондоо болон гэр бүлээрээ ашиглахын тулд хуулбарлаж болно. Гэвч IPO-гоос бичгээр ирүүлсэн тусгай зөвшөөрөлгүйгээр тэдгээрийг арилжааны зорилгоор хувилан олшруулж болохгүй. Хэрэв аль нэг зургийг хувилан олшруулахыг хориглосон бол "хувилан олшруулж болохгүй" гэсэн үгс зургийн тайлбарын дэргэд байдаг.

*Сүмээс хэвлэсэн материалуудыг хувилан олшруулж болох уу?* Сүмийн нийтлэлүүдийг Сүм дээр, гэр орондоо болон гэр бүлээрээ ашиглахын тулд ер нь хуулбарлаж болдог. Гэвч IPO-гоос бичгээр ирүүлсэн тусгай зөвшөөрөлгүйгээр тэдгээрийг арилжааны зорилгоор хувилан олшруулж болохгүй.

*Дуу хөгжмийг хувилан олшруулж болох уу?* Дуу хөгжимд зохиогчийн эрхийн тусгай хуулиуд үйлчилдэг. Хэрэв дуулал эсвэл дууны дээр тэмдэглэсэн аль нэг хязгаарлалт байхгүй бол *Hymns*, *Children's Songbook* болон Сүмийн сэтгүүлүүдээс ашиг олох зорилгоор биш, Сүм дээр, гэр орон, гэр бүлээрээ ашиглахын тулд дуу, хөгжмийг хувилж болно. Зохиогчийн эрхийг эзэмшигчээс нь зөвшөөрөл авалгүйгээр дуу, хөгжмийг хувилан олшруулах нь Сүмийн бодлогод нийцэхгүй. Энэхүү бодлогыг зөрчин хувилж олшруулсан дуу хөгжмийг Сүмийн зорилгоор ашиглаж болохгүй.

*Сүмээс гаргасан дуу, дүрс бичлэгийн материалуудыг өөрчлөх, хувилан олшруулах буюу хэсэглэн авч болох уу?* IPO (Оюуны Өмчийн Алба)-аас ийнхүү ашиглах тусгай зөвшөөрөл өгөөгүй бол болохгүй. Сүмээс эрхлэн гаргасан дуу, дүрсний материалуудыг гарын авлагууд болон хайрцаг дээрх зааврыудын дагуу ашиглах ёстой.

*Сүмийн бус материалуудыг хувилан олшруулж болох уу?* Ер нь бол болдоггүй. Хувийн эзэмшлийн материалуудыг ашиглах явдлыг зохицуулдаг зохиогчийн эрхийн хуулиуд байдаг. Сүмийн бус материалуудыг хувилан олшруулахын өмнө нийтээр баримтлах ёстой нөхцөлүүдийг заасан зааврууд байдаг. Эдгээр зааврыг ихэвчлэн тухайн нийтлэлийн эхэнд жагсаасан байдаг. Гишүүд зохиогчийн эрхийн бүх хуулийг чанд сахин мөрдөх ёстой.

*Сүмийн үйл ажиллагаанууд дээр арилжааны дуу, дүрс бичлэгийн бүтээлүүдийг үзүүлж болох уу?* Ер нь бол болдоггүй. Арилжааны дуу, дүрс бичлэгийн бүтээлүүд дээрх сэрэмжлүүлэг, хязгаарлалтуудыг Сүмийн гишүүд зөрчих ёсгүй. Сүмийн үйл ажиллагаанууд дээр арилжааны дуу, дүрс бичлэгийн бүтээлүүдийг ашиглахын тулд зохиогчийн эрхийг эзэмшигчдээс зөвшөөрөл авах шаардлагатай.

*Компьютерийн программ хангамж болон бусад програмуудыг Сүм дээр ашиглахын тулд хуулбар хийж болох уу?* Ер нь бол болдоггүй. Хэрэв холбогдох бүх зөвшөөрлийг худалдаж аваагүй бол компьютерын программууд, бусад программ хангамжийг хуулбарлаж болохгүй. Зөвхөн Сүмийн гэр бүлийн түүхийн программуудыг үнэ төлбөргүйгээр хуулбарлаж болно.

*Сүмийн вэб сайтуудаас олсон материалуудыг хуулбарлаж, тарааж болох уу?* Сүм LDS.org, Mormon.org; FamilySearch.org гэх мэт нэлээд хэдэн вэб сайтыг бий болгосон. Хэрэв өөрөөр заагаагүй бол Сүмийн эзэмшлийн бүх материал, түүний дотор үзүүлэнгүүд, бичвэр, дүрс, мэдээллийн сан болон ерөнхий мэдээллийг ашиг олохын төлөө биш, зөвхөн Сүм дээр, гэр оронд болон гэр бүлээрээ үзэх буюу хуулбарлан хэвлэж болно. Эдгээр вэб хуудсын материалыг IPO-гийн зөвшөөрөлгүйгээр үзүүлэх, засан найруулах эсвэл бусад вэб сайтууд уруу шилжүүлж болохгүй.

Сүмийн эзэмшдэг сайтууд болон эдгээр сайтууд дээрх аливаа мэдээлэл, түүний дотор мэдээллийг оруулсан хүмүүсийн нэр, хаягийг бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдах, сурталчлах, үйлчлүүлэгчдийг татах эсвэл арилжааны аливаа бусад зорилгоор ашиглаж болохгүй.

Нэмэлт мэдээллийг вэб сайтын эрх болон ашиглалтын мэдээллээс нь үзнэ үү.

*Хөгжмийн болон театрын бүтээлүүдийг үзүүлэхэд ямар зөвшөөрөл хэрэгтэй вэ?* Сүмийн эсвэл IRI-гийн эзэмшдэг бүтээлүүдийг Сүмийн удирдах газрын зөвшөөрөлгүйгээр Сүмийн арга хэмжээнүүд дээр тоглон үзүүлж болно. Хэрэв зохиогчийн эрх бүхий бүтээлийг Сүм эзэмшдэггүй бол тухайн бүтээлийг Сүмийн арга хэмжээнд бүтнээр нь эсвэл хэсэгчлэн тоглож үзүүлэхийн тулд гишүүд зохиогчийн эрхийг эзэмшигчээс зөвшөөрөл авах ёстой. Тоглолт нь төлбөргүй байлаа ч гэсэн ихэвчлэн зохиогчийн эрхийг эзэмшигч нь төлбөр эсвэл зохиогчийн хураамжийг шаарддаг. Бүх үзүүлбэр, тоглолтуудад орон нутгийн санваартны удирдагчдын зөвшөөрөл шаардлагатай.

### 21.1.13 Сургалтын материалууд

Есүс Христийн сайн мэдээг судалж, түүгээр амьдрахад нь гишүүдэд туслахын тулд Сүм судрууд, сэтгүүлүүд, гарын авлага, ном товхимол, бусад материалуудыг хэвлэн гаргасан юм.

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид судрууд болон сургалтын бусад материалуудыг гэр орон, сүм дээр ашиглахын тулд олж авахад гишүүдийг урамшуулан дэмждэг.

Багш нар чуулгууд болон ангиудын хичээлд Сүмийн баталсан материалуудыг ашигладаг байх талаар удирдагчид анхаарна. *Instructions for Curriculum (Сургалтын хөтөлбөрийн заавруud)* товхимолд ням гарагийн хичээлүүдийг хэрхэн зохион байгуулах, ямар материалуудыг ашиглах тухай мэдээлэл байдаг.

### 21.1.14 Ганц бие гишүүд ба зуучлах байгууллага

Зуучлах байгууллагууд Сүмийн ганц бие гишүүдэд үйлчилгээгээ байнга сурталчилдаг. Сүмийн байрууд, ангиуд болон хөтөлбөрүүдийг хувийн бизнесийн үйл ажиллагааг сурталчлах, түүний дотор танилцуулан зуучлах ажилд ашиглаж болохгүй. Сүмийн туслах бүлгүүдийн жагсаалтууд, гишүүдийн тухай бусад мэдээллийг бизнесийн ийм байгууллагуудад өгөх ёсгүй.

### 21.1.15 Лавлахууд

Гадас, тойргийн лавлахуудыг дараах зааврын дагуу хэвлэж болно:

Нэр, хаяг, утасны дугаар нь улсын утасны лавлахад байдаг бол эсвэл байхгүй боловч тухайн гишүүн зөвшөөрсөн бол сүмийн лавлахад оруулж болно. Э-мэйлийн хаягийг зөвхөн тухайн гишүүний зөвшөөрлөөр оруулж болно.

Гадасны эсвэл тойргийн төсвөөс лавлах хэвлэн гаргах төлбөрийг хийнэ. Лавлахуудад зар сурталчилгаа оруулж болохгүй.

Удирдагчид гадас буюу тойргийн хил хязгаараас гадна лавлахуудыг тараах, тэдгээрийг арилжааны болон улс төрийн зорилгоор ашиглах ёсгүй.

Лавлах бүрийн эхэнд үүнийг зөвхөн Сүмийн зорилгоор ашиглах ёстой бөгөөд бишоп болон гадасны ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр хувилан олшруулах ёсгүй гэсэн анхааруулгыг оруулах ёстой.

### 21.1.16 Сүмийн гишүүдийн цагаачлал

Сүмийн гишүүдийг эх орондоо байж, Сүмийг бэхжүүлэхийг нь дэмждэг. Сүмийн үйл ажиллагаанд оролцох, сайн мэдээний адислалуудыг хүлээн авах, хуваалцах боломжууд дэлхий даяар асар ихээр өсөн нэмэгдэж байна. Дэлхий даяарх гишүүд эх орондоо байж, тэнд Сүмээ хөгжүүлэхийн төлөө ажиллавал тэд өөрсдөдөө болон Сүмд агуу адислалууд авчрах болно. Дэлхий даяарх гадас, тойргууд бэхжин хүчирхэгжиж, Тэнгэрлэг Эцэгийн бусад олон хүүхдүүдтэй сайн мэдээний адислалуудыг хуваалцах боломжтой болно.

Цагаачилсан хүмүүс хэл, соёл, ёс заншил, эдийн засгийн бэрхшээлүүдтэй байнга тулгарч, үүнээс үүдэн цөхөрч, хувь хүний болон гэр бүлийн хувьд хүнд байдалд орох нь олонтаа тохиолддог.

Номлогчид бусад орнууд руу цагаачлахыг хүсч буй гишүүдийг ивээн тэтгэхийг өөрсдийн эцэг эх, төрөл төрөгсөд, бусад хүмүүсээс гуйх ёсгүй.

Аль нэг улс орон руу цагаачилж буй гишүүд холбогдох хуулиудыг сахин биелүүлэх ёстой.

Оюутны ба жуулчны визээр АНУ болон бусад орнуудад очиж байгаа гишүүд тухайн оронд очсоныхоо дараа ажил олж хийх болон байнгын виз олж авахаар хөөцөлдөх ёсгүй.

Аливаа оронд Сүмийн шугамаар ажил эрхлэхийг сонирхсон хүн цагаачлалын болон харьяат болгох хуулийн бүх шаардлагуудыг хангасан байх ёстой. Сүмийн ажил эрхлэлтээр дамжуулан цагаачлахыг Сүм дэмждэггүй.

### 21.1.17 Мацгийн өдөр

Мацгийн өдөр гэдэг нь дараалсан хоёр хоол идэж, уухгүйгээр 24 цаг байж, мацаг ба гэрчлэлийн цуглаанд оролцон, тусламж хэрэгтэй хүмүүст анхаарал халамж тавихад туслахын тулд өгөөмөр мацгийн өргөл өгөхийг хэлдэг.

### 21.1.18 Хандив цуглуулах

13.6.8-ыг үзнэ үү.

### 21.1.19 Мөрийтэй тоглоом ба хонжворт сугалаа

Аливаа хэлбэрийн мөрийтэй тоглоом, түүний дотор төрөөс гаргасан хонжворт сугалааг Сүм дэмждэггүй.

### 21.1.20 Гаднаас ирж үг хэлэх ба хичээл заах тухай

Сүмийн ихэнх цуглаанууд дээр үг хэлж, хичээл заах хүмүүс нь тухайн тойрог буюу гадасны гишүүд байх ёстой.

Тойргийн аливаа цуглаан, түүний дотор туслах бүлгүүдийн цуглаануудад гаднаас ирж үг хэлэх эсвэл хичээл заахын өмнө бишопын зөвшөөрөл шаардлагатай. Мөн Гадасны цуглаануудын хувьд гадасны ерөнхийлөгчийн зөвшөөрөл шаардагдана.

Бишоп эсвэл гадасны ерөнхийлөгч нь зочин үг хэлэгч болон зочин багш нарын хэлэх үг, заах хичээлийг сайтар шалгах ёстой. Ийнхүү шалгахдаа тухайн хүний бишоптой нь холбоо барьж

болно. Бишоп, гадасны ерөнхийлөгч нар дараах зүйлсийг анхаарах ёстой:

1. Хэлэх үг, заах зүйл нь Сүмийн сургаалтай нийцэж байх ёстой.
2. Гаднаас ирж үг хэлж эсвэл хичээл зааж буй хүнд төлбөр төлөх ёсгүй. Тэрээр оролцогчдыг элсүүлэх эсвэл үйлчлүүлэгчээ болгон татах зүйл хийж болохгүй.
3. Гадны үг хэлэгч болон зочин багш нарын унааны зардлыг орон нутгийн нэгжийн төсвөөс болон хувь хүмүүсээс төлөх ёсгүй.
4. Хэлэх үг, заах хичээлүүд нь Сүмийн барилга байгууламжийг ашиглах удирдамжтай нийцэж байх ёстой (21.2-ыг үзнэ үү).

### 21.1.21 Орлогын татвар

Сүмийн гишүүд оршин суудаг улс орныхоо татварын хуулиудыг итгэлийн арванхоёрдугаар тунхгийн дагуу дуулгавартай дагах үүрэгтэй (мөн С ба Г 134:5-ыг үзнэ үү). Татварын хуулиа дэмждэггүй гишүүд эдгээрийг хууль тогтоомжуудаар эсвэл үндсэн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах замаар өөрчлүүлэхийг хичээж болно. Татварын хуулийн тухай эрхзүйн эсэргүүцлийг гишүүд шүүхээр шийдвэрлүүлж болно.

Татварын бичиг баримтыг бүрдүүлэх, орлогын татвараа төлөх болон татварын талаар шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс татгалзах нь Сүмийн хууль, сургаалыг зөрчсөн хэрэг юм. Ийм гишүүдэд ариун сүмийн бичиг олгох ёсгүй мөн тэднийг Сүмийн чухал хариуцлагатай дуудлагуудад дуудах ёсгүй. Татварын хуулийг санаатайгаар зөрчсөн гишүүдийг тухайн нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр Сүмийн сахилгын хурлаар авч хэлэлцэнэ.

### 21.1.22 Интернет

Зөв зохистойгоор хэрэглэсэн үед интернет нь Сүмийн ажлыг зохицуулж, итгэлийг бэхжүүлэн, бусдад үйлчлэл үзүүлэхэд тусалж чадна. Гэхдээ биечлэн уулзах боломжтой үед э-мэйлээр харилцах нь хүнтэй биечлэн харилцах боломжийг орлох учиргүй гэдгийг гишүүд анхаарах хэрэгтэй.

#### Сүмийн интернетийн албан ёсны эх сурвалжууд

Сүм бүх нийтээр ашиглах зориулалт бүхий албан ёсны нэлээд хэдэн вэб хуудас болон интернетийн бусад эх сурвалжуудыг бий болгосон юм. Эдгээр хуудас болон эх сурвалжуудыг Сүмийн логогоор эсвэл бусад хэлбэрээр албан ёсны болгосон юм. Эдгээр нь эрх зүйн болон Сүмийн оюуны өмчийн ба хувийн нууц хадгалалтын бодлогын шаардлагуудыг хангасан байдаг.

Зөвхөн Сүмийн албан ёсны интернетийн эх сурвалжуудыг ашиглан гадас, тойргийн вэб хуудсыг бий болгож болно. Сүмийн вэб хуудсын албан эх сурвалжийг ашиглахаас бусад тохиолдолд гадас, тойргуудыг вэб хуудас эсвэл блог зохиохыг зөвшөөрдөггүй.

Гадас, тойргийн вэб хуудас нь орон нутгийн нэгжүүдийн харилцаа, үйл ажиллагааг зохицуулахад тус дөхөм үзүүлж чадна. Эдгээр вэб хуудсуудад зарлал, үйл ажиллагаануудын хугацаа, удирдлагын болон гишүүнчлэлийн лавлахууд, барилга байгууламжийг ашиглах хуваариудыг тавьж болно. Хэрэв гадас, тойргийн вэб хуудас бий болгосон бол зорилгыг нь хэрэгжүүлэхийн тулд тогтмол, бүрэн дүүрэн ашиглах ёстой.

Гадасны ерөнхийлөгч Сүмийн албан ёсны эх сурвалжуудыг ашиглан гадас, тойргийн Вэб хуудас бий болгох зөвшөөрлийг хүсэхдээ Сүмийн удирдах газар дахь дараах албатай холбоо барина:

Member and Statistical Records Division
Attn: Local Unit Internet Resources
50 East North Temple Street, Room 1320
Salt Lake City, UT 84150-0013
Утас: 1-801-240-3500 эсвэл 1-800-453-3860,
дотуур утас 2-3500
Э-мэйл: msrmail@ldsmail.net

Гадас, тойргийн вэб хуудсын тухай нэмэлт мэдээллийг LDS.org дахь “LDS Site Development Guide”-аас үзэж болно.

Зарим үед Сүмийн албан ёсны вэб хуудсыг гадас дундын төслүүд, онцгой үйл явдал, ганц бие залуу насанд хүрэгчдийн үйл ажиллагаануудыг зохион байгуулах болон бусад зорилгоор ашиглахад зөвшөөрөл өгч болно. Ийм хуудсын зөвшөөрөл авахын тулд тухайн байгууллагын санваартны удирдагч уг зорилго болон хэрэгцээг нотолсон хүсэлтээ Дальн Ерөнхийлөгчийн эсвэл Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнд явуулна.

Ариун сүм, номлол, зочдын төвүүдийг вэб хуудастай болохыг зөвшөөрдөггүй.

#### Гишүүд Сүмийн дуудлагадаа интернетийг ашиглах нь

Гишүүд Сүмийн дуудлагуудаа ашиглах вэб хуудсууд болон блогуудыг интернетийн бусад эх сурвалжуудыг ашиглан бий болгож болно. Харин тэд “Энэ бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн албан ёсны вэб хуудас биш” гэсэн тодотголыг оруулах хэрэгтэй. Гишүүд бас дараах удирдамжуудыг баримтлах ёстой:

1. Сүмийн логог ашиглах буюу дууралган хийж болохгүй.
2. Вэб хуудсыг хариуцсан гишүүний нэр, холбоо барих мэдээллийг оруулах ёстой.
3. Өөрсдийнх нь вэб хуудас буюу үйл ажиллагааг Сүм ивээн тэтгэж байгаа эсвэл баталж байгаа гэсэн үгс, мэдээллийг оруулж болохгүй.
4. Сүмийн эзэмшдэг урлагийн бүтээл, хөгжим, бусад материалуудыг Сүмийн албан ёсны вэб хуудсын "Rights and Use Information" хуудсын эсвэл Сүмийн Оюуны Өмчийн Албанаас (IPO) ашиглах зөвшөөрөл аваагүй бол авч байршуулж болохгүй.
5. Бусад хүмүүсийн гэрэл зураг эсвэл тэдний тухай хувийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр вэб хуудсанд байршуулж болохгүй.

#### Интернетийг хувиараа ашиглах нь

Гишүүдийг бүх цаг үед, бүх газарт, түүний дотор интернетэд сүмийн гишүүний хувьд үлгэр жишээ байхыг дэмждэг. Хэрэв тэд блог, олон нийтийн сүлжээ болон интернетийн бусад технологийг ашигладаг бол бусдыг хүчирхэгжүүлж, тэдэнд ашигтай, сайн, магтууштай зүйлсийг мэдэхэд нь туслахад тэднийг хөхүүлэн дэмжих хэрэгтэй. Боломж гарсан үед Сүмийг дурдаж, Сүмийн баталсан материалуудад холбогдон, хуваалцахад гишүүдийг дэмждэг.

Гишүүд Сүмийн дуудлагуудаас өөр зорилгоор интернетийг ашиглаж байгаа үед тэдний захиас хувийн чанартайг ойлгох ёстой. Тэд Сүмийг төлөөлдөг эсвэл Сүм тэднийг ивээн тэтгэдэг гэсэн сэтгэгдлийг төрүүлэх ёсгүй.

LDS.org дахь "Internet Usage Helps for Members"-т хайлт хийх замаар нэмэлт тусламж, удирдамжуудыг үзэж болно.

### 21.1.23 Улсын хууль тогтоомж

Сүмийн гишүүд өөрсдийн оршин суудаг болон очсон улс орныхоо хуулиудыг дуулгавартай дагаж, хүндэлж, дэмжих ёстой (С ба Г 58:21–22, Итгэлийн Тунхаг 1:12-ыг үз). Үүнд шашин дэлгэрүүлэхийг хориглодог хуулиуд мөн орно.

### 21.1.24 Гишүүд Сүмийн удирдах газартай харилцах нь

Сүмийн гишүүдийг сургаал болон хувийн асуудлуудын талаар Ерөнхий Эрх мэдэлтнүүд рүү утасдаж, захидал бичихийг дэмждэггүй. Сүмийн гишүүнчлэл маш хурдтайгаар өсч байгаа учир эдгээр асуултуудад биечлэн хариулах нь хүч хүрэх аргагүй ажил бөгөөд үүргээ биелүүлэхэд нь хүндрэл учруулж болно. Ерөнхий Эрх мэдэлтнүүд Сүмийн гишүүдийг хайрладаг бөгөөд тэд өөрсдөд нь шаардлагатай удирдамж, дэмжлэгээр хангахгүй байна гэсэн сэтгэгдэл төрүүлэхийг хүсдэггүй. Гэвч бүх зүйл мэргэн ухаан, дэг журмаар хийгддэг байх хэрэгтэй.

Гишүүн бүрд сүнслэг зөвлөгч байж, амьдралын асуудлуудад нь зөвлөгчийн үйлчлэл үзүүлдэг бишоп, салбарын ерөнхийлөгч, гадас, дүүргийн болон номлолын ерөнхийлөгчтэй байлгахаар Их Эзэн мэргэн ухаанаар өөрийн Сүмийг зохион байгуулсан билээ. Тэдний дуудлагын учир орон нутгийн удирдагч нарт гишүүддээ зөвлөх илчлэлтийн болон ялган таних чадварын сүнс өгөгддөг.

Сүнсний удирдамж хэрэгтэй, хэцүү асуудалтай эсвэл сургаалын талаар асуулт бүхий гишүүд чин сэтгэлээсээ залбирч, судар судлах зэргээр асуултуудынхаа хариуг өөрсдөө олохын төлөө шаргуу хүч чармайлт гаргах ёстой. Хувийн амьдралдаа, гэр бүлдээ, түүнчлэн Сүмийн үүрэгт ажлуудынхаа төлөө Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийлэхэд гишүүдийг дэмжих ёстой.

Хэрэв тэдэнд тусламж хэрэгтэй бол тэд хамгийн түрүүнд бишоптойгоо зөвлөлдөх ёстой. Шаардлагатай бол бишоп тэднийг гадасны ерөнхийлөгч уруу явуулж болно.

Ихэнх тохиолдолд Ерөнхий Эрх мэдэлтнүүдэд гишүүдээс ирсэн аливаа захидал бичгийг орон нутгийн удирдагчдад буцаан явуулдаг. Сургаалын болон Сүмийн бусад асуудлуудын талаар тодруулга хэрэгтэй байгаа гадасны ерөнхийлөгч гишүүдийнхээ төлөө Тэргүүн Зөвлөлд хандан бичиж болно.

### 21.1.25 Гишүүдийн ажил, мэргэжил болон бусад байгууллагын гишүүнчлэл

Сүмд баптисм хүртэх, санваар хүртэх түүнчлэн ариун сүмийн бичиг олгох нь дэлгэрэнгүй ярилцлагаар тогтоогддог ба хувь хүн бүрийн зохистой байдал дээр тулгуурладаг. Ингэснээрээ тэд сайн мэдээний зарчмууд хийгээд Аврагчийн сургаалуудад нийцэх Их Эзэний адислалуудыг хүсч болохын тулд сүмийн үйл ажиллагаа болон ажил хөдөлмөртөө тууштай байх ёстой.

### 21.1.26 Хөгжлийн бэрхшээлтэй гишүүд

Сүмийн гишүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ойлгож, итгэл найдвар өгч, хайраа харуулдаг Аврагчийн үлгэр жишээг дагахыг дэмждэг. Санваартны болон туслах бүлгүүдийн

удирдагчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сайн мэддэг байж, чин сэтгэлээсээ анхаарал тавих ёстой.

Эцэг эх, хүүхэд, ах, эгч нар нь хөгжлийн бэрхшээлтэйн улмаас нэмэлт ачаалалтай байж мэдэх гишүүдээ санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид мэддэг байх хэрэгтэй. Гэр бүлийнхээ хөгжлийн бэрхшээлтэй гишүүнийг халамжлах нь итгэлийг бэхжүүлэн төгөлдөржүүлдэг. Гэвч энэ нь санхүү, гэрлэлт, гэр бүлд бэрхшээл учруулж болно.

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид нь гэр бүлийн гишүүдээсээ хол, нийтийн байр, бусад газруудад амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй гишүүдийг олж тогтоох хэрэгтэй.

### Хөгжлийн бэрхшээлтэй гишүүдийг ойлгодог байх нь

Удирдагчид, багш нар болон бусад гишүүд хүний хөгжлийн бэрхшээл болон үүнтэй холбоотой хэрэгцээг ойлгохыг хичээдэг байх ёстой. Тэд тухайн хүнтэй болон гэр бүлийнх нь гишүүдтэй ярилцсанаар тэднийг илүү сайн ойлгодог. Тэд Сүмийн удирдагчдын хэлсэн үгс, Сүмийн сэтгүүлүүдэд нийтлэгдсэн өгүүллүүд, disabilities.lds.org дахь онлайны эх сурвалжуудыг унших болно.

### Тусламж үзүүлэх нь

Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэднийг халамжлагчдын хэрэгцээг олж тогтоодог. Хэрэгцээг зохих ёсоор шийдвэрлэхэд туслахын тулд тойрог, гадасны эх үүсвэрүүдийг хэрхэн ашиглахыг эдгээр удирдагчид тодорхойлдог. Гишүүдийг хайр болон нөхөрлөлөөр хүмүүст хүрч ажиллан, тусалдаг байхад нь удирдагчид дэмждэг. Бишопын зөвлөл болон гадасны ерөнхийлөгчийн зөвлөл нь хувь хүмүүс, гэр бүлүүдэд туслах тойргийн эсвэл гадасны хөгжлийн бэрхшээлтэй гишүүдийн асуудал хариуцсан зохицуулагчийг дуудаж болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлд тусламж үзүүлдэг нийгмийн эх үүсвэрүүдийг удирдагчид бас олж тогтоож болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах тухай нэмэлт мэдээллийг удирдагчид, гишүүд disabilities.lds.org-с үзэж болно. Удирдагчид ХҮГ Гэр Бүлийн Хөтөлбөртэй (ийм хөтөлбөр хэрэгжиж буй газарт) холбоо барьж болно.

Тухайн гэр бүлд яагаад хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа тухай удирдагчид болон гишүүд тайлбарлах гэж оролдох хэрэггүй. Хөгжлийн бэрхшээл бол Бурханы шийтгэл гэж тэд хэзээ ч хэлж болохгүй (Иохан 9:2–3-г үзнэ үү). Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй байгаа нь адислал ч гэж хэлэх ёсгүй.

### Ёслолуудыг гүйцэтгэх нь

Санваартны удирдагчид оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүнд ёслол гүйцэтгэх тухай асуудлыг авч үзэхдээ *Гарын авлага 1-ийн* 16.1.8 дахь удирдамжийг баримтална.

### Үйлчлэх, оролцох боломж олгох нь

Хөгжлийн бэрхшээлтэй олон гишүүд Сүмийн ихэнх ажил үүрэгт үйлчилж болно. Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид хүн бүрийн үйлчлэх чадвар, хүслийг залбирч үзээд, тохирох үйлчлэх боломжоор хангадаг. Удирдагчид нь тухайн хүний гэр бүлд зөвлөгөө өгч, Сүмийн дуудлага нь түүнд болон гэр бүлд нь эсвэл халамжлагчид нь хэрхэн нөлөөлөхийг авч үзэх ёстой.

Удирдагчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг халамжилдаг хүмүүст Сүмийн ажил үүрэг, дуудлага өгөхдөө хувь хүмүүс болон гэр бүлүүдийн нөхцөл байдлыг сайтар анхаарах хэрэгтэй.

Удирдагчид болон багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хурал цуглаан, хичээл, үйл ажиллагаануудад аль болохоор бүрэн оролцуулж байх хэрэгтэй. Хичээл, хэлэх үг, заах арга барилыг хүн бүрийн хэрэгцээнд тохируулах хэрэгтэй. Хичээлүүдийг тохируулан өөрчлөх тухай мэдээллийг disabilities.lds.org-оос үзнэ үү.

Бишопын зөвлөлөөс хөгжлийн бэрхшээлтэй хүнд хичээл дээр туслах багшийн туслахыг дуудаж болно. Мөн цуглаан, үйл ажиллагаан дээр хөгжлийн бэрхшээлтэй хүнд туслахыг хэн нэгнээс хүсч болно.

Хэрэв уг хүн цуглаан, хичээл, үйл ажиллагаанд оролцож чадахгүй бол удирдагчид, багш нар түүний хэрэгцээг хэрхэн шийдвэрлэх тухай гэр бүлтэй нь зөвлөлдөж болно. Гадасны ерөнхийлөгч эсвэл бишоп хөгжлийн бэрхшээлтэй гишүүдэд зориулан тусгай хичээл, хөтөлбөрүүдийг зохион байгуулж, батлан хэрэгжүүлж болно (доорх "Тусгай анги, хөтөлбөр, нэгжийг зохион байгуулах нь" хэсгийг үзнэ үү). Тухайн хүн Сүмийн цуглаануудад оролцох боломжгүй бол хичээл, хэлсэн үгсийн бичлэг болон хэвлэмэл материалуудаар хангаж болно.

Санваартны удирдагчид санваар эзэмшигч эрэгтэйчүүдийг тохиромжтой үед ёслолуудад оролцохыг нь дэмжих хэрэгтэй. Санваартнууд болон 12 ба түүнээс дээш настай баптисм хүртэж, гишүүнээр батлагдсан зохистой

эмэгтэйчүүд ариун сүмд нас барагсдын өмнөөс баптисм хүртэж, гишүүнээр батлуулж болно. Хөгжлийн бэрхшээлтэй гишүүд ариун сүмд хувийн хишиг хүртэх тухай удирдамж *Гарын авлага 1-ийн* 3.3.3-т байдаг.

### Тусгай анги, хөтөлбөр, нэгжийг зохион байгуулах нь

Хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээтэй гишүүд Сүмийн тусгай зохион байгуулагдсан асрах байранд амьдардаггүй бол тэднийг харьяалагддаг тойрогтоо ням гарагийн цуглаануудад оролцохыг нь дэмждэг.

Тойрог буюу гадсанд хөгжлийн адил төстэй бэрхшээлтэй гишүүд байдаг бол удирдагчид тэдэнд зориулан тусгай Мючел эсвэл Хүүхдийн Хэсгийн тусгай анги, хөтөлбөрүүдийг зохион байгуулж болно. Удирдагчид ням гарагийн ангийн тусгай анги болон бусад ангиудыг зохион байгуулж болно. Эдгээр хичээл, хөтөлбөрүүдийг тухайн тойргийн хичээлийн хөтөлбөрт нэмж оруулж болдог.

Гадас дундын түвшинд тусгай анги буюу хөтөлбөрийг зохион байгуулахад Далын эсвэл Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүний зөвшөөрөл шаардлагатай. Эдгээр удирдагчид тусгай хуваариар хичээллэх анги буюу хөтөлбөрийг зохион байгуулж үйл ажиллагаанд нь хяналт тавих хариуцагч гадасны ерөнхийлөгчийг томилно.

Тойрог дундын түвшинд тусгай анги, хөтөлбөрийг зохион байгуулахад гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн зөвшөөрөл шаардлагатай. Гадасны ерөнхийлөгч тусгай хуваариар хичээллэх анги буюу хөтөлбөрийг зохион байгуулж үйл ажиллагаанд нь хяналт тавих хариуцагч бишопыг томилно.

Хариуцагч гадасны ерөнхийлөгч болон бишоп нь оролцогч гадаснуудын ерөнхийлөгч эсвэл бишопуудтай зөвлөлдөж, эдгээр ангиуд буюу хөтөлбөрүүдийг санхүүгийн талаар дэмжих журмыг гаргана. Эцэг эхчүүд эсвэл халамжлагчид нь унаа тээврийг хариуцна.

Гадас дундын анги буюу хөтөлбөр зохион байгуулагдсан бол оролцогч гадас бүрийн ерөнхийлөгч нар тусгай анги, хөтөлбөрт хамрагдахыг хүссэн гишүүдийг элсүүлэх ажлыг зохицуулахад тусалж, удирдагчид болон багш нараар хангах, хариуцагч гадасны ерөнхийлөгчийн боловсруулсан санхүүжилтийн журмыг мөрдүүлэх дээд зөвлөлийн гишүүдийг томилж болно.

Тусгай анги, хөтөлбөрт үйлчлэх гишүүдийг хариуцагч нь гадасны ерөнхийлөгчөөр эсвэл бишопоор эсвэл тэдний удирдлага дор санваартнаар дуудагдаж, адислагдана. Эдгээр удирдагчид дуудлага өгөх, дуудлагаас чөлөөлөхдөө Сүмийн ердийн журмыг баримтална. Тусгай анги, хөтөлбөрийн удирдагчид болон багш нар гишүүдийн үйл ажиллагаа, амжилтын тухай мэдээллийг харьяалагддаг тойргийн удирдагчдад мэдээллэх ба тэнд байнгын бүртгэл нь хадгалагдаж урамшуулал өгдөг.

Хариуцагч гадасны ерөнхийлөгч эсвэл бишоп урьсан үед тусгай анги, хөтөлбөрийн удирдагч нар гадасны эсвэл тойргийн удирдлагын хуралд оролцож болно. Тэд тусгай анги, хөтөлбөрийн үйл ажиллагааг төлөвлөхийн тулд өөрсдийнхөө хурлыг хийж болно.

Удирдагчид Сүмийн Боловсролын Системийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй гишүүдэд зориулсан ангиуд байгуулах боломжийн талаар мэдэхийн тулд Шашны семинар, институтийн зохион байгуулагчидтай холбоо барьж болно.

Сонсголын бэрхшээлтэй гишүүдийн тойрог, салбарыг зохион байгуулж болно. Эсвэл газарзүйн тодорхой бүсийн хүрээнд сонсголын бэрхшээлтэй гишүүдийн бүлэг байгуулахыг тойргоос хүсч болно. Ийм тойрог, салбар, эсвэл бүлэг нь үйлчлэлд бүрэн оролцож, сайн мэдээнээс суралцахад сонсголын бэрхшээлтэй гишүүдэд тусалдаг. Эдгээр нэгжүүдийг зохион байгуулах тухай заавар *Гарын авлага 1-ийн* 9.1.4 болон 9.1.10-т байдаг.

Дохионы хэлээр харилцдаг гишүүд болон тэдний гэр бүл Сүмийн гишүүнчлэлийн бүртгэлээ дараах газруудын аль нэгэнд байлгахаар сонгож болно: (1) харьяалагддаг тойрогтоо, (2) сонсголын бэрхшээлтэй гишүүдийн бүлэг байгуулсан тойрогт, (3) сонсголын бэрхшээлтэй гишүүдэд зориулж зохион байгуулсан тойрог эсвэл салбарт.

### Сонсголын бэрхшээлтэй гишүүдэд зориулж хөрвүүлэг хийгчид

Сайн мэдээний зарчим, сургаалуудаас суралцахад сонсголын бэрхшээлтэй гишүүдэд харилцааны бэрхшээл тулгардаг. Хэрэв тэд дохионы хэлээр харилцдаг бол Сүмийн цуглаан, санваарын ёслолууд, ариун сүмийн ажил, гэрчлэлээ хуваалцах, ярилцлага, үйл ажиллагаануудад бүрэн оролцоход нь туслах хөрвүүлэгчид тэдэнд хэрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй гишүүд бие даах чадвартай байж, өөрсдөдөө хэрэгтэй дохионы хэлээр хөрвүүлэгчдийг бий болгох ажлыг санваартны удирдагчидтай хамтран санаачлан зохион байгуулахыг дэмжинэ. Ганцаарчилсан ярилцлага, Сүмийн сахилгын хурал зэрэг эмзэг

нөхцөл байдалд хөрвүүлэгч хэрэглэх эсэх тухай санваартны удирдагчид уг гишүүнтэй зөвлөлдөж шийднэ. Энэ тохиолдолд удирдагчид гэр бүлийнх нь гишүүн бус хөрвүүлэгчийг (боломжтой бол) олохыг хичээх ёстой.

Хангалттай хөрвүүлэгчид байхгүй бол удирдагчид өөрийн бүст хэрэглэгддэг дохионы хэлийг заах тойргийн эсвэл гадасны хичээлийг зохион байгуулж болно. Энэ хичээлийг заах мэргэшсэн гишүүдийг удирдагчид дуудаж болно. Сонсголын бэрхшээлтэй бөгөөд дохионы хэлээр харилцдаг гишүүд хамгийн түрүүнд дээрх хичээлийг заах хэрэгтэй. Ашигтай эх сурвалж бол *Dictionary of Sign Language Terms for The Church of Jesus Christ of Latter-day Saints (Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Дохины хэлний нэр томьёоны толь бичиг)* юм.

Зөвхөн зохистой гишүүд ариун ёслолын цуглаан, санваартны хурлууд, ярилцлагуудыг дохионы хэлээр хөрвүүлэх ёстой. Санваартнуудын хурлын үеэр хөрвүүлэх санваартан байхгүй бол тэргүүлэх эрх мэдэлтэн дохионы хэлээр хөрвүүлэг хийж өгөхийг эмэгтэй хүнээс хүсч болно. Гишүүд дохионы хэлээр хөрвүүлэх чадвартай болтол үйл ажиллагаа болон бусад хурал цуглаан дээр гишүүн бус сайн дурын дохионы хэлээр хөрвүүлэгчийг түр хугацаагаар ашиглаж болно.

Хэрэв ёслол буюу адислалыг хүлээн авагч нь сонсголын бэрхшээлтэй бол дохионы хэлээр хөрвүүлэг хийж өгөхийг тэргүүлэх эрх мэдэлтэн нэг санваартнаас хүсч болно. Санваартан байхгүй бол дохионы хэлээр хөрвүүлэг хийж өгөхийг тэргүүлэх эрх мэдэлтэн эмэгтэй хүнээс хүсч болно.

Хичээл буюу хурал цуглааны үеэр хөрвүүлэгчид индэр дээр биш, ангийн эсвэл ариун ёслолын танхимын өмнө талд байна. Мөн үг хэлэгчээс бусдын анхаарлыг сарниулахааргүй зайд байх хэрэгтэй. Сонсголын бэрхшээлтэй гишүүд ярьж байгаа хүний уруулын хөдөлгөөн, дохио зангааг харснаар ойлгодог учраас, хөрвүүлэгчийг болон багшийг нэг зэрэг харж чадахаар байх ёстой. Хангалттай тооны дохионы хэлний хөрвүүлэгчид байдаг бол амарч болохын тулд ойролцоогоор 30 минутаар ээлжилж хөрвүүлэг хийхийг удирдагчид тэднээс хүсч болно.

Санваарын ёслол болон ярилцлагын үеэр хөрвүүлэгч нь ёслол гүйцэтгэж байгаа буюу ярилцлага хийж байгаа хүнд ойрхон байх хэрэгтэй.

Сонсголын бэрхшээлтэй гишүүд дохионы хэл мэддэггүй боловч уруулын хөдөлгөөнийг харж уншихад туслах хөрвүүлэгчид хэрэгтэй бол дохионы хэл хөрвүүлэгчдийг олоход баримталдаг журмыг удирдагчид баримтална.

#### Гишүүдийн хувийн мэдээлэл

Хувь хүмүүсийн хэрэгцээг хэлэлцсэн удирдлагын хурлын үеэр болон дараа нь удирдагчид гишүүдийн хувийн мэдээлэлд хүндэтгэлтэй хандах ёстой.

#### Эх сурвалж материалууд

Хөгжлийн бэрхшээлтэй гишүүд, тэдний гэр бүл, халамжлагчид, түүнчлэн удирдагчид, багш нарт зориулсан эх сурвалж материалууд disabilities.lds.org-т байдаг. Энэхүү вэб хуудсанд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг сорилтуудыг ойлгох ойлголтоо нэмэгдүүлэхэд туслах мэдээлэл.
2. Хөгжлийн бэрхшээлийн төрлүүд болон асуулт хариултууд.
3. Судрууд, эшлэлүүд болон хэрэгтэй эх сурвалжуудаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй гишүүд болон тэдний гэр бүлийг тайтгаруулах зүйлс.
4. Хөгжлийн бэрхшээлтэй гишүүдийг Есүс Христийн сайн мэдээгээр амьдарч, Сүмд үйлчлэхэд нь туслах материалуудын жагсаалт.

Хөгжлийн бэрхшээлтэй гишүүдэд зориулсан Сүмийн материалуудыг *Church Materials Catalog* болон disabilities.lds.org-д жагсаасан байгаа.

Хөгжлийн бэрхшээлтэй гишүүдэд зориулсан материалуудын тухай асуултуудыг дараах хаягаар хандан тавьж болно:

Members with Disabilities<br>
50 East North Temple Street<br>
Salt Lake City, UT 84150-0024<br>
Утас: 1-801-240-2477<br>
Э-мэйл: specialcurriculum@ldschurch.org

### 21.1.27 Бусад шашнууд

Бусад шашнуудад олон сайн зүйлс байдаг. Номлогчид болон Сүмийн бусад гишүүд бусдын итгэл бишрэлд мэдрэмжтэй, хүндэтгэлтэй хандаж, тэднийг гомдоохоос зайлсхийх ёстой. Христийн бус шашнуудтай харилцах тухайд бэрхшээл тулгарч буй гадасны болон номлолын ерөнхийлөгч нар Далын эсвэл Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гишүүнтэй холбоо барих ёстой. Ийм асуудлуудтай тулгарсан орон нутгийн удирдагчид гадасны эсвэл номлолын ерөнхийлөгчтэй холбоо барих хэрэгтэй.

### 21.1.28 Хоногоор явах үйл ажиллагаа

13.6.12 and 21.2.8-ыг үзнэ үү.

### 21.1.29 Улс төр, олон нийтийн үйл ажиллагаа

Сүмийн гишүүдийг иргэнийхээ хувьд улс төрийн болон төр засгийн, түүний дотор өөрсдийнхөө сонгосон улс төрийн намын ажил хэрэгт оролцохыг дэмждэг. Хамт олон нийгмээ хөгжүүлэх зөв зохистой ажил хэрэгт оролцож, нийгэм, хамт олныг гэр бүлээ авч явах, эрүүл саруул, аятай таатай орчин бий болгох үйлсэд идэвхтэй оролцохыг гишүүдээс хүсэн хүлээдэг билээ.

Гишүүдийг өөрсдийн төр засгийн хуулийн дагуу санал өгөхөөр бүртгүүлэх, улс орны асуудлууд болон нэр дэвшигчдийг анхааралтайгаар судлах, мөн шударга болон мэргэн ухаанаар ажиллана гэж үзсэн хүмүүсийн төлөө санал өгөхийг дэмждэг. Зарчимч шударга, сайн, ухаалаг удирдагчдыг эрж олон, тэдний төлөө саналаа өгч, дэмжих онцгой үүрэг Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд байдаг (С ба Г 98:10-ыг үзнэ үү).

Улс төр, нийгмийн асуудлуудаар санал бодлоо илэрхийлэх эрхийг дэмждэг боловч Сүм нь улс төрийн намууд, тэдний байр суурь болон нэр дэвшигчдийн тухайд төвийг сахидаг. Сүм ямар ч улс төрийн нам эсвэл нэр дэвшигчийг дэмждэггүй. Мөн саналаа яаж өгөхийг гишүүддээ зөвлөдөггүй. Гэвч зарим онцгой тохиолдолд аль нэг хууль тогтоомж, ялангуяа ёс суртахууны асуудлуудтай холбоотой хууль тогтоомж гаргахад Сүм байр сууриа илэрхийлэх болно. Зөвхөн Тэргүүн Зөвлөл Сүмийг төлөөлөн ярих бөгөөд аль нэг хууль тогтоомжийг Сүм дэмжих, эсэргүүцэх буюу хууль зүйн асуудлуудад оролцох эсэхийг шийднэ. Бусдаар бол гадасны ерөнхийлөгчид болон орон нутгийн бусад удирдагчид улс төрийн асуудлуудад оролцохыг зохион байгуулах эсвэл хэрхэн оролцох талаар тэдэнд нөлөөлөхийг хичээж болохгүй.

Сүмийн гишүүдийг орон нутгийн болон төрийн албанд сонгогдох эсвэл томилогдон ажиллахыг сайшаадаг. Төрийн албанд нэр дэвшигчид нэрээ Сүмээр эсвэл Сүмийн удирдагчдаар дэмжүүлэх ёсгүй. Сүмийг аливаа улс төрийн нам, тэдний байр суурь эсвэл нэр дэвшигчийг дэмждэг хэмээн ташаа ойлгож болох мэдээлэл буюу үйлдлээс Сүмийн удирдагчид болон гишүүд зайлсхийх ёстой.

Нийгмийн ёс суртахууныг, ялангуяа нийгмийн үндсэн нэгж болсон гэр бүлийг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг дэмжихэд гишүүдийг дэмждэг.

Сүмийн бүртгэл, лавлах, шуудангийн жагсаалтууд болон эдгээртэй адил төстэй материалуудыг улс төрийн зорилгоор ашиглаж болохгүй.

Сүмийн барилга байгууламжуудыг улс төрийн зорилгоор ашиглаж болохгүй. Гэхдээ өөр хувилбар байхгүй тохиолдолд Сүмийн барилга байгууламжийг санал өгөгчдийг бүртгэх болон санал авах байр болгон ашиглаж болно (21.2-ыг үзнэ үү).

### 21.1.30 Шуудангийн хууль дүрэм

АНУ болон бусад зарим оронд шуудангийн төлбөргүйгээр аливаа материалыг шуудангийн хайрцагт хийх эсвэл дээр нь тавих юм бол шуудангийн дүрэм журмыг зөрчсөнд тооцогддог. Энэхүү заавар тойргийн болон гадасны үйл ажиллагааны тухай мэдээлэл, зарлал, Сүмтэй холбоотой бусад материалуудад хамаатай. Ийм зүйлсийг шуудангийн хайрцагт хийх буюу дээр нь тавих ёсгүйг Сүмийн удирдагчид гишүүдэд зааварлах ёстой.

### 21.1.31 Гишүүдийн хувийн мэдээлэл

Сүмийн удирдагчид гишүүдийн хувийн мэдээллийг хамгаалах үүрэгтэй. Сүмийн бүртгэл тайлангууд, лавлахууд, түүнчлэн эдгээртэй адил төстэй материалуудыг хувийн, арилжааны эсвэл улс төрийн зорилгоор ашиглаж болохгүй (мөн 21.1.15 ыг үзнэ үү).

### 21.1.32 Хувийн журмаар хэвлүүлсэн зохиол бүтээлүүд

Гишүүд Ерөнхий эрх мэдэлтнүүд болон Бүсийн Далуудаас хамтран зохиогч болохыг эсвэл Сүмийн номнууд, бусад бичээсүүдэд батламж өгөхийг хүсэх ёсгүй.

### 21.1.33 Ерөнхий Эрх мэдэлтнүүд, Бүсийн Далуудын хэлсэн үгийн бичлэг хийх тухайд

Гадасны чуулган, номлогчдын хурлууд, бусад цуглаанууд дээр Ерөнхий эрх мэдэлтнүүд болон Бүсийн Далуудын хэлсэн үгсийн бичлэгийг Сүмийн гишүүд хийх ёсгүй. Ерөнхий чуулганы шууд нэвтрүүлгүүдийн бичлэгийг гишүүд арилжааны бус, хувийн хэрэглээнд зориулж, гэртээ хийж болно.

### 21.1.34 Сүм болон Сүмийн гишүүдийг дурдах нь

Сүм олон улс орон, соёл, ёс заншил, хэлтэн үндэстнийг хамран өсч байгаа үед Сүмийн илчлэгдсэн нэр болох Есүс Христийн Хожмын үеийн Гэгээнтнүүдийн Сүм гэдэг (С ба Г

115:4-ийг үзнэ үү) нэрийг хэрэглэх нь Аврагчийн нэрийг бүх дэлхий даяар тунхаглах бидний үүрэг хариуцлагад илүү их чухал болсоор байна. Иймээс боломжтой тохиолдолд Сүмийг хэлэхдээ бүрэн нэрийг нь хэлж байх ёстой. Сүмийн бүтэн нэрний товч хувилбарууд нь "Сүм" эсвэл "Есүс Христийн Сүм" байж болно.

Сүмийг "Мормоны Сүм," "Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм" эсвэл "ХҮГ Сүм" гэж нэрлэхгүй байвал зохино.

Сүмийн гишүүдийг нэрлэхдээ, "Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээтнүүдийн Сүмийн гишүүд" гэсэн нийлэмж үгийг хэрэглэх нь зүйтэй. Товчилсон хэлбэрээр, "Хожмын Үеийн Гэгээнтнүүд" гэж болно. Мөн "Мормончууд" гэж болно.

*Мормон* гэдэг үг Мормоны Ном эсвэл Мормоны Табернеклын Найрал дуучдад оноосон нэр болон хэрэглэгдсээр байх болно. Мөн энэ үг "Мормоны анхдагчууд" зэрэг нийлэмж үгсэд тэмдэг нэрийн утгаар хэрэглэгдэж болно. Түүнээс гадна *Мормон* гэдэг үг зарим оронд Сүмийг таних нийтийн мэддэг үг болгон хэрэглэгдэх нь зайлшгүй байж болно.

### 21.1.35 Сүм дэх судалгааны ажлууд

Судалгаа хийх эрх бүхий Сүмийн цорын ганц байгууллага бол Research Information Division of the Correlation Department (Зохицуулалтын Газрын Мэдээлэл Судалгааны Хэлтэс) юм. Энэ газрын төлөөлөгчид Ерөнхий Эрх мэдэлтнүүдэд шаардлагатай мэдээлэл цуглуулахын тулд санал асуулгын хуудас, ярилцлагуудыг ашигладаг. Эрх олгогдсон Сүмийн судлаачдыг гишүүдтэй холбоо барихад нь Сүмийн төлбөргүй утасны дугаар болон удирдах газрын холбоо барих хүний нэрийг өгдөг. Түүнээс гадна судалгааны зарим асуултад хариулахгүй байх эсвэл бүх асуултанд хариулахгүй байж болохыг гишүүдэд хэлнэ.

Зөвшөөрөл олгогдоогүй хүмүүс болон агентлагууд мэдээлэл цуглуулахын тулд Сүмийн цуглаануудыг ашиглах ёсгүй. Мөн Сүмийн гишүүдийн нэрсийг дээрх хүмүүс болон агентлагуудад өгөх ёсгүй. Хэрэв орон нутгийн удирдагчид санал асуулга эсвэл ярилцлага хийх зөвшөөрлийг нь шалгахыг хүсвэл, тэд Research Information Division (утас 1-801-240-2727 эсвэл 1-800-453-3860, дотуур утас 2-2727)-тэй холбоо барих хэрэгтэй.

### 21.1.36 Худалдааны байгууллага

Бүтээгдэхүүнээ борлуулахын тулд Сүм болон Сүмийн удирдагч нарын нэрийг барьдаг худалдааны байгууллагыг Сүмийн удирдагч нар хүлээн зөвшөөрөх ёсгүй.

### 21.1.37 Хиймэл дагуулын болон видео төхөөрөмж

Сүмийн хиймэл дагуулын болон видео төхөөрөмжийг арилжааны бус, зөвхөн Сүмтэй холбоотой зорилгоор гадасны ерөнхийлөгчийн зөвлөл буюу бишопын зөвлөл зөвшөөрөл олгосноор ашиглаж болно. Энэ төхөөрөмжийг Сүмийн бус телевиз, кабелийн болон хиймэл дагуулын хөтөлбөрүүдийн бичлэг хийхэд ашиглаж болохгүй. Мөн Сүмийн хиймэл дагуулын төхөөрөмжийг Сүмийн биш хөтөлбөрүүдийг үзэхэд ашиглаж болохгүй. Сүмийн удирдах газрын зөвшөөрөлгүйгээр гишүүд хиймэл дагуулын болон дамжуулагчийн нэг сувгаас нөгөө рүү антенныг чиглүүлж болохгүй.

Зөвхөн сургагдсан хүмүүс л төхөөрөмжийг ажиллуулж болно. Төхөөрөмжийг ажиллуулахад залуучууд тусалж болох боловч зөвхөн хяналтан дор ажиллах ёстой.

Ашиглаагүй байгаа үед бүх төхөөрөмжийг цоожтой байлгах ёстой. Гэртээ эсвэл хувиараа ашиглахаар төхөөрөмжийг сүмийн байрнаас авч явж болохгүй.

### 21.1.38 Санхүүгийн тусламж хүсэх нь

Сүмийн үндэслэсэн хөтөлбөрүүд нь зохистой хувь хүмүүст болон зөв зорилгуудыг хэрэгжүүлэхэд санхүүгийн туслалцаа үзүүлдэг. Сүмийн тусламж үзүүлэх ажлыг бишопууд хариуцдаг. Учир нь тэд нөхцөл байдлыг сайн мэддэг бөгөөд тусламж дэмжлэг давхардах, үүнийг буруугаар ашиглахаас сэрэмжилдэг. Тийм учраас гишүүд Сүмийн удирдах газраас эсвэл орон нутгийн удирдагчид болон гишүүдээс санхүүгийн нэмэлт тусламж хүсэх ёсгүй.

Хэрэв гишүүд санхүүгийн туслалцаа хүссэн хүсэлт хүлээж авбал Сүмийн зааврын дагуу санхүүгийн туслалцаа үзүүлэхийн тулд тэд өөрсдийн тойрогт мөнгө хандивладаг гэж хариулж болно.

### 21.1.39 Сүмийн удирдагчдын хэлсэн үгсийн тухай

Сүмийн удирдагчдад хамаарах үнэн бус мэдээллүүд үе үе гардаг. Ийм мэдээллүүд нь өнөөгийн Сүмийн сургаалуудыг мушгин гуйвуулсан ба цуурхал болон далд атгаг санаан дээр тулгуурласан байдаг. Эдгээр мэдээллүүдийг хэзээ ч албан ёсоор хийдэггүй, харин аман яриагаар, э-мэйлээр, эсвэл мэдээллийн бусад хэрэгслүүдээр дамжуулдаг. Гишүүд ийм мэдээллүүдийг

албан мэдэгдэл, захидал болон нийтлэлүүд зэрэг Сүмийн батлагдсан эх сурвалжуудаас мөн эсэхийг магадлан шалгахгүйгээр заах болон эш татахгүй байхыг анхаарах ёстой.

Ерөнхий эрх мэдэлтнүүд, Бүсийн Далууд, түүнчлэн Сүмийн бусад удирдагчдаас гадасны чуулган болон цуглаанууд дээр хэлсэн үг, хийсэн аливаа мэдэгдлийг үг хэлэгчийн зөвшөөрөлгүйгээр хувилан тараах ёсгүй. Хувийн тэмдэглэл бол зөвхөн хувь хүн ашиглах зориулалттай юм.

### 21.1.40 Симпозиум ба адил төрлийн хурал цуглаан

Заадаг зүйлүүд нь, (1) сүмийн эрхэмлэн дээдэлдэг ариун зүйлүүдийг үл тоомсорлосон, дооглон тохуурхсан, эдгээрт хөнгөмсгөөр эсвэл ямар нэг тохиромжгүй байдлаар ханддаг, (2) Сүмд хохирол учруулах, үүрэг зорилгоос нь гажуудуулах болон гишүүдийнх нь сайн сайхан байдалд хохирол учруулж болох симпозиум эсвэл үүнтэй төстэй цуглаанд оролцохоос Сүм гишүүдээ сэрэмжлүүлдэг. Гишүүд Сүм дэх өөрсдийн дуудлага ба гишүүнчлэлийг ийм цугларалтуудыг аливаа хэлбэрээр дэмжихэд ашиглах ёсгүй.

### 21.1.41 Татвар ноогддог үйл ажиллагаанууд

Сүмийн үйл ажиллагаанууд нь Сүмийн татвараас чөлөөлөгддөг эрхийг зөрчихөөргүй байх ёстойг тойрог, гадасны удирдагчид анхаарах ёстой. Удирдамжуудыг 21.2-оос үзнэ үү.

### 21.1.42 Ариун сүмийн хувцас ба гармент

Ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэхийн тулд хишиг хүртсэн гишүүдийг өөрсдийн ариун сүмийн хувцас худалдаж авахад нь дэмжих хэрэгтэй. Энэхүү ариун хувцсыг Сүмийн Хангамжийн төвүүдээс худалдан авч болно. Зарим ариун сүмд ариун сүмийн хувцаснуудыг түрээслэх боломжтой. Хэрэв ариун сүмд түрээслэх хувцас байхгүй бол гишүүд ариун сүмийн хувцсаа өөрсдөө авч очих хэрэгтэй.

Хэрэв гишүүд Сүмийн хангамжийн төвөөр дамжуулан хормогчны хатгамалын болон оёдлын зөвшөөрөгдсөн машиныг авч ашиглавал тэд хувийнхаа ариун сүмийн хормогчийг өөрсдөө хийж болно. Ариун сүмийн ёслолын бусад хувцсыг хийж болохгүй. Гарментийг ч хийж болохгүй.

Сүмийн гишүүд хишиг хүртээлтийн үед ариун сүм дотор өмссөн гарментаа өгөгдсөн зааврын дагуу цаашид өмсөх үүргийг хүлээдэг. Гармент нь ариун сүмд хийсэн гэрээнүүдийн байнгын сануулагч болдог. Гармент нь зохих ёсоор өмссөн үед уруу таталт болон нүгэл хилэнцийн эсрэг хамгаалалт болдог. Гарментийг өмсөх нь Аврагчийг дагах дотоод итгэлийн илэрхийлэл болдог.

Хишиг хүртсэн гишүүд ариун сүмийн гарментийг өдөр, шөнийн алинд ч өмсөх ёстой. Тэд гарментийг бүрэн эсвэл хагаслан тайлах ёсгүй. Тэд гэр орондоо усан сэлэлтийн эсвэл даруу биш хувцас өмсч байхын тулд гарментийг тайлах ёсгүй. Усанд сэлэх зэрэгт гарментийг тайлсан үед аль болох түргэн буцааж өмсөх ёстой.

Гишүүд хувцасны хэв загварт тохируулахын тулд гарментийг засварлах эсвэл үүнийг зааврын дагуу бус хэлбэрээр өмсөх ёсгүй. Гарментийг зөвшөөрөгдсөн загвараас нь өөрчлөх ёсгүй. Хоёр хэсгээс бүрдсэн гарментийг хэрэглэж байгаа үед хоёр хэсгийг үргэлж хоёуланг нь өмсөх ёстой.

Гармент бол ариун зүйл бөгөөд бүх цаг үед хүндэтгэлтэй хандаж байх ёстой. Гарментийг шалан дээр тавих ёсгүй. Гарментийг цэвэрхэн, бүрэн бүтэн байлгах ёстой. Гарментийг угаасны дараа хүнд ил харагдах газарт өлгөж болохгүй. Бас үүний утга учрыг үл ойлгох хүмүүст үзүүлэх буюу тэдэнд ил харагдахаар тавьж болохгүй.

Ариун сүмд гэрээнүүд хийсэн гишүүд гарментийг өмсөх тухай хувийн асуултуудаа хариулт авахын тулд Сүнсээр удирдагдах ёстой.

Элэгдэж хуучирсан ариун сүмийн гарментүүдийг устгахын тулд, гишүүд тэмдгүүдийг хайчилж аван устгах ёстой. Дараа нь гишүүд үлдсэн хэсгийг гармент гэж мэдэгдэхээргүй болгон хэсэглэж хайчилна. Тэмдгүүдийг авчихвал, даавууг ариун гэж үздэггүй.

Элэгдэж хуучирсан ариун сүмийн хувцсыг устгахын тулд гишүүд хувцсыг хэсэглэн хайчилж, танигдахааргүй болгоно.

Сайн хэвээрээ байгаа гарментууд болон ариун сүмийн хувцсыг гишүүд, ариун сүмийн хишиг хүртсэн зохистой бусад гишүүдэд өгч болно. Ийм хувцас хэнд хэрэгтэй байгааг тогтооход бишоп тусалж чадна. Ямар ч тохиолдолд гишүүд ариун сүмийн гармент болон ёслолын хувцсыг Дезерет Индастриес, бишопын агуулах эсвэл энэрлийн байгууллагуудад өгч болохгүй.

Онцгой нөхцөлд (цэргийн алба хааж байгаа гишүүд, өвчний улмаас хэвтэрт байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй гишүүдэд) ариун сүмийн хувцас, гарментуудийг захиалах мэдээлэл *Гарын авлага 1-ийн* 3.4-т байдаг.

### 21.1.43 Аялах журам

13.6.24-ийг үзнэ үү.

## 21.2 Сүмийн барилгууд ба бусад өмчийг ашиглах журам

Сүмийн барилгууд болон бусад өмчийг сүсэг бишрэл, шашны хичээл, Сүмтэй холбоотой бусад үйл ажиллагаануудад ашиглах ёстой. Арилжааны эсвэл улс төрийн зорилгоор Сүмийн өмчийг ашиглах ёсгүй. Ингэвэл Сүмийн татвараас чөлөөлөгддөг эрх бүхий хуулийг зөрчсөн асуудал болно. Мөн хууль зөрчихөд хүргэж болох зорилгоор Сүмийн өмчийг ашиглаж болохгүй. Сүмийн өмчийг ашиглахыг зөвшөөрдөггүй тохиолдлуудыг дараах жагсаалтанд харуулав:

1. Арилжааны зорилгоор Сүмийн барилга байгууламжуудыг түрээслүүлэх.
2. Бизнесийн болон хөрөнгө оруулалтын байгууллагуудын, түүний дотор төлбөртэй бараа үйлчилгээний зар сурталчилгааг байрлуулах.
3. Бараа, үйлчилгээ, хэвлэл нийтлэл болон уран бүтээл худалдан авах, худалдах, сурталчилах эсвэл бараа материал дэлгэн үзүүлэх.
4. Зөвшөөрөлгүй хандив цуглуулах ямар-ваа үйл ажиллагаа зохион байгуулах (13.6.8-ыг үзнэ үү).
5. Семинар, хичээл, аэробикийн дасгалын үеэр төлбөртэй зочин үг хэлэгч эсвэл багш урих, мөн тэдгээр нь үйлчлүүлэгч олж авахын тулд хүмүүсийг элсэхийг хүсэх. Сүмийн байрны төгөлдөр хуур, орган хөгжмийг төлбөртэй хувийн сургалтанд ашиглахад дээрх журмыг баримтлахгүй байж болно (14.7-г үзнэ үү).
6. Сүмээс зохион байгуулаагүй спортын тоглолтууд болон дасгал сургуулилалт хийх.
7. Улс төрийн хурал цуглаан, кампанит ажлууд зохион байгуулах. Зөвхөн доорх нөхцөлүүдэд Сүмийн барилга байгууламжуудыг сонгууль явуулах төрийн байгууллагын хүсэлтээр санал өгөгчдийг бүртгэх, сонгууль явуулах газар болгон ашиглаж болно:
   - а Өөр боломжит хувилбар байхгүй бол.
   - б Сонгуулийн ажилтнууд, санал өгөгчид барилгын дотор сүмийн жишгүүдийг дагах тохиолдолд.
   - в Үйл ажиллагаа Сүмийн барилгад хохирол учруулахааргүй бол.
   - г Үйл ажиллгаа нь Сүмийн нэр хүндэд муугаар нөлөөлөхгүй бол.

Сүмийн өмчийг ашиглах нь оролцогчдод болон өмчид хохирол учруулах эрсдэлтэй байх ёсгүй. Мөн энэ нь Сүмийг үндэслэлгүй өр төлбөрт оруулах эсвэл орчны амгалан тайван байдлыг алдагдуулах ёсгүй.

Сүмийн барилгууд болон бусад өмчийг ашиглах, анхаарал тавих тухай нарийвчилсан зааврuudыг *Сүмийн байрууд болон Сүмийн бусад өмчийн талаарх Барилга байгууламжийн менежментийн удирдамжуудаас* үзэх буюу Сүмийн удирдах газар эсвэл харьяа үйлчлэлийн төвтэй холбоо барина уу.

### 21.2.1 Урлагийн бүтээл

Сүмийн байруудад зориулан зөвшөөрөгдсөн урлагийн бүтээлийг *Church Facilities Artwork* товхимлыг судалсны үндсэн дээр барилга байгууламжийн менежерээр дамжуулан олж авна. Барилга байгууламжийн менежер урлагийн бүтээлийг Сүмийн Хангамжийн Төвүүдээр дамжуулан авч болно.

Зургууд болон урлагийн бусад бүтээлийг сүмийн байранд тохиромжтой газарт байрлуулж болно. Гэвч ариун ёслолын танхим дотор болон баптисмын сангийн ойролцоо байрлуулж болохгүй. Уран баримал, ханан дээрх уран зураг, шилэн шигтгэмэл зураг хийхийг зөвшөөрдөггүй. Энэ бодлого нь Сүмийн байранд олон жилийн өмнө тавигдсан урлагийн бүтээлүүдэд хамаарахгүй.

Сүмийн байруудад тавих урлагийн бүтээлийг үзэмжтэйгээр жаазалсан байх хэрэгтэй.

### 21.2.2 Чимэглэл

Христийн мэндэлсний баяр, бусад баяр ёслолууд болон эдгээртэй төстэй бусад үйл явдлуудаар чимэглэлүүдийг сүмийн байрны үүдний танхим, соёлын танхимд гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор зөвшөөрөл авч түр хугацаагаар байрлуулж болно. Сүмийн байрны гадна тал болон газрыг чимэглэх ёсгүй.

Чимэглэлүүд нь даруухан, үнэтэй биш, түүнчлэн галын аюулгүй байх ёстой. Өвс, сүрэл, дал модны навч, бусад хуурай материалууд, түүнчлэн лаа хэрэглэж болохгүй. Хэрэв гацуур мод хэрэглэвэл мод нь хиймэл эсвэл галын аюулгүй байх ба чимэглэлийн гэрэл болон лаа хэрэглэж болохгүй. Орон нутгийн галаас хамгаалах болон аюулгүй байдлын хууль дүрэм, захирамжуудыг баримтлах ёстой.

### 21.2.3 Онцгой байдал

Онцгой байдлын үед тойргийн тогтмол цуглаануудыг хийх эсэхийг гадасны ерөнхийлөгчийн зөвлөл шийдвэрлэнэ.

Нийгэмд учирсан онцгой байдал эсвэл байгалийн гамшгийн үед сүмийн байруудыг хоргодох газар болгон ашиглах боломжийг гадасны ерөнхийлөгч онцгой байдлын газарт олгон тусалж болно. Барилгуудыг ашиглах хүмүүс барилгад байрлах үеэрээ биеэ авч явах Сүмийн жишгүүдийг, түүний дотор Мэргэн Ухааны Үгийг сахих ёстойг гадасны болон тойргийн удирдагчид анхаарах ёстой.

### 21.2.4 Галт зэвсэг

Бурханыг шүтэн бишрэхийн төлөө, дэлхийн санаа зовоосон асуудлуудаас хоргодох газар байхын төлөө Сүмүүдийг онцгойлон адисалдаг. Хуулиар зөвшөөрөгдсөн албаныхнаас бусад хүмүүс биедээ аливаа төрлийн зэвсэг авч явахыг хориглоно.

### 21.2.5 Гал болон лаа

Сүмийн барилгуудад ил гал болон лаа асааж болохгүй.

### 21.2.6 Төрийн далбаа

Төрийн далбааг орон нутгийн заншил, тогтсон хэвшлийн дагуу ямар ч үед Сүмийн газар мандуулж болно. Үндэсний баяр зэрэг онцгой үйл явдлуудаар үндэсний далбааг Сүмийн барилгуудын дотор талд байрлуулж болно. Эх оронч үзэл нь үндэсний далбааг шүтээний байруудад байнга байрлуулахыг шаарддаггүй.

### 21.2.7 Даваа гарагийн үдэш

13.6.10-ыг үзнэ үү.

### 21.2.8 Хоногоор явах аялал зугаалга

Сүмийн байр орчныг шөнө хоноглох, аялал зугаалга, унтаж амрахад ашиглаж болохгүй.

### 21.2.9 Машины зогсоол

Сүмийн машины зогсоолыг ашиглахдаа энэ хэсгийн эхэн дэх удирдамж 21.2-г дагах ёстой. Түүнээс гадна Сүмийн машины зогсоолыг Үйлчлэлийн төвийн менежерийн зөвшөөрөлгүйгээр төлбөртэй зогсоол болгон ашиглаж болохгүй.

### 21.2.10 Ариун ёслолын танхимд гэрэл зураг авах, дүрс бичлэг, нэвтрүүлэг хийх тухай

Ариун ёслолын танхимд гэрэл зураг авах эсвэл дүрс бичлэг хийхийг зөвшөөрдөггүй. Ариун ёслолын танхимд болж байгаа хурал цуглаан, бусад үйл ажиллагааг интернетээр буюу мэдээллийн бусад хэрэгслээр дамжуулж болохгүй (Энэ журмыг баримтлахгүй байх тохиолдлыг 18.3.1 ээс үзнэ үү).

### 21.2.11 Сүмийн байр талбай

Сүмийн байр талбайд зөвхөн сургалт болон бусад үйл ажиллагаанд зориулан хоол хийнэ. Бусад тохиолдолд Сүмийн байр талбайд хоол хийх ёсгүй. Байран дотор болон гадна талбайд хоолоор үйлчлэх үед хоолыг өөр газарт бэлтгэж, авчрах ёстой.

### 21.2.12 Сүмийн байранд хадгалах зүйлс

Сүмийн байруудад хадгалахыг зөвшөөрдөг зүйлүүд нь засвар үйлчилгээнд зориулсан зүйлс, зөвшөөрөгдсөн бусад эд юмс, тоног төхөөрөмж юм. Халамжийн бараа бүтээгдэхүүн, бусад иймэрхүү зүйлүүдийг сүмийн байранд хадгалж болохгүй.

Бензин, хий, шүдэнз, аялал зугаалгын хэрэглэл зэрэг материалуудыг сүмийн байрнаас өөр барилгуудад хадгалах ёстой.

Машин, амралт чөлөөт цагийн тээврийн хэрэгсэл, түүнчлэн хувийн бусад тоног төхөөрөмжийг Сүмийн газар дээр агуулж болохгүй.

## 21.3 Эмчилгээ, эрүүл мэндийн бодлого

### 21.3.1 Цогцсын задлан шинжилгээ хийх тухай

Хэрэв нас барсан хүний гэр бүл зөвшөөрвөл, энэ нь хуулийн дагуу бол цогцсын задлан шинжилгээ хийлгэж болно.

### 21.3.2 Цогцос чандарлах тухайд

Сүм цогцос чандарлахыг ерөнхийдөө дэмждэггүй. Нас барсан хүний гэр бүл оршуулга болон цогцос чандарлахыг зохицуулдаг хуулиудад нийцүүлэн цогцсыг чандарлах эсэхийг шийднэ. Зарим оронд цогцос чандарлахыг хуулиар шаарддаг.

Боломжтой бол ариун сүмийн хишиг хүртсэн гишүүний цогцсыг чандарлахад ариун сүмийн хувцсыг нь өмсгөх хэрэгтэй. Оршуулгын ёслолыг зохион байгуулж болно (18.6-г үзнэ үү).

### 21.3.3 Зориудаар үхүүлэх тухайд

Эдгэршгүй өвчин зэрэг нөхцөл байдлаас зовон шаналж байгаа хүний амьдралыг зориудаар зогсоохыг зориудаар үхүүлэх хэмээн тодорхойлдог. Зориудаар үхүүлэхэд оролцсон, тухайлбал хэн нэгнийг амиа хорлоход тусалсан

хүн Бурханы зарлигуудыг зөрчдөг. (Мөн 21.3.8-ыг үзнэ үү.)

### 21.3.4 ХДХВ-ийн халдвар ба ДОХ

ХДХВ (Хүний дархлал хомсдолын вирус)-ээр халдварласан эсвэл ДОХ (Дархлал хомсдолын олдмол хам шинж)-той гишүүдэд нигүүлсэнгүй сэтгэлээр, хүндэтгэлтэй хандах ёстой. ХДХВ-тэй зарим хүмүүс бусдын үйлдлээр хохирсон гэм буруугүй хохирогчид байдаг. Жишээ нь тэд болгоомжгүйгээр цус шилжүүлэх байдлаар эсвэл эцэг эхээсээ халдвар авсан байж болдог. Хэрэв халдвар нь Бурханы хуулиудыг зөрчсөнөөс үүдэлтэй бол нүглийг зэмлэн буруутгахын хамт нүгэлтнийг хайрлаж, наманчлахад нь урамшуулан дэмжиж байсан Их Эзэний үлгэр жишээг Сүм дагадаг. Зовж шаналсан хүмүүст гишүүд нинжин сэтгэл, тайтгаруулаар хандаж, тэдний хэрэгцээг хангаж асуудлыг шийдэхэд нь туслах ёстой.

ХДХВ болон ДОХ-оос хамгаалах үндсэн арга бол гэрлэхээсээ өмнө ариун явдлыг чанд сахиж, гэрлэснээсээ хойш чин үнэнч байж, ижил хүйстэнтэй бэлгийн харилцаанд орохгүй байх, хар тамхинаас татгалзаж, бие махбоддоо хүндэтгэлтэйгээр хандах явдал юм.

ХДХВ-ийн халдвартай болон ДОХ-той хүмүүстэй хамт Сүмийн цуглаануудад оролцох нь эрүүл мэндийн ноцтой асуудал бий болгодоггүй. ХДХВ нь гэр орон, сургууль, Сүм эсвэл ажлын газар дээр ердийн харилцаагаар дамжин халдварладаггүй нь эрүүл мэндийн байгууллагуудаар нотлогдсон.

Үе үе цусаа цэвэршүүлэх болон анхан шатны тусламж авах хэрэгтэй хүмүүс орон нутгийн эрүүл мэндийн газрын зөвлөмжүүдийг дагах ёстой.

ХДХВ-тэй эсвэл ДОХ-той хүмүүсийн баптисм ба гишүүний баталгааны тухайд бол Бурханд итгэх итгэлээ илэрхийлдэг, наманчилдаг бөгөөд Есүс Христийн сайн мэдээгээр амьдарч байгаа аливаа бусад хүмүүсийн адилаар тэдэнд хандах ёстой.

### 21.3.5 Ховс

Өвчин болон сэтгэцийн эмгэгийг эмчлэхэд ховсыг мэргэжлийн чадварлаг эмнэлгийн хяналтан дор ашиглах нь анагаах ухааны асуудал юм. Үзүүлбэр, зугаа цэнгэлийн зорилгоор гишүүд ховсдолтод оролцох ёсгүй.

### 21.3.6 Эмчилгээний болон эрүүл мэндийн асуудлууд

Ёс зүй эсвэл эрх зүйн хувьд эргэлзээтэй эмчилгээний буюу эрүүл мэндийн аргуудыг гишүүд ашиглах ёсгүй. Орон нутгийн удирдагчид эрүүл мэндийн асуудлуудтай гишүүдийг өөрсдийн улс оронд ажилладаг зөвшөөрөл бүхий, мэргэжлийн чадварлаг эмч нараас зөвлөгөө авахыг зөвлөх ёстой.

### 21.3.7 Эрхтэн, эд эсийн донор ба эрхтэн шилжүүлэн суулгах тухай

Эрхтэн, эд эсийн донор бол эмчилгээний асуудал бүхий хувь хүмүүст агуу ашиг тусыг авчирдаг, амь биеэ хайрлаагүй үйлдэл бөгөөд эмчилгээний зорилгоор хүн биеийнхээ эрхтэн, эд эсийг өгөх буюу донорлох шийдвэр, гэр бүлийн нас барсан гишүүнээс эрхтэн, эд эсийг нь шилжүүлэн суулгахыг зөвшөөрөх шийдвэрийг хувь хүн эсвэл нас барсан гишүүний гэр бүл гаргадаг.

Донорлосон эрхтнийг хүлээн авах шийдвэрийг мэргэжлийн эмнэлгийн зөвлөгөө авсны дараа, түүнчлэн залбирлаар дамжуулан баталгаажуулсны дараа гаргах ёстой.

### 21.3.8 Үхлийг зохиомлоор хойшлуулах тухайд

Хүнд өвчин туссан үед гишүүд Их Эзэнд итгэх итгэлээ хөгжүүлэхийн хамт эмнэлгийн мэргэжлийн тусламжийг эрж хайх ёстой. Гэхдээ үхэл зайлшгүй тохиох болсон үед үүнийг адислал хийгээд мөнх оршихуйн зорилгын нэг хэсэг хэмээн үзвэл зохино. Гишүүд хүлээн зөвшөөрөмгүй арга хэрэгслээр зуурдын амьдралыг сунгах хэрэгтэй хэмээн бодох ёсгүй. Анагаах ухааны мэргэжлийн, ухаалаг зөвлөгөөг хүлээн авч мацаг барилт, залбирлаар дамжуулан тэнгэрлэг удирдамж эрэлхийлсний дараа гэр бүлийн гишүүд энэ талаар дүгнэлт хийх хэрэгтэй.

### 21.3.9 Бусад бие даасан бүлэг, эвслүүд

Өөрсдийгөө таньж мэдэх, өөрсдийгөө хүндлэх болон сүнслэг байдлыг дээшлүүлэх зорилго агуулсан хөтөлбөртэй хувийн болон бизнесийн бүлэг эвсэл, байгууллага олон байдаг. Мөн зарим нь "туршлага нэвтрүүлэх" "чадвар эзэмшүүлэх" сургалт санал болгодог.

Зарим бүлэг нь тэдний хөтөлбөрийг Сүм эсвэл тэргүүлэх эрх мэдэлтний нэг баталсан хэмээн худал мэдээлдэг. Гэвч Сүм ийм ямар ч бүлгийг сайшаан дэмждэггүй бөгөөд тэдний мэдэгдлүүдэд итгэхгүй байхыг Сүмийн гишүүдэд сэрэмжлүүлдэг. Сүм ийм бүлгүүдийг албан ёсоор няцаадаггүй нь тэднийг дэмждэг эсвэл хүлээн зөвшөөрдөг гэсэн үг биш юм.

Сүмийн гишүүдэд эдгээр бүлгийн зарим нь хор уршигтай байж болох ухагдахуун болон аргуудыг хэрэглэдэг талаар сэрэмжлүүлж

байна. Түүнээс гадна ийм олон бүлэг дэндүү өндөр хураамж авч, урт хугацааны оролцоог хүсдэг. Зарим бүлэг сүнслэг байдал болон итгэлийг үгүйсгэж болох дэлхийн ухагдахууныг сайн мэдээний зарчимтай хольж ойлгуулдаг.

Цаг хугацаа, хувь хүний хүч чармайлтыг шаарддаг асуудлуудыг түргэн шийдвэрлэнэ хэмээн эдгээр бүлгүүд амлах хандлагатай байдаг. Хэдийгээр оролцогчид сэтгэл санаа нь түр зуурын хөнгөрөлийг мэдрэх боловч хуучин асуудлууд нь ахин давтагдаж, урьдынхаас илүү цөхрөл, гутралд хүрдэг.

Сүмийн удирдагчид ийм бүлгүүдэд мөнгө төлөх болон оролцохыг дэмжих ёсгүй. Түүнчлэн Сүмийн байранд ийм үйл ажиллагаа явуулж болохгүй.

Жинхэнэ ёсоор өөрийгөө хөгжүүлэх нь сайн мэдээний зарчмуудаар амьдарснаар дамжин ирдгийг орон нутгийн удирдагчид гишүүдэд заах ёстой. Нийгмийн болон сэтгэл санааны асуудалтай гишүүд сайн мэдээний зарчмуудад нийцэх тусламжийн эх сурвалжуудыг олж авахын төлөө санваартны удирдагчидтай зөвлөлдөж болно.

### 21.3.10 Амьгүй төрсөн хүүхдүүд (төрөхөөсөө өмнө эндсэн хүүхдүүд)

Амьгүй төрсөн хүүхдүүдэд зориулж ариун сүмийн ёслолууд гүйцэтгэдэггүй. Гэхдээ мөнх амьдралд амьгүй төрсөн хүүхэд нь тухайн гэр бүлийн хэсэг байх боломжгүй гэсэн хэрэг биш юм. Ийм тохиолдлуудыг өөрийн мэдэх арга замаар шийдвэрлэхийг Их Эзэнд итгэн даатгахад эцэг эхчүүдийг дэмжих нь зүйтэй. Гэр бүл нь амьгүй төрсөн хүүхдийн нэрийг гэр бүлийн цэдэгт оруулж нэрнийх нь ард хаалтанд *амьгүй төрсөн* гэж бичиж болно.

Эцэг эхийнх нь шийдвэрээр хүндэтгэл буюу оршуулах ёслолыг хийж болно.

Тухайн хүүхэд төрөхөөсөө өмнө амьдарч байсан нь үнэн болно. Гэхдээ сүнс түүний биенд хэзээ ордог талаар шууд илчлэлт байдаггүй.

### 21.3.11 Мэргэн Ухааны Үг

Мэргэн Ухааны Үгэн дэх “халуун ундаанууд”-ын (С ба Г 89:9) цорын ганц албан ёсны тайлбар бол эхэн үеийн Сүмийн удирдагчдын хэлсний дагуу цай, кофе юм.

Хуулиар хориглодог мансууруулах бодис агуулсан ямар ч бодисыг гишүүд ашиглах ёсгүй. Хэрэв мэргэжлийн эмчийн хяналтан дор биш бол хортой эсвэл донтуулагч бодисуудыг гишүүд хэрэглэх ёсгүй.

## 21.4 Бэлгийн ёс суртахууны талаарх бодлого

### 21.4.1 Үр хөндөлт

“Чи . . . хүн алах ёсгүй, тэрчлэн энэ мэт ямар ч зүйлийг үйлдэх ёсгүй” (С ба Г 59:6) хэмээн Их Эзэн зарлиг болгосон билээ. Хувийн болон нийгмийн үзэл бодлоор үр хөндөхийг Сүм эсэргүүцдэг. Гишүүд үр хөндөлтөд оролцох, гүйцэтгэх, зохион байгуулах, мөнгө төлөх буюу зөвшөөрөл өгч, дэмжиж болохгүй. Зөвхөн дараах тохиолдлуудад үр хөндүүлж болно:

1. Хүчин эсвэл цус ойртолтоос үүдэлтэй жирэмслэлтийн үед.
2. Хүүхэд төрүүлэх нь эхийн амь нас, эрүүл мэндэд онц аюултайг мэргэжлийн эмч тодорхойлсон үед.
3. Төрсний дараа хүүхэд амьд мэнд үлдэх боломжгүй ноцтой гажиг үр хөврөлд байгааг мэргэжлийн эмч тогтоосон үед.

Дээрх тохиолдлуудад ч гэсэн үр хөндөлтийг шууд зөвтгөдөггүй. Үр хөндүүлэлт бол нэн ноцтой асуудал бөгөөд хариуцлага хүлээх хүмүүс өөрсдийн бишопуудтай уулзаж, залбирлаар дамжуулан бурханлиг нотолгоо хүлээн авсны дараа л үүнийг шийдэх ёстой.

Үр хөндөлтийг зөвшөөрсөн, гүйцэтгэсэн, зохион байгуулсан, дэмжсэн эсвэл үүний төлөө мөнгө төлсөн гишүүдийг Сүмийн сахилгын хурлаар авч хэлэлцэх ёстой.

Үр хөндөлтийн нүглээс хүн наманчилж, уучлагдаж болох нь илчлэгдсэн билээ.

### 21.4.2 Хүчирхийлэл ба хэрцгий авир

